



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭН

ХУВИЙН ЭРХ ЗҮЙД ХОЛБОГДОХ СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХЭТГЭЛ

IX БОТЪ

(2021 онд хийж гүйцэтгэсэн судалгаа)

Улаанбаатар хот
2022 он

ДАА 346
ННА 67.412.2
Х-647

**ХЗҮХ-ийн Хууль зүйн судалгааны төвийн
Эрдэм шинжилгээний ажилтан:**

С.Цэрэндолгор
Л.Амгаланбаатар
Э.Анударь
Б.Дүүрэнжаргал
Д.Дэмидханд
Х.Санчир

Судлаач:

Б.Буянхишиг, МУИС-ийн Хууль зүйн
сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах
багш, Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
Г.Давааням, МУИС-ийн Хууль зүйн
сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах
багш, Хууль зүйн ухааны доктор (LL.D)
Э.Байгал, МУИС-ийн Хууль зүйн
сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн дэд
профессор, Хууль зүйн ухааны доктор (Ph.D),
Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах
шатны шүүхийн шүүгч Э.Золзаяа

© Хууль зүйн үндэсний хүрээлэн

Хянан тохиолдуулсан : Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах

Эмхэтгэсэн: Эрдэм шинжилгээний ажилтан, номын сангийн
менежер Х.Ариунсүрэн

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Эх бэлтгэгч, дизайнер Б.Заяа

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

Хэвлэсэн хугацаа : 2022 он

ISBN 978-9919-9964-1-3

ӨМНӨХ ҮГ

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвийн 2021 онд гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүнг эмхэтгэн уншигч Танаа өргөн барьж байна. Судалгааны тайлангийн энэхүү IX ботид хувийн эрх зүйд хамаарах судалгааг багтаасан болно.

Монгол Улсад хувийн эрх зүйн хөгжлийн асуудал тулгамдсан хэвээр байгаа билээ. Үүнийг манай судлаачид олон талаас нь нухацтай авч үзэхийн зэрэгцээ суурь шинжтэй асуудлыг хөндөж тавьж байгаагийн нэг жишээ нь Монгол Улсын Иргэний хуулийг бүтцийн талаас нь бусад улс оронтой харьцуулан судалсан Ч.Буянхишиг докторын судалгаа юм. Тэрээр 2002 онд батлагдсанаас хойш өнөө хүртэл мөрдөгдөж буй Иргэний хуульд өмнөх социалист нийгмийн үеийн Иргэний хуулиудын уламжлал хадгалагдсаар байгаа нь хувийн эрх зүйн шинэтгэлд ямар нөлөө үзүүлж байгаад дүн шинжилгээ хийж, Иргэний хууль нь аж ахуйн үйл ажиллагааг түлхүү зохицуулсан, хувь этгээдийн хамгаалалт дутмаг хэмээн дүгнэсэн байна.

Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн хэлбэр болох хувьцаат компани, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааг хуульчилсан байдал, түүний хэрэгжилтэд үнэлгээ хийсэн доктор Г.Даваанямын судалгаанаас үзэхэд, улсын бүртгэлд бүртгүүлсэн нийт компанийн 99.8 хувь нь ХХК байхад хуульд ХХК-д хамаарах заалтын тоо харьцангуй цөөн байгааг онцолж, үүний үр дагаврыг шинжилжээ.

Хувийн эрх зүйн салбарт хамаарах нэг чухал сэдэв бол гадаад элемент бүхий иргэний хэрэг, маргааныг шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тогтоох асуудал бөгөөд уг асуудлыг доктор Э. Байгал онолын үндэслэл, олон улсын туршлага, өөрийн улсын хууль тогтоомж, шүүхийн практикт тулгуурлан авч үзээд, практикт хэрэгжүүлэх тодорхой санал, зөвлөмж боловсруулсан байна.

Судлаач Э.Анударь, Б.Дүүрэнжаргал нарын судалгаанд “хуулийн этгээдийн эрхгүй байгууллага” гэх ойлголтыг хуулийн этгээдээс ялгаж тодорхойлох оролдлогыг хийж, уг ойлголтод хамааруулж болох СӨХ, ойн нөхөрлөл зэрэг нь манай улсын практикт хуулийн этгээдийн нэгэн адил шүүхэд нэхэмжлэгч, хариуцагч болох явдал цөөнгүй байгааг дурджээ. Онолын ойлголт амьдралаас зөрүүтэй байгаа уг асуудлыг хэрхэн шийдвэрлэх нь хувийн эрх зүйн бас нэгэн сорилт юм.

Дээрх асуудлын анхдагч суурь нь болох “хуулийн этгээд” хэмээх эрх зүйн хийсвэрлэл бол манай улсын хувийн эрх зүйд нэг мөр болж, тогтоогүй ойлголт болохыг судлаач Э.Анударь, Д.Дэмидханд, Х.Санчир нарын судалгаанаас харж болно. Энэхүү судалгаанд хувийн эрх зүйн төдийгүй нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн тухай асуудлыг хөндсөн нь онцлог болжээ.


Судлаач Э.Анударь, Т.Лхагважаргал нарын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний үр дүнд уг хууль батлагдсанаас хойшхи хугацаанд гэрлэлт цуцлах маргаанд эвлэрүүлэн зуучлал амжилтгүй байгаа шалтгааныг тогтоох оролдлого хийсэн.

Энэхүү эмхэтгэлд орсон, судалгааны зөвлөх Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Э.Золзаяа, судлаач Л.Амгаланбаатар, С.Цэрэндолгор нарын хийсэн, иргэний процесст хамаарах бөгөөд судалгааны гол дүгнэлт нь холбогдох хуульд байгаа зарим бүрхэг зүйл, заалтаас үүдэн хэрэг хянан

шийдвэрлэх ажиллагаа удаашрах тохиолдол нэлээд байгааг хэрхэн засах талаар тодорхой санал дэвшүүлжээ.

Хувийн эрх зүй бол нийгмийн өргөн хүрээний харилцааг зохицуулдаг гол салбар бөгөөд дээр товч танилцуулсан 7 судалгаа нь энэ салбар эрх зүйд тулгамдаж буй олон чухал асуудлыг хөндөж, онол, практик, харьцуулсан эрх зүйн мэдлэгт тулгуурлан сонирхолтой бөгөөд практик ач холбогдол бүхий дүгнэлт хийсэн нь бусад судлаачдад санаа сэдэл төрүүлж, цаашид судалгааны эргэлтэд орж, хууль зүйн шинжлэх ухааны хөгжилд зохих хувь нэмрээ оруулна гэдэгт итгэж байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор (Dr.jur)



Х.Эрдэм-Ундрах

АГУУЛГА

ХУВИЙН ЭРХ ЗҮЙД ХОЛБОГДОХ СУДАЛГАА

1. **Монгол Улсын болон гадаадын иргэний хуульд
бүтцийн анализ хийх нь.** 1
Б.Буянхишиг, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн
ахлах багш, Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
2. **2011 оны Компанийн тухай хууль дахь хязгаарлагдмал
хариуцлагатай компанийн эрх зүйн зохицуулалтын
хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ**53
Г.Давааням, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн
ахлах багш, Хууль зүйн ухааны доктор (LL.D)
3. **Олон Улсын шинжтэй иргэний хэрэг маргааны шуухийн харьяалал:
ИХШХШТХ-ийн 189-193 дугаар зүйлийг хэрэглэж буй практик,
боловсронгүй болгох асуудал** 89
Э.Байгал, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн дэд
профессор, Хууль зүйн ухааны доктор (Ph.D)
4. **Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага** 125
Судалгааг удирдсан: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах
Судалгааг гүйцэтгэсэн: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний ажилтан Э.Анударь
Эрдэм шинжилгээний ажилтан Б.Дүүрэнжаргал .
5. **Монгол Улсын хууль тогтоомж дахь хуулийн этгээдийн ойлголт,
нэр томьёоны хэрэглээ** 159
Судалгааг удирдсан: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах
Судалгаа гүйцэтгэсэн: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний ажилтан Э.Анударь
Эрдэм шинжилгээний ажилтан Д.Дэмидханд
Эрдэм шинжилгээний ажилтан Х.Санчир
6. **Гэр бүлийн холбогдолтой маргааныг эвлэрүүлэн
зуучлах ажиллагаа (Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн
хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ)** 255
Судалгааг удирдсан: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
Хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах
Судалгааг гүйцэтгэсэн: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний ажилтан Э.Анударь
Дадлагажигч, МУИС-ийн ХЗС-ийн 4 дүгээр түвшний
оюутан Т.Лхагважаргал

**7. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн
хэрэгжилтийн үр дагаварт хийсэн дүн шинжилгээ 285**

Судалгааны зөвлөх: Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны
шүүхийн шүүгч Э.Золзаяа

Судалгааг гүйцэтгэсэн: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний ажилтан Л.Амгаланбаатар
Эрдэм шинжилгээний ажилтан С.Цэрэндолгор

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
АИХ	Ардын Их Хурал
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АМХГ	Аймгийн мэргэжлийн хяналтын газар
БНИУ	Бүгд Найрамдах Итали Улс
БНПУ	Бүгд Найрамдах Перу Улс
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНТУ	Бүгд Найрамдах Турк Улс
БНПУ	Бүгд Найрамдах Польш Улс
БНПУ	Бүгд Найрамдах Перу Улс
БНКУ	Бүгд Найрамдах Казакстан Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНФУ	Бүгд Найрамдах Франц Улс
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БОГУУХ	Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналт
ГБХТтХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ГҮТББ	Гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага
ДТХ	Дампуурлын тухай хууль
ЕАБХАБ	Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Байгууллага
ЕХ	Европын холбоо
ЗГ	Засгийн газар
ЗД	Засаг дарга
ЗХШХШтХ	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ЗХДЗШШ	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх
ЗЕХ	Захиргааны хэргийн хууль
ЗХАШШ	Захиргааны хэргийн анхан шатны шүүх
ЗХШ	Захиргааны хэргийн шүүх
ЗШША	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа
ЗШШтХ	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
ИХШХШтХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ИХАШШ	Иргэний хэргийн анхан шатны шүүх
ИХ	Иргэний хууль
ИБУИНВУ	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
ИБУТЭТОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
КТХ	Компанийн тухай хууль
МСӨХДЗ	Монголын сууц өмчлөгчдийн холбооны дээд зөвлөл
МУ	Монгол улс
МУЕтХ	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль
МУИХтХ	Монгол Улсын Их Хурлын тухай хууль

МҮХАҮТ	Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
МХБ	Мэргэжлийн хяналтын байгууллага
МХБ	Монголын хөрөнгийн бирж
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
НМХГ	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
ННФ	Нээлттэй нийгэм форум
НДЗХАШШ	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх
НШГА	Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба
НЭЗЭ	Нийтийн эрх зүйн этгээд
ОХУ	Оросын Холбооны Улс
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо
СӨХЭЗБНЗОСБДӨЭХТХ	Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль
СнЗ	Сайд нарын зөвлөл
ТАтХ	Төрийн албаны тухай хууль
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨтХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТЗ	Төрийн захиргааны
ТТ	Төрийн тусгай
ТХШтХ	Төрийн хяналт шалгалтын тухай хууль
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УДШ	Улсын дээд шүүх
УИХ	Улсын их хурал
УТХТХ	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль
УТХ	Улсын тэмдэгтийн хураамж
УША	Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа
ҮЦБ	Үнэт цаасны байгууллага
ҮЦЗЗТХ	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
ХАБҮЛЛ	Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХХША	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ХМХА	Хилийн мэргэжлийн хяналтын алба
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ХШЗ	Хянан шалгагчдын зөвлөл
ХШ	Хянан шалгагч
ХЭУБ	Хуулийн этгээдийн улсын бүртгэл

ХЭҮК	Хүний эрхийн Үндэсний комисс
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШШГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэл
ШШГТХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
ЭХ	Эрүүгийн хууль
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
ЭХХША	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа
ЭХШ	Эрүүгийн хэргийн шүүх
ЭХАШШ	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
ЭИХХЦХ	Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналт
РС	Private company
LLC	Limited liability company
SARL	Société à Responsabilité Limitée
SRL	Società a responsabilità limitata
GmbH	Gesellschaft Mit Beschränkter Haftung
LS	Limited Sirket

НЭГ. МОНГОЛ УЛСЫН БОЛОН ГАДААДЫН ИРГЭНИЙ ХУУЛЬД БҮТЦИЙН АНАЛИЗ ХИЙХ НЬ

Судалгааг гүйцэтгэсэн:

Б.Буянхишиг. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш,
Хууль зүйн ухааны доктор (Ph.D) (Ass.Juri.)

УДИРТГАЛ

I. Тулгамдсан асуудал ба судалгааны зорилго

“Хувийн эрх зүйн хөгжил, цаашдын чиг хандлага” сэдэвт уулзалтын үеэр тавьсан илтгэлдээ Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар Иргэний хуулийг Үндсэн Хуулийн дараа орох чухал хууль болохыг онцлон тэмдэглээд, 2002 оны ИХ-ийг батлагдахад тухайн үеийн хуулиудыг уялдуулан шинэчлэх ажил хийгдэж байсан ч Газрын тухай, Гэр бүлийн тухай, Өрсөлдөөний тухай, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай гэх мэт хуулиудыг ИХ-ийн суурь зохицуулалт, үзэл баримтлалд нийцүүлж чадаагүй өдий хүрч байгаа тухай дурдсан¹. ХЗДХЯ-ны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хэрэглэгчийн эрхийг шуурхай хангах, сэргээх болон гэр бүлийн эрх зүйн зарим шинэтгэл хийгдэх гэж буйтай холбогдуулан ХЗҮХ-ээс зарласны дагуу МУ-ын ИХ-д бүтцийн анализ хийж, “иргэн”, хувь этгээд нь хэрэглэгч, эсвэл аж ахуй эрхлэгчийн иргэний гүйлгээнд оролцож буй практикт үндэслэн хувь этгээдийн буюу хэрэглэгчийн эрхийн хамгаалалт ба аж ахуй эрхлэгч, хуулийн этгээдийн хүлээх үүрэг хоёр нь салшгүй холбоотой гэсэн дүгнэлтэд хүрч, эдгээрт холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор ИХ-ийн системчлэлийг нийтэд нь үнэлэхийг зорив.

Монгол Улсын хувийн эрх зүйн нэгдмэл кодификаци нь Иргэний Хууль мөн боловч өдгөө устан үгүй болсон социалист хуулийн бүтэц, хуулийн техник, системчлэл зэрэг элементүүдийг авч үлдсэнээрээ кодификацийн сэтгэлгээний ИХ-иудаас зөрж байхын сацуу системийн хувьд уян хатан бус, дотоод зөрчилтэй байна. Хувийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд энэхүү нэгдмэл кодификацийг хэрхэн задлах талаар яригдаж байгаа бөгөөд ИХ-ийг бусад төлөөлөх загваруудтай макро түвшинд харьцуулбал өдгөө манай хувийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд яригдаж буй асуудлуудыг аль хэдийн оновчтой зохицуулж, системчилсэн байдаг.

Социалист улсуудын хамгийн том төлөөлөл байсан ОХУ, БНХАУ зэрэг нь хуулийн техникийн хүрээнд ашиглаж байсан социалист ИХ-ийн бүтэц, системийн элементүүдээс бүрэн татгалзсан байхад Монгол Улс эдгээрийг хадгалан үлдэж, шинэтгэлийн хүрээнд ч ашиглах нь оновчгүй юм. 2002 оны ИХ-ийг батлахад хууль тогтоох байгууллагын гишүүд эдийн засгийн харилцаагаа зохицуулсан суурь хууль хэмээн гараа өргөж байсан бол өдгөө энэхүү эдийн засгийн үндсэн хуулиасаа арилжааны салбарыг тусгаарлах ажил хийж байна. Гэтэл ИХ-ийн “иргэн” хүнд холбоотой хэсгийг шинэчлэх асуудал нь илүү тулгамдсан байх талтай нь “Хувийн эрх зүйн шинэтгэл” олон улсын бага хурлын зөвлөмжид тусгагдсанаас илт байна.

Дээрхээс үзвэл хувийн эрх зүйн системчлэлийн үндсээ онолын түвшинд нухацтай шийдвэрлэх явдал аль ч улсад ихээхэн үр өгөөжтэй бөгөөд өөр хоорондоо харилцан хамааралгүй олон тооны тусгай хууль батлахаас сэргийлдэг. Тиймээс энэхүү судалгаанд ИХ-ийн системчлэл ба шинэтгэлийн асуудлыг өмнөх илтгэлүүдэд дурдсан хувийн эрх зүйн шинэтгэлийн бодлоготой нийцүүлэн гүйцэтгэхийг зорилоо.

1 Х.Нямбаатар, “Хувийн эрх зүйн хөгжил, цаашдын чиг хандлага” сэдэвт илтгэл, 2021 оны 9 сарын 17, 1 дэх тал.

II. Судалгааны ажлын бүтэц

Энэхүү судалгаа нь ИХ-ийн бүлэг бүрийн тэнцвэрт байдалд тулгуурлан эдгээрт зарчмын хувьд дутагдаж байгаа эрхийн хамгаалалт, хуулийн техникийн шинжтэй шийдлүүдэд төвлөрсөн бөгөөд Удиртгал, Үндсэн хэсэг, Дүгнэлт санал, Хавсралт гэсэн хэсгүүдээс бүрдэж байна.

III. Сэдвийн судлагдсан байдал

Дотоод, гадаадын ИХ-ийн бүрдэл хэсэг тус бүрээр нь харьцуулсан судалгаа, сурах бичиг элбэг бөгөөд хууль зүйн боловсролын зэрэг хүртэхээр зэхэж буй оюутан, судлаач бүр ИХ-ийн маргаантай асуудлаар судалгаа хийдэг. Эдгээр судалгааны ажилд ИХ-ийн дутагдалтай талуудыг тоочиж, эд юмсын эрх зүй, үл хөдлөх хөрөнгийн эрх зүй, өвийн эрх зүй, гэм хорын эрх зүйн салбарт их бага хэмжээний шинэтгэл хийх шаардлагатай гэсэн байдаг. Ийнхүү хувийн эрх зүйн салбар эрх зүйг шинэтгэх онолын шалгуур нь кодификацийн онолын хүрээнд зарчмын шийдлээ эргэн харах, эдгээр салбаруудыг зохих хуулийн техникийг ашиглан өөр хооронд нь уялдуулах юм.

Нийт системийн түвшинд харьцуулан тусгасан судалгаа цөөн байна. Тухайлбал үүнд 2019 онд ХЗҮХ-ийн Хууль зүйн судалгааны төвөөс хийсэн “Кодификацийг амжилттай хэрэгжүүлж буй гадаад орны туршлага” сэдэвт судалгааны ажил, 2021 онд бэлтгэсэн “Хувийн эрх зүйн кодификаци, харьцуулалт” нэг сэдэвт бүтээлийг дурдах нь зүйтэй.

Олон улс үндэстний хувийн эрх зүйн хууль тогтоомж, нэн ялангуяа Иргэний Хууль нь ойролцоо төстэй олон зохицуулалт агуулах боловч харьцуулсан эрх зүйн хувьд тус бүрнээ өөр өөр ангилал, бүлд багтаж байдаг. Энэ нь тэдгээрийн хуулиа системчилсэн суурь шийдэлтэй холбоотой бөгөөд олон зуун жилийн хүчинтэй үйлчлэх хувийн эрх зүйн үндсийг өвөрмөц байдлаар тодорхойлсон кодификацийн сэтгэлгээний загвар бүхий улс орнууд, тэдгээрийн уламжлалыг рецепцийн аргаар тусган хэрэгжүүлсэн улс голлох байр суурийг эзэлж байна. Бичмэл хууль тогтоомж батлан хэрэгжүүлээд удсан ч кодификацийн сэтгэлгээний ангилалд багтаагүй англо-америкийн эрх зүйн тогтолцоо бүхий улс орнууд нь дээрхээс системийн хувьд эрс ялгагдана. Тиймээс ИХ-ийн агуулга, системчлэлийг эх газрын эрх зүйн тогтолцоо бүхий улс орны ИХ-тай харьцуулан дүгнэх, үнэлгээ өгөх боломжтой.

Хувийн эрх зүйн салбарт хийгдсэн судалгааны ажлуудад ИХ болон бусад хууль тогтоомжийн харилцан хамаарлыг сайжруулахыг шаардсан, тодорхой хэсэгт анализ хийсэн ажлууд олон, харин системийн анализ хийсэн нь ховор, шилжилтийн эхэн үеийн цөөн тооны материал нь ерөнхий эх газрын болон common law тогтолцооны макро харьцуулалт агуулсан байсан². ИХ-ийн тодорхой салбарыг авч судалсан магистр, докторын судалгааны ажлуудад ИХ-ийн техник, бүтэц, материаллаг эрх зүйн хэрэглээ зарим талаар практик шаардлагад нийцэхгүй байгаа тухай дурдсан байдаг³.

2 Эрх зүйн шинэтгэл, 2002 он.

3 Б.Улаанбаатар, Гэрээслэлээр өв залгамжлах нь, 2019; Ш.Сүхбаатар, Хүний нэр төр, алдар хүндийн эрх зүйн хамгаалалт, 2012 он; Г.Цагаанбаяр, МУ-ын ИХ дахь өмчлөх эрхийг шилжүүлэх зохицуулалт (Харьцуулсан эрх зүйн үүднээс): шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ (Магистрын судалгааны ажил), 2016 он; Янжинхорлоо, Үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрх зүйн зохицуулалт: тулгамдсан асуудал, 2016 он; Ц.Давхарбаяр, Эд юмсын эрх зүй дэх эзэмшил, түүний хамгаалалтын тулгамдсан асуудал, 2018 он, УБ хот.

Рецепцийн туршлага хэрэгжүүлээд удаагүй Монгол Улсад нэгдмэл тогтолцоо, хууль тогтоомжийн харилцан уялдаа бүхий байдал шаардлагатай. Мэдээж эдийн засаг нийгмийн хөгжилд анхааран бизнесийн хууль тогтоомж, ялангуяа арилжаа, хуулийн этгээдийн эрх зүйг түлхүү хөгжүүлэх ёстой байгаа нь Иргэний Хуульд гоц анхаарал хандуулж, түүнд байвал зохих бүрэлдэхүүнийг тусгаж, байх ёсгүй өмнөх бүтцийн зохицуулалтыг өөрчлөх зэрэг ажил хийхийг шаарддаг.

IV. Судалгааны аргачлал:

Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59-р тогтоолын дагуу батлагдсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал нь Иргэний Хуулийн тодорхой зохицуулалтыг сонгон авч, асуудал дэвшүүлж, шийдвэрлэх арга замыг санал болгоход чухал ач холбогдолтой.

Нийт ИХ-ийн системийн түвшинд хувийн эрх зүйн хууль тогтоох онолыг тодорхойлох, хөгжүүлэхэд төрөлжүүлэн нэгтгэх буюу кодификацжуулах аргыг хэрхэн ашигласан байгааг 2002 оны ИХ-ийн хүрээнд авч үзэх макро харьцуулалтын хүрээнд түлхүү ашиглах арга болдог. Харьцуулсан эрх зүйн макро ба микро харьцуулалтын арга нь хэм хэмжээг шинэтгэх дүн шинжилгээ хийхэд түлхүү ашиглагдлаа.

НЭГ. ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН ӨНЦГӨӨС ИРГЭНИЙ ХУУЛЬД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ НЬ

А. Хууль тогтоомж өөрчлөх, кодификацжуулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлох:

Хууль тогтоогчийн зүгээс шинээр хууль батлах, улмаар хуулийг кодификацжуулах шалтгаан нь янз бүр байх ч хуучин үйлчилж байсан хууль тогтоомжоо дээдлэх, уламжлал заншлаа хүндэтгэх, эсвэл аргачлал, агуулгын хувьд хэт яарсан хууль батлахгүйн тулд ул суурьтай хандах нь зүйтэй гэж үзэх хандлага нь шинэ үеийн хууль тогтоох онолын агуулга нэгэнт болжээ. Үе үеийн судлаачид хуулийн зорилго, зорилт, рациональ сэтгэлгээ, цаг үеийн шаардлага⁴, хуулийн цоорхойг арилгах, мөн хууль тогтоомжийг шинээр илэрсэн нөхцөл байдалд нийцүүлэх⁵ болон эрх зүйн тогтолцооны нэгдмэл байдлыг буй болгох⁶ хүсэл эрмэлзэлдээ хөтлөгдөн хуулийг засах, сайжруулах, шинээр батлах, бүр кодификацжуулахыг уриалж байв. Иргэний Хуулийн бүтэц агуулгыг авч үзвэл эх газрын эрх зүйн бүл, түүний нөлөөгөөр иргэний хуулиа бүтээсэн улс орны нийтлэг бүтээцтэй адил бөгөөд энэ нь хувийн эрх зүйн тогтолцоог системчлэгдсэн хэмээн хүлээн зөвшөөрөхөд хүргэж байна. Улмаар 20 шахам жилийн нүүр үзэж байгаа нь энэ хуулийг хувийн эрх зүйн кодификаци хэмээн хүлээн авахад нөлөөлсөн. Ойрын үед ИХ-ийг хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хууль тогтоомжоор баяжуулан ахин кодификацжуулах⁷, арилжааны хууль тогтоомжийг нэмж батлах нь оновчтой⁸ хэмээн үзэх болжээ.

4 Mohl, Robert von: Politik (Staatsrecht, Voelkerrecht und Politik), Tuebingen 1862, §412, Seite 427 ff

5 Wolff, Politik, §412, Seite 427, 429 ff.

6 Feuerbach, Philosophie und Empirie, Seite 89; Bentham, Traites de legislation, Bd.1, S.109.

7 Б.Буянхишиг, Хувийн эрх зүйн кодификаци, харьцуулалт, 2021 он, 274 дэх тал.

8 Б.Амарсанаа, С.Батбаяр, Арилжааны хуулийн тандан судалгаа, 96 дахь тал.

Аливаа кодификацууд нийгэмд хэр хүлээн зөвшөөрөгдөх нь тухайн салбар эрх зүйг хэр сайн системчилж чадсанаас шалтгаална. Эдгээр кодификацууд нь ерөнхий ангийн тусламжтай эрх зүйн олон салбарыг нэгтгэж, нэг тогтолцоонд багтааж чаддагаараа онцлогтой.

Эдгээр нийтлэг ба ерөнхий зохицуулалтууд нь тухайн салбарын хүрээнд ижил төстэй асуудлаар өөр өөр шийдэлд хүрэхээс сэргийлж байдаг.

1. Хууль тогтоох үйл ажиллагааг эхлүүлэх:

Энэхүү үйл ажиллагааг эхлүүлэхэд хууль тогтоогч оролцох, үйлдэл хийх шаардлага бий эсэхийг шалгах, одоо үйлчилж буй хууль тогтоомжтой хэрхэн уялдуулах, ямар цаг мөч хамгийн тохиромжтой болохыг тогтоох нь чухал. Тухайлбал:

а) Шинэ хууль батлах шаардлага бий эсэхийг шалгах. Хууль тогтоомжийн тоо, нягтрал ихэсэх явдал хууль тогтоох салбарын үндсэн сэдэв байсаар ирсэн тул хууль тогтоогчийн үйл ажиллагааг анхнаасаа л хамгийн чухал харилцааг хуульчлах үйлдлээр хязгаарлах, аль болох цөөн ба богино хэмжээтэй байхыг шаарддаг. Орчин үед нөхцөл байдал эсрэгээрээ эргэж, хууль батлах давалгаа эхэлсэн. Хууль тогтоомж тогтвортой байж, хэт яарсан, буруу сэдэлт бүхий өөрчлөлтүүдээс сэргийлэх шаардлага зарим салбарт тулгамдсан хэвээр байна. Хуучны хууль ба легитим байдал хоёрын уялдаа холбоо үгүй болсон бөгөөд эх газрын эрх зүйн бүл дэх хууль тогтоох онолын дагуу хуулийн агуулга өөрөө зөвтгөгдөх үндэслэлтэй (легитим) байхаас гадна хууль тогтоох үйл ажиллагааг эхлүүлэх ч мөн зөвтгөгдөх ёстой. Энэ онол нь хууль тогтоогч одоо үйлчилж буй хуулийг шинэчлэх шаардлагатайг харсаар байж, юу ч хийхгүй байх эсвэл хялбархан өөрчлөх хүсэл сонирхолдоо автан хуулийг байнга солих хоёр туйлыг хориглодог. Кодификацийн сэтгэлгээ хөгжих явцад энэ 2 туйл хэрхэн өөрчлөгдсөнийг авч үзье.

Хадгалах элемент. Эхний бүлэгт тусгасанчлан Ромын эрх зүйг шинэчилж, зөрчилдөөнтэй хэм хэмжээ, тодорхойгүй нөхцөлүүдийг арилгах шаардлагаар анхны хувийн эрх зүйн кодификацууд бий болсон. Өдгөө ч гэсэн аливаа шинэчлэлийн эхлэл нь үргэлж үйлчилж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгоход чиглэдэг. Эрх зүйн тогтолцоог агуулгын хувьд шинээр бүтээх явдал уламжлал болж төлөвшөөгүй бөгөөд эрх зүйн шинэтгэлүүд нь өмнөх хууль тогтоомжийг сайжруулахад чиглэдэг. Барууны орнуудад шинэ хуулийн нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөлөл замбараагүй байдал авчрах шууд үр дүнтэй хэмээн өмнөх хуулийг цоо шинэ хууль тогтоомжоор орлуулах хандлагыг дэмждэггүй. Харин аливаа хууль нь нийтийн эрх ашиг, шударга ёсонд харш, эсвэл тодорхойгүй, зөрчилдөөнтэй зохицуулалт агуулсан нөхцөлд шинэтгэл шаардлагатай онцгой тохиолдол хэмээн хүлээн зөвшөөрдөг. Агуулгын хувьд туйлын оновчтой байж болох шинэтгэл ч гэсэн зөвтгөх үндэслэл (легитимац) шаардана.

Шинэчлэх элемент. Шинэчлэх элемент нь хууль тогтоох онолын салшгүй хэсэг биш хэдий ч зарим тохиолдолд чухалд тооцогдож ирсэн. Английн эрдэмтэн Бентам хуулийн хүчин төгөлдөр үйлчилсэн хугацаа түүний үргэлжлүүлэн үйлчлэхийн зөвтгөл болж чадахгүй бөгөөд хуульд өөрчлөлт оруулах явдлыг хууль тогтоох онолын суурь зарчим байх ёстой гэж үзсэн⁹ бол Германд рациональ сэтгэлгээ, үр өгөөжийн асуудлыг авч үзэх болж, практикт гарч буй хэрэгцээ бүрийг хууль тогтоох шаардлага бий болгох эсэхийг нэг бүрчлэн тогтоосон байна.

9 Bentham: Traites de legislation, Band 1, 109.

Эхний багц тохиолдол нь тухайн хууль формал шаардлага хангаагүй эсвэл агуулгын хувьд доголдолтой байхыг хамарна¹⁰. Эрх зүйг шаардлагатай нөхцөлд өөрчлөн зохицуулж болох тогтолцоо хэмээн ойлгох эрх зүйн ухамсар бий болж, улмаар хуулийн насжилт, гарал үүсэл, хүмүүсийн дадал зуршил ач холбогдолгүйд тооцогдон хуулийн бодит зорилго, рациональ сэтгэлгээ, цаг үетэй хөл зэрэгцүүлэх шинж чухал шалгуур болжээ. Хоёр дахь бүлэг тохиолдолд хуулийн хийдэл, зөрчилдөөн хууль тогтоох ажиллагааг эхлүүлэх зайлшгүй шалтгаанд тооцогдох¹¹ ба позитив хууль тогтоомжийн онцлог нь заавал хийдэл үүсэх явдал, өмнө оршин байсан ч хууль тогтоох үед хамрагдаагүй нөхцөл байдалд хуулийг зохицуулан өөрчлөх шаардлагатай гэж үзэх багтана. Дараагийн бүлэг тохиолдолд цоо шинэ материаллаг нөхцөл бүрдэх явдал багтана¹². Хууль тогтоох үйл ажиллагаа өөрчлөгдсөн нөхцөл байдалд нийцэх шаардлага нь 19, 20-р зууны хууль тогтоох онолын чухал шалгуур болсон.

б) Одоо үйлчилж буй хууль тогтоомжтой холбох. Хууль тогтоох онол нь хууль тогтоогчийг одоо үйлчилж буй хууль тогтоомжоос ангид хамааралгүй үйл ажиллагаагаа явуулах боломж олгосон ч гэсэн энгийн хууль эсвэл кодификаци батлахын аль алинд нь хууль тогтоогч үйлчилж буй хууль тогтоомж дээр ажиллахаас үйл ажиллагаагаа эхэлдэг. Энэ шалтгааны улмаас хууль тогтоогчийн үйл ажиллагааны цар хүрээ тухайн үеийн хэрэгцээ шаардлагаар тогтоогдоно гэж үзэх болсон. Өөрөөр хэлбэл үйлчилж буй хууль тогтоомжийг гагцхүү шаардлагатай хэмжээгээр л өөрчлөх нь зүйтэй. Харин кодификаци батлах гэж буй хууль тогтоогч нь “*tabula rasa*” буюу оргүй хоосноос эрх зүйн тогтолцоог бий болгох учиргүй. Тэрээр байгаа хууль тогтоомж дээр ажиллах ёстой ба үнэхээр өөрчлөлт шаардлагатай хэсэгт л үүргээ хэрэгжүүлнэ. Энэхүү үйл ажиллагааг эхлүүлэхэд тавигдах онол арга зүйн шаардлага нь кодификаци батлахын өмнө эрх зүйн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, эрх зүйн зарчим ба институт бүрийг нийгмийн харилцаанд тохирч буй эсэхэд үнэлэлт өгч, өөрчлөх шаардлагатай. Хуулийн шинэтгэлийг нийгмийн амьдралд үнэхээр шаардлагатай нөхцөлд л хийж байх шаардлага нь өмнөх хуультай нягт холбоотой ажиллахыг хууль тогтоогчид тулгаснаараа “*tabula rasa*” буюу огт байгаагүй кодификацийг батлахаас сэргийлэх, өмнөх хуулиа өөрчлөгдсөн нөхцөл байдалд тохируулан тууштай хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг онцлогтой. Энэ зарчмын дагуу кодификацийн сэтгэлгээнд багтах сонгодог ИХ-иудыг батлахад /ZGB, BGB/ өмнөх хуулиудад нарийн дүн шинжилгээ хийх ажил голчилж, тэдгээрийг шинжлэх ухааны түвшинд эмхэтгэх, системчлэх аргаар тэдгээрийн зүйл заалтыг бүрдүүлсэн.

в) Хууль тогтоох зохимжтой цаг үеийг тодорхойлох нь. Хууль тогтоох шаардлагатай гэж үзсэн бол батлах тохиромжтой цаг хугацааг тодорхойлно. Энэ нь 2 үндсэн аспектаас хамаарна. Тухайлбал хууль тогтоогчийн үйл хөдлөл хууль зүйн шинжлэх ухаан болон шүүхийн практикийн хөгжлөөс хэр шалтгаалахыг тогтоох; нөгөө талаас энэ цаг мөчийг тодорхойлох чухал хүчин зүйл нь тухайн улсын гадаад, дотоод аюулгүй байдал байдаг. Английн судлаач Бэкон хууль тогтоомжийн консолидац хийх цаг хугацаа нь шинжлэх ухаан, техник болон практикийн хөгжил өндөрт хүрсэн нөхцөлд тохиромжтой гэсэн бол Савигни мөн хувийн эрх зүйг кодификацжуулах оновчтой цаг мөчийг судалж, эрх зүйн баталгаат байдлыг бий

10 Mohl, Robert von: Politik (Staatsrecht, Voelkerrecht und Politik), Tuebingen 1862, Band 1, S.421

11 Mohl, Robert von: Politik (Staatsrecht, Voelkerrecht und Politik), Tuebingen 1862, Band 1, S.427.

12 Mohl, Robert von: Politik (Staatsrecht, Voelkerrecht und Politik), Tuebingen 1862, Band 1, S.420

болгох явдал хуулийн дээд зорилго хэмээгээд энэ нь эрх зүйн нийтлэг зарчим болон ухагдахууны уялдаа холбоог нарийн таньсны дараа сая боломжтой гэж үзсэн¹³. Хувийн эрх зүйн салбарт эдгээр уялдаа холбоо тодорхойгүй нөхцөлд аль нэг салбарыг системчлэх боломжгүй, дан ганц энгийн хууль батлах явдал өмнөх хуулийн алдаа дутагдлыг засах зорилготой нөхцөлд хангалттай юм.

2. Шинэ хууль бэлтгэх:

МУ-ын Засгийн Газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59-р тогтоолоор хууль тогтоомж батлахад мөрдвөл зохих аргачлалыг баталсан байдаг. Хууль тогтоомжийн тухай хуулийн §12.1-ийн хүрээнд “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ыг 1 дүгээр, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг 2 дугаар, “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг 3 дугаар, “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ыг 4 дүгээр, “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх аргачлал”-ыг 5 дугаар, “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг 6 дугаар хавсралтаар тус тус баталжээ¹⁴.

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлохдоо хууль тогтоогч нь 1/. нийт эрх зүйн харилцаанд оролцогсдын хооронд үүсэж буй бодит амьдрал дээрх харилцааг судлах ба 2/. одоо үйлчилж буй хуулиа шийдвэрийнхээ үндэслэл болгож, 3/. шаардлагатай нөхцөлд гадаадын хууль тогтоомжтой харьцуулалт хийж, рецепцийн асуудлыг шийдвэрлэх ба 4/. шинэ зохицуулалтын одоо үйлчилж буй хууль тогтоомжид хэрхэн нөлөөлөхийг шалгаж, улмаар эрх зүйн цэвэрлэгээ хийдэг.

Монгол Улсад хууль тогтоомжийн системчлэлийн асуудал яригдаж, багц хууль батлах хандлага бий болсон ч багцад хамаарах хууль тогтоомжийн хоорондын системчлэл нь кодификацийн түвшинд хүрэхгүй, мөн хуулийн зөрчилдөөнийг шийдвэрлэх хангалттай арга хэрэгсэл болж чадахгүй байна. Хувийн эрх зүйн салбарт нэлээд олон хууль тогтоомж батлагдсан бөгөөд тэдгээрийг ИХ-тай ямар харилцан хамааралд орших нь төгс шийдвэрлэгдээгүй, мөн аж ахуй эрхлэгчид хамаарах хууль тогтоомжийг системчлэх зорилгоор Арилжааны хууль батлах шаардлагатай гэж үздэг¹⁵. Энэ хүрээнд:

- 1/ ИХ-иа задлан, кодификацийн шинжийг үгүйсгэх буюу хэрэглэгч, аж ахуй эрхлэгч, иргэний асуудлыг тус бүрчлэн ердийн хуулиар зохицуулах эсвэл
- 2/ ИХ-д нэмэлт өөрчлөлт оруулах замаар аж ахуй, бизнесийн үйл ажиллагааг илүү оновчтой зохицуулах, эсвэл
- 3/ Гол эрх зүйн салбаруудыг дэлгэрүүлэн зохицуулж, тусгайлсан кодификацийн аргаар системчлэх 3 сонголт бий.

Аль ч сонголтыг хэрэгжүүлсэн бусад хамаарал бүхий хуулиудтай багц хууль болгон эмхэтгэх боломж нь нээлттэй. Харин шинэтгэлийн хүрээнд өдгөө үйлчилж буй ИХ-д нэг бүрчлэн дүн шинжилгээ хийж, улмаар эдийн засаг нийгмийн харилцаанд шаардагдах ямар зохицуулалт дутагдаж буйг нь эхлээд тодорхойлох шаардлагатай.

13 Savigny: Beruf, S. Mertens.

14 Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтыг үзэх, legalinfo.mn

15 Ханс Зайделийн Сан: Арилжааны хуулийн төслийн тандан судалгаа, <https://mongolia.hss.de/mn>

Б. 2002 оны Иргэний хуульд хийсэн бүтцийн анализ

I. ИХ-ийн ерөнхий бүтэц, агуулга:

МУ-ын 2002 оны ИХ-ийн системчлэлийг авч үзвэл нийт I-VI хэсгээс бүрдэх ба эдгээрээс уг хуулийн тогтолцоог тод харж болно. Тухайлбал 1/.ерөнхий анги буюу нийтлэг үндэслэлүүд, ИХ-ийн §§1-185; 2/.үүргийн эрх зүйн нийтлэг зохицуулалт, ИХ-ийн §§186-242; 3/.гэрээний эрх зүй, ИХ-ийн §§243-486; 4/.гэрээний бус үүрэг, ИХ-ийн §§487-514; 5/. өвлөх, ИХ-ийн §§515-538; 6/. олон улсын иргэний эрх зүй, ИХ-ийн §§539-552 гэсэн хэсгээс бүрдэнэ. МУ-ын ИХ нь ерөнхий ангийн техникийг ашигласан нийтлэг зохицуулалт хэмээх нэгдүгээр бүлэгтээ иргэний эрх зүйн хэлцэл, төлөөлөл, хөөн хэлэлцэх хугацаа зэрэг ерөнхий агуулга бүхий зохицуулалтаас гадна эд юмсын эрх зүйг хамарсан гадаад бүтэцтэй. Энэ хэсэг нь нийт хувийн эрх зүйн түвшинд объект, субъектийг тодорхойлсон, нийтлэг зарчмын шинжтэй хэм хэмжээ агуулж буй нь ИХ-ийг хувийн эрх зүйн үндсэн кодификаци гэж үзэх үндэслэл болдог¹⁶.

ИХ-ийн II хэсэгт үүргийн эрх зүйг зохицуулсан. Энд (ИХ-ийн §§186–242) үүргийн эрх зүйн ерөнхий анги, харин ИХ-ийн III хэсгээс тусгайлсан үүргийн буюу гэрээний зохицуулалт тус тус тусгагджээ. Нийтлэг журмыг ийнхүү зохицуулах явдлыг ИХ-ийн ерөнхий ангид чанд баримталсан бол үүргийн ерөнхий ангийн зохицуулалт нь мөн давхар хаалтын аргачлалаар бүтсэн, бусад бүлэгт нийтлэг үйлчлэх шинжийг агуулдаг. Харин IV хэсэгт гэрээний бус үүргийн эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан. Гэрээний болон гэрээний бус үүрэг нь үүргийн эрх зүйн тусгай ангийг бүрдүүлж байна. Хуулиас үүдэх үүрэг ба үүргийн ерөнхий ангийн холбоосыг тодруулбал ИХ-ийн §194-т “үүргийн шинж чанарт харшлахгүй бол гэрээний бус үүргийн харилцаанд гэрээний үүргийн холбогдох журмыг хэрэглэж болно” хэмээн заасны дагуу үүргийн зарим зохицуулалт нь гэм хорын эрх зүйн хувьд мөн ерөнхий зохицуулалтын чиг үүргийг гүйцэтгэдэг. Эдгээрээс үзвэл МУ-ын ИХ нь ерөнхийгөөс тусгай руу шилжсэн бүтэцтэй, энэ тогтолцоо үүргийн эрх зүйн салбарын хувьд ч нэгэн адил үйлчилнэ.

ИХ-ийн V хэсэгт өвийн эрх зүйг (ИХ-ийн §§515-538) зохицуулсан. Энд аливаа этгээд насан эцэслэсэн нөхцөлд хувийн хөрөнгийг хэрхэх тухай (өмчийн эрх зүйн шинжтэй) эрх зүйн үр дагаврыг агуулсан бие даасан салбар болж, тусгайлсан кодификацийн нэг бүлэг номтой дүйцэхүйц практик чиг үүргийг хэрэгжүүлж байна. Энэхүү салбарыг нэг талаас хуульд зааснаар өвлөх, нөгөө талаас хэлцлийн үндсэн дээр буюу гэрээслэл, өвийн гэрээний тусламжтай өвлүүлэх гэсэн хоёр бүлэгт хувааж үзнэ.

Олон улсын хувийн эрх зүй нь хил дамнасан эсвэл эрх зүйн харилцаанд оролцогсад нь өөр улсад харьяалагдах зэрэг гадаадын хууль тогтоомж нэгэн адил ач холбогдолтой нөхцөлд хэд хэдэн улсын хууль тогтоомжоос алийг нь хэрэглэхийг сонгох тухай зөрчилдөөнийг шийдэх хэм хэмжээ (ИХ-ийн §§538-552) агуулсан ерөнхий нийтлэг хэм хэмжээний шинжтэй. Аль улсын материаллаг эрх зүйн хууль тогтоомжийг шүүх хэрэглэж, хэрэг маргааныг шийдэхийг тодорхойлох энэ чиг үүрэг нь нийт хувийн эрх зүйн кодификацийн хэрэглэгдэх хүрээ нээгдэх эсэхтэй холбоотой.

16 Б.Буянхишиг, Хувийн эрх зүйн кодификаци, харьцуулалт, 2021 он.


II. 2002 оны ИХ-ийг либерал загварын ИХ-ийн бүтэцтэй харьцуулах нь:

1990-ээд оноос эхэлсэн улс төрийн шинэтгэл нь социалист эрх зүйн тогтолцооны бүтцийн элементүүдийн дийлэнхийг нь өөрчилсөн. Эрх зүйн шинэтгэл нь тодорхой үе шаттай хийгдэж, ИХ-ийн үг хэллэг, найруулга зэргийг өөрчилж, баруун Европын иргэний хуулиудтай адил жишиг бүхий гэрээний болон гэрээний бус үүргийн эрх зүйг боловсруулсан ч социалист ИХ-ийн бүтэц, хуулийн техникээ хадгалж үлдсэн байдаг. Энэ нь 2002 оны ИХ-ийг кодификацийн сэтгэлгээний уламжлалд хамаатуулахгүй, постсоциалист ангилалд багтаан үзэх бүтэц, системийн онцлогийг бүрдүүлдэг.

Либерал загварын томоохон бүлэг болох кодификацийн сэтгэлгээний гэх ИХ-иуд нь 18-19-р зуунд батлагдсан Францын ИХ (Code Civil), Германы ИХ (BGB), Швейцарийн ИХ (BGB), Австрийн ИХ (ABGB), Италийн ИХ (Codice civile) билээ¹⁷. Эх газрын эрх зүйн үндсэн төлөөлөл болсон кодификацийн сэтгэлгээний ИХ-иудад дараах ижил төстэй бүтцийн элементүүд бий. Үүнд 1/. нийтлэг үндэслэл (гол зорилго нь хувь этгээдийн эрх зүйн байдлыг тодорхойлох); 2/. үүргийн эрх зүй (гэрээний болон гэрээний бус); 2/. эдийн болон эдийн бус баялгийн эрх зүй; 3/. өвийн эрх зүй гэсэн үндсэн салбарууд багтсан. Эдгээр ангилал тус бүрд нь ИХ-ийн тулгуур үзэл баримтлал агуулагдаж, өөр хоорондоо кодификацийн аргаар холбогдсон байдаг. Францын ИХ (Code Civil) нь формал тэгш эрхийн зарчимд суурилсан, улмаар хувийн өмчийн анхдагч тогтолцоо, гэрээний эрх чөлөө, үүрэг зөрчсөний улмаас хариуцлага хүлээх зарчим нь бүх нийтэд тэгш үйлчлэх шинжтэй, рациональ бүтэц бүхий хууль болсон. Энэ зарчмуудыг агуулсан, мөн цаг хугацааны хувьд Францын ИХ (Code Civil)-тэй ойролцоо батлагдсан дээрх 6 улсын ИХ-ийг кодификацийн сэтгэлгээнийх гэх ба хууль тогтоох кодификацийн онолын үндсийг бүрдүүлнэ. Түүнчлэн эдгээрт хэрэглэсэн бусад хуулийн техник, системчлэл нь тодорхой эрх зүйн бүлийг бүрдүүлэгч хүчин зүйл болж байна.

МУ-ын ИХ нь бусад улсуудын нэгэн адил эдгээр зарчмуудад суурилсан мэт, мөн агуулга бүтцийн хувьд дээрхтэй ойролцоо төстэй. Гэсэн хэдий ч аливаа ИХ-ийг кодификацийн сэтгэлгээний уламжлалд багтаах, тэдгээрийн рецепцийн түүхэнд хамаатуулан судлах нь зүй ёсны үзэгдэл биш юм. Ялангуяа социалист ИХ бүхий улс орнууд “эх газрын эрх зүйн уламжлалтай” хэмээгээд өнгөн талдаа шүүгчийн тогтоосон бус, формал хууль тогтоомжоо нотолгоо болгон харуулдаг. Гэвч кодификацийн онол нь агуулгын шаардлагатай тул дан ганц хууль тэгш үйлчлэх эсвэл тэгш хандах зарчим зэргийг ИХ-д тунхаглах замаар шууд кодификацийн сэтгэлгээний уламжлалд ИХ-иа хамаатуулах боломжгүй нь олон жишээнээс харагддаг. МУ-ын ИХ-ийг системчлэлийн кодификацийн сэтгэлгээний ИХ-тай ерөнхийлөн харьцуулахад дараах зураглал гарна.

17 Пруссийн улсуудын Үндэсний Ерөнхий Хууль (ALR), Баварийн Улсуудын Кодекс нь Германы ИХ (BGB) батлагдсанаар хүчингүй болсон тул шинэ кодификацийн судлагдахуун болж үлдсэн. Мөн Португалийн ИХ нь цаг хугацааны хувьд дээрх бүлэгт хамаарч болох ч, Францын ИХ-ийн уламжлалд (формаль тэгш эрхийн зарчим) багтаагүйн улмаас кодификацийн сэтгэлгээний түүхэнд багтдаггүй.

Зураг 1. МУ-ын ИХ ба кодификацийн сэтгэлгээний ИХ-ууд

Эдгээрт ашигласан хуулийн техникийг харьцуулан судлахад бүтэц нь чанарын гол үзүүлэлт болдог. Энэ нь тухайн хуулийн зохицуулах зүйлийн цар хүрээгээр тодорхойлогдоно. Хуулийн бүтэц, ангилалд тавигдах шаардлагыг тодорхойлоход тухайн хууль тогтоомжийн дотоод, гадаад бүтэц голлох үүрэгтэй. Хуулийн удиртгал, ерөнхий анги, хавсралт нь бүтцийг тодорхойлох тусгай үзүүлэлтүүд бөгөөд ИХ-ийн хэсэг, бүлэг, нэгж бүр нь кодификацийн бүтцэд тавигдах зарчмын шинжтэй шаардлагуудтай уялдаж байх ёстой. Кодификацийн сэтгэлгээний ИХ-ууд нь МУ-ын ИХ-иас сонгодог ба тусгайлсан кодификацийн аргыг нягт хослуулсан онцлогоороо ялгагдах ба ашиглах хуулийн техник тодорхой байх тусам нь хуулийн хэрэглээ, бусад хуультай уялдаа холбоо нь сайжирдаг. Барууны орнуудад кодификацийн төслийг бэлдэхээс өмнө кодификацийн хөтөлбөр боловсруулж хэвшсэн. Энд хуулийн агуулгын ангиллыг гарчгийн тусламжтай тодорхойлж, бүтцээ гадаад болон дотоод хэмээн ангилж үзнэ. Гадаад бүтцийг судлахад агуулгыг илтгэж чадах гарчиг болон хайсан зүйлээ хурдан олох, бүлэг, ном хоорондын харилцан хамаарал тодорхой байхыг шаардана. Дотоод бүтэц нь аливаа хуулийн дэлгэрэнгүй гарчигтай ижил зарчимтай, ойлгомжтой, бүлэг, ном бүрийг ижил төстэй аргаар тэнцвэржүүлэн таниулсан байх шаардлагатай.

МУ-ын Хууль тогтоомжийн тухай хуулийн §12.1.1-ийн дагуу батлагдсан “Хууль тогтоомжийн төсөл бэлтгэх аргачлал”-д төслийн хүрээнд хуулийн төсөл нь гарчиг, бүтцийн үндсэн нэгж болох зүйл, зүйлийн доторх хэсэг, хэсгийн доторх заалт, заалтын доторх дэд заалт, шаардлагатай бол бүлэг, дэд бүлэг, хэсэг, дэд хэсэг, ангитай байхаар заасан¹⁸.

Өдгөө хамгийн олон салбарыг хамарсан дотоодын кодификаци нь ИХ байх ёстой боловч, үүнд томоохон салбар эрх зүйн түвшинд хөгжвөл зохих номчилсон кодификацийн техник, холбогдох хөтөлбөр зэргийг боловсруулах ажил хийгдээгүй нь БНХАУ зэрэг хөрш орнуудтай харьцуулахад хууль тогтоох онолын хөгжил

сул байгааг илтгэдэг. Хуулийн бүтэц, дотоод ангилалд тавигдах шалгуурыг оновчтой болгох тусам кодификацийн дотоод бүтэц сайжирч, улмаар гадаад бүтцийг мэргэшсэн тусгай хуулийн түвшинд нэгтгэдэг. Дээрхээс үзвэл хувийн эрх зүйн шинэтгэлд юуны өмнө хууль тогтоох онолын ямар хөгжлийг хүсч байгаагаа тодорхойлох нь чухал аж.

1. Системчлэл ба зөрчилгүй байх шаардлага. Эхэн үеийн кодификацуудын агуулга нь ИХ-ийн гадаад бүтцийг тодорхойлох хүчин зүйл болж, ерөнхий ангиллыг өргөжүүлэн дэлгэрүүлэх хандлагатай, үүнийгээ ашигласан ухагдахуунтай нэгтгэн нийтлэг зохицуулалтын түвшинд бэлтгэгдэж байсан тул хууль хэрэглэгч болон практик дахь хуульчдад зориулсан заавар ихээр агуулж байв. Улмаар 19-р зуунд хууль тогтоох онол өөрчлөгдөн хувьсаж, кодификацийн системт бүтцийг эрх зүйн сурах бичигт тусгах төдий байдлаар бус, илэрхий бие даасан шинжтэй ангилалт хийх, мөн хуулийн эх текстээс гадуур, дан хуулийн бүтцэд хамаарах эсвэл эрх зүйн үр дагавар шууд агуулаагүй заавар зөвлөгөө өгсөн зохицуулалт тусгах болсон. Хууль тайлбарлах хориг суларснаар хууль тогтоогч болон хууль зүйн шинжлэх ухааны чиг үүрэг өөрчлөгдөж, хууль тогтоогч тодорхой системт тогтолцоонд суурилах болсон ч шинжлэх ухааны ололтыг ашиглах эсэхээ шийдэх бололцоо бүрдсэн. Ямартай ч уг тогтолцоогоо гадагш чиглүүлэх эсвэл системээ өөрийг нь хуульчлах байдлаар шинжлэх ухааны салбар луу халих эрхгүй болж, ерөнхий ойлгомжтой байх шаардлагад нийцүүлэхийн тулд шинжлэх ухааны танин мэдэхүйн үндсэн дээр хуулийг системчилсэн бүтцэд оруулах ёсгүй; харин материаллаг эрх зүйн салбарыг дагуулан практик амьдралын хүрээгээр ангилах боломжтой хэмээн үзэх болжээ.

Аливаа кодификацийн хүрээнд хуулийн зүйл заалтын дотоод холбоо, харилцан хамаарлыг нарийн дэгд оруулах нь чухал арга бөгөөд улмаар логик бүтцэд шилжүүлэхийг шаарддаг. Өөр хуулийн заалтын агуулгыг мэдсэн нөхцөлд л ойлгомжтой болохуйц зүйл заалтын өмнө энэ төрлийн заалтыг оруулах ба энд ерөнхий зохицуулалтаас тусгай зохицуулалт руу шилжих дарааллыг баримтална. Хувийн эрх зүйн институтыг зохицуулахдаа жишээлбэл цар хүрээг нь илтгэх ерөнхий зохицуулалт эхэндээ байх шаардлагатай бол араас нь гарах үр дагавар тус бүрээр ялгагдах хэм хэмжээг тусгадаг.

2. МУ-ын ИХ-ийн гадаад бүтэц. Кодификацийн дотоод бүтцээс гадна түүний гадаад бүтэц нь хууль хэрэглэгчид зохицуулалтын агуулгыг ойлгомжтой болгох чиг үүрэгтэй. Эх газрын болон нийтлэг эрх зүйн уламжлалд гадаад бүтцийг эрс ялгаатай тэмдэглэж ирсэн. Кодификацийн гадаад бүтцэд ном, бүлэг, хэсэг, гарчиг, догол мөр, зүйл гэх мэт үзүүлэлтүүд багтана. Дотоодын хуулийн төсөлд тавигдах ерөнхий шаардлагыг авч үзвэл ердийн нөхцөлд гарчиг, зүйл, зүйлийн доторх хэсэг, хэсгийн доторх заалт, заалтын доторх дэд заалт, шаардлагатай бол бүлэг, дэд бүлэг, хэсэг, дэд хэсэг, анги хэмээн задрах бөгөөд эдгээр нь МУ-ын ИХ-ийн бүтцийг тодорхойлж байна. Орчин үед хуулийн зүйл заалтыг тус бүрд нь гарчиглах аргаар хуулийг хүн бүрд ойлгомжтой болгохыг зорьсон. Энэ нь хуулийн заалтын агуулгын нөхвөр болж, мөн хэт нуршихаас сэргийлдэг.

Харин тусгайлсан кодификацийн хүрээнд нэгдсэн нийтлэг нэр томьёог ашиглахын зэрэгцээ бүтцийг бий болгох зэрэг шалгарсан аргуудыг түлхүү ашиглана. Хууль тогтоох онолын энэхүү үр дүн нь тусгайлсан кодификацид нэгэн адил хамаарна. Кодификацийн гадаад бүтэц дотоод бүтэцтэйгээ нэгэн адил хууль

хэрэглэгчид ойлгомжтой ангилал, тогтоцтой байх ёстой. Мөн гадаад бүтэц нь ч мөн нэгдмэл, ойлгоход хялбар найруулгатай байна.

Тусгайлсан кодификацийн аргаар бүтсэн ИХ-иудын гадаад бүтцийг авч үзвэл ном, түүний нэр буюу гарчиг нь систечлэх үндсэн үүрэгтэй. Бүх хууль өөрийн гэсэн нэр буюу гарчигтай байх нь тодорхой ч эдгээр нь хуулийн албан найруулга, үг хэллэгт хамаарах тул хууль тогтоогч бүхэлд нь батлах шаардлагатай. Хуулийн гарчгийг зарим улсад хуулийн төслийн хоёр дахь уншилтын явцад хэлэлцүүлдэг. Агуулгын хувьд тухайн хуулийн зүйл заалттай дүйж байх шаардлагатай. Тиймээс гарчгийн чиг үүргийг хуулийн заалтын агуулгыг аль болох хураангуй богино хэлбэрээр толилуулагч хэмээн ойлгодог. Ном ба түүний зохицуулалтын агуулгыг авч үзвэл хувийн эрх зүйн нэлээд бие даасан тусгаар хэсгүүдийг төлөөлөх ба кодификацийн хөтөлбөрт тусгасанчлан ном бүхэн өөрийн гэсэн тодорхой агуулгатай байж, тэдгээр нь нийт кодификацийн системт тогтолцоог бүрдүүлнэ. Түүнчлэн энд ном буюу бүлгийн тэнцвэртэй байдлын тухай хөндөх ёстой. Кодификацийн ном, бүлгүүд тус бүрнээ бие даасан салбарыг эрх зүйн түвшинд зохицуулах хүчин чадалтай; тэдгээрийн тэнцвэртэй байдлыг хангах гэдэгт гадаад төрхийн хувьд ижил түвшинд хүргэхийг ойлгоно. Тухайлбал Германы ИХ-д гэр бүлийн болон өвийн эрх зүй бусад гэрээний болон гэрээний бус үүргийн эрх зүйтэй тэнцвэрт байдалд оршиж байна. Тэгвэл МУ-ын ИХ-нд бүхэл бүтэн салбар эрх зүйн тэнцвэрийг хадгалаагүй болох нь тус хуулийн бүтэц, зүйл заалтын тоо, агуулгаас илхэн харагддаг. МУ-ын өвийн эрх зүйн зохицуулалтыг ИХ-ийн §§515-538-д нийт 23 орчим зохицуулалтад багтаасан бол ХБНГУ-ын ИХ-д гэр бүлийн ба өвийн салбарууд бие даасан ном буюу тус бүрнээ 300 орчим зүйл заалтаас бүрдэж, гэрээний эрх зүйтэй харьцуулахад туйлын тэнцвэртэй бие даасан салбарыг бүрдүүлж байна .

Ерөнхийгөөс тусгай руу шилжих зарчим нь дотоод бүтцийн хувьд тавигдах шалгуур бөгөөд гадаад бүтцээр биеллээ олно. Гадаад бүтцийг сайжруулах зорилгоор урт хугацааны туршид хууль бэлтгэх үйл явц үргэлжлэх ч кодификацийн гадаад бүтцийг хадгалах нь тусгайлсан кодификацийн гол бэрхшээл юм. ҮХ-д аливаа салбарыг кодификацжуулах тухай тусгах явдал нь ардчиллын онолын үүднээс мөн л суурь хуулиудын загварын нэгэн адил эргэлзээтэй; ийнхүү баталгаажуулаагүй нөхцөлд кодификацийн зохицуулах хүчин чадал бага байна. Энд хугацаа дууссанаар кодификаци хүчингүй болох интеграцийн заалтуудыг ашиглах нь зүйтэй. Энэ загвар нь зохицуулах чиг үүргээ баталгаажуулж чадахгүй ч гэсэн өмнөх хууль тогтоогч хуулийг хүчинтэй хэвээр үлдээхээс сэргийлдэг. Үндсэндээ гадаад бүтцийг хамгаалах эрх зүйн боломж хязгаарлагдмал бөгөөд сайн хууль тогтоомж батлах үүргээ биелүүлэх нь ардчилсан хууль тогтоогчийн зорилготой уялдаатай хэвээр байна.

Либерал загварын ИХ-иуд тусгайлсан кодификацийн аргаар бүтээгдсэн байх ба ИХ-ийн хэсэг тус бүр нь нэг “ном” хэмээн тооцогддог. Харин МУ-ийн ИХ нь хэсэг, дэд хэсэг, бүлгийн зохион байгуулалттай байгаа нь сонгодог кодификацийн загварыг дагуулан бэлтгэсэн буюу сонгодог кодификацийн аргыг ашиглах оролдлого байсныг илтгэдэг.

3. ИХ-ийн дотоод бүтэц. Салбар бүрийн кодификацуудын дотоод бүтэц нь өөр хоорондоо материаллаг агуулгаараа маш их ялгаатай. Гэхдээ хуульд байвал зохих нийтлэг зохицуулалт болон формал шаардлагад нийцүүлсэн дотоод бүтэц, төгсгөлийн зохицуулалтыг нь харьцуулж болно. Нийтлэг зохицуулалтыг аливаа кодификацийн эхэнд хэрэглэхийн сацуу тусгай ангийн бүлэг бүрийн эхэнд ийм

зохицуулалтыг тусгах боломжтой. Энэ хэсэгт юуны өмнө удирдах чиг үүрэг бүхий зохицуулалт болох хуулийн зорилго, зорилт, нэр томьёоны тодорхойлолт, үйлчлэх хүрээг тодорхойлсон зохицуулалт зэрэг хамрагдана. Зарим хууль тогтоомжийн бүлэг бүр удирдах эсвэл чиглүүлэх зохицуулалтаар эхлэх тохиолдол бий. Үүнд хуулийн эсвэл бүлгийн зорилт, үндсэн зарчим, зорилгыг агуулсан хэм хэмжээг ойлгоно. Нэр томьёоны тодорхойлолт нь дотоод бүтцийг хэлбэржүүлэгч элемент байх тул кодификацийн эхэнд тодорхойлолтуудыг багцлан хялбар олох боломжийг бүрдүүлдэг. Гол нь эдгээр нэр томьёог кодификацийн хэд хэдэн хэсэгт ашигласан байх ёстой. Нэр томьёо нь зөвхөн нэг эсвэл цөөн тооны зохицуулалтад тусгагдсан бол эх текстээр тодорхойлох арга илүү тохиромжтой. Энд хэрэглэх хүрээг тодорхойлох аргыг өргөн ашиглах, нийтлэг зохицуулалт дотор аливаа хууль, түүний бүлэг хэсгийг агуулсан зохицуулалт тусгах боломжтой. Нийтлэг зохицуулалтыг тусгай ангид мөн тодорхой хэсгийг хамарсан байдлаар тусгаж болно. Үүндээ тусгай зохицуулалтын хэрэглэх хүрээг тодорхойлно. Гэхдээ МУ-ын ИХ-ийн гэрээний эрх зүйн 2-р дэд хэсгийн адилаар эд хөрөнгө хөлслөх, түрээсийн гэрээ, газрын түрээс гэх мэт хэт олон шаталсан бүтэц үгүй бол тусгай ангийн салбар бүрд энэ аргыг хэрэглэх шаардлагагүй. Дотоод бүтцийг хэлбэржүүлэх явцад хуулийн бүтцийг цааш нарийсган задалсан тохиолдол элбэг байна. Эдгээр нь хуулийн зүйл заалтыг тайлбарлах, хэрэглэх үйл явцыг хялбаршуулна. Төгсгөлийн зохицуулалтыг нийтлэг байдлаар хэрэглэх үзэгдэл нь энэ төрлийн хэм хэмжээг хуулийн бүтэц хэмээх ухагдахуунд хамруулах үндэслэл болж байна. Тухайлбал аливаа кодификаци өөрөө өөрийнхөө хэрэглэх хүрээг зохицуулах нь зохимжгүй шалтгаанаар Швейцараас бусад орны ИХ-д олон улсын хувийн эрх зүйн зохицуулалт тусгагдаагүй, харин Хууль хэрэгжүүлэх тухай хуульд байршжээ.

Либерал ИХ-иуд нь Civil Law гэгдэх энэ хуульд хувь хүний тухай эрх зүйн чухал зохицуулалт болох гэр бүлийн эрх зүй, өвийн эрх зүйн дэлгэрэнгүй зохицуулалт агуулагдаж байж сая “иргэний” хууль болдог гэж үздэг. Тиймээс ерөнхий бүтцийн хувьд кодификацийн сэтгэлгээний ИХ-иуд нь гэр бүлийн эрх зүй, өвийн эрх зүйн маш дэлгэрэнгүй зохицуулалт агуулдаг. Харин МУ-ын ИХ-д гэр бүлийн эрх зүйгээс гагцхүү хөрөнгийн эрхийн асуудлыг ИХ-ийн §§126-130-д тусгаж, бусад иргэн хүний эрх зүйн асуудлыг Гэр бүлийн тухай хуулиар зохицуулсан, мөн хувийн өмчийг хамгаалах, өвлүүлэх үндсэн эрх бүхий өнөөгийн нийгэмд өвийн эрх зүйн зохицуулалт хэлбэр төдий байх ба фискус буюу төр нь холын төрөл садны оронд өвлөх тогтолцоо бүхий социалист хуулийн техникийн илрэл юм. Социалист эрх зүйн уламжлалд гэр бүлийн асуудал нь амин хувийн буюу төрөөс ангид байх салбар учраас тусгай хуулиар зохицуулагдах харилцаа, харин ИХ нь нийгэм эдийн засгийн харилцаанд тулгуурлана гэсэн үзэл баримтлал оршиж байсан нь хожим МУ-ын ИХ-ийн §1.1-д тусгагдаж, ИХ-ийг эдийн засгийн үнэлэмжид суурилсан хууль тогтоомж гэдгийг баталгаажуулсан. Энэхүү социалист хуулийн техникийн улмаас гэр бүлийн эрх зүйг хэт “амины” хэмээн үзэж, ИХ-д тусгахгүй байх шалтгаан болжээ.

Судалгаанд хамрагдсан либерал ИХ-иуд нь дотоод агуулгаа формал хэлбэрээр тодорхойлж, иргэний эрх зүйн хууль тогтоомжид нийтдээ тусгалаа олсон эрх зүйн харилцааг иргэний эрх зүйн зохицуулах зүйл мөн гэж үзэх формал хуулийн техник үйлчилдэг¹⁹. Харин МУ-ын ИХ-ийн §1.1-д “эрх зүйн этгээдийн хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой харилцааг зохицуулна” гэсэн нь нийт нийгмийн харилцаанаас иргэний эрх зүйн харилцааг таслан авч үзэхийг шаардана.

19 Petev, Valentin: Sozialistisches Zivilrecht, 1977, S.17.

Тухайн нийгмийн харилцаа ямар шинжтэй байхыг эрх зүйн түвшинд бүрэн тодорхойлох боломжгүйн улмаас энэ тодорхойлолт өөр хүчин зүйлсийг ашиглахад хүргэх ба үүгээрээ социалист хуулийн техникийн сул талыг өөртөө агуулжээ²⁰. ИХ-иар зохицуулж байж сая аливаа харилцаа иргэний эрх зүйн харилцаа болдог логиктой.

Энд “хөрөнгийн харилцаа” эсвэл “эдийн болон эдийн бус баялгийн харилцаа” гэсэн үг хэллэгийг ашигласан. Гэхдээ энэ нь ч мөн туйлын тодорхойгүй юм. Социалист ИХ нь бүх эрх зүйн субъект хоорондын хөрөнгийн харилцааг, тухайлбал социалист тогтолцоон дахь бүх иргэн, ААН, байгууллага хоорондын эд хөрөнгийн харилцааг хамарч байв. Харин энэ тодорхойлолт нь 1/. эдийн ба эдийн бус баялаг хүн хооронд эрх зүйн харилцаа үүсэж болохгүй гэсэн үзэл онолд тулгуурласан, эд юмсын эрх зүй дэх өмчлөх эрхийн болон бусад хязгаарлагдмал эрхийн асуудлыг оновчтой шийдвэрлэхэд саад болохуйц байна. Мөн 2/. захирах-захирагдах харилцаан дахь хөрөнгийн харилцаанаас иргэний эрх зүйн харилцааг зааглах ялгахад ихээхэн хүндрэл дагуулах ба баялгийн хуваарилалттай холбоотой хууль тогтоомжид /газар гэх мэт/ ялгавартай зохицуулалт тусгахад бэрхшээл үүсгэж, агуулгаар нь захиргааны эрх зүйд хандуулах зэрэг зөрчилд хүргэж байгаа; 3/. хөдөлмөрийн болон үйлчилгээний салбар энэ тодорхойлолтод хамаарч байгаа эсэхээс үл хамааран тусгаарлах болсон үндэслэл нь тодорхой бус учир дутагдалтай.

Энэ асуудлыг шийдэх зорилгоор судлаач Д.Наранчимэг²¹ шинэ ИХ батлагдсан даруй “иргэний эрх зүй нь талуудын эдийн болон эдийн бус амины харилцааг зохицуулдаг” хэмээн тодотгосон ч энэ үзэл нь нийгмийн харилцаанаас эх авсан буюу тодотгох шаардлагатай хэвээр байна. Энэ онол нь өдгөө гэр бүлийн эрх зүй болон хэрэглэгчийн эрх зүйг тусгаарлах гол шалтгаан болдог. Өөрөөр хэлбэл төрийн эрх мэдэл гэр бүлийн эрх зүйн хөрөнгийн бус харилцаанд орж нөлөөлөхгүй тул энэ салбарыг амины харилцаанаас хасжээ. Үүнээс үзвэл МУ-ын ИХ-ийн §1.1 нь ИХ-ийг эдийн засгийн үнэлэмжид суурилсан хууль тогтоомж гэдгийг илтгэж буй социалист хуулийн техникийн илрэл бөгөөд ИХ нь бараа, үйлчилгээг эргэлтэд оруулах хөрөнгийн харилцааг зохицуулсан байна. Хойшид энэ тодорхойлолтыг хадгалж үлдвэл “иргэн, хувь хүнтэй” холбоотой зохицуулалтаа тусгаарласан ИХ-ийг ийнхүү нэрлэх оновчтой эсэхийг судлах шаардлагатай.

Барууны бүрэн либералчлагдсан ИХ-иуд нь дотоод агуулгаа формал хэлбэрээр тодорхойлдог бөгөөд иргэний эрх зүйн хууль тогтоомжид нийтдээ тусгалаа олсон эрх зүйн харилцааг иргэний эрх зүйн зохицуулах зүйл мөн гэж үздэг (агуулгаар зааглах хуулийн техник). Энэ талаар судлаач О.Жамбалдоржийн иргэний эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдсан нийгмийн харилцаа гэсэн тодорхойлолт нь уг хуулийн зохицуулах зүйлээр харилцааг хязгаарласан оновчтой тайлбар болж байна²². Тиймээс ИХ-ийн §1.1 нь захиргааны эрх зүйн маргаанаас иргэний маргааныг ялгах чадваргүйн дээр хувь хүний амины эрх, гэр бүлийн эрх зүйг ИХ-д тусгахад саад болж буй тул ИХ-иар зохицуулах харилцааг шууд нэмж зохицуулан харилцааг хуулийн дотоод аргаар тодорхойлдог техникийг ашиглах боломжтой.

20 Б.Содовсүрэн, Д.Зундуй, БНМАУ-ын Иргэний эрх зүй, 1988 он, 4-5 дахь тал; БНМАУ-ын Дээд Шүүхийн хэвлэл: БНМАУ-ын Иргэний эрх (Товч сурах бичиг), 1966 он, 7 дахь тал.

21 Д.Наранчимэг, Иргэний эрх зүйн үндсэн асуудал, 1999 он, I дэвтэр, 1 дэх тал.

22 О.Жамбалдорж, МУ-ын Иргэний эрх зүй (Ерөнхий үндэслэл), I дэвтэр, 2004 он, 76 дахь тал.

Дээрх жишээнээс бид өмнөх хуулийн ерөнхий ангийн суурь бүтцийг хадгалж үлдэх нь системийг хадгалах элемент болсныг, мөн ИХ-ийн зохицуулах зүйлийг хууль тогтоогч шинээр сонгох боломжтойг ч харж болно. ИХ-ийн өмнөх хуулийн уламжлалыг санаатайгаар хадгалах нь ИХ-ийн “иргэний” шинжийг улам багасгах хүчин зүйл билээ. 2002 оны ИХ-ийн бараа, үйлчилгээг эргэлтэд оруулах хөрөнгийн харилцааг зохицуулсан байдлыг өөрчилж, агуулгаа формал хэлбэрээр тодорхойлох барууны хуулийн техникийг сонгох боломж дараагийн хууль тогтоогчид бий.

4. Кодификацийн бүрэн бүтэн байдал. ИХ нь бусад томоохон кодификацийн нэгэн адил шударга ёсны илрэл болсон дараах 3 үндсэн шаардлагад нийцэх ёстой. Үүнд урт хугацаанд үйлчлэх, хийдэлгүй байх, рациональ сэтгэлгээнд суурилсан байх багтана. Эдгээр шинж чанарыг өөр хооронд нь чанд ялгах, тусгаарлах боломжгүй бөгөөд нэг нь нөгөөгөө нөхцөлдүүлж байдаг. Анх үүнд 1/. зохицуулбал зохих харилцааг аль болох бүрэн хамарсан байх; 2/. одоо үйлчилж буй эрх зүйн бүх хэм хэмжээг хамрах буюу кодификацжуулах (энэ нь позитив бус хэм хэмжээ үйлчлэх орон зай үлдээхгүй байх гэсэн үг); 3/. зохицуулах зүйлийг 1 хуульд хамруулах, хэд хэдэн хуулиар тараахгүй байхыг ойлгож байсан бол өдгөө эдгээр шалгуур нэлээд уян хатан хэлбэрээр үйлчлэх болжээ.

а). Зохицуулбал зохих харилцааг бүрэн хамрах. Кодификацийн сэтгэлгээний бүрэн бүтэн байх идеал зорилго нь зохицуулбал зохих харилцааг аль болох бүрэн хамарсан байх явдал юм. Үүнийг хийдэлгүй байх шаардлага гэж нэрлэж болно²³. Хууль хийдэлгүй байх нь нэг талаас хууль тогтоогчийн бодит зорилт байх боломжтойн сацуу философи сэтгэлгээний хувьд үл гүйцэтгэх идеал зорилго билээ²⁴. Хийдэлгүй хууль тогтоомж батлах идеаль зорилгод “хүрэх”, ойртож очих боломжийн талаар 2 үндсэн үзэл бий.

Кодификацийн сэтгэлгээний эхэн үед зохицуулбал зохих харилцааг ИХ-иар аль болох бүрэн хамруулахыг хичээх, ийнхүү тусгаж амжаагүй тохиолдол илэрвэл хожим үүнийг нэмж зохицуулах замаар хуулиа бүрэн бүтэн болгох боломжтой²⁵. Барууны ИХ-иудад хийдэлгүй байх зорилгод хүрэхийн тулд казуист аргыг ашиглах шаардлагагүй, харин бүгдийг хамарсан ерөнхий хэм хэмжээ бүтээх аргаар л хийдлийг арилгана гэдэг²⁶. Кодификацийн бүрэн бүтэн байдлыг хянах энэхүү шалгуур нь хууль тогтоомж ойлгомжтой, тодорхой байх зорилтуудын хүрээнд тусгасан казуист ба хийсвэрлэлийн аргын харилцан хамаарлыг хөнддөг. Өмнөх үзэл баримтлал нь практикт тохиох бүх асуудлыг зохицуулах зорилгоор өргөн хүрээг хамарч байсан тул тодорхой тохиолдлуудыг ерөнхий зохицуулалтын нөхвөр болгон хэрэглэхийн оронд тэдгээрийн орлуулга болгон хэрэглэсэн сул талтай.

23 Mertens, Bernd. Gesetzgebungskunst im Zeitalter der Kodifikationen, Tuebingen 2004, S.326.

24 Bacon, Francis. De Dignitate et Augmentis Scientiarum, (1623) Stuttgart 1962, Bd.1, Buch 8, Kap.3, Aphorismen 10/32; Wolff, Politik, §412, S.427; Bentham, Specimen of a Penal Code, Table of contents, Note 1, Bowring-Ed., Bd.1, S.164.

25 Wolff: Politik, §412, S.427; Reitemeier: Gesetzeswissenschaft, S.20; Gesetzgebung, S.99. Жишээлэхэд нийт 19194 зүйл бүхий хамгийн том кодификаци болох Пруссийн улсуудын Үндэсний Ерөнхий Хуулиудын (ALR/ General National Law) §§49,50-д хууль тайлбарлахад гарах эргэлзээ ба хуулийн цоорхой хэмээх ухагдахууныг ялгасан ба ийм цоорхой илэрвэл хууль зүйн дээд байгууллагад мэдэгдэх үүргийг зохицуулсан нь бүрэн бүтэн байх итгэл үнэмшил хязгаарлагдмал байсныг илтгэх үзүүлэлт юм. Энэ нь хууль тогтоогч шинэ эрх зүйн харилцаа бий болох магадлал үргэлж байдгийг тооцоолсон, мөн шинээр олсон мэдлэг нь хуучин зохицуулалтаа өөрчлөх, нөхөх шаардлага бий болгодгийг хүлээн зөвшөөрсөн жишээ юм.

26 Feuerbach. Kritik, Teil 1, S.10; Philosophie und Empirie, S.71; Mohl: Politik, Bd.1, S. 429.

Харин хоёр дахь үзэл баримтлал нь санаатайгаар ерөнхийлөх, зарчимд тулгуурлах аргыг ашиглан урьдчилан харах, тоочих боломжгүй тохиолдлуудыг хуулийн зүйл болгохыг зорьсон. Эдгээр 2 үзэл баримтлалын сул ба давуу талыг харгалзсанаар хуулиа нөхөн шинэчилж, цаг үетэй нь хөл нийлүүлэх нь зүйтэй гэж дүгнэхээр байна. Кодификацийн онолд хууль тогтоогч практикт хамгийн чухал хэсгээ өөрөө зохицуулж, бусад эрх зүйн асуудлыг шинжлэх ухаан болон хууль хэрэгчид үлдээхийг дэмждэг. Ер нь кодификаци гэдгийг бүхэл бүтэн эрх зүйн тогтолцооны хийдэлгүй байх шинжтэй хольж ойлгох шаардлагагүй²⁷. Заншлын эрх зүй болон шүүгчийн хууль бүтээх ажиллагаа хосолбол эрх зүйн тогтолцоо бүхэлдээ хийдэлгүй болж, кодификаци хүртэл бүрэн бүтэн болно.

Хийдэлгүй байх шаардлагыг хэт явцууруулах аваас өнөөгийн ИХ, Эрүүгийн Хууль зэргийг кодификаци хэмээн дүгнэх боломжгүй. Иргэний болон эрүүгийн эрх зүйн салбарын чухал зохицуулалтууд гол төлөв тусгайлсан хууль тогтоомжоор зохицуулагдаж, эдийн засаг, нийгмийн хөгжлийг даган эдгээрийн тусгай салбарууд олноор бий болж байдаг. Хийдэлгүй байх гэсэн ойлголтыг хэт туйлшруулахгүй, кодификаци хэмээх ухагдахууныг өргөн хүрээтэй авч үзэх нь чухал. Кодификацийн гол зорилго нь эрх зүйн нэг салбарыг бүхэлд нь хамрах явдал боловч зарим салбар эрх зүйн асуудлыг тусгай хууль тогтоомжид тусгахыг зөвшөөрөхөөс өөр аргагүй. Тухайлбал МУ-ын ИХ нь хувийн эрх зүйн салбарын үндсэн кодификаци байгаа ч оюуны өмч, үнэт цаасны эрх зүйн салбарууд тусгайлсан хууль тогтоомжоор зохицуулагдах нь гарцаагүй. Тиймээс хийдэлгүй байх шалгуурыг өргөн хүрээнд авч үзэх, тусгай зохицуулалт бүхий салбар олноор бий болсон ч ИХ-ийн суурь кодификацийн шинжийг хүлээн зөвшөөрдөг.


б). Эрх зүйн салбарыг бүрэн хамрах шаардлага. ИХ-ийн кодификацжуулалт нь эрх зүйн тогтолцоо эсвэл түүний тодорхой нэг салбарыг бүрэн хамрах зорилгоор нөхцөлдсөн. Хувийн эрх зүйг кодификацжуулах үндсэн зорилго нь бусад эрх зүйн эх сурвалжийг бүрэн устгах явдал бус, харин хувийн эрх зүйн ерөнхий нийтлэг хэм хэмжээг нэгтгэх байдаг. ИХ-д зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгаж, тэдгээрийн агуулгыг нь эрх зүйн шинжлэх ухаан тодорхойлох боломжтой хэмээн үлдээх нь зүйтэй. Өнөө үед харин яг ямар асуудлыг эрх зүйн шинжлэх ухааны мэдэлд үлдээх вэ, ямар асуудлыг шүүгчийн эрх хэмжээнд орхих вэ, ямар асуудлыг заншлын эсвэл жам ёсны эрх зүйд даатгах вэ гэдгээ бодлогын хүрээнд шийдсэн байх шаардлагатай. Энэ шийдлийн дагуу хууль тогтоогчийн зүгээс бэлтгэж буй кодификацийн бүрэн бүтэн байдал гэдгийг уян хатнаар ойлгох нь зүйтэй²⁸.

Тиймээс хувийн эрх зүйн нэлээдгүй салбарыг орхигдуулсан 1926 оны ИХ-ийг МУ-ын хувийн эрх зүйн салбарын анхны кодификаци хэмээн хүлээн зөвшөөрөх хандлага мэр сэр гарч, 1952 оны ИХ-ийг оюуны өмчийн салбараас зохиогчийн эрхийн салбарыг 18, 19-р бүлэгтээ тус тус тусгасан авч оюуны өмчийн бусад салбар байгууллагын дүрэм эсвэл Сайд Нарын Зөвлөлийн тогтоолоор зохицуулагдсан хэвээр үлдсэн нь түүний кодификаци байх шинжийг үгүйсгэх нөхцөл болоогүй. Бүтцийн хувьд 2002 оны ИХ нь 1993 оны ИХ болон социалист эрх зүйн тогтолцооны өмчийн төрөл, хэлбэрүүдийг зүй ёсны мэт хүлээн зөвшөөрч хадгалан үлдсэн боловч хувь хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн ҮХ-ийн хүрээнд хувийн чөлөөт байдлыг дээдлэх зарчмыг хэрэгжүүлснээр өмнөх уламжлалаас бага зэрэг хөндийрч чадсан онцлогтой. 2002 оны ИХ-ийн хамрах хүрээг зургаар үзүүлбэл:

27 Huber, Eugen. Erläuterungen, Heft 1, S.35.

28 Mertens, Bernd. Gesetzgebungskunst im Zeitalter der Kodifikationen, Tuebingen 2004, S.337.

Зураг 2. ИХ-ийн хамрах хүрээ, тусгай хууль тогтоомж



2002 оны ИХ-ийн хүрээнд оюуны өмч, гэр бүл болон хөдөлмөрийн зэрэг салбаруудыг бүрэн тусгаарлаж, ИХ-д хамруулаагүй. Өөрөөр хэлбэл эдгээр салбар нь аливаа кодификацийн хувьд хувийн эрх зүйн ерөнхий зохицуулалт хэмээн тооцогдохгоо больж, тусгайлсан легитимац бүхий тусгай салбарт хамаарах болсон. Зохицуулалтгүй үлдээснээс бусад тохиолдолд ИХ-д тусгах шаардлагагүй хэм хэмжээ гэж үзэх болжээ. 2002 оны ИХ батлах үед МУ-д оюуны өмчийн хууль тогтоомжуудыг дөнгөж батлаад үр дүнг нь хараахан үзэж амжаагүй, Гэр бүлийн тухай хууль, Хөдөлмөрийн хуультай ч Худалдааны хууль байгаагүй тул тухайн үеийн хууль тогтоогч хувийн эрх зүйн дийлэнх салбарыг ИХ-д хамруулах эсэхээ тусгайлан шийдэх ёстой байв. ИХ-ийн үзэл баримтлалын төсөлд эрх зүйн хэм хэмжээний давхардал, хийдлийг арилгах; иргэний эрх зүйн тусгай ба нийтлэг зохицуулалтын зөрчлийг арилгах гэсэн зорилго тусгагдсан²⁹. ИХ-д хамгийн түрүүнд дэлхий нийтийн эдийн засаг, эрх зүйн харилцааны хөгжлийг өөрийн орны хөгжлийн чиг хандлагатай, мөн гэрээний эрх чөлөөг төрийн зохицуулалттай уялдуулах, улмаар оролцогсдын тэгш эрхийг хангах явдал гэжээ. Улмаар хувь хүнд холбогдох гэр бүлийн асуудлыг Гэр бүлийн тухай хуулиар тусгайлан зохицуулсан. Хэрэглэгчийн асуудлыг багахан хэмжээ бүхий Хэрэглэгчийн тухай хуульд тусгасан. Эдгээр нь 2002 оны ИХ-ийг иргэний гэхээсээ эдийн засгийн харилцааны суурь кодификаци гэж үзэхэд хүргэдэг. ИХ-д тусгагдсан хувь этгээд хоорондын гэрээний зохицуулалт нь дангаараа энэ таамгийг үгүйсгэхэд хангалтгүй бөгөөд эдийн засгийн харилцаанд хамаарах суурь зохицуулалт нь өмнөхөн батлагдсан оюуны өмчийн болон хожмын үнэт цаасны эрх зүй, эд хөрөнгийн бүртгэлийн эрх зүйн зарим заалттай давхардах, агуулгын хувьд огтлолцож буй зохицуулалт харьцангуй бага байв.

Дээрхээс үзвэл 2002 оны ИХ нь Civil Law нэртэй л болохоос эдийн засгийн харилцааны суурь кодификаци буюу Арилжааны Кодекс юм. Тийм учраас энд логикийн хувьд Арилжааны Кодексийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа ИХ-иас Арилжааны Хуулийг таслан баталсанаар логикийн хувьд өөр нэртэй боловч эдийн засгийн нэг зорилго бүхий 2 хууль бий болно. Аль ч нөхцөлд ИХ-д иргэний асуудлыг зохицуулах асуудал дутагдаж байгаа нь харагдаж байна. Цахим эринд иргэнд хуулийн ямар хамгаалалт олгох вэ? гэсэн асуулт нь эргээд арилжаа эрхлэгчийн үүрэг ролийг тодотгох тул бизнесийн ёс зүйг дээшлүүлэх суурь асуудал юм. Эдгээр үндсэн асуудлуудад хэрхэн хариу өгч байгаагаар хууль тогтоогч кодификацийн бүрэн бүтэн байдлыг тодорхойлж, өөрөө хууль тогтоох онолоо хөгжүүлж байдаг.

29 А.Доржготов, Б.Амарсанаа, З.Сүхбаатар, МУ-ын ИХ-д холбогдох баримт бичгийн эмхэтгэл (2001-2002), 2018 он, 4 дэх тал.

Дээр дурдсан хувийн эрх зүйн тусгайлсан салбаруудыг хүлээн зөвшөөрөх тусам МУ-ын ИХ-ийн бусад салбар хуулиудтай харилцан хамаарал нь бүдгэрч, тодорхой бус байгаа талаар шүүмж их гарсан. ИХ нь бусад иргэний хууль тогтоомжийн хэмжүүр болох тухай ИХ-ийн §2.1-д заасан нь хувийн эрх зүйн салбар дахь компанийн болон оюуны өмчийн тухай хууль тогтоомж зэрэг системийг бүрдүүлэгч актуудаас ИХ-ийн давуу үйлчлэлийг тогтоох тухай өөр хэм хэмжээгээр зохицуулагдаагүй хэмээн ихээхэн шүүмжлэл дагуулдаг. Нэг талаас кодификацийн бүрэн бүтэн байдал буюу хийдэлгүй байх зарчим нь тусгай хууль тогтоомж оршин байхыг нэгэнт хүлээн зөвшөөрсөн тул ИХ-ийн §2.1-ийг өөрчлөх эсвэл хэрхэн ойлгохыг тодруулах нь ИХ ба бусад хууль тогтоомжийн харилцан хамаарлыг тодотгох үр дагавартай.

III. ИХ-ийн бүтцийн хүрээнд шийдвэрлэх онолын асуудлууд

Асуудал №1: ИХ-ийн хамрах хүрээ ба гадаад/дотоод бүтэц, кодификацийн бүрэн байдал

- ИХ-ийн бүтцийн элементүүдийг эргэж харах, томоохон бүлэг хоорондын тэнцвэрт байдлыг хангах

- Энэ зарчмын хүрээнд ялангуяа Арилжааны Хууль, Хэрэглэгчийг хамгаалах тухай хуулийн шинэтгэл яригдаж байгаа өнөө үед ИХ-ийн хамрах хүрээг эргэн харж, үнэлэлт өгөх шаардлагатай.

1.1. ИХ-ийн бүтцийн элементүүдийг эргэж харах гэдэгт томоохон бүлэг дэд хэсгийг хадгалж үлдэх эсэхээ шийдэхийг ойлгоно. Энэ нь аливаа хуулийн хамрах хүрээгээр буюу агуулгаас тодорхойлогддог жамтай. “ИРГЭНИЙ ХУУЛЬ” нь бүтцийн хувьд иргэн хүний иргэний эрх зүйн харилцаанд оролцох нийтлэг хэлбэрийг цогц байдлаар илэрхийлсэн хэм хэмжээний нийлбэр юм.

Иргэн нь юуны өмнө хувь хүн тул ИХ-д хувь хүний буюу амины эрхийн хамгаалалт тусгалаа олсон байх ёстой.

Иргэн нь ихэвчлэн хувь хүн гэдэг утгаараа иргэний гүйлгээнд орох тул юуны өмнө хэрэглэгч бөгөөд хэрэглэгчийн хамгаалалт ИХ-д тусгагдсан байх ёстой. Иргэн хүнд холбоотой хэрэглэгчийн хамгаалалтыг оновчтой тусгах, иргэний амин чухал эрхийг агуулсан гэр бүлийн эрх зүйн үндсэн зохицуулалтаар баяжуулах, арилжааны хэлцлийн бүлэг хэсгийг тусгаарлах, найруулах, өмчийн буюу эд юмсын эрх зүйн системчлэлийг оновчтой болгох, зарчмын шийдлүүд багтана.

Иргэн нь хувиараа аж ахуй эрхэлж /ҮХ-ийн 16.3/ иргэний гүйлгээнд оролцох ба ИХ-ийн тусгай ангид заасан аль гэрээний харилцаанд тал болж байдаг. Гэтэл түүний энэ бодит шинжийг ерөнхий ангид дурдаагүй учир иргэн ААЭ эсвэл хэрэглэгчийн хувиар хариуцлага хүлээх нөхцөлийг ялгамжтай зохицуулалтгүй байна.

Жишээлэхэд ХБНГУ-д ИХ-с гадна Арилжааны хууль үйлчилж байгаа ч ИХ-ийнхаа эхэн хэсэгт хувь этгээдийг тун ялгамжтай зохицуулсан. Энэ нь хожим байгуулж буй гэрээнд нь зохих хамгаалалтыг ялгамжтай тусгах нөхцөлийг бүрдүүлдэг.

ХБНГУ-ын ИХ-ийн Нэгдүгээр ном. Ерөнхий анги - Нэгдүгээр бүлэг. Хувь этгээд
Гарчиг 1. Иргэн, хэрэглэгч, аж ахуй эрхлэгч

§ 1. Эрх зүйн чадвар эхлэх. Хувь хүний эрх зүйн чадвар төрсөн үеэс эхэлнэ.

§ 2. Насанд хүрэх. 18 нас хүрсэн үеэс аливаа этгээдийг насанд хүрсэн гэж үзнэ.

§ 13 Хэрэглэгч. Хэрэглэгч гэдэгт аливаа хэлцлийг хийдээ аж ахуйн үйл ажиллагаа голлон эрхлэх эсвэл бие даан мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зорилго агуулаагүй иргэн, хуулийн этгээдийг ойлгоно.

§ 14 Аж ахуй эрхлэгч. (1) Аж ахуй эрхлэгч гэдэгт аливаа хэлцлийг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх эсвэл бие даан мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зорилгоор хийж буй иргэн, хуулийн этгээд болон эрх зүйн чадамжтай хувь хүмүүсийн нэгдлийг ойлгоно.

2. Эрх зүйн чадамжтай хувь этгээдийн нэгдэл нь бие даан эрх олж авах, үүрэг хүлээх боломжтой байна .

Дээр дурдсанчлан ИХ нь арилжааны эрх зүйн харилцааг түлхүү зохицуулахад анхаарсан тул системийн хувьд арилжааны эрх зүй зохицуулагдаагүй эсвэл хагас дутуу байна гэж үзэх үндэслэлгүй юм. Харин хуулийн шинэчилсэн найруулгын түвшинд засаж болох хэд хэдэн асуудал байгааг дурдах нь зүйтэй. Үүнд:

МУ-ын эдийн засгийн салбарт арилжаа эрхлэгч нь гол төлөв зохион байгуулалтад орж амжаагүй хувь хүмүүс байгаа бодит байдал нь компанийг үндсэн арилжаа эрхлэгчээр тодорхойлсон эрх зүйн бодит байдлаас ялгагдаж байна. ИХ-ийн ерөнхий ангийн “хувь этгээдийн эрх зүйн байдлыг” тодорхойлсон зохицуулалтууд нь дээрх гэрээг байгуулан үйл ажиллагаа явуулдаг арилжаа эрхлэгчийг тодорхойлоогүй³⁰. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд ИХ-ийн харилцаанд оролцогчийн тухай хэсэгт арилжаа эрхлэгч, хэрэглэгч 2-ыг ялгах зохицуулалт оруулах шаардлагатай. Хувь хүн ба хуулийн этгээд гэсэн оролцогчоор хязгаарласан нь эрх, үүргийн бодит тогтолцоонд нийцэхгүй. Арилжааны Хуулийг тусгайлан баталсан ч ИХ-ийн ерөнхий ангид энэ нь агуулгын хувьд тусгалаа олсон байх нь чухал.

Бизнесийн ёс зүй нь ИХ-д хэд хэдэн газар тусгалаа олсон харилцан итгэлцлийг хамгаалах зарчим, гүйгээг хөнгөвчлөх арга механизмаас гадна эцсийн хэрэглэгчтэй харилцах дүрэм журам тодорхой байх нөхцөлд тэнцвэртэй хөгжиж байдаг. Тиймээс хэрэглэгчид хандсан гэрээний нөхцөлийг тодруулах, дэлгэрүүлэх буюу хэрэглэгчийн хамгаалалтыг ИХ-д тусгах шаардлагатай. Эрх зүйн түүхээс үзвэл хэрэглэгчийн асуудлыг ИХ-ийн тухайн харилцаа үүсч байгаа зохицуулалттай хамт тусгахгүй нөхцөлд огт хэрэгжихгүй байгаа.

Өдгөө хууль батлах үйл явцыг УИХ-ын сонгуульт хугацаанд багтаахын тулд эдгээр холбоо бүхий хуулийг тус тусад нь бие даасан хууль болгон батлахыг илүүд үзэж байна. Харин кодификацийн бүрэн бүтэн байдлыг хангах зарчим нь ИХ буюу Civil Law дор хаяж иргэний холбогдолтой зохицуулалтыг нэг хуульд багтаан зохицуулахыг шаардана. Тухайлбал үүнд хувь хүн хэрэглэгч байхтай холбоотой хамгаалалт бүхэлдээ багтаж байдаг. Тиймээс хэрэглэгчид хамаарах хамгаалалтыг гэрээний эрх зүйд хэрхэн тусгах талаар саналыг гэрээний эрх зүйд хамаарах хэсгээс үзнэ үү.

Хууль тогтоомжийн агуулгыг тархаан байршуулах, нэг асуудлыг хэд хэдэн талаас нь зохицуулсан хууль тогтоомжийн зөрчилдөөн, хэрэглэх хүрээг нь зааглах ярвигтай асуудал гарах тул тодорхой салбарыг нэг хуулиар багтаан зохицуулах шаардлагыг бий болгодог³¹. Энэ шаардлага нь нэг агуулгаар гарсан зохицуулалтыг анхааралгүй шинээр зохицуулалт бэлтгэж, хэм хэмжээний өрсөлдөөн, бөөгнөрлөөс

30 Б.Амарсанаа, Монгол Улс, Япон Улсын хууль тогтоомжийн хөгжил: Худалдаа (арилжааны эрх зүй), 2017 он, 51 дэх тал.

31 Mertens, Bernd. Gesetzgebungskunst im Zeitalter der Kodifikationen, Tuebingen 2004, S.344.

сэргийлэх зорилготой. Өмнөх хуулийн агуулгатай ижил агуулга бүхий шинэ хууль ихээр баталбал тэдгээрийн хэрэглээг зааглахад бэрхшээлтэй болох ба эдгээрийн зөрчилдөөнөөс болж холбогдох этгээдийн эрх зүйн байдлыг тодорхойлох боломжгүй нөхцөл үүсэж, товчоор хууль тогтоомжийн тоо ихсэх хандлагыг хянах боломжгүй болно. Зөрчилдөөнийг шийдвэрлэх боломжгүй нөхцөлд л тус салбарыг ахин кодификацижуулах буюу “цэвэрлэгээ хийх” шаардлага гарах ба агуулга нь огтлолцож буй хууль тогтоомжийг багцлан хэрэглээний багц хууль зэргээр нэгтгэх нь эрх зүйн цэвэрлэгээ хийх оролдлого болдог.

Австрийн ИХ /ABGB/, Германы ИХ /BGB/, Швейцарийн ИХ-ийг /ZBG/ батлагдах үед эдийн засаг, иргэний нэгдсэн суурь кодекс нэн чухал байсан ч Худалдааны хууль эдгээр улсуудад аль хэдийн үйлчилж байсан нь зохицуулах зүйлийг нэг л хуульд хамруулах, хэд хэдэн хуульд хамруулж тараахгүй байх шаардлагыг ИХ анхнаасаа хувийн эрх зүйн харилцааг бүрэн хамрах идеал зорилго агуулаагүй гэж үзэхэд хүргэсэн. Харин МУ-д ИХ нь цөөн хэдэн гэрээний зохицуулалтыг эс тооцвол эдийн засгийн кодекс бөгөөд бүхэлдээ бизнесийн харилцаанд үйлчлэх чиг үүрэгтэй. Хэрэв бүрэн тусгаарлалтын аргаар Арилжааны Хуулийг батлах нөхцөлд ИХ-ийн зохицуулалтын 80% нь шаардагдана. Харин формал тусгаарлалтын аргыг ашиглан АХ-ийг батлах нөхцөлд бид бусад орны жишгээр ИХ, АХ хоёрыг хослуулан хэрэглэнэ. Барууны орнууд, мөн Япон улс зэрэг арилжааны бие даасан хуультай орнуудад ч мөн формал тусгаарлалт ашигласан байх ба бүрэн тусгаарлалтыг боломжгүй гэж үздэг.

1.2. Эд юмсын эрх зүйн кодификацлал. МУ-ын ИХ-ийн §§83-88 болон ИХ-ийн §§89-185 нь эд юмсын эрх зүйн ерөнхий ба тусгай хэм хэмжээг агуулж байна. Эдгээрийн аль аль нь ИХ-ийн бусад салбар хэсгүүдийн нийтлэг зохицуулалт мөн эсэх нь эргэлзээтэй. Системийн хувьд өмнөх ИХ-иас уламжлагдсан энэ бүтэц буюу дээрх хэм хэмжээ нь бүгдээрээ ИХ-ийн ерөнхий ангид байвал зохих нийтлэг хэм хэмжээ гэж үзэх боломжгүй³². МУ-ын ИХ-ийн нийтлэг үндэслэл буюу §§89-185-д эд юмсын өмч, эзэмшлийн тухай зохицуулалтыг байршуулсан нь кодификацийн сэтгэлгээний ИХ-иудаас эрс ялгагддаг. Тухайлбал ХБНГУ-ын ИХ-ийн эд юмсын эрх зүй нь гэрээний болон гэрээний бус үүргийн ард байгаа нь тусгаарлах зарчим үйлчилдэг ч эд юмсын эрх зүй нь зарим талаар үүргийн эрх зүйн зохицуулалтад суурилсан гэж үзэх хангалттай үндэслэл болдог³³. Хэдийгээр энд үүрэг, өмчийн эрх зүйн хооронд хатуу тусгаарлах зарчим үйлчилж байгаа ч логикийн хувьд өмч шилжүүлэх үүрэг үүссэн байх нь өмчийн шилжүүлгийн үндэс юм. Харин гэрээгээр өмчлөх эрхийн шилжүүлэг хийгдэж байгаагүй социалист эрх зүйн тогтолцоонд өмчлөх эрхийн зохицуулалт хаана ч байсан ач холбогдолгүй гэж үздэг хуулийн техник үйлчилж байсныг 2002 оны ИХ-д хадгалан үлдсэн нь өнөөгийн эд юмсын эрх зүйн кодификациллыг тайлбарладаг. Нэгдмэл зарчим үйлчилдэг Францын ИХ-д иргэний эрх зүйн объектыг тодорхойлох зохицуулалт ерөнхий ангид байршсан байгаа ч өмчлөх эрх шилжих, хязгаарлагдмал эрх үүсэх зэрэг нь ИХ-ийнхаа тусгай ангид бий. Тиймээс өмчийн зохицуулалтыг тусгаарлах, гэрээний ба гэрээний бус үүргийн ард байршуулах нь оновчтой логик холбоог илтгэнэ. Мөн Швейцарийн ИХ-д өмч, эд юмсын эрх зүйг төгсгөлд нь өвийн эрх зүйн ард байршуулсан нь энэ салбарыг тусгай харилцаа болохыг нотолдог³⁴.

32 Ж.Оюунтунгалаг, Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2017 он, 12 дахь тал.

33 ХБНГУ-ын Иргэний Хууль, орч. 2017 он.

34 Б.Тамир, Швейцарийн Иргэний Хуулийн орчуулга, 2018 он.

МУ-ын ИХ дахь өмчийн зохицуулалтын бүтэц нь дээрхийн эсрэг үүргийн эрх зүйнхээ суурь хэмээн үзсэн мэт харагдаж байна. Өмчийн зохицуулалтууд нь гэрээний эрх зүйн зөвхөн эхний бүлгийн бүх гэрээний болон 3-р бүлгийн зарим гэрээний хувьд ач холбогдолтой байж болох хэдий ч бусад гэрээний хувьд өмчлөх эрх шилжүүлэх зорилго агуулаагүй тул аль ч тохиолдолд өмч нь гэрээний эрх зүйн нийтлэг зохицуулалтын чиг үүргийг гүйцэтгэхгүй. Аливаа кодификаци дахь эрх зүйн салбар хэсгийн зохицуулалтын дараалал ач холбогдолгүй мэт ойлгогдож болох хэдий ч энэ нь агуулга, мөн чанарын хувьд хууль хэрэглээг бүрэн тодорхойлох, түүнд шууд нөлөөлөхүйц байдаг. Тиймээс нийтлэг зохицуулалтын чиг үүрэггүй зохицуулалт болох ИХ-ийн §§89-185-ыг ерөнхий ангиас хасч, тусгай салбарыг бүрдүүлэн ИХ-ийн тусгай ангид кодификацжуулах нь системийн хувьд оновчтой, өмчийн эрхийг дэлгэрүүлэн зохицуулах цаг үеийн шаардлагад нийцүүлэх давуу талтай.

1.3. Гэрээний болон Гэрээний бус үүргийн эрх зүй. Эдгээр нь бүтцийн хувьд 2002 оны ИХ-д бие даасан дэд хэсгийн журмаар тусгалаа олсон, дотоод агуулга нь зарим талаар гадаад улс орны ИХ-иудаас өргөн байдаг. Гэхдээ хувь этгээдийн хамгаалалтын нэг хэсэг болох хэрэглэгчийн хамгаалалт дутуугаас арилжаа эрхлэгч талын гэрээгээр хүлээх үүрэг нь дутуу тусгагдсан (Энэ талаар дэлгэрэнгүйг дор Агуулгын анализ хэсгээс үзэх).

1.4. Өвийн эрх зүй. ИХ-ийн ерөнхий анги буюу бүтцийг бүрдүүлэгч хэсэгтээ “өмч, хөрөнгө” хэмээх ухагдахууныг нарийн зааглаж, хөрөнгийн эрхийн өргөн хамгаалалт олгох эсэхээ тухай бүр нь зөв шийдэх нь өвийн эрх зүйн хүрээнд зарчмын ач холбогдолтой. Өдгөө насан эцэслэсэн этгээдийн нийт хөрөнгө өвлөгдөж, түүнээс өр төлбөрийг хасан өв залгамжлагч нарт хуваан олгодог тогтолцоо дэлхий нийтэд хэрэгжиж байхад МУ-д эд зүйлсийг тусад нь өвийн объект мэт ойлгох зэргээр системийн шийдэл нь тодорхой бус байна. Өвийн эрх зүй нь нас барагчийн ҮХ-иар хамгаалсан өмчлөх эрхийн хамгаалалтын үргэлжлэл мэдээж тодорхой эд зүйлсийн өвлөгчид хандуулах эрх нь түүнд бий. Гэхдээ энэ нь зөвхөн хөрөнгө хуваарилалтын асуудал бөгөөд эдгээрийг нарийвчлан зохицуулах нь ҮХ-д нийцнэ. Харин ИХ нь зах зээлийн харилцааг зохицуулахад түлхүү анхаарч, өвийн эрх зүйн салбарт ямар ч шинэчлэлт хийгээгүй³⁵ нь гэр бүлийн гишүүдэд заавал ноогдох хэсгийг тодорхойлох зохицуулалт дутмаг, хуулийн бодлого нь тодорхойгүй, гэрээслэл тайлбарлах арга дулимаг байхаас гадна энд өв хүлээн авах, татгалзах, хөрөнгө арчлан хамгаалах, захиран зарцуулах зэрэг зохицуулалтыг хэт ерөнхий байдлаар хуульчилсан. Энэ нь өвийн эрх зүйн хөгжил хоцронгүй үлдсэн шалтгаан болж байна³⁶.

1.5. Зөрчилдөөний хэм хэмжээг хэрхэх тухай. Хууль тогтоох онолын өнцгөөс ИХ-ийн V дахь дэд хэсэгт зохицуулсан “Олон улсын хувийн эрх зүй” хэмээх бүлгийн үндсэн чиг үүрэг нь гадаад элемент бүхий гэрээнд ИХ хэрэглэгдэх эсэхийг шийддэг чухал ач холбогдолтой. Олон улсын хувийн эрх зүй нь хил дамнасан эсвэл эрх зүйн харилцаанд оролцогсод нь өөр улсад харьяалагдах зэрэг гадаадын хууль тогтоомж нэгэн адил ач холбогдолтой нөхцөлд хэд хэдэн улсын хууль тогтоомжоос алийг нь хэрэглэхийг сонгох тухай зөрчилдөөнийг шийдэх хэм хэмжээ (ИХ-ийн §§538-552)

35 М.Ванчигмаа, Гэрээслэлээр өвлөх эрх, 2015 он, 29 дэх тал, Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, 5-р хэвлэл, 2019 он, 461 дэх тал.

36 Б.Улаанбаатар, МУ дахь гэрээслэл, Асуудал, шинэчлэлт, Анхны хэвлэлт, 2017 он, 5-11 дахь тал, М.Ванчигмаа, Гэрээслэлээр өвлөх эрх, 2015 он, 29 дэх тал, Ц.Оюунаа, Өв залгамжлалын эрх зүй, 2017 он, 13 дахь тал.

агуулсан байдгаараа ерөнхий нийтлэг хэм хэмжээний шинжтэй. Нөгөө талаас аль улсын материаллаг эрх зүйн хууль тогтоомжийг шүүх хэрэглэж, хэрэг маргааныг шийдэхийг тодорхойлох энэ чиг үүрэг нь нийт хувийн эрх зүйн кодификацийн хэрэглэгдэх хүрээг нээх эсэхтэй холбоотой бөгөөд өмнөх хэсэгт дурдсан кодификацийн онол нь олон улсын хувийн эрх зүйг Хууль хэрэгжүүлэх хуулийн бүрдэл хэсэг хэмээн үздэг тухай тусгасан. Энэ шалтгаанаар Швейцарийн ИХ-д энэ асуудлыг хаалтын аргачлалын дагуу ерөнхий ангид зохицуулж байснаа онолын хувьд хууль хэрэгжүүлэх тухай хуульд тусгах ёстой хэмээн үзэж, кодификацийн бүрдэл хэсгээс гарган тусгай хуулиар зохицуулсан³⁷.

ИХ-д тусгагдсан өөр нэг зөрчилдөөний хэм хэмжээ бол ИХ-ийн §2.1 бөгөөд иргэний эрх зүйн системчлэлийг бүрдүүлж буй гэдэг утгаараа ИХ нь бусад иргэний хууль тогтоомжийн хэмжүүр болох тухай энд заажээ. Энэхүү ИХ-ийн давуу үйлчлэл нь бусад хууль тогтоомж, ялангуяа төр эрх зүйн шинжтэй, тогтолцооны тухай хэм хэмжээгээр зохицуулагдаагүй. Тиймээс практикт тусгай хууль тогтоомж давуу үйлчлэх ерөнхий онолын зарчмыг баримтлах нь элбэг. Тухайлбал хувийн эрх зүйн салбарт Компанийн тухай хууль, оюуны өмчийн тухай хууль тогтоомж зэрэг нийт салбарын системийг бүрдүүлэгч актууд бий. Эдгээр тусгай хууль тогтоомжийг ИХ-д нийцүүлэн шалгах уу эсвэл тусгайлсан агуулга бүхий хууль гэдэг утгаараа ИХ-ийн агуулгатай үл нийцэх тохиолдлыг хүлээн зөвшөөрөх үү гэдэг тухайд ИХ-ийн §2.1-д заасан зөрчилдөөний хэм хэмжээ нь эрх зүйн ерөнхий онолын *lex specialis derogat legi generali* буюу тусгайлсан зохицуулалт нийтлэг хэм хэмжээнээс давуу үйлчлэх зарчмаас зөрж байна. Эрх зүйн харилцаанд энэ нь 2 янзаар хэрэглэгдэж ирсэн. Тухайлбал газар, ашигт малтмал зэрэг нийтийн эрх зүйн хууль тогтоомжоор зохицуулсан хэсэгт тусгай хууль тогтоомжийг ашиглах боловч зарим тусгай агуулга бүхий хэм хэмжээг ИХ-д нийцүүлэн хянах хандлага, хүсэлт их гарч байна.

Хувийн эрх зүйн онолын түвшинд ИХ ба бусад хууль тогтоомжийн харилцан хамаарлыг кодификацийн онолын хүрээнд нэгбүрчлэн судлан тогтоох шаардлагатай. ИХ-ийн §2.1-ийн үндсэн зорилго нь ИХ-ийн үндсэн зарчим, зарчмын шийдлүүдийг өөр хууль болон хүчин чадлаараа хуульд захирагдвал зохих эрх зүйн бусад хэм хэмжээний актуудаар хялбар үгүйсгэх, зөрчихөөс сэргийлсэн зохицуулалт бөгөөд тусгай агуулга бүхий материаллаг хуулийн зүйл заалт бүрийг ИХ-д нийцэх эсэхээр нь шалгахыг шаардахгүй. Ийнхүү хууль хоорондын зөрчилдөөнийг ИХ-ийн §2.1 эцэслэн шийдвэрлээгүй гэж үзвэл ямар аргаар хувийн болон нийтийн эрх зүйн хэм хэмжээний давхардал, хийдлийг шийдвэрлэх вэ? гэсэн үндсэн асуулт гарч ирж байна.

ИХ зэрэг томоохон кодификацийг хэрэгжүүлэх тухай хууль асар их ач холбогдолтой зөрчилдөөний хэм хэмжээ болох нь барууны улсуудын жишгээс харагддаг. Нэгдүгээрт, ИХ ба Газрын тухай хууль, банк санхүүгийн үйл ажиллагааны тухай эсвэл барьцааны хууль тогтоомж зэрэг дотоодын материаллаг хуулийн зөрчилдөөн, 2/. хэд хэдэн улсын хууль тогтоомж зөрчилдөх зэрэгт Хууль хэрэгжүүлэх тухай хуулиар нарийн зохицуулах нь оновчтой. Түүнчлэн нэг хуульд их олон нэмэлт өөрчлөлт оруулах, нэг бүлэг хэсгийг цахим орчинд шилжсэнтэй холбогдуулан хэлбэрийн хувьд өөрчлөх нөхцөлд шилжилтийн зохицуулалтыг хэрэглэх эсвэл шинэ кодификаци үйлчлэх тухай хуулийг батлахаас аргагүй. Зарчмын хувьд хууль хэрэгжүүлэх агуулга бүхий хоёр төрлийн зохицуулалт байгаа ч эдгээрийг тус тусад нь бус, ихэвчлэн зэрэгцүүлэн ашиглах нь илүү үр дүнтэй.

37 Орч. Б.Тамир, Швейцарын Холбооны Улсын Олон улсын хувийн эрх зүйн тухай хууль, 2019 он.

Хууль хэрэгжүүлэх тухай хуулийг юуны өмнө хуучин байсан харилцаанд тулгуурлан шинээр кодификаци бэлтгэх нөхцөлд батална. Шинэ зохицуулалтыг хэзээнээс, хэрхэн үйлчлэх тухай шилжилтийн зохицуулалт шаардлагатай³⁸. Кодификацийг хэрэгжихэд шилжилтийн болон нэмэлт өөрчлөлт оруулах тухай зохицуулалт шаардлагатай. Хэрэв кодификацид өөрт нь эдгээрийг тусгавал хууль хэрэглэгчид ойлгомжгүй болох тул хууль танилцуулах ба хэрэгжүүлэх тухай зохицуулалтад тусгадаг³⁹. Хууль хэрэгжүүлэх тухай хуулийн ач холбогдлыг тодорхойлоход түүний чиг үүрэг голлох үүрэгтэй. Юуны өмнө энд одоо хэрэгжиж буй хууль тогтоомжийг өөрчлөх чиг үүрэг, хуулийг хүчингүй болгох чиг үүрэг, тухайн кодификацийн хүрээнд бэлтгэсэн тогтоол, журмыг өөрчлөх, хүчингүй болгох чиг үүрэг, зарим зохицуулалтыг хүчинтэй авч үлдэх чиг үүрэг багтана.

МУ-ын хувьд хууль хэрэгжүүлэх тухай хуулийг гагцхүү шинэ кодификацийн үйлчлэх хугацаа, нутаг дэвсгэр зэргийг тодорхойлох зорилгоор баталсан. Олон улсын хувийн эрх зүйн хэм хэмжээг тусгай хуулиар зохицуулаагүй онцлогтой. ЕХ-ны улс орнуудын хувьд олон улсын хувийн эрх зүйн хэм хэмжээг ИХ-иар зохицуулна гэсэн ойлголт байдаггүй⁴⁰. Кодификацийн онолын дагуу хууль хэрэгжүүлэх тухай хууль нь ийнхүү материаллаг хуульдаа тусгагдсан байх явдал нь хуулийн техникийн алдаа мэт тооцогддог. Тиймээс дотоодын судлаачид олон улсын хувийн эрх зүйн хэм хэмжээг тусдаа хуулиар зохицуулахыг дэмждэг⁴¹. ИХ нь бусад хуультай ямар харилцан хамааралтай байхыг кодификацаас тусдаа хуулиар зохицуулах нь зайлшгүй зөрчилдөөнөөс сэргийлэх, эрх зүйн тодорхойгүй байдлын улмаас хийдэл үүсэхээс сэргийлэх, хэрэгжүүлэх хуулиа түргэн шуурхай өөрчлөх боломж олгоно. Үндсэн кодификацийг ойлгомжтой, цөөн тооны зохицуулалтаар хязгаарлах нь олон давуу талтай. Жишээлэхэд түлхүү нийтийн эрх зүйн зохицуулалт бүхий нийтийн өмч буюу уул уурхайн салбарт ИХ-ийн зохицуулалтыг хэрэглэх эсэх тухай зөрчилдөөний хэм хэмжээг баруун Европын улсууд ИХ-ийг хэрэгжүүлэх тухай хуульдаа тусгасан байх тул агуулгын давхардал гарах нь харьцангуй цөөн байна. МУ-ын хувьд энэ төрлийн хэм хэмжээг газрын эрх зүйн хүрээнд ашиглах нь ИХ болон газрын тухай хууль тогтоомжийн зөрчилдөөнийг шийдвэрлэх чухал ач холбогдолтой.

ИХ-ийг хэрэгжүүлэх тухай хуулийг баталж, мөрдүүлсэн байдлаараа ХБНГУ, Швейцар зэрэг кодификацийн уламжлал бүхий орнууд жишиг болж байна. Тухайлбал ХБНГУ-ын ИХ-ийг Хэрэгжүүлэх тухай хууль \EGBGB⁴²\ нь зөрчилдөөнийг шийдвэрлэх хэм хэмжээг өөртөө агуулдагаараа онцлогтой. Энэ хууль нь гадаад элемент оролцсон нөхцөлд ИХ хэрэглэгдэх эсэхийг шийддэг зөрчилдөөний хэм хэмжээ (олон улсын хувийн эрх зүй), ИХ-ийн агуулгатай адил төстэй агуулга бүхий орон нутгийн хууль тогтоомжийн зэрэгцээ тус хуулийг хэрхэн хэрэглэх тухай зохицуулалт, ялангуяа газрын тухай хууль тогтоомжийн үйлчлэлийн талаар шилжилтийн зохицуулалтыг агуулдаг.

38 Л.Өлзийсайхан, Хууль бүтээх урлаг, УБ хот 2018 он, 112 дахь тал.

39 Mertens, Bernd. Gesetzgebungskunst im Zeitalter der Kodifikationen, Tuebingen 2004, S.356.

40 Грациано Каднер. Европын олон улсын хувийн эрх зүйг хуульчлах үйл явц: Швейцарын Холбооны Улсын Олон улсын хувийн эрх зүйн тухай хууль – Европын олон улсын хувийн эрх зүйн боловсронгуй загвар мөн үү?, Эрх зүй сэтгүүл 2018 он, №3, 269-299 (279).

41 Э.Байгал, Олон улсын хувийн эрх зүй, 2016 он, 2 дахь хэвлэл, 37-38 дахь тал; Б.Тамир, Швейцарын Холбооны Улсын Олон улсын хувийн эрх зүйн тухай хууль, 2019 он, 4 дэх тал.

42 German Code on the Conflict of Laws: Э.Байгал, Гадаад улсуудын олон улсын хувийн эрх зүйн хууль тогтоомжийн эмхэтгэл, 2022 он.

Дээрхээс үзвэл олон улсын хувийн эрх зүйг ИХ-ийн хэрэгжүүлэх хуульд тусгаснаар хэд хэдэн улсын материаллаг хуулийн зөрчилдөөнийг шийдвэрлэхийн сацуу ГтХ, Бүртгэлийн хууль тогтоомж зэргийн ИХ-ийг хэрхэн хэрэгжүүлэх тухай хууль хоорондын зөрчилдөөнийг шийдэх боломжтой.

Зарим судлаачид Иргэний ба Эрүүгийн хуулийн, банкны оролцоо бүхий хэргүүд дээр ИХ ба банкны хууль тогтоомж болон Эрүүгийн Хуулийн хэрэглээг хөндөж буй нөхцөлд хэм хэмжээний зөрчилдөөнийг шийдвэрлэх шаардлагатайг тэмдэглэдэг⁴³. Харин зарим нь үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой асуудлыг бүртгэлийн зохицуулалт ИХ-ийн хэм хэмжээтэй зөрж буй тохиолдолд хэрхэн зөрчилдөөнийг шийдвэрлэх нь тодорхойгүй байгааг онцолжээ⁴⁴. Эдгээр хуулийн агуулга зорилго, эрх зүйн үр дагавар нь адилгүй тул энэ төрлийн давхардал анхнаасаа гарах ёсгүй буюу хууль боловсруулах шатанд эрэмбийг нь мэргэжлийн хууль тогтоох байгууллага шийдсэн байх ёстой.

Асуудал №2: Хууль тогтоох онолын хүрээнд ИХ-ийн бүтцийг системчлэх аргыг сонгох
Дотоод бүтцийн хувьд сул холбоос бүхий тусгайлсан кодификацийн аргыг эсвэл сонгодог кодификацийн аргыг ашиглах уу? Эдгээрийг хослуулах уу эсвэл хувийн эрх зүйн салбар тус тусдаа хуулиар /декодификаци/ зохицуулагдах уу? гэдгээ сонгох.

2.1. Постсоциалист /социалист/ хэв загвараа хадгалах. Дотоодын хувийн эрх зүй дэх анхны рецепц нь ЗХУ-ын ИХ-иас жишиг авч эхэлсэн ба хожим баруун Европын либерал ИХ-ийн зохицуулалтыг өмнөх ИХ-ийн бүтцэд оруулсан зэрэг түүхэн хөгжил нь эдгээр тогтолцоон дахь эсрэг тэсрэг зарчмуудын зөрчилдөөнд хүргэж, улмаар ИХ дахь дотоод зөрчлийг бий болгосон⁴⁵. Хожим бичмэл болон бичигдээгүй хуулийн хэм хэмжээ, эрх зүйн зарчимтай харилцан үйлчлэлцэх замаар өнөөгийн эрх зүйн шинэ өвөрмөц тогтолцоо бий болсныг гадны судлаачид постсоциалист загвар гэж нэрлэсэн. 2002 оны ИХ-ийн хувийн хэргийг судалбал хуучин бүтэц, тогтолцоог үргэлжлүүлэн ИХ-ийн норматив цөмийг хадгалахыг хууль тогтоох байгууллагын ихэнх гишүүд дэмжсэн⁴⁶ нь харагдах ба үр дүнд нь эрх зүйн хуучин соёлоо хадгалан үлдсэн нь ИХ-ийн бүтцээс тод харагдаж байна. Либерал загварын дагуу өрнөсөн ИХ-ийн өөрчлөлтүүд нь хууль эрх зүйн тогтолцоог үндсээр нь өөрчлөн байгуулахад хүргээгүй ч, эрх зүйн шинэтгэл хийхийг шаардаж, иргэний эрх зүйн шинэтгэл нь эрх зүйн тогтолцоонд том өөрчлөлт авчирсан. Өмнөх ИХ-ийн хуулийн бүтэц, хэв маяг, үзэл суртлын загвар, шилжилтийн үйл явц нь шинэчлэлийн үр дүнд бий болсон шинэ хэм хэмжээ, арга барил, механизмтай харилцан үйлчлэлд орж, шинээр нэвтрүүлсэн загварыг тухайн эрх зүйн орчинд төлөвшүүлэхэд нөлөөлсөн. Энэ үйл явц нь эрх зүйн орчныг шинэчлээд зогсоогүй, шилжүүлэн авсан эрх зүйн зохицуулалтын бүтцийн аль алиныг нь өөрчилж, үр дүнд нь хуучин шинийг хослуулсан холимог бүтэц бий болжээ. Завсрын болон шилжилтийн үед ийнхүү шинэ ба хуучин хууль, тогтолцооны зөрчилдөөн үүсэх нь гарцаагүй бөгөөд 2002 оны ИХ болон ИХШХШТХ-ийг нийгэмд өрсөлдөж буй хоёр загварын хоорондох зөрчлийн тусгал юм. Эдгээр хуульд хамтын буюу коллектив нийгмийн загвар болон либерал (индивидуалист) үндсэн зарчмуудын өрсөлдөөний⁴⁷ шинжүүд илэрч байгаа бөгөөд

43 С.Должин, Д.Бадам, Залилах гэмт хэрэг ба гэрээний маргаан, 2018 он, 5-6 дахь тал.

44 GIZ. МУ-ын шинэ ИХШХШЭЗ ба Үл хөдлөх хөрөнгийн эрх зүй, 55, Д.Янжинхорлоо, Үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудал, 2016 он, 108 дахь тал.

45 Б.Буянхишиг, Хувийн эрх зүйн кодификаци, харьцуулалт, 2021 он, 71 дэх тал.

46 Б.Амарсанаа, З.Сүхбаатар, 2002 оны ИХ-ийн хувийн хэрэг, 36 дахь тал.

47 Kurzynsky: Transformation durch Rezeption?, 2014, S.25.

үүнийг эцэслэн шийдвэрлэж, давуу талыг нь авч үлдэх нь шинэтгэлийн зорилго байх ёстой. Дотоодын хувийн эрх зүйн кодификацид зарчмын болон бүтцийн анализ хийж, хэрэгжилтэд нь үнэлэлт дүгнэлт өгсний үндсэн дээр цааш хөгжүүлэх, ИХ-ийг хуваах, нэгтгэх зэрэг асуудлыг шийдвэрлэхдээ онолын үндэслэлтэй, уламжлалт бүтцийн давуу чанарыг залгамж болгон хадгалахад анхаарах нь чухал билээ.

2.2. Декодификацийн эринд шилжсэн ИХ-ийн загварууд. Энэхүү ойлголтыг ахин кодификацжуулах /recodification/ хэмээн тайлбарлавал анхны кодификацуудын уламжлалыг шинэчлэх, өмнөх хуулийн төслийг шинээр хийх гэсэн утгатай болох ба кодификацаас татгалзах буюу энгийн ганцаарчилсан хууль тогтоомжид задлах /decodification/ хэмээн ойлгох тайлбарлавал бид ҮХ-иас эх авсан энгийн хуулиудын шат дараалал, харилцан хамаарал зэргийг тогтоох боломжгүй нөхцөл байдал үүснэ.

Эдийн засаг, нийгэм хөгжих тусам хувийн эрх зүйн салбарт үнэт цаас, оюуны өмч зэрэг тусгай бие даасан салбаруудыг хөгжүүлж, тусгайлсан кодификаци батлах бололцоотой. Гэхдээ энэ нь суурь кодификаци ба тусгай хууль тогтоомжийн кодификацжуулалтаас татгалзах үндэслэл биш юм. Тухайлбал 100 гаруй жил оршин тогтнож буй Герман, Францын ИХ-иуд, мөн Нидерланд дахь иргэний ба худалдааны хуулийн нэгтгэл, Хятад улсын хувийн эрх зүйн тусгай хууль тогтоомжоо нэгдсэн системд оруулах алсын зорилго зэрэг нь кодификацийн эрин үе ид дундаа орж буйн илрэл юм. Харин техникийн дэвшил, эдийн засгийн өсөлт зэрэг нь хувийн эрх зүйн зарим салбарыг ахин эргэж харах буюу кодификацжуулах шинэ шаардлага бийг харуулдаг. Жишээ нь Японы эрдэмтэн Като Масанобү⁴⁸ Япон, Солонгос, Тайвань зэрэг зүүн Азийн улс орнууд ИХ-даа их хэмжээний өөрчлөлт оруулж буй үйл явцыг ахин кодификацийн эрин үе хэмээн үздэг.

МУ-ийн ИХ-ийн хүрээнд шинэчилсэн найруулга хийгдвэл ахин кодификацжуулалт хэмээн үзэх бөгөөд багц хууль олноор батлагдах болсон нь нэгдсэн системчлэлийн эхлэл хэмээн үзэхэд хүргэх ба ИХ-иас эдийн засаг, арилжааны эрх зүйн шинжтэй зохицуулалтыг салгаад, улмаар хэрэглэгч буюу хувь хүний эрхийн, мөн гэр бүлийн эрх зүй тус тусдаа хууль болон батлагдах нөхцөлд декодификацийн үед шилжих юм.

2.3. Кодификацийн сэтгэлгээний уламжлал бүхий ИХ-ийн загвар. Дэлхий дахины кодификацийн сэтгэлгээний түүхэнд 18-19-р зуунд ИХ-иа нэгтгэн баталсан Францын ИХ (Code Civil), Германы ИХ (BGB), Швейцарийн ИХ (BGB), Австрийн ИХ (ABGB), Италийн ИХ (Codice civile) албан ёсоор багтдаг. Эдгээр хуулиуд нь зарчмын шийдлүүд болон цаг хугацааны шалгуураар кодификацийн сэтгэлгээг бүрдүүлсэн бол хожим баталсан адилтгахуйц агуулга, зарчим бүхий ИХ-иудад кодификацийн сэтгэлгээний уламжлал нотлогдвол рецепцийн арга ашигласан хэмээн үзэж, тодорхой эрх зүйн бүлийн рецепцийн түүхэнд хамруулан судалдаг. ОХУ болон Хятад улсын хувийн эрх зүй судлаачид эх газрын эрх зүйн ерөнхий ангиллын рецепцийн түүхэнд хамаарч байгаа талаар бүтээлдээ тусгадаг ч өмнөх ИХ-ийн уламжлалаа хадгалсан, зарим талаар үзэл сурталжсан холимог тогтолцоо бодитоор оршсоор байгаа нь үүнд эргэлзэхэд хүргэдэг.

48 Масанобү, Като. Кодификацийн болон дахин кодификацийн эрин үе сэдэвт илтгэл, МУ-ын хувийн эрх зүйн тулгамдсан асуудал: Иргэний болон Худалдааны хууль тогтоомжийн олон улсын жишиг, ОУ-ын симпозиумын илтгэлийн эмхэтгэл, УБ 2019 он, 45 дахь тал.

Хуучин социалист ИХ-ийн бүтцээ хадгалсан уламжлалаа либерал ИХ-ийн загвартай хослуулан холимог тогтолцоог бүрдүүлсэн МУ-д эрх зүйн бүл ба аймгийн асуудал маргаантай, хувийн эрх зүйн суурь кодификацийг тулгуур үзэл баримтлалыг судалбал бусад кодификацийн уламжлал бүхий ИХ-иуд болон ОХУ-ын ИХ-тай хуулийн техникийн хэв маяг ижил төстэй байна. Энэ нь кодификацийн онол зарим талаар хэрэгжиж буйг илтгэх хүчин зүйлс юм.

Зураг. ИХ-ийн загваруудад свот анализ хийх нь

Харьцуулах загварууд	Давуу талууд	Сул талууд
Постсоциалист загвар	Өөрийн гэсэн өвөрмөц уламжлалыг хадгалах	Бусад улс орнуудад байхгүй болж байгаа /ИХ-ийн холбогдох хэсгийг шинэчилсэн/ ИХ-ийн “иргэний” шинжийг үгүйсгэнэ ИХ ба тусгай хууль тогтоомжийн хамаарлыг хатуу тогтоосон нь хэрэгжих боломжгүй /ИХ-ийн 2.1/
Декодификацад шилжсэн загварууд	Эдийн засгийн болон олон улсын эрх зүйн хөгжилд хөл нийлүүлэх хялбар, шуурхай арга Олон хуулийг нэгэн зэрэг батлан гаргах боломжтой	хууль тогтоомжийн уялдаа холбоог хожим казуист аргаар нэг бүрчлэн шийдвэрлэх нь өөрөө зардал ихтэй хуулийн агуулгын огтлолцол, зөрчлийг шийдвэрлэх онолын аргачлал дутмаг
Кодификацийн сэтгэлгээний загварууд	Кодификацийн онол нь дотоодын ИХ-д тусгалаа олсон ИХ-ийн бүтэц, бүлэг, зохицуулалтын агуулгыг шинэчлэх замаар хэрэгжих боломжтой	Хийсвэр-ерөнхий хуулийн техникийг түлхүү ашиглах тул хуулийн агуулга энгийн иргэдэд ойлгомжгүй болох талтай

Хууль тогтоомжийн тоо ихэсэх хандлага давамгайлж буй өнөө үед ялангуяа хувийн эрх зүйн салбарыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн кодификацжуулах хэрэгцээ шаардлага өмнөх үеэс илүү чухал хэвээр байна. Хувийн эрх зүйг кодификацжуулсан түүх болон кодификацад хандсан шүүмжийг тодорхой бүтцэд шилжүүлэн үзэхэд аливаа кодификаци улс төрийн болон хуулийн техникийн хувьд ихээхэн ажиллагаа шаардсан төсөл тул кодификацийн нэрлэсэн давуу талуудыг бүрэн хэрэгжүүлэх, кодификаци батлах үйл явцыг хялбаршуулах шинэлэг хэлбэрүүдийг эрэлхийлэх шаардлагатай. Барууны орнуудад хувийн эрх зүйн салбарыг тусгай ном болгон кодификацжуулсан нь улс төр, шинжлэх ухаан, юуны өмнө хууль хэрэглэгчид туйлын ашигтай гэсэн дүгнэлтэд хүрээд байгаа бөгөөд энэ төрлийн кодификаци боловсруулах үйл явц нэлээд ярвигтай хэмээн үздэг⁴⁹. Энэхүү тусгайлан номлосон кодификацийн хэлбэрийг байгаль орчин, хөдөлмөрийн эрх зүй болон мэдээллийн салбарт туршисан бөгөөд кодификацийг халах буюу декодификацжуулах хандлагын оронд кодификаци бэлтгэх аргачлалаа сайжруулах, шинэчлэх нь оновчтой гэсэн дүгнэлтэд хүрчээ⁵⁰. Тухайлбал Нидерланд улс нь Байгаль орчны хууль тогтоомжийн кодекс болон Иргэний Хуулиа энэ аргаар боловсруулсан⁵¹. Нидерланд улс нь урьд өмнө ИХ болон Худалдааны хуультай байсан бол тусгайлсан кодификацийн аргаар эдгээрийг нэгтгэж чадсан байна. Эрх зүйн томоохон салбарыг ийнхүү тус бүрнээ нэг бүлэг номын хэмжээ бүхий хэд хэдэн номоос бүрдэх тусгайлсан кодификацад багтаан зохицуулах нь хууль тогтоомжийн системчлэл, нэгдмэл байдлыг дээшлүүлэхийн сацуу, ном тус бүрээр нь хурдан хугацаанд өөрчлөлт хийх, ерөнхий ба тусгай салбарыг шаталсан хэлбэрээр дэс дараалуулан батлах боломж олгодог.

49 schaerdel, florian. die buecherkodifikation (untersuchung einer gesetzgebungstechnik), 2012, s. 16.

50 Schaerdel. Die Buecherkodifikation (Untersuchung einer Gesetzesgebungstechnik), S.104.

51 Klopfer, Michael. Sinn und Gehalt des kommenden Umweltgesetzbuches, UPR 2007, S.161 (167).

Аливаа кодификаци нь өргөн хүрээ бүхий цогц хууль тогтоомж бөгөөд ерөнхий анги эсвэл нийтлэг зохицуулалт агуулсан хэсэгтээ өндөр хийсвэрлэлийг ашиглах тул тус бүрд нь баталсан энгийн хуультай харьцуулахад илүү өндөр түвшний хууль эрх зүйн акт юм. Системчилсэн кодификаци нь байнга тохиох ерөнхий асуудлыг нийтлэг зохицуулалтад тусгасан байх ба энэ нь хууль эрх зүйн асуудлыг илүү хурдан шийдвэрлэх боломж олгоно. Энэ нь зөвхөн материаллаг хуульд хамаатайгаас гадна, процессын хууль тогтоомжид ч мөн адил хамаарна. Бүх иргэний хувьд адил процесс ажиллагаа, процессын эрхийг санал болгох нь хувь хүний хэргийг шийдвэрлэхдээ эрх зүйт төрийн зарчмын гол илрэл болсон тэгш хандах зарчмыг хэрэгжүүлж буй хэлбэр юм. Агуулгын хувьд ойролцоо тусгай хууль тогтоомжууд нь харилцан ялгаа бүхий материаллаг стандарттай бөгөөд эрх бүхий байгууллага, иргэд нь тухайн хуулийг хэрэглэхдээ өөр өөр процесс ажиллагаа хэрэглэдэг бол энэ нь хуулийг хүлээн зөвшөөрөх явдалд сөргөөр нөлөөлж, тэгш хандах зарчимд харшилна.

Кодификацийн онолыг эрх зүйн ерөнхий онолын судлаачид⁵² агуулгын шаардлага тавьдаггүй, цэвэр хуулийн техник талаас нь тодорхойлсон. Гэвч энэ онол нь кодификацийн сэтгэлгээний угшилтай буюу агуулгын шаардлагатай, сүүлийн 2-300 жилийг хамарсан философи сэтгэлгээний томоохон урсгал юм. Кодификацийн аргыг ашигласан улс орны ИХ-ийг Англо-саксоны common law системтэй, бүтэц зарчим, хэрэглээний аргачлалаар харьцуулахад зарим суурь зарчмын шинжтэй зүйлс нь ил харагддаггүй тул системийн хугарал үүсдэг. Түүнчлэн кодификацийн сэтгэлгээний уламжлалтай Герман улс болон түүнээс рецепц хийн хөгжиж буй Япон улсын хувийн эрх зүйн кодификацуудыг харьцуулбал Япон улс нь иргэний хууль, хэрэглэгчийн тухай хууль, арилжааны хууль гэсэн тусгай хуулиудаас бүрдэх ба декодификацийн шатанд шилжсэн тогтолцоо юм. Энд хүн амын нягтаршил, боловсон хүчний чадавх, өвөрмөц соёлын нөлөөлөл дор тусгай хуулийн харилцан үйлчлэл үр нөлөөтэй хэрэгжиж байна.

Харин МУ-ын хувьд ИХ-ийн системт тогтолцоог хангах хувилбарыг сонгох шаардлагатай бөгөөд эдийн засгийн агууламжаараа давамгайлсан хуулиа тэнцвэржүүлж, иргэн хувь хүн, хэрэглэгчийн хамгаалалтыг түлхүү тусгах нь дижитал эрин үетэй хөл нийлүүлэх сонголт юм. Жишээлэхэд хувийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Хэрэглэгчийн гэрээний тухай хууль, Арилжааны хууль болон бусад үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжийг батлах, боловсронгуй болгох нь чухал. Гэхдээ Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль Иргэний хуулиас тусдаа байснаар МУ-д зээлийн болон ажил үйлчилгээний хэрэглэгчээ хангалттай хамгаалж чадаагүй, нэг гэрээнд үйлчлэх зохицуулалтыг өөр хооронд нь салгаж хөгжүүлсэн байдаг. Иргэний байгуулах гэрээнд л энэ талаар тусгаж өгөхгүй бол зээлээр авсан эд хөрөнгийг цуцалсан бол холбоотой гэрээг цуцлах зэрэг цогц асуудлыг оновчтой шийдвэрлэж чадахгүй байх, мөн томоохон гэрээ хэлцлийн хүрээнд мэдээлэл өгөх үүргийг олон улсын гэрээ, конвенцэд заасан хэмжээнд тусгаж чадахгүй байгаа зэрэг хүндрэлүүд гарч байна. Хувийн эрх зүйн энэ олон төсөл хэлэлцүүлэг нь бүгд үр дүнтэй, нөгөө талаас хангалттай хэрэгжихийн тулд Иргэний Хуулийн системчлэл, хэрэглэх хуулийн техникээ кодификацийн сэтгэлгээний уламжлалд хамаарах байдлаар сонгох нь илүү дөхөм байна.


52 О.Амархүү, Эрх зүйн онолын 50 асуулт, 2008 он, 59 дэх тал; Ч.Нямсүрэн, Эрх зүйн ерөнхий онол – үндсэн ойлголт тулгамдсан асуудал, 2012 он, 236 дахь тал; Д.Лүндээжанцан, Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник, 2016 он, 120 дахь тал; Т.В.Кашанина, “Хууль зүйн техник”, (монгол хэлнээ хөрвүүлсэн.)

В.2002 оны ИХ-д суурь зарчмын анализ хийх нь:

I. Хувийн эрх зүйн зарчим, тэдгээрийн хэрэгжилт.

Эрх зүйн зарчмуудыг хуульчлах (тэргүүлэх зохицуулалтыг тусгах) нь хууль зүйн техникийн хамгийн их маргаан дагуулдаг арга билээ. Хэм хэмжээний онолын түвшинд эрх зүйн хэм хэмжээ нь тодорхой нөхцөлт холбоос бүхий зохицуулалт, уг зохицуулалт нь бүрэлдэхүүнтэй байхын сацуу энэхүү нөхцөлүүд бүрдвэл тодорхой хууль зүйн үр дагавар бий болох тухай нөхцөлт холбоос агуулсан байдгаараа онцлогтой⁵³. Эрх зүйн зарчим нь энэ төрлийн холбоос буюу эрх зүйн шууд үр дагавар агуулаагүй байдгаараа ердийн хэм хэмжээнээс ялгардаг. Аль нэг хэм хэмжээг тайлбарлах шаардлага гарвал энэ орон зайг эрх зүйн зарчмаар нөхөн бүрдүүлэх буюу тайлбарлана. Эрх зүйн зарчмууд нь хууль тайлбарлах хэд хэдэн аргаас тодорхой нэг аргыг сонгох үндэслэлийг зааж өгдөг онцлогтой⁵⁴.

МУ-д зарчмыг хуулийн бүтцээс олж унших, гаргаж авах явдал хэвшээгүй тул үгчлэн тусгах нь зүйтэй гэж үздэг. Энэ шалтгаанаар хуулийн эхэнд зарчмыг тоочих аргыг гол төлөв ашигладаг. Харин нийт зохицуулалтын дийлэнхэд шингэсэн эсвэл хуулийн бүтцээс ургаж буй нийтлэгийг зарчим хэмээн хүлээн зөвшөөрөх нь зарим судлаачдад бэрхшээлтэй хэвээр байна. Тухайлбал үүнийг судлаач О.Жамбалдорж⁵⁵ иргэний эрх зүйд 8 зарчим үйлчилж байгаа гэсэн бол Т.Мөнхжаргал оролцогчдын бие даасан байдлыг хангах, өмчлөгчийн эрх ашгийг хамгаалах, бусдын хэрэгт хөндлөнгөөс үл оролцох зэрэг 5 зарчим байна⁵⁶ гэх мэт харилцан адилгүй тодорхойлсноос харах боломжтой.



53 Rütters/Fischer, Rechtstheorie, 2010, Rn.491b; Ханс Кельзен: Хэм хэмжээний тухай ерөнхий онол, 3 дахь хэвлэл, УБ хот, 2017 он, 15/212 дахь тал.

54 Alexy, Robert, Zum Begriff des Rechtsprinzips, Rechtstheorie, Beiheft 1, 1979, S.59 /63/.

55 О.Жамбалдорж, МУ-ын Иргэний эрх зүй (Ерөнхий анги), I дэвтэр, 2004 он, 57 дахь тал.

56 Т.Мөнхжаргал, МУ-ын Иргэний эрх зүй (Ерөнхий анги), 2007 он.

Энд дурдсан зарчмууд нь төрөөс хараат социалист эдийн засаг бүхий ИХ-ийн зарчмууд байх талтай ч өдгөө зарим нь либерал ИХ-иудад тусгалаа олсон зарчмуудтай адил төстэй, харин зарим хэсэг нь хувийн эрх зүйн гэхээсээ илүү эрх зүйт төрийн зарчмын зүй ёсны илрэл юм. Тухайлбал дээр дурдсан оролцогсдын тэгш байдлыг хангах зарчим нь ҮХ-д тусгагдсан, хууль тогтоогчид хандсан хувийн эрх зүйн харилцаанд оролцогсдод нийтэд нь тэгш хандах зарчим уу, либерал ИХ-иудад тусгалаа олсон зарчим эсвэл төр давуу эрхтэй байх социалист тогтолцоог халсан гэдгээ тодотгох элемент үү гэдэг нь тодорхойгүй.

Өмчийн халдашгүй байх зарчим нь ҮХ-иар олгогдсон хувийн өмчийн баталгааг хэрэгжүүлэх шинэ элемент мөн боловч хамгаалалтын хувьд иргэний бусад эрхийн нэгэн адил шүүхэд хандах зэргээр эрхээ хамгаалуулах нийтлэг үндсэн эрхийн баталгаа юм.

Түүнчлэн хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх зэрэг нь нэг талаас төр өмнөх тогтолцоонд иргэний эрх зүйн харилцааг дүрэм, журмаар хялбархан оролцох боломжгүйг тодотгох зорилготой, нөгөө талаас хувийн чөлөөт байдлын зарчим тусгалаа олсон гэж үзэх нөхцөлийг бүрдүүлдэг.

Харин гэрээний чөлөөт байдлын зарчим нь нийт ИХ-ийн зохицуулалтаар амилсан, хэлбэрийн шаардлага, агуулгын цөөн тооны зохицуулалтаар хязгаарлагдсан суурь зарчим мөн⁵⁷. Гэрээний эрх чөлөөг ҮХ-иар хамгаалаагүй, гагцхүү ИХ-ийн §1.2-т тусгалаа олсон тул хувийн эрх зүйн бусад хэм хэмжээг гэрээний чөлөөт байдлыг хэт хязгаарласан эсэхийг тогтооход ихээхэн хүндрэл дагуулдаг⁵⁸.

Хуулийн зорилгыг үгчлэн тодорхойлох шаардлагагүй, харин тухайлан нэрлээгүй байсан ч хуулийн зохицуулалтаас зарчмын шинжтэй болох нь харагдаж байж сая эрх зүйн зарчим хэмээн хүлээн зөвшөөрөгдөх нь зохистой шударга юм. Тиймээс зарим улсад хууль тогтоох гарын авлага бэлтгэхдээ хуулийн зорилго, зарчим зэргийг хуульд өөрт нь дэлгэрэнгүй үгчлэн тусгахыг хориглож, ердийн зохицуулалтаар амилсан байхыг чухалчилж байна⁵⁹. Энд аливаа хуульд утгын тайлбар хийгээгүй байхад агуулга нь туйлын ойлгомжтой байж чадвал сайн хууль гэж тооцогдож, хуульд агуулагдаж буй эрх зүйн зарчим нь хэм хэмжээний нийтлэг олонлогт суурилах ёстой гэж үздэг. МУ-ын ИХ-д дараах үгчлэн тусгасан ба тусгаагүй зарчмууд үйлчилж, тус хуулийн хэм хэмжээг тайлбарлах, онол арга зүйн чиглэл өгдөг.

Хууль тогтоогч ИХ-д зарчмын аргыг ашигласан байдлыг авч үзвэл 1/. ИХ-д эд юмсын эрх зүй ба гэрээний эрх зүй гэсэн хоёр том салбарыг өөр бүлэг, хэсэгт зохицуулсан нь эдгээрийг тусгаарлах зарчим үйлчилнэ гэсэн үг; 2/. үүргийн эрх зүй бүхэлдээ харьцангуй шинжтэй нь нийт зохицуулалтын агуулгаас харагдах тул үүрэг харьцангуй байх зарчим үйлчилнэ. Мөн хувийн эрх зүйн үндэс нь ҮХ-иар хамгаалсан хувийн чөлөөт байдал, хувь хүний эрх чөлөө бөгөөд энэ нь гэрээний чөлөөт байдлын зарчмаар илэрдэг. Түүнчлэн ИХ нь кодификацийн сэтгэлгээний уламжлалыг рецепцийн аргаар шилжүүлэн авсан тул формал тэгш хандах зарчимд

57 Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн удиртгал, 4 дэх хэвлэл, 2021 он, 82 дахь тал; Иргэний эрх зүйн тусгай анги, 6-р хэвлэл, 2021 он, 14 дэх тал.

58 Б.Буянхишиг, “Эдийн засгийн эрх чөлөөг Үндсэн Хуулиар хангалттай хамгаалсан уу?”, Үндсэн Хууль ба эрх зүйт ёс VII, 2016 он, 9-23.

59 BMJ. Handbuch der Rechtsformlichkeit, Rn.362.

суурилна⁶⁰. Судлаач Д.Наранчимэг эдгээр зарчим үйлчилж байгааг бүтээлдээ дурдсан.

Эдгээр зарчим нь кодификацийн аргаар нийт тогтолцооноос илэрч байгаа ч үгчлэн тусгаагүй зэргээс үйлчлэх эсэх дээр нь маргадаг. Эрх зүйн зарчмууд нь хуульд маш олон хэлбэрээр тусгагддаг. Зарим нь удиртгал хэсэгт байх бол нөгөөг нь хуулийн зорилго, чиг үүрэг хэсэгт байршуулдаг. Хууль тогтоогч зарчмын шинжтэй зохицуулалтыг хэрхэн нэрлэсэн нь ач холбогдолгүй. Нэршил, байршил зэрэг нь зарчмын нөлөөллийг өөрчлөхөд нөлөөлөхгүй. Зарчим нь хууль тайлбарлахад туслах гол хэрэгсэл бөгөөд барууны орнуудад эрх зүйн зарчмыг хуульчлах үзэгдлийг эсэргүүцэх үзэл газар авсаар байна.

Өнөөгийн гэрээний эрх зүйн үзэл баримтлал нь анхны хувийн эрх зүйн кодификацид бүрэн тусгалаа олж, улмаар эдийн засгийн хөгжлийг даган улам хурдацтай төгөлдөржиж буйн сацуу энд олон улсын нийтлэг хэм хэмжээ дотоодын хуульд олноор тусгагдаж байна. МУ-ын ИХ-ийн §1.2 дахь иргэний хууль тогтоомж нь гэрээний эрх чөлөөнд суурилах тухай заалт нь хувийн эрх зүйн тулгуур зарчим мөн. Улсын эдийн засгийн тулгуур зарчмууд нь эдийн засгийн баталгаа тул ҮХ-д тусгалаа олох ёстой⁶¹; гэрээний эрх чөлөө нь олон улсын эдийн засгийн эрх зүйн суурь зарчим гэдэг нь маргаангүй⁶² ч МУ-ын ҮХ-д үгчлэн тусгаагдаагүй тул гэрээний чөлөөт байдлыг хөндсөн бусад хууль тогтоомжийг ҮХ-аар хамгаалагдсан эрх зөрчсөн тохиолдолд өмчлөх эрх, аж ахуйн үйл ажиллагаа чөлөөтэй эрхлэх эрх зэрэг бусад үндсэн эрхийн хүрээнд хяналт хийж байгаа⁶³ нь практикт гарч буй бодит хүндрэл бөгөөд салбар эрх зүйн харилцаанд оролцогч хэн бүхэнд хамаарах энэ суурь зарчмыг ҮХ-д ил тод тусгаагүй нь хуулийн техникийн алдаа юм. Гэрээний эрх чөлөөг хамгаалахын тулд тусгай хууль тогтоомж ИХ-ийн §1.2-т заасан зарчимд нийцэж буй эсэхийг нягтлах

60 Өмнөх бүлгээс үзнэ үү.

61 Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, 2008 он, 60 дахь тал; Б.Буянхишиг, Эдийн засгийн эрх чөлөөг ҮХ-иар хангалттай хамгаалсан уу? Сэдэвт илтгэл, ҮХ ба эрх зүйт ёс, VII боть, 9 дэх тал.

62 М.Уянга, Олон улсын эдийн засгийн эрх зүй, 2014 он, 92 дахь тал.

63 ҮХЦ-ийн 2006 оны 1-р сарын 11-ний өдрийн тогтоолоор “Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хууль”-ийн §27.1/2 дахь заалт ҮХ зөрчсөн гэж үзсэн шийдвэр гарсан. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдах явцад эзэлдэгч үндсэн үүргийн харилцаатай холбоотой асуудлаар шүүхэд хандах эрхээсээ татгалзаж, гагцхүү худалдан борлуулах ажиллагаанд гомдол гаргах эрхтэй байхаар журамласныг шүүх “ҮХ-ийн 16-р зүйлийн 14-т заасан шүүхэд мэдүүлэх” эрх хязгаарлагдсан хэмээн хуулийг хүчингүй болгосон. Үл маргах журмаар ипотекийн зүйлийг худалдан борлуулах нь тухайн процессын эрх зүйн хувьд олон улсад зөвшөөрөгдсөн практик тул дээрх заалт зөрчигдсэн эсэх нь эргэлзээтэй. Энэ хэрэгт хууль тогтоогчийн төлөөлөгчид оролцохоор ирээд “үндсэн үүргийн харилцаанаас үүдэлтэй (зээлийн гэрээтэй холбоотой) гомдол саналаа шүүхэд гаргахаас татгалзсан явдал нь гэрээний эрх чөлөөгөө эдэлсэн хэрэг” тул дээрх хууль ҮХ зөрчөөгүй гэсэн утгатай байсан. Гэтэл ҮХЦ-ээс гэрээний эрх чөлөө ба шүүхэд эрхээ хамгаалуулах эрхийн харилцан хамаарлыг огт бодолцоогүй, гагцхүү шүүхэд мэдүүлэх эрхээр шийдвэрийг гаргасан. Энэ нь гэрээний эрх чөлөөг ҮХ-нд маш тодорхой тусгаагүйн нэг үр дагавар юм. Эдийн засгийн нарийн төвөгтэй харилцаанд шүүгч хүн ч өөрийн дотоод итгэлээр үнэн зөв шийдвэр гаргах төвөгтэй болдог тул зөрчилдөх хоёр үндсэн эрхийн тэнцвэржилтийг олдог онолын зарчмыг хэрэглэх ёстой. Дээрх хуулийн §27.1/2 нь шүүхэд мэдүүлэх эрхэнд халдаж буй эсэхийг шалгаад гэрээний чөлөөт байдлын зарчимтай нийцэх эсэхийг практик конкордацийн аргаар тогтоовол энд ҮХ-ийн 16-р зүйлийн 14 зөрчигдөөгүй гэсэн дүгнэлт хийхээр байна. Ер нь ИХ өөрөө заавал мөрдөх болон талуудын тохиролцоогоор өөрчилж болох диспозитив зохицуулалт гэсэн 2 төрлийн хэм хэмжээнээс бүрдэх ба анхнаасаа диспозитив шинжтэй зохицуулалт нь гэрээний эрх чөлөөг дээдлэх хувийн эрх зүйн суурь зарчимтай уялдаатай тул энэ эрхийн илрэл ҮХ-ийн 16-р зүйлийн 14-ийн зөвшөөрөгдсөн хязгаарлалт гэлтэй.

нь үр дүнгүй. Учир нь ҮХ-д ИХ ба бусад хууль тогтоомжид ийнхүү шат дараалал тогтоосон заалт байхгүй тул гэрээний эрх чөлөөг хуулиар хязгаарласан эсэхийг хянах боломжгүй байна. ҮХ-д өөрчлөлт оруулалгүй “өмч хөрөнгө чөлөөтэй олж авах” гэсэн ҮХ-ийн 16-р зүйлийн 3 дахь заалтыг ашиглан тайлбар хийх аргаар ҮХЦ-ээс гэрээний эрх чөлөөг ҮХ-ийн түвшинд хамгаалдаг. ҮХЦ-д мэдүүлж буй гомдлын тайлбарт энэ талаар тусгагдах нь элбэг хэдий ч хуулийг гэрээний чөлөөт байдлыг зарчимд харш эсэхийг Цэц хянаж, шийдвэрийн тогтоох, үндэслэх хэсэгт тусгасан тохиолдол гараагүй байна.

2018 оны ИХ-ийн §280.3-т орсон “хувь этгээд хоорондын зээлийн гэрээнд хүү тооцохгүй” гэх мэт өөрчлөлтийг гэрээний чөлөөт байдлын зарчимд нийцэж буй эсэхийг хянах оновчтой механизм нь энэ суурь зарчмыг ҮХ-иар үгчлэн тусгаж хамгаалах юм. Хувийн эрх зүйн энэхүү суурь зарчим дан ИХ-д байх нь гэрээний эрх чөлөөг хэт хязгаарласан зохицуулалтыг өнөөгийн байдлаар хянуулах боломжгүй болгож байна.

Гэрээний эрх зүйн системчлэл, зарчмуудыг судлан үзэхэд кодификацийн сэтгэлгээний ИХ-иудад тусгалаа олсон зарчим, аргачлал хэрэгжиж байгаа ч эдгээр нь хууль хэрэглээний зарим уламжлалт практиктэй зөрчилдөж буй нь МУ-ын ИХ-ийн гэрээний эрх зүйн системчлэлээс тод харагдаж байна. Францын ИХ /Code Civil/-тэй харьцуулахад МУ-ын ИХ-ийн гэрээний эрх зүйд гэрээ байгуулах нь дангаараа өмчлөх эрхийг шилжүүлэх хүчин зүйл болдоггүй. Энэ нь дотоодын гэрээний эрх зүйг Ромын эрх зүйн бүлд хамаарах концепцийн шинж агуулаагүйг нотолж байна. МУ-ын ИХ-д гэрээний үүргийн эрх зүйг өмчийн шилжүүлгээс тусгаарлан зохицуулах техник ашигласан ч өмчийн шилжүүлэг, өмчийн тогтолцоо хэсэгтээ өмнөх хуулийн техникээ хадгалсан. Харин өнөөгийн хууль тогтоогч энэ зарчим үйлчлэх эсэхийг тодорхой болгох үүрэгтэй. Өөрөөр хэлбэл өнөөгийн ИХ-ийн бүтэц нь өмч, үүргийн тусгаарлалт буй мэт, харин өмчлөгчийн зөвшөөрөл буюу өмчийн хэлцэл хэмээх ухагдахууныг логик бүтцэд оруулаагүй нь эргэлзэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Өмчийн нэгдмэл тогтолцоо. Өмчийн харилцааг хуулиар зохицуулж буй улс орон 2 үндсэн асуудлыг шийдсэн байх шаардлагатай. Үүнд 1/. эдийн засгийн эргэлтэд орж болох үнэт зүйлсийг өмчлөх эрхийн эзэн буюу субъектэд хамааруулах, 2/. тэдгээрийн эдлэх эрх хэмжээ ямар байх буюу өмчлөгчийн байр суурийг тодорхой болгох ёстой.

Эхний асуудлын хүрээнд ямар үнэт зүйлс хэний өмчлөлд байхыг улс бүхэн өөр өөрөөр шийдэх буюу харилцан адилгүй үр дүнд хүрч болно. Нийтлэг байх шийдэл нь хүн бүхэн онолын хувьд эд зүйл бүрийг өөрийн хүссэн хэлбэрээр өмчлөх боломжтой гэсэн үзэл, үүнийг өмчийн үнэмлэхүй шинж буюу универсал зарчим гэнэ⁶⁴. Нөгөө талаас олон төрлийн хуваарилалтын аргыг ашиглах буюу зарим эсвэл бүх хүмүүс тодорхой зүйлсийг эзэмших огт боломжгүй байхаар эсвэл зарим төрлийн эд зүйлс онцгой объектийн шинжийг агуулах журмаар тэдгээрийг гагцхүү тодорхой хэлбэрээр өмчлөлдөө шилжүүлж болох аргаар зохицуулдаг⁶⁵.

64 Jakobs, Otto-Wilhelm. “Das Eigentum Als Rechtsinstitut Im Deutschen und Sowjetischen Recht.” in: *The Rabel Journal of Comparative and International Private Law*, vol. 29, no. 4, 1965, pp. 694–725 (701). JSTOR.

65 Мөн тэнд.

Энэ асуудлыг шийдсэний дараа өмчлөгчийн эрхийг хуульчлах л үлдэх байм хэм хэмжээг өмчлөх эрхийн агуулгыг тодорхойлох хэм хэмжээ гэж нэрлэнэ. Өмчлөгч этгээдийн субъектив эрхийн агуулга нь дээрх хоёр төрлийн хэм хэмжээний нийлбэр, мөн тухайн эрх зүй дэх өмчийн тогтолцооны үндсэн зарчмын шийдлүүдээс бүрдэнэ.

Хүн бүр оршин буй эд зүйлсийг харьяалалдаа авах бололцоотой, өмчийн нэгдмэл тогтолцоо үйлчилнэ гэж үзсэн нь универсал зарчмыг сонгосны илрэл юм. Нэг талаас өмч, эд баялаг нөгөө талаас шударга ёсны үзлийн харилцан хамаарал нь энэ салбарын үзэл баримтлалын тэргүүлэх хэсгийг бүрдүүлэх боловч өмчийн талаарх онолын сэтгэлгээний түүхээс энэхүү суурь ухагдахуун, үзэл баримтлал байнга өөрчлөгдөн хувьсаж байгаа нь харагддаг.

Ийнхүү өмчийн үнэмлэхүй шинжийг онцлох нь өмч хэмээх хамгийн чухал ухагдахууныг олон янзаар тодорхойлсонтой холбоотой нотлох баримт бүрдүүлэх хүндрэлээс зайлсхийх давуу талтай. Кодификацийн сэтгэлгээний уламжлал бүхий либерал зарчимд суурилсан ИХ-иуд нь энэхүү өмчийн универсал шинжийг хүлээн зөвшөөрдөг хэдий ч энэ талаар ИХ-ндаа үгчлэн тусгадаггүй; энд хүн бүр хүссэн зүйлээ хүссэн хэлбэрээрээ өмчлөх нийтлэг боломж бий гэж үзэх ба үр дүнд нь өмчийн нэгдмэл тогтолцоо үйлчилж⁶⁶, аливаа эд баялгийн харьяалал тогтоох тухай зүйл заалтаа энэ зарчимд тулгуурлан бэлтгэнэ. Жишээ нь Германы ИХ-д /BGB/ өмчийн универсал шинжийг хүлээн зөвшөөрсөн бөгөөд энэ талаар ИХ-ндаа үгчлэн тусгаагүй нь зарчмыг энгийн зохицуулалтын хэрэгжилтээс дүгнэх кодификацийн аргыг ашигласан явдал юм. Энд өмчийн шатлал байхгүй нь универсал зарчмыг ягштал баримталсан үзэгдэл бөгөөд хувийн эрх зүйн бусад судалгаа ч үүнээс огт хазайдаггүй.

Өмчийн талаарх энэ үзлийг хэт хийсвэр хэмээн шүүмжилдэг судлаачид хэд хэдэн төрлийн өмч байх боломжтой гэж үздэг⁶⁷. Тэд өмчийг анхнаас нь үл хөдлөх, хөдлөх хэмээх ангилахыг дэмжиж, мөн өмчийн нийгэм дэх чиг үүрэг, хувийн ноёрхлыг хамгаалах чиг үүргээр нь хувийн ба улсын эдийн засаг гэсэн хоёр өөр эдийн засгийн салбар байх ёстой хэмээдэг. Төрийн эдийн засаг ба хувийн хэвшлийн эдийн засгийг тусгаарлах, ялгах нь дээр дурдсан өмчийн универсал зарчмаас хазайсан үзэгдэл бөгөөд энд “res extra patrimonium” буюу өмчлөх боломжгүй эд зүйлсэд өмчлөгч бий болох боломжгүй нөхцөл байдал, түүнчлэн “res extra commercium” буюу өмчлөх боломжгүй зүйлсийг эдийн засгийн эргэлтэд оруулах боломжгүй орчин үүсэж, улмаар тэдгээртэй холбоотой хэлцэл нь хүчингүй хэмээн тооцогдоно⁶⁸.

Нийтийн өмчийн салбар хөгжих тусам өмчлөх, эргэлтэд оруулах боломжгүй зүйлс ихсэх ба эдгээрийг тусгаарлах тусам хувийн хэвшлийн эдийн засгийн хөгжил сүүдрийн шинжтэй болох аюултай⁶⁹. Универсал зарчмаас хазайсан тохиолдолд 1/. эрх зүйн харьяаллын болон 2/. эргэлтэд орох боломжгүйн улмаас өмчлөх эрхийн агуулгын хүрээнд хоёр түвшинд эргэцүүлэх асуудлууд гарна.

66 Аристоль нийтийн өмчийг эсэргүүцсэн тухай Г.Арап-Эрдэнэ, Хувийн өмчийн онол, 2009 он, 20 дахь тал; Wieacker, Wandlungen der Eigentumsverfassung (1935) 9., 25, 70.

67 Платоны үзэл баримтлалыг Г.Арап-Эрдэнэ, Хувийн өмчийн онол, 2009 он, 20 дахь тал; Ц.Цэрэнжээ, Өмчийн эрх зүй, УБ 2000, 113 дахь тал; Wieacker, Wandlungen der Eigentumsverfassung (1935) 9, 25, 70.

68 Jakobs, Otto-Wilhelm. “Das Eigentum Als Rechtsinstitut Im Deutschen Und Sowjetischen Recht.” in: *The Rabel Journal of Comparative and International Private Law*, vol. 29, no. 4, 1965, p. 703. JSTOR.

69 Jakobs, Otto-Wilhelm. “Das Eigentum Als Rechtsinstitut Im Deutschen Und Sowjetischen Recht.” in: *The Rabel Journal of Comparative and International Private Law*, vol. 29, no. 4, 1965, p. 704. JSTOR.

Барууны цөөн судлаачид, ялангуяа Ромын ба Францын хууль тогтоомжид төрийн болон ЗЗНДН-ийн өмчид байх нийтийн эрх зүйн өмч ба иргэний хуулийн дагуу хувь этгээдийн өмчлөлд хамаарах хувийн өмч хэмээх хоёр өмчийн хэлбэр зэрэгцэн орших боломжтой гэж үздэг⁷⁰. Энэ загварын зорилго нь нийтийн өмч төрийн өмчид байх хугацаанд ИХ үйлчлэхгүй байлгах, ингэснээр иргэний эрх зүйн эрх шилжих үйл явцаас сэргийлэх, процессын хувьд шүүхийн шийдвэрийн агуулгын нөлөөлөлд хамаатуулахгүй байлгах явдал байв. Харин төрийн тухай орчин үеийн үзэл баримтлал нь анх эрх зүйн субъект болохыг нь хүлээн зөвшөөрч, хөрөнгийн асуудлаар хувь хүнтэй адил тэгш авч үзсэн. Энэ ухамсар нь нийтийн өмчийг эрх зүйн тогтолцоонд тусгаарлан үзэхгүй үлдээж, төрийн өмчийг хувийн өмчийн тогтолцооны нэг хэлбэр гэсэн нь дундад зууны төрийн захиргаадалтаас татгалзсан дэвшилтэт үзэгдэл гэжээ. Нийтийн өмч нь хувь хүн төвтэй нийгмийг нийтэд төвлөрсөн шинжтэй болгох тул нийтийн өмчийг хүлээн зөвшөөрөх эсвэл ингэхээс татгалзахад шууд утгаараа аль нэгийг нь сонгосон шийдвэр гаргах болдог. Гэхдээ энэ шийдвэрийг гаргахдаа тодорхой үр дүнд төвлөрөх бус, харин энэ хоёр загварын зөвтгөх үндэслэлийг голлон анхаарах ёстой.

МУ-ын эд юмсын эрх зүйн онцлог нь ҮХ болон ИХ-ийн түвшинд өмчийн янз бүрийн хэлбэрийг ялгаж үзэх явдал юм. Үүгээрээ ОХУ-ын ҮХ, ИХ-д агуулагдах өмчийн тогтолцоотой адил төстэй. Тухайлбал ОХУ-ын ҮХ-ийн 8.2.-т “хувийн, төрийн, хотын өмч болон бусад өмчийн хэлбэрийг ижил хэмээн хүлээн зөвшөөрч, хамгаалалт олгосон” ба улмаар ОХУ-ын ИХ-ийн §212-т ижил утга бүхий зохицуулалтыг тухайлбал хувийн өмч, төрийн өмч, нийтийн өмч (ЗЗНДН-ийн өмч) болон “өмчийн бусад хэлбэр” оршин байх талаар заасан⁷¹. Үүний адилаар МУ-ын ҮХ-ийн 5.2-т нийтийн болон хувийн өмчийг хүлээн зөвшөөрч, аль алийг нь хамгаалахаар заасан нь шилжилтийн үеийн зохицуулалт байсан боловч өдгөө ҮХ-ийн 6.2-т газар, түүний хэвлий төрийн нийтийн өмч байхаар нэмэлт өөрчлөлт⁷² оруулсан нь тогтолцооны шинжтэй өөрчлөлт гэж үзэх боломжтой. Энэ нь МУ-ын ИХ-ийн §99.1-д заасан өмчийн хэлбэрүүдтэй хослох замаар МУ-ын өмчийн тогтолцоо, өмчийн концепцийг бүрдүүлж байна⁷³. МУ-ын 1994 оны ИХ-ийн §74.1-д хувийн болон нийтийн өмчийг институтын түвшинд баталгаажуулж байсан уламжлалыг 2002 оны ИХ-ийн §99.1-д нийтийн болон хувийн өмчийн тогтолцоо үйлчлэх тухай заалт үргэлжлүүлж байна. Нийтийн өмч нь төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн хэлбэртэй байхаар ИХ-ийн §99.2-т заасан нь өмчийн эрх зүйн нэгдмэл бус зарчмын илрэл бөгөөд кодификацийн сэтгэлгээний ИХ-иудаас ялгарсан, хувийн өмчийн нэгдмэл тогтолцоог хангахаас татгалзсан хэмээн дүгнэхээр байна. Энэ зохицуулалтыг социалист ИХ-иас шилжүүлэн авсан ба шилжилтийн үед тохиромжтой хэмээн үзсэн⁷⁴.

70 Г.Банзрагч, Эрх зүй сэтгүүл 2016 оны №1, Цуврал 33, “Нийтийн өмчийн талаарх МУ-ын эрх зүйн зохицуулалт”, 62 дахь тал.

71 Комментарий к Гражданскому Кодексу Российской Федерации, Том 1, Части I, II ГК РФ, 6-е издание, под редакцией Т.Е.Абовой/ А.Ю.Кабалкина, 2011 г, с.165/ 261; Суханов: Вещественное Право России, Том I, Часть 7, стр. 473.

72 МУ-ын Үндсэн хуулийн эмхэтгэл (1924, 1940,1960,1992), 2020 он, 17 ба 92 дахь тал.

73 Б.Буянхишиг, “МУ-ын өмчийн тогтолцоо нь либерал ба социалист өмчийн коцепцийн дундах шинэ загвар болох нь” сэдэвт илтгэл, Үндсэн хууль ба эрх зүйт ёс эмхэтгэл, 2021 он, 14 дэх тал.

74 Б.Чимид, Улс төр хуульчийн нүдээр, 2006 он, 140 дэх тал.

ОХУ-ын ИХ нь хувийн өмчийн тогтолцоог эн тэргүүнд тавьсан боловч зах зээлийн эдийн засгийн үед төр, түүний нэгжүүд бусад хувь хүн, хуулийн этгээдээс өөр аргаар өмчлөх эрхийг олж авах эрхтэй байгаа нь ойлгомжгүй хэмээн ОХУ-ын өмчийн тогтолцоог барууны судлаачид шүүмжилдэг⁷⁵. Либерал эрх зүйн тогтолцоонд өмчийн универсал зарчмыг тусгаснаар давхаргын тогтолцооноос үүдэлтэй хязгаарлалтууд үгүй болж, хуваагдмал өмчийн нөхцөл байдлаас ангижирсан бол социалист улсуудын хууль тогтоомжид ҮХ-ийн 6.2-т заасантай адилтгахуйц төрийн өмчийн нэгдсэн сангийн зарчим хэрэгжиж өмчийг төрд төвлөрүүлэх үүргийг баталгаажуулсан. Гэсэн хэдий ч МУ-ын өнөөгийн хуулийн үг хэллэгт суурилан өмчийн үнэмлэхүй бөгөөд туйлын шинжийг хүлээн зөвшөөрч, өмчийн либерал үзэл баримтлалыг хослуулах боломжтой. ҮХ-ийн шинэ тогтолцоо нь зарим судлаачдын хэлж байгаачлан нийтийн шийдвэрлэх асуудал болсноор газар, түүнтэй холбоотой баялгийг “үрэн таран хийхээс сэргийлэх”⁷⁶ арга хэрэгсэл болох ёстой бол органик хуулийн түвшинд төрийн өмчид тусгайлан хандсанаар капиталист ба социалист нийгмийн өмчийн давхаргат тогтолцоо, өмчийн хуваагдмал байдлыг сэргээж, улмаар нийтийн өмчийн тухай хууль олноор батлах бус, харин өмчийн либералчлах нь оновчтой.


Өмчийн универсал шинжийг хадгалах нь өмчийн талаарх нийтийн ба хувийн эрх зүйн хууль тогтоомжийн тэнцвэрийг хангахад чиглэнэ. Жишээлэхэд газрын өмч, эзэмшлийн тогтолцоог салгаж, нэг объектын түвшинд тус тусын хөгжлөөр замнахаас сэргийлэх юм. Үүнд өмчлөх эрхийн хамгаалалт, эрх үүсэх, дуусгавар болох нөхцөл, гүйлгээнд оруулах асуудлыг ИХ зохицуулж байхад энд тусгагдаагүй ганц хэлбэр болох оссиру буюу “булаан эзлэх” эсвэл “олборлох” асуудлыг Ашигт малтмалын хууль тогтоомжид оновчтой байршуулах, мөн бодлогын чанартай Газар, Ой, Усны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ИХ ба Газрын тухай хуулийн чиг үүргийн давхардлыг ялгаж, салгаж, арилгах ажлыг хийх нь концепцийн тулгамдсан асуудал юм⁷⁷. Тиймээс өмчийн концепцийг бүрдүүлж буй хууль тогтоомжийн нийлбэрийг цогцоор нь харж, тус тусад нь хуульчлах замаар өмчийн шаталсан тогтолцоог бий болгохын оронд бүгдийг нэгдсэн хэлбэрээр ойлгож, тэнцвэржүүлэх нь чухал юм. Гагцхүү энэ тохиолдолд л ҮХ-ийн нэмэлт өөрчлөлт нь өмнөх дэглэмд буцаж шилжсэн үзэгдэл биш, харин либерал ба социалист загварын дундах шинэ буюу гуравдагч замыг олсон үйл явдал хэмээн хүлээн зөвшөөрөгдөх боломжтой.

ИХ-ийн зарчмуудыг зайлшгүй үгчлэн дурдах албагүй ч зарчмын түвшинд хийвэл зохих шинэтгэлийг дараах байдлаар багцлав:

75 Butler W.E., Russian Law, 3d edition, Oxford, 2009, Ownership 9.50., p. 403.

76 Б.Чимид: Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал, 2-р дэвтэр 2008 он, 147 дахь тал.

77 Б.Чимид: Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал, 2-р дэвтэр 2008 он, 145-174 дэх тал.



II. ИХ-д агуулгын анализ хийх нь

1. Хувь этгээдийн эрх зүйн байдал:

Эрх зүйн чадварын үл хуваагдах шинж. Либерал ИХ-иуд нь ихэвчлэн “хувь этгээд”, “хувийн эрх зүйн харилцаанд оролцогч” гэсэн гарчиг бүхий зүйл заалтаар эхлэх бол МУ-ын болон ОХУ-ын ИХ нь иргэний эрх зүйн харилцааг тогтоох социалист уламжлалт техникийн дагуу харилцааг тодорхойлсон заалтаар эхэлдэг.

МУ-ын ИХ-д §15-с “иргэний эрх зүйн чадвар” гэсэн нэр томъёог ашигласан нь хувийн эрх зүйн салбарын бүх эрхүүдийг бүх хүн тэгш хүртэх бодит боломж хязгаарлагдмал учир тусгай эрх зүйн чадвар байх боломжтой⁷⁸; иргэний эрх зүйн чадвар гэдэгт хувийн эрх зүйн салбарт эрх эдэлж, үүрэг хүлээх боломжийг ойлгож байсан хэмээн өрөөсгөл тайлбарт хүргэж байна⁷⁹. Үндсэндээ бүх эрх зүйн чадвар бүхий этгээд иргэний эрх зүйн харилцааны субъект байх бололцоотой, мөн энэ нь ямар ч нөхцөлд хязгаарлагдахгүй байх нь ямагт эрх зүйн субъект болдог хувь хүний төрөлхийн шинжтэй холбоотой. Тэрээр иргэний гүйлгээнд буюу хэлцэл суурьтай эрх зүйн харилцаанд, тухайлбал үүргийн эрх зүй, хэлцлийн үндсэн дээр үүсэх эд юмсын эрх зүйн болон худалдааны эрх зүйн харилцаанд бүх хувь этгээд оролцох, бүх эрх зүйн институтийг ашиглах боломжтой. Тиймээс ИХ-д хувь этгээдийн чадвар нь ҮХ-ийн адил нийтлэг эрх зүйн чадварт суурилна.

78 Ч.Нямсүрэн, Эрх зүйн онол, 2010 он, Palandt, Bürgerliches Gesetzbuch, 64. Aufl., 2005, S.9.

79 Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн удиртгал, 2014 он, 2 дахь хэвлэл, 44 дэх тал.

Онолын хувьд хувь хүний эрх зүйн чадвар нь үл хуваагдах шинжтэй. Энэ шалтгааны улмаас эрх зүйн чадварыг “иргэний эрх зүйн” болон “нийтийн эрх зүйн” хэмээн салбар эрх зүйгээр ангилах ёсгүй. Гэсэн ч ИХ нь эрх зүйн чадварыг нийтлэг хэмээн хүлээн зөвшөөрөөгүй, мөн тусгай эрх зүйн чадварын зохицуулалт агуулах нөхцөлд үүнийг ҮХ-д нийцэх эсэхийг нягтлах шаардлагатай. Энэ шалтгаанаар хувь хүний гэрлэх “чадварын” тухай олон улсын эрх зүйд ярихдаа “гэрлэх нас, чадамж” гэж нэрлэх эсвэл өөр үг хэллэгээр орлуулах нь зөв гэдэг. Түүнчлэн энэ нь хувь хүний эрх зүйн чадварыг жам ёсны байгалиас заяасан гэж үзэх кодификацийн сэтгэлгээний эсрэг, социалист эрх зүйн бүлд байсан “аливаа чадвар” нь хязгааргүй эрхт төрийн хуулиар олгосон гэх норматив утгыг дэмжсэн хуулийн техник юм.

Эрхийн хамгаалалт. Онолын хувьд хувь этгээдийн эрх зүйн байдлыг 1/. эрх зүйн этгээдийн тухай зохицуулалт, 2/. хувь этгээдийн эрхийн тухай гэсэн хоёр хэсэгт хувааж зохицуулдаг. “Хувь хүн” гэсэн ерөнхий нэр томъёо нь эрх зүйн харилцааны субъект байх боломжийг илтгэнэ. Эрх зүйн чадвар болон хувь хүнтэй холбоотой эрх зүйн хамгаалалтыг адилтгаж хэрэглэвэл эрх зүйн ухагдахууны мөн чанарт харш⁸⁰; хувь хүний үнэ цэнийг илтгэдэг эрх зүйн чадвар хэмээх ухагдахуун бүхий хэсэг нь хамгаалалтаа нэгэн зэрэг агуулах боломжгүй гэж үздэг⁸¹.

Хувь хүн нь амьдралынхаа туршид өөрийгөө хөгжүүлэн төгөлдөржүүлж, бусдаас тодорхой үнэлэмж олж авах ба эндээс тухайн хүний хувь шинжийн талаарх үзэл баримтлал үүсэж хөгжсөн. Жишээ Францын иргэний эрх зүйн онолд хувь хүний эрхүүдийг эрх зүйн хамгаалалтын хүрээнд тусгаарлан зохицуулсан. Энэ аргачлал нь кодификацийн онолд хувь хүний эрх зүйн байдлыг хамгаалалтаас нь тусгаарлах ойлголтыг бий болжээ⁸². МУ-ын ИХ-ийн §§21, 27-д амины эрхийн хамгаалалтыг хувь хүний эрх зүйн байдалд хамаатуулан зохицуулсан байгаа нь хувь этгээдийн байдал ба хамгаалалтыг нэгтгэсэн үйлдэл юм.

Хүснэгт. Хувь этгээдийн эрх зүйн байдлыг харьцуулах нь

Харьцуулалтын объектууд /ИХ	Эрх зүйн этгээдийн тухай зохицуулалт	Хувь этгээдийн эрхийн хамгаалалт
МУ-ын ИХ	ИХ-ийн §§14-19, 25-26	ИХ-ийн §21, 12 /27 Гэм хорын эрх зүй
ХБНГУ-ын ИХ	1-р бүлэг. Хувь этгээд нь Иргэн, хэрэглэгч, аж ахуй эрхлэгч байна	Гэм хорын эрх зүй
Францын ИХ-д (Code Civil)	Эрх зүйн чадварын нийтлэг ойлголт personalite	хувь хүний эрх зүйн чадварыг хувь хүний амины эрхээс эрс тусгаарлах үзэл
Швейцарийн ИХ-д (ZBG)	Хувь этгээдийн зохицуулалтаар эхэлнэ	ZGB 28 a III, ZGB 28 g III Холимог хэлбэрээр зох.

80 Zweigert\ Kötz: Einführung in die Rechtsvergleichung, 3. Aufl., 1996, S.98.

81 Zweigert\ Kötz: Einführung in die Rechtsvergleichung, 3. Aufl., 1996, S.84.

82 Zweigert\ Kötz: Einführung in die Rechtsvergleichung, 3. Aufl., 1996, S.318.

Хуулийн этгээдийн нэрийн эрхийн хамгаалалтыг мөн ИХ-ийн §27-д үргэлжлүүлэн байршуулсан нь эрх зүйн чадвар ба эрхийн хамгаалалтын асуудал нэгдмэл байгааг харуулж байна. Түүнчлэн арилжааны эрх зүйг ИХ-ийн нэгдмэл кодификацаас тусгаарлах легитимацийн асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүн буюу иргэн, арилжаа эрхлэгч буюу арилжааны нэгжүүдийг эрх зүйн үүднээс харилцан адил бус байдлаар авч үзэх шалтгаан нөхцөл бүрдүүлнэ. Хэрэв эрх зүйн бодлогын хүрээнд тусгаарлах шийдвэр гаргаваас хувь этгээд хэмээх нэгдмэл ойлголт 2 төрөлд бус, харин 2 тусдаа хэлбэрээр илрэх юм.

Хувь хүний эрхийн зөрчил нь гэм хорын эрх зүйн зохицуулалтын бүрэлдэхүүнийг хангасан тохиолдолд эрхийн хамгаалалт амжилттай хэрэгжинэ. Тиймээс энд ИХ-ийн ерөнхий ангид тусгагдсан хувь этгээдийн хамгаалалтын зохицуулалт ба гэм хорын эрх зүйн шаардах эрхийн хоорондын уялдаа холбоог хуулийн системийн үүднээс тодорхойлох шаардлагатай. Хувь этгээдийн эрх зөрчигдөхөөс хамгаалах үйл явц нь аргагүй хамгаалалт хэрэгжүүлээгүй нөхцөлд гэм хорын эрх зүйн шаардах эрхийн бүрэлдэхүүнээс ихээхэн хамаарна. Эцсийн бүлэгт гэм хорын эрх зүйн хамгаалалт нь хуулийн техникийн хувьд ерөнхий ангийн хувь этгээдийн хамгаалалтын үргэлжлэл бөгөөд энэ хоёр бүлэг зохицуулалт зарчмын хувьд нягт уялдаатай юм. Тиймээс ИХ-ийн §§21,27 дахь хамгаалалтыг системийн хувьд хуулиас үүдэх үүрэгт хамаатуулан үзэж, хамтад нь зохицуулах нь оновчтой.

Хохирлын эрх зүйн тэнцвэрт байдал. Хувийн эрх зүй, түүний дотор хувь хүний эрхийг хамгаалах зарчим нь гэм хорын эрх зүйн хамгаалалтыг зайлшгүй шаарддаг. Эдгээрийг хүний амины эрхийн хамгаалалт гэж үзэх ба хувь хүний эрхийн зөрчил бүхэн хохирлыг арилгах ойлголттой салшгүй холбоотой болдог. Хохирлын эрх зүй нь системийн хувьд үүргийн ерөнхий ангийн зохицуулалт болох ИХ-ийн §§228-230, мөн гэм хорын эрх зүйн хохирлыг арилгах тухай ИХ-ийн §§505-510 гэсэн 2 хэсгээс бүрддэг. Хохирол нь материаллаг болон материаллаг бус, сэтгэл санааны хохирлыг нэгэн адил хамрах ёстой. Өөрөөр хэлбэл хувь этгээдийн эрхийн зөрчлийг арилгуулах, хохирлыг барагдуулахтай холбоотой бүлэг зохицуулалт нь ИХ-ийн кодификацийн үзэл баримтлалаар нягт холбогдож, нэг нь нөгөөгөө хэрэгжүүлэх арга хэрэгсэл болох тул эрхийн хамгаалалтын системчлэлийг бүрдүүлнэ.

МУ-ын ИХ-д эдийн бус, сэтгэл санааны хохирлыг арилгах зохицуулалт хангалтгүй байгаа нь хувь этгээдийн амины эрхийг тал бүрээс нь хамгаалах ИХ-ийн суурь үзэл баримтлалтай нийцэхгүй болохыг судлаачид тэмдэглэсээр ирсэн⁸³. Тухайлбал нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд нь хувь этгээдийн амины эрхийн тусгай ойлголтууд байдаг. Эрх зүйн тогтолцоонд алив хүнээр хүндэтгүүлэх, чөлөөтэй хөгжих, үйл хөдлөл хийх ерөнхий эрх нь хувь этгээдийн эрх зүйн үндэс, энэ талаарх зохицуулалтад тусгалаа олсон байх ёстой. Гэм хорын эрх зүйн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийн хамгаалалт нь хувь хүний эрхийн төгс хамгаалалт болж чаддаггүй. Эдгээр нь ИХ-ийн §§12, 21, 27-д тусгагдсан нэрийн эрхийн нэг хэсэг бөгөөд үүнээс гадна хамгаалбал зохих амины эрхүүд, жишээлбэл тэмдэглэлийн дэвтэр, өвчний түүх зэрэг хувийн нууцад хамаарах хэсэг нь эзнийхээ хувьд эд хөрөнгө болон бусад эрхээс өөрцгүй үнэт зүйлс юм. Иймд эдгээрийг ИХ-ийн §497-д тусгасан үнэт зүйлс, эрхийн адил хамгаалах шаардлагатай.

83 Э.Отгонзул, Эдийн бус хохирол, түүнийг арилгах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь сэдэвт бакалаврын дипломын ажил, МУИС-ийн ХЗС, 2011 он, 25 дахь тал.
Сүхбаатар, Хүний нэр төр, алдар хүндийн эрх зүйн хамгаалалт, 2012 он, 135-136 дахь тал.

Тиймээс энэ зүйлийн “бусад эрх” хэмээх тодорхойгүй нэр томьёонд хамаатуулан үзнэ⁸⁴.

Түүнчлэн эдгээр амины эрхийн зөрчлийн үр дагаврыг эдийн бус хохирлыг барагдуулах зохицуулалтгүйгээр төсөөлөх боломжгүй. Хууль тогтоогч ИХ-ийн §230-д гагцхүү “хуульд заасан нөхцөлд барагдуулна” гэсэн нь хувь этгээдэд бодитоор учирсан хохирлын тэн хагасыг гаргуулах үр дагаварт хүргэдэг. Энэ талаарх хамгийн өргөн хүрээтэй зохицуулалт Протугалийн ИХ-д бий. Үүнийг “хувь этгээдийн эрхийн нийтлэг хамгаалалт” бүлэгтэй харьцуулбал “хувь хүний эрхийг бүхий л хууль бус халдлага, биеийн болон сэтгэл санааны хувьд хувь хүн байх эрхэд аюул заналхийлсэн үйлдлээс хамгаална. Энд хувь хүний амины эрх нь насан эцэс болсны дараа ч хамгаалалтад багтана” гэж заажээ.

Шүүхийн практикт ИХ-ийн §21 нь нэр төр, ажил хэргийн нэр хүнд, алдар хүндэд халдсан нөхцөлд холбогдох эрхийг сэргээх шаардах эрх болдог⁸⁵. УДШ-ээс зохион байгуулсан “Эдийн бус баялгийн хохирлыг арилгах зарим асуудал сэдэвт” бага хурлаар ИХ-ийн §511-ийг практикт бие даасан шаардах эрхийн түвшинд хэрэглэж байгаа тухай тэмдэглэсэн. Ийнхүү иргэний эрх зүйн салбарт хүний нэр төр, алдар хүндийн эрхийг ИХ-ийн §§497, 21, 511 хамгаалж буй боловч эдийн бус гэм хорыг арилгах арга зам хангалтгүй гэсэн дүгнэлтэд хүрэхээр байгаа⁸⁶, энэ нь хувь этгээдийг эрхийг хамгаалах үндсэн зарчимд үл нийцэх үр дүн юм. Тухайлбал ИХ-ийн §§230, 511-ийн хүрээнд сэтгэл санааны хохирлыг үнэлэх асуудал хангалтгүй байгаа бөгөөд системийн хувьд дутуу болох нь хэд хэдэн судалгаагаар нотлогдсон⁸⁷.

Хуулийн хүрээнд системийн тайлбар хийж үзвэл ИХ-ийн §511-ийн үндсэн зорилго нь нэр хүнд, ажил хэргийн нэр хүндэд холбоотой худал мэдээлэл тараах нөхцөлд зөрчил нотлох баримтаар нотлогдохгүй бол хариуцагч эд хөрөнгийн хохирлоос гадна эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлүүлэхэд чиглэсэн punitive damage олгох зохицуулалт мэт харагдаж байна. Нэхэмжлэгч шүүхэд нэхэмжлэлээ гаргахдаа түүний нэр хүндэд халдсан баримтат үйл явцыг нэхэмжлэлдээ тодорхой хэлбэрээр бичиж, дурдах ба үүндээ учирсан хохирол, мэдээ тараасан арга хэрэгсэл зэргийг тусгаж, ингэснээр л шүүх уг хэргийг авч хянан хэлэлцэх нь ойлгомжтой. Харин процессын явцад хариуцагч гол нотолгооны үүргийг хүлээх нь шударга, нотлох баримт хуваарилалтын хувьд хариуцагчид гол ачааг үүрүүлсэн нь оновчтой. Гэхдээ энд нотлох баримт хуваарилалтыг чухалчлахаас илүүтэйгээр ямар нөхцөлд “нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд” халдсан гэж үзэх тухай үндсэн шалгуурыг тодотгох асуудал гарна. Дээрх зохицуулалтыг хэрэглэх явцад бие махбод, амь насанд хохирол учруулснаар үүсэх эдийн бус

84 Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, Анхны хэвлэл, 2010 он, 340 дахь тал; 3 дахь хэвлэл, 434-440 дэх тал.

85 Өвөрхангай аймгийн сум дундын шүүхийн шийдвэр: МУ-ын шүүхийн шийдвэрийн эмхэтгэл, Иргэний хэрэг 2010/8, 4 дэх тал.

86 УДШ: “Эдийн бус баялгийн хохирлыг арилгах зарим асуудал сэдэвт” бага хурлын эмхэтгэл, 2014 он, 33 дахь тал.

87 Ш.Сүхбаатар, Хүний нэр төр, алдар хүндийн эрх зүйн хамгаалалт, 2012 он, 135-136 дахь тал; Э.Отгонзул, Эдийн бус хохирол, түүнийг арилгах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь сэдэвт бакалаврын дипломын ажил, МУИС-ийн ХЗС, 2011 он, 30 дахь тал; Д.Ганхүрэл, МУ-д сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх эрхийг хүлээн зөвшөөрсөн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2019 оны №3, 32 (40) дахь тал.

хохирлыг нөхөн төлүүлэх асуудал өнөөг хүртэл шийдэгдээгүй. Эдийн бус хохирлыг арилгуулах асуудлын хүрээнд “нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд” халдсанаас бусад тохиолдолд мөнгөн төлбөр олгогдохгүй байгаа нь ИХ-ийн §230 нь эдийн бус хохирол зөвхөн хуульд заасан нөхцөлд л арилгах боломжтой гэсэнтэй шууд холбогдоно. Энэ нь ИХ-ийн §511-ээс өөр эдийн бус хохирол нөхөн төлүүлэх арга хэрэгсэл байхгүйг сануулдаг. Нэгэнт ИХ-ийн §230-д ийм зохицуулалт байхад өөр ямар ч зохицуулалтыг эрүүл мэндийн эрх зөрчигдсөн үед төсөөтэй хэрэглэх боломжгүй. Практикт “Бие махбод, амь насанд хохирол учруулснаар үүдэх эдийн бус хохирлыг нөхөн төлүүлдэг болох” нь зүйтэй гэсэн саналыг хууль хэрэглэгчдийн дийлэнх олонх нь гаргасаар байна⁸⁸. Энэ нь халдлагын улмаас хохирогчид их сэтгэл санааны хохирол учирдагтай холбоотой. Тиймээс дэлхий нийтийн жишгийг дагаж, сэтгэл санааны хохирлыг арилгадаг болох нь хувь этгээдийн хамгаалалтын чухал хэсэг юм. ИХ-нд зохих өөрчлөлт ороогүй нөхцөлд шүүхийн зүгээс төсөөтэй хэрэглэх асуудал хуулиар хориотой. Тиймээс ИХ-ийн §230-ыг өөрчлөн найруулах нь хувь этгээдийн хамгаалалтыг төгс болгох талтай.

Харин ИХ-ийн §230 нь зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд л эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлөх хязгаарлалт хийсэн нь гагцхүү нэр төрийн болон дүрсийн эрхийн зөрчлөөс учирсан эдийн бус хохирлыг авч үзэж, бусад үнэт зүйлсийн зөрчлийн хүрээнд үүссэн эдийн бус хохирлыг орхигдуулдаг. Энэ нь иргэний эрх зүйн хохирол арилгахаас өмнөх байдалд эрхийг сэргээх үндсэн зарчим, цаашлаад ҮХ-иар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхолд үл нийцэж, тэгш ёс, шударга ёсонд харш үзэгдэл юм. Хувь этгээдийн эрхийг хамгаалахад чиглэсэн дээрх зохицуулалтыг кодификацийн үндсэн хэсэгт тусгах явдал нь хувь этгээдийн эрхийн зөрчлийг арилгуулах зохицуулалтыг хэрэгжүүлэх кодификацийн арга бөгөөд энд үүргийн эрх зүйн хохирол арилгах зохицуулалтыг хэрэглэхэд хүргэж, улмаар хохирлын хэлбэр, төрлөөс хамааран холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгохыг шаарддаг. Дээрхээс үзвэл хувь этгээдийг тэгш бөгөөд төгс хамгаалах кодификацийн үзэл баримтлал нь амины эрхийн зөрчлийг арилгуулахад чиглэсэн бүх алхмыг авч хэрэгжүүлэхийг шаардах ба ИХ-ийн §230-ыг нээлттэй орхисон нь зарчимд үл нийцэх, хуулийн алдаа мөн.

Хувийн эрх зүйн нэгдлийг эрх үйн харилцаанд тэгш оролцох боломжийг хангах. Нийт хувийн эрх зүйн нэгдлүүдийг хуулийн этгээд буюу эрх зүйн чадвартай, эрх зүйн чадваргүй хэмээн ангилж байгаа нь жам ёсны болон кодификацийн сэтгэлгээний эсрэг, норматив хандлагыг илэрхийлнэ. Эрх зүйн чадварын асуудал нийтлэг хувь этгээдийн эрх зүйн байдалд хамаарах бол эрх зүйн чадамжийн хувьд тусгай хууль тогтоомж үйлчилнэ. Жишээлбэл энд Компанийн тухай хуулийн §83.6 зэрэгт дурдсан орган төлөөллийн бүтцийг ашиглан хуулийн этгээдийн чадамжийг бий болгодог. Иргэн, хувь хүнээс гадна бүртгүүлсэн хуулийн этгээд иргэний эрх зүйн чадвартай байх тухай МУ-ын ИХ-ийн §§25-26-д тусгасан. Социалист улсуудын хувийн эрх зүйн онолд 1/.өөрийн гэсэн дотоод зохион байгуулалттай байх; 2/.гишүүдийн хөрөнгөөс тусдаа хөрөнгөтэй байх, 3/. эрх зүйн гүйлгээнд бие даан өөрийн нэрээр оролцох, 4/. хүлээсэн үүргээ өөрийн хөрөнгөөр хариуцан гүйцэтгэх шинжээр хуулийн этгээдийг тодорхойлж байсан⁸⁹. Эдгээр нь хожим ИХ-ийн §25.1-д тусгалаа олсон байна.

88 Ш.Сүхбаатар, Хүний нэр төр, алдар хүндийн эрх зүйн хамгаалалт, 2012 он, 135-136 дахь тал;
Э.Отгонзул, Эдийн бус хохирол, түүнийг арилгах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь сэдэвт бакалаврын дипломын ажил, МУИС-ийн ХЗС, 2011 он, 25 дахь тал.

89 БНМАУ-ын Дээд Шүүхийн хэвлэл: БНМАУ-ын Иргэний эрх (Товч сурах бичиг), 1966 он, 97 дахь тал.

МУ-ын ИХ-ийн §26 нь хуулийн этгээд эрх зүйн харилцаанд субъект байх нөхцөлийг бүртгэлтэй нягт холбоотой хэмээн заасан нь практикт бусад хувийн эрх зүйн нэгдлийг субъект байх боломжгүй гэх үзлийг бий болгодог сул талтай. Үнэн хэрэгтээ СӨХ зэрэг ИХ-ийн §25-ын шалгуурыг хангаж буй бүртгэлгүй этгээдийг эрх зүйн харилцааны субъект байх чанарыг хүлээн зөвшөөрөх, ИХШХША-нд зохигчоор оролцуулах шаардлагатай. ИХ-ийн §26 үүнд саад болж байгаа мэт үзээд, шүүх эрх зүйн харилцаанд оролцох бүрэн чадвар бүхий нэгдлүүдийг эрх зүйн субъект хэмээн хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж, тэдгээрийн ИХШХША-нд бие даан оролцох боломжийг үгүйсгэдэг нь тэнцвэргүй байдал үүсгэдэг⁹⁰. ИХ-ийн §7.1-д хуулийн этгээдийн эрхгүй байгууллага мөн иргэний эрх зүйн харилцааны оролцогч байхаар заасан нь огт хэрэгжихгүй байна. ИХ-ийн §26.1-ийг “бүртгэлээс хамаарах этгээдийн эрх зүйн чадвар нь бүртгэсэн үеэс эхлэн бий болно” хэмээн тайлбарлах, өөрчлөн найруулах, үүний сацуу бусад иргэний эрх зүйн нэгдлүүдийн чадварыг шүүхээр алган хүлээн зөвшөөрөх боломжтой байх ёстой. Үүний тулд норматив үзлээс хөндийрч, жам ёсны сэтгэлгээг дагах, энэ өнцгөөс дээрх зохицуулалтыг тайлбарлах шаардлагатай.

Эрх зүйн чадамж. ИХ-д эрх олж, үүрэг хүлээх чадвартай этгээд эрх зүйн харилцаанд бие даан оролцох боломжтой ч энэ нь бодит байдал дээр тухайн этгээдийн хариуцлагаа ухамсарлах, юмыг дүгнэж цэгнэх чадвараас шууд хамааралтай. Хариуцлагаа ухамсарлах энэхүү нөөц бололцоог иргэний эрх зүйн чадамж хэмээн тодорхойлж, МУ-ын ИХ-ийн §15.1-ийн дагуу 18 наснаас, Швейцарийн ИХ-ийн дагуу 20 наснаас эхлэхээр тус тус заажээ. Харин насанд хүрсэн этгээд эрх зүйн чадамжгүй болохыг нотлоход шийдвэр гаргах чадваргүй, хариуцлага хүлээх ухамсаргүй, хариуцлага хүлээх боломжийг хязгаарласан нөхцөл байдал илэрсэн эсэхийг харгалзан үздэг. Шийдвэр гаргах чадвартай ч хариуцлага хүлээх ухамсар бага эсвэл хязгаарлагдмал болох нь тогтоогдсон этгээд нь хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөлтэй үйлдэл хийж, үүрэг хүлээх бололцоотой.

Хуулийн техникийн хувьд энэхүү суурь зохицуулалт нь аливаа субъектийн эрхээ хэрэгжүүлэх гадаад хэлбэрийг заах тул “эрхийн харьяалал” хэмээх ухагдахуунаар ерөнхийлөн томъёологдоно. Үндсэн зарчмын шинжтэй энэ ойлголт нь хувийн эрх зүйн салбар бүрд холбогдох этгээдийн эрхээ хэрэгжүүлэх боломжийг нийтлэг хэлбэрээр тодорхойлсон хэдий ч утга агуулгын хувьд уг томъёоллыг тусгайлан авч үзэх боломжтой. Тухайлбал эрх эдэлж, үүрэг хүлээх чадамж нь тодорхой эрх зүйн учир холбогдол бүхий үйлдэл хийх чадамж хэмээн нэрлэгдэх боломжтой, (иргэний) эрх зүйн чадамж гэх ухагдахуунтай нэгэн ижил утгатай ИХ-д тусгагдсан. Дараачийн түвшинд энэ нь “хэлцэл хийх чадамж”, мөн гэрээний эрх зүйд “гэрээ байгуулах чадамж” гэсэн агуулгыг илэрхийлнэ.

Насанд хүрээгүй этгээд нь гэрээний хариуцлага хүлээх боломж бий эсэх тухай асуудал гэрээний эрх зүйн философийн хүрээнд хөндөгддөг гол асуудал юм. Хувийн эрх зүйн кодификацууд үүнд хариулахдаа гэрээний гүйцэтгэл хувь хүний хувьд, мөн эдийн засгийн үүднээс хэрхэн нөлөөлөхийг голлож үздэг. Гэрээ байгуулахад оролцох чадамжийг тухайн гэрээний онцлогоос шалтгаалан янз бүрээр авч үзсэн байна. Жишээ нь хөдөлмөрийн гэрээ байгуулах нь өдөр тутмын хэрэглээний эд хөрөнгө олж авах зорилгоор байгуулах гэрээнээс огт өөрөөр үнэлэгдэх нь бий. Гэрээний эрх зүй дэх эрх зүйн чадамж нь гэр бүлийн эрх зүйн хүрээн дэх чадвар,

90 Д.Энхзүл, Хувийн эрх зүйн байгууллага ба түүний эрх зүйн чадвар, Эрх зүй сэтгүүл, 2018 оны тусгай дугаар, 263 ба 271 дэх тал.

чадамжаас огт өөр. Энэ салбар дахь хувь этгээдийн эрх зүйн холбогдолтой эрх зүйн институтийг нь гэрээ, хэлцлийн чадамжтай шууд холбох аргагүй.

Гэр бүлийн эрх зүйд аажим шинэтгэл хийж байсан ч энэ салбарыг кодификацжуулах асуудал өөрийн гэсэн онцлогтой, шилжилтийн үедээ явж байгаа гэж хэлж болно. Тухайлбал гэр бүлийн хөрөнгөтэй холбоотой эрхийг МУ-ын ИХ-ийн §126-с эхлэх зүйл заалтад тусгасан нь үндсэн кодификацад багтсан, бусад зохицуулалтыг Гэр бүлийн тухай хуульд тусгайлан хуульчилсан. Хууль тогтоох онолын өнцгөөс энэ салбарыг тусгайлсан кодификацийн аргаар нэгтгэх бүрэн боломжтой. ХБНГУ-ын жишээг үзвэл гэр бүлийн эрх зүй нь хувь этгээдийн эрх зүйн үргэлжлэл байх ёстой гэдэг утгаараа ИХ-ийн 4 дэх номд тусгагдсан. Тусгайлсан кодификацийн аргаар бүтсэн энэ хууль нь онцгой нөхцөлд зарим гэр бүлийн эрх зүйн асуудлыг энгийн хуулиар тусад нь зохицуулахыг зөвшөөрдөг ч, ерөнхий ангийн техникийн дагуу “хувь этгээд” хэмээх ухагдахуун гэр бүлийн эрх зүйг кодификацийн хэсэгт тусгах үндсэн шалтгаан хэмээн үздэг.

2. Гэрээний эрх зүй. МУ-ын ИХ нь хувь этгээд хоорондын болон арилжааны олон тооны гэрээ хэлцлүүдийг зохицуулснаараа кодификацийн сэтгэлгээний ИХ-иудын гэрээний эрх зүйгээс илүү эдийн засгийн агууламж давамгайлсан шинжтэй, худалдааны эрх зүйн кодификаци билээ. Энэхүү хувийн эрх зүйн гол институт нь хоёр талын хүсэл зоригийн илэрхийллийн нэгдэл дээр тогтох ба гэрээний эрх зүйн мөн чанарыг талуудын зөвшилцөл (конзэнсийн зарчим) илтгэх тул энэ нь гэрээний эрх зүйн онолын үзэл баримтлалын суурь юм⁹¹. Гэрээний эрх зүйн тусгай ангийн бүтэц, ангиллыг авч үзвэл бараа, үйлчилгээ нийлүүлэх болон ажил гүйцэтгэх, туслалцаа үзүүлэх гэрээнд ихээхэн ач холбогдол өгсөн. Эдийн засаг, нийгмийн амьдралд зээлийн болон хамтран ажиллах гэрээний харилцаа их чухал байр суурь эзэлдэг. Харин гэр бүлийн болон өвийн эрх зүйн салбарын гэрээ, хэлцлүүдийг дээрхээс огт өөр өнцгөөс харах, дүгнэхийг шаардана⁹².

Гэрээний эрх зүй нь гэрээний тусгай төрлүүдээс гадна хууль тогтоогч бүх гэрээнд үйлчлэх зүй тогтлын шинжтэй нийтлэг хэм хэмжээг Үүргийн ерөнхий ангид төвлөрүүлсэн. Үүргийн хэлцлийн хувьд практикт хэвшсэн заншлыг гэрээний эрх зүйн үр дагавартайд тооцож шийдэх нь тухайн үүргийн харилцаанд шударга ёсыг тогтоох эерэг нөлөөтэй. МУ-ын хувийн эрх зүйд нийтлэг тогтсон заншил төлөвшсөн, хэм хэмжээний түвшинд хүрсэн талаар судалгаа маш бага, ХЗДХЯ-ны захиалгаар анх арилжааны заншлын хэм хэмжээг 2020 онд судалсан⁹³. Үүргийн эрх зүй, үүргийн хэлцэл хэмээх ерөнхий ухагдахуун нь ромын эрх зүйн бүлд анх “облигац” буюу үүрэг хэмээх түүхэн ойлголтоос эх авсан ба гэрээ хэлцлийг ийнхүү ерөнхий ухагдахуун ашиглан нэгтгэх арга нь (хаалтын арга гэх) гэрээний эрх зүйг бусад үүргийн эрх зүйн харилцаатай хослуулах боломжийг бүрдүүлдэг. Хуулийн техникийн хувьд гэрээний эрх зүй нь ИХ-ийн ерөнхий анги, үүргийн ерөнхий анги, тусгай ангийн зохицуулалтаас хослон бүрддэг⁹⁴. Тиймээс Гэрээний эрх зүйн институтийг сайжруулахад эдгээр зохицуулалтын уялдааг хангах нь чухал.

91 Б.Тэмүүлэн \ Д.Энхзул \ Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн ерөнхий анги, 2010 он; Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, 2010 он, Анхны хэвлэл.

92 Б.Буянхишиг, Гэрээ байгуулах арга техник, 2017 он, 2 дахь хэвлэл, 119-131 дэх тал.

93 ХЗДХЯ-ны захиалгаар хийсэн Арилжааны хуулийн төслийн хүрээнд арилжааны харилцаанд хэрэглэгдэх заншлыг судалсан тайлан, 2020 он.

94 Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, 2010 он, Анхны хэвлэл, 25 дахь тал.

МУ-ын ИХ-нд гэрээний эрх зүй нь арилжааны хэлцлүүд, хувь хүний өдөр тутмын хэлцэл, хэрэглэгчийн гэрээг тусгасан ч хэрэглэгчийн хамгаалалтын зарим хэсэг нь Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд, зарим нь ИХ-д байгаа нь системийн хувьд дутуу байна. ИХ-ийн хувь этгээдийн хамгаалалтыг төгс хамрах кодификацийн чанарыг ч алдагдуулдаг.

Гэрээний эрх зүйд ИХ-ийн ерөнхий ангийн гэрээ байгуулахтай холбоотой нийтлэг зохицуулалт зүй ёсоор багтана. Системийн хувьд эдгээр ерөнхий ангийн зохицуулалтууд нь гэрээний философийн нэг хэсэг бөгөөд гэрээ хэмээх институтын ач холбогдлыг нэмэгдүүлдэг. ИХ нь “иргэний” шинжээ хадгалахын тулд хэрэглэгч хувь хүнийг хамгаалах, хувь хүний амин хувийн асуудлыг ч мөн зохицуулах нэн тэргүүний чиг үүрэгтэй. Тиймээс ИХ-ийн ерөнхий ангид хувь хүний “хэрэглэгчийн” статусыг тодорхой болгох, мөн хэрэглэгчтэй гэрээ байгуулж гэрээний эрх зүйн харилцаанд оролцож буй “аж ахуй эрхлэгч”, “арилжаа эрхлэгчийг” тодорхойлох нь хувийн эрх зүйн харилцаанд оролцогчийн эрх үүргийн тогтолцоог нийтэд ойлгомжтой болгох системийн чиг үүрэгтэй⁹⁵.

Улмаар үүргийн эрх зүйн ерөнхий ангид бүх гэрээнд нийтлэг үйлчлэх хэрэглэгчийн хамгаалалт, гэрээ хэлцлийн хэлбэр зэргийг нарийвчлан тусгах шаардлагатай. Энэ нь нэг талдаа хэрэглэгч хувь этгээдийн эрхийн хамгаалалтыг боловсронгуй болгох, нөгөө талаас ААЭ, АЭ-ийн хэрэглэгчийн өмнө хүлээсэн үүргийг төгөлдөржүүлнэ. Үүнд:

Гэрээний стандарт нөхцөлийг ашиглан гэрээний үүргийн харилцааг зохицуулахад хэрэглэгчийн эрхийг хамгаалах хуулийн хяналтыг сайжруулах;

Үүргийн харилцааг тодорхойлох хэсэгт хэрэглэгчийн гэрээ болон борлуулалтын онцгой хэлбэрүүдийг тус бүрийг дэлгэрэнгүй зохицуулах. Тухайлбал:

- Хэрэглэх хүрээ /B2C гэрээнд хэрэглэх/, хэрэглэгчийн гэрээний үндсэн зарчмууд
- Ажлын байрнаас гадуур байгуулах, алсаас борлуулалт хийх тухай гэрээнүүд
- Цахимаар бизнес эрхлэх ба гэрээ хэлцэл хийх, нотлох баримт хуваарилалт⁹⁶
- Хэрэглэгчийн гэрээг цуцлах /гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах ялгамжтай зохицуулах/
- Хоорондоо холбоотой гэрээг цуцлахад нөгөөг нь дуусгавар болгох эрхийг олгох гэх мэт нийтлэг хэм хэмжээ багтана.

95 Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн ерөнхий анги, 2021 он, Дөрөвдүгээр хэвлэл, 80-81 дэх тал.

96 Жишээ нь ХБНГУ-ын ИХ-ийн II ном /УЕА/, 3-р бүлгийн Хэсэг 3-т Электрон хэрэгслээр дамжуулан бизнес эрхлэх ба гэрээ хэлцлийг дараах байдлаар зохицуулжээ: §312i Цахим хэрэгслээр дамжуулан бизнес эрхлэхэд хүлээх ерөнхий үүрэг ААЭ нь бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн гэрээ байгуулах зорилгоор сүлжээний мэдээллийн хэрэгсэл (электрон хэрэгслээр бизнес эрхлэх орчинд гэрээ байгуулах) ашиглах нөхцөлд үйлчлүүлэгчийн өмнө дараах үүрэг хүлээнэ:

1. захиалга өгөхөөс өмнө алдаагаа олж харах, засах боломж олгоход тохиромжтой, үр нөлөөтэй, хүртээмжтэй техник хэрэгсэл хэрэглэгчид хүргэх;
2. ИХ-ийг Хэрэгжүүлэх тухай хуулийн 246с-д тусгасан мэдээллийг захиалга өгөхөөс хангалттай хугацааны өмнө ойлгомжтой тодорхой хэлбэрээр хүргэх;
3. захиалгын санал хүрсэн тухай электрон хэлбэрээр нэн даруй баталгаажуулах;
4. гэрээ байгуулах үед гэрээний зүйл заалт, ГСН татаж авах, ахин нээж үзэхүйц хэлбэрээр хадгалах боломж олгох.

ИХ-ийн тусгай ангид хэрэглэгчийн гэрээний тусгайлсан хамгаалалтыг гэрээ нэг бүрээр хөндөх, төлбөрийн хэрэгслийн хэлбэр нарийвчлалыг тусгах шаардлагатай.

ХХАГ-ний харилцаа: Хэрэглэгчийн худалдах-худалдан авах гэрээ гэдэгт аж ахуй эрхлэгчээс хэрэглэгч хөдлөх эд хөрөнгө худалдан авч буй гэрээг ойлгоно. Хөдлөх эд хөрөнгө худалдахаас гадна үйлчилгээ үзүүлэх нэмэлт үүрэг хүлээсэн гэрээг хэрэглэгчийн худалдах-худалдан авах гэрээ гэж үзэх боломжтой.

МУ-ын ИХ-ийн §255 болон ИХ-ийн §247 зэрэг хэрэглэгчийн гэрээнд хэрэглэгдэхгүй байгаа нь худалдан авагч ИХ-ийн §254-д тусгасан үндсэн эрхээ алдахаас сэргийлэх, ИХ-ийн §254.6-д зөвхөн баталгаат хугацаа олгосон эсвэл эзэмшил шилжсэнээс хойш 6 сарын дотор доголдол “илрүүлсэн” худалдагч нь дээрх нотлох үүргээс чөлөөлөгдөх зэрэг цөөн тооны хамгаалалт тусгажээ. Ердийн тохиолдолд худалдан авагч нь ИХ-ийн §254-д заасан үндсэн эрхээ хэрэгжүүлэхдээ бараа бүтээгдэхүүн эрсдэл шилжих үед доголдолтой байсан гэдгийг нотлох ёстой байдаг. Харин ИХ-ийн §254.6-д заасан хуулийн таамаг үйлчилснээр ХЭАХТХ-ийн §5.3-д хэрэглэгч дор хаяж 6 сарын хугацаанд баталгаа авах тухай зохицуулалттай адилтгах хөнгөлөлт эдэлж байна. Гэсэн ч худалдах-худалдан авах гэрээнд хэрэглэгчийн хамгаалалтыг сайжруулах шаардлага байсаар байна. Тухайлбал хэрэглэгчийн ХХАГ-нд өмнөх хэсэгт дурдсан үүргийн ерөнхий ангийн холбоотой гэрээг цуцлах зэрэг зохицуулалт дутаж байгаа, түүнчлэн хэрэглэгчийн гэрээгээр доголдолтой бараа бүтээгдэхүүнийг буцаан авах үүрэг хүлээсэн арилжаа эрхлэгч нь өөрийн нийлүүлэгчийн эсрэг барааг буцаахад ИХ-ийн §254-ийн нэмэлт хугацаа тогтоох зэрэг шаардлагаас чөлөөлөх нь оновчтой⁹⁷.

Зээлийн гэрээний харилцаа: ИХ-ийн §§451-453-д банк санхүүгийн байгууллагаас олгох зээлийг тусгасан ч үүнийг гэрээний эсрэг талд оролцож буй этгээдээр нь хэрэглэгчийн зээл болон аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдэд олгох зээл хэмээн хуваан үзэх боломжтой. Хэрэглэгчийн зээлтэй холбоотой асуудлыг ХЭАХТХ-д тусгаагүй нь банкны эрх ашгийг хэт дээгүүрт тавьсан ИХ үйлчилж буйг харуулдаг. Нэг талаас банк, банк бус санхүүгийн байгууллага нөгөө талд хэрэглэгч зээлдэгчийн хувиар оролцож буй гэрээг хэрэглэгчийн зээл гэх ба энэ гэрээнд хэрэглэгчийг хамгаалах, мэдээлэл өгөх үүргүүд үүсдэг. Өнөөг хүртэл энэ асуудлыг банкны дотоод журмаар зохицуулж байсан бөгөөд хэрэглэгчид ээлтэй, хангалттай мэдээлэл өгөх, хэрэглэгчийн эрхийг хангах асуудлыг банк, банк бус санхүүгийн байгууллага өөрөө шийддэг байх нь тохиромжгүй.

Харин хэрэглэгчийн зээлийн гэрээнд үйлчлэх зохицуулалтыг ИХ-д нийтлэг байдлаар тусгах шаардлагатай. ХБНГУ-ын ИХ-ийн § 491 Хэрэглэгчийн зээлийн гэрээ зээлдүүлэгч нь аж ахуй эрхлэгч, зээлдэгч нь хэрэглэгч байх хэмээн тодорхойлсон. МУ-ын ИХ-ийн ИХ-ийн §§451-453-д зээлдэгчийн шинжээр ялгах нь чухал байх ёстой.

97 ХБНГУ-ын ИХ-ийн § 478 Нийлүүлэгчийн эсрэг ААЭ-ийн шаардах эрх:

1. ААЭ нь шинээр үйлдвэрлэсэн эд зүйлийг доголдлын улмаас буцаан авах үүрэгтэй эсвэл хэрэглэгч үнийг бууруулах эрхээ эдэлсэн бол ААЭ бараа нийлүүлэгчийн эсрэг хэрэгжүүлж болох энэ хуулийн §437-д заасан эрхүүдийг хэрэгжүүлэхдээ нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй.
2. ААЭ нь шинээр үйлдвэрлэсэн эд зүйлийг худалдсан бөгөөд доголдол нь нийлүүлэгчээс түүнд эрсдэл шилжих мөчид байсан бол хэрэглэгчийн өмнө энэ хуулийн § 439.2-ын дагуу хариуцсан зардлаа нийлүүлэгчээс шаардах эрхтэй.

Хэрэглэгчийн зээлийн гэрээний бэлтгэл үе шатанд , мөн гэрээт харилцааны туршид мэдээлэл өгөх үүрэг голлох ба холбоотой гэрээг цуцлах асуудал энд мөн яригдана⁹⁸.

Санхүүгийн туслалцаа ба тогтмол хугацаанд хэсэгчлэн нийлүүлэлт хийх тухай гэрээ. Бараа худалдан авч буй этгээд нэг дор үнийг бүхэлд нь төлөх чадавхгүй байх явдал практикт элбэг тохиох тул үүнтэй холбогдуулан лизингийн гэрээ байгуулах /ИХ-ийн §312/ болон өөр бусад хэлбэрээр бараа худалдан авах ажиллагааг санхүүжүүлэх нь түгээмэл. Мөн талууд хэлэлцэн тохирсны үндсэн дээр үнэ төлөх тогтмол хугацааг тогтож, график гарган үнийг төлснөөр өмч шилжүүлэх болзол тавьсан зээлээр худалдах-худалдан авах гэрээ байгуулах боломжтой, ИХ-ийн §262. Үүнээс гадна ердийн худалдах- худалдан авах гэрээ байгуулсан талууд үнэ төлөх үндсэн үүргийн гүйцэтгэлийн хугацааг ИХ-ийн §208-ын дагуу хойшлуулж болно.

Эдгээрийг санхүүгийн туслалцаа авч буй хэлбэрүүд гэх ба зээлийн гэрээний зарим шинжийг агуулсан тодорхой эрх зүйн арга хэрэгсэл гэж үзнэ. Учир нь санхүүжилтийг зээлийн гэрээнд хөрвүүлэх боломж энд бий. Хамгийн чухал нь нийлүүлсэн эд зүйл доголдолтой нөхцөлд санхүүгийн туслалцаа үзүүлэх арга хэрэгслийг нэгэн адил зогсоох шаардлага гарна.

Тухайлбал бараа бүтээгдэхүүн худалдан авах зорилгоор зээл авч буй хэрэглэгч нь зээлийн үйл ажиллагаа эрхлэгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр олгосон төлбөрийг бараа борлуулагчид төлж, барааг худалдан авах гэрээг мөн байгуулдаг. Дэлхий нийтэд энэ 2 хэлцлийн аль нэгээс татгалзсан, гэрээг цуцалсан бол нөгөөг мөн дуусгавар болгох нь зүйтэй гэж үзэж, хэрэглэгчээс гаргуулах зээлээс худалдагчид төлсөн төлбөрийг шууд хасах практик хэрэгжээд нэлээдгүй хугацаа өнгөрчээ⁹⁹.

МУ-ын зээлийн гэрээний эрх зүйд энэ талаар тусгайлан хуульчлаагүй ч дээрх 2 хэлцлийг хамтатган шийдэх бодит шаардлага гарч байгааг иргэний процессын арга хэрэгслийг ашиглан шийдвэрлэх практик тогтжээ. Хэрэглэгч нь ИХШХША-ны явцад худалдагчийн эсрэг сөрөг нэхэмжлэл гаргах зэргээр хандах боломжтой. Гэхдээ процессын эрх зүйн энэ шийдэл нь хангалтгүй бөгөөд материаллаг эрх зүйн хувьд бараа ХХАГ болон үүнийг санхүүжүүлэх зээлийн гэрээг холбоотой авч үзэх ИХ-ийн зохицуулалт үгүй байна. ИХ-ийн татгалзах эрхийн зохицуулалтууд нь зөвхөн гэрээний талууд хооронд үйлчлэх зорилготой. Ялангуяа бараа худалдагч нь зээл олгогчтой хамтран ажилладаг бол зохих шийдэл шаардлагатай. Холбоотой гэрээний хувьд зээлийг ИХ-ийн §205.1-ийн дагуу буцаан шаардах эрхээс хэрэглэгчийн зүгээс худалдагчид хандан төлсөн үнийг буцаан шаардах эрхийг шууд хасан тооцох нь зээлдэгчийн ашиг сонирхолд бүрэн нийцнэ.

98 Жишээ нь ХБНГУ-ын ИХ-ийн § 495 Гэрээний саналаас татгалзах эрх:

а. Хэрэглэгчийн зээлийн гэрээний зээлдэгч нь энэ хуулийн § 355-д заасны дагуу гэрээнээс татгалзах эрхтэй.

б. Дараах зээлийн гэрээнээс татгалзах боломжгүй:

1. зээлдэгч төлбөрийн хугацааг хэтрүүлсэн нөхцөлд зээл олгогч өрийн нийт хэмжээ үндсэн гэрээний төлбөрөөс бага байх нөхцөлд (Иргэний Хуулийг Хэрэгжүүлэх тухай хуулийн 247-р зүйл, §3) шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэмнэх зорилгоор гэрээг цуцлах эрхээ төлбөрийг буцаан төлөх тухай тохиролцоогоор орлуулах, нөхөх боломжтой,

2. нотариатаар гэрчлүүлбэл зохих гэрээнд нотариатч энэ хуулийн §§ 491а болон 492-т заасан зээлдэгчийн эрх хангагдсан гэдгийг баталгаажуулсан.

3. гэрээ нь энэ хуулийн § 504. 2 болон § 505-д нийцсэн.

99 Жишээ нь ХБНГУ-ын ИХ-ийн § 358 II /III /IV-ийг үзнэ үү.

Хууль тогтоогч энд тодорхой шийдлийг тусгах хүртэл ИХ-ийн §220.1 эсвэл ИХ-ийн §221-ийг төсөөтэй хэрэглэж, худалдсан эд зүйл доголдолтойн улмаас зээлийг цуцлах, зээлийн гэрээг цуцлах бусад эрхийг хэрэгжүүлсэн худалдан авагч буюу зээлдэгч нь ХХАГ-гээ дуусгавар болгох эрхтэй байх ёстой. Холбоотой гэрээг дуусгавар болгох зохицуулалт ИХ-ийн §56.1.10-с өөр байхгүй байгаа нь учир дутагдалтай юм¹⁰⁰.

Нийлүүлэлтийг тодорхой хугацаанд хэсэгчлэн гүйцэтгэхэд чиглэсэн гэрээ нь эсрэг тал эд зүйлийн үнийг төлөхөөс өмнө нийлүүлдэггүйгээрээ үнийг хэсэгчлэн төлдөг дээрх гэрээнээс ялгагдана. Энд барааг хүлээлгэн өгөх үед үнийг төлсөн байх шаардлагатай. Тиймээс бараа бүтээгдэхүүн хэсэгчлэн нийлүүлэхэд чиглэсэн гэрээ нь угтаа санхүүгийн туслалцаа үзүүлэх хэрэгсэл болдоггүй. Гэсэн ч энд мөн хэрэглэгчийн эрх ашгийг онцгойлон хамгаалах, бараа бүтээгдэхүүнтэй холбоотой доголдол илэрсэн бол гэрээ цуцлах эрх олгох нь зүйтэй. Энэ асуудлыг ИХ-ийн §220-ийн дагуу шийдэж байгаа нь хангалтгүй.

Практикт дээрх гэрээнүүдийг зээлийн гэрээний харилцаанаас ялгах асуудал талуудын хүсэл зоригийн илэрхийлэл, гэрээний нэршлээр тодорхойлогдсон хэвээр байна.

ЭХХГ-ний харилцаанд хөлслөгч нь хэрэглэгч байх нөхцөлд гэрээг цуцлах, хэрэглэгчийг албадан гаргах зэрэгт тодорхой нэмэлт хамгаалалт шаардагддаг. МУ-д амьдрах зориулалттай сууцыг гэр хороолол, гэр байр, орон сууц, хаус гэсэн зэрэглэлд хөлсөлж, түрээслэх явдал элбэг. Гэтэл хэрэглэгч нь гагцхүү орон сууц хөлслөх нөхцөлд л ИХ-ийн §302-оос эхлэх хамгаалалтад багтаж, өвлийн улирал зэрэгт түүний эсрэг шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг түдгэлзүүлэх зохицуулалттай. Орон сууцыг нийтийн эрх зүйн хууль тогтоомж, ялангуяа Барилгын тухай хуулиар тогтоох нь гэр байр, хашаа байшинд хөлслөн суугаа хэрэглэгчээс илүү хамгаалах хандлага юм. Хувийн эрх зүйд энэхүү амьдрах зориулалттай объектийн шинжээс үл хамааран хөлслөгчийг хэрэглэгчийн хувиар хамгаалах шаардлагатай. Бусад улс оронд орон сууц хөлслөгч иргэн, гэр хорооллын иргэн гэсэн ялгаа ИХ-д байхгүй.

Түүнчлэн хэрэглэгчийн зээлийн гэрээнд зуучлах, аялал жуулчлалын гэрээнд хэрэглэгчийг хамгаалах шаардлагууд нь гэрээний эрх зүйд зарим талаар тусгалаа олсон байна.

Эцэст нь цахим худалдаа өргөжиж буйтай холбогдоод дийлэнх улс орнуудын ИХ-д төлбөрийн үйлчилгээг бусдын өмнөөс гүйцэтгэж байгаа этгээд нь үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс төлбөр хүлээн авагчид төлбөрийг гүйцэтгэх харилцааг даалгаврын гэрээний тусгай төрөл болгон хуульчилж, төлбөрийг таних механизмыг мөн баталгаажуулах талаар тусгадаг. Энэ нь цахим худалдаа эрхлэгч нь худалдан авагч буюу хэрэглэгчтэй байгуулсан гэрээнд энэхүү төлбөрийн үйлчилгээ эрхлэгчийн санал болгож буй цахим гүйлгээний платформ системийг холбон ашиглана гэсэн үг юм. ХЗДХЯ-с цахим худалдааны тухай хуулийг батлах нөхцөлд энд заасан төлбөрийн хэрэгслээр төлбөр гүйцэтгэх хэрэгсэл гэж үзэх тухай ИХ-ийн §§445-448-д тусгах буюу эдгээр зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай.

100 ХБНГУ-ын ИХ-ийн § 358 Гэрээнээс татгалзах, нягт уялдаа холбоо бүхий гэрээ:

1. Бараа бүтээгдэхүүн болон бусад зүйл нийлүүлэхэд чиглэсэн гэрээг байгуулахад шаардлагатай хүсэл зоригийн илэрхийллээс татгалзсан хэрэглэгч нь энэ гэрээтэй холбоотой зээлийн гэрээ байгуулах хүсэл зоригийн илэрхийллээс мөн адил татгалзсанд тооцно.
2. Энэ хуулийн § 495.1-д заасны дагуу хэрэглэгчийн зээлийн гэрээ байгуулахад чиглэсэн хүсэл зоригийн илэрхийллээс татгалзсан хэрэглэгч нь бараа бүтээгдэхүүн болон бусад зүйл нийлүүлэхэд чиглэсэн хүсэл зоригийн илэрхийллээс татгалзсан мөн адил татгалзсанд тооцно.

Үүргийн зөрчлийн асуудал. Гэрээний эрх зүйг нэгдмэл байдлаар ойлгон тайлбарлах, ИХ-ийн ерөнхий, тусгай ангийн аль алианаар зохицуулагдсан гэрээний зөрчлийг нэгдмэл хэлбэрээр авч үзэх шаардлагатай. Үүрэг гүйцэтгэгчийн зүгээс үүрэг гүйцэтгүүлэгчид хандан үүргээ гүйцэтгэвэл зохих үйл баримтад тулгуурласан гэрээний үүргийн зөрчлийн тухай үзэл баримтлал нь энэхүү нэгдмэл үзлийн үндэс юм. Гэхдээ хуулийн техникийн хувьд бүх гэрээнд нийтлэг тохиох үүргийн зөрчлийг үүргийн ерөнхий ангид, тусгай гэрээний онцлогтой холбоотой хэсгийг тухайн гэрээний зохицуулалтын хүрээнд байршуулдаг.

Талуудын байгуулсан гэрээнд үүргийн зөрчлөөс шалтгаалан ИХ-ийн §225, 254, 355.1, 378 зэрэгт гэрээг дуусгавар болгох эрхийг тусгасан. Эдгээр хоёр талт гэрээний харилцаанд хүлээсэн үүргээ зөрчсөн, үүрэг гүйцэтгэгч зөрчлөө арилгахгүй бол гэм буруугаас үл хамааран гэрээнээс татгалзах эрх үүснэ. ИХ-ийн §225 нь хоёр талт гэрээнд хэрэглэгдэх зохицуулалт бөгөөд үндсэн ба бусад үүргийн гүйцэтгэл саатсан, гүйцэтгэлээс бусад үүргийн зөрчил гарсан нөхцөлд хэрэглэгдэх ерөнхий агуулгатай. Гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэх гол шалтгаан нь эсрэг талын үндсэн үүргийн зөрчил бөгөөд үүргээ огт гүйцэтгээгүй, хожимдож гүйцэтгэсэн нөхцөлд гэрээнээс татгалзах нөхцөл болно. Харин үндсэн үүргээс бусад үүргийн зөрчил тухайлбал нэмэлт, дагавар, ерөнхий үүргийн зөрчил гэрээг дуусгавар болгох боломж олгох эсэх нь эргэлзээтэй. ИХ-ийн §225.1-ийн үг хэллэг нь ерөнхий агуулгатай, яг ямар зөрчил гэрээнээс татгалзах шалтгаан болох тухай тусгайлан заагаагүй тул энэ зохицуулалтыг хэрэглэгдэг. Харин ХБНГУ-ын ИХ зэрэгт гэрээний бүх зөрчилд холбогдох гэрээ дуусгавар болгох эрхийг хуульчилсан ба “гэрээг цуцлах”, “татгалзах” асуудлыг гэрээний төрлөөр ялган зохицуулжээ.

Хөлсөөр ажиллах зэрэг гүйцэтгэл нь олон акттай, урт хугацааны гэрээнд гэрээг цуцлах нөхцөлд төлсөн хөлсийг буцаах боломжтой, ажил хийсэн хөдөлмөрийг буцаах боломжгүй. Энэ нөхцөлд гэрээний харилцааг дуусгавар болгоход хэрэглэх тусгай зохицуулалт шаардлагатай.

ИХ-ийн концепцийн дагуу үүргээ гүйцэтгэснээр гэрээгээ биелүүлсэн хэмээн үзнэ (ИХ-ийн §236). Ингэснээр үүргийн харилцаа нь гүйцэтгэлийг орлуулах аргаар дуусгавар болох боломжтой. Энэ бүтэц нь үндэслэлтэй хэдий ч гэрээний зөрчлийн тухай зохицуулалтын адил туйлын хийсвэр шинжтэй. Гэрээний эрх зүйг шинэчлэх оролдлого бүхэн эцсийн бүлэгт гэрээний төрөл зүйлээр нэгтгэх хандлагыг дэмжих ба ингэснээр зөрчил бүхэн тодорхой болно. Үүргийн зөрчлийн хүрээнд тусгай ангид буй ИХ-ийн §254.1\2 зэрэг гэрээний нэг талын үндсэн эрхийг ИХ-ийн §225-д заасан ерөнхий журам, зарчмын заалтаар нөхөн тайлбарлах нь хэрэглээний нэгдсэн аргачлалыг бүрдүүлнэ.

Мөн үүргийн гүйцэтгэлийг хангах арга хэрэгслүүдийг өмчийн ба үүргийн шинжтэй эсэхээс үл хамаарч, хуучин Зөвлөлтийн ИХ-ийн жишгийг хадгалан үүргийн эрх зүйн ерөнхий ангид зохицуулсан нь системийн хувьд оновчгүй байна. ИХ-ийн §231.1-д заасан тоочих аргыг ашиглаж болох ч фидуцийн гэрээ, барьцааны гэрээ зэрэг нь эд юмсын эрх зүйн тусгай харилцаа болох тул үүргийн эрх зүйн ерөнхий ангид байх нь тохиромжгүй.

ГУРАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Хувийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд ИХ-ийн бүтэц, системчлэлд тулгамдаад буй асуудлыг онолын үндэстэй шийдвэрлэх нь зүйтэй. Дийлэнхдээ рецепцийн аргаар хувийн эрх зүйг кодификацжуулж байсан МУ-д хууль тогтоомжийн хийдэл, зөрчлийн асуудлыг шийдвэрлэх чухал байна. 2002 оны ИХ-д хуучин, шинэ эрх зүйн тогтолцооны дотоод үнэлэмжийн зөрчил нэлээд илрэх бөгөөд энэ байдал нь иргэний эрх зүйн хэм хэмжээг рецепцийн аргаар зөөвөрлөх тохиолдолд өөр өөр үзэл баримтлал, хандлагын нийлбэр бий болдогтой шууд холбоотой. МУ-ын ИХ нь кодификацийн сэтгэлгээний уламжлалыг хүлээн авсан, зарим талаар өмнөх социалист нийгмийн ИХ-иудынхаа уламжлалыг өөртөө шингээсэн, эдийн засгийн харилцааг түлхүү зохицуулах зорилго бүхий хувийн эрх зүйн үндсэн кодификаци бөгөөд сонгодог кодификацийн аргаар бүтээгджээ.

Хэдий “иргэний” хууль нэртэй ч хувь этгээдийн эдийн засгийн харилцаанд оролцох, аж ахуйн үйл ажиллагаанд хандсан эрх зүйн зохицуулалтад түлхүү агуулсан, иргэн хувь этгээдийн хамгаалалт дутуу байгаа нь хувийн эрх зүйн харилцааг төгс хамрах анхдагч зорилгодоо хүрээгүй гэж үзэх үндэслэл юм. Энэ шалтгаанаар 2002 оны ИХ-д дүн шинжилгээ хийсний үр дүнд хувийн эрх зүйн цөмийг агуулсан уг хуулийг тусгайлсан кодификацийн аргаар дэлгэрүүлэн зохицуулах нь ИХ-ийн хамрах хүрээ, дэлхий нийтийн сайн жишигт нийцэх, мөн хууль хэрэглээний түвшинд нэгэнт байгуулсан нүсэр системт тогтолцоогоо улам чанаржуулах, цахим орчинд хэрэглэгчийг хамгаалсан өргөн хүрээ бүхий хууль тогтоомж болгон хөгжүүлэх боломжтой хэмээн дүгнэлээ.

Туйлын олон зохицуулах зүйл бүхий хувийн эрх зүйн харилцаанд сонгодог кодификацийн аргыг түүний дэвшилтэт хувилбар болох номоор буюу тусгайлсан кодификацийн аргатай хослуулан гэр бүлийн эрх зүй, хэрэглэгчийн гэрээний хамгаалалтыг нэгтгэх нь хувийн эрх зүйн тусгай салбарууд бие даан хөгжих, зохицуулалтыг тухай бүр нь шинэчлэн найруулах боломж олгохоор байна.

ИХ-д хийсэн бүтцийн анализ нь иргэний гүйлгээнд оролцож буй “хувь этгээдийн” тодорхойлолтыг боловсронгуй болгох, үүнд “иргэнийг” хэрэглэгч, аж ахуй эрхлэгчийн хувиар оролцож буй бодит байдлыг хүлээн зөвшөөрч, ерөнхий ангид тодруулан хуульчлах нь системийн ач холбогдолтойн сацуу дижитал хэрэглэгчийн асуудлыг цаашдын бүлгүүдэд тусгах эхлэл болохоор байна.

Бүтцийн хувьд эд юмсын эрх зүйг объектын ерөнхий зохицуулалтаас салгаж, тусгайлан зохицуулах, ингэхдээ хийсвэрлэх зарчим үйлчлэх эсэхийг баталгаажуулах.

Өвийн эрх зүйн зохицуулалтыг өргөжүүлэн дэлгэрүүлэх, объектоор эсвэл хөрөнгөөр өвлөх зарчмын шийдлийг тусгах.

ИХ-ийг хэрэглэх эсэхийг тодорхойлдог олон улсын хувийн эрх зүй болон ИХ бусад материаллаг хуулийн зөрчилдөөний хэм хэмжээ, цахим орчин зэрэгт ИХ-ийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл өгөх үүрэг зэргийг Хууль хэрэгжүүлэх тухай хуульд төвлөрүүлэх.

Зарчмын анализ хийсний дүнд хувийн эрх зүйн үндсэн зарчмыг ҮХ-д тусгаж, шинэ хууль тогтоомжийн хийсвэр хяналтыг тэнцвэржүүлэх, хийсвэрлэх зарчмын хэрэгжилтийг тодруулах зэрэг зарчмыг амилуулах зохицуулалтын өөрчлөлтийг хийх шаардлагатай; мөн өөрийн тогтолцооны өвөрмөц онцлогийг харгалзан өмчийн туйлын буюу универсал шинжийг хадгалахын тулд нэг талаас эрүү,

иргэн, захиргааны хууль тогтоомжид хамгаалалтын хуваарилахын сацуу, өмчийн шатлалыг аль болох бага байлгах, газар буюу үл хөдлөх хөрөнгө зэрэг нэг объектод хандсан хууль тогтоомжийг нийцжүүлэх буюу хэрэглээний эрэмбийг тогтоох.

Агуулгын хувьд хувь этгээдийн эрх зүйн байдал хэсэгтээ эрхийн хамгаалалтыг гэм хорын эрх зүйд нэгтгэх, хохирлын тэнцвэрт байдлыг хангах /эдийн бус хохирлын зохицуулалтыг тусгах/, хуулийн этгээдээс бусад иргэний эрх зүйн нэгдлийн иргэний гүйлгээнд оролцож буйг харгалзан бие даасан эрх зүйн субъект хэмээн хүлээн зөвшөөрөх, эсвэл энэ эрхийг шүүхэд олгох.

Гэрээний эрх зүйд дээр дурдсан хэрэглэгчийн хамгаалалтыг тусгах нь зүйтэй хэмээн үзлээ.

НОМ ЗҮЙ

А. Монгол хэл дээрх бүтээл:

1. Г.Агар-Эрдэнэ, Хувийн өмчийн онол, 2009 он.
2. Б.Амарсанаа, Монгол улс, Япон улсын хууль тогтоомжийн хөгжил: худалдаа (арилжааны эрх зүй), 2017 он, 51 дэх тал.
3. Б.Амарсанаа, З.Сүхбаатар, 2002 оны ИХ-ийн хувийн хэрэг, 2018 он.
4. Б.Амарсанаа, С.Батбаяр, Ханс Зайделийн Сан: Арилжааны хуулийн төслийн тандан судалгаа, <https://mongolia.hss.de/mn>.
5. О.Амархүү, Эрх зүйн онолын 50 асуулт, 2008 он
6. Б.Буянхишиг, “Эдийн засгийн эрх чөлөөг Үндсэн Хуулиар хангалттай хамгаалсан уу?”, Үндсэн Хууль ба эрх зүйт ёс VII, 2016 он, 9-23.
7. Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги, Анхны хэвлэл, 2010 он, 340 дахь тал; 3 дахь хэвлэл, 434-440 дэх тал.
8. Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн удиртгал, 4 дэх хэвлэл, 2021 он.
9. Б.Буянхишиг, ХБНГУ-ын Иргэний Хууль, орч. 2017 он.
10. Б.Чимид, Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал, 2-р дэвтэр 2008 он.
11. Э.Байгал, Олон улсын хувийн эрх зүй, 2016 он, 2 дахь хэвлэл.
12. Г.Банзрагч, Эрх зүй сэтгүүл 2016 оны №1, Цуврал 33, “Нийтийн өмчийн талаарх МУ-ын эрх зүйн зохицуулалт”, 62 дахь тал.
13. БНМАУ-ын Дээд Шүүхийн хэвлэл: БНМАУ-ын Иргэний эрх (Товч сурах бичиг), 1966 он.
14. Б.Буянхишиг, “МУ-ын өмчийн тогтолцоо нь либерал ба социалист өмчийн коцепцийн дундах шинэ загвар болох нь” сэдэвт илтгэл, Үндсэн хууль ба эрх зүйт ёс эмхэтгэл, 2021 он, 14 дэх тал.
15. Б.Буянхишиг, Гэрээ байгуулах арга техник, 2017 он, 2 дахь хэвлэл.
16. Б.Буянхишиг, Хувийн эрх зүйн кодификаци, харьцуулалт, 2021 он.
17. М.Ванчигмаа, Гэрээслэлээр өвлөх эрх, 2015 он, 29 дэх тал;
18. Д.Ганхүрэл, МУ-д сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх эрхийг хүлээн зөвшөөрсөн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2019 оны №3.
19. Грациано Каднер, Европын олон улсын хувийн эрх зүйг хуульчлах үйл явц: Цвейцарын Холбооны улсын олон улсын хувийн эрх зүйн тухай хууль – Европын олон улсын олон улсын хувийн эрх зүйн боловсронгуй загвар мөн үү?, Эрх зүй сэтгүүл 2018 он, №3, 269-299 (279).
20. Ц.Давхарбаяр, Эд юмсын эрх зүй дэх эзэмшил, түүний хамгаалалтын тулгамдсан асуудал, 2018 он, УБ хот.
21. С.Должин, Д.Бадам, Залилах гэмт хэрэг ба гэрээний маргаан, 2018 он.
22. А.Доржготов, Б.Амарсанаа, З.Сүхбаатар, МУ-ын ИХ-д холбогдох баримт бичгийн эмхэтгэл (2001-2002), 2018 он
23. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтыг үзэх: legalinfo.mn
24. Кашанина Т.В, “Хууль зүйн техник”, монгол хэлнээ хөрвүүлсэн.
25. Д.Лүндээжанцан, Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник, 2016 он,
26. Масанобү, Като, Кодификацийн болон дахин кодификацийн эрин үе сэдэвт илтгэл, МУ-ын хувийн эрх зүйн тулгамдсан асуудал: Иргэний болон

- Худалдааны хууль тогтоомжийн олон улсын жишиг, ОУ-ын симпозиумын илтгэлийн эмхэтгэл, УБ 2019 он, 45 дахь тал.
27. МУ-ын ИХ дахь өмчлөх эрхийг шилжүүлэх зохицуулалт (Харьцуулсан эрх зүйн үүднээс): шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ (Магистрын судалгааны ажил), 2016 он;
 28. МУ-ын Үндсэн хуулийн эмхэтгэл (1924, 1940, 1960, 1992), 2020 он, 17 ба 92 дахь тал.
 29. Д.Наранчимэг, Иргэний эрх зүйн үндсэн асуудал, 1999 он, I дэвтэр, 1 дэх тал.
 30. Ч.Нямсүрэн, Эрх зүйн ерөнхий онол – үндсэн ойлголт тулгамдсан асуудал, 2012 он,
 31. О.Жамбалдорж, МУ-ын Иргэний эрх зүй (Ерөнхий анги), I дэвтэр, 2004 он, 57 дахь тал.
 32. О.Жамбалдорж, МУ-ын Иргэний эрх зүй (Ерөнхий үндэслэл), I дэвтэр, 2004 он, 76 дахь тал.
 33. Э.Отгонзул, Эдийн бус хохирол, түүнийг арилгах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь сэдэвт бакалаврын дипломын ажил, МУИС-ийн ХЗС, 2011 он, 25 дахь тал.
 34. Ж.Оюунтунгалаг, Хууль дээдлэх ёс сэтгүүл, 2017 он.
 35. Өвөрхангай аймгийн сум дундын шүүхийн шийдвэр: МУ-ын шүүхийн шийдвэрийн эмхэтгэл, Иргэний хэрэг 2010/8, 4 дэх тал.
 36. Л.Өлзийсайхан, Хууль бүтээх урлаг, УБ хот 2018 он.
 37. Б.Содовсүрэн, Д.Зундуй, БНМАУ-ын Иргэний эрх зүй, 1988 он.
 38. Ш.Сүхбаатар, Хүний нэр төр, алдар хүндийн эрх зүйн хамгаалалт, 2012 он, 135-136 дахь тал.
 39. Т.Мөнхжаргал, МУ-ын Иргэний эрх зүй (Ерөнхий анги), 2007 он.
 40. Б.Тамир, Цвейцарын Холбооны Улсын Олон улсын хувийн эрх зүйн тухай хууль, 2019 он.
 41. Б.Тэмүүлэн, Д.Энхзул, Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн ерөнхий анги, 2010 он,
 42. УДШ, “Эдийн бус баялгийн хохирлыг арилгах зарим асуудал сэдэвт” бага хурлын эмхэтгэл, 2014 он, 33 дахь тал.
 43. Б.Улаанбаатар, Гэрээслэлээр өв залгамжлах нь, 2019 он.
 44. М.Уянга, Олон улсын эдийн засгийн эрх зүй, 2014 он.
 45. ҮХЦ-ийн 2006 оны 1-р сарын 11-ний өдрийн тогтоол
 46. Х.Нямбаатар, “Хувийн эрх зүйн хөгжил цаашдын чиг хандлага” сэдэвт илтгэл, 2021 оны 9 сарын 17, 1 дэх тал.
 47. Ханс Кельзен, Хэм хэмжээний тухай ерөнхий онол, 3 дахь хэвлэл, УБ хот, 2017 он.
 48. ХЗДХЯ-ны захиалгаар хийсэн Арилжааны хуулийн төслийн хүрээнд арилжааны харилцаанд хэрэглэгдэх заншлыг судалсан тайлан, 2020 он.
 49. Ц.Оюунаа, Өв залгамжлалын эрх зүй, 2017 он.
 50. Ц.Цэрэнжээ, Өмчийн эрх зүй, УБ 2000, 113 дахь тал.
 51. Б.Чимид, Улс төр хуульчийн нүдээр, 2006 он.
 52. Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, 2008 он.
 53. Д.Энхзул, Хувийн эрх зүйн байгууллага ба түүний эрх зүйн чадвар, Эрх зүй сэтгүүл, 2018 оны тусгай дугаар, 263 ба 271 дэх тал.
 54. Д.Янжинхорлоо, Үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрх зүйн зохицуулалт: тулгамдсан асуудал, 2016 он.

Б. Гадаад хэл дээрх бүтээлүүд:

1. Alexy, Robert, Zum Begriff des Rechtsprinzips, Rechtstheorie, Beiheft 1, 1979, S.59 /63/.
2. Bacon, Francis, De Dignitate et Augmentis Scientiarum, (1623) Stuttgart 1962, Bd.1, Buch 8, Kap.3, Aphorismen 10/32.
3. Bentham, Specimen of a Penal Code, Table of contents, Note 1, Bowring-Ed., Bd.1, S.164.
4. Bentham, Traites de legislation, Band 1, 109.
5. BMJ, Handbuch der Rechtsfoermlichkeit, Rn.362.
6. Butler W.E., Russian Law, 3d edition, Oxford, 2009, Ownership 9.50., p. 403.
7. Feuerbach, Philosophie und Empirie, Seite 89.
8. Feuerbach, Kritik, Teil 1, S.10; Philosophie und Empirie.
9. German Code on the Conflict of Laws: Э.Байгал, Гадаад улсуудын олон улсын хувийн эрх зүйн хууль тогтоомжийн эмхэтгэл, 2022 он.
10. Huber, Eugen: Erlauchungen, Heft 1, S.35.
11. Jakobs, Otto-Wilhelm, "Das Eigentum Als Rechtsinstitut Im Deutschen und Sowjetischen Recht." in: The Rabel Journal of Comparative and International Private Law, vol. 29, no. 4, 1965, pp. 694–725 (701). JSTOR.
12. Kloepper, Michael, Sinn und Gehalt des kommenden Umweltgesetzbuches, UPR 2007, S.161 (167).
13. Mertens, Bernd, Gesetzgebungskunst im Zeitalter der Kodifikationen, Tuebingen 2004, S.326.
14. Mohl, Robert von, Politik (Staatsrecht, Voelkerrecht und Politik), Tuebingen 1862, §412, Seite 427 ff.
15. Palandt, Bürgerliches Gesetzbuch, 64. Aufl., 2005, S.9.
16. Petev, Valentin: Sozialistisches Zivilrecht, 1977, S.17.
17. Rüthers/Fischer, Rechtstheorie, 2010, Rn.491b.
18. Schaerdel, Florian: Die Buecherkodifikation (Untersuchung einer Gesetzesgebungstechnik), 2012, S. 16.
19. Wieacker, Wandlungen der Eigentumsverfassung (1935) 9, 25, 70.
20. Wieacker, Wandlungen der Eigentumsverfassung (1935) 9, 25, 70.
21. Wolff, Politik, §412, Seite 427, 429 ff.
22. Zweigert\ Kötz: Einführung in die Rechtsvergleichung, 3. Aufl., 1996, S.98.

**ХОЁР. 2011 ОНЫ КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬ ДАХЬ
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР
ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**

Судалгааг гүйцэтгэсэн:

Г.Давааням. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш,
Хууль зүйн ухааны доктор (LL.D)

УДИРТГАЛ

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Компанийн тухай хууль дахь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, практикт тулгарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтын боломжит хувилбарыг тодорхойлж, санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримталж, төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар судалж, үнэлгээ хийв.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1 Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Зах зээлийн эдийн засагт компани нь томоохон байр суурийг эзэлнэ. Ялангуяа, хувьцаат компани /цаашид “ХК” гэнэ./ нь хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын дор олон нийтээс хөрөнгийг татан төвлөрүүлж, мэргэшсэн этгээд болох төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэнэ./-ийн тусламжтайгаар компанийг удирдаж, ногдол ашиг тараах замаар үйл ажиллагаа явуулж ирсэн. Улмаар хувьцаат компанийн эрх зүй нь компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг хувьцаа эзэмшигчийн эрх ашигт нийцүүлэх хүрээнд хөгжсөн хэмээн дүгнэж болно.

Нөгөө талд, хувийн хөрөнгөд суурилах замаар арилжааны үйл ажиллагааг явуулах тохиолдолд арилжааны зохион байгуулалтын хувьд ХК нь оновчтой хэлбэр биш байх боломжтой. Улмаар бусад улсууд эзэмшил болон удирдлага салаагүй нөхөрлөл болон ХК-ийн зарим шинжийг өөртөө шингээсэн арилжааны зохион байгуулалтын дундын хэлбэр болох ХХК /хялбаршуулсан ХК/-ийг бий болгосон. Тухайлбал, Англи /PC/, Америк /LLC/, Герман /GmbH/, Франц /SARL/, Итали /SRL/ Турк /LS/, Япон /Goudoukaishya/ зэрэг улсын туршлагыг дурдаж болно.

Энэхүү жишгийн дагуу 2011 оны Монгол Улсын Компанийн тухай хууль /цаашид “КТХ” гэнэ./ нь 1991 оны Нөхөрлөл, компанийн тухай хуулийн үзэл баримтлалыг залгамжлан олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэх боломж бүхий ХК-ийг, түүний зарим шинжийг өөртөө агуулсан ХХК-ийг хуульчлан тогтоосон. Өнөөгийн байдлаар Монгол Улсад үүсгэн байгуулагдсан нийт 144 000 гаруй компани (Хуулийн этгээдийн бүртгэлийн 2019 оны мэдээлэл)-ийн 0.2% нь ХК, үлдсэн 99.8% нь ХХК-ийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.¹

Гэвч өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй 2011 оны КТХ нь эзэмшил болон удирдлага салсан ХК-ийн харилцааг суурь болгон зохицуулсан бөгөөд энэ нь эзэмшил болон удирдлага салаагүй ХХК-ийн харилцаанд нийцэхгүй байна. Мөн ХХК-ийн эрх зүйн зохицуулалтын хөгжил сул байгаа нь бизнесийн практикт болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүндрэл үүсгэж, сөрөг үр дагавар гарах болжээ (1-7-г үзнэ үү).

1 “Ковид-19”-ийн өмнөх нөхцөл байдлын хүрээнд авч үзэв.

КТХ-ийн зохицуулалтын бүтцийг авч үзвэл КТХ-ийн нийт 100 зүйл нь 869 заалтаас бүрдэх бөгөөд эдгээрийн 172 заалт нь ХК, 38 заалт нь ХХК, бусад 659 заалт нь нийтлэг байдлаар үйлчлэхээр байна. Өөрөөр хэлбэл, ХХК-ийн харилцаанд чиглэсэн заалт цөөн байхаас гадна “компани” гэх ерөнхий нэр томъёоллын хүрээнд хоёр компанийн хэлбэрт үйлчлэх нийтлэг зохицуулалтыг олноор тусгаж өгчээ.²

Иймд ХХК-ийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын 3.2.1 болон 3.2.2-т заасан үнэлгээ хийх шалтгаан бүрдсэн хэмээн дүгнэж болно.

1.2 Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээ хийх шалтгаанд үндэслэн, 2021 оны КТХ-ийн ХХК-ийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээний хүрээг дараах байдлаар тогтоов. Үүнд:

Үнэлгээний хүрээ	
–	Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хяналт
А.	Том хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хяналтын орган
В.	Мэдээллийн ил тод байдал
–	Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцааг шилжүүлэх
А.	Хувьцааг хариу төлбөргүйгээр бусдад шилжүүлэх
В.	Хувьцаа эзэмшигч эрхийн чадвараа алдах
–	Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал
А.	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
В.	Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах хугацаа
–	Хязгаарлагдмал хариуцлагатай компаниас үнэт цаас гаргах, эргүүлэн худалдаж авах
А.	Үнэт цаас нээлттэй хүрээнд гаргах
В.	Энгийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авах
–	Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчийн хариуцлага
А.	Хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлага
В.	Хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагыг нэвтлэх
–	Хувьцаа эзэмшигчийн эрх
А.	Хувьцаа эзэмшигчийн таслан зогсоох нэхэмжлэл
В.	Хувьцаа эзэмшигчийн төлөөлөн нэхэмжлэл
–	Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн арилжааны итгэлийг хамгаалах
А.	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ба үр дагавар
В.	Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхэд хийсэн компанийн хязгаарлалт

Ингэхдээ бизнесийн практикт сөрөг үр дагавар үүсгэж байна хэмээн хуульч, судлаачдын зүгээс үнэлсэн судалгааны ажлын үр дүн, ном сурах бичиг³-т тулгуурлаж ХХК-ийн эрх зүйн зохицуулалтыг сонгосноос гадна ХХК-ийн эрх зүйн зохицуулалтын шүүх дэх хэрэглээг анхаарч үзсэн болохыг онцолж байна.

2 С.Батбаяр, Компанийн тухай хууль дахь хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эрх зүйн зохицуулалтыг ялгамжтайгаар зохицуулах хэрэгцээ, шаардлага, МХХ-ны Иргэний эрх зүйн хороо, Илтгэлийн эмхэтгэл (2020), 6 дахь тал.

3 С.Батбаяр, Компанийн тухай хууль дахь хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эрх зүйн зохицуулалтыг ялгамжтайгаар зохицуулах хэрэгцээ, шаардлага, МХХ-ны Иргэний эрх зүйн хороо, Илтгэлийн эмхэтгэл (2020); Г.Давааням, Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд, (УБ:Соёмбо, 2020); Г.Давааням, Хувьцаат компанийн эрх зүйн үндсэн ойлголт, (УБ:Соёмбо, 2021) .

1.3 Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгох

А. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

“Зорилгод хүрсэн түвшин” шалгуурын хүрээнд сонгож авсан эрх зүйн зохицуулалт нь зорилгодоо нийцэж байгаа эсэхийг судлан, эерэг болон сөрөг үр дагаврыг тодруулж үнэлгээ хийнэ.

Сонгосон заалтуудыг хүснэгтээр харуулбал:

№	2011 оны Компанийн тухай хуулийн зүйл, заалт
1	59 дүгээр зүйл.Хувьцаа эзэмшигчдийн хурал 59.4.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна. 59.5.Энэ хуулийн 59.4-т заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно.
2	5 дугаар зүйл.Хязгаарлагдмал хариуцлагатай компани 5.3.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигч нь компанийн болон бусад хувьцаа эзэмшигчийн худалдах хувьцаа, түүнийг худалдан авах эрхийн бичиг болон тэдгээрт хөрвөх үнэт цаасыг гуравдагч этгээдэд санал болгох үнээр өөрийн эзэмшлийн хувьцааныхаа тоонд хувь тэнцүүлэн энэ хууль болон компанийн дүрэмд заасны дагуу тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй.
3	49 дүгээр зүйл.Үнэт цаас эргүүлэн худалдаж авах 49.2.Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь худалдан авч болох бөгөөд харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджийн 25 хувиас хэтэрч болохгүй.
4	9 дүгээр зүйл.Компанийн болон хувьцаа эзэмшигчийн хариуцлага 9.3.Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
5	9 дүгээр зүйл.Компанийн болон хувьцаа эзэмшигчийн хариуцлага 9.5.Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна.
6	59 дүгээр зүйл.Хувьцаа эзэмшигчдийн хурал 59.4.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна. 59.5.Энэ хуулийн 59.4-т заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно. 59.6.Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн бүрэн эрх нь дуусгавар болсон өдрөөс хойш байгуулсан гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус байна.
7	83 дугаар зүйл.Гүйцэтгэх удирдлага 83.8.Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

В. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Энэ хүрээнд сонгож авсан зүйл, заалтууд практикт хэрхэн хэрэгжиж байгааг судалж, үүсгэж буй эерэг болон сөрөг үр дагаврыг авч үзнэ.

Сонгосон заалтуудыг хүснэгтээр харуулбал:

№	2011 оны Компанийн тухай хуулийн зүйл, заалт
1	88 дугаар зүйл. Их хэмжээний хэлцэл хийх 88.4.Компани нь тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний хэлцэл, түүний үнэ зэргийг улирал, жилийн тайлангийн тодруулгад тусгах замаар нийтэд мэдээлэх үүрэгтэй. 89 дүгээр зүйл. Сонирхлын зөрчил бүхий этгээд 89.5.Компани тухайн тайлангийн хугацаанд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн талаарх мэдээллийг жилийн тайландаа тусган нийтэд мэдээлэх үүрэгтэй.
2	60 дугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах 60.1.Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/, эсхүл энэ хуулийн 61.7-д заасан этгээд хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэрийг гаргана. 60.3.Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлыг энэ хуулийн 60.1-д заасан шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоногийн дараа хуралдуулна.
3	5 дугаар зүйл. Хязгаарлагдмал хариуцлагатай компани 5.2.Хязгаарлагдмал хариуцлагатай компани нь хувьцаа, түүнийг худалдан авах эрхийн бичиг болон тэдгээрт хөрвөх үнэт цаасыг зөвхөн хаалттай захиалгын үндсэн дээр гаргах бөгөөд бусад үнэт цаасыг нээлттэй болон хаалттай аль ч хэлбэрээр гаргаж болно.
4	49 дүгээр зүйл. Үнэт цаас эргүүлэн худалдаж авах 49.2.Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь худалдан авч болох бөгөөд харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджийн 25 хувиас хэтэрч болохгүй.

1.4 Харьцуулах хэлбэрийг сонгох

Харьцуулах хэлбэрийн хүрээнд, аргачлалын 3.5.3.4.-т заасны дагуу тохиолдол судлах-хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт) хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийх аргыг сонгон хэрэгжүүлнэ.

Улмаар тодорхой зүйл, заалт тус бүр дээр бусад улс /Франц, Япон, Герман, Турк/-ын ХХК-ийн эрх зүйн зохицуулалтыг харьцуулан авч үзэж, дүн шинжилгээ хийхийг зорьсон.

1.5 Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг томъёолох

“Шалгуур үзүүлэлтийг томъёолох” хүрээнд сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавьсан бөгөөд үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалтын тухайд “зорилтод хүрсэн түвшин ямар байна вэ?”, “практикт хэрхэн нийцэж байна вэ?” гэсэн асуултын хүрээнд үнэлгээ хийв.

1.6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Аргачлалын 3.7.3-т мэдээлэл цуглуулах аргуудыг тодорхойлсон ба үүнээс “Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах» аргыг сонгож, үнэлгээ хийх мэдээллийг

цуглуулав. Аргачлалын 3.7.3.1-д “бэлэн байгаа мэдээллийг цуглуулахдаа тухайн хууль тогтоомжийг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, тухайн сэдвээр гарсан мэргэжлийн ном, товхимол, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эх сурвалжийг ашиглана” гэж заасныг баримталсан.

Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд: ХХК-ийн эрх зүйн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлыг илрүүлэхийн тулд өмнө хийгдэж байсан судалгаа, ном, товхимол, илтгэл, өгүүлэл, нийтлэл, нэг сэдэвт бүтээл зэргийг цуглуулан үнэлгээ хийхэд ашиглав.

Түүнчлэн www.shuukh.mn вэб сайтаас нэг бүрчлэн хайлт хийх замаар ХТХ-ийн 9.3 болон 9.5-д хамаарах хүрээнд шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийж, судалгааны тайланд тусгав.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон, байгаа мэдээллийг цуглуулах аргын дагуу дараах мэдээллийг цуглуулж, судалгаа хийхэд ашигласан. Үүнд:

I. Хууль тогтоомж

Компанийн тухай хууль (2011 он);

II. Сурах бичиг, эрдэм шинжилгээний өгүүлэл

Г.Давааням, Морал хазардын асуудлаас үүдэх толгой компанийн хариуцлага, (Адмон., 2020) ;

Г.Давааням, Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд, (Соёмбо, 2020);

Г.Давааням, Хувьцаат компанийн эрх зүйн үндсэн ойлголт, (Соёмбо., 2021);

С.Батбаяр, Компанийн тухай хууль дахь хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эрх зүйн зохицуулалтыг ялгамжтайгаар зохицуулах хэрэгцээ, шаардлага, МХХ-ны Иргэний эрх зүйн хороо, Илтгэлийн эмхэтгэл (2020);

III. Шүүхийн шийдвэрийн судалгаа

Сүхбаатар дүүрэг, 2013.02.27, Дугаар 513;

Чингэлтэй дүүрэг, 2015.09.17, Дугаар 6228;

Сүхбаатар дүүрэг, 2014.06.23, Дугаар 2489;

Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг, 2015.10.16, Дугаар 6929;

Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг, 2015.11.04, Дугаар 7425;

Улсын дээд шүүх, 2016.12.09, Дугаар 001/ХТ2016/011373.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

I. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хяналт

ХХК-ийн хяналтын механизм нь ХК-иас ялгаатай хэрэгждэг. ХХК нь итгэлцлийн харилцаанд суурилсан цөөн тооны хувьцаа эзэмшигчдээс бүрдэх бөгөөд компанийн удирдлагын чиг үүргийг хувьцаа эзэмшигч өөрөө гүйцэтгэх нь нийтлэг тул хувьцаа

эзэмшигч компанийн үйл ажиллагаанд шууд хяналт тавих боломжтой байдаг. Өөрөөр хэлбэл, ХХК-ийн хувьд эрх зүйн хүрээнд хувьцаа эзэмшигчдийг төлөөлөн компанийг удирдаж, хяналт тавих чиг үүрэг бүхий бие даасан органыг байгуулах шаардлага байхгүй.

Үүний оронд ХХК-ийн хувьцаа эзэмшигч нь компанийн үйл ажиллагаанд хяналт тавих эрхээ чөлөөтэй хэрэгжүүлэх боломжтой байх асуудал чухлаар тавигдана. Энэ хүрээнд хувьцаа эзэмшигчийн компанийн өдөр тутмын болоод эдийн засгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл авах эрхтэй байх, олж авсан мэдээлэлдээ үндэслэн удирдлагын хууль бус үйл ажиллагааг таслан зогсоохоор шаадлага, нэхэмжлэл гаргах, төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхээ хэрэгжүүлэх асуудал яригдана.

Зарим тохиолдолд ХХК-ийн үйл ажиллагааны цар хүрээ томорч, зах зээлд томоохон нөлөөтэй болсон тохиолдолд зах зээл болон оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах үүднээс бие даасан хяналтын орган байгуулах хууль зүйн шаардлагыг КТХ-иар тогтоож өгөх хэрэгцээ шаардлага үүсдэг байна.

А.Хязгаарлагдмал хариуцлагатай том компанийн хяналтын орган

ХХК-ийн бизнесийн үйл ажиллагааны цар хүрээ тэлж, зах зээл дээрх эдийн засгийн чадавхийн хувьд томд тооцогдох болсон тохиолдолд зах зээл болон түүний оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах үүднээс бие даасан хяналтын органтай байх асуудал чухлаар тавигдана. Тухайлбал, 2020 оны байдлаар, Монгол Улсын ТОП-100 компанийн 89 нь ХХК-ийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.⁴

Энэ хүрээнд КТХ-ийн 75 дугаар зүйлийн 75.2 болон 75.5 дахь хэсэгт ХХК нь сайн дурын үндсэн дээр ТУЗ байгуулах, хараат бус гишүүн оруулж болохоор зохицуулсан.⁵

75.2. ... хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлгүй байж болно.

75.5. Компанийн дүрэмд заасан бол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төлөөлөн удирдах зөвлөл хараат бус гишүүнтэй байж болно.

Гэвч бусад улсын туршлагаас үзэхэд ХХК-ийн хөрөнгө, орлогын хэмжээ, ажилчдын тоо, хувьцаа эзэмшигчдийн тооноос шууд хамаарч бие даасан хяналтын органыг байгуулахаар хуульчилсан байна. Тухайлбал, Герман Улсын хувьд GmbH нь 500-аас дээш ажилтантай тохиолдолд Хянан шалгагчдын зөвлөл⁶ /цаашид ХШЗ/ байгуулах үүргийг хүлээдэг. Итали Улсын хувьд SRL⁷ нь 1) нэгдсэн санхүүгийн

4 Монгол Улсын Засгийн газар, МҮХАЙТ-аас жил бүр хамтран тодруулдаг ТОП-100 ААН-ийн жагсаалт: <https://www.mongolchamber.mn/p/363>.

5 Тусгайлсан хуулиар зохицуулагдах банк, банк бус санхүүгийн байгууллага, даатгалын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл бүхий компаниуд хамаарахгүй.

6 ТУЗ-ийн хоёр шатлалт тогтолцоог хэрэглэж байсан 2011 оны Компанийн тухай хуулиас өмнөх хуулиудын хүрээнд “Хянан шалгагчдын зөвлөл” эсхүл “Хянан шалгах зөвлөл” гэх бие даасан хяналтын органыг үүсгэн байгуулж байв.

7 Итали Улсад түгээмэл байдаг компанийн хэлбэр бөгөөд 1 хүн ч дангаар үүсгэн байгуулж болно. Дүрмийн сангийн доод хэмжээ нь 10.000 евро байх бөгөөд үүсгэн байгуулахдаа 2.500 еврог заавал оруулж, үлдсэн хэсгийг жил болгон нэмэгдүүлэх замаар дүрмийн сангийн хэмжээг бүрдүүлнэ. Компанийн хөрөнгө нь эзэмшиж буй хувьд хуваагдах бөгөөд дүрэмд өөрөөр заагаагүй бол бусдад шилжүүлж болно.

тайлан гаргах үүрэг бүхий компани, 2) ХШЗ (collego sindacale) байгуулах, эсхүл Хянан шалгагч (sindaco unico) /цаашид «ХЗ» гэнэ./ ажиллуулах шаардлага бүхий компанийн толгой компани, 3) нийт хөрөнгө, эсхүл борлуулалт нь 4.000.000 еврогоос дээш болон 20-оос дээш ажилтантай бол ХШЗ эсхүл ХШ-ийг ажиллуулах үүргийг хүлээнэ.⁸

Мөн Монгол Улсын 2011 оны КТХ-д ХХК-ийн хүрээнд зөвхөн ТУЗ-ийн нэг шатлал бүхий хяналтын тогтолцоог хуульчилж өгсөн нь эргэлзээ төрүүлж байна. ТУЗ-ийн нэг шатлал бүхий хяналтын тогтолцоо нь АНУ-ын нээлттэй компанийн практикаас үүдэлтэйгээс гадна нээлттэй хүрээнд санхүүжилт шаардлага бүхий ХК-ийн түвшинд түлхүү хэрэглэгдэнэ. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулагчид танил компанийн засаглалыг бий болгох замаар санхүүжилт татахад нэг шатлал бүхий ТУЗ-ийн хяналтын тогтолцооны үндсэн ач холбогдол нь оршдог.

Харин ХХК-ийн хувьд цөөн тооны итгэлцлийн харилцаанд суурилсан хувьцаа эзэмшигчдээс бүрдэх бөгөөд ХК-ийн адилаар олон нийтээс хувьцаанд суурилсан санхүүжилт татах асуудалд төдийлэн ач холбогдол өгөх шаардлагагүй юм. Улмаар ТУЗ-ийн нэг шатлалт хяналтын тогтолцооноос гадна ТУЗ-ийн хоёр шатлалт хяналтын тогтолцоог сонгох боломжийг бэхжүүлж өгөх нь оновчтой байж болно. Энэ төрлийн хяналтын тогтолцоог 1991 оны Аж ахуйн нэгжийн тухай хуулиас эхлээд 1999 оны КТХ хүртэлх хугацааны бүхий л ХХК-ийн засаглалын хүрээнд хэрэглэж ирсэн түүхэн уламжлал бий.

Иймд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй том хэмжээний ХХК-ийн өнөөгийн нөхцөл байдалд судалгаа хийсний үндсэн дээр ТУЗ-ийг байгуулах, хараат бус гишүүн оруулах, эсхүл цаашид ХШЗ бүхий ТУЗ-ийн хоёр шатлалт хяналтын тогтолцоог нэвтрүүлэх асуудалд анхаарал хандуулах учиртай.

В. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн мэдээллийн ил тод байдал

Үнэт цаасны зах зээл нь мэдээллийн ил тод байдлын үндсэн дээр оршин тогтдог гэж хэлж болно. Учир нь үнэт цаасны зах зээлд оролцогч хөрөнгө оруулагч нь компанийн мэдээлэлд үндэслэх замаар түүний гаргаж буй үнэт цаасыг худалдан авах, эсхүл худалдан авахгүй байх, эсвэл бусдад худалдах шийдвэр гаргана.

Улмаар КТХ болон ҮНЦЗЗТХ-д компанийн эргэлтэд гаргах эсхүл гаргасан үнэт цаасны үнэд нөлөөлөх боломжтой бүхий л мэдээлэл /санхүүгийн болон санхүүгийн бус/-ийг нийтэд мэдээлэх замаар ил тод байдлыг хангах зохицуулалтыг тусгаж өгсөн. ХК-ийн хувьд СЗХ-оос баталж гаргасан Ил тод байдлын журам үйлчилж байна.

Үүний үндэслэл нь КТХ-ийн 88 дугаар зүйлийн 88.4 болон 89 дүгээр зүйлийн 89.5-д заасан зохицуулалт юм.

88 дугаар зүйл. Их хэмжээний хэлцэл хийх

88.4.Компани нь тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний хэлцэл, түүний үнэ зэргийг улирал, жилийн тайлангийн тодруулгад тусгах замаар нийтэд мэдээлэх үүрэгтэй.

89 дүгээр зүйл. Сонирхлын зөрчил бүхий этгээд

89.5.Компани тухайн тайлангийн хугацаанд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн талаарх мэдээллийг жилийн тайландаа тусган нийтэд мэдээлэх үүрэгтэй.

8 KPMG, Investment in Italy, 21 (2020).

ХК-ийн хувьд хувьцаа болон түүнд хөрвөх үнэт цаас, бусад үнэт цаасыг олон нийтэд нээлттэй арилжаалах тул мэдээллийн ил тод байдлыг хангах асуудал чухлаар тавигдана. Энэ ч утгаараа КТХ-ийн 88.4 болон 89.5 дахь заалт нь ХК-ийн хүрээнд эрх зүйн үйчлэлийн оновчтой үр дагаврыг үүсгэдэг.

Гэвч хувьцаа болон хувьцаа худалдан авах эрхийн бичиг, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг хаалттай хүрээнд гаргах замаар цөөн тооны хувьцаа эзэмшигчдийн үндсэн дээр үйл ажиллагааг явуулдаг ХХК-ийн хувьд КТХ-ийн 88.4 болон 89.5 дахь заалт нь бодит байдалд нийцэхгүй байна.⁹ Өөрөөр хэлбэл, итгэлцлийн харилцаанд суурилсан цөөн тооны хувьцаа эзэмшигчдээс бүрдсэн ХХК-ийн хувьд их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчил бүхий хэлцлийн талаар нийтэд мэдээлэх шаардлага байхгүй юм.

ХХК нь өрийн бичиг(бусад үнэт цаас)-ийг олон нийтэд нээлттэй санал болгох онцлогийн үүднээс тодорхой түвшинд зөвтгөх үндэслэл байхыг үгүйсгэх боломжгүй боловч, өнөөгийн нөхцөлд Зохицуулах байгууллага (СЗХ) болон Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага (МХБ, ҮЦБ)-ын нарийн зохицуулалт, хяналт байгааг анхаарах шаардлагатай (Үүнд хамаарах эрх зүйн зохицуулалтын үнэлгээг 4) А. Үнэт цаас нээлттэй хүрээнд гаргах хэсгээс уншина уу).

Иймд КТХ-ийн 88 дугаар зүйлийн 88.4 болон 89 дүгээр зүйлийн 89.5-д заасныг дараах байдлаар өөрчлөн найруулж болох юм.

Судлаачийн санал:

88 дугаар зүйл. Их хэмжээний хэлцэл хийх

88.4. Хувьцаат компани нь тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний хэлцэл, түүний үнэ зэргийг улирал, жилийн тайлангийн тодруулгад тусгах замаар нийтэд мэдээлэх үүрэгтэй.

89 дүгээр зүйл. Сонирхлын зөрчил бүхий этгээд

89.5. Хувьцаат компани тухайн тайлангийн хугацаанд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн талаарх мэдээллийг жилийн тайландаа тусган нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Харин хаалттай ХК-д нийтэд мэдээлэх үүрэг хүлээх эсэх асуудлын талаар тодорхой шалгуурын үндсэн дээр СЗХ-оос журам гаргах замаар нарийвчлан зохицуулах боломжтой.

II. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал

А. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал

Хувьцаа эзэмшигч нь компанийн эзэмшигч болохын хувьд тодорхой давтамжтайгаар тогтмол хуралдаж, өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангагдсан байх учиртай. Энэхүү боломжийг хувьцаа эзэмшигчид олгох чиг үүргийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал гүйцэтгэдэг.

Улмаар КТХ-д хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор зарлан хуралдуулахаар зохицуулсан (КтХ 59.4). Хэрэв хуульд заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулаагүй тохиолдолд төлөөлөн

9 С.Батбаяр, Компанийн тухай хууль дахь хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эрх зүйн зохицуулалтыг ялгамжтайгаар зохицуулах хэрэгцээ, шаардлага, МХХ-ны Иргэний эрх зүйн хороо, Илтгэлийн эмхэтгэл (2020), 13 дахь тал.

удирдах зөвлөлийн компанийн хууль болон компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно (КТХ 59.5).

59 дүгээр зүйл.Хувьцаа эзэмшигчдийн хурал
 59.4.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна.
 59.5.Энэ хуулийн 59.4-т заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно.

Эдгээр хэм хэмжээ нь эзэмшил болон удирдлага салсан ХК-ийн харилцаанд суурилсан буюу ТУЗ-ийн үйл ажиллагааг ХЭХ-ийн эрх ашигт нийцүүлэхэд чиглэсэн байх бөгөөд ТУЗ-ийн бүрэн эрх нь анхдагч биш бөгөөд ХЭХ-ын шийдвэрт тулгуурласан байх ёстой гэсэн үзэл санаанд суурилж байна. Өөрөөр хэлбэл, компанийн эзэн болох хувьцаа эзэмшигчид компанийн хяналтыг ТУЗ-д алдах эрсдэлээс сэргийлэх эцсийн зорилгыг агуулсан зохицуулалт юм.¹⁰

Гэвч ХХК-ийн хувьд хувьцаа эзэмшигч нь нийтлэг байдлаар компанийн ТУЗ /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн бүрэн эрхийг өөрөө хэрэгжүүлж байх бөгөөд компанийн удирдлагад компанийн хяналтыг алдах боломж байхгүй. Энэ ч утгаар ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тавигдах процедурыг ХХК нь дүрэмдээ заах замаар уян хатан байдлаар тогтоож өгөх боломжийг бий болгох асуудал чухлаар тавигдана.

Ялангуяа, КТХ-ийн 59 дүгээр зүйлийн 59.5-т заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн бүрэн эрхийг шууд дуусгавар болгохоор зохицуулсан нь ХХК-ийн удирдлагын бодит нөхцөл байдалд нийцэхгүй байгааг дурдах нь зүйтэй.

Герман болон Турк Улсын хувьд ХХК-ийн ХЭХ-ийн талаар дараах байдлаар зохицуулж өгчээ.

Герман Улсын “GmbH”	Турк Улсын “Ticaret Kanunu”
Хувьцаа эзэмшигчдийн хурал 48.1. Хувьцаа эзэмшигчдийн шийдвэр нь хурлын үндсэн дээр гарна. 48.2. Бүх хувьцаа эзэмшигчид тухайн зүйлийн талаар бичгээр(e-mail, fax), эсхүл саналын хуудсаар саналаа өгсөн бол хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах шаардлагагүй. Зарлан хуралдуулах 49.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг удирдлага зарлан хуралдуулна. 49.2. Тодорхой зааснаас бусад тохиолдолд компанийн эрх ашгийн үүднээс зайлшгүй бол хурлыг зарлан хуралдана. 49.3. Жилийн санхүүгийн тайлан эсхүл жилийн дундуур гарсан балансад хувь нийлүүлсэн хөрөнгийн тал хүртэл багассан бол хувьцаа эзэмшигчдийн хурлыг нэн даруй хуралдуулна.	Хувьцаа эзэмшигчдийн хурал 617.1. Гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссаны дараа 3 сарын дотор зарлан хуралдуулна. Компанийн дүрэмд заасан тохиолдолд ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно. 617.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хамгийн багадаа хурлыг хуралдуулахаас 15 хоногийн өмнө зарлана.

10 АНУ-ын нээлттэй компанийн хувьцааны тархалт өндөр бөгөөд үүнээс шалтгаалан хувьцаа эзэмшигчид компанийн удирдлагад хяналт тавьж чадахгүй болох “засаглалын хямрал” үүсч байсан. Үүнийг эзэмшил болон хяналт салах хэмээн нэрлэдэг (separation of ownership and control).

Герман Улсад ХХК нь ХЭХ-ийг заавал зарлан хуралдуулах шаардлагагүй бөгөөд саналын хуудсыг бүх хувь нийлүүлэгчдэд хүргүүлэх замаар шийдвэрийг гаргаж болно (GmbH 48.2.). Мөн ХЭХ-ыг компанийн эрх ашгийн үүднээс шаардлагатай тохиолдолд зарлан хуралдуулахаар зохицуулсан байна.

Турк Улсын хувьд Монгол Улсын КТХ-ийн зохицуулалттай нэлээд төстэй байдлаар санхүүгийн жил дууссанаас хойш 3 сарын ээлжит хурлыг зарлан хуралдуулахаар зохицуулсан боловч, тухайн заалтын зөрчсөний үр дагаврыг гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхтэй холбоогүй байна. Өөрөөр хэлбэл, ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг гүйцэтгэх удирдлагын зүгээс хуульд заасан хугацаанд зарлан хуралдуулаагүй тохиолдолд хувьцаа эзэмшигчид хурлыг зарлан хуралдуулахаар шаардах эрх үүсдэг.

Мөн Франц Улсын “SARL”-ийн хувьд ХЭХ нь жилийн санхүүгийн тайланг хэлэлцэх болон тодорхой тооны хувьцаа эзэмшигчид (хувьцаа эзэмшигчдийн 10%, хувьцааны 10%)-ийн шаардсан тохиолдолд албан ёсоор хуралдана. Харин бусад тохиолдолд ХХК-ийн дүрэмд заах замаар саналын хуудсаар шийдвэр гаргах, янз бүрийн бичгэн хэлбэрээр шийдвэр гаргахыг хүлээн зөвшөөрдөг.¹¹

ХЭХ-ийг гүйцэтгэх удирдлага зарлан хуралдуулах бөгөөд түүнийг байхгүй тохиолдолд ХШ-ийн зүгээс тухайн бүрэн эрхийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй байдаг. Хэрэв гүйцэтгэх удирдлага нь хувьцаа эзэмшигчид шаардсан боловч хурлыг зарлан хуралдуулахгүй байгаа тохиолдолд аль нэг хувьцаа эзэмшигч нь хурлаар хэлэлцэх асуудлыг шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах этгээдийг томилуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байхаар зохицуулжээ.¹²

ХХК нь цөөн тооны хувьцаа эзэмшигчдээс бүрдэх, дийлэнх тохиолдолд хувьцаа эзэмшигчийн зүгээс компанийн удирдлагын чиг үүргийг давхар гүйцэтгэх онцлогийг харгалзаж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Герман Улсын адилаар уян хатан байдлаар хуралдуулах боломжийг нээж өгч болох юм. Мөн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах хуульд болон дүрэмд заасан журмыг зөрчсөн тохиолдолд үүсэх үр дагаврыг Турк Улсын адилаар хувьцаа эзэмшигчийн зүгээс шаардах эрхтэй уялдуулан зохицуулж болно.

Судлаачийн санал:

59 дүгээр зүйл. Хувьцаа эзэмшигчдийн хурал

59.4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна.

У. Энэ хуулийн 59.4-т заасан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах хугацааг хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрөөр тогтоож болно.

У2. Энэ хуулийн 59.4-т заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-өөс хувьцаа эзэмшигчдийн хурлын зарлан хуралдуулахыг хувьцааг эзэмшигч шаардаж болно. төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно.

У3. Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь хувьцаа эзэмшигчийн шаардлагын үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн хурлыг нэн даруй зарлан хуралдуулах үүрэг хүлээнэ.

11 Kiplingavocats, Main legal characteristics of the French Limited Liability Company (SARL) 3[<https://www.kiplingavocats.com/wp-content/uploads/2012/12/The-limited-liability-company.pdf>]

12 Id.

У4. Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулахгүй байгаа тохиолдолд аль нэг хувьцаа эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах этгээдийг томилуулахаар Санхүүгийн зохицуулах хороо эсхүл шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй. Судлаачийн дээр дурдсан санал нь ХХК-ийн эзэмшил болон удирдлага салаагүй байх онцлогт тулгуурлан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахад чиглэсэн харилцааг уян хатан байдлаар зохицуулах зорилготой бөгөөд том хувьцаа эзэмшигч болон жижиг хувьцаа эзэмшигчийн зөрчилдөөнийг шийдвэрлэхэд чиглээгүй болно.

В. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах хугацаа

ХХК-ийн хувьд цөөн тооны хувьцаа эзэмшигчээс бүрдэх тул ХЭХ-ийг зарлан хуралдуулах асуудлыг хурдан шуурхай зохион байгуулж, уян хатан байдлаар шийдвэрлэх боломжоор хангагдсан байх нь зүйд нийцнэ.

КТХ-ийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт ХХК нь дүрэмдээ өөрөөр заах замаар ХЭХ-ийг зарлан хуралдуулах шийдвэр гарсан өдрөөс хойш хэдийд ч зохион байгуулах боломжтой байхаар зохицуулсан.

60 дугаар зүйл.Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах
60.1.Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/, эсхүл энэ хуулийн 61.7-д заасан этгээд хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэрийг гаргана.
60.3.Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлыг энэ хуулийн 60.1-д заасан шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоногийн дараа хуралдуулна.

Гэвч практикт түгээмэл гарч буй асуудлын дийлэнх нь ХХК-ийн хувьд үүсгэн байгуулах үедээ ХЭУБ-ийн газраас гаргасан загвар дүрмийг ашигладаг бөгөөд тухайн дүрэмд ХЭХ-ийг зарлан хуралдуулахадтай холбоотой зохицуулалт байхгүй. Үүнээс ямар ч ХХК-ийн хувьд яаралтай асуудлаа ХЭХ-аар шийдвэрлэж чадахгүй 40 хоногийн хугацааг хүлээх шаардлагатай болдог.¹³

Харин бусад улсад ХЭХ-ийг хуралдах өдрийн зарлан хуралдуулах зартай уялдуулан тогтоосон байна. Тухайлбал, Герман Улсын “GmbH”-ийн 51 дүгээр зүйлийн 51.1-т ХЭХ-ийг хуралдуулахын өмнө хамгийн багадаа нэг 7 хоногийн өмнө зарыг хувь нийлүүлэгчдэд хүргүүлэхээр зохицуулжээ. Мөн хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т хурал нь хуульд заасан журмын дагуу зарлагдаагүй байсан ч бүх хувь нийлүүлэгч оролцсон бол хүчин төгөлдөр хэмээн үзэхээр хуульчилсан.

Мөн Турк Улсын хувьд Худалдааны хуулийн 617.2-т гүйцэтгэх удирдлага нь ээлжит хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш 15 хоногоос доошгүй хугацааны дотор хуралдуулна. Энэхүү хугацааг гүйцэтгэх удирдлага уртасгаж, эсхүл 10 хоног хүртэл багасгаж болно хэмээн зохицуулсан. Франц Улсын SARL-ийн хувьд ч ХЭХ хуралдах өдрөөс 15 хоногийн өмнө хурлын зарыг шуудангаар хүргүүлэх бөгөөд бүх хувьцаа эзэмшигчид байгаа, эсхүл хүрэлцэн ирсэн тохиолдолд амаар зарыг хүргэж болно хэмээн зохицуулжээ.¹⁴

Иймд ХХК-ийн өнөөгийн практикт тулгарч буй асуудлыг харгалзан КТХ-ийн 60.3-ийг ХХК-ийн онцлогт нийцүүлэн ХЭХ-ийн зарлан хуралдуулахад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг уян хатан байдлаар өөрчлөн найруулах боломжтой.

13 С.Батбаяр, Компанийн тухай хууль дахь хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эрх зүйн зохицуулалтыг ялгамжтайгаар зохицуулах хэрэгцээ, шаардлага, МХХ-ны Иргэний эрх зүйн хороо, Илтгэлийн эмхэтгэл (2020), 11 дэх тал.

14 Kiplingavocats, Main legal characteristics of the French Limited Liability Company (SARL) 3[<https://www.kiplingavocats.com/wp-content/uploads/2012/12/The-limited-liability-company.pdf>]

Судлаачийн санал:

60 дугаар зүйл.Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах
60.1.Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/, эсхүл энэ хуулийн 61.7-д заасан этгээд хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэрийг гаргана.
60.3.Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд заагаагүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлыг энэ хуулийн 60.1-д заасан шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоногийн дараа хуралдуулна. Энэхүү хугацааг төлөөлөн удирдах зөвлөл/ байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ нь үндэслэл бүхий шалтгаанаар уртасгаж эсхүл ажлын 5 хоног хүртэл багасгаж болно.
У. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм болон энэ хуульд заасан журмыг баримтлаагүй боловч, бүх хувьцаа эзэмшигчид хуралд оролцсон бол хурлын шийдвэрийг хүчин төгөлдөр гэж үзнэ.

Судлаачийн дээр дурдсан санал нь ХХК-ийн ХЭХ-ийг зарлан хуралдуулах хугацааны талаар Герман болон Турк Улсын эрх зүйн зохицуулалтад тулгуурласан болно.

III. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа шилжүүлэх

А.Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцааг хариу төлбөргүйгээр шилжүүлэх

ХХК-ийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд түгээмэл тулгардаг асуудал нь хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлэх асуудал юм. Энэ нь ХХК-ийн хувьд хувьцаа эзэмшигчид нь найз нөхөр, гэр бүл зэрэг итгэлцлийн харилцаанд суурилсан байх тул хувьцаа эзэмшигч нь хэн байх вэ гэдэг асуудал чухал ач холбогдолтой байдагтай холбоотой.

- ХХК-ийн хувьцаа эзэмшигч нь хувьцааг бусдад дараах хэлбэрээр шилжүүлдэг:
- Хариу төлбөртэй шилжүүлэх /худалдах../
- Хариу төлбөргүй шилжүүлэх /бэлэглэх, өв залгамжлуулах../

Улмаар КТХ-ийн 5 дугаар зүйлд ХХК-ийн хувьцаа эзэмшигч бусдад хувьцаа шилжүүлэхэд тодорхой хязгаарлалтыг тогтоож өгсөн.

5 дугаар зүйл.Хязгаарлагдмал хариуцлагатай компани
5.3.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигч нь компанийн болон бусад хувьцаа эзэмшигчийн худалдах хувьцаа, түүнийг худалдан авах эрхийн бичиг болон тэдгээрт хөрвөх үнэт цаасыг гуравдагч этгээдэд санал болгох үнээр өөрийн эзэмшлийн хувьцааныхаа тоонд хувь тэнцүүлэн энэ хууль болон компанийн дүрэмд заасны дагуу тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй.

КТХ-ийн 5 дугаар зүйлд хувьцааг хариу төлбөртэйгээр шилжүүлэх асуудлыг зохицуулсан буюу худалдах хэлбэрийн хүрээнд тодорхой хязгаарлалтыг хийж өгчээ.

Харин хариу төлбөргүйгээр бусдад хувьцаа шилжүүлэх буюу бэлэглэх, өв залгамжлуулах хэлбэрийн талаар зохицуулаагүй байна. Өөрөөр хэлбэл, ХХК-ийн хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчидтэй хувийн харилцаагүй этгээдэд өөрийн эзэмшлийн хувьцааг бэлэглэх эсхүл өв залгамжлуулах тохиолдолд КТХ-ийн 5 дугаар зүйлд заасан зохицуулалт үйлчлэх эсэх нь тодорхойгүй. Иймд ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн зүгээс өөрийн эзэмшлийн хувьцааг бусад этгээдэд хариу төлбөргүйгээр бусдад шилжүүлэх тохиолдолд үйлчлэх эрх зүйн механизмыг бий болгох шаардлага тулгарч байна.

Аль ч тохиолдолд ХХК-ийн онцлогийг харгалзан үзэж, хувьцаа эзэмшигчид хоорондын итгэлцлийн харилцааг эрх зүйн түвшинд чухалчилан авч үзэх шаардлагатай. Учир нь цөөн хувьцаа эзэмшигчдээс бүрдсэн ХХК-ийн хувьд нэг хувьцаа бусад хувьцаа эзэмшигчидтэй зөрчилдөөнтэй байх нь компани цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулах, түргэн шуурхай шийдвэр гаргахад сөргөөр нөлөөлнө.

Харин бусад улсад ХХК-ийн хувийг хариу төлбөргүйгээр бусдад шилжүүлэх тохиолдолд хариу төлбөртэй шилжүүлэхтэй адил төрлийн хязгаарлалт тавигдаж болохоор зохицуулсан байна.

Япон Улсын КТХ	Герман Улсын “GmbH”
Өв залгамжлалын тусгай зохицуулалт 608.1. Хувь нийлүүлсэн компани нь түүний гишүүн нь нас барсан тохиолдолд ...тухайн гишүүний өв залгамжлагч ... уг гишүүний хувийг өв залгамжилж болохоор дүрэмдээ тусгаж болно.	Хувиа шилжүүлэх 15.1 Хувийг бусдад шилжүүлж, өв залгамжлуулж болно.
Хувиа шилжүүлэх 585.1 Гишүүн нь бусад гишүүдийн зөвшөөрлийг авалгүйгээр өөрийн эзэмшлийн хувийг бүгдийг нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлж болохуй.	Хувиа шилжүүлэх 15.5 Компани дүрэмдээ хувь шилжүүлэх нөхцөл болон компанийн зөвшөөрлийг авахаар тусгаж болно.

Ийнхүү Япон болон Герман Улсын эрх зүйн зохицуулалтаас үзэхэд хувь шилжүүлэх хүрээнд хариу төлбөртэй болон хариу төлбөргүй хэмээн ялгахгүйгээр нийтлэг байдлаар зохицуулсан байна. Ингэхдээ зарчмын хувьд хувь шилжүүлэх асуудлыг зөвшөөрсөн боловч, гишүүдийн зөвшөөрлийг авах, компанийн дүрэмдээ хязгаарлалтыг тодорхой тусгаж өгөхөөр хуульчилжээ.

Монгол Улсын хувьд ч Япон болон Герман Улсын эрх зүйн зохицуулалтын туршлагад тулгуурлан бусдад хувьцаагаа хариу төлбөргүй шилжүүлэх асуудлыг зарчмын хувьд зөвшөөрч, бусад хувьцаа эзэмшигчдээс зөвшөөрөл авах эсэх, шилжүүлж болохгүй нөхцлийн талаар стандарт зохицуулалтыг тогтоож өгөх боломжтой.

Судлаачийн санал:

Энгийн хувьцаа болон түүнд хөрвөх үнэт цаасыг өв залгамжлах У. Хязгаарлагдмал хариуцлагатай компани дүрэмдээ заасан эсхүл бүх хувьцаа эзэмшигчид зөвшөөрсөн тохиолдолд нас барсан хувьцаа эзэмшигчийн энгийн хувьцаа болон түүнд хөрвөх үнэт цаасыг түүний өв залгамжлагч өвлөж болно. У2. Энэ хуулийн У-т зааснаас бусад тохиолдолд нас барсан хувьцаа эзэмшигчийн өв залгамжлагчид компани нь нөхөн төлбөрийг бүрэн хэмжээгээр төлнө.	Энгийн хувьцаа болон түүнд хөрвөх үнэт цаасыг бусдад бэлэглэх У. Энэ зүйлд зааснаас бусад тохиолдолд хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн энгийн хувьцаа болон түүнд хөрвөх үнэт цаасыг бусдад бэлэглэхийг хориглоно. Х. Бэлэглэж буй этгээд нь тухайн хязгаарлагдмал хариуцлагатай компанийн энгийн хувьцаа эзэмшигч Х2. Компанийн дүрэмд бусдад бэлэглэхийг зөвшөөрсөн, эсхүл бэлэглэж болох этгээдийг нэрлэн заасан Х3. Бүх хувьцаа эзэмшигчид санал нэгтгэйгээр зөвшөөрсөн.
---	--

Судлаачийн дээр дурдсан санал нь ХХК-ийн хувьцааг хариу төлбөргүйгээр шилжүүлэхэд чиглэсэн Япон болон Герман Улсын эрх зүйн зохицуулалтад тулгаарласан болно.

В. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигч эрхийн чадвараа алдах

ХХК нь хувьцаа эзэмшигч хоорондын итгэлцлийн харилцаанд суурилсан компанийн хэлбэр болох талаар өмнө авч үзсэн. Энэ хүрээнд гэр бүл, найз нөхдийн хүрээний бус этгээд компанийн хувьцаа эзэмшигч болсон эсхүл гэр бүл, найз нөхөд хоорондын итгэлцлийн харилцаа эвдэрсэн тохиолдолд цаашид компани тогтвортой үйл ажиллагаа явуулах боломжгүй болдог.

Улмаар ХХК-ийн харилцааны хүрээнд хувьцаа эзэмшигчийн эзэмшлийн хувьцааг устгах, тодорхой шалтгааны улмаас компаниас хасах замаар хувьцаа эзэмшигчийг тухайн компаниас шахан гаргах боломжийг хүлээн зөвшөөрөх нь нийтлэг практик юм /Бусад улсад хүлээн зөвшөөрөгдсөн байна/.

Монгол Улсын КТХ-ийн хүрээнд 49 дүгээр зүйлийн 49.1-т заасны дагуу компани бусад хувьцаа эзэмшигчтэй тохиролцсоны үндсэн дээр тэдгээрийн эзэмшлийн хувьцааг худалдаж авах боломжийг тогтоосон байна.

49 дүгээр зүйл. Үнэт цаас эргүүлэн худалдаж авах
49.1. Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компани нь төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн шийдвэрээр өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчтэй нь тохиролцсоны үндсэн дээр худалдан авч болно.

Гэвч бодит байдал дээр бусад хувьцаа эзэмшигчид/том хувьцаа эзэмшигч/-тэй зөрчилдөөн бүхий хувьцаа эзэмшигчид компанид хувьцаагаа худалдахдаа хэт өндөр үнийн санал тавих, эсхүл худалдахаас татгалзсан тохиолдолд эрх зүйн зохицуулалтын хувьд гацаанд ордог. Улмаар ХХК нь компанийн үйл ажиллагааг тогтвортой, түргэн шуурхай явуулахын тулд КТХ-ийн 49 дүгээр зүйлийн 1-д заасныг хэрэглэх замаар жижиг хувьцаа эзэмшигчийн эзэмшлийн хувьцааг хүчээр худалдан авсан тохиолдолд гардаг.

Иймд хаалттай компанийн эрх зүйн хүрээнд зөрчилдөөн бүхий хувьцаа эзэмшигчдээс бүрдсэн ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн зөрчилдөөнийг шийдвэрлэх эрх зүйн боломжийг нээж өгөх шаардлага чухлаар тавигдаж байна. Бусад улсын эрх зүйн зохицуулалтаас үзэхэд 1) хувьцаа буцаан авах, 2) хувьцаа эзэмшигчийг компаниас хасах замаар ХХК-ийн хувьцаа эзэмшигчид хоорондын зөрчилдөөнийг шийдвэрлэх туршлага бий.

Хувьцаа буцаан авах болон компанийн хасах асуудлыг нарийвчлан авч үзье. Харин АНУ дахь ХХК-ийн эрх зүйн зохицуулалт нь нөхөрлөлийн харилцаанд суурилсан байх тул Монгол Улсын ХХК-тай төстэй хялбаршуулсан хувьцаат компанийн хэлбэр бүхий Герман Улсын “GmbH” болон Япон Улсын хувь нийлүүлсэн компанийн эрх зүйн зохицуулалтыг голчлон авч үзлээ.

Герман Улсын “GmbH”	Япон Улсын КТХ
Хувиа буцаан авах 34.1. Компанийн дүрмийн хүрээнд зөвшөөрсөн тохиолдолд гагцхүү компанийн зүгээс хувиа буцаан авч болно. 34.2. Хувийг буцаан авах нь гагцхүү хувь нийлүүлэгч хувийг олж авахаас өмнө тухайн компанийн дүрэмд заасан тохиолдолд хэрэгжих бөгөөд хувь нийлүүлэгчийн зөвшөөрлийг авах шаардлагагүй.	Хувь нийлүүлсэн компанийн гишүүнийг хасах нэхэмжлэл 859.1. Хувь нийлүүлсэн компанийн гишүүн нь дараах үндэслэл байгаа бол тухайн компанийн нэхэмжлэлийн субъект бус гишүүдийн олонхын саналаар, шаардлагад үндэслэн тухайн гишүүнийг хасахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно. 1. Хувь нийлүүлэх үүргээ гүйцэтгээгүй; 2. 594.1 (үл өрсөлдөх үүрэг)-т дэх заалтыг зөрчсөн; 3. Үйл ажиллагаа явуулахдаа зүй бус үйлдэл хийж, эсхүл удирдах эрхгүй боловч, удирдлагын үйл ажиллагаанд оролцсон; 4. компанийг төлөөлөхдөө зүй бус үйлдэл хийж, эсхүл төлөөлөх бүрэн эрх байхгүй боловч, төлөөлөн үйл ажиллагаа явуулсан; 5. Дээр дурдсанаас бусад чухал үүргээ биелүүлээгүй.

Хувийг буцаан авах

ХХК-ийн хувь нь хөрвөх чадвар султай байдаг тул хувийг буцаан авах замаар хувь нийлүүлэгчийн хүсэл зоригоос гадуур компаниас хасахыг хүлээн зөвшөөрөх шаардлага үүснэ. Герман Улсын “GmbH” 34.1-т заасны дагуу компанийн дүрэмд заасан тохиолдолд хувийг хувь нийлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр буцаан авна. Энэхүү арга хэмжээг авах нөхцөл нь хувь нийлүүлсэн хөрөнгийг буцаан төлөх асуудал байдаг (19.2.1). Мөн хувийг буцаан авсны дараа өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгөөс багасах тохиолдолд хувийг буцаан худалдан авахыг хориглоно (GmbH 34.3, 30.1.1). Түүнчлэн ХХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах замаар хувийг буцаан авах заалт оруулах тохиолдолд бүх хувь нийлүүлэгчийн зөвшөөрөл шаардлагатай байхаар зохицуулжээ.

Улмаар ХХК нь дүрэмдээ хувь нийлүүлэгчийн хувийг буцаан авах нөхцлийг тусгах шаардлагатай бөгөөд шүүхээс дараах нөхцлийг нийтлэг байдлаар хүлээн зөвшөөрдөг байна. Үүнд:

- Хувьцаа эзэмшигч дампуурсан;
- Хувиа барьцаанд тавьсан;
- Хувьцааг зөвшөөрсөнөөс бусад этгээдэд шилжүүлсэн;
- Хувьцаа эзэмшигч нас барсан.

Компаниас хасах

“Компаниас хасах” гэдэг нь компанид хувь нийлүүлсэн этгээдийн хүсэл зоригт үл тулгуурлан бусад хувь нийлүүлэгчийн шийдвэрт үндэслэн компаниас гаргах тогтолцоо юм. ХХК-ийн харилцаа нь хувь нийлүүлсэн этгээдүүдийн итгэлцэл дээр суурилдаг. Улмаар компаниас хасах тогтолцоо нь тухайн хувь нийлүүлэгчтэй компани үйл ажиллагаагаа үргэлжүүлэн явуулахад эдийн засгийн, эсхүл итгэлцлийн хувьд боломжгүй болсон тохиолдолд тодорхой хувь нийлүүлэгчийн байр суурийг булаах замаар компанийн тогтвортой байдлыг хангахад чиглэнэ.¹⁵ Хувь нийлүүлсэн этгээдийг компаниас хасах нь компанийн орган дотооддоо шийдвэрлэхэд төвөгтэй харилцаа байдаг тул шүүхийн оролцоог хангах нь зайлшгүй зүйл юм.

Герман Улсын шүүхийн жишигт хувь нийлүүлэгчийн хувийг буцаан авах дүрмийн заалт байхгүй бөгөөд тохиролцооны үндсэн дээр хувийг нь буцаан авах боломжгүй тохиолдолд эцсийн аргын хүрээнд компаниас хасах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна.

Шүүх болон судлаачдын хандлагаас үзэхэд хувь нийлүүлэгчийг хасах үндэслэл нь хасагдах хувь нийлүүлэгч болон түүний үйл ажиллагаанаас шууд шалтгаалдаг. Компаниас хувь нийлүүлэгчийг хасах нь компанийн шийдвэр гаргах ажиллагааг гацаанаас гаргах цорын ганц арга байх тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд өөр арга байгаа бол зөвшөөрөх боломжгүй гэж үздэг.

Шүүхээс дараах тохиолдолд хувь нийлүүлэгчийг компаниас хасахыг хүлээн зөвшөөрсөн байна (Япон Улсын хувьд КТХ-ийн 859.1-т заасан). Үүнд:

- Компанийн дүрэмд заасан хувь нийлүүлэгчийн шалгуурыг хангахгүй болсон;

15 Tachibana Hirshoshi, The Operation and Ethics of Limited Liability Company, 61-62 (Chuokezai Co., 2nd ed., 2021).

- Компанийн дүрэмд заасан бол харилцан хэлэлцэх үүргээс татгалзсан;
- Үүргийн ноцтой зөрчил үүссэн (хувийн эрх ашгийн үүднээс компанийн эрх ашгийг зөрчсөн) ;
- Хувь нийлүүлэгч хоорондын итгэлцлийг сэргээх боломжгүй байдлаар эвдсэн.

Хувь нийлүүлэгчийг компаниас хасахад хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр шаардлагатайгаас гадна шүүхийн шийдвэрээр баталгаажуулах ёстой байдаг (Gmbh 61). Хувь нийлүүлэгчдийн хурлын саналын хувьд компанийг татан буулгахын нэгэн адилаар нийт гишүүдийн дөрөвний гуравын зөвшөөрөл шаардлагатай. Хасагдах асуудал хэлэлцэгдэж буй хувь нийлүүлэгчийн хувьд саналын эрхгүй боловч, үг хэлэх эрхтэй байдлаар оролцоно. Хоёр хувь нийлүүлэгчтэй ХХК-ийн хувьд түүний аль нэг хувь нийлүүлэгч нь нөгөө этгээдийг компаниас хасахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

Ямар ч тохиолдолд компаниас хасагдсан хувь нийлүүлэгч нь компаниас нөхөн төлбөр шаардах эрхийг эдлэх бөгөөд нөхөн төлбөрөө бүрэн авах хүртэл хувь нийлүүлэгчийн байр сууриа хадгална. Компанийн хувьд хасагдсан хувь нийлүүлэгчийн хувийг өөрөө эзэмших, эсхүл бусдад шилжүүлэх, устгах арга хэмжээг авч хэрэгжүүлж болно.

Ийнхүү Герман, Япон Улсын туршлагаас үзэхэд ХХК-ийн онцлогоос үүдэн түүний тогтвортой байдлыг хадгалахын тулд хувь нийлүүлэгчийн байр суурийг хүчээр авахад чиглэсэн тогтолцоог бий болгожээ. Монгол Улс дахь ХХК-ийн хэлбэр бусад улсын адилаар итгэлцлийн харилцаанд суурилсан зохион байгуулалтын хэлбэр тул итгэлцлийн харилцаа байхгүй болсон тохиолдолд хэрэгжүүлж болох эрх зүйн механизмыг бэхжүүлэх шаардлагатай байна.

Харин ХХК болон түүний олонхийн хувьцаа эзэмшигчийн зүгээс итгэлцлийн харилцаагүй болсон хувь эзэмшигчийн байр суурийг булаан авах асуудлыг ямар хүрээнд хүлээн зөвшөөрөхийг тодорхой судалгааны үндсэн дээр шийдвэрлэх учиртай.

Судлаачийн санал:

Энгийн хувьцааг буцаан авах У. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд заасан тохиолдолд компани эргэлтэд гаргасан энгийн хувьцаагаа буцаан авч болно. У2. Компаний дүрэмд дараах тохиолдолд энгийн хувьцаагаа буцаан авахаар тусгаж болно. Х. Хувьцаа эзэмшигч төлбөрийн чадваргүй болсон; Х2. Хувьцаа эзэмшигч нас барсан; Х3. Компани дүрмээр зөвшөөрсөнөөс бусад этгээдэд шилжүүлсэн; Х4. Хувьцааг хууль болон компанийн дүрэмд заасан журмыг зөрчиж барьцаалсан; У3. Хувьцааг буцаан авсан тохиолдолд тухайн хувьцаа эзэмшигчид нөхөн төлбөрийг бүрэн хэмжээгээр төлнө.	Компаниас хасах У. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигчид дараах үндэслэлээр аль нэг хувьцаа эзэмшигчийг компаниас хасахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно. Х. Компанитай өрсөлдөх үйл ажиллагаа явуулсан Х2. Хувийн эрх ашгийг тэргүүнд ээлжинд тавьсан Х3. Хувьцаа эзэмшигчид хоорондын итгэлцлийг сэргэх боломжгүй байдлаар эвдсэн Х4. Дүрэмд заасан бусад ноцтой зөрчил У2. Шүүхэд нэхэмжлэл гаргах эрхийг нийт хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын саналаар хэрэгжүүлнэ. У3. Хасагдах асуудал нь хэлэлцэгдэж буй хувьцаа эзэмшигч саналын эрхгүйгээр оролцож болно. У4. Хоёр хувьцаа эзэмшигч бүхий хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьд аль нэг хувьцаа эзэмшигч нь шүүхэд нэхэмжлэлийг гаргаж болно. У5. Хувьцаа эзэмшигчийг компаниас хасахыг шүүхээс зөвшөөрсөн шийдвэр гарсан тохиолдолд түүний эзэмшлийн хувьцааны нөхөн төлбөрийг бүрэн хэмжээгээр төлнө.
--	--

Судлаачийн дээр дурдсан санал нь энгийн хувьцааг буцаан авах болон хувьцаа эзэмшигчийг компаниас хасахад дүйцэх Япон болон Герман Улсын эрх зүйн зохицуулалтад тулгуурласан болно.

IV. Хязгаарлагдмал хариуцлагатай компаниас үнэт цаас гаргах, эргүүлэн худалдан авах

Хүснэгт 1. ХХК-иас нээлттэй хүрээнд гаргасан өрийн бичиг

№	Бонд гаргагч	Бондын нэр	Хугацаа	Хүү	Нэрлэсэн үнэ	Зарласан тоо	Нийт дүн	Хүү төлөх хугацаа	Бүртгэсэн огноо
3	"Пума групп" ХХК	"Пума бонд"	12 сар	21.60%	10000 төг	100,000 ширхэг	1,000,000,000	3 сараар	2004
4	"MCS Электроникс" ХХК	"MCS Электроникс бонд" / төгрөг/	18 сар	19.00%	120,000 төг	22,000 ширхэг	872,640,000	6 сараар	2004
5	"MCS Электроникс" ХХК	"MCS Электроникс бонд" / доллар/	12 сар	11.00%	100 доллар	14,728 ширхэг	605,000,000	Хугацааны эцэст	2004
6	"Анод банк" ХХК	"Анод Бонд"	24 сар	19.60%	10,000 төг	200,000 ширхэг	209,490,000	6 сараар	2004
7	"Алтан хот корпораци" ХХК	"Их барилга"	8 сар	19.80%	10,000 төг	100,000 ширхэг	996,920,000	Хугацааны эцэст	2002
9	"Их барилга төсөл" ХХК	"Их барилга төсөл"	8 сар	19.80%	50,000 төг	16,000 ширхэг	1,300,000,000	Хугацааны эцэст	2003
11	"Монфреш жүүс" ХХК	"Монфреш бонд" / доллар/	12 сар	11%	10 доллар	100,000 ширхэг	182,811,800	6 сараар	2007
13	"Жаст агро" ХХК	"Монгол мах"	12 сар	16.20%	10,000 төг	3,000,000 ширхэг	4,394,540,000	3 сараар	2011
14	"Эрчим инженеринг" ХХК	"Эрчим бонд"	12 сар	18.50%	10,000 төг	50,000 ширхэг	457,750,000	Хугацааны эцэст	2015

Эх сурвалж: "Монголын Хөрөнгийн Бирж" ХК

А. Үнэт цаас нээлттэй хүрээнд гаргах

Үнэт цаас гаргагч компанийн нээлттэй хүрээнд гаргасан үнэт цаас нь хөрөнгийн бирж дээр арилжаалагдах тул түүний хөрөнгө оруулагчийн өмнөх ил тод байдал чухлаар тавигдана. Улмаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар компаниуд үнэт цаасыг анхдагч зах зээл дээр гаргахад 1) үнэт цаасны танилцуулга, хоёрдогч зах зээл дээр 2) хууль болон журамд заасан мэдээллийг олон нийтэд тогтмол ил тод байлгах үүргийг хүлээдэг.

5 дугаар зүйл.Хязгаарлагдмал хариуцлагатай компани
 5.2.Хязгаарлагдмал хариуцлагатай компани нь хувьцаа, түүнийг худалдан авах эрхийн бичиг болон тэдгээрт хөрвөх үнэт цаасыг зөвхөн хаалттай захиалгын үндсэн дээр гаргах бөгөөд бусад үнэт цаасыг нээлттэй болон хаалттай аль ч хэлбэрээр гаргаж болно.

Гэвч КТХ-ийн 5 дүгээр зүйлийн 5.2-т ХХК нь хувьцаа, түүнийг худалдан авах эрхийн бичиг болон тэдгээрт хөрвөх үнэт цааснаас бусад төрлийн үнэт цаасыг

нээлттэй хүрээнд буюу хөрөнгийн бирж дээр арилжаалж болохоор зохицуулсан. Өөрөөр хэлбэл ХХК нь өнөөгийн эрх зүйн зохицуулалтын хүрээнд дараах үнэт цаасыг нээлттэй хүрээнд гаргаж болно. Үүнд:

- Ердийн өрийн бичиг (ҮЦЗЗтХ 4.1.9, КтХ);
- Опцион, фьючерс (ҮЦЗЗтХ 4.1.10, 11);
- Хадгаламжийн бичиг (ҮЦЗЗтХ 4.1.12).

Ялангуяа, хадгаламжийн бичгийн хувьд хөрөнгийн биржид бүртгүүлсэн үнэт цаасаар баталгааждаг тул хаалттай хүрээнд гаргах боломжгүй үнэт цаас гэдгийг анхаарах нь зүйтэй.¹⁶

Эдгээр үнэт цаас дотроос өрийн бичгийг ХХК нээлттэй хүрээнд гаргасан тохиолдол олон бий.

Үнэт цаасыг нээлттэй хүрээнд арилжаалахын тулд анхдагч болон хоёрдогч зах зээлийн мэдээллийн ил тод байдал чухлаар тавигдахаас гадна хөрөнгө оруулагчийг хамгаалах үүднээс эзэмшил болон удирдлага салсан байх шаардлага нийтлэг байдлаар тавигдана. Улмаар ХХК-ийн эзэмшил болон удирдлага салаагүй, мэдээллийн хувьд хаалттай зэрэг онцлогийг харгалзвал зарим төрлийн үнэт цаасыг нээлттэй хүрээнд арилжаалахыг зөвшөөрсөн КТХ-ийн 5.1 дэх хэсэг нь хөрөнгө оруулагч, хөрөнгийн зах зээл дээр итгэлийг хамгаалах үүднээс үзвэл оновчгүй заалт юм.

Мөн СЗХ-оос 2020 оны 12 дугаар сарын 9-ны өдрийн 995 дугаар тогтоолын хавсралтаар “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан нь ХХК-ийн зүгээс хаалттай хүрээнд үнэт цаас гаргах замаар санхүүжилт татах боломжийг бэхжүүлж өгсөн.

Түүнчлэн нээлттэй хүрээнд үнэт цаас гаргах чадвар бүхий ХХК-ийн хувьд МХБ-ийн бүртгэлийн шалгуурыг хангах шаардлагатай тул үйл ажиллагаа болон орлогын хувьд томд тооцогдох бөгөөд энэ төрлийн компаниуд нь ХК-ийн хэлбэрээр зохион байгуулагдах бүрэн боломжтой.

Иймд КТХ-ийн 5.2 дэх хэсгийг ХХК нь ямар ч үнэт цаасыг зөвхөн хаалттай захиалгын үндсэн дээр гаргах байдлаар өөрчлөн найруулах нь оновчтой байж болох юм. Ингэхийн тулд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн холбогдох зохицуулалтыг хамтатган авч үзэх шаардлага үүснэ.

В. Хязгаарлагдмал хариуцлагатай компаниас эргэлтэд гаргасан энгийн хувьцааг эргүүлэн худалдан авах

Компанийн эрх зүй нь компани өөрийн гаргасан энгийн хувьцааг эргүүлэн худалдан авах хэмжээнд тодорхой хязгаарлалтыг тавьдаг. Энэ нь хөрөнгийн зах зээл дээрх их хэмжээний эргүүлэн худалдан авалтаас шалтгаалан хувьцааны үнэ хөөрөгдөж, жижиг хувьцаа эзэмшигч хохирол хүлээх эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зохицуулалт юм.

16 С.Батбаяр, Компанийн тухай хууль дахь хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эрх зүйн зохицуулалтыг ялгамжтайгаар зохицуулах хэрэгцээ, шаардлага, МХХ-ны Иргэний эрх зүйн хороо, Илтгэлийн эмхэтгэл (2020), 8-9 дэх тал.

Энэхүү зохицуулалтын хүрээнд КТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт заасан зохицуулалтыг авч үзье.

49 дүгээр зүйл. Үнэт цаас эргүүлэн худалдаж авах
49.2. Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь худалдан авч болох бөгөөд харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджийн 25 хувиас хэтэрч болохгүй.

Дээрх эрх зүйн зохицуулалт нь үйлчлэлийн хувьд ХК-ийн хүрээнд оновчтой хэмээн дүгнэж болно. Харин найз нөхөд, гэр бүлийн хүрээлэл зэрэг цөөн тооны хувьцаа эзэмшигчээс бүрдсэн ХХК-ийн хувьд төдийлөн ач холбогдолгүй бөгөөд ХХК-ийн бизнесийн практикт сөрөг үр дагаврыг үүсгэж байна. Тухайлбал, тэнцүү хэмжээгээр хувьцаа эзэмшдэг гурван хувьцаа эзэмшигчтэй ХХК нь нэг хувьцаа эзэмшигчид ногдох хувьцаа буюу 33%-ийг эргүүлэх худалдаж авах тохиолдолд КТХ-ийн 49.2 дахь хэсэг зөрчигдөх үү гэсэн асуулт үүснэ.¹⁷

Цаашид шүүх дэх хуулийн хэрэглээг хялбар болгох үүднээс КТХ-ийн 49.2 дахь хэсгийг зөвхөн ХК-д хамааралтай байдлаар өөрчлөн найруулах боломжтой.

Судлаачийн санал:

49 дүгээр зүйл. Үнэт цаас эргүүлэн худалдаж авах
49.2. **Хувьцаат** компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь худалдан авч болох бөгөөд харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджийн 25 хувиас хэтэрч болохгүй.

V. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчийн хариуцлага

Компанийн эрх зүйд зохион байгуулалтын хэлбэр нь ХК эсхүл ХХК байхаас үл хамааран хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын зарчим хэрэгждэг. Энэхүү зарчим нь эзэмшил болон удирдлага салсан компанийн хэлбэр болох ХК-ийн хүрээнд туйлын шинжтэйгээр хэрэгжих бөгөөд уг зарчмыг үгүйсгэх эрх зүйн боломж байхгүй хэмээн хэлж болно.

Харин компанийн эзэмшил болон удирдлага салаагүй ХХК-ийн хувьд хувьцаа эзэмшигч компанийн үйл ажиллагаанд шууд оролцох боломжтой байхаас гадна тухайн компанийг халаасны компани (цаасан дээрх компани) байдлаар ашиглаж, гуравдагч этгээдэд хохирол учруулсан тохиолдолд хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагыг нэвтлэх боломжтой.

Гэвч хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагыг нэвтлэх ойлголт нь гагцхүү онцгой тохиолдолд л хэрэгжих бөгөөд КТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.5, ДТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.1, КТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.6 дэх хэсгийн хүрээнд яригдана.

Гэвч ХХК-д хамаарах шүүхийн практикт анхаарвал зохих асуудлууд үүсч байна. Үүнийг дараах хоёр хэсэгт хуваан авч үзье.

17 С.Батбаяр, Компанийн тухай хууль дахь хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эрх зүйн зохицуулалтыг ялгамжтайгаар зохицуулах хэрэгцээ, шаардлага, МХХ Иргэний эрх зүйн хороо, Илтгэлийн эмхэтгэл (2020), 6 дахь тал.

А. Хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлага¹⁸

Хувьцаа эзэмшигч компанийн хувьцааг эзэмшсэний оронд тухайн компанид хөрөнгө оруулахаас бусад компанийн аливаа үүрэгт хариуцлага хүлээхгүй. Үүнийг хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын зарчим (англи хэл., *limited liability of shareholders*) гэх бөгөөд орчин цагийн компанийн эрх зүй дэх хамгийн том нээлтэд тооцогддог.¹⁹

Энэхүү зарчим нь ХК-аас гадна ХХК-д хамаарах бөгөөд КТХ-ийн 9.3-т тусгалаа олсон байна.

9 дүгээр зүйл. Компанийн болон хувьцаа эзэмшигчийн хариуцлага
9.3. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

Энэ заалт нь 1999 оны КТХ-ийн 9.3 дахь хэсгээс эхтэй. Уг хуулийн 9.3 дахь хэсэгт “Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ” хэмээн заасан байжээ.

Гэвч шүүхийн практикт КТХ-ийн 9.3 дахь хэсэгт заасан “хувьцаа эзэмшигч нь ... гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.” гэснийг хоёр өөр агуулгаар тайлбарлан хэрэглэж байна. Үүнд:

Нэгдүгээрт, шүүхээс хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагын мөн чанарын дагуу “хувьцаа эзэмшигч компанийн хувьцааг эзэмшсэний оронд хөрөнгө оруулахаас бусад компанийн үүрэгт хариуцлага хүлээхгүй”²⁰ хэмээн ойлгож, компанийн өр төлбөрийн өмнө хүлээх хувьцаа эзэмшигчийн хариуцлагыг бүрэн үгүйсгэж байна.

Хоёрдугаарт, шүүхээс хувьцаа эзэмшигчийн хувь тэнцүүлсэн хариуцлагын үүднээс “хувьцаа эзэмшигч компанид эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр өр төлбөрийг хувь тэнцүүлэн хариуцна” хэмээн ойлгож, компанийн өр төлбөрийн өмнө хүлээх хувьцаа эзэмшигчийн хувь тэнцүүлсэн хариуцлагыг хүлээн зөвшөөрч байна.

Шүүхийн практикт КТХ-ийн 9.3 дахь хэсгийн “Хувьцаа эзэмшигч ... гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.” гэснийг үндэслэн хувьцаа эзэмшигчид хувь тэнцүүлсэн хариуцлага хүлээлгэсэн тохиолдолууд байгаа нь анхаарал татаж байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Хувь тэнцүүлсэн хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийн жагсаалт

1	Сүхбаатар дүүрэг, 2013.02.27, Дугаар 513	НШГА ²¹ нь “ОСАК ДӨЛ” ХХК-ийн өр төлбөрийг <u>34%-ийн хувьцаа эзэмшигч Д.Алимаа, 40%-ийн хувьцаа эзэмшигч Г.Баярмаагаас шаардсан.</u>	КТХ-ийн 9.3-д үндэслэн НШГА-ны шаардлагыг хангасан.
2	Чингэлтэй дүүрэг, 2015.09.17, Дугаар 6228	НШГА нь “Беринг” ХХК-ийн өр төлбөрийг төлүүлэх хүрээнд 49%-ийн хувьцаа эзэмшигч <u>“Волтам” ХХК-ийн харилцах дансыг зогсоосон.</u>	КТХ-ийн 9.3-д үндэслэн “Волтам” ХХК-ийн нэхэмжлэлийг хүчингүй болгох замаар НШГА-ны шаардлагыг хангасан.

18 Г.Давааням, Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд, (УБ:Соёмбо, 2020), 1-3 дахь талаас дэлгэнгүй үзнэ үү.

19 Bernard F. Cataldo, Limited Liability with One Man Companies and Subsidiary Corporations, 18 Law & Contemp. Prob. 473, 473 (1953); See also Frank H. Easterbrook & Daniel R. Fischel, Limited Liability and the Corporation, 52 U. Chi. L. Rev. 89, 89 (1985).

20 江頭憲治郎『株式会社法』35頁(有斐閣 第七版 2017年).

21 Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба.

Тухайлбал, Сүхбаатар дүүрэг, 2013.02.27, Дугаар 513 шийдвэрийг дурдаж болно.

Хэргийн агуулга

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанаас “Осак дөл” ХХК-ийн өр төлбөрийн хүрээнд түүний хувьцаа эзэмшигч Г.Баяраа, Д.Алимаа нарыг төлбөр төлөгч хэмээн тодорхойлж, төлбөрийг хувь тэнцүүлэн оногдуулсантай холбогдуулан Г.Баярмаа, Д.Алимаа нар КТХ-ийн 9.3-т заасныг үндэслэн төлбөр барагдуулах үйл ажиллагааг хүчингүй болгуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан.

Уг хэргийн хүрээнд 1-д, Баянзүрх дүүргийн шүүхийн 2010 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 1989 дугаар шийдвэрээр “ОСАК Дөл” ХХК-аас 16.967.950 төгрөгийг гаргуулан “Улаанбаатар дулааны сүлжээ” ХК-д олгохоор шийдвэрлэсэн, 2-т “ОСАК Дөл” ХХК –ийн 25 хувийг Т.Халиун, 35 хувийг Д.Алимаа, 40 хувийг Г.Баяраа эзэмшдэг болох, 3-т Лавлагаагаар дүрмийн сан 85.555.9 төгрөгөөр нэмэгдэж, 87.220.9 төгрөгөөр өөрчлөлт орсон болохыг 2011 оны 01 дүгээр сарын 28-нд улсын бүртгэлд бүртгүүлсэн, 4-т “Осак дөл” ХХК нь төлбөр төлөх эд хөрөнгөгүй, 5-т Т.Халиун өөрийн эзэмшлийн хувьцааны хэмжээнд оногдох 4.252.000 төгрөгийг төлсөн зэрэг үйл баримт авагдсан байна.

Шийдвэрийн агуулга

“Улсын бүртгэлийн ерөнхий газраас Хуулийн этгээдийн тухай лавлагааг гаргуулснаар уг компанийн дүрмийн сан 85.555.978 төгрөгөөр нэмэгдэж 87.220.978 төгрөг болж өөрчлөгдөн, шинэчилсэн бүртгэлд бүртгэгдсэн, хувь нийлүүлэгч Г.Баяраа нийт хувьцааны 40 хувь, Т.Халиун 25 хувь, Д.Алимаа 35 хувийг эзэмшдэг болохыг тогтоожээ.”

“Хариуцагч дээрх баримтыг үндэслэн 2012 оны 8 дугаар сарын 07, 16-ны өдрүүдэд компанийн хувь нийлүүлэгч Д.Алимаад төлбөрийн 5.938.782 төгрөгийг төлөх ... тухай мэдэгдэл өгснийг нэхэмжлэгч шүүхэд ирүүлсэн нэхэмжлэлдээ хавсарган ирүүлсэн байна.”

“Энэ нь КТХ-ийн 9.3. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээнэ гэснийг зөрчсөн гэж үзэхгүй. Иймд тухайн шийдвэрийг гүйцэтгэх явцад компанийн хувьцаа эзэмшигч нараас эзэмшиж буй хувьцааны хэмжээгээр төлбөр төлөхийг мэдэгдсэн ажиллагааг хууль бус гэж үзэх буюу дурьдсан этгээдүүдийг төлбөр төлөх үндэслэлгүй гэж үзэхгүй тул нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй.”

Улмаар шүүхээс “ОСАК ДӨЛ” ХХК-ийн өр төлбөрийг түүний 35%-ийн хувьцаа эзэмшигч Д.Алимаа, 40%-ийн хувьцаа эзэмшигч Г.Баярмаа нараар тэдгээрийн эзэмшлийн хувьцааны хэмжээгээр хувь тэнцүүлэн гаргуулахаар шийдвэрлэсэн байна.

Гэвч хувь тэнцүүлсэн хариуцлага хэрэглээний хувьд компанийн эрх зүйн хөгжлийн эхэн үед буюу 1849-1931 оны хооронд Америкийн Калифорния муж улсад богино хугацаанд хэрэглэгдсэнээс өөр практик байхгүй.²² Энэ хувь тэнцүүлсэн

22 Blumberg, P. I., Limited Liability and Corporate Groups, The Journal of Corporation Law 11 (Summer), 573, 573–631 (1986).

хариуцлага нь 1) хэрэгжих боломжгүй ба хэрэгжсэн ч шүүхийн зардал, төлбөрийг гаргуулахад ихээхэн хүндрэл үүснэ.²³ 2) компанийн үйл ажиллагаанд идэвхгүй оролцоотой жижиг хувьцаа эзэмшигчид хувь тэнцүүлсэн хариуцлага ногдуулах нь тохиромжтой бус²⁴ байдагтай холбоотой юм.

Онолын хувьд КТХ-ийн 9.3-т заасан “гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.” гэдэг нь хувьцаа эзэмшигч нь компанийн хувьцааг олж авсны оронд компани хувь нийлүүлэх замаар компани балансад бичүүлсэн хөрөнгийн хэмжээгээр хариуцлага нь хязгаарлагдана гэсэн санааг илэрхийлнэ.

Гэвч шүүхийн практикт КТХ-ийн 9.3-т заасан “гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.” гэсэн хэсгийг хувь тэнцүүлсэн хариуцлага хэмээн ойлгон хэрэглэх тохиолдол байгаа тул хуулийн хэрэглээний нэгдмэл байдлыг хангах үүднээс КТХ-ийн 9.3-ийг дараах байдлаар өөрчлөн найруулах боломжтой.

9 дүгээр зүйл. Компанийн болон хувьцаа эзэмшигчийн хариуцлага
9.3. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

Хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь бодит байдал дээр компани балансад бичигдсэн компанийн хөрөнгө болох тул компанийн шаардах эрх бүхий этгээдийн өмнө тухай хөрөнгөөр хариуцлага хүлээх нь нягтлан бодох бүртгэлийн үүднээс үзсэн ч ойлгомжтой зүйл юм.

В.Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хязгаарлагдмал хариуцлагыг нэвтлэх²⁵

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагааны практикт шийдвэр гүйцэтгэгч ХХК-ийн өр төлбөрт хамаарах шийдвэрийг гүйцэтгэхдээ компанийн хөрөнгөөс шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсны дараа үлдсэн өр төлбөрийг тухайн компанийн хувьцаа эзэмшигчээс шаардах тохиолдол гарах болсон. Ингэхдээ ШШГТХ-ийн 93.4 болон КТХ-ийн 9.5-т үндэслэж байна.

ШШГТХ-ийн 93.4-т “Төлбөр төлөгчийн нийт хөрөнгө нь гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй тохиолдолд тухайн хуулийн этгээдийн үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн эд хөрөнгөөс төлбөр гаргуулах эсэх асуудлыг үүсгэн байгуулагч, хувь эзэмшигчийн эд хөрөнгийн хариуцлагын харилцааг зохицуулсан хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлэнэ” хэмээн зохицуулжээ.

23 Janet C. Alexander, Unlimited Shareholder Liability through a Procedural Lens, 106 Harv. L. Rev. 387, 388-339 & 418-444 (1992).

24 Компанийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд идэвхгүй оролцдог жижиг хувьцаа эзэмшигчид хувь тэнцүүлсэн хариуцлага хүлээлгэвэл толгой компанийн нөхөн төлбөр багасана. Энэ тохиолдолд, охин компаниар дамжуулан оруулсан хөрөнгөнөөс илүү хэмжээний орлого олж байгаа толгой компани бол морал хазард үйлдэх сэдэл улам нэмэгдэх эрсдэлтэй. Мөн охин компанийн идэвхгүй хувьцаа эзэмшигч бол идэвхтэй хувьцаа эзэмшигчтэй хэлэлцээ хийх боломжтой ч, охин компанийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх чадваргүй тул хувьцаа эзэмшигчийн пропорциональ хариуцлага нь хувьцаа эзэмшигчийн сэдлээс үүдэлтэй морал хазардын эсрэг арга хэмжээний хүрээнд хангалтгүй гэж үздэг. See Timothy P. Glynn, Beyond “Unlimited” Shareholder Liability Vicarious Tort Liability for Corporate Officers, 57 Vand. L. Rev. 329, 378-380 (2004); 向井貴子「株主有限責任のモラル・ハザード問題と非任意債権者の保護」九大法学91号267頁、387頁(2005年)。

25 Г.Давааням, Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд, (УБ:Соёмбо, 2020) 16-26 дахь талаас дэлгэрүүлж үзнэ үү.

Улмаар шийдвэр гүйцэтгэгч компанийн үлдэгдэл өр төлбөрийг түүний хувьцаа эзэмшигчээс гаргуулах эсэх асуудлыг хувьцаа эзэмшигчийн хариуцлагын талаар зохицуулсан КТХ-д үндэслэн шийдвэрийг гүйцэтгэх шаардлага үүсдэг. Энэ хүрээнд ач холбогдол бүхий заалт нь КТХ-ийн 9.5 дахь хэсэг юм.

КТХ-ийн 9.5-ын хэрэглээний хүрээнд хувьцаа эзэмшигчийн хариуцлага хүлээх хөрөнгийн хүрээ судлаачдын анхаарлыг татаж байна.

9 дүгээр зүйл. Компанийн болон хувьцаа эзэмшигчийн хариуцлага
9.5. Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна.

Үүнтэй холбоотойгоор КТХ-ийн зарчим зүйл, заалтын тайлбарлах тухай УДШ-ийн 2007 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн 27 дугаар тогтоолд КТХ-ийн 9.5-д заасан “компанийн өр төлбөрийг давхар хариуцна” гэдэг нь компанийн төлбөрийг барагдуулахад хувь нийлүүлэгчийн бүх хөрөнгө нь компанийн өөрийн хөрөнгөд тооцогдон түүгээр компанийн хүлээх хариуцлагыг нөхөн төлнө гэж ойлгоно” хэмээн тайлбарласан. Өөрөөр хэлбэл, УДШ-ийн тайлбараас хувьцаа эзэмшигч хувийн бүх хөрөнгөөр давхар хариуцлага хүлээнэ хэмээн ойлгож болно.

Мөн хувьцаа эзэмшигчийн хариуцлага хүлээх хөрөнгийг хүрээний талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн практикт УДШ-ийн тайлбартай адил байр суурийг баримталж байна. Өөрөөр хэлбэл, хувьцаа эзэмшигчийн бүх хөрөнгө гэх ойлголтын хүрээнд компанийн үйл ажиллагааны хүрээнд ашиглаж буй түүний аж ахуйн зориулалттай хөрөнгөөс гадна гэр бүлийн гишүүний хамтран өмчлөх дундын өмчийн хөрөнгө болон хуваарьт хөрөнгийг хамааруулан ойлгож байна.

Хүснэгт 3. НШГА-аас хувьцаа эзэмшигчийн хөрөнгөд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсан байдлын талаар шүүхийн шийдвэрийн жагсаалт

№	Шийдвэрийн мэдээлэл	Хувьцаа эзэмшигчийн хөрөнгөд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулсан байдал	Шүүхийн шийдвэрийн агуулга
1	Сүхбаатар дүүрэг, 2014.06.23, Дугаар 2489	НШГА нь “Гууддоор ХХК”-ийн өр төлбөрийг төлүүлэх хүрээнд 100%-ийн хувьцаа эзэмшигч Д.Энхжаргалын орон сууцыг битүүмжилж, захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн.	КТХ-ийн 9.5-д заасны дагуу хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан хөрөнгө хувийн хөрөнгөөс тодорхой заагдлагсан эсэхийг нягтлах ёстой гээд орон сууцны битүүмжлэх тогтоолыг хүчингүй болгосон.
2	Баянзүрх, Сүхбаатар Чингэлтэй дүүрэг, 2015.10.16, Дугаар 6929	НШГА нь “Гүн бэйс групп” ХХК-ийн өр төлбөрийг төлүүлэх хүрээнд 34%-ийн хувьцаа эзэмшигч Т.Дамдиндоржийн нэр дээр бүртгэлтэй автомашиныг битүүмжилсэн.	ИХ-ийн 25.1 болон КТХ-ийн 9.3-д үндэслэн НШГА-ны автомашин битүүмжлэх тогтоолыг хүчингүй болгосон.
3	Баянзүрх, Сүхбаатар Чингэлтэй дүүрэг, 2015.11.04, Дугаар 7425	НШГА нь “Хайсын хүчтэнүүд” ХХК-ийн татварын өрийг төлүүлэх хүрээнд 30%-ийн хувьцаа эзэмшигч Ц.Сайнбилэг өөрийн эзж Л.Сувдаатай хамтран өмчилдөг дундын хөрөнгө болох орон сууцыг битүүмжилсэн.	КТХ-ийн 9.5-д үндэслэн хувийн өмчийн орон сууц нь компанийн хөрөнгөөс бүрэн тусгаарлагдмал байж, ялган зааглах бүрэн боломжтой байдлаар бүртгэгдэж, ашиглагдаж байсан хэмээн орон сууцны битүүмжлэх тогтоолыг хүчингүй болгосон.
4	Улсын Дээд Шүүх 2016.12.09, Дугаар 001/ХТ2016/011373	НШГА нь “Сэйсфон” ХХК-ийн өр төлбөрийн төлүүлэх хүрээнд 70%-ийн хувьцаа эзэмшигч “Тавантолгой Транс” ХХК-ийн өмчлөлийн автомашиныг битүүмжилсэн.	1-т КТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт зааснаар хувьцаа эзэмшигч “Тавантолгой транс” ХХК-ийн үүргийг хариуцахгүй, 2-т КТХ-ийн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт заасан “зааглагдаагүй эд хөрөнгөд” “Тавантолгой транс” ХХК-ийн өмчлөлийн автомашин хамаарахгүй гэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн.

Эндээс КТХ-ийн 9.5 дахь хэсэгт заасан “хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр” гэснийг өргөн утгаар тайлбарлан хэрэглэх хандлагатай байгааг харж болно (Хүснэгт 3).

Аж ахуйн үйл ажиллагаа явуулах хүрээнд компани өөрийн гэсэн тодорхой хэмжээний хөрөнгөтэй байх нь зайлшгүй зүйл юм. Улмаар хувьцаа эзэмшигч компани байгуулах замаар үйл ажиллагаа явуулахдаа тухайн компанид оруулах хөрөнгийн хэмжээг хумих асуудалд тодорхой хязгаар байдаг. Гэвч хувьцаа эзэмшигч өөрийн өмчлөлийн, эсхүл хамаарал бүхий этгээдийн өмчлөлийн хөрөнгийг компанид түрээслэх, компанийн өмчлөлийн хөрөнгийг барьцаалах замаар өөрөөсөө эсхүл хамаарал бүхий этгээдээс мөнгө гарган компанийг санхүүжүүлэх зэрэг аргаар үйл ажиллагаа явуулж компанийн хөрөнгийн хязгаарыг гэтлэх боломжтой.²⁶

Энэхүү түрээслүүлэгч болон барьцаалагч зэрэг этгээд нь онолын хувьд хувьцаа эзэмшигчтэй огт хамааралгүй гуравдагч этгээд байх боломжтой ч, практикт хувьцаа эзэмшигч өөрөө, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхол бүхий этгээд, компанийн нэгдлийн оролцогчид байх тохиолдол олонтаа.²⁷

Энэхүү аж ахуйн үйл ажиллагааны хөрөнгөө хуулийн этгээд байгуулах замаар зааглах тохиолдлыг судлаачид “Judgment-proof” хэмээх ойлголтын хүрээнд авч үздэг.²⁸ Энэ нь компанийн үйл ажиллагааг эхлэх үед компанид чиглэсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн хүрээнд гаргах хөрөнгөөс тодорхой хөрөнгийг зааглахын тулд компанийн хөрөнгийг хохирол нөхөн төлөхөд хангалтгүй байлгах” тухай ойлголт юм.

Энэхүү шүүхийн шийдвэрийн гүйцэтгэл нь КТХ-ийн үндсэн зарчим болох хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагад харшилж байна. Улмаар хязгаарлагдмал хариуцлагын үүднээс КТХ-ийн 9.5 дахь хэсгийг онолын үндэслэлтэй тайлбарлан хэрэглэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. КТХ-ийн 9.5 дахь хэсэгт заасан “хувьцаа эзэмшигч өөрийн бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр” гэснийг хувьцаа эзэмшигчийн компанид оруулах замаар зааглаагүй буюу “хувьцаа эзэмшигч компанийн үйл ажиллагааны хүрээнд ашиглаж буй аж ахуйн зориулалттай бүх эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр” компанийн өр төлбөрт давхар хариуцлага хүлээнэ хэмээн тайлбарлан хэрэглэх нь оновчтой байж болох юм.

Энэ хүрээнд хувьцаа эзэмшигч өөрийн эрхэлж буй зэргэлдээ аж ахуйн үйл ажиллагаа болон бусад компанид оруулсан хөрөнгөөр хариуцлага хүлээх эсэх талаарх маргаан үүсэж болох юм²⁹. Үүнийг шийдвэрлэхдээ шүүхээс хувьцаа эзэмшигчид “judgment-proof” байгаа эсэхийг шалгуур болгон тухайн хэрэг маргааны үйл баримтад тулгуурлах нь зүйд нийцнэ.

26 後藤元『株主有限責任制度の弊害と過小資本による株主の責任』（商事法務 2007年）120頁.

27 Тухайлбал, Зээлдэгчийн хүрээнд Улсын Дээд Шүүх, 2018.04.17, Дугаар 001/ХТ2018/00617.

28 Lynn M. LoPucki, The Irrefutable Logic of Judgment Proofing: A Reply to Professor Schwarcz, 52 Stan. L. Rev. 55, 14-30 (1999), Stephen G. Gills, The Judgment-Proof Society, 63 Wash. & Lee L. Rev. 603 (2006).

29 Давж заалдах шатны шүүх(2016.08.17, Дугаар 1448)-ээс “Компанийн тухай хуулийн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт заасан “зааглагдаагүй эд хөрөнгөд” “Тавантолгой транс” ХХК-ийн өмчлөлийн автомашин хамаарахгүй гэсэн шүүхийн дүгнэлт Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт нийцжээ. Өөрөөр хэлбэл, “Тавантолгой транс” ХХК нь “Сейсфон” ХХК-ийн хувьцааны 70 хувийг эзэмшдэг нь тодорхой байх бөгөөд “Тавантолгой транс” ХХК-ийн өмчлөлийн эд хөрөнгийг хувийн эд хөрөнгө гэж үзэхгүй юм. Учир нь хувийн гэх тодотголтой эд хөрөнгө нь хувь хүний эд хөрөнгө болно” хэмээн дүгнэсэн нь анхаарал татаж байна.

Улмаар КТХ-ийн 9.5-ийг “Хувьцаа эзэмшигчийн компанид оруулсан эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх нь хувийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээс тодорхой зааглагдаагүй бол уг хувьцаа эзэмшигч тухайн компанийн аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд ашиглаж буй өөрийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхээр компанийн өр төлбөрийг давхар хариуцна” хэмээн өөрчлөн найруулж болно.

Мөн дээрх зохицуулалт нь эзэмшил болон удирдлага салаагүй ХХК болон түүний хувьцаа эзэмшигч хоорондын харилцаанд л үйлчлэх боломжтой бөгөөд ХК-ийн харилцаанд яригдах боломжгүй болохыг анхаарах шаардлагатай. Харин компанийн нэгдлийн хүрээнд хэрэглэгдэх боломжтой тул хуулийн заалтад “ХХК” гэсэн тодотгол хийхгүй байхыг судлаач илүү оновчтой гэж үзэж байна.

VI. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчийн эрх

A. Таслан зогсоохоор нэхэмжлэл гаргах эрх

ХХК-ийн хувьд ХК-аас ялгаатай тал нь эзэмшил болон удирдлага салаагүй байдаг тул компанийн нэг эсхүл хэсэг бүлэг хувьцаа эзэмшигч компанийн үйл ажиллагааг удирдах нь нийтлэг байдаг. Мөн хувьцаа эзэмшигчдийн нийтлэг эрх ашгийг төлөөлөн компанийг удирдах, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий төлөөлөн удирдах зөвлөлгүй байх тохиолдол түгээмэл юм.

Улмаар компанийн удирдлагын үйл ажиллагаанд шууд оролцдоггүй идэвхгүй хувьцаа эзэмшигчийн зүгээс компанийн удирдлагын үйл ажиллагаанд шууд хяналт тавих эрх зүйн механизмыг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага үүсдэг.

Энэ хүрээнд КТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.11 дэх хэсгийг авч үзэж болно.

5 дугаар зүйл.Хязгаарлагдмал хариуцлагатай компани

5.11.Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигч нь компанийн талаарх бүх мэдээллийг авах, санхүүгийн болон бусад баримт бичигтэй танилцах эрхтэй.

КТХ-ийн 5.11 дэх хэсгээр ХХК-ийн хувьцаа эзэмшигчид компанийн талаарх бүх мэдээллийг авах, санхүүгийн болон бусад баримт бичигтэй танилцах замаар бусад хувьцаа эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, хууль бус үйл ажиллагааг илрүүлэх боломжийг олгосон.

Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл авах эрх нь тухайн мэдээлэлд үндэслэн тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх механизмгүйгээр эрх зүйн хувьд бодит ач холбогдолгүй байдаг. Улмаар компанид хохирол үүсэхээс өмнөх шатанд тухайн хууль бус үйл ажиллагаатай холбоотой 1) хувьцаа эзэмшигчийн таслах зогсоох нэхэмжлэл гаргах эрх, 2) шүүхэд төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхээр хангасан байх учиртай.

Гэвч КТХ-ийн 5.11 дэх хэсэгт хувьцаа эзэмшигчийн мэдээлэл авах эрхийг хуульчлан тогтоосон боловч, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох нэхэмжлэл гаргах эрхийг орхигдуулсан байна. Япон Улсын эрх зүйн зохицуулалтаас үзвэл хаалттай компанийн хувьцаа эзэмшигч нь компанийн гүйцэтгэх удирдлагын хууль бус үйл ажиллагааг олж илрүүлсэн тохиолдолд таслан зогсоох нэхэмжлэлийг шүүхэд гаргах эрхтэй байна.

Япон Улсын КТХ

Хувьцаа эзэмшигчийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг таслан зогсоох

422.1. 6 сар (үүнээс богино хугацааг дүрмээр тогтоосон бол тухайн хугацаа)-ын өмнөөс хувьцааг нь эзэмшиж буй хувьцаа эзэмшигч нь гүйцэтгэх удирдлага нь хороодтой компанийн зорилгоос гадуур үйл ажиллагаа явуулсан, эсхүл хууль болон дүрмийг зөрчсөн, эсхүл зөрчих эрсдэл байгаа бөгөөд тухайн үйлдлийн улмаас буцаан төлөх боломжгүй хохирол учрахаар байгаа тохиолдолд тухайн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг зогсоохоор нэхэмжлэл гаргаж болно.

422.2. Нээлттэй биш хороодтой компанийн дээрх заалтын хэрэглээний хувьд бүхий л хувьцаа эзэмшигч нэхэмжлэл гаргаж болно.

Япон Улсын зохицуулалт нь эзэмшил болон удирдлага салсан байх боломж бүхий хороодтой компанийг объектоо болгосон. ХХК-ийн хувьд нийтлэг байдлаар эзэмшил болон удирдлага салаагүй байдаг тул гүйцэтгэх удирдлагын хууль бус үйл ажиллагааг таслан зогсоохоор нэхэмжлэх эрх нь төдийлэн ач холбогдолгүй байх боломжтой. Гэвч ХХК-ийн үйл ажиллагаанд оролцдоггүй, идэвхгүй хувьцаа эзэмшигч эсхүл яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд хуульчлан тогтоож болох юм. Ялангуяа, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой ХХК-ийн хүрээнд хувьцаа эзэмшигчээс гүйцэтгэх удирдлагын хууль бус үйл ажиллагааг таслах зогсоохоор нэхэмжлэх эрх нь онцгой ач холбогдолтой хэмээн хэлж болно.

Судлаачийн санал:

Хувьцаа эзэмшигчийн таслан зогсоох нэхэмжлэл

У. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигч нь гүйцэтгэх удирдлагын хууль бус үйл ажиллагааг олж мэдсэн тохиолдолд таслан зогсоохоор компанид шаардлага гаргах, шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

Судлаачийн дээр дурдсан санал нь Япон Улсын эрх зүйн зохицуулалтад тулгуурлав.

В.Хувьцаа эзэмшигчийн төлөөлөн нэхэмжлэл

1999 оны КТХ-д “хувьцаа эзэмшигчийн төлөөлөн нэхэмжлэл” анх удаа хуульчлагдсан. Уг хуулийн 83.1-т “Компанийн энгийн хувьцааны нэг буюу түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанид учруулсан хохирлыг компанийн эрх бүхий албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй” гэжээ.

Эндээс үзэхэд компанийн энгийн хувьцаа эзэмшигч компанийг төлөөлөн шүүхэд шууд нэхэмжлэл гаргана. Өөрөөр хэлбэл, хувьцаа эзэмшигч компаниар дамжуулах эсхүл шүүхэд хандахыг компаниас шаардахгүйгээр компанийг шууд төлөөлөн нэхэмжлэл гаргах боломжтой байна. Гэвч компанийн эрх зүйн практикт хувьцаа эзэмшигчийн зүгээс хувьцаа эзэмшигчийн төлөөлөн нэхэмжлэл гаргах эрхийг хэрэгжүүлэхэд шүүхийн зардлын асуудал хүндээр тусч байна. “Шүүхийн зардал” гэдэгт хувьцаа эзэмшигчийн төлөөлөн нэхэмжлэлийг хэрэгжүүлэхэд гарах улсын тэмдэгтийн хураамж, өмгөөллийн хөлс зэрэг процессын зардлыг хамааруулан ойлгоно.

Хувьцаа эзэмшигчийн төлөөлөн нэхэмжлэлийн үр дүнд гарсан шүүхийн шийдвэр нь тухайн нэхэмжлэл гаргасан хувьцаа эзэмшигч бус компанид үйлчилнэ. Хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлийг шүүх хангасан тохиолдолд нөхөн төлбөр нь компанид төлөгдөнө. Энэ нь төлөөлөн нэхэмжлэлийн мөн чанар нь албан тушаалтанд чиглэсэн компанийн шууд бус нэхэмжлэл байдаг оршино. Гэвч Монгол Улсын КТХ болон процессийн хуульд хувьцаа эзэмшигчид ногдох шүүхийн зардлын дарамтыг хөнгөлөх эсхүл бусад этгээдэд хуваарилах талаар ямар нэгэн зохицуулалтыг тусгаж өгөөгүй.

Улмаар төлөөлөн нэхэмжлэлийг хэрэгжүүлэхэд гарах шүүхийн зардлаас шалтгаалан хувьцаа эзэмшигч төлөөлөн нэхэмжлэлийг хэрэгжүүлж чадахгүй байх нөхцөл байдал үүсч байна. Өөрөөр хэлбэл, зарим тохиолдолд хувьцаа эзэмшигчдээс албан тушаалтны компанид учруулсан хохирлын асуудлаар шүүхэд хандаж чадахгүй байгаа нь ИХШХШТХ-ийн 57 дугаар зүйл, УТХТХ-ийн /шинэчилсэн найруулга/ 7 дугаар зүйлд заасны дагуу нэхэмжлэлийн үнийн дүнгээс хамааран улсын тэмдэгтийн хураамж, их хэмжээний өмгөөллийн хөлсийг өөрөө хариуцан төлдөгтэй холбоотой.

УТХТХ-д зааснаар нэхэмжлэлийн үнийн дүнгээс шалтгаалан хураамжийн хэмжээ өөрчлөгдөх тул их хэмжээний нэхэмжлэлийн үнийн дүн бүхий төлөөлөн нэхэмжлэлийн хувьд улсын тэмдэгтийн хураамж нэлээд үнэтэй тусна. Үүнээс гадна, өмгөөллийн хөлсийг ч хариуцан төлөх ёстой.

Хүснэгт 4. Эд хөрөнгийн чанартай нэхэмжлэлийн үнийн дүнд харьцуулсан УТХ-ийн тооцоолол:³⁰

Нэхэмжлэлийн үнийн дүн /төгрөгөөр/	Хураамжийн хувь, хэмжээ /төгрөгөөр/
0-130000	4550 төгрөг.
130001-650000	4550 төгрөг дээр 130000 төгрөгөөс давсан дүнгийн 3 хувийг нэмнэ.
650001-1 300000	20150 төгрөг дээр 650 000 төгрөгөөс давсан дүнгийн 2.4 хувийг нэмнэ.
1300001-13000000	35750 төгрөг дээр 1 300 000 төгрөгөөс давсан дүнгийн 1.6 хувийг нэмнэ.
13000001-ээс дээш	222950 төгрөг дээр 13 000 000 төгрөгөөс давсан дүнгийн 0.5 хувийг нэмнэ.

Харин бусад улсад улсын тэмдэгтийн хураамжийн хүрээнд нэхэмжлэлийн үнийн дүнгээс үл хамааран тогтмол байдлаар хуульчлан тогтоох практик нийтлэг байна. Энэ хүрээнд Америк, Япон улс зэргийг дурдаж болно. Тухайлбал, Япон улс 1993 онд КТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулахдаа хувьцаа эзэмшигчийн төлөөлөн нэхэмжлэлд хамаарах улсын тэмдэгтийн хураамжийг тогтмол 13,000 иен байхаар хуульчилсан³¹. Үүний дараа төлөөлөн нэхэмжлэлийн хувь нэмэгдсэн байна³².

Өмгөөлөгчийн хөлсийн хүрээнд Япон улс хувьцаа эзэмшигчийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг шүүхээс хангасан тохиолдолд хувьцаа эзэмшигч нь өөрийн зүгээс гаргасан өмгөөллийн хөлс болон шүүх хуралдааны явцад гаргасан холбогдох зардлаа компаниас нэхэмжлэх эрхтэй байхаар зохицуулсан³³. Энэ нь хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлийн үр дүн нь хувьцаа эзэмшигч бус компанид ашигтай тусдагтай холбоотой юм.

Харин Америк улсын хувьд тухайн маргаанд ялсан эсхүл эвлэрсэн тохиолдолд л өмгөөлөгч хөлс авах тул төлөөлөн нэхэмжлэлийн хэрэгжүүлэх хувьцаа эзэмшигчийн сэдэл өндөр байдаг³⁴. Мөн шүүх хурал дуустал өмгөөлөгчийн зүгээс ямар нэгэн зардлыг үйлчлүүлэгчийн зүгээс шаардахгүй байх практик нийтлэг байдаг нь хувьцаа эзэмшигчийн төлөөлөн нэхэмжлэлийг хэрэгжих томоохон хөшүүрэг

30 Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль 7.1, 2010 он;

31 民事訴訟費等に関する法律4条2項・別表第一 第一項（1971年）.

32 伊藤靖史など、「会社法」230頁（有斐閣、第2版 2012年）.

33 会社法852条1項（2005年）.

34 高橋均『株主代表訴訟の理論と制度改正の課題』（同文館出版、2008）133.

болдог байна³⁵. Түүнчлэн маргаанд ялсан хувьцаа эзэмшигч нь тухайн төлөөлөн нэхэмжлэл бодит байдал дээр компанийн хувьд ашигтай (substantial benefit) байсан тохиолдолд компаниар өмгөөллийн хөлсийг гаргуулах боломжтой.

Улмаар хувьцаа эзэмшигчийн төлөөлөн нэхэмжлэлийн хүрээнд шүүхийн зардлыг хуваарилах нь зүйтэй. Үүнд, нэгдүгээрт төлөөлөн нэхэмжлэлд хамаарах улсын тэмдэгтийн хураамжийг нэхэмжлэлийн дүнтэй уях бус, тогтмол байдлаар тогтоох, хоёрдугаарт холбогдох өмгөөллийн хөлсийг компаниас шаардан гаргуулах боломжтой байдлаар зохицуулах шаардлагатай байна.

Судлаачийн санал:

Улсын тэмдэгтийн хураамж

У. Хувьцаа эзэмшигч төлөөлөн нэхэмжлэл гаргахдаа төлөх Улсын тэмдэгтийн хураамж нь тогтмол байх бөгөөд 5 жил тутам Санхүүгийн Зохицуулах Хорооноос шинэчлэн тогтооно.

Хууль зүйн туслалцааны зардлыг шаардах

У. Шүүхээс хувьцаа эзэмшигчийн төлөөлөн нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн эсхүл хэсэгчилэн хангах шийдвэр гаргасан тохиолдолд хууль зүйн туслалцааны үйл ажиллагаанд шууд хамаарах зардлыг компаниас нөхөн төлнө.

Харин ХК-ийн хувьд түүний хувьцаа олон нийтэд чөлөөтэй арилжаалагдах шинжтэй холбоотойгоор хувьцааны үнэ унах, өрсөлдөгч компанийн зүгээс хувьцааг худалдан авах замаар төлөөлөн нэхэмжлэл гаргах зэрэг сөрөг үр дагавар үүсэх тул төлөөлөн нэхэмжлэлийн хүрээнд тодорхой хязгаарлалтыг хийх шаардлага үүсдэг болохыг анхаарах шаардлагатай.

VII. Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн арилжааны итгэлийг хамгаалах

Монгол Улсын бизнесийн практикт компанитай гэрээ хэлцлийн харилцаанд орж буй тал түүний төлөөлөх бүрэн эрх бүхий этгээдийн эрх зүйн чадварыг нягтлахын тулд 1) ХЭХ-ийн тогтоол, 2) гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээ, компанийн дүрмийг шаардан гаргуулах асуудал үүсч байна³⁶.

Энэхүү нөхцөл байдал нь арилжааны харилцааг удаан, төвөгтэй болгохоос гадна баримт бичгийн солилцоо, хяналт-шинжилгээний зардлыг нэмэгдүүлж, гэрээний талуудын гүйлгээний зардлыг /transaction cost/ өндөр болгож байна.

Үүний шалтгааныг КТХ-ийн 59 дүгээр зүйлийн 59.5, 59.6 дахь хэсгийн заалттай холбон тайлбарлаж болно.

А. Хувьцаа эзэмшигчийн ээлжит хурал ба үр дагавар

ХХК-ийн харилцааг гадаад болон дотоод хэмээн салган авч үзэж болно. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг сонгох нь компанийн дотоод харилцаа бөгөөд тухайн үйл баримтын талаар компанитай эрх зүйн харилцаанд оролцох тал мэдэх боломжгүй юм.

35 同上、134頁。

36 Тухайлбал, арилжааны банкнаас компанид зээл олгохдоо компанийн дүрэм, гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээ зэргийг шаардаж байна.

59 дүгээр зүйл.Хувьцаа эзэмшигчдийн хурал

59.4.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна.

59.5.Энэ хуулийн 59.4-т заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно.

59.6.Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн бүрэн эрх нь дуусгавар болсон өдрөөс хойш байгуулсан гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

КТХ-ийн 59 дүгээр зүйлийн 59.6 дахь хэсэгт санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулаагүй бол ТУЗ /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн бүрэн эрх нь дуусгавар болсон өдрөөс хойш байгуулсан гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус байхаар зохицуулсан.

Энэ нь ХХК-тай эрх зүйн харилцаанд орох талын хувьд гэрээ, хэлцлийг хүчин төгөлдөр бус байх эрх зүйн эрсдэлээс өөрийгөө хамгаалах үүднээс ХХК-ийн дотоод харилцаанд хамаарах ХЭХ хурлын талаарх мэдээллийг олж авах шаардлагыг үүсгэж, арилжааны зардал(transaction cost)-ыг нэмэгдүүлж байна.

Улмаар компанитай эрх зүйн харилцаанд оролцогч талын арилжааны итгэлийг хамгаалах үүднээс КТХ-ийн 59.6 дахь хэсгийг эргэн харах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэхүү зохицуулалтын сөрөг үр дагавар нь ХХК төдийгүй ХК-ийн хүрээнд ч яригдана. Иймд гуравдагч этгээдийн арилжааны итгэлийг хамгаалах үүднээс КТХ-ийн 59.5, 59.6 дахь хэсгийг өөрчлөн найруулах нь зүйд нийцнэ.

Судлаачийн санал:

59 дүгээр зүйл.Хувьцаа эзэмшигчдийн хурал

59.4.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна.

59.5.Энэ хуулийн 59.4-т заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулаагүй тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно.

59.6.Төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн бүрэн эрх нь дуусгавар болсон өдрөөс хойш байгуулсан гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

Харин эрх зүйн шийдлийн хүрээнд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахаар шаардах эрх, зарлан хуралдуулахгүй байгаа тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах эрхийг хувьцаа эзэмшигчид олгох механизмыг хэрэглэж болох юм.

В.Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхэд хийсэн дотоод хязгаарлалт

Бодит байдал дээр компани бүрийн өөрийн хөрөнгийн хэмжээ харилцан адилгүй байх тул өөрийн онцлогд нийцүүлэн итгэмжлэлгүйгээр төлөөлөх бүрэн эрх бүхий этгээдийн бүрэн эрхийг хязгаарлах шаардлага үүсдэг байна.

Компани нь өөрийн дотоод харилцааг хуульд нийцүүлэн чөлөөтэй зохицуулах боломжтой тул компанийн дүрэм, дотоод журам, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрт тусгах замаар итгэмжлэлгүйгээр төлөөлөх бүрэн эрх бүхий этгээдийн бүрэн эрхэд тодорхой хязгаарлалтыг тавьж болно. Монгол Улсын бизнесийн практикт ч итгэмжлэлгүйгээр төлөөлөх бүрэн эрх бүхий этгээд болох гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхэд тодорхой хязгаарлалт хийх практик хэвшиж тогтсон.

Энэ нь КТХ-ийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэгт гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд байхаар зохицуулсантай холбоотой юм.

83 дугаар зүйл. Гүйцэтгэх удирдлага

83.8. Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

Энэхүү гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхэд тавьсан аливаа дотоод хязгаарлалт нь компанийн дотогш чиглэсэн харилцаанд хамаарах тул гуравдагч этгээдэд үйлчлэхгүй гэсэн суурь зарчмыг дагах учиртай. Энэ нь компанийн гадагш чиглэсэн улсын бүртгэлийн мэдээлэлд итгэж гэрээний харилцаанд орсон гуравдагч этгээдийн итгэлийг хамгаалах үзэл санаанд тулгуурладаг.

Гэвч гүйцэтгэх удирдлага компанийн дотоод харилцааны хүрээнд тогтоогдсон өөрийн бүрэн эрхийн хязгаарлалтыг хэтрүүлэх замаар гэрээ хэлцэл хийсэн тохиолдолд уг гэрээ хэлцэл нь ИХ-ийн суурь зарчмын дагуу төлөөлөх бүрэн эрхгүй этгээдийн хийсэн хэлцэлд хамаарах тул хэлцлийн үр дагавар нь компанид хамаарахгүй байх эрсдэл үүсэх болсон. Энэ тохиолдолд гуравдагч этгээдийн зүгээс компанийн гүйцэтгэх удирдлагын эрх зүйн байдалд итгэх боломжгүй болох тул

1) харилцагч талын судалгааны зардал нэмэгдэхээс³⁷ гадна 2) итгэмжлэлгүйгээр төлөөлөх бүрэн эрхийн тогтолцооны хүрээнд зайлшгүй байдлаар тавигдах арилжааны итгэл алдагдах эрсдэл үүснэ.

Улмаар компанийн гадагш чиглэсэн харилцааны хүрээнд арилжааны итгэлийг хамгаалах үүднээс компанийн зүгээс дотооддоо итгэмжлэлгүйгээр төлөөлөх бүрэн эрх бүхий этгээдийн бүрэн эрхэд хийсэн хязгаарлалт нь тухайн нөхцөл байдлыг мэдэх боломжгүй гуравдагч этгээдэд үйлчлэхгүй байхад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлага урган гарч байна.

Харин гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхэд хийсэн компанийн дотоод хязгаарлалтыг зөрчиж гэрээ, хэлцэл байгуулсан гүйцэтгэх удирдлагын хариуцлага нь компанийн дотоод асуудал болохыг анхаарах шаардлагатай.

Япон Улсын КТХ	Герман Улсын "GmbH"
Хувь нийлүүлсэн компанийн төлөөлөл 599.4. Хувь нийлүүлсэн компанийг төлөөлөх гишүүн нь хувь нийлүүлсэн компанийн хүрээнд шүүхийн болон шүүхийн бус үйл ажиллагааг явуулах бүрэн эрхтэй. 599.5. Өмнөх бүрэн эрхэд хийсэн хязгаарлалт нь энэ талаар мэдээгүй гуравдагч этгээдэд үйлчлэхгүй.	Компанийн төлөөлөл Representation of company 35.1. Компанийг шүүхийн болон шүүхийн бус харилцаанд түүний удирдлагууд төлөөлнө. ... Төлөөлөх бүрэн эрхийн хязгаарлалт 37.2. Удирдлагын компанийг төлөөлөх бүрэн эрхэд хийсэн хязгаарлалт нь гуравдагч этгээдэд эрх зүйн үр дагаврыг үүсгэхгүй. Энэ нь төлөөлөх бүрэн этгээдийн хувьд тодорхой бизнес эсхүл бизнесийн төрөл, тодорхой нөхцөлийн хүрээнд, тодорхой хугацаанд, тодорхой газар, хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрлөөр, тодорхой бизнесийн үйл ажиллагаанд компанийн органы үйлдлээр хязгаарлагдсан байгаа тохиолдолд үйлчилнэ.

37 Харилцагч талын зүгээс гэрээ хэлцэл байгуулах үе шатанд Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг тодорхойлох үүднээс Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын болон ТУЗ-ийн шийдвэр, компанийн дүрэм, дотоод журмыг шаардах нөхцөл байдал үүсч болно. Энэхүү нөхцөл байдал нь компанийн бүхий л харилцагчдын хүрээнд яригдах боломжтой юм.

Ийнхүү Япон, Герман Улсын ХХК-ийн зохицуулалт нь арилжааны итгэлийг хамгаалах үүднээс компанийн дотоод болон гадаад харилцааг ялгаж, дотоодод хийсэн хязгаарлалт нь гуравдагч этгээдэд үйлчлэхгүй гэсэн үзэл санааг баримталж байна.

Улмаар Япон, Герман Улсын ХХК-ийн эрх зүйн зохицуулалтын туршлагад тулгуурлан Компанийн тухй хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-д заасныг дараах байдлаар өөрчлөн найруулж болох юм. Мөн ХХК-тай эрх зүйн харилцаанд орж буй гуравдагч этгээдийн арилжааны итгэлийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг шинээр тусгаж болно.

Судлаачийн санал:

83 дугаар зүйл. Гүйцэтгэх удирдлага

83.8. Гүйцэтгэх удирдлага нь ~~төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд~~ хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

У. Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхэд хийсэн компанийн хязгаарлалт нь энэ талаар мэдээгүй гуравдагч этгээдэд үйлчлэхгүй.

У2. Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхэд хуулиар хязгаарлалт хийж болох бөгөөд энэ тохиолдолд энэ зүйлийн У. хэсгийг баримтлахгүй.

Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхэд хийсэн хуулийн хязгаарлалтын хүрээнд сонирхлын зөрчилтэй эсхүл их хэмжээний хэлцэл хийх тохиолдол ТУЗ эсхүл ХЭХ-аас зөвшөөрөл авахаар зохицуулсан тохиолдолд хамаарна. Энэ тохиолдолд компанитай эрх зүйн харилцаанд орж буй гуравдагч этгээдийн хувьд тухайн зохицуулалтын талаар мэдэж байх, судлах үүрэг (хуулийг мэдэхгүй байх нь хамгаалагдах үндэслэл болохгүй гэсэн зарчим үйлчилнэ.) хүлээнэ.

ДҮГНЭЛТ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан энэхүү үнэлгээг хийв.

ХХК-ийн эрх зүйн зохицуулалтад хийсэн үнэлгээний үр дүнг дараах байдлаар нэгтгэн дүгнэж байна.

Нэгдүгээрт, 2011 оны КТХ-ийн зохицуулалт нь нийтлэг байдлаар олон тооны хувьцаа эзэмшигчдээс бүрдэж, эзэмшил болон удирдлага нь салсан ХК-ийн харилцааг зохицуулахад чиглэсэн байх бөгөөд бодит байдал дээр ХХК-ийн харилцаанд нийцэхгүй байна. Энэ хүрээнд ХЭХ-ийн зохицуулалт, энгийн хувьцааг эргүүлэн худалдаж авахад хамаарах зохицуулалт, мэдээллийн ил тод байдлын зохицуулалтыг дурдаж болно.

Хоёрдугаарт, эзэмшил болон удирдлага нь салаагүй байх ХХК-ийн онцлогт тулгуурлан түүний харилцааг тусгайлан зохицуулахад чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг бэхжүүлэх шаардлага үүсч байгааг онцолж байна. Тухайлбал, том ХХК-ийн хяналтын механизм, хувьцааг хариу төлбөргүйгээр шилжүүлэх, хувьцаа эзэмшигч эрхийн чадвараа алдах, хувьцаа эзэмшигчийн хязгаарлагдмал хариуцлагыг нэвтлэх үндэслэл, удирдлагын үйл ажиллагааг таслан зогсоохоор шаардах, нэхэмжлэл гаргах хувьцаа эзэмшигчийн эрх зэргийг үүнд хамааруулан ойлгож болох юм.

Гуравдугаарт, ХХК төдийгүй ХК-ийн хүрээнд ч яригдах боломж бүхий нийтлэг зохицуулалтын хүрээнд компанитай харилцаанд орж буй этгээдийн арилжааны итгэлийг хамгаалах, гүйлгээний зардлыг багасгах асуудал чухлаар тавигдаж байна. Энэ асуудлыг мөн тус үнэлгээний тайланд хөндөж тусгалаа.

Дөрөвдүгээрт, харьцуулсан судалгаанаас үзэхэд ХХК-д зориулсан тусгай хуультай эсэхээс үл хамааран ХК болон ХХК-ийн харилцаа нь шинж чанарын хувьд томоохон ялгаатай болохыг харгалзан үзэж тус бүрийн онцлогт нийцсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгосон байна.

Цаашид Монгол Улсын хувьд ХК болон ХХК-ийн онцлогт тулгуурлах замаар тус бүрийн харилцаанд хамаарах эрх зүйн зохицуулалтыг ялгамжтай байдлаар системчлэн тогтоох асуудалд анхаарал хандуулах нь зүйтэй. Энэ хүрээнд ХХК-ийн эрх зүйн зохицуулалтыг сайжруулах үүднээс судлаачийн зүгээс өөрийн санал, зөвлөмжийг судалгааны тухайлсан хэсэгт бүрт тодорхой байдлаар тусгасан болно.

Эх сурвалж

1. Jeffry J. Haas, Corporate Finance, (West Academic Publishing, 3rd 2015).
2. Bernard F. Cataldo, Limited Liability with One Man Companies and Subsidiary Corporations, 18 Law & Contemp. Prob. 473 (1953).
3. Blumberg, P. I., Limited Liability and Corporate Groups, The Journal of Corporation Law 11 (Summer), 573 (1986).
4. Frank H. Easterbrook & Daniel R. Fischel, Limited Liability and the Corporation, 52 U. Chi. L. Rev. 89 (1985).
5. Janet C. Alexander, Unlimited Shareholder Liability through a Procedural Lens, 106 Harv. L. Rev. 387 (1992).
6. Lynn M. LoPucki, The Irrefutable Logic of Judgment Proofing: A Reply to Professor Schwarcz, 52 Stan. L. Rev. 55 (1999).
7. Stephen G. Gills, The Judgment-Proof Society, 63 Wash. & Lee L. Rev. 603 (2006).
8. Timothy P. Glynn, Beyond "Unlimited" Shareholder Liability Vicarious Tort Liability for Corporate Officers, 57 Vand. L. Rev. 329 (2004).
9. Г.Давааням, Морал хазардын асуудлаас үүдэх толгой компанийн хариуцлага, (Адмон., 2020).
10. Г.Давааням, Компани, арилжааны эрх зүйн тулгамдсан асуудлууд, (Соёмбо, 2020).
11. Г.Давааням, Хувьцаат компанийн эрх зүйн үндсэн ойлголт, (Соёмбо., 2021).
12. С.Батбаяр, Компанийн тухай хууль дахь хувьцаат компани болон хязгаарлагдмал хариуцлагатай компанийн эрх зүйн зохицуулалтыг ялгамжтайгаар зохицуулах хэрэгцээ, шаардлага, МХХ-ны Иргэний эрх зүйн хороо, Илтгэлийн эмхэтгэл (2020).
13. 伊藤靖史など、「会社法」(有斐閣 第2版 2012年) .
14. 向井貴子「株主有限責任のモラル・ハザード問題と非任意債権者の保護」九大法学91号267頁(2005年) .
15. 後藤元『株主有限責任制度の弊害と過小資本による株主の責任』(商事法務 2007年) .
16. 江頭憲治郎『株式会社法』(有斐閣 第七版 2017年) .
17. 高橋均『株主代表訴訟の理論と制度改正の課題』(同文館出版、2008) .
18. Сүхбаатар дүүрэг, 2013.02.27, Дугаар 513.
19. Чингэлтэй дүүрэг, 2015.09.17, Дугаар 6228.
20. Сүхбаатар дүүрэг, 2014.06.23, Дугаар 2489.
21. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг, 2015.10.16, Дугаар 6929.
22. Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг, 2015.11.04, Дугаар 7425.
23. Улсын дээд шүүх, 2016.12.09, Дугаар 001/ХТ2016/011373.

**ГУРАВ. ОЛОН УЛСЫН ШИНЖТЭЙ ИРГЭНИЙ ХЭРЭГ
МАРГААНЫ ШҮҮХИЙН ХАРЬЯАЛАЛ: ИХШХШТХ-ИЙН
189-193 ДУГААР ЗҮЙЛИЙГ ХЭРЭГЛЭЖ БУЙ ПРАКТИК,
БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ**

Судалгааг гүйцэтгэсэн:

Э.Байгал. МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор,
Хууль зүйн ухааны доктор (Ph.D)

УДИРТГАЛ

Монгол Улс чөлөөт зах зээлийн харилцаанд шилжиж, иргэд хуулийн этгээд олон улсын хувийн эрх зүйн харилцаанд чөлөөтэй оролцох болсон үеэс эхлэн гадаад элемент бүхий гэрээ хэлцэл, гэр бүл, өв залгамжлалын харилцаанд өргөнөөр оролцох болсон билээ. Үүнээс үүдэн сүүлийн жилүүдэд гадаадын иргэн, хуулийн этгээдтэй холбоотой иргэний хэрэг маргааныг шийдвэрлүүлэхээр хандах нь түгээмэл болж байна.

ОУХЭЗ-н хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд хамгийн түрүүнд шүүхээс тодруулах асуудал нь шүүхийн харьяалал юм. Тухайн хэрэг маргаан нь Монгол Улсын шүүх эрх мэдэлд хамаарах эсэх, шүүхийн харьяалалд хамаарах эсэхийг шийдвэрлэсний дараа сая тухайн талуудын маргааныг аль улсын хуулийн дагуу хэрхэн шийдвэрлэх асуудлыг хөндөх боломжтой болдог. Харин урьд өмнө хаалттай нийгэм, эдийн засагтай байсан, нийгмийн өөрчлөлтийн дүнд үүсч буй үр дагавар нь сүүлийн жилүүдэд хүчтэй илэрч буй бид энэ талаар харьцангуй бага туршлагатай. Иймээс, олон улсын шүүхийн харьяалал, Монгол Улс дахь эрх зүйн зохицуулалт, түүнийг хэрэглэж буй практикийг судлан цаашид боловсронгуй болгох нь нэн чухал асуудлын нэг болон хувирч байна.

Энэхүү судалгааны хүрээнд, Монгол Улс дахь олон улсын иргэний процессын эрх зүйн хөгжлийн тойм, олон улсын эрх зүйн эх сурвалж, шүүхийн харьяалал тодорхойлох онолын үндэслэл, ангиллыг авч үзсэн бөгөөд зарим шүүхийн шийдвэрт судалгаа хийсэн болно. Энэ хүрээнд хамгийн их тулгамдаж буй асуудлын нэг болох параллел процесс буюу зэрэгцээ процессын ажиллагаанаас урьдчилан сэргийлэх арга замыг судалж, эцэст нь Монгол Улсын эрх зүйн зохицуулалт, хууль хэрэглэх практикийг боловсронгуй болгох саналыг дэвшүүлсэн болно.

1. ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН СУУРЬ ЗАРЧИМ

Олон улсын иргэний процессын эрх зүй нь үндсэн хоёр асуудлыг зохицуулдаг:

- Дотоодын шүүх ямар тохиолдолд олон улсын хамаарал бүхий хэргийг харьяалан шийдвэрлэх,
- Гадаадын шүүхийн шийдвэр нь дотоодод хэрхэн үйлчлэх вэ?

Дээрхээс гадна, гадаадын оролцогч бүхий процессын ажиллагааг явуулах онцлог, бусад улсад нотлох баримтыг хүргэх буюу нотлох баримт цуглуулах, гадаадын эрх зүйг процесст хэрэглэхтэй холбогдон үүсэх асуудлыг судална.

Олон улсын хувийн эрх зүй хэмээх нэр томъёоны дараа олон улсын иргэний процесс хэмээх нэр томъёо хэрэглэгдэх болсон бөгөөд үндсэн гурван ойлголтыг илэрхийлдэг:

- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа
- Хөндлөнгийн шүүх буюу арбитра
- Шүүх, арбитраын шийдвэрийг биелүүлэх

Нэр томъёо. Олон улсын иргэний процесс хэмээх нэр томъёо нь үгийн утгаараа бүх улсуудын шүүхэд үйлчилдэг нэгдмэл эрх зүй, өөрөөр хэлбэл олон улсын иргэний шүүхийн эрх зүй гэж ойлгогдоно. Гэхдээ ийм нэгдмэл эрх зүй өнөөг хүртэл маш хязгаарлагдмал хүрээнд л бий болж чадсан ба тодруулбал, Европын холбооны хүрээнд л ач холбогдол нь өсөн нэмэгдэж байгаа юм.

Өргөн утгаараа, гадаад элемент бүхий иргэний процессын явцад үйлчлэх бүхий л эрх зүйн хэм хэмжээг ОУИП гэж нэрлэнэ. Тухайлбал, гадаад элемент бүхий иргэний хэргийн шүүхийн харьяалал, гадаадын иргэдийн процессын эрх, гадаад элемент бүхий хэргийг шүүхэд шийдвэрлэхэд тохиолддог онцлог зохицуулалт /гадаадын эрх зүйг хэрэглэх гэх мэт/, гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөх болон олон улсын эрх зүйн туслалцааны асуудлыг хамаарч байдаг.

“Шүүхэд гадаадын иргэд болон гадаадын хуулийн этгээдтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлэх, маргааныг шийдвэрлэх явцад тэдний процессын эрхийг тодорхойлох болон хамгаалах, тухайн хэргийн харьяалал болон гадаадын шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч, биелүүлэхтэй холбогдон үүсэх процессын шинжтэй хэм хэмжээний нийлбэр цогцыг олон улсын иргэний процессын эрх зүй гэнэ” хэмээн тодорхойлж болно.

Ач холбогдол. Олон улсын эдийн засгийн харилцаа улам өргөжиж байгаатай холбогдон ОУИП-ын ач холбогдол ч нэмэгдсээр байна. Өөрөөр хэлбэл, шүүхэд олон улсын шинж хамаарал бүхий хэрэг маргааныг шийдвэрлэж буй тоо огцом өсөж эхэлсэн билээ.

ОУХЭЗ-н дагуу хэрэглэвэл зохих эрх зүйг тодорхойлдогос үл хамааран ОУИП нь олон улсын шинжтэй иргэний хэргийн харьяалал, гадаадын шүүх, арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.

Олон улсын иргэний процессын эрх зүйд баримтлах зарчим. Аливаа улс шүүх эрх мэдлийг гагцхүү өөрийн улсын нутаг дэвсгэр дээр хэрэгжүүлэх эрхтэй байдаг. Гэхдээ энд гадаад улсын иргэн, хуулийн этгээдтэй холбоотой аливаа хэрэг маргааныг хянан шийдвэрлэх нь зайлшгүй юм. Энд дараахь зарчмыг баримтлах нь зүйтэй:¹

Тэгш эрхийн зарчим. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 14.1-т “хүн бүр шүүх болон шүүх таслах ажиллагааны өмнө эрх тэгш байна” хэмээн заасан,² Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 6, 7, 8 дугаар зүйлд “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчлалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү Тунхаглалд харшлах аливаа алагчлалаас болон тийнхүү алагчлахыг өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй. Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн тогтоолгох эрхтэй. Хүн бүр хаана ч байсан эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх эрхтэй” гэж заасан.

Харин Монгол Улсын Үндсэн хуулийн 14.1-т “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1-т “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа /цаашид “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэх/ нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, хуулийн этгээдийг өмчийн хэлбэр, эрх хэмжээгээр нь ялгаварлахгүй эрх тэгш байх зарчимд

1 Dr. Heimo Shack. Internationales Zivilverfahrensrecht. 7 Auflage, München 2017., ff11; УДШ, Ханс Зайделийн сан. Иргэний хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай. УБ 2021 он. 12-13 дахь тал.

2 Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ 2008 он, 28 дахь тал.

үндэслэн явагдана” хэмээн тус тус зааснаар энэ зарчмыг тусгасан. Гадаадын иргэн, хуулийн этгээд оролцсон хувийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд ч энэхүү зарчмыг баримтлах нь зүй юм.

“Lex fori” буюу шүүх ажиллагаанд үндэсний дэглэмийг баримтлах. Аливаа улс нь гадаадын иргэн, хуулийн этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох тохиолдолд өөрийн орны иргэн, хуулийн этгээдтэй ижил тэгш эрхийг олгодог. Харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь бүхэлдээ тухайн улсын үндэсний хууль тогтоомжийн дагуу явагдах, өөрөөр хэлбэл “lex fori” зарчмыг баримтална.

ИХШХШТХ-ын 189.1-т “Монгол Улсын шүүхээр гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнтэй холбогдолтой иргэний хэргийг хянан шийдвэрлэхэд тэдгээр нь хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн адил эрхтэй байна” гэж заасан. Олон улсын шинж хамаарал бүхий иргэний процессын ажиллагаанд хэрэглэгдэх эрх зүйн тухай асуудал нь хуульчдын хувьд тодорхой зүйл болоод удаж байгаа билээ. Тийм ч учраас “lex fori”-ийг процессын зарчим гэж үзэж болох бөгөөд процессын бүхий л ажиллагаа, нотлох баримт гаргаж өгөх эрх зэрэгт аливаа шүүх өөрийн орны эрх зүйг хэрэглэнэ.

1.1. Монгол Улс дахь ОУИП-ын эрх зүйн хөгжлийн тойм

1990 онд зах зээлийн эдийн засагт шилжиж, социалист үзэл баримтлал бүхий хууль тогтоомжийг шинэчлэн найруулж, заримыг шинээр боловсруулан батлан мөрдөж эхэлсэн. 1994 оны 5 сарын 9-ний өдөр баталсан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 235-240 дүгээр зүйлд Олон улсын иргэний хэрэг хянан шийдвэрлэхэд хамаарах зохицуулалтыг тусгасан байв. Олон улсын иргэний хэргийн шүүхийн харьяалал, хэрэглэх олон улсын гэрээ болон харьяаллын төрлүүдийг энд тусгаагүй бөгөөд, тун ерөнхий зохицуулалттай байсан. Харин 2002 оны ИХШХШТХ-д өмнөхөөс илүү дэлгэрэнгүй зохицуулалт тусгахыг эрмэлзсэн ба шүүхийн харьяаллын төрлүүдийг ангилж, зарим төрлийн хэрэг маргааныг нарийвчлан зааснаараа онцлог байна.

Үндэсний хууль тогтоомжоос гадна, Монгол Улс 1958 онд анх Унгар улстай Эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулснаас хойш өдгөө 16 улстай ийм төрлийн гэрээг байгуулсан. Эрх зүйн харилцан туслалцааны гэрээ нь гол төлөв процессын журам агуулсан байх бөгөөд шүүхийн харьяалал, шүүхийн даалгавар, шүүхийн баримт бичиг гардуулах журам, шүүхийн шийдвэр биелүүлэх журмыг тусгасан байдаг.

1.1.1. Үндэсний эрх зүйн эх сурвалж

ОУИП нь ОУХЭЗ-н нэгэн адил дотоодын эрх зүйн нэгэн бүрдэл хэсэг гэж тооцогддог. Тийм ч учраас ОУИП-ын эрх зүйн эх сурвалжид дотоодын процессын тухай хууль болон иргэний процессын эрх зүйд холбогдох бусад хууль тогтоомж хамаарна. Гол эх сурвалж нь ИХШХШТХ болно. Тус хуулийн 189-194 дүгээр зүйлд олон улсын шинжтэй иргэний хэрэг маргаан хянан шийдвэрлэхэд баримтлах журмыг заасан. Гэхдээ энд гол төлөв харьяаллыг тодорхойлоход холбогдох заалт зонхилно. ИХШХШТХ-ийн 16.2, 39, 160№-160/5, 168.1 дүгээр зүйлүүд тус тус ОУИПЭЗ-д хамаарах зохицуулалт юм.

1967, 1994, 2002 оны Иргэний процессын хуулиуд дахь олон улсын иргэний процесст хамаарах зохицуулалтыг дор харьцуулан үзлээ.

1967 оны Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний Байцаан Шийтгэх тухай хууль.³

Энэхүү хуулийн 6 дугаар хэсэгт Олон улсын иргэний эрхийн холбогдолтой байцаан шийтгэх ажиллагааны тухай зохицуулсан. Энэ бүлэгт шүүхийн харьяаллын тухай зохицуулалт дараах байдлаар туссан байна.

Шүүхэд эрх олгох хэлэлцээр. БНМАУ-ын шүүн таслах ажиллагааны эрх хэмжээнд хамаарагдахгүй эд хөрөнгийн маргааныг тус улсын шүүхийн эрх хэмжээнд хамааруулах тухай зохигчид хэлэлцэн тохирч болно.

БНМАУ-ын шүүхийн эрхт хамаарагдах эд хөрөнгийн маргааныг гадаад улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны эрхт хамааруулах асуудлыг гагцхүү уг хэрэгт БНМАУ-ын хуулийн этгээд оролцож байгаа бол зохигчид хэлэлцэн тохирч байна.⁴

Шүүхийн харьяаллын тухай хэлэлцээр

БНМАУ-ын хуулийн этгээдийн хийсэн гадаад худалдааны хэлцлээс үүссэн маргааны талаар уг хэргийн шүүхийн газар нутгийн ба шүүхийн харьяаллыг зохигчид хэлэлцээрээр өөрчилж болно.⁵

1994 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт.⁶ 1994 оны ИХШХШТХ-ийн 16 дугаар бүлэгт Олон улсын иргэний эрх зүйн холбогдолтой хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар зохицуулсан байна. Энэ бүлэгт иргэний хэргийн шүүхийн харьяаллын тухай зохицуулалт дараах байдлаар тусгагджээ.

Шүүхэд эрх олгох. Монгол Улсын шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааны эрх хэмжээнд хамаарагдахгүй эд хөрөнгийн маргааныг тус улсын шүүхийн эрх хэмжээнд хамааруулах тухай зохигчид хэлэлцэн тохирч болно.⁷

“Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хийсэн гадаад хэлцлээс үүссэн маргааны шүүхийн газар нутгийн ба шүүхийн харьяаллыг зохигчид харилцан тохиролцсоноор өөрчилж болно⁸ шүүхийн харьяаллын талаар заажээ.

3 Бүгд Найрамдах Монгол Улсын хуулиуд I, УБ 1980., 541 дэх тал.

4 БНМАУ-ын 1967 оны Иргэний байцаан шийтгэх тухай хуулийн 307 дугаар зүйл.

5 Мөн хуулийн 308 дугаар зүйл.

6 МУИС, Хууль Зүйн Сургууль, Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. УБ 2000., 176 дахь тал.

7 1994 оны ИХШХШТХ-ийн 237 дугаар зүйл.

8 Мөн хуулийн 238 дугаар зүйл.

1967 оны ИБШТХ	1994 оны ИХШХШТХ	2002 оны ИХШХШТХ	Харьцуулалт
БНМАУ-ын шүүн таслах ажиллагааны эрх хэмжээнд хамаарагдахгүй эд хөрөнгийн маргааныг тус улсын шүүхийн эрх хэмжээнд хамааруулах тухай зохигчид хэлэлцэн тохирч болно. БНМАУ-ын шүүхийн эрхт хамаарагдах эд хөрөнгийн маргааныг гадаад улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны эрхт хамааруулах асуудлыг гагцхүү уг хэрэгт БНМАУ-ын хуулийн этгээд оролцож байгаа бол зохигчид хэлэлцэн тохирч байна	Монгол Улсын шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааны эрх хэмжээнд хамаарагдахгүй эд хөрөнгийн маргааныг тус улсын шүүхийн эрх хэмжээнд хамааруулах тухай зохигчид хэлэлцэн тохирч болно	2002 оны ИХШХШТХ-д шүүхэд эрх олгох талаар зохицуулалт байхгүй байна.	1967 оны болон 1994 оны хуулиудад гадаад иргэд оролцсон олон улсын шинжтэй маргааны харьяалал нь хэдий МУ-д хамаарахгүй байсан ч талууд тохиролцон МУ-ын шүүхээр хэргээ хянан шийдвэрлүүлэх боломжтой байсан байна. Мөн 1967 он 1994 оны хуулийн энэхүү зохицуулалтын нэг ялгаатай тал 1967 онд зөвхөн хуулийн этгээд оролцсон маргааны хувьд ийнхүү шүүхэд эрх олгодог байсан бол 1994 оны хуульд Иргэн гэх нэр томъёог нэмж зохицуулсан байна.
БНМАУ-ын хуулийн этгээдийн хийсэн гадаад худалдааны хэлцлээс үүссэн маргааны талаар уг хэргийн шүүхийн газар нутгийн ба шүүхийн харьяаллыг зохигчид хэлэлцээрээр өөрчилж болно.	Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн хийсэн гадаад хэлцлээс үүссэн маргааны шүүхийн газар нутгийн ба шүүхийн харьяаллыг зохигчид харилцан тохиролцсоноор өөрчилж болно	Энэ талаарх зохицуулалт байхгүй.	Дээр дурдсанчлан 1967 оны болон 1994 оны хуулиудад шүүхэд эрх олгох замаар талууд шүүхийн харьяаллыг харилцан тохиролцож болохыг энэхүү заалтаар тодруулж өгсөн байна.

Эндээс үзвэл 2002 онд ИХШХШТХ-ийг баталж олон улсын иргэний эрх зүйн ач холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны харьяаллын зохицуулалтыг ердийн, тусгай, онцгой харьяалалд хамаарах хэргүүд хэмээн нарийвчлан МУ-ын шүүхийн харьяалан шийдвэрлэх хэргүүдийг өмнөх иргэний хэрэг хянан шийдвэрлэх хууль болоод иргэний байцаан шийтгэх хуулийг бодвол илүү тодорхой болгож өгсөн. Гэхдээ энд нэг зүйлийг орхигдуулсан явдал нь шүүхэд эрх олгох эрх зүйн зохицуулалтыг хасаж зохицуулсан байна.

Гадаадын орнуудын Иргэний процессын хууль болон энэ талаарх олон улсын гэрээнд шүүхэд эрх олгох буюу талууд харилцан тохиролцож тухайн улсын шүүхэд үл хамаарах хэргийг хянан шийдвэрлүүлэх боломжийн талаар зохицуулж өгсөн байдаг. Гэтэл манай улс олон улсын хувийн эрх зүйн ач холбогдолтой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны харьяаллын зохицуулалтыг илүү сайжруулах явцдаа энэхүү зохицуулалтыг чухам ямар учраас хасаж тодорхойлсон нь тодорхойгүй байна.

1.1.2.Олон улсын эрх зүйн эх сурвалж

Олон улсын иргэний процессын эрх зүйд хамаарах олон улсын гэрээ конвенц цөөнгүй. Эдгээрээс Монгол Улс дараах конвенцид нэгдэн орсон:

№	Нэр	Байгуулсан огноо	Нэгдэн орсон огноо
ОЛОН УЛСЫН ОЛОН ТАЛТ ГЭРЭЭ			
1	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай конвенц	1954.3.1	1999.7.21
2	Олон улсын маргааныг энх тайвнаар шийдвэрлэх тухай конвенц	1907	2018
3	Улс ба бусад улсын иргэдийн хооронд хөрөнгө оруулалтын талаар үүссэн маргааныг шийдвэрлэх тухай конвенц	1965.3.18	1996.5.28
4	Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх ба биелүүлэх тухай конвенц	1958.6.10	1994.5.26
5	НҮБ-ын төрөлжсөн байгууллагын эрх, дархын тухай конвенц	1947.11.21/1948.12.02	1970
6	Дипломат харилцааны тухай Венийн конвенц	1961.4.18/1964.04.24	1966.11.24
7	Түгээмэл шинжтэй олон улсын байгууллагад улс гүрнээ төлөөлөх тухай Венийн конвенц	1975.03.14	1988.06.20
8	Консулын харилцааны тухай Венийн конвенц	1963.04.24/1967.03.19	1988.06.20
9	Олон улсын иргэний агаарын тээврийн тухай Чикагогийн конвенц	1944.12.07/1947.04.04	1986
10	Олон улсын иргэний агаарын тээвэрт хамаарах зарим журмыг ижилтгэх тухай Варшавын конвенц	1929.10.12	1962
11	Олон улсын агаарын тээвэрт хамаарах зарим журмыг ижилтгэх тухай Монреалийн конвенц	1999.05.28	2004.10.05
12	Барааг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай ТИР КАРНЕЙ-н конвенц	1975.11.14	2001.11.15
13	Олон улсын хоорондын авто замаар ачаа тээвэрлэх тухай конвенц	1956.5.19	2003.05.08
14	Олон улсын төмөр замын ачааны харилцааны тухай хэлэлцээр	1951/2015	2002/2015
ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ХОЁР ТАЛТ ХЭЛЭЛЦЭЭР			
1	БНМАУ, БНУАУ-ын хооронд иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ		1968.11.22
2	БНМАУ, БНБАУ-ын хооронд иргэний ба гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ		1968.11.22
3	БНМАУ, БНСРУ-ын хооронд иргэний болон гэр бүл, эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ		1972.11.25
4	БНМАУ, БНЧУ-ын хооронд иргэн, гэр бүл ба эрүүгийн хэргийн талаар эрхийн туслалцаа үзүүлэх болон эрхийн харилцаа тогтоох тухай гэрээ		1976.10.15
5	БНМАУ, БНАСАУ-ын хооронд иргэн, гэр бүл болон улс хоорондын иргэн, гэр бүл болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ		1988.10.29
6	БНМАУ, БНХАУ-ын хооронд иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ		1997.08.19
7	Монгол Улсын Засгийн Газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн Газар хооронд иргэний хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх, иргэний хэргийн талаар шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенц		1992.02.27
8	Иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, БНКаЗУ-ын хоорондын гэрээ		1993.10.22

9	Монгол Улс, БНПУ-ын хооронд иргэн, гэр бүл, хөдөлмөр, эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх болон эрх зүйн харилцааны тухай гэрээ	1998.10.19
10	Монгол Улс, ОХУ-ын хооронд эрх зүйн туслалцаа үзүүлэх, иргэний ба эрүүгийн хэргийн талаархи эрх зүйн харилцааны тухай гэрээ	1999.04.20
11	Иргэний болон худалдааны хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, БНСУ-ын хоорондын гэрээ	2008.10.15
12	Монгол Улс, Украин Улсын хооронд иргэний болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ	1995.06.27
13	Монгол Улс, БНСВУ-ын хооронд иргэн, гэр бүлийн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ	2000.04.17
14	Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улсын хооронд иргэн, аж ахуйн болон эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ	2000.05.02
15	Монгол Улс, БНЭУ-ын хооронд иргэний ба аж ахуйн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ	2001.01.03

Хоёр талт эрх зүйн туслалцааны гэрээ нь гол төлөв процессын журам, зөрчилдөөний хэм хэмжээ агуулдгаараа онцлогтой. Гэхдээ гэрээ бүрт шүүхийн харьяаллыг тусгасан гэж үзвэл өрөөсгөл бөгөөд улс бүртэй байгуулсан гэрээний зохицуулалт харилцан адилгүй байдаг. Монгол Улс нь 1968 оноос хойш 20 гаруй улстай иргэний болон гэр бүл, эсхүл иргэн, гэр бүл, хөдөлмөрийн, иргэний ба худалдааны хэргээр, түүнчлэн эрүү, иргэний хэргээр, ялтан шилжүүлэх, гэмт этгээдийг шилжүүлэн өгөх зэрэг зорилго бүхий эрх зүйн туслалцааны гэрээг байгуулснаас 16 нь хувийн эрх зүйн харилцаанд хамаарах зохицуулалтыг агуулдаг. Эдгээрээс, хувийн эрх зүйн маргааны шүүхийн харьяаллын зохицуулалтыг дор хүснэгтээр ялгаж үзүүллээ.

Хоёр талт гэрээн дэх харьяаллын эрх зүйн зохицуулалт

№	Улс	Гэрээний зохицуулалт	Тайлбар
1	Болгар	19.3: Гэрлэгсдийн хувийн ба эд хөрөнгийн харилцаанаас үүдэлтэй маргааныг хэлэлцэн тохирогч 2 этгээдийн байгууллага уг асуудлыг шийдвэрлэх эрхтэй 20.1: Гэрлэлт цуцлах тухай хэргийг хэлэлцэн тохирогч 2 этгээдийн хуулийн байгууллага авч хэлэлцэнэ. 22.3: Эцэг тогтоох, эцэг эх хүүхдийн харилцаанд нутаг дэвсгэрт нь хүүхэд оршин суугаа хэлэлцэн тохирогч Этгээдийн хуулийн байгууллага хэргийг шийдвэрлэх эрхтэй. 23.2: хүүхдийн тэтгэмж авбал зохих хүн нутаг дэвсгэр дээр нь оршин суугаа Хэлэлцэн тохирогч этгээдийн хуулийн байгууллага шийдвэрлэх эрхтэй 24.3: хүүхэд үрчлэхэд үрчлэгч эхнэр нөхөр хоёр өөр өөр хэлэлцэн тохирогч этгээдийн харьяат байвал Хэлэлцэн тохирогч хоёр этгээдийн хууль тогтоомжийг баримтлах 24.4: хүүхэд үрчлэх үед үрчлэгчийн харьяалагдаж байгаа Хэлэлцэн тохирогч талын байгууллага шийдвэрлэх эрхтэй 29.1: үл хөдлөх хөрөнгийн хувьд нутаг дэвсгэр дээр нь уг үл хөдлөх эд хөрөнгө байгаа улсын хуулийн байгууллага асуудлыг авч хэлэлцэх эрхтэй 34.1: Өвлөх харилцаанд- хөдлөх хөрөнгий өвлөхөд өвлүүлэгч нас барах үедээ иргэн нь байсан улсын эрх бүхий байгууллага, 34.2: үл хөдлөх эд хөрөнгө өвлүүлэхэд нутаг дэвсгэр дээр нь үл хөдлөх эд хөрөнгө байгаа Хэлэлцэн тохирогч этгээдийн байгууллага	Гэрлэлт цуцлахад талууд өөр өөр улсад амьдарч байсан, эсхүл аль нэг талын нутаг дэвсгэрт амьдарч байсан бол хэлэлцээрийн тал болох улсын аль нь ч харьяалан шийдвэрлэж болохоор заасан

2	Румын	25.1: Гэрлэлтийг цуцлах тухай хэргийг Хэлэлцэн Тохирогч аль нэг этгээдийн хуулийн байгууллага шийдвэрлэх эрхтэй. Хэрэв гэрлэлт цуцлах тухай хэргийг үүсгэх үед гэрлэгсдийн нэг нь Хэлэлцэн тохирогч нэг Этгээдийн нутаг дэвсгэр дээр, нөгөө нь Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн нутаг дэвсгэр дээр оршин суугаа бол гэрлэгсдийн харьяалагдаж байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн хуулийг хэрэглэх бөгөөд гэрлэлтийг цуцлах тухай хэргийг Хэлэлцэн Тохирогч аль ч этгээдийн хуулийн байгууллага шийдвэрлэх эрхтэй.	
		30.1. Энэхүү Гэрээний 27,28,29-р зүйлд заасан эрхийн харилцааны хэргийг хүүхдийн харьяалагдах Хэлэлцэн Тохирогч этгээдийн хуулийн байгууллага шийдвэрлэх эрхтэй. Хэрэв нэхэмжлэгч ба хариуцагч нь Хэлэлцэн Тохирогч этгээдийн нутаг дэвсгэр дээр оршин суугаа бол хууль тогтоомжийн тухай энэхүү Гэрээний 28, 29-р зүйлд заасны дагуу Хэлэлцэн Тохирогч тэр этгээдийн шүүхийн байгууллага эрх бүхий байна.	Эцэг, эх хүүхдийн хоорондын харилцаа, эцэг эх тогтоох
		33. Энэхүү Гэрээнд өөр журам заагаагүй бол асран хамгаалах харгалзан дэмжих асуудлыг тогтоох болон хүчингүй болгохдоо асран хамгаалуулагч буюу харгалзан дэмжүүлэгчийг харьяалах Хэлэлцэн Тохирогч этгээдийн байгууллага шийдвэрлэнэ.	
		35.2: Энэ зүйлийн 1-д зааснаар асран хамгаалуулах, харгалзан дэмжүүлэх тухай хэргийг хүлээн авсан Хэлэлцэн Тохирогч этгээдийн байгууллага уг хэргийг өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ. Харин энэ байгууллага нь асран хамгаалуулагч, харгалзан дэмжүүлэгчийн хувийн эрхтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргаж болохгүй.	
		44 дүгээр зүйл. Өв залгамжлах хэргийг авч хэлэлцэх эрх хэмжээ Хэрэв энэхүү Гэрээгээр өөр журам тогтоогдоогүй бол хөдлөх эд хөрөнгийг өвлөх хэргийг өв залгамжлуулагчийн нас барах үедээ харьяат нь байсан Хэлэлцэн Тохирогч этгээдийн байгууллага авч хэлэлцэх эрхтэй. Үл хөдлөх эд хөрөнгийг өвлөх хэргийг уг эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн Тохирогч этгээдийн байгууллага авч хэлэлцэх эрхтэй. Өвлөх эрхтэй холбогдсон маргааныг шийдвэрлэхдээ энэ зүйлийн 1, 2-т заасныг баримтална. Хэлэлцэн Тохирогч нэг этгээдийн харьяат нас барсны дараа үлдсэн бүх хөдлөх эд хөрөнгө хэрэв Хэлэлцэн Тохирогч нөгөө этгээдийн нутаг дэвсгэрт байгаа бол бүх өв залгамжлагчдын зөвшөөрөл, ав залгамжлагч буюу хувь авагчийн хүсэлтээр Хэлэлцэн Тохирогч этгээдийн байгууллага уг өв залгамжлах хэргийг авч хэлэлцэнэ.	
3	Чех /Словак	18.1: Сураггүй алга болсон, нас барсан байдлыг тогтоох тухай хэргийг уг иргэний амьд байсан үеийн тухай сүүлчийн мэдээ авсан бөгөөд мөн тэр үедээ харьяалагдаж байсан Хэлэлцэн Тохирогч Талын эрх бүхий хуулийн байгууллага шийдвэрлэнэ.	

	1. Гэрлэгсдийн хувийн болон эд хөрөнгийн харилцааны хэргийг тэднийг харьяалж байгаа Хэлэлцэн Тохирогч Талын шүүх шийдвэрлэх эрхтэй. Хэрэв хэргийг авч хэлэлцэх үед гэрлэгсэд Хэлэлцэн Тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт оршин сууж байвал тэдний хүсэлтийг Хэлэлцэн Тохирогч энэхүү Талын шүүх шийдвэрлэх эрхтэй. 2. Хэлэлцэн Тохирогч нэг Талын шүүхэд асуудлыг шалгаж эхэлсэн бол Хэлэлцэн Тохирогч нөгөө Талын шүүхэд уг асуудлыг шалгаж шийдвэрлэхгүй. Энэ заалт 23, 27 дугаар зүйлд нэгэн адил хамаарна. 3. Хэрэв гэрлэгсдийн нэг нь Хэлэлцэн Тохирогч нэг Талын харьяат, нөгөө нь Хэлэлцэн Тохирогч нөгөө Талын харьяат бол тэдний хувийн болон эд хөрөнгийн эрхийн харилцааны холбогдолтой хэргийг уг иргэдийн сүүлийн үед хамт оршин сууж байсан буюу сууж байгаа газрын Хэлэлцэн Тохирогч Талын шүүх шийдвэрлэх эрхтэй ба хэрэв хамт оршин сууж байсан буюу сууж байгаа тийм газаргүй бол хариуцагчийг харьяалах Хэлэлцэн Тохирогч Талын шүүхээр шийдвэрлэнэ.	21 дүгээр зүйл
	25: Тэтгэвэр төлөх үүрэгтэй этгээдийн оршин суугаа нутаг дэвсгэрийн Хэлэлцэн Тохирогч Талын шүүх тэтгэвэр төлөх тухай хэргийг шийдвэрлэх эрхтэй.	
	26: Хүүхдийн эцгийг тодорхойлох тухай /эцэг мөн эсэхийг тогтоох/ хэргийг хүүхдийг харьяалж байгаа Хэлэлцэн Тохирогч Талын шүүх шийдвэрлэх эрхтэй. Хэрэв нэхэмжлэгч, хариуцагч хоёулаа Хэлэлцэн Тохирогч нэг Талын нутаг дэвсгэрт байгаа бол энэ хэлэлцэн Тохирогч талын шүүх шийдвэрлэх эрхтэй.	
	27.2: Энэ зүйлийн 1-д заасан эрхийн харилцааг хүүхдийг харьяалах Хэлэлцэн Тохирогч Талын шүүх, эсхүл хүүхдийн байнга буюу түр оршин суугаа Хэлэлцэн Тохирогч Талын шүүхийн аль аль нь шийдвэрлэх эрхтэй.	
	28: Энэ гэрээгээр өөр журам тодорхойлоогүй бол насанд хүрээгүй хүүхдийн тэтгэмж, хүмүүжлийн болон үүнтэй холбогдох асуудлыг уг хүүхдийг харьяалах Хэлэлцэн Тохирогч Талын шүүх шийдвэрлэх эрхтэй. Хэрэв Хэлэлцэн Тохирогч нэг Талын харьяат иргэний эсрэг тэтгэвэр төлөхтэй холбогдсон нэхэмжлэл гарсан бол энэ Хэлэлцэн Тохирогч Талын эрх бүхий байгууллага нь нөгөө Хэлэлцэн Тохирогч Талын харьяат насанд хүрээгүй хүүхдийн хангамжийн тухай асуудлыг авч хэлэлцэнэ. Хүүхдийн хувийн болон эд хөрөнгийн эрхийг хамгаалахын тулд хойшлуулж болшгүй тохиолдолд зайлшгүй шаардлагатай түр арга хэмжээг уг хүүхэд нутаг дэвсгэр дээр нь оршин суугаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талын шүүх авч болно. Хэрэв энэ зүйлийн 2-т заасны дагуу мэдэгдэл хүлээн авсан шүүх 3 сарын дотор ямар нэгэн байцаан шийтгэх ажиллагаа хийгээгүй байвал тийм байцаан шийтгэх ажиллагааг хүүхэд нутаг дэвсгэр дээр нь оршин суугаа Хэлэлцэн Тохирогч Талын шүүх гүйцэтгэнэ. Шүүх өөрийн шийдвэрээ хүүхдийг харьяалж байгаа Хэлэлцэн Тохирогч Талын эрх бүхий шүүхэд мэдэгдэнэ.	

		30: Үрчлэн авах буюу түүнийг хүчингүй болгох явдлыг хүүхэд үрчлэх, түүнийг хүчингүй болгох үед үрчлэн авагчийг харьяалж байгаа Хэлэлцэн Тохирогч Талын байгууллага шийдвэрлэх эрхтэй байна. Энэ гэрээний 29 дүгээр зүйлийн 3-т заасан тохиолдолд гэрлэгсдийн сүүлийн удаа хамт оршин сууж байсан буюу сууж байгаа газрын эрх бүхий байгууллага шийдвэрлэх эрхтэй.	
		32.1: Энэ гэрээнд өөр журам тогтоогоогүй бол асран хамгаалах, харгалзан дэмжих асуудлыг тогтоох болон хүчингүй болгохдоо асруулагчийг харьяалах Хэлэлцэн Тохирогч Талын байгууллага шийдвэрлэнэ.	
		37: Энэ гэрээний 36 дугаар зүйлд заасан эрхийн харилцаанаас үндэслэн үүссэн нэхэмжлэлийн талаарх хэргийг хариуцагчийн оршин суугаа нутаг дэвсгэрийн Хэлэлцэн Тохирогч Талын шүүх авч хэлэлцэх эрхтэй. Нэхэмжлэгчийн нутаг дэвсгэр дээр хариуцагчийн эд хөрөнгө буюу маргаж байгаа зүйл байгаа бол нэхэмжлэгчийн оршин суугаа Хэлэлцэн Тохирогч Талын шүүх түүнийг авч хэлэлцэх эрхтэй. Энэ гэрээний 34 дугаар зүйлийн 1-д заасан үүргийн эрхийн харилцаанд оролцогчид хэлэлцэн тохиролцох замаар хэргийн талаарх шүүхийн харьяаллыг өөрчилж болно. Гэхдээ шүүхийн эрх хэмжээгээр шийдэх хэргийг өөр байгууллагаар шийдвэрлүүлэхээр хэлэлцэн тохирч болохгүй.	
		42: Хэрэв энэ гэрээгээр өөр журам тогтоогоогүй бол хөдлөх эд хөрөнгийг өвлөх хэргийг өв залгамжлуулагчийн нас барах үедээ харьяат байсан Хэлэлцэн Тохирогч Талын байгууллага авч хэлэлцэх эрхтэй. Үл хөдлөх эд хөрөнгийг өвлөх хэргийг уг эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн Тохирогч Талын байгууллага авч хэлэлцэх эрхтэй. Өвлөх эрхтэй холбогдсон маргааныг шийдвэрлэхдээ энэ зүйлийн 1, 2-т дурьдсан заалтыг хэрэглэнэ. Хэлэлцэн Тохирогч нэг Талын харьяат иргэний нас барсны дараа үлдсэн үл хөдлөх эд хөрөнгө Хэлэлцэн Тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр байгаа бол өв залгамжлагч буюу өв залгамжлахаас татгалзагчдын хүсэлтээр, хэрэв бүх өв залгамжлагчид зөвшөөрвөл энэ Хэлэлцэн Тохирогч Талын байгууллага уг өв залгамжлах хэргийг авч хэлэлцэнэ.	Өв залгамжлах хэргийг авч хэлэлцэх эрх хэмжээ
		Дөчинзургадугаар зүйл. Гэрээслэлийг нээх Гэрээслэл байгаа нутаг дэвсгэрийн Хэлэлцэн Тохирогч Талын өв залгамжлах хэргийг эрхлэх байгууллага гэрээслэлийг нээн зарлах эрхтэй.	
4	БНАСАУ	Иргэнийг сураггүй алга болсон буюу нас барсанд тооцох, түүнчлэн нас барсан үйл баримтыг тогтоох хэргийг сүүлчийн мэдээ баримтаар уг иргэн амьд ахуй цагтаа харьяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын байгууллагууд өөрийн улсын хууль тогтоомжийг баримтлан шийдвэрлэх эрхтэй байна.	16 дугаар зүйл. Сураггүй алга болсон буюу нас барсанд тооцох, нас барсан үйл баримтыг тогтоох

		Гэрлэх ба түүнийг цуцлах нөхцөл, түүнчлэн гэр бүлийн харилцаанаас үүссэн хувийн болон эд хөрөнгийн харилцааг гэрлэгсэд харьяат нь байгаа хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллага өөрийн орны хууль тогтоомжийг баримтлан шийдвэрлэнэ. Хэрэв гэрлэгсэд өөр өөр харьяалалтай байвал гэрлэлт буюу түүнийг цуцлах, хүчингүйд тооцохтой холбогдсон асуудлыг уг хэргийг хянаж байгаа Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага өөрийн орны хууль тогтоомжийг баримтлан шийдвэрлэнэ.	17 дугаар зүйл. Гэрлэлт ба түүнийг цуцлах
		Эцэг тогтоох болон энэ талаар гарсан маргаан, мөн эцэг эх, хүүхдийн хоорондын эрх зүйн харилцааг хүүхэд харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага өөрийн орны хууль тогтоомжийг баримтлан шийдвэрлэнэ.	18 дугаар зүйл. Эцэг эх, хүүхдийн эрх зүйн харилцаа
		Гэрээнд өөрөөр заагаагүй бол асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоох тухай асуудлыг асран хамгаалуулах, харгалзан дэмжүүлэх шаардлагатай хүн харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.	20 дугаар зүйл. Асран хамгаалах, харгалзан дэмжих
5	ОХУ	Иргэнийг иргэний хязгаарлагдмал эрх зүйн эрхийн чадамжтай буюу чадамжгүйд тооцоход хэрэв энэхүү Гэрээнд өөрөөр заагаагүй бол иргэний хязгаарлагдмал эрх зүйн эрхийн чадамжтай болон чадамжгүйд тооцогдох ёстой этгээд харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын шүүх эрх бүхий байна. Шүүх нь өөрийн улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ.	20 дугаар зүйл. Иргэний хязгаарлагдмал эрх зүйн эрхийн чадамжтай буюу чадамжгүйд тооцох
		Иргэнийг сураггүй алга болсон буюу нас барсанд тооцох, түүнчлэн нас барсан үйл баримтыг тогтооход сүүлчийн мэдээгээр уг иргэн амьд ахуй цагтаа харьяат нь байсан Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий шүүх өөрийн улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.	21 дүгээр зүйл. Иргэнийг сураггүй алга болсон буюу нас барсанд тооцох
		Үл хөдлөх эд хөрөнгөд хамаарах эрх зүйн харилцаанд уг эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага эрх бүхий байх бөгөөд тухайн улсын хууль тогтоомжийг хэрэглэнэ.	23 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгө
		Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан асуудлаар хариуцагч нутаг дэвсгэрт нь оршин суугаа буюу оршин байгаа Хэлэлцэн тохирогч Талын шүүх эрх бүхий байна. Түүнчлэн нэхэмжлэгч нутаг дэвсгэрт нь оршин суугаа буюу оршин байгаа Хэлэлцэн тохирогч Талын шүүх нь маргааны объект буюу эсхүл хариуцагчийн эд хөрөнгө уг нутаг дэвсгэрт байгаа бол эрх бүхий байна. Өөртөө үүрэг хүлээсэн зохигчид энэ эрх мэдлийг хэлэлцээ хийх замаар өөрчилж болно.	24 дүгээр зүйл. Гэрээний дагуу хүлээх үүрэг Гэрээний дагуу хүлээх үүрэг нь зохигчдын сонгож авах улсын хууль тогтоомжоор тодорхойлогдоно. Хэрэв зохигчид нь хэрэглэхэд тохиромжтой хууль тогтоомжоо сонгоогүй бол тухайн гэрээний агуулгын хувьд шийдвэрлэх ач холбогдолтой биелэлтийг хэрэгжүүлж буй тал нутаг дэвсгэрт нь оршин суугаа, эсхүл үүсгэн байгуулагдсан болон эсхүл оршин байгаа Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжийг хэрэглэнэ.

		Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан асуудлаар гэм хорыг арилгуулах тухай шаардлагын үндэслэл болж буй нөхцөл байдал нутаг дэвсгэрт нь гарсан буюу, эсхүл хариуцагч нутаг дэвсгэрт нь оршин суугаа буюу оршин байгаа Хэлэлцэн тохирогч Талын шүүх эрх бүхий байна. Нэхэмжлэгч нутаг дэвсгэрт нь оршин суугаа буюу оршин байгаа Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт хариуцагчийн эд хөрөнгө байгаа бол Хэлэлцэн тохирогч энэ Талын шүүх эрх бүхий байна.	25 дугаар зүйл. Гэм хор учруулснаас үүсэх үүрэг Гэм хор учруулснаас үүсэх үүрэг нь гэм хорыг арилгуулах тухай шаардлагын үндэслэл болж буй нөхцөл байдал нутаг дэвсгэрт нь гарсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлогдоно. Хэрэв нэхэмжлэгч болон хариуцагч Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн бол Хэлэлцэн тохирогч энэ Талын хууль тогтоомжийг хэрэглэнэ.
		Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан асуудлаар нутаг дэвсгэрт нь ажил гүйцэтгэж буй, гүйцэтгэсэн буюу гүйцэтгэх ёстой байсан Хэлэлцэн тохирогч Талын шүүх эрх бүхий байна. Түүнчлэн хариуцагч нутаг дэвсгэрт нь оршин суугаа буюу оршин байгаа, эсхүл нутаг дэвсгэрт нь нэхэмжлэгч оршин суугаа буюу оршин байгаа бөгөөд хэрэв уг нутаг дэвсгэрт маргааны эд зүйл болон хариуцагчийн эд хөрөнгө байгаа бол Хэлэлцэн тохирогч Талын шүүх эрх бүхий байна. Энэхүү эрх мэдлийг хөдөлмөрийн гэрээнд оролцогч талууд хэлэлцээ хийх замаар өөрчилж болно.	26 дугаар зүйл. Хөдөлмөрийн харилцааг зохицуулах хууль тогтоомж Хөдөлмөрийн гэрээнд оролцогч талууд тэдний хөдөлмөрийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийг өөрсдөө сонгон авч болно.
			Хэрэв хууль тогтоомжийг сонгоогүй бол хөдөлмөрийн гэрээ үүсэх, өөрчлөгдөх, дуусгавар болохыг болон түүнээс үүсэн гарч буй гомдлын шаардлагыг нутаг дэвсгэрт нь ажил гүйцэтгэж байгаа, гүйцэтгэсэн буюу гүйцэтгэх ёстой байсан Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор зохицуулна. Хэрэв Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэр дээр байгаа ажилтан Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа үйлдвэртэй байгуулсан хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажил гүйцэтгэж буй бол хөдөлмөрийн гэрээ байгуулах, өөрчлөгдөх, дуусгавар болохыг болон түүнээс үүсэн гарах гомдлын шаардлагыг Хэлэлцэн тохирогч энэ Талын хууль тогтоомжоор зохицуулна.

6	Вьетнам	Зохигчид болон эрх зүйн маргаан нь адил хэргийн байцаан шийтгэх ажиллагааг Хэлэлцэн тохирогч хоёр Талын эрх бүхий шүүхүүд үүсгэсэн тохиолдолд энэ гэрээнд өөрөөр заагаагүй бол Хэлэлцэн тохирогч зохих Талын хууль тогтоомжийн дагуу сүүлд хэрэг үүсгэсэн шүүх нь байцаан шийтгэх ажиллагааг зогсоож, энэ тухай нөгөө хэлэлцэн тохирогч талд мэдэгдэнэ.	21 дүгээр зүйл
		Иргэнийг сураггүй алга болсон буюу нас барсанд тооцох, түүнчлэн нас барсан үйл баримтыг тогтоох тухай хэргийг сүүлчийн мэдээ баримтаар уг иргэн амьд ахуй цагтаа харьяат байсан Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага шийдвэрлэнэ.	23 дугаар зүйл. Сураггүй алга болсон, нас барсанд тооцох буюу нас барсан үйл баримтыг тогтоох
		Гэрлэгсдийн хувийн болон эд хөрөнгийн эрхийн харилцааны асуудлыг энэ зүйлийн 1,2,3-т заасны дагуу хууль тогтоомжийг нь баримтлах Хэлэлцэн тохирогч Талын байгууллага шийдвэрлэх эрх бүхий байна. Харин 4-т заасан тохиолдолд Хэлэлцэн тохирогч хоёр Талын шүүх эрх бүхий байна.	25 дугаар зүйл. Гэрлэгсдийн хувийн болон эд хөрөнгийн эрхийн харилцаа
		Энэ зүйлийн 2-т заасан тохиолдолд гэрлэгсэд хоёулаа нутаг дэвсгэрт нь оршин суугаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага эрх бүхий байна. Хэрэв гэрлэгсдийн нэг нь хэлэлцэн тохирогч нэг талын нутаг дэвсгэрт, нөгөө нь хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт оршин суудаг бол Хэлэлцэн тохирогч хоёр Талын байгууллага эрх бүхий байна.	26 дугаар зүйл. Гэрлэлтийг цуцлах
		Гэрлэснийг хүчингүйд тооцох тухай хэргийн талаар эрх бүхий байгууллагыг энэ гэрээний 26 дугаар зүйлийн 3,4-т зааснаар тодорхойлно.	27 дугаар зүйл. Гэрлэснийг хүчингүйд тооцох
		Хүүхэд үрчлэхтэй холбогдсон асуудлыг үрчлэн авагч иргэн харьяат нь байгаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага шийдвэрлэх эрх бүхий байна. Энэ зүйлийн 3-т заасан тохиолдолд эхнэр, нөхөр нутаг дэвсгэрт нь хамт оршин суугаа буюу оршин байгаа Хэлэлцэн тохирогч Талын байгууллага эрх бүхий байна. Энэ зүйлийн 1,2,3,4 дэх заалт үрчлэлтийг хүчингүй болгоход нэгэн адил хамаарна.	29 дүгээр зүйл. Хүүхэд үрчлэх
		Хөдлөх эд хөрөнгийг өв залгамжлах тухай хэргийг өвлүүлэгч сүүлийн удаа нутаг дэвсгэрт нь байнга оршин сууж байсан Хэлэлцэн тохирогч Талын хуулийн байгууллага шийдвэрлэх эрх бүхий байна. Үл хөдлөх эд хөрөнгийг өв залгамжлах тухай хэргийг уг эд хөрөнгө нутаг дэвсгэрт нь байгаа хэлэлцэн тохирогч талын хуулийн байгууллага шийдвэрлэх эрх бүхий байна. Өв залгамжлах хэргээс үүссэн маргааныг шийдвэрлэхэд энэ зүйлийн 1,2-т заасныг баримтална.	37 дугаар зүйл. Өв залгамжлалын хэргийг шийдвэрлэх эрх бүхий байгууллага

	Энэ зүйлийн 1,2-т заасан асуудлаар шийдвэр гаргахад хууль тогтоомжийг нь баримтлах Хэлэлцэн тохирогч Талын хуулийн байгууллага эрх бүхий байна.	41 дүгээр зүйл. Гэм хор арилгах Гэм хор учруулснаас үүссэн үүргийн талаар хүлээх хариуцлагыг гэм хорыг арилгах тухай шаардлага тавих үндэслэл болсон үйл явдал буюу өөр нөхцөл байдал нутаг дэвсгэрт нь бий болсон Хэлэлцэн тохирогч Талын хууль тогтоомжоор тодорхойлно. Гэм хор учруулсан этгээд болон хохирогч нь Хэлэлцэн тохирогч нэг Талын иргэн бол учирсан гэм хорыг арилгахдаа Хэлэлцэн тохирогч энэ Талын хууль тогтоомжийг баримтална.
--	---	---

1.2.Бусад эх сурвалж

Шүүхийн харьяаллыг тодорхойлохтой холбоотой дараах олон улсын конвенцууд байдаг. Үүнд:

- Шүүх сонгох хэлэлцээрийн тухай Гаагийн конвенц 2005 он;
- Иргэний ба худалдааны хэргийн тухай шүүхийн харьяалал болон шүүхийн шийдвэр хүлээн зөвшөөрч биелүүлэх тухай 1968 оны Брюсселийн конвенц;
- Иргэний ба худалдааны хэргийн тухай шүүхийн харьяалал болон шүүхийн шийдвэр хүлээн зөвшөөрч биелүүлэх тухай Луганогийн конвенц;
- УНИДРУА-ийн зарчмууд багтана.

Эдгээр конвенцийн зохицуулалтыг дор тус бүр товч авч үзье.

Шүүх сонгох хэлэлцээрийн тухай Гаагийн конвенц (шүүхийн харьяалал сонгох тухай)

Энэхүү конвенц нь 2005 оны 6 дугаар сарын 30-ны өдөр байгуулагдсан ба 2015 оны 10 дугаар сарын 1-ний өдөр Европын холбооны улс /Дани улс гишүүн бус/ орнууд болон Мексик нэгдэн орсноор хүчин төгөлдөр болсон. Мөн энэхүү конвенцид БНХАУ болон АНУ гарын үсэг зурсан хэдий ч хараахан хүчин төгөлдөр болоогүй байна⁹. Тус конвенц нь олон улсын шинжтэй иргэний ба худалдааны хэргийн маргаанд шүүхийг сонгоход хэрэглэгдэнэ. Харин дараах хэрэгт энэхүү конвенц үйлчлэхгүй. Үүнд:

- Иргэний эрх зүйн чадвар, чадамжтай холбоотой;
- Тэжээн тэтгэх үүрэгтэй холбоотой;
- Гэр бүлтэй холбоотой маргаан, гэрлэгсдийн эд хөрөнгийн эрх болон гэрлэх болон адил харилцаанаас үүсэх эрх үүрэгтэй холбоотой;
- Гэрээслэл, өв залгамжлал;

9 https://www.lexisnexis.com/uk/lexispsl/disputeresolution/document/393747/5618-BYD1-F18B-7365-00000-00/Conventions_and_the_common_law_overview#.

- Компанийн төлбөрийн чадваргүй байдал, нөхөн олговор, татан буугдахтай холбоотой маргаан;
- Бараа болон зорчигч тээвэрлэхтэй холбоотой;
- Далайн бохирдол, далайн нэхэмжлэлтэй холбоотой хариуцлагын хязгаарлалт, хөлөг онгоцыг хамгаалах үйлдлээс болж учирсан хохирол болон яаралтай аврах ажиллагаатай холбоотой;
- Өрсөлдөөнтэй холбоотой;
- Цөмийн ослын хариуцлагатай холбоотой;
- Гэрээнээс үүдээгүй материаллаг өмчийн хохирлыг нэхэмжлэх;
- Үл хөдлөх хөрөнгө өмчлөх, эзэмшихтэй холбоотой;
- Хуулийн этгээдийн хүчин төгөлдөр эсэх эсхүл тэдний гаргасан шийдвэр хүчин төгөлдөр эсэхтэй холбоотой;
- Оюуны өмчийн хөрөнгө болох зохиогчийн эрхтэй холбоотой;
- Эрх бүхий байгууллагын бүртгэл хүчин төгөлдөр эсэхтэй холбоотой;
- Арбитрын ажиллагаатай холбоотой маргаанд энэхүү конвенц хамаарахгүй¹⁰ гэж тодорхойлсон байна.

Иргэний ба худалдааны хэргийн шүүхийн харьяаллыг тодорхойлох болон шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх тухай Брюсселийн конвенц /мөн Журам/

Брюсселийн конвенц буюу Иргэний ба Худалдааны хэргийн шүүхийн харьяаллыг тодорхойлох болон шүүхийн шийдвэр биелүүлэх тухай 1968 оны конвенцид Иргэний хэргийн олон улсын шүүхийн харьяаллын талаар маш тодорхой заан өгсөн байдаг. Энэхүү конвенцыг Европын холбооны улс орнууд хэргийн харьяаллыг тогтоох мөн шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд хэрэглэдэг байна.

Монгол Улс энэхүү конвенцид нэгдэн ороогүй буюу тус конвенцын гишүүн улс биш юм. Иймээс энэхүү конвенцийг олон улсын шинжтэй иргэний хэргийн шүүхийн харьяаллыг тогтооход хэрэглэх боломжгүй юм.

Энэхүү конвенцын агуулга нь конвенцийн гишүүн орнууд шүүх, шүүхийн шийдвэрийг харилцан хүлээн зөвшөөрөх, шүүхийн олон улсын харьяаллыг тодорхойлох, хүлээн зөвшөөрөх явдлыг хөнгөвчлөх, шүүн таслах ажиллагаа, түүний баримт бичиг, шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагааг түргэн шуурхай явуулах журмыг бий болгох юм¹¹.

Тус конвенцийг батлагдсанаас хойш 2001 он, 2012 онд шинэчлэн найруулж баталсан. Ийнхүү шинэчлэн батлахдаа конвенц гэсэн нэрийг нь Журам /Regulation/ болгон өөрчилсөн байна¹². 2012 оны Брюсселийн I Журам нь Европын холбооны бүх гишүүн улсуудад үйлчилдэг. Харин Европын Чөлөөт Худалдааны Нийгэмлэгийн гишүүн улсууд Брюсселийн конвенцид нэгдэх боломжгүй тул анхны 1968 оны Брюсселийн конвенц

10 Шүүх сонгох хэлэлцээрийн тухай Гаагийн конвенцын 2 дугаар зүйл <https://www.hcch.net/en/instruments/conventions/full-text/?cid=98>.

11 <https://eur-lex.europa.eu/LexUriServ/LexUriServ.do?uri=OJ:L:2001:012:0001:0023:en:PDF>.

12 https://www.lexisnexis.com/uk/lexispsl/disputeresolution/document/393747/5618-BYD1-F18B-7365-00000-00/Conventions_and_the_common_law_overview#.

батлагдсаны дараагаар Европын Зөвлөлийн 12 гишүүн улс ба Чөлөөт Худалдааны Нийгэмлэгийн гишүүн 6 улсуудад Луганогийн конвенц үйлчилдэг байна¹³.

“Брюссель-1” Журам нь олон улсын шүүхүүдийн дүрэм журмуудын нарийвчилсан ижилтгэлийг агуулдаг байна. Түүнийг тодорхойлох үндсэн зарчим нь талуудын домицили буюу гол шалгуур нь хариуцагчийн оршин суугаа газар юм. Конвенц нь оршин суугаа газар гэдэг ойлголт, шүүгдэхийг салгаж зааглах үндэслэлүүдийг тодорхойлж, тусгай болон гэрээний журмаар шүүхийг хүлээн зөвшөөрөх тухай дүрэм журмыг баталж өгчээ¹⁴.

2001 оны Брюсселийн I Журмын 1 дүгээр зүйлийн 1-д зааснаар “Журмыг ямар ч шүүх байлаа нь иргэний ба худалдааны хэрэгт хэрэглэгдэнэ. Татвар, гааль, болон захиргааны маргаанд хамаарахгүй. Мөн 1 дүгээр зүйлийн 2-т тус журмаар зохицуулахгүй зүйлд:

- эрх зүйн чадамж, гэрлэгсдийн харилцаанаас үүдэх эд хөрөнгийн эрх, өв залгамжлал болон гэрээслэл;
- дампуурал, компани, хуулийн этгээдийг төлбөрийн чадваргүй гэж үзэх шүүхийн шийдвэр, нөхөн олговор төлүүлэх болон үүнтэй ижил ажиллагаа;
- нийгэм хамгаалал
- арбитр зэрэг орно¹⁵ гэж заажээ.

Тус Журамд хэргийн харьяаллын тухай дээр дурдсан 3 төрөл болон хэргийн харьяалал сонгох /prorogation/ тухай зохицуулалтууд оржээ. Ердийн харьяалал гэдэгт хариуцагчийн байнга оршин суудаг газрын шүүх хэргийг харьяалах талаар заасан.¹⁶

Харин тусгай харьяалалд дараах хэрэг хамаарахаар заасан байна. Үүнд:

- гэрээтэй холбоотой;
- гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой маргаан;
- Тэжээн тэтгэхтэй холбоотой маргаан;
- Гэм хор, зөрчилтэй холбоотой маргаан;
- Хохирол болон гэм хорыг арилгуулах тухай нэхэмжлэлийг Эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагааны дүнд гаргах тухай;
- Салбар, агентлаг болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой маргаан;
- Итгэмжлэгдсэн төлөөлөгч эсхүл эд хөрөнгийн итгэмжлэгдсэн этгээдтэй холбоотой маргаан;
- Ачаа болон карго хамгаалсны шан, шагнал, төлбөртэй холбоотой маргаантай холбоотой нэхэмжлэлийг гишүүн улсын байнгын оршин суугч нөгөө гишүүн улсын эсрэг гаргаж буй тохиолдлуудад аль шүүх хэргийг харьяалах тухай тодорхойлсон.

13 Б.Тамир, Олон улсын хуулийн эрх зүй. УБ 2019 он., 90 дэх тал.

14 Ц.Оюунаа, Олон улсын хувийн эрх зүй. УБ 2016 он., 245 дахь тал.

15 Ц.Оюунаа, Олон улсын хувийн эрх зүй. УБ 2016 он., 245 дахь тал.

16 Брюсселийн I журам 2 дугаар зүйлийн 1.

Түүнчлэн зарим хэргийн хувьд тусад нь зүйл болгон авч үзсэн байна. Тухайлбал даатгалтай холбоотой хэргийн шүүхийн харьяалал, хэрэглэгчийн гэрээтэй холбоотой хэргийн шүүхийн харьяалал, ганцаарчилсан хөдөлмөрийн гэрээтэй холбоотой хэргийн шүүхийн харьяаллын талаар зохицуулсан байна.

Онцгой шүүхийн харьяаллын тухайд Журмын 22 дугаар зүйлд иргэний байнга оршин суугаа газраас үл хамааран шүүх хэргийг харьяалан шийдвэрлэвэл зохих шүүхийг дараах байдлаар заасан байна. Үүнд:

- үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой маргааныг хянан шийдвэрлэх нь хөрөнгө байгаа газрын шүүх;
- гишүүн улсын нутаг дэвсгэрт байрлах хуулийн этгээд болон холбоог татан буулгах болон бусад шийдвэр мөн хуулийн этгээдийн дүрэм журмын хүчин төгөлдөр болон хүчин төгөлдөр бус байдалтай холбоотой маргааныг тухайн хуулийн этгээдийн оршин байгаа газрын шүүх;
- эд хөрөнгийн талаар улсын бүртгэгчийн бүртгэл хүчин төгөлдөр эсэхтэй холбоотой маргааныг тус бүртгэлийг хийсэн улсын шүүх;
- Патент, барааны тэмдэг, бүтээгдэхүүний загвар бусад үүнтэй холбоотой эрхийг бүртгэсэн улсын шүүх;
- шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбоотой маргааныг тус шийдвэрийг гаргасан эсхүл хүчин төгөлдөр болсон улсын шүүх харьяалахаар заасан байна.

Брюсселийн I Журамд талууд шүүхийн харьяаллыг харилцан тохиролцож өөрчлөх /prorogation/ тухай зохицуулалтыг “Хэрэв талуудын аль нэг нь эсхүл хоёул гишүүн улсад байнга оршин суудаг ба аливаа эрх зүйн маргаан гарсан тохиолдолд харилцан тохиролцож шүүхийн харьяаллыг тодорхойлж болно. Ингэхдээ талууд онцгой харьяалалд хамаарах хэргээс бусад хэрэгт тохиролцож болно” гэж заажээ. Шүүхийн харьяаллын тухай гэрээ нь:

- бичгээр эсхүл бичгээр нотлогдсон;
- практикт нийцсэн хэлбэрээр талууд хоорондоо харилцан тохиролцож тогтоох;
- олон улсын худалдаа арилжаанд.

Брюсселийн I журмын 5 дугаар зүйлийн 1-д зааснаар гэрээтэй холбоотой хэргийн шүүхийн харьяаллыг үүрэг гүйцэтгэх газраар тодорхойлно гэж заасан.

Журмын 5 дугаар зүйлийн 1б-д нь илүү олон зүйлийг зохицуулж өгсөн нь бараа худалдах худалдан авах гэрээний харьяалал нь бараа хүргэгдэх газраар тодорхойлогдох бол үйлчилгээ үзүүлэх гэрээний харьяалал нь үйлчилгээ үзүүлсэн газраар тодорхойлогдоно. Энэ 2 заалт нь нэлээн төстэй заалт юм. Энэ заалттай холбоотой гарч болох төвөгтэй байдлыг 3 зүйлээр тодорхойлсон нь эхнийх нь хэд хэдэн хүргэлтийн газар болон үйлчилгээ үзүүлэх заалт байвал яах ёстой вэ? Хоёр дахь нь хүргэлтийн газар болон үйлчилгээ үзүүлэх заалтыг хэрхэн тодорхойлох вэ? Гурав дахь нь гэрээнүүдийг хэрхэн 5 дугаар зүйлийн 1-т заасан шиг ангилах явдал байна.¹⁷

Иргэний ба худалдааны асуудлаарх шүүхийн харьяаллыг тодорхойлох ба шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрч биелүүлэх тухай Луганогийн конвенц

17 Pippa Rogerson, Private International law- Jurisdiction. The Cambridge Law Journal Vol.69, No.3 pp. 452-455.

Энэхүү олон улсын гэрээнд Монгол Улс нэгдэн ороогүй буюу тус конвенцийн гишүүн улс биш юм. Иймд тус конвенцийг МУ олон улсын шинжтэй иргэний хэргийн харьяалал тодорхойлоход хэрэглэхгүй гэсэн үг юм.

Энэхүү конвенцыг байгуулах болсон шалтгаан нь Европын Чөлөөт Худалдааны Нийгэмлэгийн гишүүн улсууд Брюсселийн конвенцид нэгдэх боломжгүй тул анхны 1968 оны Брюсселийн конвенц батлагдсаны дараагаар Европын Зөвлөлийн 12 гишүүн улс ба Европын Чөлөөт Худалдааны Нийгэмлэгийн гишүүн 6 улсуудад /Австри, Финланд, Исланд, Норвеги, Швед, Швейцарь/ үйлчлэхээр 1988 онд баталсан ба 2007 онд шинэчлэн баталсан байна. Гэвч 2012 онд баталсан Брюсселийн I Журам Европын холбоонд амьдран суудаггүй этгээдтэй холбоотой шүүхийн харьяаллыг тогтооход хэрэглэх боломжтой болсон¹⁸ байна.

Энэхүү конвенц нь гишүүн орнуудынхаа нутаг дэвсгэртээ оршин суух хүмүүсийн хууль ёсны хамгаалалтыг бэхжүүлэх зорилгоор шүүхийнхээ олон улсын шүүхийн харьяаллыг тодорхойлох, хүлээн зөвшөөрөх явдлыг хөхиүлэн дэмжих, шүүн таслах ажиллагаа, хэрэгсэл, шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагааг түргэн шуурхай явуулах журмыг бий болгох шаардлагатай¹⁹ гэж үзсэний дүнд байгуулагдсан.

Үүнээс гадна Европын Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Нийгэмлэг болон Европын Чөлөөт Худалдааны Нийгэмлэгийн гишүүн улсуудын хооронд байгуулсан чөлөөт худалдааны хэлэлцээрээр эдийн засгийн талбарт зөвшөөрсөн тэдгээрийн хоорондох холбоог таньж мэдэх, 1968 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр Брюсселийн конвенцыг Европын Холбоо, Европын хамтын нийгэмлэгийн дараалан өргөжүүлж, НҮБ-ын Дүрмийн дагуу конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах замаар иргэний болон худалдааны асуудлаар шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангахыг хүсэж конвенцыг байгуулав гэжээ²⁰.

Конвенцын 1 дүгээр зүйлд “энэхүү конвенцийг шүүх, арбитрын шинж чанарыг үл харгалзан иргэний болон худалдааны зорилгоор хэрэглэнэ. Гэхдээ орлого, гааль, удирдлагын асуудал, иргэний эрх зүйн байдал, эрх зүйн чадамж, гэрлэлтийн үр дүнд бий болсон эд хөрөнгийг эрх, гэрээслэл, өв залгамжлал, дампуурал, хуулийн этгээдийг татан буулгах, нийгмийн хамгаалал, арбитрын ажиллагаа зэрэгт хамаарахгүй” гэж заажээ.

Конвенцийн 2 дугаар зүйлд “энэхүү конвенцын дагуу хэлэлцэн тохирогч улсын оршин суугч этгээд харьяаллаасаа үл хамааран тухайн улсын шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй” талаар заасан байна. Харин 6 дугаар зүйлд “үл хөдлөх эд хөрөнгө ба эд хөрөнгийн эрхтэй холбоотой асуудлыг тухайн эд хөрөнгө оршин байгаа хэлэлцэн тохирогч улсын шүүх харьяалах” талаар заасан.

УНИДРУА²¹-гийн Зарчим

Энэхүү зарчмуудыг УНИДРУА-ийн Зөвлөлөөс 2004 оны 4 дүгээр сард хүлээн зөвшөөрч баталсан Олон улсын иргэний процессын зарчмууд байна. Энэхүү баримт бичгийг Америкийн хуулийн хүрээлэнтэй хамтран боловсруулсан.

18 Б.Тамир, Олон улсын хувийн эрх зүй. УБ 2019 он., 90 дэх тал.

19 Луганогийн конвенц удиртгал хэсэг.

20 Мөн тэнд.

21 International Institute for the Unification of Private Law- Хувийн эрх зүйг ижилтгэх олон улсын институт.

Зорилго нь олон улсын болон үндэстэн дамнасан маргааныг шийдвэрлэх иргэний процессын ижилтгэсэн журмыг бий болгох явдал байсан. Энэ зарчмууд нь загвар хууль хэлбэрээр боловсруулагдсан бөгөөд аль ч улс өөрийн иргэний процессын журмыг боловсруулахад ашиглаж болох юм.²²

Энэхүү зарчмын хүрээнд Худалдааны хэлцэлд худалдах худалдан авах гэрээ, түрээсийн гэрээ, зээлийн гэрээ, хөрөнгө оруулалт, банк, нийгэм хамгаалалт, хөрөнгө (оюуны өмч) мөн бусад бизнесийн болон санхүүгийн хэлэлцээрүүд хамаарна гэж заажээ.

2. ОЛОН УЛСЫН ШИНЖТЭЙ ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ХАРЬАЛАЛ ТОДОРХОЙЛОХ АРГА, ЖУРАМ

Нэр томъёо. Олон улсын маргааны шүүхийн харьяалал гэдэг нь, гадаад элемент бүхий хувийн эрх зүйн хэрэг маргааныг аль улсын шүүх харьяалан шийдвэрлэх эрхтэй вэ, шүүхэд нь нэхэмжлэл гаргасан улсын хуулийн дагуу тухайн улсын шүүхэд харьяалагдах боломжтой юу хэмээх асуудлыг судална. Энд, тухайн маргааныг харьяалан шийдвэрлэж болох хэд хэдэн улсын харьяалал ч байх магадлалтай ба ийм үед чухам аль улсын шүүхэд нь хандах нь илүү зохимжтой байх асуудал ч гарч ирнэ. Түүнчлэн маргааныг шийдвэрлэх зохимжгүй шүүх, шүүхийн маргаан зэрэгцээ өрнөх зэрэг асуудал ч харьяаллын хүрээнд судлагдах ёстой.

Шүүх гэдэг нь төрийн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллага бөгөөд “*facultus jurisdictionis*” хэмээх нэр томъёогоор илэрхийлэгддэг. Энэ нь эрх зүйн тухай ярих эрх мэдэл гэсэн үг юм. Шүүх бол төрийн бүрэн эрхийн илрэх нэгэн хэлбэр бөгөөд гагцхүү онцгой тохиолдолд л олон улсын нийтийн эрх зүйн дагуу эрх нь хязгаарлагддаг.

Ач холбогдол. Шүүх ба олон улсын хэргийн харьяалал нь хэд хэдэн чиг үүрэг бүхий бие даасан процессын шаардлага юм. Шүүхэд хамаарах хууль тогтоомж, журмын дагуу тухайн шүүх буюу шүүгч уг маргааныг шийдвэрлэх эрх нь олон улсын нийтийн эрх зүйгээр хязгаарлагдах эсэхийг тогтоодог. Харин хэргийн олон улсын шүүхийн харьяаллын талаархи зохицуулалт нь тухайн эрх зүйн маргаан дотоодын шүүхэд харьяалагдах, оролцогчид нь эрх зүйн хамгаалалт эдэлж чадах эсэхийг тодорхойлдог ороо ялгаатай юм.

2.1. Олон улсын хувийн эрх зүйн маргааныг шийдвэрлэх шүүх эрх мэдэл, түүний хязгаар

Олон улсын нийтийн эрх зүйн хязгаарлалт. Олон улсын нийтийн эрх зүй нь аливаа улсыг эрх мэдлээ өөрийн нутаг дэвсгэрээс гадагш хэрэгжүүлэхийг хориглодог. Тийм ч учраас шүүх эрх мэдлээ хэрэгжүүлэх боломж нь түүний нутаг дэвсгэрээр хязгаарлагдана. Эндээс, гадаад улсын нутаг дэвсгэр дээр аливаа процессын ажиллагаа, тухайлбал шүүхийн болон шүүхийн бус баримт бичгийг хүргэх, нотлох баримт цуглуулах үйл ажиллагаа хийгдэхгүй ба эдгээрийг гагцхүү олон улсын эрх зүйн туслалцааны хүрээнд хийж болохоор заасан байдаг. Түүнчлэн аливаа улсын дотоодод ч олон улсын нийтийн эрх зүй нь тодорхой хязгаарлалтыг тогтоож өгсөн:

22 Э.Байгал, Олон улсын хувийн эрх зүй. УБ 2016., 256 дахь тал.

1/ Төрийн дархан эрх

Улсуудын тэгш байдлын зарчим ба түүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх үндсэн дээр төрийн дархан эрх нь дараах 3 аспектыг агуулдаг.

а/ Хууль тогтоомжийн дархан эрх: Ямар ч улс өөр улсыг хууль тогтоомждоо захируулахгүй.

б/ Шүүхийн дархан эрх: нэг улс нөгөө улсыг өөрийн шүүхэд хариуцагчаар татахгүй.

в/ Шийдвэр гүйцэтгэлээс ангид байх дархан эрх: нэг улс нөгөө улсын эсрэг шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлж болохгүй.

Нэг улс нөгөө улсынхаа эсрэг шүүхийн процессын ажиллагаа явуулах нь тусгаар улсын бүрэн эрх, тэгш байдлыг зөрчсөн хэрэг болох юм. Шүүхийн дархан эрх буюу “*par item non habet jurisdictionem*” хэмээх өгүүлбэр нь бүр постглоссаторуудын үеэс үйлчилж байсан.

Дэлхийн хоёрдугаар дайныг дуусах хүртэл ОУНЭЗ-д төрийн туйлын дархан эрхийн онол үйлчилж байв.

Улс гүрэн олон улсын худалдаа, эдийн засгийн харилцаанд, тухайлбал төрийн өмчит аж үйлдвэрүүд, төрийн банк зэрэг хэлбэрээр оролцох нь улам бүр өсөн нэмэгдсэнээр дотоодын шүүхээс гадаадын төр нь ямар нэгэн хязгаарлалтгүйгээр чөлөөлөгдөх нь тохиромжгүй нь гэж үзэх болсон. Өнөөдөр олон улсын хэмжээнд дийлэнхийн баримталж буй “харьцангуй” буюу “төрийн хязгаарлагдмал дархан эрхийн онол” нь төрийн дархан эрх гагцхүү засаглалыг хэрэгжүүлэх явцад үйлчилж /*acta jure imperii*/ харин хувийн эрх зүйн болон эдийн засгийн эрх зүйн харилцаанд оролцохдоо хуулийн этгээдийн хувиар оролцоно хэмээн үздэг болсон. Өөрөөр хэлбэл дархан эрхээсээ сайн дураараа татгалзана гэсэн үг юм /*acta jure gestionis*/.

2/ Шүүх эрх мэдлээс ангид байх эрх

Гадаадын зарим хувь хүн ч дотоодын шүүхэд харьяалагдахгүй. Түүний дархан эрх нь юуны өмнө “Дипломат харилцааны тухай” болон “Консулын харилцааны тухай” Венийн конвенциор зохицуулагдсан байдаг. Үүний зэрэгцээ олон улсын нийтийн эрх зүйн заншлын хэм хэмжээний үндсэн дээр, жишээ нь төрийн зочны дархан эрхийн үндсэн дээр шүүхэд харьяалагдахгүй байна.

Монгол Улс нь дээр дурьдсан Венийн конвенциудад 1966, 1988 онд тус тус нэгдэн орсон бөгөөд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 193 дугаар зүйлд тусгаснаар дотоодын эрх зүйн хэм хэмжээ болж хувирсан юм.

Дээр дурьдсан конвенцийг судлахад, хувь хүний болон албан үүргийн хувьд шүүхээс ангид байхыг ялгаж авч үзсэн.

а/ Хувь хүн шүүхээс ангид байх. Дипломат бүрэн эрх бүхий этгээд нь иргэний болон эрүүгийн шүүхийн харьяаллаас, тэрчлэн хувийн эрх зүйн харилцаанаас үүссэн маргааны улмаас гаргасан нэхэмжлэлийн хувьд ч шүүхээс ангид байна. Энэхүү дархан эрх нь шүүхийн шийдвэр гүйцэтгэлд ч хамаатай. Гэхдээ тэрээр гагцхүү дипломат бүрэн эрхийг хэрэгжүүлэн сууж буй улсын шүүхээс хараат бус байхаас илгээгч орны, өөрөөр хэлбэл өөрийн орны шүүхэд бүрэн харьяалагдана. Түүнчлэн энэхүү дархан эрхийг гагцхүү албан үүргээ хэрэгжүүлэх явцдаа л эдэлнэ. Түүнчлэн дипломат эрх бүхий этгээдийн гэр бүлийн гишүүд нь уг дархан эрхийг эдлэх ба харин хүлээн авагч орны иргэн бол эрх эдлэх боломж нь үгүйсгэгдэнэ. Харин

дипломат төлөөлөгчийн газрын захиргааны ба техникийн ажилтан, тэдгээрийн гэр бүл зарим тохиолдолд иргэний ба захиргааны шүүхээс ангид байх эрхийг эдэлдэг.

б/ Албан үүргийн дагуу шүүхээс ангид байх. Дээр дурьдсанаас бусад этгээд, жишээ нь элчин сайдын яамны ажилтан, консулын төлөөлөгчийн газрын гишүүд нь албан үүргээ гүйцэтгэх явцдаа шүүхээс ангид байх хязгаарлагдмал дархан эрхийг эдэлнэ.

в/ Нутаг дэвсгэрт хамаарахгүй байх. Энд аливаа улсын дотоодод оршин байгаа ч халдаж болохгүй, төрийн албадлагаас ангид байх нөхцлийг ойлгоно. Тухайлбал, гадаад улсын элчин сайдын яамдын барилга байшин, консулын газар, тэдгээрийн архив, банкны харилцах данс зэргийг дурьдаж болно.

НҮБ-ын “Төрийн шүүхийн болон өмчийн дархан эрхийн тухай” конвенц. 2005 онд НҮБ-аас Төрийн шүүхийн болон өмчийн дархан эрхийн тухай конвенцийг боловсруулан гаргасан. Уг конвенц нь 2007 оноос эхлэн улс орнууд гарын үсэг зурахад нээлттэй болсон. Гэхдээ конвенцийн дагуу 30 улс түүнд нэгдэн орж, ратификаци хийсний дараа хүчин төгөлдөр үйлчилж эхлэх юм. 2021 оны байдлаар нийт 28 улс гарын үсэг зурсан ч тэдгээрээс 22 улс нь ратификаци хийсэн байна.

Европын холбооны улсын “Төрийн дархан эрхийн тухай” Базелийн конвенци. Дотоодын шүүхийн өмнө гадаадын төр ямар тохиолдолд, ер нь хариуцагчаар татагдаж болох эсэх асуудлыг ОУНЭЗ-н заншлын хэм хэмжээ болон ОУНЭЗ дэх олон улсын гэрээний дагуу зохицуулж байна. Олон улсын нийтийн эрх зүйн гэрээний хувьд Европын зөвлөлөөс баталсан Төрийн дархан эрхийн тухай Европын конвенци үйлчилдэг. Энэхүү конвенци нь 1972 оны 5 сарын 16-нд Базел хотноо батлагдсан. Нийт 6 бүлэг, 41 зүйлболон 14 зүйл бүхий нэмэлт протоколоос бүрдэнэ. Уг конвенцийн үндсэн үзэл санаа нь төрийн хязгаарлагдмал дархан эрхийн онол юм.

2.2. Олон улсын хувийн эрх зүйн маргааны шүүхийн харьяаллын төрөл

Аливаа улсын шүүхийн байгууллага нь өөрийн орны нутаг дэвсгэр дээр шүүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг. Харин шүүхийн олон улсын харьяаллын талаархи хэм хэмжээ нь тухайн улсын шүүх ямар үндэслэлээр гадаад элемент бүхий хэргийг харьяалан шийдвэрлэх вэ хэмээх асуудлыг зохицуулна.²³ Товчоор хэлбэл, олон улсын хувийн эрх зүй нь аль улсын эрх зүйд хэрэглэгдэх вэ гэдгийг зохицуулдаг бол олон улсын иргэний процессын эрх зүй аль улсын шүүхээр шийдвэрлэх вэ гэдгийг зохицуулна.

Олон улсын шинжтэй маргааны шүүхийн харьяалал нь:

- Тухайн улсын шүүх эрх мэдэлд хамаарах эсэх;
- Тухайн улсын шүүхийн харьяалалд хамаарах эсэх асуудлыг шийдвэрлэх гол зорилготой.

ОУ-ын иргэний хэрэг маргааны шүүхийн харьяалаллын эрх зүйн зохицуулалтыг нэг талын шинжтэй гэж үздэг бөгөөд учир нь улс зөвхөн өөрийн шүүхийн харьяалж болох маргааны хүрээг тогтооно, харин өөр бусад улсын шүүхийн харьяаллыг тогтоох боломжгүй /улсын бүрэн эрхийн зарчим зөрчигдөнө/ гэсэн үзлээс үүдэлтэй.

23 Т.Мөнхжаргал /ред/, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй /ерөнхий анги/. Улаанбаатар 2011 он., 59-63 дахь талаас дэлгэрүүлэн үзнэ үү.

Онолын үндэслэл нь ОУХЭЗ дэх нягт холбооны зарчим гэж үздэг бол Европын орнууд: хэргийн нөхцөл байдал ба шүүхийн харилцан хамаарал, АНУ-д хэргийн нөхцөл байдал, шүүхийн харилцан хамаарал, хариуцагчийн оршин байгаа газраас хамааран шүүх харьяалан шийдвэрлэх эрхтэй эсэхийг тодорхойлдог.²⁴

Монгол Улсын ИХШХШТХ-ийн 189-194 дүгээр зүйлд олон улсын шинжтэй хэрэг маргааны шүүхийн харьяаллыг зохицуулсан.

Олон улсын хувийн эрх зүйн холбогдолтой маргааны харьяаллыг тодорхойлох үндсэн гурван аргыг гол төлөв ашигладаг.²⁵

а/ Ердийн харьяалал /нутаг дэвсгэрийн шинжтэй/

б/ Тусгай харьяалал /тодорхой төрлийн хэргийн хувьд хэрэглэгдэх харьяалал/

в/ Онцгой харьяалал /гагцхүү тухайн улсын шүүхээр шийдвэрлэвэл зохих хэргийг харьяалал/

Монгол Улсын ИХШХШТХ-ийн 189-192 дугаар зүйлд дээрх төрлийн харьяаллыг тус бүр ангилан тусгасан байдаг.

Талууд шүүхийн харьяаллыг харилцан тохиролцох. Олон улсын бизнесийн гэрээнд талууд шүүхийн харьяаллыг тохиролцох боломжтой байдаг. Энэ нь ОУХЭЗ-н харилцаанд оролцох талуудад олгогддог онцлог эрх/боломж юм. Энд тавигдах гол шалгуур нь шүүхийн харьяаллыг сонгосон нь хүчин төгөлдөр байх ёстой. Шүүхийн харьяаллыг сонгохдоо, тухайн гэрээ хаана хэрэгжихээс хамааран талуудын сонгосон улсын шүүх эрх мэдэлд хамаарах, өөр улсын шүүхийн онцгой харьяалалд хамаарах эсэхийг хянах шаардлага зайлшгүй үүснэ. Өөрөөр хэлбэл, шүүхийн харьяаллыг сонгох боломж нь шүүхийн онцгой харьяаллын үүднээс хязгаарлагдах нь бий. Үндэсний эрх зүйд ч талууд харилцан тохиролцсон бол шүүхийн харьяаллыг хуульд зааснаас өөрчлөн сонгож болох ба үүнийг ИХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1-т тусгасан. Энд мөн л шүүхийн онцгой харьяаллыг харгалзан үзэх ба аль нэг шүүхийн онцгой харьяалалд хамаарахгүй маргааны тухайд, нутаг дэвсгэрийн харьяаллыг өөрөөр тохиролцох боломжийг олгожээ.²⁶

1/ Шүүхийн ердийн харьяалал /General jurisdiction/Home court jurisdiction/

Шүүхийн ердийн харьяалал нь нутаг дэвсгэрийн шинжтэй бөгөөд, дийлэнхдээ хариуцагчийн оршин байгаа улсын шүүхэд харьяалан шийдвэрлүүлэхээр заасан байдаг. Харин олон улсын хувийн эрх зүйн маргааны тухайд Хариуцагч болох хувь хүн, хуулийн этгээдийн оршин суугаа газар буюу “domicil” аль улс вэ гэдгийг тодруулах шаардлага гарна. Энд, гадаадын иргэн, хуулийн этгээдийн байнга оршин суугаа, оршин байгаа газар гэх ялгаатай ойлголтуудыг анхаарах шаардлагатай.

ИХШХШТХ-ийн 189 дүгээр зүйлд Монгол Улсын шүүхийн ердийн харьяалалд хамаарах хэргийг тусгайлан заасан байдаг. Эдгээр нэг бүрчлэн урьдчилсан нөхцлөөр нь задлан авч үзье.

189.2.1.Нэхэмжлэлийн хариуцагч нь Монгол Улсад байнга оршин суудаг буюу аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг бол:

24 Trevor C Hartley, Basic Principles of Jurisdiction in private international law: The European Union, The United States and England. International & Comparative Law Quarterly (online), Cambridge 2021. p3.

25 Т.Мэндсайхан, Олон улсын хувийн эрх зүй. Улаанбаатар 2008 он., 190 дэх тал.

26 Б.Буянхишиг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй. УБ 2021 он., 68-69 дэх тал.

- Олон улсын шинжтэй хувийн эрх зүйн харилцаа үүссэн байх;
- Хариуцагч нь Монгол Улсад байнга оршин суудаг, эсхүл аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг байх.

189.2.2. Нэхэмжлэлийг хэд хэдэн этгээд хамтран гаргасан ба тэдгээрийн аль нэг нь Монгол Улсад байнга оршин суудаг;

- Олон улсын хувийн эрх зүйн шинжтэй харилцаа үүссэн байх;
- Нэхэмжлэлийг хэд хэдэн этгээд хамтран гаргасан байх;
- Нэхэмжлэл гаргасан этгээдүүдийн аль нэг нь Монгол Улсад байнга оршин суудаг байх.

189.2.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нэхэмжлэл гаргасан ба тухайн үүргийг Монгол Улсад гүйцэтгэх ёстой байсан:

- Олон улсын хувийн эрх зүйн шинжтэй гэрээний харилцаа үүссэн;
- Талуудын аль нэг нь гэрээний үүргээ гүйцэтгээгүй буюу зөрчсөн байх;
- Үүрэг гүйцэтгэх газар нь Монгол Улс байх.

189.2.4. Бусдад гэм хор учруулсны улмаас Монгол Улсын нутаг дэвсгэр дээр тухайн этгээдэд гэм хор учирсан:

- Олон улсын шинжтэй гэрээний бус үүргийн /гэм хор/ харилцаа үүссэн байх;
- Гэм хор учруулсан үйлдэл аль улсад хийгдсэнээс үл хамааран гэм хор Монгол Улсын нутаг дэвсгэр дээр учирсан байх.

189.2.5. Хуулийн этгээдийн Монгол Улсын нутаг дэвсгэр дэх салбар буюу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны улмаас маргаан үүссэн:

- Гадаад улсын хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн газар байх
- Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин байх
- Тус салбар төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны улмаас үүссэн маргаан байх

189.2.6. Монгол Улсын иргэн буюу Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байнга оршин суудаг гадаадын иргэн, харьяалалгүй хүн эцэг тогтоох ба тэтгэмж төлөхтэй холбоотой гаргасан нэхэмжлэл:

- Олон улсын шинжтэй гэр бүлийн эсхүл эцэг эх-хүүхдийн харилцаа үүссэн байх;
- Хариуцагч нь Монгол Улсын иргэн, эсхүл Монгол Улсад байнга оршин суудаг гадаадын иргэн, харьяалалгүй хүн байх;
- Нэхэмжлэлийн зүйл нь эцэг тогтоох, эсхүл эцэг тогтоож тэтгэмж төлүүлэхтэй холбоотой байх.

189.2.7. Нэхэмжлэлийн зүйл нь өв залгамжлах эрх, өв залгамжлуулагчаас эд хөрөнгийг хуваах, гэрээслэл, үүрэг гүйцэтгэхтэй холбоотой бөгөөд өв залгамжлуулагч нас барахаасаа өмнө Монгол Улсад амьдардаг буюу оршин суудаг байсан, эсхүл тухайн өв хөрөнгө нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа.

- Гадаад улсын иргэн, эсхүл гадаад улсад амьдарч байсан Монгол Улсын иргэн байх;
- Өв залгамжлал, өвлөгдөх хөрөнгө хуваах, гэрээслэл, үүрэг гүйцэтгэхтэй холбоотой маргаан үүссэн байх;

- Өвлүүлэгч нас барахаасаа өмнө Монгол Улсад амьдардаг буюу оршин суудаг байсан, эсхүл өв хөрөнгө Монгол Улсад байгаа.

Шүүхэд олон улсын шинж хамаарал бүхий иргэний хэрэг маргааныг шийдүүлэхээр нэхэмжлэл гаргасан тохиолдолд хэрэв Монгол Улсын шүүхийн ердийн харьяалалд хамаарах магадлалтай гэж үзсэн тохиолдолд дээрх урьдчилсан нөхцлийн дагуу шалгаж, харьяаллыг эцэслэн тодорхойлох нь зүйтэй болно.

2/ Шүүхийн онцгой харьяалал /Exclusive jurisdiction/

Шүүхийн онцгой харьяалал гэдэг нь гагцхүү тухайн улсын шүүх харьяалан шийдвэрлэх маргааны төрлийг хэлэх ба гагцхүү онцгой харьяалал бүхий шүүх хянан шийдвэрлэвэл зохих маргаан энд хамаарна. Ийм маргааныг өөр улсын шүүх, эсхүл арбитр шийдвэрлэсэн бол түүнийг биелүүлэхээс татгалзах эрхийг улс орнууд эдэлнэ. Ийм зохицуулалт нь аливаа төрийн бүрэн эрх, ашиг сонирхлыг харгалзан үзсэний үндсэн дээр бий болдог бөгөөд олон улсын эрх зүй дэх төрийн бүрэн эрх, дархан эрхийн зарчимд суурилдаг. ИХШХШТХ-ийн 190 дүгээр зүйлд Монгол Улсын шүүхийн онцгой харьяалалд хамаарах хэргийн төрлийг зааж өгсөн ба үүнийг Европын холбооны Иргэний болон худалдааны хэргийн шүүхийн харьяалал, шүүхийн шийдвэрийг биелүүлэх тухай 1968 оны Брюсселийн конвенцийн²⁷ 16 дугаар зүйлээс Монгол Улс жишээ авсан гэж харагддаг /адил зохицуулалттай/.

Монгол Улсын шүүхийн онцгой харьяалалд дараахь төрлийн хэрэг маргаан хамаарна:

190.1.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой маргаан:

- Маргааны талууд нь гадаадын иргэн, хуулийн этгээд болон Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байх;
- Маргааны зүйл нь үл хөдлөх хөрөнгийг өмчлөх, эзэмших, ашиглах асуудлын аль нэг байх;
- Үл хөдлөх эд хөрөнгө нь Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин байх.

190.1.2. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байршилтай хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах буюу тухайн хуулийн этгээдийн болон түүний салбар төлөөлөгчийн газрын гаргасан шийдвэртэй холбоотой маргаан:

- Монгол Улсад байрлах хуулийн этгээд байх /гадаадын хуулийн этгээдийн охин болон хараат компани байхаас үл хамаарна/;
- Дараах маргааны аль нэг байх:
 - Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах, татан буулгах;
 - Хуулийн этгээдийн, эсхүл түүний салбар төлөөлөгчийн газрын гаргасан шийдвэртэй холбоотой маргаан.

190.1.3. Монгол Улсын шүүх буюу бусад эрх бүхий байгууллагын бүртгэл хүчин төгөлдөр эсэх талаархи маргаан:

- Маргааны талууд нь олон улсын шинжтэй байх;
- Монгол Улсын шүүх, эрх бүхий байгууллагын хийсэн бүртгэлийн хүчин төгөлдөр эсэхтэй холбоотой маргаан.

27 <https://www.jus.uio.no/lm/brussels.jurisdiction.and.enforcement.of.judgments.in.civil.and.commercial.matters.convention.1968/doc.html>.

190.1.4. Монгол Улсын эрх бүхий байгууллага патент, барааны тэмдэг болон бусад оюуны өмчтэй холбоотой эрхийг бүртгэсэн, бүртгэхээр өргөдлийг хүлээн авсан;

190.1.5. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх арга хэмжээ авсан буюу холбогдох этгээд ийм арга хэмжээ авахуулахаар өргөдөл гаргасан бол:

- Гадаад улсад болон Монгол Улсад гарсан шүүхийн шийдвэр биелүүлэхээр хүсэлт гаргасан;
- Эсхүл шүүхийн шийдвэр гүйцэтгэх арга хэмжээ авсан байх;
- /энд анхаарах нь, гадаадын шүүх, арбитрын шийдвэрийн алинаас нь хамаарч талуудын хувьд хүчин төгөлдөр болсон байх, өөрөөр хэлбэл арбитрын ажиллагаа явагдсан газрын эрх бүхий шүүхэд шийдвэрийг хүчингүй болгуулахаар гомдол гаргах хугацаа дууссан байх, арбитрын бүрэлдэхүүнд шийдвэрийг өөрчлүүлэх, тайлбар хүсэх хугацаа дууссан байх зэрэг шалгуурыг заавал харгалзан үзэх бөгөөд үүнийг үл хайхран шийдвэр гүйцэтгэх захирамж гаргавал туйлын бүдүүлэг алдаа болно/

3/ Гэр бүлийн холбогдолтой хэргийн харьяалал /Special jurisdiction/alternative grounds jurisdiction/

Улс гүрэн шүүхэд тодорхой төрлийн хэргүүдийн хувьд тусгай харьяалал тогтоох боломжтой байх ба энэ нь нэн ялангуяа гэр бүл, өв залгамжлал, эсхүл гэрээний зарим төрлийн асуудалд хамаарах нь түгээмэл байдаг. ИХШХШТХ-ийн 192 дугаар зүйлд гэр бүлийн холбогдолтой зарим хэргийг шүүхийн тусгай харьяалалд хамааруулахаар заасан.

Гэр бүлийн холбогдолтой хэрэг гэдэгт гэрлэлт цуцлах, гэрлэлт хүчингүйд тооцох, гэрлэлтийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах, гэр бүлийн харилцаа үүссэн эсэхийг тогтоох /хамтын амьдралтай байсан эсэх/, гэрлэлтийг сэргээх, эцэг эхийг тогтоох, хүүхэд үрчлэх зэрэг асуудлыг хамааруулан үздэг /ИХШХШТХ 192.2/. Эдгээр зохицуулалтын урьдчилсан нөхцлийг задлан авч үзье. Үүнд:

192.1.1. Гэрлэгчдийн аль нэг нь Монгол Улсын иргэн буюу гэрлэх үедээ Монгол Улсын харьяат байсан:

- Олон улсын шинжтэй гэр бүлийн харилцаа үүссэн байх /гэрлэгсдийн аль нэг нь гадаадын иргэн, эсхүл харьяалалгүй этгээд байх, гэрлэлт гадаад улсад гадаад улсын хуулийн дагуу үүссэн бол, гэрлэгсдийн эд хөрөнгийн болон амины харилцаа гадаад улсын эрх зүйгээр зохицуулагдаж байгаа бол гэх мэт/;
- Гэрлэгсдийн аль нэг нь Монгол Улсын иргэн байх, эсхүл гэрлэлтээ бүртгүүлэх үед Монгол Улсын иргэн байсан байх

192.1.2. Гэрлэгчдийн хариуцагч тал гадаадын иргэн, харьяалалгүй хүн боловч Монгол Улсад байнга оршин суудаг:

- Олон улсын шинжтэй гэр бүлийн харилцаа үүссэн байх /гэрлэгсдийн аль нэг нь гадаадын иргэн, эсхүл харьяалалгүй этгээд байх, гэрлэлт гадаад улсад гадаад улсын хуулийн дагуу үүссэн бол, гэрлэгсдийн эд хөрөнгийн болон амины харилцаа гадаад улсын эрх зүйгээр зохицуулагдаж байгаа бол гэх мэт/;

- Нэхэмжлэлийн хариуцагч нь гадаадын иргэн, эсхүл харьяалалгүй хүн байх;
- Хариуцагч Монгол Улсад байнга оршин суудаг байх.

192.1.3. Эцэг эх, хүүхдийн хоорондох харилцааг тогтоох, эцэг, эх байх эрхийг хасахтай холбоотой маргаан үүссэн тохиолдолд хариуцагч, нэхэмжлэгчийн аль нэг нь Монгол Улсын харьяат, эсхүл Монгол Улсад байнга оршин суудаг:

- Эцэг эх, хүүхдийн хоорондын маргаан үүссэн байх /эцэг эх хүүхдийн харилцааг тогтоох, эцэг эх байх эрх хасах/;
- Дээрх харилцаа олон улсын шинжтэй байх, өөрөөр хэлбэл талуудын аль нэг нь гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн байх;
- Талуудын аль нэг нь Монгол Улсад байнга оршин суудаг байх.

192.1.4. Хүүхэд үрчлүүлэх, хүүхэд үрчлэн авахад үрчлэн авагч буюу үрчлэгдэж буй хүүхэд Монгол Улсын харьяат, эсхүл Монгол Улсад байнга оршин суудаг этгээд:

- Гадаадын иргэн хүүхэд үрчлэн авахтай холбоотой харилцаа үүссэн байх /харьяалалгүй хүнд энэ зохицуулалт үл хамаарна, учир нь гагцхүү харьяалах улсынхаа эрх бүхий байгууллагаар дамжуулан үрчлэн авах хүсэлт гаргадаг тул боломжгүй/

Дээрх тохиолдолд гэр бүлийн холбогдолтой хэргийг Монгол Улсын шүүх өөрийн харьяалалд хамааруулан шийдвэрлэх эрх хэмжээтэй байна. Практикт, гадаад улсад гэрлэсэн гэрлэлтээ хэрхэн цуцлуулах, Монгол Улсын иргэн нь нөгөө улсад оршин суугаа иргэнтэй энэ асуудлаар хэрхэн холбогдохоо сайн мэддэггүй учир гэрлэлтээ цуцлуулж чадахгүй удаан хугацааг өнгөрүүлэх асуудал элбэг тохиолддог.

3. ИХШХШТХ-ЫН 189-193 ДУГААР ЗҮЙЛИЙГ ХЭРЭГЛЭЖ БҮЙ ПРАКТИК

3.1. Шүүхийн шийдвэрт харьяаллын үндэслэл дурьдагдаж буй эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Гадаадын иргэн, хуулийн этгээд оролцсон хувийн эрх зүйн харилцаа өргөжихийн хэрээр, ийм харилцаанаас үүдэлтэй маргааны тоо нэмэгдэж шүүхэд хандах нь улам бүр олшрох нь зүй юм. Энэ зүй тогтол ч Монгол Улсад ажиглагдаж байгаа бөгөөд цөөнгүй олон улсын хувийн эрх зүйн хэрэг маргааныг шүүхэд хянан шийдвэрлэжээ. Эдгээрийн заримыг дор авч үзье.

Шийдвэр 1. Ажил гүйцэтгэх гэрээтэй холбоотой маргаан.

Дорноговь аймгийн Замын-Үүд сумд оршин суудаг Т.О нь БНХАУ-ын төмөр замын 21 дүгээр компани Л.Х.Ф-д холбогдуулан ажил гүйцэтгэх гэрээний үүрэг болох 22,800,000 төгрөг гаргуулах тухай нэхэмжлэлийг гаргасан тус аймгийн иргэний хэргийн анхан шатны шүүхэд гаргасан.

Талууд 2018.03.05-2018.05.05 хооронд дэд бүтцийн угсралтын ажил хийлгэх зорилготойгоор ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Гэрээний хугацаанд Т.О нь 15-35 ажилтантай, 3 крантай ажилласан бөгөөд гэрээний хугацаанд материалын дутагдлаас болоод 8 дугаар сард ажлыг нь бүрэн дуусгаж өгсөн байна. Гэтэл Л.Х.Ф компаниас гэрээний үүрэг болох ажлын үнийн дүнг төлөхгүй байгаа тул нэхэмжлэл гаргасан. Харин хариуцагчийн зүгээс Т.О-ийн зүгээс гэрээний хугацаанд ажлыг хийж дуусгаагүй тул нэхэмжлэгчийн шаардсан мөнгийг төлөхгүй гэж хариу тайлбар гаргасан байна.

Энэхүү хэргийг тус аймгийн анхан шатны шүүх шийдвэрлэхдээ иргэний хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Нэхэмжлэгч шүүхийн шийдвэрт гомдож дамж заалдах гомдол гаргасны дагуу шүүхээс тус хэргийг ахин шийдвэрлэсэн. Давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүх иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн байна гэж үзэн шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасугай гэж шийдвэрлэсэн. Шийдвэрийн нэг үндэслэл нь:

“талуудын хооронд байгуулагдсан гэрээний агуулгаас үзэхэд Дорноговь аймгийн Замын-Үүд суманд каргоны хашаа төсөл буюу барилга барих ажлыг иргэн Т.О гүйцэтгэхээр ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан байх боловч гэрээнд захиалагч нь хэн болохыг тодорхой заагаагүй /А тал гээд нэрийг Хятадаар бичсэн орчуулгагүй, хүний нэр, эсхүл байгууллагын нэр болох нь тодорхойгүй/ хэдий ч энэхүү гэрээний нэг тал нь гадаад улсын иргэн, эсхүл байгууллага байхын гадна гэрээг БНХАУ-ын хуулийг үндэслэн байгуулсан байх ба энэ утгаараа гэрээ нь олон улсын иргэний эрх зүй гэрээ болох талтай буюу гэрээнд маргааныг аль улсын шүүхээр шийдвэрлүүлэх талаар заагаагүй тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 189 дүгээр зүйлийн 189.2 дахь хэсэгт заасан хэргийг өөрийн харьяалалд хамааруулан хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэл болох эсэхийг анхан шатны шүүх анхаараагүй” гэж үзсэн²⁸.

Шийдвэр 2. Өв залгамжлагчаар тогтоолгохтой холбоотой хэрэг.

БНХАУ-ын иргэн Л.Ж.Б, Л.Ю.Ж нарын нэхэмжлэл болон Л.Ж.Б-ын шүүх хуралдаанд гаргасан тайлбарт: Л.Ж.Б нь Улаанбаатар хотод 1970 онд төрсөн, мөн эхнэр Ж.Ч.Х нь 1972 онд Улаанбаатар хотод төрсөн. Л.Ж.Б нь 1996 онд эхнэртэйгээ танилцаж, 1997 онд гэр бүл болж охин Л.Ю.Ж төрсөн. Л.Ж.Б намайг болон миний охин Л.Ю.Ж-ыг нас барагч Ж.Ч.Х-гийн өмчлөлд бүртгэлтэй дор дурдсан эд хөрөнгийн хууль ёсны өв залгамжлагч болохыг тогтоож өгнө үү. Үүнд: Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо 1 дүгээр 40 000-тын 9-7 тоот худалдаа, үйлчилгээний зориулалттай байрны өвлүүлэгчид ногдох хэсэг, нас барагчийн Голомт банк дахь тоот юанийн дансан дахь 85 503 юань буюу 18 945 008 төгрөг, тоот дансан дахь 377 122 төгрөгийн, тоот валютын дансан дахь 147.40 ам.доллар буюу 206 368 төгрөгийн мөнгөн хөрөнгө буюу нийт 19 528 798 төгрөгийн мөнгөн хөрөнгө, БНХАУ-ын Тариалангийн банк дахь 3093 хадгаламжийн картын дугаар дахь 18 720 юань буюу 4 197 855 төгрөгийн мөнгөн хөрөнгөнүүд болно. Дээрх хөрөнгийн 1/3 хэсгийг Л.Ж.Б надад оногдох 1/3 хэсгийг охин Л.Ю.Ж-д хуваарилж өгнө үү гэсэн нэхэмжлэлийг шүүхэд гаргасан.

Харин хариуцагчийн зүгээс Нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрөхгүй. Л.Ж.Б, талийгаач Ж.Ч.Х нар БНХАУ-ын Элчин сайдын яаманд гэрлэлтээ бүртгүүлсэн байсан. Тэдний гэрлэлтийг БНХАУ-ын хуулиар бүртгэсэн, гэрлэлтийн тал дээр маргаантай. Тэдний дундаас охин Л.Ю.Ж төрсөн. Хүүхдийн хувьд Иргэний хуулийн 520 дугаар зүйлийн 520.1.1 дэх хэсэгт зааснаар хууль ёсны өвлөгч тул дахин тогтоох шаардлагагүй гэж үзэж байна. Ж.Ч.Х нь 2010 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр нас барсан. Иргэний хуулийн 528 дугаар зүйлд заасан өв хүлээн авах

28 <http://new.shuukh.mn/irgendavah/11068/view>.

журмыг харвал нэхэмжлэгчийг татгалзсан гэж үзнэ. Учир нь Монголын нотариатын танхимаас ирүүлсэн бичигт Ж.Ч.Х-ийн өвийг авах хүсэлтийг гаргаагүй байсан. Талийгаачийг нас барснаас хойш 2 жил 2 сар 5 хоногийн дараа шүүхэд нэхэмжлэл гаргасан байсан. Мөн хуульд зааснаар хүндэтгэн үзэх шалтгаан байсан эсэх, хуульд заасан хугацааг хэтрүүлснээс уг хугацааг сэргээлгэх тухай хүсэлтийг гаргаж шийдвэрлүүлээгүй болно. Эд хөрөнгийн хувьд талийгаачийн хөрөнгийг түүний төрсөн эх нь Иргэний хуулийн 528 дугаар зүйлд зааснаар эзэмдэн авсан учир түүнд шилжих ёстой гэжээ.

Анхан шатны шүүх ИХ-ийн 515.1, 520.1 дэх хэсэгт зааснаар Л.Ю.Ж нь Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо 1 дүгээр 40 000-тын дүгээр байрны тоотод орших худалдаа үйлчилгээний зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийн 1/6 хэсгийг, Голомт банкны дансан дахь талийгаач Ж.Ч.Х-ийн 19 528 498 төгрөгийн, БНХАУ-ын Тариалангийн банк дахь картын дугаар дансан дахь мөнгөн хөрөнгийн 1/3 хэсгийг өв залгамжлан авах эрхтэй болохыг тогтоосон. Харин Иргэний хуулийн 532 дугаар зүйлийн 532.1 дэх хэсэгт зааснаар Ж.Ч.Л, Ж.Ш.И нараас 16 816 588 төгрөгийг гаргуулж Л.Ю.Ж-д олгож, Иргэний хуулийн 520 дугаар зүйлийн 520.1.1 дэх хэсэгт зааснаар Ж.Ч.Л, Ж.Ш.И нарт холбогдох Л. Ж.Б-ы гаргасан нэхэмжлэлийг бүхэлд нь, Ж.Ч.Л, Ж.Ш.И нарт холбогдох талийгаач Ж.Ч.Х-ийн өвлөгч болохыг тогтоолгох, Голомт банк, БНХАУ-ын Тариалангийн банк дахь мөнгөн хөрөнгөөс ногдох хэсгийг гаргуулах тухай Л.Ю.Ж-ын нэхэмжлэлийн шаардлагыг тус тус хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн өмгөөлөгчийн гаргасан давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Хяналтын шатны шүүхээс анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг аль алиныг хэвээр үлдээж хариуцагчийн гомдлыг хангахгүй орхисугай гэж шийдвэрлэсэн.²⁹

Хэргийн шүүхийн харьяалал. Энэхүү хэрэгт маргалдагч талуудын аль аль нь гадаадын иргэн байна. Мөн нас барсан этгээд нь МУ-ын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг бөгөөд маргааны гол зүйл болох хөрөнгө нь МУ-ын нутаг дэвсгэрт байх тул ИХШХШТХ-ийн 189 дүгээр зүйлийн 189.2.7. нэхэмжлэлийн зүйл нь өв залгамжлах эрх, өв залгамжлуулагчаас эд хөрөнгийг хуваах, гэрээслэл, үүрэг гүйцэтгэхтэй холбоотой бөгөөд өв залгамжлуулагч нас барахаасаа өмнө Монгол Улсад амьдардаг буюу оршин суудаг байсан, эсхүл тухайн өв хөрөнгө Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гэсэн үндэслэлээр МУ-ын шүүх энэхүү хэргийг хянан шийдвэрлэх эрхтэй байна.

Шийдвэр 3. Гэрлэлт цуцлуулж, хүүхдийн асрамж тогтоолгохтой холбоотой хэрэг.

Хятад улсын иргэн Б овогтой В нь Монгол Улсын иргэн Н.Э-тэй 2004 онд танилцаж, 2008 оноос хамтран амьдарч улмаар 2008 онд Монгол Улсад гэрлэлтээ бүртгүүлсэн. 2009 онд хүү В. Т төрсөн. Тэд 2004 оноос 2013 он хүртэл хамтдаа Венхай Хөх хотод амьдарч байсан. 2013 онд эхнэр Э нь таньдаг хүн, найз нөхөд байхгүй, ах дүү хамаатан садан байхгүй, ажил олдохгүй, харьцах халуун дулаан орчин байхгүй, өөрт нь хэцүү байна гэсэн шалтгаанаар төрсөн нутаг Монгол руу өөрийн хүсэлтээр явсан. Тэд тусдаа бараг 2 жил амьдарсан. Энэ хугацаанд хэн аль нь бие биенээ үгүйлээгүй, тусдаа амьдрах боломжтой гэдгээ ойлгосон, мөн

29 http://www.shuukh.mn/irgenhyanal/686/view?fbclid=IwAR2Mr3A71eljWqlXa81CyTHFId-PHWId5Wmf3VQStjRdZeph_245dXyO4Jiw.

бидний үзэл бодол таардаггүй хэвээр, цаашдаа хамт амьдаръя гэсэн ч үзэл бодол таарахгүй бие биетэйгээ ойлголцохгүй болсон. В нь өөрийн гэр бүлийн бизнес хийж тэндээ ажиллаж, амьдарч амин зуулгаа залгуулна. Монголд амьдрахад надад хийх ажил олдохгүй, гэр бүлээ, өөрийгөө ч тэжээж чадахгүй, миний эхнэр Хөх хотод дахин амьдрах боломжгүй, тэнд ажил хийх гэхээр хэлний асуудалтай тул байнга гэрт суух нь амьдралыг үзэх үзэл бодолтой нь харшилдаг. Эхнэр маань цаашдаа Хөх хотод амьдрахгүй гэсэн тул бид дахин хамт амьдрах боломжгүй болсон, бид гэр бүлээ цуцлуулахад ямар нэг маргаан байхгүй, хүүгээ би өөрийн асрамжид авна, бидэнд дундын хөрөнгийн маргаан байхгүй, миний виз дуусч байгаа. Иймээс бидний гэрлэлтийг цуцалж, хүүг маань миний асрамжид үлдээж өгнө үү. Бид тус тусын амьдралтай болсон тул эвлэрч амьдрах боломжгүй байгаа.

Талуудын аль аль энэ тал дээр нэг саналтай мөн хүүг ээжтэй нь уулзуулж байх тал дээр харилцан тохиролцсон байна.³⁰

Шүүх ИХШХШТХ-ийн 192 дугаар зүйлийн 192.1.1 “гэрлэгчдийн аль нэг нь Монгол Улсын харьяат иргэн буюу гэрлэх үедээ Монгол Улсын харьяат байсан бол” мөн хуулийн 192 дугаар зүйлийн 192.1-д “Монгол Улсын шүүх гэр бүлийн холбогдолтой хэргийг өөрийн харьяалалд авч хянан шийдвэрлэх ажиллагаа явуулна” гэж зааснаар хариуцагч Н.Энхчимэг нь Монгол Улсын иргэн тул хэргийн харьяалал зөрчөөгүй гэж үзэн хэргийг харьяалан шийдвэрлэсэн байна.

Шийдвэр 4. Монгол Улсын харьяат Б компани нь Г улсын харьяат Г-тэй Хамтран ажиллах гэрээ байгуулж үйл ажиллагаа эхэлсэн ч хэсэг хугацааны дараа Г нь гэрээнд заасан үүргээ биелүүлэхгүй болсноос үүдэн хамтын үйл ажиллагаа цаашид явагдахад хүндрэлтэй болсон бөгөөд Б нь удаа дараа Г-д хандан гэрээний үүргээ биелүүлж, төслийг хэрэгжүүлж дуусгахыг шаардсан ч амжилт олоогүй. Иймд Г-д хандан гэрээг цуцлах тухай мэдэгдлийг хүргүүлж, өөр компанитай хамтран төслөө үргэлжлүүлсэн байна. Гэтэл Г нь Д улсын олон улсын арбитра хандан Б-ийн эсрэг нэхэмжлэл гаргасан бөгөөд, Г нь хамтран ажиллахаас татгалзсан гэх тайлбарыг өгч, харин Г нь заавал хамтран ажиллахыг шаардсан байна. Г улсын хууль болон Монгол Улсын Иргэний хуулийн дагуу хамтран ажиллах гэрээнээс гарахыг хориглосон хэлцэл хүчингүйд тооцогдох боловч, арбитраын бүрэлдэхүүн Б-д Г-тэй үргэлжлүүлэн хамтран ажиллахыг даалгажээ. Энэхүү арбитраын шийдвэр нь талуудад 2021.10.28-ны өдөр ирсэн бөгөөд үүнийг гардаж авсан өдөр гэж тооцно. Гэтэл Г-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь 2021.11.29-ний өдөр Б-ын хуулийн этгээд харьяалагдах дүүргийн шүүхэд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулах хуудас бичүүлэхээр хүсэлт гаргажээ. Арбитраын ажиллагаа явагдсан улсын Иргэний процессын тухай хуульд заасны дагуу талууд шийдвэрийг гардан авснаас хойш 3 сарын дотор шийдвэрийг хүчингүй болгох, түдгэлзүүлэхээр хүсэлт гаргах эрхтэй ба энэ хугацаа нь 2022.01.29-нд дуусна. Энэ хүртэл талуудын хувьд шийдвэр хүчин төгөлдөр болоогүй гэж үзэх ч шүүх үүнийг үл харгалзан захирамж гаргаж, шийдвэрийг биелүүлэхээр гүйцэтгэх хуудас бичсэн байна. Талуудын хувьд хүчин төгөлдөр болоогүй арбитраын шийдвэрийг биелүүлэх асуудлыг шийдвэрлэх нь мөн л харьяаллын бус маргаан гэж тооцогдох ба нөгөө талаас Арбитраын тухай хуулийн 47.3 болон 6.2-т заасны дагуу талуудын хувьд арбитраын шийдвэр хүлээн авснаас хойш 90 хоногийн дотор дүүргийн шүүх хүлээн авч харьяалан шийдвэрлэсэн нь илтэд буруу, хууль бус болжээ. Угтаа энэ шийдвэрийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлыг шийдвэрлэх шүүх нь Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүх гэдэг нь хуульд тодорхой тусгагдсан байна.

30 <http://www.shuukh.mn/irgenanhan/46612/view>.

Шүүхэд шийдвэрлэгдэж буй ОУХЭЗ-н шинжтэй хэрэг маргааныг бүхэлд нь судалж, дүгнэлт хийхэд харьцангуй урт хугацаа шаардагдах бөгөөд сүүлийн жилүүдэд shuuh.mn цахим шийдвэрийн санд хэргийн оролцогчдын нэрний эхний үсгийг тавьж мэдээлдэг болсноор гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн оролцсон маргааныг судлахад бэрхшээлтэй болсныг энд дурьдах нь зөв болов уу. Дээр авч үзсэнчлэн, зарим маргааныг шийдвэрлэхэд шүүгч харьяаллын асуудлыг зөв тодорхойлон шалгаж, процессын ажиллагааг үргэлжлүүлж байгаа бол зарим маргааны тухайд, ямар үндэслэлээр шүүх харьяалан шийдвэрлэж байгаагаа шийдвэрт дурьдахгүй байгаа нь ч цөөнгүй тохиолддог.

3.2.Зэрэгцээ процессын ажиллагаа явагдахаас урьдчилан сэргийлэх /parallel proceeding/

Сүүлийн жилүүдэд олон улсын хувийн эрх зүйн салбарт чухлаар тавигдах болсон нэгэн асуудал бол зэрэгцээ процессын ажиллагаа, түүний сөрөг үр дагаварын асуудал юм. Энэ нь нэг хэргээр хоёр улсын шүүхэд эсхүл шүүх, арбитра зэрэг маргаан үүсэх тухай ойлголт бөгөөд, нэг хэргийг 2 шүүх нэгэн зэрэг шийдвэрлэх боломжгүй, тиймээс аль нэг нь татгалзах ёстой гэх үзэл дээр үндэслэдэг. Зэрэгцээ процессын ажиллагаанаас татгалзвал зохих онолын үндэслэлийг “forum non conveniens”, “lis alibi pendens” гэх ойлголтоор илэрхийлдэг.

Forum non conveniens нь хэргийг шийдвэрлэх зохимжгүй шүүх гэсэн утгатай ба нийтийн эрх зүйт орнуудад түгээмэл хэрэглэдэг. Гол агуулга нь нэг хэргийг 2 шүүхэд зэрэг шийдвэрлэхгүй, аль тохиромжтой шүүхийг тогтоож өгөх явдал юм. Forum non conveniens тогтооход зайлшгүй харгалзан үзвэл зохих асуудал нь:

- Өөр тохиромжтой шүүх байгаа эсэх;
- Талууд аль улсад оршин сууж байгаа;
- Нотлох баримт аль улсад байгаа, түүнийг олж авахад ямар ажиллагаа шаардагдах;
- Аль улсын эрх зүйг хэрэглэж маргаан шийдвэрлэх;
- Хөөн хэлэлцэх хугацаа;
- Шүүхийн шийдвэрийн биелэгдэх боломжтой байдал юм.³¹

Эдгээрийг харгалзан үзсэний үндсэн дээр хэргийг хянан шийдвэрлэх тохиромжгүй шүүх гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авахгүй байх нь зүйтэй байна.

Харин “Lis alibi pendens” нь эх газрын эрх зүйн тогтолцоот улсуудад өргөн хэрэглэдэг зохицуулалт бөгөөд хоёр өөр шүүхэд зэрэг хэрэг үүссэн бол хамгийн эхэнд хэрэг үүсгэсэн шүүх харьяалан шийдвэрлэнэ. Аль нэг улсын шүүх нь онцгой харьяалалтай байгаа эсэхийг хянана, онцгой харьяалал байвал тэр шүүх нь хянан шийдвэрлэнэ гэх үзэл дээр үндэслэсэн зохицуулалт юм. Энэ зарчмыг хуульд тусгасан улс бол Швейцарь бөгөөд зарим олон улсын гэрээнд ч тусгалаа олсон байх нь бий.

31 Cheshire, North&Fawcett. Private International law. 15th edition. Oxford 2017. P 202; Б.Тамир, Олон улсын хувийн эрх зүй. УБ 2019 он., 108 дахь тал.

Тухайлбал, Швейцарын ОУХЭЗ-н тухай хуулийн 9 дүгээр зүйлд:

“нэг ижил талууд нэг ижил шаардлага бүхий нэхэмжлэлийг гадаад улсын шүүхэд гаргасан бөгөөд тухайн гадаад улсын шүүх нь Швейцарьт хүлээн зөвшөөрөгдөхүйц шийдвэрийг боломжийн хугацааны дотор гаргахаар хүлээгдэж байгаа тохиолдолд Швейцарын шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаа түдгэлзүүлнэ”, 9.2-т “Швейцарьт хэрэг үүсгэсэн огноог тодорхойлоход хэрэг үүсгэхэд шаардлагатай эхний хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлсэн огноог баримтална. Эвлэрүүлэх ажиллагаанд оролцох тухай мэдэгдэл хүргүүлсэн байхад хангалттай”, 9.3-т “Швейцарьт хүлээн зөвшөөрөгдөхүйц гадаад улсын шийдвэрийг хүлээн авсан даруйд Швейцарын шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаа цуцална” хэмээн заасан байна.

Параллель процессын ажиллагаа явагдах нь маргааны талуудад цаг хугацаа, зардал ихээр гаргахаас гадна хэрэв 2 шүүх, эсхүл шүүх ба арбитр нь өөр өөр агуулга бүхий шийдвэр гаргасан тохиолдолд түүнийг хэрхэн биелүүлэх вэ гэх чухал асуудлыг хөндөнө. Олон улсын арбитрын ажиллагааны түүхэнд ийм тохиолдлууд гарч байсан ба нэг арбитр нь нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, харин нөгөө нь 300 сая долларын нөхөн төлбөрийг хариуцагч төлөх ёстой гэсэн шийдвэр гаргаж байв.³²

Иймээс зайлшгүй шийдвэрлэвэл зохих асуудлын нэг болон хувирч байгаа юм. Нөгөө талаас, *res judicata* хэмээх зарчим ч чухалд тооцогдох болсон ба нэгэнт шийдвэрлэсэн хэргийн хувьд дахин хэрэг үүсгэх боломжгүй гэж үздэг. Гэхдээ энэ нь гагцхүү шүүх буюу арбитрын шийдвэрлэсэн нэхэмжлэлийн агуулгын хувьд яригдах нь зүйтэй бөгөөд талуудын хооронд цаашид өөр асуудлаас үүдсэн маргааныг шүүх хүлээн авч шийдвэрлэх нь зүйтэй.

Арбитрын тухай хуулийн 10 дугаар зүйлд:

10 дугаар зүйл. Арбитрын хэлэлцээр ба шүүхэд нэхэмжлэл гаргах

10.1. Арбитрын хэлэлцээртэй боловч шүүхэд нэхэмжлэл гаргасан бөгөөд аль нэг тал тайлбар гаргахаасаа өмнө уг маргааныг арбитрын журмаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан бол шүүх аль нэг талын хүсэлтээр арбитрын хэлэлцээрийг хүчин төгөлдөр бус, эсхүл биелүүлэх боломжгүй гэж үзсэнээс бусад тохиолдолд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгоно.

10.2. Энэ хуулийн 10.1-д зааснаар нэхэмжлэл гаргасан тохиолдолд арбитр нь шүүхийн ажиллагаа явагдаж байх хугацаанд арбитрын ажиллагааг эхлүүлэх, эсхүл үргэлжлүүлэх, арбитрын үндсэн шийдвэр гаргах эрхтэй. гэж заасан нь шүүх болон арбитрт нэгэн зэрэг нэг ижил маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж болохоор зохицуулсан нь зохимжгүй болжээ.³³ Иймд, аль нэг маргаан таслах байгууллагад маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж дуусах хүртэл нөгөө нь түдгэлзэх зохицуулалтыг тусгах нь зүйтэй байна.

32 Ronald S. Lauder v. The Czech Republic, UNCITRAL /харьяалан шийдвэрлэсэн ч нэхэмжлэлийн шаардлагыг хангаагүй/ харин CME Czech Republic B.V. v. The Czech Republic, UNCITRAL /нэхэмжлэлийн шаардлагыг хангасан/.

33 Энэ зохицуулалтын тухай Д.Дүгэржав, Арбитрын тухай хуулийн товч тайлбарын 34-36 дахь талаас дэлгэрэнгүй үзнэ үү.

4. ОУИП-ЫН ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

2018 онд ОУХЭЗ-н Гаагийн бага хурал нь Америкийн ОУХЭЗ-н нийгэмлэгтэй хамтран хийсэн судалгааны үр дүнд, нэн ойрын хугацаанд хөгжүүлэх шаардлагатай салбар бол ОУИП, олон улсын эрх зүйн хамтын ажиллагаа мөн хэмээн үзжээ.³⁴ Шүүхийн харьяалал, олон улсын шүүхийн хамтын ажиллагаа, шүүхийн шийдвэрийн үр нөлөөтэй байдлаар дамжуулан хүний эрхийг хамгаалалтыг баталгаажуулах нь ойрын хугацаанд хийх ажлын нэг хэмээн тооцогдсон бол ОУИП-ын эрх зүйг дараах байдлаар хөгжүүлэх нь зүйтэй хэмээн төлөвлөснийг дор үзүүлье:

а/ ойрын хугацаанд хөгжүүлэхэд анхаарвал зохих асуудалд:

- 1/ шинэ технологийг суурьшуулах – байж болох хамгийн том, өргөн хүрээнд энэ ажлыг хийх бөгөөд холын зайнаас мэтгэлцээнд оролцох, электрон байдлаар нотлох баримтыг ирүүлэх, хүлээн авах асуудлыг одоо байгаа эрх зүйн хамтын ажиллагааны дүрэм журамд тулгуурлан шийдвэрлэх;
- 2/ гадаадын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх;
- 3/ Америкийн ОУХЭЗ-н нийгэмлэгээс боловсруулсан Шүүх ажиллагаанд улс дамнан оролцох зарчим хэмээх баримт бичгийг бүс нутгийн болон олон улсын түвшинд нэвтрүүлэх.

б/ дунд хугацаанд хөгжүүлэх асуудалд:

- 1/ гадаадын хууль тогтоомжийг олж авах боломж;
- 2/ *lis pendens* болон *denial of justice* зөрчлийн асуудал: шүүхийн харьяалал, шүүхээр хамгаалуулах эрхийг хангахад чиглэх;
- 3/ конвенцийг хэрэгжүүлэх явцад мониторинг хийх.

в/ урт хугацаанд:

- 1/ Урьдчилан сэргийлэх арга хэмжээ: олон улсын хамтын ажиллагааны механизмыг хөгжүүлэх;
- 2/ шүүхийн баримт бичгийг хүлээн зөвшөөрч, биелүүлэх: дижитал флатформыг хөгжүүлэх зэрэг болно.

Эндээс, харахад шүүхийн харьяалал, шүүхийн харьяаллын давхардлыг арилгах асуудал хамгийн гол чухал асуудлын нэг гэдэг нь тодорхой бөгөөд, энэхүү олон улсын хамтын ажиллагаа, судалгаанд идэвхитэй оролцсоны дүнд өөрийн орны эрх зүйг хөгжүүлэх боломжтой юм.

5. ОУХЭЗ-Н МАРГААНЫ ШҮҮХИЙН ХАРЬААЛЛЫН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ САНАЛ ЗӨВЛӨМЖ

Энэхүү судалгааны ажлын дүнд ОУХЭЗ-н хэрэг маргаан хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн дараах санал зөвлөмжийг дэвшүүлж байна:

34 HCCCH, ASADIP. The future of Private International Law and the challenges to the Hague Conference on Private International Law within next 25 years. 2018 Ned., P3.

1. Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үүднээс:
 - 1.1. ИХШХШТХ-д олон улсын шинжтэй хэрэг маргааны хүрээг тодорхойлох. Ингэснээр ямар тохиолдолд тухайн хэм хэмжээг шүүх хэрэглэх боломжтойг хуулиас шууд харах боломжтой ба харьяалал тодорхойлох асуудалд хуульч, шүүгчид нэг мөр ойлголттой болоход дөхөм болно;
 - 1.2. Шүүхэд эрх олгох. ИХШХШТХ-ийн 189-193-т зохицуулаагүй асуудлаар нэхэмжлэл гаргасан тохиолдолд харьяалан шийдвэрлэх эрх хэмжээг шүүх өөрөө тодорхойлох зохицуулалтыг хуульд тусгах;
 - 1.3. Илтэд харьяаллын бус ОУХЭЗ-н маргаан хянан шийдвэрлэсэн тохиолдолд үүсэх эрх зүйн үр дагаварыг тодорхойлсон зохицуулалтыг бий болгох /тухайлбал, арбитрын хэлэлцээртэй гэдгийг талууд тайлбарлаж байгаа ч шүүх шийдвэрлэсэн тохиолдолд/;
 - 1.4. Зэрэгцээ процессын ажиллагаа явагдахаас урьдчилан сэргийлэх зохицуулалт, зарчмыг хуульд тусгах.
2. Хууль хэрэглэх арга, журмыг боловсронгуй болгох үүднээс:
 - 2.1. ОУИП-ын эрх зүйн сургалтын хөтөлбөрийг бакалаврын ба хуульчдын давтан сургалтын түвшинд боловсруулж, хэрэгжүүлэх;
 - 2.2. ОУХЭЗ-н маргааны харьяаллын эрх зүйн зохицуулалтын талаархи харьцуулсан судалгаа болон гадаад улсын шүүхийн практик судалгааг хийх;
 - 2.3. Шүүхийн шийдвэрт ОУХЭЗ-н хэрэг маргааны харьяаллын үндэслэл, хэрэглэх хуулийн үндэслэлийг тодорхой заах, ингэснээр шүүхийн шийдвэрийн үндэслэл илүү тодорхой болох ба шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх давуу талтай;
 - 2.4. ОУИП-ын ажиллагааг шуурхай, чирэгдэлгүй болгох үүднээс эрх зүйн туслалцаа, хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлэх.

Ойрын хугацаанд эдгээр санал зөвлөмжийг зорилт болгон хэрэгжүүлснээр, олон улсын шинжтэй иргэний хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай, үндэслэлтэй болгох суурь тавигдах ба цаашид олон улсын гэр бүл, өв залгамжлал, олон улсын бизнесийн гэрээ зэргээс үүдэлтэй маргааныг шийдвэрлэхэд анхаарах асуудал, арга зүйн талаар тогтмол шинэ сургалт, судалгааг хийж хүртээл болгох нь зүйтэй байна.

НОМ ЗҮЙ

1. Б.Буянхишиг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй. УБ 2021 он
2. Д.Дүгэржав, Арбитрын тухай хуулийн товч тайлбар. УБ 2017 он.
3. Б.Тамир, Олон улсын хувийн эрх зүй. УБ 2019 он
4. Т.Мэндсайхан, Олон улсын хувийн эрх зүй. Улаанбаатар 2008 он.
5. Ц.Оюунаа, Олон улсын хувийн эрх зүй. УБ 2016 он.
6. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ 2008 он.
7. УДШ, Ханс Зайделийн сан. Иргэний хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай. УБ 2021 он.
8. ХЗДХЯ. Эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх нь. УБ 2009 он.
9. Cheshire, North&Fawcett. Private International law. 15th edition. Oxford 2017.
10. Dr. Heimo Shack. Internationales Zivilverfahrensrecht. 7 Auflage, München 2017.
11. HCCH, ASADIP. The future of Private International Law and the challenges to the Hague Conference on Private International Law within next 25 years.
12. Pippa Rogerson, Private International law- Jurisdiction. The Cambridge Law Journal Vol.6
13. Trevor C Hartley, Basic Principles of Jurisdiction in private international law: The European Union, The United States and England. International & Comparative Law Quarterly (online), Cambridge 2021.
14. www.shuukh.mn
15. www.hcch.net
16. www.unidroit.org
17. www.un.org

ДӨРӨВ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХГҮЙ БАЙГУУЛЛАГА

Судалгааг удирдсан:	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах
Судалгааг хянасан:	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн ухааны доктор С.Сүхбаатар
Судалгааг гүйцэтгэсэн:	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан Э.Анударь Эрдэм шинжилгээний ажилтан Б.Дүүрэнжаргал

УДИРТГАЛ

Иргэний эрх зүйн харилцаанд оролцогч нь иргэн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байна.¹ Иргэний хуульд иргэн, хуулийн этгээдийг тодорхойлсон хэдий ч хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын ойлголт, эрх, үүргийг нарийвчлан заагаагүй юм. Практикт хуулийн этгээдийн эрхгүй зарим байгууллага хуулийн этгээдийн эрх эдэлж, харин үүрэг хүлээхгүй байгаа бөгөөд тэдгээрийн эрх зүйн байдлыг тодорхойлсон хэм хэмжээ хоорондоо зөрчилдөж байна. Энэ нь зарим хууль тогтоомж Иргэний хуульд нийцэхгүй байгаагийн илрэл төдийгүй хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын эрх зүйн байдлыг судлах үндэслэл болж байна.

Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх, түүний төрлүүдийн эрх зүйн байдлыг хууль тогтоомжоор тодорхойлохдоо Иргэний хуулийн Дөрөвдүгээр бүлэгт зааснаас өөрөөр хуульчилснаас болж хуулийн этгээд гэдэг ухагдахууныг нэг мөр ойлгох, хэрэглэхэд бэрхшээлтэй байна.² Иймд хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг судалснаар зарим нэр томъёоны агуулгыг тодорхойлох боломжтой болох юм.

Тухайлбал, “аж ахуйн нэгж” гэдэгт хуулийн этгээд болон хуулийн этгээдийн эрхгүй этгээд хамаардаг³ бөгөөд төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж гэсэн ойлголтыг тодруулахын тулд хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг тодорхойлох шаардлага үүсч байна. Түүнчлэн нийтийн эрх зүйн этгээд гэсэн ойлголт нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс ялгаатай ойлголт эсэхийг тодруулахын тулд НЭЗЭ гэдэгт хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг хамааруулах асуудлыг судлах хэрэгтэй болно.

Манай улсын хувьд хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад сууц өмчлөгчдийн холбоо, хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар болон хамтран ажиллах гэрээний үндсэн дээр бий болсон байгууллагыг хамааруулж байна. Тодруулбал, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь хамтран ажиллах гэрээгээр болон бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөлийн, эсхүл хуулийн этгээдийн нэгдэл хэлбэрээр үйл ажиллагаа явуулж болно.

Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар нь хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болдог бол хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь улсын бүртгэлд бүртгүүлдэггүй онцлогоос үүдэн тус байгууллага эрх зүйн чадвартай эсэх нь тодорхойгүй байна.

Иймд өнөөдрийн байдлаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг судалж, тэдгээрийн эрх зүйн байдлыг тодорхойлох замаар Иргэний хуульд тусгасан хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын талаарх эрх зүйн зохицуулалтад үнэлгээ хийхийг зорилоо. Үүний тулд сууц өмчлөгчдийн холбоо, ойн нөхөрлөлийн эрх зүйн байдлыг тодруулж, практикт ямар эрх, үүрэг эдэлж эрх зүйн харилцаанд оролцож байгаад дүн шинжилгээ хийх юм.

1 Иргэний хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг

2 Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын хууль тогтоомж дахь хуулийн этгээдийн ойлголт, нэр томъёоны хэрэглээ, УБ, 2021. 5 дахь тал

3 Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэг

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХГҮЙ БАЙГУУЛЛАГЫН ОЙЛГОЛТ, ШИНЖ

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХГҮЙ БАЙГУУЛЛАГЫН ОЙЛГОЛТ

Хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг англи хэлэнд “entity without legal personality”, “unincorporated entity”⁴, орос хэлэнд “организация без статуса юридического лица” гэж нэрлэдэг бөгөөд манай улс уг нэр томъёог орос хэлнээс буулгасан байж болох юм. Эрх зүйн харилцааны субъектыг 3 үндсэн төрөлд хуваана. Үүнд⁵:

1. Хувь хүн, иргэн
2. Төр, байгууллага
3. Албан тушаалтан, ажилтан г.м.

Байгууллага бүхэн хууль зүйн тодорхой шалгуурыг хангасан үед эрх зүйн харилцааны субъект болдог. Уг шалгуур нь хуулийн этгээд байх чадвар юм. Хуулийн этгээд гэдэг нь эрх зүйн харилцаанд өөрийгөө төлөөлж, эрх, үүргийг хэрэгжүүлж, төр, иргэний өмнө болон шүүхэд хариуцлага хүлээх чадвартай, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж чадах, төсөв санхүү, зохион байгуулалтын бие даасан бүтэцтэй байгууллагын нэгж мөн.⁶ Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага гэдэгт хуулийн этгээдийн үндсэн шинжийг агуулдаггүй хүмүүсийн болон хуулийн этгээдүүдийн нэгдэл байж болно.⁷

Үүнээс харвал хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад эрх зүйн чадавх⁸ (legal personality) байхгүйгээс гадна хуулийн этгээдэд буй шинжийг агуулахгүй юм. Манай улсын хувьд Иргэний хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг иргэний эрх зүйн харилцааны оролцогч байхаар хуульчилсан бөгөөд үүнд хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар⁹, бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөл¹⁰, сууц өмчлөгчдийн холбоо¹¹, байгаль хамгаалах чиглэлээр байгуулагдсан байгаль орчныг хамгаалах, ой хамгаалах нөхөрлөл хамаарахаар заажээ. Ийнхүү ямар байгууллагууд хуулийн этгээдийн эрхгүй байхыг заасан хэдий ч тэдгээрийн шинж, эрх, үүргийг тодорхойлоогүйгээс гадна уг асуудлыг тухайлан судалсан эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл ховор байна. Иймд хуулийн этгээдийн эрх зүйн чадавх болон бусад шинжүүдийг дэлгэрүүлэн авч үзсэний үндсэн дээр хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг тодорхойлохыг оролдъё.

4 Уг нэр томъёо хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг илэрхийлэхгүй боловч шинжээрээ төстэй байгууллагыг илэрхийлэх Англо-Саксоны эрх зүйн бүлийн улсуудад хэрэглэгддэг нэр томъёо юм.

5 Д.Баярсайхан, Эрх зүйн онол. УБ, 1996. 148 дахь тал.

6 Мөн тэнд, 150 дахь тал.

7 Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. Шинжлэх ухааны тайлбар. УБ, 2015. 5 дахь тал.

8 “Legal personality” гэж хүнээс бусад этгээдийн эрх зүйн чадвар, чадамжийг хамтад нь илэрхийлж буй ерөнхий ойлголт юм. Англи хэлэнд “legal personality”, орос хэлэнд “правосубъектность” гэж хэлдэг бөгөөд энэхүү судалгааны хүрээнд монгол хэлэнд эрх зүйн чадавх гэж орчуулав.

9 Иргэний хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэг.

10 Иргэний хуулийн 481 дүгээр зүйлийн 481.1, 481.2 дахь хэсэг.

11 Иргэний хуулийн 143 дугаар зүйлийн 143.3 дахь хэсэг.

1.Хуулийн этгээдийн эрх зүйн чадавх

Иргэний эрх зүйн харилцаанд оролцохын тулд төрөөс хүлээн зөвшөөрсөн эрх зүйн чадавхтай байх шаардлага бий болдог.¹² Эрх зүйн чадавхыг зарим судлаачид эрх зүйн чадвартай адилтгаж авч үздэг. Харин зарим нь эрх зүйн чадвар, чадамжийн нийлбэр бөгөөд энэ нь зэрэг үүсч, дуусгавар болдог гэж тайлбарладаг байна.¹³

Хуулийн этгээдийн эрх зүйн чадавх хувь хүн болон төрийн эрх зүйн чадавхаас ялгаатай юм. Жишээ нь, хуулийн этгээд иргэний адилаар хөрөнгөө гэрээслэн үлдээж чадахгүй, мөн хууль зөрчсөн хэмээн хөрөнгийг төр шиг хураан авах эрхгүй байдаг. Харин иргэн, төр аль аль нь хуулийн этгээд шиг салбар, төлөөлөгчийн газраа байгуулах чадваргүй. Иймд хуулийн этгээдийн эрх зүйн чадавх түүний мөн чанараас урган гардаг байна.¹⁴ Үүнээс харвал, хуулийн этгээдийн эрх зүйн чадавх нь түүний салбар, төлөөлөгчийн газраар илрэн гарч байгаа тул тэдгээр нь хуулийн этгээдийн эрхгүй байх нь зүй ёсны хэрэг юм.

Эрх зүйн чадавх нь эрх зүйн чадвар болон чадамжийг өөртөө багтаах бөгөөд улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуулийн этгээдийг эрх зүйн харилцаанд оролцогч болохыг тодорхойлно. Энэ учраас эрх зүйн чадварыг заримдаа эрх зүйн чадавх гэж нэрлэдэг ч түүний нэг төрөл гэж оросын эрдэмтэн В.Ф.Яковлев үзжээ.¹⁵

Хуулийн этгээдийн эрх зүйн чадвар нь нийтлэг (ерөнхий) буюу иргэний эрх зүйн бүх төрлийн харилцаанд оролцох боломжтой болон тусгай (хязгаарлагдмал) буюу эрх зүйн тодорхой харилцаанд хязгаарлагдмал хүрээнд оролцох боломжтой байдаг. Иргэн, хувь хүн хуулиар зөвшөөрөгдсөн дурын эд хөрөнгийн болон амины эрхийг эдлэх боломжтой байдаг тул түүний эрх зүйн чадвар үргэлж ерөнхий байна. Харин хуулийн этгээдийн эрх зүйн чадвар хязгаарлагдмал (зорилгын) байдаг шалтгаан нь тэрээр хууль болон үүсгэн байгуулах баримт бичигт заасан зорилгодоо нийцсэн иргэний эрх эдэлж, үйл ажиллагаандаа таарсан үүрэг хүлээх юм.¹⁶

Оросын эрдэмтэн Е.А.Сухановын үзсэнээр хуулийн этгээд нь эрх зүйн чадамжтай юм. Жишээ нь, Швейцар улсын Иргэний хуулийн 54 дүгээр зүйлд хуулийн этгээдийн эрх зүйн чадамж хууль болон үүсгэн байгуулах баримт бичигт заасан хуулийн этгээдийн байгууллага байгуулагдсанаар үүснэ. Хуулийн этгээдийг эрх зүйн чадамжтай гэж үздэг бусад улсын жишээнд Украин болон Молдав улсыг дурдаж болно. ОХУ-ын Иргэний хуулийн 53 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хуулийн этгээд нь иргэний эрхийг хууль, бусад эрх зүйн акт болон дүрмийн дагуу үүссэн өөрийн байгууллагаар дамжуулан эдэлнэ гэжээ. Ингэснээр ОХУ-ын хууль тогтоогчид хуулийн этгээдийн эрх зүйн чадамжийг түүний байгууллагын эрх зүйн чадамжаар дамжуулан тодорхойлсон байна.¹⁷

12 Министерство образования Российской Федерации. Московская государственная юридическая академия. Калпин А.Г. (ред.), Масляев А.И. (ред.) Гражданское право. Часть первая. Учебник. 2-е изд., перераб. и доп. М., 2002. стр.94.

13 Мөн тэнд, стр.95.

14 Мөн тэнд.

15 Гордеева Ж.А., Правоспособность и правосубъектность: к вопросу о содержании и соотношении понятий. <https://cyberleninka.ru/article/n/pravosposobnost-i-pravosubektnost-k-voprosu-o-soderzhanii-i-sootnoshenii-ponyatiiv/viewer>.

16 Московский государственный университет имени М.В.Ломоносова. Е.А.Суханова (ред.). Гражданское право в 4-х томах. Том I. Общая часть. Учебник. 3-е изд., перераб. и доп. М., 2010.

17 Сабирова Л.Л., Теоритические и правовые основы юридических лиц в российском и зарубежном праве. Вестник экономики, права и социологии, 2014, №2. стр.143.

Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага улсын бүртгэлд бүртгүүлдэггүй тул хуулийн этгээдийн эрх зүйн чадвар, чадамж үүсэхгүй бөгөөд ийм байгууллага эрх зүйн чадавхгүй гэж хэлэхэд хилсдэхгүй болж байна. Өөрөөр хэлбэл, эрх зүйн харилцаанд өөрийн нэрээр оролцож, бие даан эрх эдэлж, үүрэг хүлээх боломжгүй юм.

2.Хуулийн этгээдийн шинж

Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь эрх зүйн чадавхгүй этгээд болохыг тодруулсан бөгөөд үүнийгээ дагаад хуулийн этгээдийн шинжийг бүрэн агуулах боломжгүй юм. Хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг хуулийн этгээдийн үндсэн шинжийг хэлбэрийн төдий агуулсан, ашгийн болон ашгийн төлөө бус зорилгод хүрэхийн тулд байгуулагдах боловч улсын бүртгэлд бүртгүүлдэггүй, түр зуурын шинжтэй зохион байгуулалтын нэгдэл¹⁸ гэж зарим судлаач тодорхойлсон байна. Энэ утгаар нь хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын шинжийг тодруулах боломжтой байх тул дэлгэрүүлэн авч үзье. Үүнд:

1. Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй;
2. Өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг;
3. Үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаварыг эд хөрөнгөөрөө хариуцдаг;
4. Нэхэмжлэгч, хариуцагч байж чадах;
5. Тодорхой зорилго бүхий;
6. Тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдэл байна.

Хуулийн этгээдийн шалгуурт хүрдэггүй хүмүүсийн нэгдлийг Иргэний хуульд тусгасан байдаг. Үүнд нийт 3 төрлийн хувь этгээдийн нэгдэл тухайлбал хамтран ажиллах гэрээний талууд, гэр бүлийн гишүүдийн нэгдэл (Иргэний хуулийн 128 дугаар зүйл) болон хамтран өв залгамжлагчид (Иргэний хуулийн 530 дугаар зүйл) багтана. Энэхүү хувь этгээдийн нэгдлийн гол онцлог шинж нь аливаа хөрөнгийг хэд хэдэн этгээд хамтдаа захиран зарцуулах эрхтэй байдаг оршино. Эдгээр тусгай хөрөнгө нь гэр бүлийн дундын өмч, өвлөгдөх гэж буй эд хөрөнгө болон хуулийн этгээдийн хөрөнгийг хамрах ба дээрх нэгдэлд оролцож буй хувь этгээдийн хөрөнгөөс тусгаарлаж авч үздэгээрээ хуулийн этгээдтэй төстэй.¹⁹ Хуулийн этгээдийн эрхгүй холбоо нь гишүүдээсээ салангид бие даан оршдоггүй гэж үздэг.²⁰ Иймд хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын гишүүн өөрийн нэрээр буюу хувь хүнийхээ эрх зүйн чадвар, чадамжтайгаар л хэлцэл хийх боломжтой байна.

Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээхгүй тул хариуцлагыг түүний гишүүд бие даан хариуцах юм. Харин хуулийн этгээдтэй тодорхой зорилго бүхий, зохион байгуулалтын нэгдэл байдгаараа төстэй байна. Судлаач Б.Улаанбаатарын үзсэнээр хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь тогтвортой үйл ажиллагаа эрхлэх бус түр зурын шинжтэй хүмүүсийн нэгдлийг ойлгохоор байна.

18 Б.Улаанбаатар, Иргэний эрх зүй-тайлбар толь. УБ, 2005. 137 дахь тал.

19 Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн удиртгал. УБ, 2002. 51 дэх тал.

20 McC, J. M. Trusts for Unincorporated Associations. Legal Entity and Perpetuity. *Virginia Law Review* 35, no. 8 (1949): 1068–90. <https://doi.org/10.2307/1069654>.

II.ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага үйл ажиллагаа явуулж болохыг улс болгон зөвшөөрөөгүй юм. Жишээ нь, БНСУ-д хувь хүнээс бусдаар аливаа байгууллага зайлшгүй хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлж, хуулийн этгээдийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг. Харин хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг хуулиараа хүлээн зөвшөөрдөг улс орнуудад бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөлийн хэлбэрээр түлхүү байгуулах боломжтой байна. Түүнчлэн эрх зүйн бүлээсээ хамааран хуулийн этгээдийг ойлгох сэтгэлгээ, онол, түүх, зарчим өөр тул хуулийн этгээдийн эрхгүй байгууллага үүсч хөгжсөн байдал ялгаатай болохыг анхаарах нь зүйтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсэгт олон нийтийн байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулсан. Иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх бол тэдгээрийн сайн дурын үндсэн дээр өөрсдийнх нь үнэнхүү итгэл үнэмшил, ашиг сонирхолд нийцсэн бөгөөд тэр нь нэр томьёоны хувьд эвлэл, эвсэл, холбоо, нам, зөвлөл гэх мэт байж болох бөгөөд аль ч нэрийг авсан байхаас шалтгаалахгүй гол зорилго нь нийгмийн болон эсхүл эвлэлдэн нэгдсэн хэсгийн ашиг сонирхлыг хамгаалахад оршино. Ардчилсан нийгэмд иргэд улс төрийн нийтлэг үзэл бодлын хувьд эвлэлдэн нэгдэх явдал чөлөөтэй байдаг учраас ямар ч нэртэй байгууллагад эвлэлдэн нэгдэж болдог. Гэхдээ эдгээр байгууллага нь нь ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж болохгүй гэдэг түгээмэл хэвшил байдаг.²¹

Хүмүүсийн нэгдэл ямар ч нэрээр байсан нийгмийн болон эсхүл эвлэлдэн нэгдсэн хэсгийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор эвлэлдэн нэгдэх эрхтэйг Үндсэн хуулиараа баталгаажуулсан учир хуулийн этгээдийн эрхгүй байгууллагаар дамжуулан иргэд хуулийн этгээд байгуулахгүйгээр эвлэлдэн нэгдэх боломжийг олгожээ. Уг байгууллагын эрх зүйн үндэс дан ганц эвлэлдэн нэгдэх эрхээр тайлбарлагдахгүй боловч чухал үндэслэл мөн болохыг тэмдэглэх нь зүйтэй.

1.ХБНГУ

ХБНГУ-ын Иргэний хуулийн 54 дүгээр зүйлд эрх зүйн чадваргүй холбооны талаар зохицуулсан. Үүнийг тодруулбал:

54 дүгээр зүйл. Эрх зүйн чадваргүй холбооны харилцаанд нөхөрлөлийн харилцааг зохицуулдаг хэм хэмжээг хэрэглэнэ. Ийм холбооны өмнөөс гуравдагч этгээдтэй хийсэн хэлцлээс үүсэх хариуцлагыг уг хэлцлийг түүний өмнөөс хийсэн этгээд хүлээнэ. Хэрвээ хэлцлийг хэд хэдэн этгээд төлөөлж хийсэн бол түүнээс үүсэх хариуцлагыг тус тусдаа бие даан хүлээнэ.²² Үүнээс харвал, бүртгэгдээгүй холбоонд хуулийн этгээдийн нэг төрөл болох нөхөрлөлийн хэм хэмжээ үйлчлэхээр байна. Монгол Улсын хувьд бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөл байж болохыг Иргэний хуульд заасан хэдий ч тэдгээрийн харилцааг зохицуулах хэм хэмжээ байхгүй юм.

21 Г.Совд, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ, 2000. 103 дахь тал.

22 Гражданское уложение Германии. Вводный закон к Гражданскому уложению. 3-е изд., перераб. М., 2008. стр.79.

2.ОХУ

Хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг орос хэлэнд “организация без статуса юридического лица” гэж нэрлэдэг бөгөөд Иргэний хуулиар бус, ОХУ-ын 1995 оны Холбооны тухай хуулиар зохицуулдаг. Тодруулбал, иргэд улсын бүртгэлд бүртгүүлээгүй холбооны хэлбэрээр нэгдэх боломжийг олгожээ.

Хуулийн этгээдээр бүртгүүлээгүй холбооны эрх:

- a. Өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг чөлөөтэй дамжуулах
- b. Хурал, цуглаан болон бусад уулзалтыг чөлөөтэй явуулах
- c. Гишүүн болон оролцогчдынхоо эрхийг төрийн эрх барих, гүйцэтгэх засаглалын байгууллага, бусад холбоодын өмнө хамгаалах эрхтэй.

Хуулийн этгээдээр бүртгүүлээгүй холбоо дараах эрхийг эдлэхгүй. Үүнд:

- a. Хэлцэл хийх;
- b. Салбар, төлөөлөгчийн газар байгуулах;
- c. Орон нутгийн нэгж байгуулах;
- d. Өөр бусад хуулийн этгээдийн төлөөлөх;
- e. Өөр бусад холбооны гишүүн байх;
- f. Үйлдвэрчний эвлэл байгуулах;
- g. Гишүүнчлэлийн төлбөр авах;
- h. Харилцах данс нээх;
- i. Улсаас буцалтгүй тусламж, хандив, хөрөнгө авах, төрөөс үнэ төлбөргүй орон байраар хангагдах эрх багтаж байна.²³

Үүнээс харвал, хуулийн этгээдийн эрхгүй холбоо нь хуулийн этгээдийн шинжийг агуулахгүйгээс үүдэн зарим эрхийг огт эдлэхгүй байна. Монгол Улсын хууль тогтоомжид эдгээр эрх, хязгаарлалтыг тодорхойлоогүй учир практикт тодорхойгүй байгаа зарим байгууллагын эрх зүйн байдлыг тодорхой болгоход ач холбогдолтой мэдээлэл юм.

3.Их Британи, АНУ

Англо-саксоны эрх зүйн бүлийн зарим оронд хуулийн этгээдийн эрхгүй байгууллага “unincorporated association” буюу хуулийн этгээдээр бүртгүүлээгүй холбоо болон “partnership” буюу нөхөрлөлийн хэлбэртэй байдаг. Жишээ нь, Их Британид Английн хуулийн дагуу ерөнхий болон тусгай статусаар эрх зүйн чадавхтай хэмээн бүртгүүлээгүй, тодорхой зорилгын төлөө нэгдсэн хүмүүсийн нэгдлийг ойлгож байна. Гэвч ийм холбоог тараах эрх зүйн зохицуулалт хангалтгүй төвшинд байдаг. Учир нь хуулийн этгээдийн эрхгүй холбоо нь гэрээний эрх зүй болон итгэмжлэлийн эрх зүйн зохицуулах зүйлийн уулзварт оршдог байна.²⁴

23 https://reg-nko.ru/sub/Obschestvennaya_organizaciya_bez_yur_lica.

24 Green, Brian. The Dissolution of Unincorporated Non-Profit Associations. The Modern Law Review 43, no. 6 (1980): 626–49. <http://www.jstor.org/stable/1095522>.

АНУ-д “нөхөрлөл”-ийг хуулийн этгээд гэж этгээд (хувь хүн болон хийсвэр) биш тул өөрийн нэрээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхгүй²⁵ гэж үздэг. Бүлэг хүмүүс өөрсдийн нийтлэг эрх, үүргийг гэрээгээр зохицуулаагүй нөхцөлд хууль зүйн хувьд ямар нэг ач холбогдолгүй байна. Мөн “холбоо” гэдэг бол гэрээний үүргээр холбогдож, хувь хүмүүсээс тусдаа эрх зүйн чадавх үүсгээгүй хүмүүсийн нэгдлийг хэлэхгүй юм. Харин холбооны хөрөнгө гишүүдийнхээ өмчлөлд байж, хөрөнгийн итгэмжлэл нэг эсхүл хэд хэдэн хүнд байхыг ойлгоно.²⁶

Brightman J “Re William Denby Sick and Benecolent Fund” бүтээлдээ хуулийн этгээдийн эрхгүй холбоо 4 аргаар татан буугдахыг дурджээ.

Тухайлбал, 1/гишүүдийнхээ сайн дурын үндсэн дээр; 2/холбооны дүрэмд холбоо шууд тарахаар заасан тусгай нөхцөл байдал бий болсон; 3/холбоо байнгын суурь шинжээ алдсан тохиолдолд; 4/шүүхийн харьяаллын дагуу татан буулгахыг “үндэслэлтэй бөгөөд шударга ёсонд нийцнэ” гэж үзсэн тохиолдолд холбооны үйл ажиллагаа дуусгавар болно.²⁷

Дүгнэвэл, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг улс болгон хуулиар хүлээн зөвшөөрдөггүй бөгөөд иргэний эрх зүйн харилцаанд оролцож буй байгууллага нь хуулийн этгээдийн хэлбэрээр л байгуулагдах шаардлагатай байна. Харин ХБНГУ, ОХУ, Их Британи, АНУ-д бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөлийг хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад хамааруулж байна. Тэдгээр нь хуулийн этгээдийн эрх зүйн чадавхгүй бөгөөд хэлцэл хийх, өөрийн нэрээр эрх, үүрэг олж авах, шүүхэд нэхэмжлэгч, хариуцагч байх чадваргүй юм.

Хуулийн этгээдийн эрх зүйн чадавхын агуулгад салбар, төлөөлөгчийн газар байгуулах чадвар багтдаг тул тэдгээр нь хуулийн этгээдийн эрхгүй байна. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах эрхгүй бөгөөд хэлцэл болон үйл ажиллагаанаас үүсэх үр дагавар, хариуцлагыг бүртгэгдээгүй холбооны гишүүд өөрсдийн нэрээр хүлээж байна.

ОХУ-ын хувьд бүртгэгдээгүй холбоог Холбооны тухай хуулиар зохицуулж байгаа бол уг харилцаанд ХБНГУ-д нөхөрлөлтэй холбоотой зохицуулалтыг хэрэглэхээр заажээ. Харин Монгол Улсын хувьд хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг зохицуулах хэм хэмжээ байхгүй, ийм төрлийн байгууллагын талаар бичсэн эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл дутмаг байгаагаас болж онол, практикийн зөрүү бий болох үндэс тавигджээ. Хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын эдлэх эрх гэхээсээ илүүтэй эдлэхгүй эрх буюу хязгаарлалтуудыг тодруулсан учир практикт үүссэн асуудлыг тодруулсны үндсэн дээр дүн шинжилгээ хийе.

25 Lister v. Vowell (1898) 122 Ala. 264, 267, 25 So. 565, 565.

26 Sturges, Wesley A. Unincorporated Associations as Parties to Actions. The Yale Law Journal 33, no. 4 (1924): 383–405. <https://doi.org/10.2307/788053>.

27 Мөн тэнд.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛС ДАХЬ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХГҮЙ БАЙГУУЛЛАГА, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХГҮЙ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад Иргэний хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6 дахь хэсэгт зааснаар хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар, мөн хуулийн 143 дугаар зүйлийн 143.3 дахь хэсэгт зааснаар сууц өмчлөгчдийн холбоо болон 281 дүгээр зүйлийн 281.1 дэх хэсэгт тодорхойлсон бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөл хамаарч байна. Тухайн байгууллагын гишүүд нь иргэний эрх зүйн чадвартай байх тул иргэний эрх зүйн харилцаанд оролцсоны үр дагаврыг тухайн хуулийн этгээдийн эрхгүй байгууллага хариуцахгүй, гишүүд нь хариуцдаг онцлогтой юм.

Манай улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хэд хэдэн хуульд хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад хамаарах байгууллагыг нэрлэх, эсхүл тус байгууллагын аливаа харилцаанд оролцох эрхийг тодорхойлсон байна. Эдгээрт:

- Татварын ерөнхий хууль /2019/-ийн 6 дугаар зүйлийн 6.1.47 дахь заалтад зааснаар хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь тухайн хуульд тодорхойлсон “этгээд”-д, Өрсөлдөөний тухай хууль /2010/-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт болон Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль /2019/-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад зааснаар хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь “аж ахуй эрхлэгч” болон “аж ахуйн нэгж”-д тус тус хамаарахаар байна.
- Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль /2020/-ийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэг болон Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль /2019/-ийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт зааснаар нам эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага буюу сонгуулийн сурталчилгааг эрхлэн явуулах байгууллага нь хуулийн этгээдийн эрхгүй байна.
- Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль /2012/-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтад зааснаар хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогч тал болж болох бөгөөд Өмгөөллийн тухай хууль /2019/-ийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтад зааснаар хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь өмгөөллийн үйлчилгээ авах боломжтой буюу үйлчлүүлэгчид хамаарч болохоор байна.
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /2016/-ийн 18 дугаар зүйлд зааснаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүн, хуулийн этгээд, захиргааны байгууллага оролцох эрхтэй бөгөөд хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл шүүгч захирамж гарган оролцуулж болно. Өөрөөр хэлбэл, шүүгч захирамж гаргаагүй тохиолдолд хуулийн этгээдийн эрхгүй байгууллага захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжгүй байна.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2017/-ийн 1.4 дүгээр зүйлийн 1.13 дахь заалтад зааснаар хуулийн этгээдийн эрхгүй байгууллага

хэргийн оролцогчид хамаарахгүй бөгөөд тус хуулийн 8.5 дугаар зүйлд тодорхойлсон гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэх, сэргээлгэхээр шаардлага тавьж буй этгээд буюу иргэний нэхэмжлэгч болох боломжгүй байна. Мөн тус хуулийн 8.6 дугаар зүйлд заасан иргэний хариуцагч болохгүй юм.

- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.1 дүгээр зүйл болон 3.2 дугаар зүйлд зааснаар хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны холбогдогч, хохирогчид хамаарахгүй буюу тус хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэгт тодорхойлсноор хэргийн оролцогч болохгүй байна.
- Хуулийн этгээдийн салбар төлөөлөгчийн талаарх хуулийн зохицуулалт нь: Банкны тухай хууль /2010/-ийн 3 дугаар зүйлийн 3.1.13 дахь заалтад зааснаар банкны нэгж буюу банкны салбар, төлөөлөгчийн газар, тооцооны төв, тооцооны касс зэрэг, Хөрөнгө оруулалтын тухай хууль /2013/-ийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтад зааснаар гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар нь тус тус хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад хамаарна.
- Бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөлийн талаарх хуулийн зохицуулалт нь: Ашигт малтмалын тухай хууль /2006/-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.23 дахь заалтад зааснаар бичил уурхай эрхлэх, Байгаль орчныг хамгаалах тухай хууль /1995/-ийн 3 дугаар зүйлийн 3.2.8 дахь заалтад зааснаар байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл нь Иргэний хуулийн 481 дүгээр зүйлд заасан бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөлд хамаарах боломжтой буюу хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байна.

Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлдэггүй боловч хуульд аж ахуйн нэгж байхаар заасан тул татвар төлөгчөөр бүртгүүлэх боломжтой юм. Үүнийг Татварын ерөнхий газрын дарга, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/268, А/1345 дугаартай хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтад заасан. Тодруулбал, тус хавсралтын 2 дугаар зүйлийн 2.2.1 дэх заалтад хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдлага, төлөөлөх эрх бүхий албан тушаалтны ирүүлсэн хүсэлтийг татварын алба хянан шийдвэрлэхээр заажээ. Мөн зүйлийн 2.2.3, 2.2.4 дэх заалтад зааснаар бүртгэх эрх бүхий байгууллага, Татварын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан (ТБМНС)-ийн мэдээллийг үндэслэн хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад татвар төлөгчөөр бүртгүүлэх мэдэгдэл хүргүүлж, ийнхүү хүргүүлснээс хойш 7 хоногийн дотор энэхүү журмын 2.2.1, 2.2.2-т заасны дагуу татвар төлөгчөөр бүртгүүлэх юм.

Хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг бүртгэх эрх бүхий байгууллагын мэдээлэл гэдэгт хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын оноосон нэр, бүртгэлийн дугаар, бүртгүүлсэн он, сан, өдөр, хариуцлагын хэлбэр, өмчийн хэлбэр, салбарын мэдээлэл хамаарахаар заасан байна. Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь оноосон нэртэй байх боломжтой хэдий ч хуулийн этгээд шиг хариуцлагын хэлбэр, өмчийн хэлбэртэй байх боломжгүй бөгөөд салбар байгуулах талаар ойлголт байдаггүй. Иймд хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг татвар төлөгчөөр бүртгүүлэх тухай Татварын ерөнхий газрын дарга, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын холбогдох журам нь Иргэний хуультай шууд зөрчилдөж байна.

Ийнхүү ТБМНС-д бүртгүүлэхээр заасан хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад дараах байгууллага хамаарч байна. Үүнд:

- Олон нийтийн байгууллага;
- Сууц өмчлөгчдийн холбоо;
- Элчин сайдын яам, консулын газар;
- Салбар нэгж;
- Олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллага;
- Ой хамгаалах зорилгоор байгуулсан нөхөрлөл;
- Бичил уурхай эрхлэгч бүртгэгдээгүй нөхөрлөл;
- Засгийн газрын тусгай сан, комисс, хороо, үндэсний зөвлөл;
- Төсөл хэрэгжүүлэгч нэгж;
- ОУ-ын байгууллагын Төлөөлөгчийн газар;
- Удирдах байгууллага нь МУ-д байрладаг аж ахуйн нэгж;
- Үйл ажиллагааны удирдлагыг МУ-аас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгж;
- Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч;
- Нам;
- Төлөөний газар;
- Төлөөлөгчийн газар;
- Салбар;
- Олон улсын байгууллага зэрэг юм.²⁸

Дээрх жагсаалтаас үзвэл, хуулийн этгээдэд хамаарах зарим этгээдийг хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад хамааруулан бүртгэхээр заасан нь учир дутагдалтай байна. Жишээ нь, олон нийтийн байгууллагад Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн этгээд болон хуулийн этгээдийн эрхгүй байгууллага хамаарах бөгөөд эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөө хэрэгжүүлж буй хүмүүсийн нэгдлийг илэрхийлэх өргөн агуулгатай ойлголт билээ. Иймд энэ нь хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад хамаарахгүй юм.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад “Засгийн газрын тусгай сан” гэж Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зориулалттай төсвийн тусгай дансыг ойлгохоор заажээ. Ингэснээр үүнд байгаль орчин, уур амьсгалын сан, боловсролын зээлийн сан, бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан, гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Засгийн газрын нөөц сан, зэвсэгт хүчний хөгжлийн сан, ирээдүйн өв сан, кино урлагийг дэмжих сан, мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан, нийгмийн даатгалын сан, нийгмийн халамжийн сан, соёл, урлагийг дэмжих сан, спортыг дэмжих сан, төсвийн тогтворжуулалтын сан, улсын авто замын сан, хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, хөдөө аж ахуйг дэмжих сан, шинжлэх ухаан, технологийн сан, эрүүл мэндийг дэмжих сан, эрүүл мэндийн даатгалын сан, өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан зэргийг хамааруулдаг.

28 www.etax.mta.mn холбоосоор нэвтрэн орж дээрх жагсаалтыг үзэх боломжтой.

Тухайлбал, ирээдүйн өв сан нь Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтад зааснаар төрийн өмчит хуулийн этгээдэд хамаардаг. Засгийн газрын тусгай сангийн бусад төрөл нь нийтийн эрх зүйн хуулийн этгээд, эсхүл төрийн өмчит хуулийн этгээдийн алинд хамаарах нь тодорхойгүй байдаг ч хуулийн этгээдийн эрхгүй байгууллага биш юм. Иймд Засгийн газрын тусгай санг хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад хамааруулан татвар төлөгчөөр бүртгэх үндэслэлгүй байна. Түүнчлэн хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг “төлөөний газар”, “төлөөлөгчийн газар”, “салбар нэгж” гэсэн олон янзын нэр томъёогоор илэрхийлэх нь зохимжгүй юм.

Хуулийн этгээд нь Иргэний хуулийн 25 дугаар зүйлд заасан шинжийг өөртөө агуулдаг. Харин хуулийн этгээдийн эрхгүй байгууллага эрх зүйн чадавхгүй боловч иргэний эрх зүйн харилцааны оролцогч байх чадвартай байгаа нь анхаарал татсан асуудал юм. Хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг Иргэний хуульд бие даан эрх, үүрэг эдлэхгүй, бүртгэлээр дамжуулан эрх зүйн чадвар олж аваагүй байгууллага байх агуулгаар нь зохицуулсан хэдий ч практикт зарим хуулийн этгээдийн эрхгүй байгууллагууд хуулийн этгээдийн нэгэн адил эрх эдэлж байна. Иймд бусад хууль тогтоомжоор хуулийн этгээдийн эрхгүй байгууллага болох сууц өмчлөгчдийн холбоо болон ойн нөхөрлөлийн эрх зүйн байдлыг хэрхэн тодорхойлж, практикт эдгээр нь ямар эрх, эдэлж үүрэг хүлээж байгааг тодруулан дүн шинжилгээ хийе.

1.Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал

Сууц өмчлөгчдийн холбоо нь нийтийн зориулалттай орон сууцны нэг байшинд хоёр буюу түүнээс дээш өрх сууц өмчлөгч болсон тохиолдолд дундын өмчлөлийн эд хөрөнгийг дундаа өмчлөх эрхийг хэрэгжүүлэх, орон сууцны ашиглалтын хэвийн байдлыг хангах, сууц өмчлөгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор байгуулагдана.²⁹ Сууц өмчлөгчдийн холбоог Иргэний хууль (2002)-иас гадна Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль (2003)-аар тодорхойлдог. Эдгээр хуульд СӨХ-ны эрх зүйн байдлыг хэрхэн тодорхойлж байгааг хуулийн этгээдийн шинжийг агуулахгүй байх гэсэн шалгуураар авч үзье.

Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй эсэх:

СӨХЭЗБНЗОСБДӨЭХТХ-д зааснаар СӨХ-ны өмчлөлийн хөрөнгө бус сууц өмчлөгчдийн хамтран өмчлөх хөрөнгийг тодорхойлсон буюу “Сууц өмчлөгчид нь дундын өмчлөлийн эд хөрөнгийг дундаа хамтран өмчилнө” хэмээн заасан байна. Мөн түүнчлэн орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгөд хамаарах хөрөнгийг тодорхойлсон байх бөгөөд эдгээрт:

- орон сууцны байшингийн гадна хана, даацын хана, багана, доод хонгил, дээвэр, дээврийн хонгил, цахилгаан болон явган шат, шатны хонгил, сууцны бус зориулалттай техникийн болон нэгдүгээр давхрын үйлчилгээний өрөө, сууц хоорондын талбай, түүний тагт, сууцны доторх дундын өмчлөлийн зүйл, тоног төхөөрөмж, орцны цонх, хаалга, довжоо, саравч, хог зайлуулах хоолой, орон сууцны байшингийн халаалт болон халуун, хүйтэн усны шугам сүлжээний удирдах зангилааны анхны хаалт, цахилгааны оролтын

29 Иргэний хуулийн 143 дугаар зүйлийн 143.1 дэх хэсэг.

самбар, холбооны шугамын давхрын холболтын хайрцаг хүртэлх, шалны +0.00 тэмдэгтээс дээших бохир усны шугам сүлжээнүүд, тухайн орон сууцны дээрх болон доорх нийтийн зориулалттай усан сан, машины зогсоол, тэдгээртэй адилтгах байгууламж зэрэг эд хөрөнгө;

- холбооны сангийн хөрөнгө хамаарна. Холбооны дүрэмд дундын өмчлөлийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах журмыг тусгахаар хуульчилжээ.

Мөн түүнчлэн орчны газар хэмээх ойлголт нь СӨХ-ны хувьд онцлог зохицуулалт бөгөөд СӨХЭЗБНЗОСБДӨЭХТХ-д тодорхойлсноор “орчны газар” гэж тухайн орон сууцны байшингийн суугчид, өмчлөгчдөд зориулагдсан ногоон байгууламж, зүлэг, хүүхдийн тоглоомын талбай, сүүдрэвч, явган хүний зам, авто машины зогсоол, тэдгээртэй адилтгах байгууламж бүхий нийтийн эдэлбэрийн газрыг хэлнэ. СӨХ-ны нийт гишүүдийн хурлаар сууц өмчлөгч сууцныхаа зориулалт, төлөвлөлтийг өөрчлөх зорилгоор орчны газарт барилга барих эсэхийг шийдвэрлэх бөгөөд СӨХ-ны гүйцэтгэх захирал нь орчны газрыг ашиглах тухай хүсэлт гаргах, газар ашиглах гэрээ байгуулах эрхтэй байдаг. Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т заасан «...ашиглуулж болно...» гэдгийг Сууц өмчлөгчдийн холбоо нь орчны газрыг зөвхөн энэ зүйлд заасан зориулалтаар л ашиглах бөгөөд тухайн газрыг бусдад ашиглуулах, ашиглах зөвшөөрөл олгох, түрээслэх, барьцаалах, газрын ашигтай чанарыг гаргаж хэрэглэх эрх эдлэхгүй гэж ойлгох талаар Улсын дээд шүүх тогтоол гаргасан байна.³⁰

Дээрх дундын өмчлөлийн эд хөрөнгө нь СӨХ-ны өөрийн хөрөнгөд хамаарахгүй бөгөөд сууц өмчлөгчдийн хамтран өмчлөх дундын өмч байх шаардлагатай юм. Орчны газар дээр өөр этгээд барилга, байгууламж барих зэргээр газрын эрхэд халдах тохиолдолд сууц өмчлөгчдийн холбоо бус сууц өмчлөгчид шаардлага гаргадаг, тус газрыг хамгаалах нь зүйтэй.

Өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг эсэх:

СӨХЭЗБНЗОСБДӨЭХТХ-д зааснаар холбооны дүрэмд сууц өмчлөгчийн болон СӨХ-ны эрх, үүргийг тусгах; мөн түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол холбоо нь гишүүдийн хүлээх үүргийг, гишүүд нь холбооны хүлээх үүргийг хариуцахгүй; холбоо нь дундын өмчлөлийн эд хөрөнгө, шугам сүлжээний засвар, үйлчилгээг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд засвар, үйлчилгээ хийлгэх мэргэжлийн байгууллагаа чөлөөтэй сонгох эрхтэй хэмээн зааснаас үзвэл СӨХ нь өөрийн нэрээр гэрээ байгуулах эрхийг олгожээ.

Түүнчлэн Газрын тухай хуулийн 44¹ дүгээр зүйлд СӨХ орчны газрыг ашиглах гэрээг Засаг даргатай байгуулахаар заасан нь Монгол Улсын Үндсэн хууль болон Иргэний хуульд нийцэхгүй байна. Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно” гэж заасан. Үүний дагуу хуулийн этгээдийн эрхгүй байгууллага газар ашиглах эрх эдлэхгүй юм. Гэтэл СӨХ-нд орчны газрыг “газар ашиглуулах гэрээ”-ний үндсэн дээр олгодог нь эргээд газрын маргаан үүсэхэд СӨХ нэхэмжлэгч, хариуцагч болж шүүхэд өөрийгөө төлөөлж чадахгүй байдалтай байгаа нь зөрчилдөөн үүсгэж байна. Тодруулбал, СӨХ хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын хувьд гэрээний нэг тал болохгүй бөгөөд уг хэлцлийн үндсэн дээр бий болох хариуцлагыг хүлээх чадваргүй байна.

30 <https://legalinfo.mn/mn/detail/16231242409511> УДШ тогтоол, №15, 2008.

Үүнийг Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, доктор Н.Баярмаа: “Сүүлийн жилүүдэд сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааны алдаа, хариуцлагагүй байдлын улмаас өмчлөгчдөд болон гуравдагч этгээдэд гэм хор учирсан тохиолдлууд багагүй гарах болсон бөгөөд эдгээр хэрэг маргаанаас учирсан хохирлын хэмжээ хэдэн зуугаас хэдэн саяын хэмжээнд тоологдох боломжтой. Нэгэнт үүргийн эрх зүйн харилцаанд оролцох эрх зүйн чадвартай бол уг субъектын үйлдлээс гарах үр дагаврыг хэн нэг этгээд хариуцан арилгадаг механизмыг хууль тогтоогч бий болгох учиртай. Энэ шалтгаанаар сууц өмчлөгчдийн холбооны үйлдлийн үр дагаврыг хариуцах этгээд, тэдгээрийн хүлээх хариуцлагын хэмжээг тодорхой болгох шаардлага үүсэж байна. ...Иргэний эрх зүйн хуулийн этгээдийн эрхгүй холбоо ба нөхөрлөлийн талаарх бие даасан концепц байдаг ба эдгээрийг эрх зүйн чадвартай гэж үзэх үндэслэл, шалтгаан нь практикаас урган гардаг. Тодруулбал, хуулийн этгээдийн эрхгүй хэдий ч холбоо ба нөхөрлөлийн удирдлага нь холбооны нэрийн өмнөөс үйлчилгээ авах, бүтээгдэхүүн худалдан авах гэх мэт гэрээ хэлцэл байгуулах шаардлага үүсдэг. Эдгээр гэрээ хэлцлийг холбоо сууц өмчлөгчдийн нэрийн өмнөөс бус өөрийн нэрийн өмнөөс байгуулдаг, гэрээний нэг тал нь аль нэг сууц өмчлөгч бус холбоо байдаг. Энэ агуулгаар холбоо нь хуулийн этгээдийн эрхгүй буюу эрх зүйн чадамжгүй хэдий ч эрх зүйн чадвартай гэж үзэх шаардлага үүсэж байна.”³¹ гэж үзжээ.

Ийнхүү сууц өмчлөгчдийн холбоо нь хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын хувьд өөрийн нэрээр эрх эдэлж, үүрэг хүлээхгүй хэдий ч бие даан гэрээ байгуулах, газар ашиглах эрхийг Газрын тухай хууль болон СӨХЭЗБНЗОСБДӨЭХтХ-иар олгосон нь хууль дээдлэх зарчмыг зөрчиж байна. Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хуулиар хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь газар ашиглах эрхгүй ч сууц өмчлөгчдийн холбоонд дараах хэмжээний орчны газрыг ашиглуулахаар олгосон байна.

Хүснэгт 1. УБ хотын хэмжээнд СӨХ-нд ашиглуулахаар олгосон газрын хэмжээ³²

№	Дүүрэг	Сууц өмчлөгчдийн холбооны тоо	Ашиглуулахаар олгосон газрын хэмжээ
1	Багануур	10	188,624 м ²
2	Баянгол	123	539,132 м ²
3	Баянзүрх	154	745,920 м ²
4	Сонгинохайрхан	16	80,260 м ²
5	Сүхбаатар	81	271,345 м ²
6	Налайх	9	65,340 м ²
7	Чингэлтэй	28	100,384 м ²
8	Хан-Уул	37	205,137 м ²
	НИЙТ	459	2,198,780 м ²

31 Н.Баярмаа, Нийтийн зориулалттай орон сууцны өмчлөх эрх ба сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал. 2020, 10-11 дэх тал. <https://legaldata.mn/buteel/pdf?id=829>.

32 Газрын Кадастрын нэгдсэн мэдээллийн санд 2020 оны 8 дугаар сарын байдлаар бүртгэгдсэн тоон үзүүлэлт.

Иймд СӨХ хуулийн этгээдийн эрхгүй байгууллага хэрнээ хуулийн этгээдийн эрх эдэлж байгаа асуудлыг нэг мөр цэгцлэх шаардлагатай байна.

Үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг эсэх:

СӨХЭЗБНЗОСБДӨЭХТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсэгт “Гүйцэтгэх захирал холбооны эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаарх бүх гишүүдийн болон удирдах зөвлөлийн хурлаас тогтоосон эрхээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглах зэрэг үйл ажиллагаанаас холбоонд хохирол учруулсан бол уг хохирлыг өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр барагдуулна” гэж заасан бөгөөд холбоонд учирсан хохирлыг гүйцэтгэх захирал барагдуулах тухай зохицуулалт байна. Харин холбоо нь эрх зүйн чадавхгүй тул өөрийн хөрөнгөөр хариуцлага хүлээх чадваргүй. Гэвч сууц өмчлөгч болон гуравдагч этгээдэд хохирол учруулсан маргаан практикт гарч байгаа тул холбоог эрх зүйн чадвартай болгох шаардлага үүсэхийг үгүйсгэхгүй юм.

Нэхэмжлэгч, хариуцагч байж чадах эсэх:

Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь эрх зүйн чадавхгүй тул хуулийн этгээдийн нэг шинж болох шүүхэд өөрийн нэрийн өмнөөс нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох боломж хязгаарлагдмал байдаг. Гэтэл 2008 оны Улсын дээд шүүхийн тогтоолоор³³ “Иргэний эрх зүйн харилцааны оролцогчийн хувьд гэрээний болон гэрээний бус үүргийн харилцаанаас үүссэн маргаанд, мөн Иргэний хуулийн 149 дүгээр зүйлд зааснаар сууц өмчлөгч хуульд заасан үүргээ биелүүлэхгүй, зөрчил гаргасан тохиолдолд Сууц өмчлөгчдийн холбоо өөрийн төлөөлөгчөөр дамжуулан шүүхэд нэхэмжлэл гаргах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор оролцох эрхтэй” хэмээн тайлбарлажээ. СӨХ-ны нэхэмжлэгч, хариуцагч байх эрх хэмжээг Улсын дээд шүүх тогтоол гарган шийдвэрлэх учиргүй бөгөөд түүний эрх зүйн байдлыг гагцхүү хуулиар тогтооно.

ИХШХШТХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт бусдын эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалж байгаа этгээд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд энэ хуулийн 25-р зүйлд заасны дагуу оролцож болохоор заасан. Эдгээр этгээдэд үйлдвэрчний байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллага ордог байна.³⁴

Ийнхүү СӨХ иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагчаар бус бусдын эрх, эрх чөлөө, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг хамгаалж байгаа этгээдийн хувиар оролцох боломжтойг хуулиар тодорхой заасан байна. Иймд СӨХ-ны иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хүрээ хязгаар, эрх, үүргийг тодруулж, эрх зүйн байдлыг нь тодорхой болгох шаардлагатай.

СӨХ нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоходоо ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт зааснаар шүүгчийн захирамж гарснаар оролцож болно. Харин эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд СӨХ оролцох боломжгүй байна. Учир нь хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй,

33 <https://legalinfo.mn/mn/detail/16231241946031> УДШ тогтоол, № 26, 2008.

34 Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ, 2007, 108 дахь тал.

зөрчлийн шийтгэл оногдуулахгүй юм.³⁵ Иймд СӨХ ч мөн хэрэг хариуцах чадваргүй бөгөөд бүх хэрэг маргаанд нэхэмжлэгч, хариуцагч болохгүй.

Гэтэл 2021 онд иргэний болон захиргааны хэргийн анхан шатны шүүхээс шийдвэрлэсэн хэрэг маргаанд СӨХ оролцсон байдлыг дараах хүснэгтээс үзэх боломжтой. Үүнд:³⁶

Хүснэгт 2. СӨХ-ны иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон байдал (2021 оны байдлаар)



Цахим шийдвэрийн санд Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны шийдвэрүүдээс СӨХ-той холбоотой нийт 47 шийдвэр байх бөгөөд эдгээрээс 42 хэрэгт нэхэмжлэгчээр, 4 хэрэгт хариуцагчаар, 1 хэрэгт гуравдагч этгээдээр тус тус оролцсон байна.

Хүснэгт 3. СӨХ-ны захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон байдал (2021 оны байдлаар)



Харин захиргааны хэргийн шүүх хуралдаанд оролцсон байдлыг авч үзвэл 2021 оны байдлаар СӨХ оролцсон ЗХАШШ-ийн 5 шийдвэр байх бөгөөд эдгээрээс нэхэмжлэгчээр оролцсон 2, гуравдагч этгээдээр оролцсон 3 хэрэг байна.

35 Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 06-р сарын 10-ны өдрийн 128/ШШ2021/0413 дугаар шийдвэр, www.shuukh.mn.

36 Эдгээрийг шүүхийн шийдвэрийн цахим сан буюу www.shuukh.mn цахим хаягаас хайж, хайлтын илэрцийг түүвэрлэн дүгнэв.

Тодорхой зорилго бүхий эсэх:

Иргэний хуулийн 143 дугаар зүйлийн 143.1 дэх хэсэгт тодорхойлсноос үзвэл СӨХ нь дараах зорилгоор байгуулагдана. Үүнд:

- дундын өмчлөлийн эд хөрөнгийг дундаа өмчлөх эрхийг хэрэгжүүлэх;
- орон сууц ашиглалтын хэвийн байдлыг хангах;
- сууц өмчлөгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зэрэг юм.

Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь хуулийн этгээдтэй харьцуулахад тодорхой зорилготой байдаг хэдий ч энэ нь эрх зүйн тусгай (зорилгын) чадвартай болохыг илэрхийлэхгүй. СӨХ хуулийн этгээдийн зарим эрхийг эдэлж (газар ашиглах, шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох) байгаа нь тухайн зорилгоо хэрэгжүүлэхэд нэг талаараа дэмжлэг үзүүлж байгаа мэт боловч нөгөө талаараа дундын өмчлөлийн эд хөрөнгийг дундаа өмчлөх эрхийг дангаараа дур мэдэн хэрэгжүүлэх нөхцлийг бий болгожээ.

Тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдэл эсэх:

Тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдэл байх шинж нь тухайн хуулийн этгээд өөрийн зорилго, чиг үүргээ хэрэгжүүлэхэд чиглэсэн удирдах байгууллага, дотоод бүтэцтэй байхыг хэлнэ.³⁷ Зарим судлаачийн үзэж буйгаар хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад уг шинж байхгүй бөгөөд тодорхой зорилгод хүрэхийн тулд түр зуурын байдлаар эвлэлдэн нэгдсэн бүлэг хүмүүсийг ойлгож байна.

СӨХ нь бүтцийн хувьд удирдах зөвлөл /орон тооны бус/, хяналтын зөвлөл /орон тооны бус/, гүйцэтгэх захиралтай байна. Гүйцэтгэх захирал нь СӨХЭЗБНЗОСБДӨӨХТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт зааснаар бүх гишүүдийн хурлын чөлөө цагт холбооны өдөр тутмын үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнээс харвал, СӨХ-ийн зохион байгуулалтын хэлбэр буюу удирдлага, дотоод бүтцийг хуулиар тодорхойлжээ.

Түүнчлэн Иргэний хуулийн 144 дүгээр зүйлийн 144.1 дэх хэсэгт “Орон сууц болон бусад эд хөрөнгийн дийлэнх хэсэг устаж, гэмтсэн тохиолдолд эвдрэл хохирлыг даатгалаар буюу бусад аргаар арилгах боломжгүй бол сууц өмчлөгчид холбоог татан буулгаж болно” гэж заасан бол СӨХЭЗБНЗОСБДӨӨХТХ-ийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт СӨХ-г дээрх үндэслэлээс гадна тухайн орон сууцны байшингийн бүх сууц нэг этгээдийн өмчлөлд шилжсэнээс бусад нөхцөлд татан буулгахыг хоригложээ. Иймд тус холбоо нь нийтийн зориулалттай орон сууц байгаа нөхцөлд үйл ажиллагаа явуулсаар байх үр дагавартай байна. Өөрөөр хэлбэл, СӨХ-г тогтвортой үйл ажиллагаа эрхэлж буй зохион байгуулалтын нэгдэл гэж тодорхойлж болохоор байгаа нь хуулийн этгээдийн нэг шинжийг хангаж буйг илэрхийлж байна.

Бүртгэл:

СӨХ-г зохион байгуулах хурлын шийдвэрт хурлын тэргүүлэгчид гарын үсэг зурснаар түүнийг байгуулагдсанд тооцох бөгөөд СӨХЭЗБНЗОСБДӨӨХТХ-д зааснаар тухайн сум, дүүргийн Засаг дарга нь СӨХ-г бүртгэдэг байна. Тодруулбал, СӨХЭЗБНЗОСБДӨӨХТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасны дагуу

37 Доктор Э.Байгал, “Иргэний эрх зүйн ерөнхий анги” бүтээлд дээр дурдсан бие даасан баланс ба эд хөрөнгийн төсөв бүхий шинжийн оронд хуулийн этгээд нь өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээх шинжийг тодорхойлсон байна.

холбоог бүртгэх үйл ажиллагааг сум, дүүргийн Засаг даргын тамгын газар хариуцан мэдээллийн санг бүрдүүлж байдаг.

Сууц өмчлөгчдийн холбоо 1997 оноос хойш байгуулагдаж эхэлсэн ба 2015 оны 4-р улирлын байдлаар 1.022 СӨХ үйл ажиллагаагаа явуулж байжээ.³⁸ Харин 2018 оны байдлаар улсын хэмжээнд нийт 1147 СӨХ үйл ажиллагаа явуулж байснаас нийслэлд 1032, орон нутагт 115 бүртгэгдсэн байна.³⁹

Үүнээс үзэхэд СӨХ нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлдэггүй ч сум, дүүргийн Засаг даргад бүртгүүлдэг байна.

Дүгнэвэл, СӨХ-ны эрх зүйн байдлыг Иргэний хуульд хуулийн этгээдийн эрхгүй гэж заасан боловч бусад хууль, журамд зааснаар СӨХ нь хуулийн этгээдэд байх өөрийн нэрээр эрх олж авах, нэхэмжлэгч, хариуцагч байх, тодорхой зорилготой байх, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдэл байх шинжийг хангаж, эрх зүйн харилцаанд оролцож байна. Энэ нь Иргэний хуульд заасан хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын эрх хэмжээ, хүлээх үүрэг тодорхойгүйгээс болж бусад хуулиар тус байгууллагын эрх зүйн байдлыг өөрөөр тогтоосныг илэрхийлж байна.

2. Ойн нөхөрлөлийн эрх зүйн байдал

Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл гэж нутгийн иргэдэд байгалын нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх эрхийг олгож, нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж, түүнээс гарсан үр ашгийг иргэдэд тэнцүү хуваарилах зорилготой нөхөрлөлийг хэлнэ.⁴⁰ “Ойн нөхөрлөл” гэж Иргэний хуулийн 481.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3.2.8-д заасны дагуу зохион байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн сайн дурын байгууллагыг ойлгоно.⁴¹

Ойн нөхөрлөлийн талаарх ойлголт нь ИХ-ийн 481 дүгээр зүйл, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.8 дахь заалтад зааснаар тодорхойлогдох бөгөөд ойн нөхөрлөлийн эрх зүйн байдал нь Ойн тухай хууль (2012), Байгаль орчин хамгаалах тухай хууль (1995)-иар зохицуулагддаг. Ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа ойн нөхөрлөл нь ойн санг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тусгасан ойн менежментийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулдаг. Ойн нөхөрлөл нь Иргэний хуулийн 481 дүгээр зүйлийн 481.1 дэх хэсэгт зааснаар хуулийн этгээдийн эрхгүй байгууллага бөгөөд тухайн ойн нөхөрлөлийн гишүүд нь тэр хэсэгт байнга оршин суудаг хүмүүс байх хуулийн шаардлага тавигддаг. Эдгээр хуульд ойн нөхөрлөлийн эрх зүйн байдлыг хэрхэн тодорхойлж байгааг хуулийн этгээдийн шинжийг агуулахгүй байх шалгуураар авч үзье.

38 Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн хэрэгжилт, бусад орны туршлага. Парламентын судалгааны эмхэтгэл, XXIII боть. УБ, 107 дахь тал.

39 Газрын нэгдсэн тайлан 2018.pdf.

Дам ишлэв: Н.Баярмаа, Нийтийн зориулалттай орон сууцны өмчлөх эрх ба сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, 2020, 1 дэх тал. <https://legalddata.mn/buteel/pdf?id=829>.

40 Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2.8 дахь заалт.

41 Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалт.

Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй эсэх:

Ойн нөхөрлөл нь Ойн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт зааснаар эзэмшлийн газартаа зориудаар тарьж ургуулсан ойн модыг өмчлөх боломжтой байна. Мөн түүнчлэн ойн сангийн тодорхой хэсгийг эзэмшиж, ашиглах эрхтэй бөгөөд ойн сангийн тодорхой хэсгийг ойн нөхөрлөл, аж ахуй нэгж байгууллагад эзэмшүүлэх журмыг Засгийн газар батална хэмээн заажээ. Тус журамд зааснаар⁴² ойн нөхөрлөл нь мод болон ойн дагалт баялгийг борлуулснаас олсон нийт орлогын 50-иас доошгүй хувийг дундын санд төвлөрүүлж, энэ орлогыг ойг түймрээс урьдчилан сэргийлэх, хууль бусаар мод бэлтгэхийг таслан зогсоох, хяналт тавих, ойг нөхөн сэргээх, нутгийн хөгжлийг дэмжихэд зарцуулах эрх, үүрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, Иргэний хуулийн 482 дугаар зүйлд зааснаар ойн нөхөрлөлийн гишүүдийн татвар, хандив, үйл ажиллагааныхаа орлогоос олж авсан хөрөнгө нь гишүүдийн дундын хөрөнгө байна. Үүнээс үзэхэд, ойн нөхөрлөл нь өмчлөлдөө хөрөнгөтэй байх бөгөөд энэ нь гишүүдийн дундын өмч байна.

Өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг эсэх:

Ойн тухай хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар болон ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журамд зааснаар ойн нөхөрлөлийн эрх, үүрэг тодорхойлогдох бөгөөд ойн нөхөрлөл нь ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлийн үйл ажиллагаа явуулах явуулах чиг үүрэгтэй байна. Хэлцэл хийх чадваргүй хэрнээ ойн сан эзэмших байгуулж байгаа нь ойн нөхөрлөл өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээж буй хэрэг юм.

Үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг эсэх:

Ойн нөхөрлөл нь Иргэний хуулийн 482 дугаар зүйлд зааснаар нэхэмжлэгчдийн шаардлагыг гишүүдийн дундын хөрөнгөөр хангана. Дээрх заалтаас үзвэл үйл ажиллагаанаас бий болох үр дагаврыг ойн нөхөрлөлийн хөрөнгөөр бус гишүүдийн дундын хөрөнгөөс хангах бөгөөд дундын хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд тухайн нөхөрлөлийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах бүрэн эрх бүхий этгээдүүд ижил хэмжээгээр нөхөх хариуцлага хүлээдэг байна. Үүнээс үзвэл ойн нөхөрлөлийн үйл ажиллагаанаас бий болох үр дагаврыг нөхөрлөлийн хөрөнгөөр, мөн гишүүдийн хувийн хөрөнгөөр хариуцдаг байна.

Нэхэмжлэгч, хариуцагч байж чадах эсэх:

Иргэний хуулийн 481 дүгээр зүйлд зааснаар ойн нөхөрлөл нь хуулийн этгээдийн эрхгүй байгууллага бөгөөд БОАЖЯ-ны сайдын 2010 оны А-250 дугаар тушаалаар “нөхөрлөл нь өөрийн үйл ажиллагааг зогсоох болон гэрээг цуцлах тухай сум, дүүргийн Засаг даргын шийдвэрийг зөвшөөрөхгүй бол гомдлоо аймаг, нийслэлийн Засаг даргад, эсвэл шүүхэд гаргаж болно” гэж зааснаар ЗХШ-д хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нэхэмжлэгчээр оролцох боломжийг олгожээ. Гэвч ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт зааснаар хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг шүүгч захирамж гарган оролцуулах бөгөөд мөн зүйлийн 18.1 дэх хэсэгт зааснаар хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нэхэмжлэгчээр оролцох боломжгүй байна. Харин ЗХШХШТХ-ийн 18.3 дахь хэсэгт зааснаар ойн нөхөрлөл нь нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдэд хамаарч буй тохиолдолд хүрээлэн буй орчны асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байна.

42 <https://legalinfo.mn/mn/detail/2673> ЗГ-ын тогтоол, № 227, 2009.

Харин ИХШ-д нэхэмжлэл гаргах эрхтэй эсэх нь тодорхойгүй байна. Тодруулбал, ИХШХШТХ-ийн 12 дугаар зүйлд зааснаар бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалж шүүхэд мэдүүлэх эрх нь хуулиар олгогдсон этгээдэд хамаарч болох юм. Гэвч Ойн тухай хуульд зааснаар Ойн баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллага нь ойн тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс ойн санд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байна хэмээн хуульчилжээ. Үүнээс үзэхэд ойн нөхөрлөл нь ИХШ-д нэхэмжлэл гаргах эрхгүй байна. Иймд БОАЖЯ-ны сайдын шийдвэр дээр дурдсан хуулийн зохицуулалтад нийцэхгүй юм.

Тодорхой зорилго бүхий эсэх:

Ойн нөхөрлөлийн тухай Ойн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, холбогдох журмуудад тодорхойлсноор байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх эрхийг олгож, нөөц ашиглалтыг хамтаараа, ил тод, шударга зарчимд нийцүүлэн зохион байгуулж, түүнээс гарсан үр ашгийг иргэдэд тэнцүү хуваарилах зорилготой байна гэж заажээ. Ойн нөхөрлөлийн онцлог нь ийнхүү үйл ажиллагааны зорилгоор илэрч байна.

Тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдэл эсэх:

Ойн нөхөрлөл нь хамтран ажиллах гэрээний үндсэн дээр байгуулагдах бөгөөд ойн санг гэрээгээр эзэмшүүлэх журамд зааснаар уг гэрээндээ нөхөрлөлийн оноосон нэр, хаяг, байршил, албан бичгийн нүүр, тэмдэг, дундын сангийн эд хөрөнгийн төрөл, хэмжээ, дансны дугаар, дундын хөрөнгө захиран зарцуулах, нөхөрлөлд элсэх, гарах журам болон гишүүний эрх, үүрэг, нөхөрлөлийн хурлаар хэлэлцэх асуудал, нөхөрлөлийн удирдлагыг сонгох журам, нөхөрлөлийн үйл ажиллагаа, түүнийг татан буулгах зэрэг асуудлыг тусгасан байна. Ойн нөхөрлөл нь гэрээгээр ойн санг эзэмших эрхтэй болох бөгөөд сум, дүүргийн Засаг дарга нь ИТХ-ын шийдвэрийг үндэслэн ойн санг эзэмшүүлэх гэрээг байгуулж гэрчилгээ олгодог байна. Тухайн гэрээг байгуулсан ойн нөхөрлөл нь Ойн тухай хуулийн 21.12-т зааснаар эрх эдлэх бөгөөд эдгээрийн нэг нь эзэмшлийн газартаа ойн менежментийн төлөвлөгөөний дагуу хийгдэх үйл ажиллагааг тасралтгүй явуулах эрх юм. Үүнээс үзэхэд ойн нөхөрлөл нь тухайн сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулснаар ойн менежментийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдэл гэж үзэх үндэслэлтэй байна.

Судлаач Д.Баттулга ойн нөхөрлөлийг судалсны үндсэн дээр дараах сул тал буюу асуудлыг илрүүлжээ. Үүнд:

- Ойн нөхөрлөлд Ойн тухай хуулийн 21.12.2-т “эзэмшлийн газраасаа ойн менежментийн төлөвлөгөө, эрхийн бичгийн дагуу бэлтгэсэн мод, ойн дагалт баялгийг ашиглах, хэрэгцээнээс илүү гарсан мод, ойн дагалт баялгийг худалдан борлуулах” эрх олгогдсон боловч эрхийн бичигт заасан хэмжээгээ хэтрүүлэн ашиглах, нөхөрлөлийн нэрээр ой эзэмшиж байгаа давуу байдлаа ашиглан бизнесийн үйл ажиллагаа явуулах түүхий эдийн материаллаг нөөц бололцоогоо хангаж байна;

- Нөхөрлөлийн гишүүд хэрэг зөрчил гарсан тохиолдолд хариуцлага тооцох боломж хязгаарлагдмал. ИХ-ийн 482.1-т зааснаар дундын хөрөнгөөр нэхэмжлэлийн шаардлагыг хангуулахаар заасан боловч ихэнх ойн нөхөрлөлүүд заавал шаарддаггүй учир дундын хөрөнгө, мөнгөн сан байхгүй болох нь ажиглагддаг.⁴³

Дүгнэвэл, ойн нөхөрлөл нь өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээж, БОАЖЯ-ны сайдын 2010 оны А-250 дугаар тушаалаар ЗХШ-д нэхэмжлэл гаргах боломжтой болсноороо хуулийн этгээдийн зарим шинжийг хангаж буйг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, хэлцлийн тал болохгүй, хэрэг хариуцах чадваргүй байх хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын зарим шинжийг хангахгүй байна.

СӨХ болон ойн нөхөрлөлийн эрх зүйн байдлыг харьцуулан судалвал, эдгээр хуулийн этгээдийн эрхгүй байгууллагууд нь хувьдаа тусгайлсан эд хөрөнгөгүй бөгөөд тодорхой зорилгоор үйл ажиллагаа явуулдаг, сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдсэн оршин суугчдын төлөөлөл байна.

II. ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага шүүхэд нэхэмжлэгч, хариуцагч байх чадваргүй хэдий ч практикт СӨХ болон ойн нөхөрлөл иргэний хэргийн шүүх хуралдаанд зохигчоор, захиргааны хэргийн шүүх хуралдаанд нэхэмжлэгч, гуравдагч этгээдээр оролцож байх тул эдгээр маргаануудын үндэслэл, шийдвэрлэгдсэн байдалд дүн шинжилгээ хийх замаар тэдгээр байгууллагын үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодруулахыг зорилоо.

Шүүхийн шийдвэрийн цахим сангаас 2021 онд иргэний болон захиргааны хэргийн анхан шатны шүүхээс гаргасан шийдвэрүүдтэй танилцсан бөгөөд СӨХ хэргийн зохигчоор оролцсон ИХАШШ-ийн 47 шийдвэр, нэхэмжлэгч, гуравдагч этгээдээр оролцсон ЗХАШШ-ийн 5 шийдвэр, харин ойн нөхөрлөл ЗХАШШ-д нэхэмжлэгчээр оролцсон 1 шийдвэр байгаа тул эдгээрээс түүвэрлэн дүн шинжилгээ хийе.

1. СӨХ зохигчоор оролцсон ИХАШШ-ийн шийдвэр

а) СӨХ нэхэмжлэгчээр оролцсон маргаан:

СӨХ иргэний хэргийн 42 шүүх хуралд нэхэмжлэгчээр оролцсоноос 36 хэрэгт Иргэний хуулийн 147 дугаар зүйлийн 147.1 дэх хэсэгт зааснаар дундын өмчлөлийн зүйлийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардлыг гаргуулах, 5 хэрэгт үл хөдлөх эд хөрөнгө хууль бус эзэмшлээс чөлөөлүүлэх, 1 хэрэгт барилга байгууламжийн үндсэн хийцэд гарсан зөрчлийг арилгуулах тухай нэхэмжлэл гаргасан байна. Үүнийг доорх хүснэгтээс харах боломжтой.

43 Д.Баттулга, Ойн нөхөрлөлийн эрх зүйн байдал болон тулгамдаж буй асуудал. 2018 <https://legaldata.mn/b/342>.

Хүснэгт 4. СӨХ нэхэмжлэгчээр оролцсон иргэний хэргийн нэхэмжлэлийн шаардлага (2021 онд шийдвэрлэгдсэн хэрэг)



Дундын өмчлөлийн зүйлийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардлыг нэхэмжилсэн:

Иргэний хуулийн 147 дугаар зүйлийн 147.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр нэхэмжлэл гаргасан 36 хэрэг байгаагийн 22 шийдвэрт нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн, 9 шийдвэрт нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн, 5 шийдвэрт нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон байна.

Шийдвэр 1⁴⁴

...СӨХ-оос тогтоосон төлбөрийн тарифыг миний бие хүлээн зөвшөөрөхгүй байна. Учир нь 2018 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Т хотхоны бүх гишүүдийн хурал зарлагдсан боловч хурлын ирц хуульд заасан хувьд хүрээгүй байхад Удирдах зөвлөлийн гишүүд гэх нэр бүхий этгээдүүд хүчээр төлбөрийн тарифыг өндөр тогтоосон юм.

Шийдвэр 2⁴⁵

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт: СӨХ-ны үйл ажиллагаатай холбоотой гомдлоо сууц өмчлөгч нар өөрсдөө байгуулсан СӨХ-ны хяналтын болон төлөөлөн удирдах зөвлөлд, түүнчлэн СӨХ-ны Дээд зөвлөлд хандан гаргаж шалгуулах эрхтэй болно.

Шийдвэр 3⁴⁶

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт: Хэргийн баримтаас үзэхэд Д СӨХ нь Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 5 дугаар зүйлийн 5.2, 18 дугаар зүйлийн 18.1.1, Иргэний хуулийн 143 дугаар зүйлийн 143.1-д зааснаар байгуулагдсан болох нь 2014.03.31-ний өдөр олгогдсон 147 дугаар гэрчилгээ, СӨХ-ны дүрэм, Монголын сууц өмчлөгчдийн холбоодын дээд зөвлөлийн тэргүүлэгчдийн 2014.04.01-ний өдрийн ... тоот хурлын тогтоол зэргээр тогтоогдож байна.

44 https://shuukh.mn/single_case/105983?daterange=2021-01-01%20-%202021-11-12&id=1&court_cat=1&bb=1

45 https://shuukh.mn/single_case/105246?daterange=2021-01-01%20-%202021-11-14&id=1&court_cat=1&bb=1

46 https://shuukh.mn/single_case/105235?daterange=2021-01-01%20-%202021-11-12&id=1&court_cat=1&bb=1

Шийдвэр 4⁴⁷

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт: ...Ийнхүү шийдвэрлэхээс өмнө Сууц өмчлөгчдийн холбоодын Дээд зөвлөлөөс баталсан жишиг үнийн доод хэмжээгээр тооцон засвар үйлчилгээг 1 м.кв талбайд 200 төгрөг хог 2800 төгрөг, лифт 400 төгрөг, цэвэрлэгээ 3500 төгрөг, жижүүр 5000 төгрөг, баримт 150 төгрөг, дундын гэрэл 1000 төгрөг тус тус байхаар тооцон хариуцагчаас нийт 29.030 төгрөгийг тооцон авч байжээ.

Шийдвэр 1-ээс үзэхэд, СӨХ-ны төлбөрийн хэмжээг оршин суугчид хүлээн зөвшөөрөхгүй маргаан үүссэн тохиолдолд тухайн сууц өмчлөгчдийн саналыг харгалзахгүйгээр ашиглалт, засвар үйлчилгээний төлбөрийг зайлшгүй төлүүлэхээр шийдвэрлэдэг шүүхийн жишиг тогтсон байна. СӨХ нь оршин суугчдын эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор байгуулагддаг бөгөөд орон сууцны ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардлыг сууц өмчлөгчөөс шаардах эрхтэй байна. СӨХ-д төлөх ашиглалт, засвар үйлчилгээний хураамжийн үнийн дүнг оршин суугчдын оролцоогүйгээр тогтоож байгаа нь тэдний эрх ашгийг хамгаалах бус, харин зөрчиж байгаа үйлдэл юм.

Шийдвэр 3-аас үзвэл, СӨХ-г байгуулахад Монголын Сууц өмчлөгчдийн холбоодын дээд зөвлөл (МСӨХДЗ) гэх ГҮТББ тогтоол гаргасан байна. Уг байгууллага хуулийн этгээдийн улсын бүртгэлд төрийн бус байгууллагаар бүртгүүлсэн. Гэтэл хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байгуулах шийдвэр гаргаж байгаа нь өөрт оногдоогүй эрх хэмжээ эдэлж байгааг илэрхийлж байна.

Түүнчлэн шийдвэр 4-өөс үзвэл, СӨХ-д төлөх ашиглалт, засвар үйлчилгээний хураамжийг МСӨХДЗ-ийн баталсан хэмжээгээр тогтоосон хэмээн тайлбарлажээ. Мөн шийдвэр 2-с харвал, МСӨХДЗ нь сууц өмчлөгчдийн холбоодын шатлан захирах байгууллага мэт жишиг тогтсон байдал ажиглагдаж байх тул уг байгууллагын үйл ажиллагаа, эрх хэмжээг тодорхой болгоход анхаарах шаардлагатай байна.

Шийдвэр 5⁴⁸

Хариуцагчаас шүүхэд болон шүүх хуралдаанд гаргасан хариу тайлбартаа:...Одоо бол хааяа нэг өөр хүн ирж дутуу дулимаг цэвэрлэсэн болоод явчихдаг. Орцны жижүүрийн хаалга нь сар, жилүүдээр цоожтой л байдаг. Энэ цаг үед урьдынх шигээ хийгээгүй зүйлийн төлөө, бохир заваан, тохь тухгүй орчинд амьдарсныхаа төлөө нэрэлхээд, “За яахав” гээд төлбөр төлөөд яваад баймааргүй байгаа тул тус СӨХ-ны нэхэмжилсэн мөнгийг төлөхгүй байх нь зөв зүйтэй гэж үзэж байгаа болно.

Шийдвэр 6⁴⁹

47 https://shuukh.mn/single_case/105268?daterange=2021-01-01%20-%202021-11-14&id=1&court_cat=1&bb=1

48 https://shuukh.mn/single_case/105547?daterange=2021-01-01%20-%202021-11-14&id=1&court_cat=1&bb=1

49 https://shuukh.mn/single_case/105235?daterange=2021-01-01%20-%202021-11-12&id=1&court_cat=1&bb=1

Хариуцагчаас шүүхэд болон шүүх хуралдаанд гаргасан хариу тайлбартаа: Миний бие 2016 оноос хойш буюу сүүлийн 5 жилийн хугацаанд амьдарч байгаа, эхний 3 жилийн хугацаанд СӨХ-ны төлбөрийг төлж ирсэн. Тус М СӨХ-ны төлбөрийг төлөөгүй шалтгаан нь орц нь гэрэлтүүлэг маш муу хөгшин хүн бүдэрч унахаар, жоохон хүүхэд сүнс зайлмаар, СӨХ-ны хяналтын хороо гэж байхгүй, орц өнгө үзэмжгүй, 1980 онд баригдсанаас хойш өөрчлөгдөж шинэчилсэн зүйлгүй, подвольд ариутгал хийгээгүйгээс айлуудад жоом, хулгана гүйдэг болсон, орцонд байнга архичид хонодог, архи уудаг, орцны жижүүр тогтворгүй байнга сольдог цалинг нь тавьдаггүй, лифт нь хагас дутуу ажилладаг, ачааны лифт ажиллуулдаггүй, тоглоомын талбай жижиг, хүүхэд тоглох орчингүй, СӨХ-ны дарга харилцааны соёлгүй, оршин суугчдын дийлэнх хувь нь СӨХ-ны үйл ажиллагаанд сэтгэл дундуур байгаа бөгөөд хурал хийж ажлын хэсэг байгуулж СӨХ солих арга хэмжээ авахаар ажиллаж байна. СӨХ-г соливол төлбөр барагдуулна гэв.

Шийдвэр 7⁵⁰

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт: Хариуцагч Л.Н СӨХ дундын өмчлөлийн эд хөрөнгөнд засвар үйлчилгээ хийдэггүй, цэвэрлээг сайн хийдэггүй, гадна дотор камер нь ажилладаггүй, СӨХ-ны ажилчид гэж маш хариуцлагагүй пүүтгэнд бөөгнөрч архи уусан хүмүүс байдаг гэж тайлбарлаж байгаа нь хуульд заасан СӨХ-нд төлөх төлбөрөөс чөлөөлөх үндэслэл болохгүй юм.

Дээрх шүүхийн шийдвэрүүдээс харахад, СӨХ-ны үйл ажиллагаа нь хангалтгүй байгаа учраас СӨХ-д төлөх ашиглалт, засвар үйлчилгээний хураамжийг төлөхгүй хэмээн маргасан байх боловч шүүхээс уг маргааныг шийдвэрлэхдээ СӨХ-ны хүлээсэн хариуцлагыг харгалзахгүйгээр сууц өмчлөгчөөс төлбөр гаргуулахаар шийдвэрлэсэн байна. Өөрөөр хэлбэл, СӨХ сууц өмчлөгчид хохирол учруулсан нөхцөлд хариуцлага хүлээх боломжгүй байгаа нь хуулийн этгээдийн эрхгүйтэй холбоотой бөгөөд ямар ч нөхцөлд сууц өмчлөгчид СӨХ-д төлөх төлбөрөөс чөлөөлөгдөх боломжгүй байна. Нэгэнт СӨХ хуулийн этгээдийн эрхгүй байгууллагынхаа хувьд үйл ажиллагаагаа явуулахгүй, хуулийн этгээдийн эдлэх эрхийг эдэлсэн хэрнээ хариуцлага хүлээхгүй үлдэж байгаа асуудлыг цэгцлэх шаардлагатай юм.

Үл хөдлөх эд хөрөнгө хууль бус эзэмшлээс чөлөөлүүлэх тухай:

Үл хөдлөх эд хөрөнгө хууль бус эзэмшлээс чөлөөлүүлэх үндэслэлээр СӨХ нэхэмжлэл гаргасан 4 шүүхийн шийдвэр байгаагаас 1 шийдвэрт нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан, 1 шийдвэрт нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн, 2 шийдвэрт нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон байна.

Шийдвэр 8⁵¹

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт: Нэхэмжлэгч Х СӨХ нь П.Б-той Дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалт, засвар үйлчилгээний хуримтлалын гэрээг 2019 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр байгуулж талууд гарын үсэг зурж баталгаажуулжээ. /хх-ийн 6, 7-р хуудас/ Дээрх гэрээгээр Х СӨХ-ны 23 дугаар байрны дундын өмчлөлийн эд хөрөнгө болох 33 м.кв талбайтай подвалийн нэг өрөөг сарын 100.000 төгрөгөөр, 2019 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийг дуустал хугацаанд хадгаламж зээлийн үйл ажиллагаа явуулах зориулалтаар түрээслэхээр харилцан тохиролцсон байна.

50 https://shuukh.mn/single_case/105246?daterange=2021-01-01%20-%202021-11-14&id=1&court_cat=1&bb=1

51 https://shuukh.mn/single_case/104341?daterange=2021-01-01%20-%202021-11-14&id=1&court_cat=1&bb=1

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт: Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д ... оршин суугчдын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байх тул уг зөрчлийг арилгуулахаар Ш.Өө СӨХ нь шаардах эрхтэй байх тул С.Е-ийн хууль бус эзэмшлээс Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороо, Чингисийн өргөн чөлөө, Ш.Ө хотхоны 00а байрны 00тоот хаягт байрлах орон сууцыг чөлөөлөх үндэслэлтэй байна.

Дээрх шийдвэрүүдээс үзэхэд, СӨХ нь орон сууцны дундын өмчлөлийн зүйлд хамаарах үл хөдлөх хөрөнгийг түрээслэх гэрээ байгуулах, тухайн үл хөдлөх хөрөнгийг бусдын хууль бус эзэмшлээс чөлөөлүүлэх эрхтэйгээр иргэний эрх зүйн харилцаанд оролцож байна. СӨХ нь нийтийн зориулалттай орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийг дундаа өмчлөх эрхийг хэрэгжүүлэх эрхтэй байгууллага боловч Иргэний хуулийн 148 дугаар зүйлийн 148.1.3 дахь заалтад заасан орон сууц өмчлөгчийн дундын өмчлөлийн зүйлийг захиран зарцуулахад өөрт оногдох хэсгээр саналын эрхтэй оролцох эрхийг зөрчих учиргүй. Өөрөөр хэлбэл, сууц өмчлөгчдийн зөвшөөрөлгүйгээр дундын өмчлөлийн зүйлийг гуравдагч этгээдэд түрээслүүлэх эрх хэмжээ СӨХ-д олгогдоогүй байна.

СӨХ нь ашгийн төлөө бус хуулийн этгээдийн эрхгүй байгууллага тул дундын өмчлөлийн эд хөрөнгийг захиран зарцуулж, түүнээс орлого олох эрхгүй юм. Иймд СӨХ-ийн эрх хэмжээг хуулиар хязгаарлах, түүний эрх зүйн байдлыг тодорхой болгох шаардлагатай байна.

Барилга байгууламжийн үндсэн хийцэд гарсан зөрчлийг арилгуулах тухай:

Барилга байгууламжийн үндсэн хийцэд гарсан зөрчлийг арилгуулах үндэслэлээр СӨХ нэхэмжлэл гаргасан 1 шүүхийн шийдвэр байх бөгөөд шүүх нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн байна.

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт: ХУ-ны нутаг дэвсгэрт иргэдийн орон сууц захиалан бариулах гэрээний дагуу "МӨ" ХХК нь 2 блок орон сууц автомашины зогсоол түүн дээрх тоглоомын талбай бүхий барилга байгууламжийг барьж дуусган 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдөр ашиглалтад оруулжээ. Энэ нь 33, 34 дүгээр байрууд ба дундын өмчлөлийн зүйлийн засвар үйлчилгээ нь "ХХ" СӨХ-д харьяалагддаг байна.

33, 34 дүгээр байрны доорх авто зогсоолын орцны хэсгийг зам талбайн ус орохооргүй болгож өндөрлөх В, С блокийн зоорийн давхрын шалыг арматуртай ба арматургүй бетоноор норм нормативын дагуу давхарлан цутгахыг хариуцагчид даалгах тухай нэхэмжлэлийн шаардлагыг хангаж нэхэмжлэлийн бусад хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв.

Барилгын үндсэн хийцэд гарсан зөрчлийг арилгуулах эрх нь Иргэний хуулийн 143 дугаар зүйлийн 143.1 дэх хэсэгт зааснаар орон сууц ашиглалтын хэвийн байдлыг хангах зорилгод нийцэж байна хэмээн дүгнэж болох юм. Харин уг эрхийг хэрэгжүүлэхдээ СӨХ нь өөрийн нэрээр шүүхэд нэхэмжлэл гаргах боломжгүй байна.

52 https://shuukh.mn/single_case/104071?daterange=2021-01-01%20-%202021-11-14&id=1&court_cat=1&bb=1

53 https://shuukh.mn/single_case/102589?daterange=2021-01-01%20-%202021-11-15&id=1&court_cat=1&bb=1

б) СӨХ хариуцагчаар оролцсон маргаан:

СӨХ 4 хэрэгт хариуцагчаар оролцсон байх бөгөөд нэхэмжлэлийн шаардлага нь дараах байдлаар байна. Үүнд:

- Гэрээнээс үүдэлтэй маргаан (үүргийн гүйцэтгэлийн хангуулах)- 2;
- Хөдөлмөрийн маргаан- 2.

СӨХ хариуцагчаар оролцсон маргаанд нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн 2, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн 1, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон 1 шүүхийн шийдвэр байна.

Шийдвэр 11⁵⁴

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт: Ажил олгогч “АО” сууц өмчлөгчдийн холбоо нь ажилтан Ц.С-тэй хөдөлмөрийн гэрээг 2 жилийн хугацаатай байгуулсан Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1-т заасныг зөрчсөн байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.1.2-т “ажил олгогчийн санаачилгаар ажлаас буруу халсан буюу өөр ажилд буруу шилжүүлсэн тухай ажилтны гомдлыг шүүхээр хянан шийдвэрлэнэ” гэж заасан. Иймд ажил олгогч нь ажилтныг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсөн байх тул Ц.С-ийг Баянзүрх дүүрэг, 7 дугаар хороо, 15 дугаар хороолол, 31 дүгээр байрны 1, 2, 3, 4 дүгээр орцны жижүүр, үйлчлэгчийн ажилд эгүүлэн тогтоох нь Хөдөлмөрийн тухай хуулийн 128 дугаар зүйлийн 128.1.2-т заасантай нийцнэ.

Шийдвэр 12⁵⁵

Нэхэмжлэлд хавсаргасан баримтаас үзэхэд нэхэмжлэгч Н.И-ыг 3 СӨХ-ны гүйцэтгэх захирлын 2019.04.12-ны өдрийн ...тоот тушаалаар аж ахуйн үйл ажиллагааны менежер /орлогч захирал/-ээр ажилд авсан, 2019.06.18-ны өдрийн ...тоот тушаалаар чөлөөлсөн гэх тушаал болон Н.И-тай байгуулсан хөдөлмөрийн гэрээ нь 3 СӨХ-ны тамга тэмдэггүй, 2019.04.16-ны өдрийн ажлын байрны тодорхойлолтод ажлын байрны нэр, үйлчлэгч, ажлын байрны зорилго хариуцсан байр, орц, талбайг хоггүй цэвэр цэмцгэр, өнгө үзэмжтэй байлгах, нийтийн эзэмшлийн тоноглол, эд хогшлын бүрэн бүтэн байдлыг хангах гэж тусгасан нь эргэлзээтэй байна. Н.И-ыг ажилд авсан болон чөлөөлсөн тушаал, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт зэргийг 3 СӨХ-ноос ирүүлэхийг шаардсан боловч дээрх баримтууд тус СӨХ-ны архивт хадгалагдаагүй болохыг мэдэгдсэн 3 СӨХ-ны 2020.02.27-ны өдрийн ...тоот албан бичиг ирүүлсэн байна.

Шийдвэр 13⁵⁶

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт: М сууц өмчлөгчдийн холбоо нь Э ХХК-тай 2020 оны 10-р сард харилцан тохирч Баянгол дүүргийн 13-р хорооны нутаг 4, 5, 6-р байрны авто зогсоолын хаалт хийлгэхээр харилцан тохирчээ. Ажил гүйцэтгэгч нь авто зогсоолын хаалтыг 2020 оны 11-р сард хийж гүйцэтгэсэн боловч М сууц өмчлөгчдийн холбоо хөлсийг төлөөгүйгээс маргаан гарсан байна. Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг татгалзаж байгаа үндэслэлээ ...мөнгө байхгүй гэж хэлээгүй, хаалтыг нь ашиглаагүй, машинтай өрхүүдээс мөнгө авч өгнө, хаалт нь хэврэг, суурьгүй, цахилгааны шон нь хазайсан, одоо энэ хүнтэй гэрээ хийхгүй, мөнгийг нь төлөхгүй гэж тайлбарладаг боловч энэ нь гүйцэтгэсэн хөлсийг төлөхгүй байх үндэслэл болохгүй.

Шийдвэр 11, 12-оос үзвэл СӨХ-г ажил олгогч буюу хөдөлмөрийн гэрээний нэг тал хэмээн үзэж шийдвэрлэсэн байна. Иргэний хуулийн 147 дугаар зүйлийн 147.1 дэх хэсэгт зааснаар нийтийн зориулалттай орон сууцны ариутгал, хог цахилгааны

54 https://shuukh.mn/single_case/100741?daterange=2021-01-01%20-%202021-11-15&id=1&court_cat=1&bb=1

55 https://shuukh.mn/single_case/102364?daterange=2021-01-01%20-%202021-11-15&id=1&court_cat=1&bb=1

56 https://shuukh.mn/single_case/7840?daterange=2021-01-01%20-%202021-11-27&id=1&court_cat=3&bb=1

төлбөрийг сууц өмчлөгч нь эрх бүхий байгууллагад төлөхөөр байдаг боловч бодит байдал дээр СӨХ нь өөр этгээдтэй хөдөлмөр гэрээ байгуулан ажиллуулах замаар орон сууцны ариутгал, цэвэрлэгээний ажлыг хариуцаж байна. Өөрөөр хэлбэл, Иргэний хуулийн 147 дугаар зүйлийн 147.1 дэх хэсэгт заасан эрх бүхий байгууллагын чиг үүргийг СӨХ хэрэгжүүлж байгаа учраас хөдөлмөрийн гэрээ байгуулах шаардлага бий болжээ.

Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь хөдөлмөрийн гэрээ болон бусад хэлцлийн тал болохгүй зарчимтай хэдий ч манай улсад СӨХ нь хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын хувиар иргэний эрх зүйн харилцаанд оролцохгүй байна.

2.СӨХ нэхэмжлэгч, гуравдагч этгээдээр оролцсон ЗХАШШ-ийн шийдвэр

2021 онд СӨХ газрын харилцаатай холбогдох нийт 5 маргаанд оролцсон байна. Эдгээрээс 2 шүүхийн шийдвэрт нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн байгаад дүн шинжилгээ хийе.

Шийдвэр 14⁵⁷:

Хэдийгээр Иргэний хуулийн 143 дугаар зүйлийн 143.3-т Сууц өмчлөгчдийн холбоо нь хуулийн этгээдийн эрхгүй байх боловч энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6-д Сууц өмчлөгчдийн холбоог төрийн бус байгууллагад хамааруулан хуульчилсан тул дээрх эрх бүхий байгууллага, албан тушаалтны хэн аль нь “Т” СӨХ-г уг маргаанд төлөөлөн оролцох эрхгүй гэх үндэслэлээр татгалзалгүйгээр харилцаж байсан.

Шийдвэр 15⁵⁸

Шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт: Гуравдагч этгээд Д СӨХ-д хамаарах Денверийн 12А, 12Б тоот орон сууцны барилгууд нь Нийслэлийн Засаг даргын 2011 оны 124 дүгээр захирамжаар Макс өргөө ХХК-нд орон сууцны зориулалтаар олгогдсон газар дээр, тус компанийн 2011 онд барьж ашиглалтад оруулан улсын комисст хүлээлгэн өгсөн барилгууд бөгөөд маргаан бүхий газрын урд талд байрлаж байгаа болох нь хэргийн оролцогчдын тайлбар, маргаан бүхий газарт хийсэн шүүхийн үзлэг, хэрэгт нотлох баримтаар авагдсан Нийслэлийн Засаг даргын 2011 оны 124 дүгээр захирамж, Макс өргөө ХХК-ийн 0228965 дугаар Аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээний хуулбар болон холбогдох бусад баримтаар тус тус тогтоогдож байна.

Шийдвэр 14-ээс үзвэл СӨХ-г төрийн бус байгууллагад хамаардаг гэсэн үндэслэлээр захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхтэй гэж шүүх үзсэн нь үндэслэлгүй байна. Учир нь СӨХ төрийн бус байгууллага биш бөгөөд хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын хувьд ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт заасны дагуу шүүгчийн захирамжаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжтой. Гэтэл хуульд заагаагүй үндэслэлээр захиргааны хэрэг маргаанд СӨХ-г нэхэмжлэгчээр оролцуулсан нь ИХШХШТХ, ЗХШХШТХ-д нийцэхгүй юм.

Шийдвэр 15-аас үзвэл СӨХ нь гуравдагч этгээдээр оролцсон байх бөгөөд дээрх үндэслэлээр мөн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжгүй юм. Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага эрх зүйн чадавхгүй бөгөөд иргэний болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээдээр оролцох чадваргүй байна.

57 https://shuukh.mn/single_case/8272?daterange=2021-01-01%20-%202021-11-15&id=1&court_cat=3&bb=1

58 https://shuukh.mn/single_case/7840?daterange=2021-01-01%20-%202021-11-27&id=1&court_cat=3&bb=1

3. Ойн нөхөрлөл нэхэмжлэгчээр оролцсон ЗХАШШ-ийн шийдвэр

2021 оны ИХАШШ-ийн шийдвэрүүдэд ойн нөхөрлөлд холбогдох шийдвэр олддоогүй бөгөөд ЗХАШШ-ийн шийдвэрүүдээс шүүхэд ойн нөхөрлөл нэхэмжлэгчээр оролцсон 1 шүүхийн шийдвэр олдлоо.

Шийдвэр 16⁵⁹:

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь хэсэгт тус тус зааснаар хүн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд хуульд тусгайлан заасан бол захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэж заажээ. Нэхэмжлэгч Шанд нөхөрлөл нь Ойн сан эзэмших эрхэд халдсан Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 111 дугаартай Нөхөрлөл аж ахуйн нэгжийн ойн санд өөрчлөлт оруулах тухай тогтоолын 1 дүгээр заалтыг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргажээ.

ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хувь хүн, хуулийн этгээд, захиргааны байгууллага оролцох эрхтэй байна. Харин хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зайлшгүй шаардлагатай хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг шүүгч захирамж гарган оролцуулж болно. Өөрөөр хэлбэл, ердийн нөхцөлд хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь өөрийн санаачлагаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхгүй байна. Харин практикт захиргааны хэргийн шүүх ойн нөхөрлөлийг ЗХШХШТХ-ийн нэхэмжлэгчээр оролцох эрхтэй хэмээн дүгнэж, нэхэмжлэлийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Тодруулбал, ойн нөхөрлөлийг нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээдэд хамааруулж нэхэмжлэгчээр оролцуулсан бөгөөд нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд нь ЗХШХШТХ-ийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэгт зааснаар хүрээлэн буй орчин, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмчийг хамгаалах асуудлаар нэхэмжлэл гаргах эрхтэй байна.

59 https://shuukh.mn/single_case/5708?start_date=&end_date=&id=1&court_cat=3&bb=1

ДҮГНЭЛТ

1. Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага гэж хуулийн этгээдийн эрх зүйн чадавхгүй буюу хуулийн этгээдийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан хүмүүсийн нэгдэл юм. Монгол Улсын хууль тогтоомжид зааснаар хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар (банкны нэгж буюу банкны салбар, төлөөлөгчийн газар, тооцооны төв, тооцооны касс, гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар), сууц өмчлөгчдийн холбоо, бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөл (бичил уурхай эрхлэгч, байгалийн нөөцийн менежментийн нөхөрлөл, ойн нөхөрлөл), сонгуулийн сурталчилгааг эрхлэн явуулах байгууллага зэрэг хуулийн этгээдийн эрхгүй байна.
2. Хуулийн этгээдтэй харьцуулахад хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь тодорхой зорилготой хүмүүсийн нэгдэл байх шинжээрээ төстэй боловч өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээхгүй, шүүхэд нэхэмжлэгч, хариуцагч байж чадахгүй, тусгайлсан хөрөнгөгүй, үйл ажиллагаанаас бий болсон үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаггүй. Гэвч 2002 оны Иргэний хууль болон бусад хууль тогтоомжид тус байгууллагын шинж, онцлогийг тодорхой тусгаж чадаагүй байна.
3. Зарим улс хууль тогтоомжоороо хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг хүлээн зөвшөөрдөггүй болох нь харьцуулсан судалгааны үр дүнд ажиглагдлаа. Манай улс орос хэлний “организация без статуса юридического лица” гэснийг монгол хэлэнд буулган нутагшуулсан байж болох юм. ОХУ-д хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь хэлцэл хийх, салбар төлөөлөгчийн газар байгуулах, орон нутгийн нэгж байгуулах, өөр бусад хуулийн этгээдийг төлөөлөх, өөр бусад холбооны гишүүн байх, үйлдвэрчний эвлэл байгуулах, гишүүнчлэлийн төлбөр авах, харилцах данс нээх, улсаас буцалтгүй тусламж, хандив, хөрөнгө авах, төрөөс үнэ төлбөргүй орон байраар хангагдах эрхгүй байна.
4. Хуулийн этгээдийн эрх зүйн чадавхын агуулгад салбар, төлөөлөгчийн газраа байгуулах эрх багтдаг тул тэдгээр нь хуулийн этгээдийн эрхгүй байдаг. Хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын бусад хэлбэр нь бүртгэгдээгүй холбоо, нөхөрлөл байх нь түгээмэл байна. Тухайлбал, ОХУ-ын Холбооны тухай хуульд, ХБНГУ-ын Иргэний хуульд бүртгэгдээгүй холбооны эрх зүйн байдлыг тодорхойлжээ. Тэдгээр холбоо нь өөрийн нэрээр гэрээ байгуулах чадваргүй бөгөөд холбооны нэг, эсхүл хэд хэдэн гишүүд гэрээний тал болох бөгөөд түүнээс үүсэх үр дагаврыг гэрээ хийсэн этгээд хариуцдаг. Ийм учраас англо-саксоны эрх зүйн бүлийн орнуудын хуулийн этгээдийн эрхгүй холбоо (unincorporated association)-ны харилцаа төлөөллийн эрх зүй болон гэрээний эрх зүйн зааг дээр оршдог байна.
5. Манай улсын хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын түгээмэл хэлбэр болох СӨХ болон ойн нөхөрлөлийн эрх зүйн байдлыг судлахад тэдгээр нь практикт өөрийн нэрээр эрх олж, шүүхэд нэхэмжлэгч, хариуцагч болж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байна.
6. СӨХ нь Иргэний хуулийн 143 дугаар зүйлийн 143.3 дахь хэсэгт зааснаар шүүхэд нэхэмжлэгч, хариуцагч болох чадваргүй этгээд боловч Улсын дээд шүүхийн 2008 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 26 дугаар тогтоолоор иргэний эрх зүйн харилцаанд оролцогчийн хувьд гэрээний

- болон гэрээний бус үүргийн харилцаанаас үүссэн маргаанд, мөн Иргэний хуулийн 149 дүгээр зүйлд зааснаар сууц өмчлөгч хуульд заасан үүргээ биелүүлэхгүй, зөрчил гаргасан тохиолдолд Сууц өмчлөгчдийн холбоо өөрийн төлөөлөгчөөр дамжуулан шүүхэд нэхэмжлэл гаргах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчоор оролцох эрхтэй гэжээ.
7. СӨХ-ны эрх зүйн байдлыг, тодруулбал зохигч байх эрхийг УДШ тогтоол гаргах замаар тодорхойлохгүй билээ. Хуулийн этгээдийн эрхгүй байгууллага иргэний эрх зүйн харилцаанд оролцогч байх хэдий ч хуулийн этгээдийн нэгэн адил эрх эдлэх учиргүй юм. Ийнхүү СӨХ өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээхгүй байгаа тул гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний улмаас түүний учруулсан хохирлыг барагдуулахад хүндрэл учрахаар байна. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага нь хэрэг хариуцах чадваргүй буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (ИХШХШХ, ЭХХША, ЗШША, ЗХШХША)-нд оролцох боломжгүй байна.
 8. 2021 онд шийдвэрлэгдсэн иргэн, захиргааны хэрэг маргааныг шүүхийн шийдвэрийн нэгдсэн сангаас үзэхэд, СӨХ нийт 44 хэрэг маргаанд нэхэмжлэгчээр, 4 хэрэгт хариуцагчаар, 4 хэрэгт гуравдагч этгээдээр оролцжээ. Харин ойн нөхөрлөл захиргааны 1 хэрэг маргаанд нэхэмжлэгчээр оролцсон байна.
 9. СӨХ нийтийн зориулалттай орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийн өмчлөх эрхийг төлөөлөн хэрэгжүүлэх зорилготой хэдий ч орон сууц өмчлөгчдийн зөвшөөрөлгүйгээр дундын өмчлөлийн зүйлийг бусдад түрээслэх, эзэмшүүлэх, ашиглуулах эрхгүй юм. Үүнээс харвал, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага хуулиар өөрт олгогдоогүй эрх хэмжээг эдэлж байх бөгөөд тэдгээрийн эрх, үүргийг тодорхой болгох шаардлагатай байна.
 10. Түүнчлэн МСӨХДЗ нь ГҮТББ хирнээ хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг байгуулах тогтоол гаргаж, сууц өмчлөгчдийн холбоодоос хураамж авч, тэдгээрийн шатлан захирах байгууллага шиг эрх хэмжээ эдэлж байгаа нь учир дутагдалтай юм.
 11. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд аж ахуйн нэгжид хуулийн этгээдийн эрхгүй байгууллага хамаарахаар заасны дагуу татвар төлөгчөөр бүртгүүлэх боломжтой байдаг. Татварын ерөнхий газрын дарга, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/268, А/1345 дугаартай хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралтад хуулийн этгээдийн эрхгүй байгууллага татвар төлөгчөөр бүртгүүлэхдээ хариуцлагын хэлбэр, өмчийн хэлбэр зэргийн талаарх мэдээллийг хүргүүлэхээр байна. Энэ нь хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын мөн чанарт нийцэхгүй бөгөөд уг байгууллагын талаарх ойлголт эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтэн, албан хаагч, судлаачдын дунд дутмаг байгааг илэрхийлж байна.
 12. Мөн ТБМНС-д бүртгүүлэхээр заасан хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын жагсаалтад дунд Засгийн газрын тусгай сан, нам, олон нийтийн байгууллага зэрэг хамааралгүй этгээдийг оруулсан нь учир дутагдалтай байна. Түүнчлэн зарим нэр томьёог олон янзаар хэрэглэсэн байх тул хуулийн этгээд болон хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын ялгаа, төсөөтэй талыг тодруулж, хууль тогтоомжийн төсөл боловсруулахад анхаарах шаардлагатай юм.

ЗӨВЛӨМЖ

Хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын мөн чанарыг нарийн судалж, танин мэдсэнээр зарим хуулийн этгээд (нийтийн эрх зүйн этгээдэд хуулийн этгээдийн эрхгүй байгууллага хамаарах эсэх)-ийн эрх зүйн байдлыг тодорхой болгох, худалдааны эрх зүйн суурь ухагдахуун болох худалдаа эрхлэгчийг оновчтой тодорхойлоход дэмжлэг үзүүлэх юм.

Сууц өмчлөгчдийн холбоог Иргэний хуулиар хуулийн этгээдийн эрхгүй гэсэн боловч СӨХЭЗБНЗОСБДӨӨХтХ, Газрын тухай хуулиар хуулийн этгээдийн зарим эрхийг шилжүүлэн өгчээ. Иймд СӨХ-г хуулийн этгээдийн эрхгүй гэсэн Иргэний хуулийн зохицуулалтад нийцүүлэхийн тулд СӨХЭЗБНЗОСБДӨНХтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл уг хуулийг шинэчлэн найруулах шаардлага үүсэхээр байна.

Хэрэв СӨХ-г хуулийн этгээдийн эрх зүйн чадвартай гэж хуулиар хүлээн зөвшөөрөх нөхцөлд сууц өмчлөгч болон гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг нөхөн төлөх асуудлыг анхааралдаа авах шаардлагатай болно. Аль ч тохиолдолд СӨХ нь Газрын тухай хуульд заасны дагуу орчны газрыг эзэмших үндэслэлгүй байна.

НОМ ЗҮЙ**I. Эрх зүйн акт**

1. Монгол Улсын Үндсэн хууль (1992)
2. Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)
3. Иргэний хууль (2002)
4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2002)
5. Газрын тухай хууль (2002)
6. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль (2003)
7. Ашигт малтмалын тухай хууль (2006)
8. Өрсөлдөөний тухай хууль (2010)
9. Банкны тухай хууль (2010)
10. Ойн тухай хууль (2012)
11. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль (2012)
12. Хөрөнгө оруулалтын тухай хууль (2013)
13. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2016)
14. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)
15. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль (2019)
16. Татварын ерөнхий хууль (2019)
17. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль (2019)
18. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (2019)
19. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль (2020)

II. Монгол хэл дээрх эх сурвалж

1. Д.Баярсайхан, Эрх зүйн онол. УБ, 1996
2. Г.Совд, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ, 2000
3. Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн удиртгал. УБ, 2002
4. Б.Улаанбаатар, Иргэний эрх зүй-тайлбар толь. УБ., 2005
5. Хууль зүйн үндэсний хүрээлэн. Монгол Улсын хууль тогтоомж дахь хуулийн этгээдийн ойлголт, нэр томъёоны хэрэглээ. УБ, 2021
6. Н.Баярмаа, Нийтийн зориулалттай орон сууцны өмчлөх эрх ба сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал. 2020
7. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн хэрэгжилт, бусад орны туршлага. Парламентын судалгааны эмхэтгэл, XXIII боть
8. Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар. Шинжлэх ухааны тайлбар. УБ, 2015

9. Д.Баттулга, Ойн нөхөрлөлийн эрх зүйн байдал болон тулгамдаж буй асуудал.

III. Гадаад хэл дээрх эх сурвалж

1. Министерство образования Российской Федерации. Московская государственная юридической академия. Калпин А.Г. (ред.), Масляев А.И. (ред.) Гражданское право. Часть первая. Учебник. 2-е изд., перераб. и доп. М., 2002.
2. Московский государственный университет имени М.В.Ломоносова. Е.А.Суханова (ред.). Гражданское право в 4-х томах. Том I. Общая часть. Учебник. 3-е изд., перераб. и доп. М., 2010
3. Сабирова Л.Л. Теоритические и правовые основы юридических лиц в российском и зарубежном праве. Вестник экономики, права и социологии, 2014, №2
4. Гражданское уложение Германии. Вводный закон к Гражданскому уложению. 3-е изд., перераб. М., 2008
5. McC., J. M. Trusts for Unincorporated Associations. Legal Entity and Perpetuity. Virginia Law Review 35, no. 8 (1949)
6. Green, Brian. The Dissolution of Unincorporated Non-Profit Associations. The Modern Law Review 43, no. 6 (1980)
7. Sturges, Wesley A. Unincorporated Associations as Parties to Actions. The Yale Law Journal 33, no. 4 (1924)

IV. Цахим эх сурвалж

1. www.legalinfo.mn
2. www.shuukh.mn
3. <https://legalddata.mn/b/829>
4. <https://legalddata.mn/b/342>
5. https://reg-nko.ru/sub/Obschestvennaya_organizaciya_bez_yur_lica
6. <https://doi.org/10.2307/1069654>
7. <http://www.jstor.org/stable/1095522>
8. <https://doi.org/10.2307/788053>
9. <https://cyberleninka.ru/article/n/pravospособnost-i-pravosubektnost-k-voprosu-o-soderzhanii-i-sootnoshenii-ponyatiiv/viewer>

ТАВ. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ ДАХЬ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ОЙЛГОЛТ, НЭР ТОМЬЁОНЫ ХЭРЭГЛЭЭ

Судалгааг удирдсан:	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах
Судалгааг хянасан:	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн ухааны доктор С.Сүхбаатар
Судалгааг гүйцэтгэсэн:	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан Э.Анударь Эрдэм шинжилгээний ажилтан Д.Дэмидханд Эрдэм шинжилгээний ажилтан Х.Санчир

УДИРТГАЛ

Сэдвийг сонгох үндэслэл

Монгол Улсад нийт 798 хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаагаас зөвхөн “хуулийн этгээд” гэсэн нэр томъёо орсон 190 хууль¹ байна. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад 189 хуульд хуулийн этгээд гэдэгт ямар байгууллагыг ойлгож, хэрэглэж байгаад дүн шинжилгээ хийсэн судалгаа одоогоор байхгүй байна. Хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх, хуулийн этгээдийн төрлүүдийн эрх зүйн байдлыг хууль тогтоомжоор тодорхойлохдоо Иргэний хуулийн Дөрөвдүгээр бүлэгт зааснаас өөрөөр хуульчилснаас болж хуулийн этгээд гэдэг ухагдахууныг нэг мөр ойлгох, хэрэглэхэд бэрхшээлтэй байна.

Тухайлбал, холбоо, сан зэрэг хуулийн этгээд болон шашны байгууллага, музейг төрийн бус байгууллага гэж бүртгэж, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоог нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэж тодорхойлсон хэрнээ зарим хууль тогтоомжид тэдгээрийг нийтийн эрх зүйн этгээд, эсхүл мэргэжлийн холбоо хэмээн зохицуулж байгаагаас болж онол, практикийн зөрүүтэй асуудал Монгол Улсын хууль тогтоомжид үүсгэж байна. Түүнчлэн нийтийн эрх зүйн хуулийн этгээд, нийтийн эрх зүйн этгээд гэсэн хоёр ойлголт зэрэгцэн оршиж байгаа нь хууль ойлгомжтой, нэг мөр байх боломжийг хязгаарлаж байх тул эдгээр ойлголтыг нэгтгэх, эсхүл зөрүүтэй ойлголтуудыг жигдлэх шаардлага бий болжээ.

Мөн ашгийн төлөө бус хуулийн этгээдийг төрийн бус байгууллага гэсэн нэг нэршил дор бүртгэж, ойлгож байгаа нь ойлголт, ангиллын хувьд зөрчилдөөн үүсгэж байна. Үүнээс болж хоорондоо ялгаатай байгууллагын харилцааг нэг хуулиар зохицуулж, зарим ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд татвараас зайлсхийх зорилгоор төрийн бус байгууллагын нэрээр үйл ажиллагаагаа явуулж, цаашлаад мөнгө угаах арга хэрэгсэл болох эрсдэл бодитойгоор бий болжээ.

Үүнийг гавьяат хуульч Б.Чимид өөрийн бүтээлдээ: “Нэг мөр тогтсон нэр томъёогүйгээр үзэгдэл, юмс, түүний хөгжлийн жам ёсны тухай шинжлэх ухааны ойлголтыг төсөөтэй бусад олон ухагдахуунаас ялгаж илэрхийлэх аргагүй. Бас мэргэжил эзэмших, бүр нарийн мэргэших боломжгүй. Энэ нь хууль зүйн шинжлэх ухаанд нэг адил учир холбогдолтой. Тэр дундаа эрх зүйн тухайн шинжлэх ухаан, ялангуяа монголчууд бидний амьдралд дөнгөж нэвтэрч эхлэн төлөвшиж буй бизнесийн эрх зүйд: 1/ нэр томъёог зөв оноож; 2/ нэг мөр хэрэглэж; 3/ нэг янзаар ойлгож хэвших нь бүр ч тулгамдсан хэрэгцээ болов”² гэжээ.

Иймд эрх зүйн харилцааны гол субъект болох хуулийн этгээдийн ойлголт, түүний эрх зүйн чадвар, төрөл, бүртгэл, хэрэглээг судлах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Үүнийг судалснаар төрөөс эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хийгдэх ажилд чухал хувь нэмэр оруулах бөгөөд хууль тогтоомж дахь хийдэл, зөрчил, давхардлыг арилгахад ач холбогдолтой юм.

1 Нэг удаагийн шинжтэй хуулиудыг оруулаагүй болно.

2 Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл, Хоёрдугаар дэвтэр, 2004, 91 дэх тал.

Судлагдсан байдал

Хуулийн этгээдийн талаар хувийн эрх зүйн тэр тусмаа иргэний эрх зүйн нэг сэдэвт бүтээл, сурах бичгүүдэд³ дэд хэсэг болгон авч үзсэн байх боловч хуулийн этгээд, түүний эрх зүйн чадварыг онолын үндэслэлтэйгээр бичиж, мөн чанарыг нь дэлгэрүүлэн тайлбарласан бүтээл Монгол Улсад байхгүй байна. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар судлаачид эрдэм шинжилгээний өгүүлэлдээ бичсэн байдаг ч эдгээрт хуулийн этгээдийн аль төрлийг ойлгохыг судалгаандаа дэлгэрүүлээгүй ажээ. Хуулийн этгээдийн зарим төрлийн талаар Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, доктор Н.Баярмаа “Хуулийн этгээдийн хэлбэрээр байгуулагдсан болон байгуулагдаагүй хамтарсан этгээдийн тухайд” эрдэм шинжилгээний өгүүлэл, “Нийтийн эд юмсын эрх зүй: Монгол Улс дахь төрийн болон орон нутгийн өмчийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт бодлогын судалгаа, судлаач Д.Ганхүрэл “Хуулийн этгээд үндсэн эрхээ хамгаалуулах субъект болох нь” эрдэм шинжилгээний бүтээлийг дурдаж болно. Эдгээр судалгааны ажилд хуулийн этгээдийн ерөнхий ойлголт, эрх зүйн чадварыг авч үзээгүй учир хуулийн этгээдийг “нийтийн” болон “хувийн” гэж ангилах асуудалд дүгнэлт өгөхийн тулд дэлгэрүүлэн судлах шаардлагатай байна.

Сэдвийн шинэлэг тал

Тус судалгаагаар хуулийн этгээдтэй холбоотой харилцааг зохицуулсан Монгол Улсын хууль тогтоомж дахь хийдэл, зөрчлийг илрүүлэхээс гадна хуулийн этгээдийн ойлголтыг онолын үндэслэлтэйгээр авч үзсэн нь судалгааны ажлын шинэлэг талыг илтгэнэ. Хүнээс бусад этгээдийн, тэр дундаа хуулийн этгээдийн эрх зүйн чадварыг судлах нь түүнийг ангилахад чухал ач холбогдолтой шалгуур юм. Иймд хуулийн этгээдийн ойлголт, төрөл, бүртгэлд тулгамдаж буй асуудлыг тодруулсны үндсэн дээр хуулийн этгээдийн төрлийн уялдаа, холбоогүй байдал, хууль тогтоомжийн хийдэл, зөрчлийг арилгахад ач холбогдолтой санал, зөвлөмж боловсруулахыг чармайлаа.

Судалгааны ажлын зорилго, зорилт

Энэхүү судалгааны зорилго нь хуулийн этгээдийн ойлголтыг Монгол Улсын хууль тогтоомжид хэрэглэж буй байдалд дүн шинжилгээ хийх замаар хийдэл, зөрчлийг илрүүлж, хуулийн этгээдийн ойлголт, төрөл, Иргэний хуулиар зохицуулж ирсэн түүхэн уламжлал, гадны зарим улсын хуулийн этгээдийн төрөл, бүртгэлийг судалсны үндсэн дээр уг хийдэл, зөрчлийг даван туулахад авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний санал боловсруулахад оршино.

Уг зорилгын хүрээнд хуулийн этгээдийн ойлголтыг онолын үндэслэлтэйгээр судалж, Монгол Улсын хууль тогтоомжид бий болсон зохион байгуулалтын нэгдлүүд тэдгээрийн уялдаа холбоонд дүн шинжилгээ хийж, зөрчилдөөнтэй асуудлыг тодорхойлох зорилтыг дэвшүүлж байна.

3 Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн ерөнхий анги, 2014; Б.Тэмүүлэн, Д.Энхзул, Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн ерөнхий анги, 2010; Э.Байгал, Иргэний эрх зүйн ерөнхий анги, 2009; О.Жамбалдорж, Монгол Улсын Иргэний эрх зүй ерөнхий үндэслэл. I дэвтэр, 2004 зэрэг бүтээлийг дурдаж болно.

Судалгааны ажлын арга зүй

Судалгааны ажлыг гүйцэтгэхдээ анализ, синтез, түүхчилсэн, харьцуулалтын аргаас гадна хууль тогтоомж, судалгааны ажил, нэг сэдэвт бүтээлийг судалж, баримт бичигт дүн шинжилгээ хийх аргыг ашигласан болно.

Судалгааны ажлын бүтэц

Судалгаа нь удиртгал, нэгдүгээр бүлэг, хоёрдугаар бүлэг, гуравдугаар бүлэг, дүгнэлт, зөвлөмж, ном зүй гэсэн бүтэцтэй.

Нэгдүгээр бүлэгт 1/хуулийн этгээдийн ойлголтыг онолын үндэслэлтэйгээр авч үзэж, хуулийн этгээдийн эрх зүйн чадвар, үндсэн шинж, чиг үүргийг тодруулж, 2/ Монгол Улсын 1952, 1963, 1994 оны Иргэний хууль дахь хуулийн этгээдийн ойлголт, төрлийг 2002 оны Иргэний хуультай харьцуулсан.

Хоёрдугаар бүлэгт 1/Иргэний хууль дахь хуулийн этгээдийн төрлийг бусад хууль тогтоомжоор зөрүүтэй зохицуулсан, ангилсан байдалд дүн шинжилгээ хийх байдлаар хэм хэмжээний хийдэл, зөрчлийг илрүүлж, 2/ хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар бүртгэж буй байгууллагууд болох төрийн бус байгууллага, шашны байгууллага, нийтийн эрх зүйн хуулийн этгээд, төрийн байгууллага, албан газар, үйлдвэрийн газрын эрх зүйн байдлыг тодруулж, хуулийн этгээд мөн эсэхэд дүн шинжилгээ хийх байдлаар тулгамдаж буй асуудлыг тодруулсан.

Гуравдугаар бүлэгт ОХУ, БНКУ, БНФУ, ХБНГУ, Япон улсын хуулийн этгээдийн ойлголт, төрлийг харьцуулан судалж, эцэст нь Монгол Улсын хууль тогтоомж дахь нэр томъёоны зөрүүтэй байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, хэм хэмжээний хийдэл, зөрчлийг арилгахад ач холбогдолтой байж болох санал, зөвлөмж боловсруулахыг зорилоо.

Судалгааны ажлын хүлээгдэж буй үр дүн

Монгол Улсын хууль тогтоомж дахь хуулийн этгээдийн ойлголт, төрөл, бүртгэлийн асуудлыг судалснаар одоо хүчин төгөлдөр үйлчилж буй болон цаашид боловсруулах хуулийн төсөлд хуулийн этгээдийг нэг мөр зохицуулах шаардлагыг тодотгож, хувийн болон нийтийн эрх зүйн салбарт хуулийн этгээдийн эрх зүйн чадвар, төрөл, бүртгэлийг гүнзгийрүүлэн судлах хэрэгцээтэй байгааг тодруулахыг зорьж байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ОЙЛГОЛТ, ТҮҮХЭН ХӨГЖИЛ

I. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ОЙЛГОЛТ, ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Хуулийн этгээд бий болох эх үндэс эртний Ромын үеэс эхлэлтэй бөгөөд Ромын эрх зүйд “хуулийн этгээд” гэх ойлголт байгаагүй ч эрх зүйн ийм онцгой субъект бий болж эхэлсэн. Хуулийн этгээдийг англи хэлэнд “legal entity”, “juridical entity”, “legal person”, “juridical person”, “fictitious person”, “corporation”⁴, франц хэлэнд “la personne morale”, герман хэлэнд “juristische person”, орос хэлэнд “юридическое лицо” гэж нэрлэдэг.

Хуулийн этгээдийн мөн чанарыг ойлгохын тулд түүний эрх зүйн чадварын асуудлыг судлах шаардлага зүй ёсоор бий болно. Эрх зүйн чадвар⁵, чадамжийг⁶ “legal capacity” гэж нэрлэдэг бол хүнээс бусад этгээдийн эрх зүйн чадварыг⁷ баруун Европын эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлд “legal personality”, “legal personhood”⁸ гэсэн нэр томъёогоор илэрхийлж байна.

Монгол Улсад “хуулийн этгээд” гэдэгт өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чаддаг, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг ойлгодог.⁹ Хуулийн этгээд нь зохион байгуулалтын хэлбэр, өмчийн хэлбэр, үйл ажиллагааны төрлөөсөө хамааран олон төрөлд хуваагдана.

Б.Тэмүүлэн, Д.Энхзул, Б.Буянхишиг нар “Иргэний эрх зүйн ерөнхий анги” бүтээлдээ хуулийн этгээдийг 1/хүмүүсийн нэгдэл; 2/хөрөнгийн нэгдэл гэж хуваан тодорхойлжээ. Ингэхдээ: “Хуулийн этгээд нь эрх зүйн чадвартай буюу эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Тухайн нэгдэл нь бодит байдал дээр өөрөө үйлдэл хэрэгжүүлж чадахгүй тул түүний өмнөөс удирдлагын байгууллага нь үйлдлийг хэрэгжүүлнэ. Нэгдлээс гишүүн гарах эсхүл шинээр орсноор нэгдлийн байдалд ямар ч өөрчлөлт орохгүй буюу энэхүү нэгдэл нь гишүүдийн өөрчлөлтөөс хараат бус байдаг онцлогтой.

Мөн адил хөрөнгийн нэгдлийн хувьд бие даасан эрх зүйн этгээд болох шаардлага бий болж болно. Хэн нэгэн этгээд өөрийн хөрөнгийн тодорхой хэсгийг тодорхой зорилгод хүрэхийн тулд зарцуулах шаардлага гарвал тэрээр холбогдох гэрээ, хэлцлийг өөрөө биечлэн хийх боломжтой ч тэрээр үүнийг хүсэхгүй байж болно. Зарим тохиолдолд хэн нэгэн этгээд өөрийгөө нас барсны дараа өөрийн хөрөнгийг бүхэлд нь эсхүл түүний хэсгийг тодорхой зорилгоор ашиглахыг хүсдэг.

4 Англо-саксоны эрх зүйн бүлийн орнуудад “корпораци” болон “хуулийн этгээд”-ийг ижил утгаар хэрэглэдэг.

5 Passive capacity.

6 Active capacity.

7 Иргэний хууль дахь иргэний эрх зүйн чадвараас илүү өргөн хүрээтэй, зарим талаараа нэг агуулгатай ойлголт бөгөөд монгол хэлэнд буулгаж байгаагүй байна.

8 Legal personality гэж хүнээс бусад этгээд (хуулийн этгээд, амьтан, гол, ус, хиймэл оюун ухаан)-ийн эрх зүйн чадварыг илэрхийлж буй ойлголт байна. Харин legal personhood гэж шинээр бий болж буй ойлголт бөгөөд энэхүү судалгаагаар хуулийн этгээдийн эрх зүйн чадварын мөн чанарыг ойлгоход тус онолыг ашиглах бөгөөд хүнээс бусад амьтан, хиймэл оюун ухааны эрх зүйн чадварын асуудлыг хөндөөгүй болно.

9 Монгол Улсын Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгээр.

Эдгээр шаардлагын үндсэн дээр хуулиар хөрөнгийн нэгдлийг бие даасан байх, мөн хуулийн этгээд байх боломжийг олгосон юм.¹⁰

Хүмүүсийн болон эд хөрөнгийн нэгдэл гэдгээс гадна хуулийн этгээдийн мөн чанарыг хийсвэр шинэ субъект бий болгох агуулгаар мөн ойлгодог. Жишээ нь, Мэри өөр этгээдтэй байгуулсан гэрээний үүргээ биелүүлээгүй нөхцөлд нөгөө талд учруулсан хохирлоо төлөх үүрэгтэй болно. Энэ тохиолдолд Мэри иргэний хувьд өөрийн хувийн хөрөнгөнөөс хохирлыг барагдуулна. Хэрвээ Мэри нэг хүнтэй “Мэри” нэртэй компанийг байгуулан гэрээ хийсэн бол хохирлыг тухайн компанийн хөрөнгөөс барагдуулах байсан. Мэри энэ нөхцөлд хувь хүн, хуулийн этгээд гэх хоёр өөр этгээдийн хувиар эрх зүйн харилцаанд оролцох боломжтой байна.¹¹

Ийнхүү хуулийн этгээдийн ойлголтыг онолын үндэслэлтэйгээр авч үзсэнээр Монгол Улсын хууль тогтоомжид “нийтийн эрх зүйн хуулийн этгээд”, “нийтийн эрх зүйн этгээд” гэх ойлголтыг зөрүүтэй хуульчилж буй асуудалд үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашлаад хуулийн этгээдийн бий болсон төрлүүдийг цэгцтэйгээр ангилах, тус ойлголтыг зөв, нэг мөр хэрэглэхэд чухал ач холбогдолтой юм.

1. Үгийн гарал үүсэл

Хувь хүн буюу иргэнийг “natural person”, хуулийн этгээдийг “legal person” гэж тодорхойлон бичих тохиолдол түгээмэл байна.¹² “Person” гэх үг олон утгатай. Мексик улсын хуульч, философич Эдуардо Гарси Майнез (Eduardo Garza Munez)-ийн үзсэнээр “person” гэдэг үгийн гарал үүсэл тодорхойгүй ч personare буюу баг (mask) гэдэг ойлголтоос гаралтай байж болохыг тэмдэглэжээ. Энэ утгаараа “person” гэж жүжигчин тоглолтын үед нүүрээ халхлах зорилгоор зүүдэг багийг илэрхийлэх бөгөөд баг зүүснээр түүний хоолой тод, чанга сонсогддог байжээ. Сүүлд нь хүмүүс тухайн жүжигчнийг өөрийг нь “person” гэж нэрлэх болсон.¹³

“Entity” гэх үг XV зууны сүүл үед үүссэн. Латинаар entitas, францаар entité гэдгээс гаралтай бөгөөд онцгой болон бие даасан оршихуй, байх гэсэн утгатай байна.¹⁴ Үүнээс харвал “legal entity”, “la personne morale” гэсэн нэршил нь хийсвэр, онцгой гэсэн утга агуулгыг илэрхийлж байна. Харин монгол хэлэнд “хуулийн этгээд” гэх үгийн гарал үүсэл, агуулгыг монгол хэлний тайлбар толь бичигт тайлбарлаагүй бөгөөд энэ нь цэвэр хууль зүйн нэр томьёо болохыг илтгэхээс гадна орос хэлэнд “юридическое лицо”, герман хэлэнд “juristische person” гэснийг буулгасан нэр томьёо байх боломжтой гэж үзлээ.

10 Б.Тэмүүлэн, Д.Энхзул, Б.Буянхшиг, Иргэний эрх зүйн ерөнхий анги. Анхны хэвлэл. УБ., 2010. 236-237 дахь тал.

11 A Theory of Legal Personhood. Visa A.J.Kurki. 2019. Oxford University. Холбоо: www.oxford.universitypressscholarship.com

12 Иргэний эрх зүйн чадвар нь төрснөөр бий болж, нас барснаар дуусгавар болдог бөгөөд байгалийн жам ёсоор хүн амьд байх үйл явцтай холбоотой учраас хүнийг “natural person” гэж; хуулийн этгээдийн эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хууль заасны дагуу татан буугдаж, бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болж байх тул “legal person” гэж тус тус үзсэн байх боломжтой.

13 Royal Spanish Academy, voice Person, Dictionary of Spanish Language. Espasa, 1593. Дам ишлэв: Elvia Arcelia Quintana Adriano. Natural persons, juridical persons and legal personhood. Mexican Law Review, Vol.VIII, No.1. p.104.

14 <https://languages.oup.com/google-dictionary-en/>

2. Онолын үндэслэл

Хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрх зүйн чадвар, шинжийг улс орнууд нэгдсэн байдлаар тодорхойлоогүй. Ямар субъектыг хуулийн этгээд гэж ойлгох нь ялгамжтай байдаг тул онолын үндэслэлийг тодруулах шаардлага зүй ёсоор тавигдана. Хуулийн этгээдийн ойлголтыг авч үзсэн хэд хэдэн онол байгаагаас “fictional theory” буюу хийсвэрлэх онол ноёлох байр суурийг эзэлж байна. Иймд түгээмэл хэрэглэгддэг дөрвөн онолыг авч үзье. Үүнд¹⁵:

- Хийсвэрлэх онол (Фридрих Савини¹⁶): хуулийн этгээд гэж субъектив эрх эдлүүлж, үүрэг хүлээлгэх зорилгоор бий болгосон *persona ficta* бөгөөд эдгээр эрх бодит байдал дээр түүний гишүүдэд, эсхүл эзэнгүйгээр оршдог.¹⁷ Иргэний эрх зүйд хийсвэрлэл гэдэг нь бодит байдал дээр байхгүй зүйлийг хуульчилж, тодорхой зохион байгуулалтын хэлбэрээр дамжуулан эс оршихуйг бодит болгохыг хэлнэ. Хэдэн зууны турш Савинигийн хийсвэрлэх онол шүүмжлэлд өртөөгүй. Харин XIX зууны эхэн үед уг онолыг зарим сэтгэгчид үгүйсгэхдээ бодит байдал дээр байхгүй этгээдийг хийсвэрлэх замаар бий болгох боломжгүй гэж үзжээ.¹⁸ Энэ онолын дагуу эрх эдэлж, үүрэг хүлээдэг ямар ч байгууллага хуулийн этгээд байх боломжтой.
- Зорилгын онол (Бринз¹⁹): хуулийн этгээдийн хөрөнгийг төрөөс үүсгэсэн хийсвэр байгууллага бус ерөөсөө хэн ч өмчилдөггүй. Үндсэндээ хуулийн этгээдийн өмч хувь хүмүүсийнх биш, гагцхүү зорилго (*zweckvermugten*)-д үйлчилнэ. Хэдийгээр зорилгын онолыг цөөн хүн дэмждэг ч, зарим талаараа энэ онол үндэслэлтэй юм. Зөвхөн сан, ашгийн төлөө бус байгууллагууд төдийгүй компаниудын хөрөнгө мөн ялгаагүй тусгай зорилгод чиглэдэг гэж үздэг байна.²⁰
- Реалист онол: энэ онолын дагуу хувийн болон төрийн өмчит хуулийн этгээд бодитойгоор оршино. Иймээс хүмүүс төдийгүй хүсэл зоригтой, амьд бусад этгээдүүд эрх эдлэх чадвартай байна. Энэхүү сэтгэлгээний дагуу хуулийн этгээд нь бодитойгоор орших байгууллага мөн бөгөөд хууль нь тэдгээрийн оршихуйг хүлээн зөвшөөрч, баталгаажуулдаг төдий юм. Өөрөөр хэлбэл, хууль нь хуулийн этгээдийг бий болгож чадахгүй, зөвхөн тэдгээрийн оршихуйг хүлээн зөвшөөрдөг. Эдгээр онолуудад «органицизм»

15 Royal Spanish Academy, *voice Person*, Dictionary of Spanish Language. Espasa, 1593. Дам ишлэв: Elvia Arcelia Quintana Adriano. *Natural persons, juridical persons and legal personhood*. Mexican Law Review, Vol.VIII, No.1. p.106-107.

16 Герман улсын нэрт хуульч, түүхч, сэтгэгч бөгөөд хийсвэрлэх онол (Personificationstheorie)-ыг үндэслэгч.

17 Савини Ф. К. Система современного римского права. Т.1. М., 2011. стр.138.

18 Анатолий Коструба. Теория юридического лица: Интегративный подход. Учреждение образования Гродненский Государственный Университет имени Янки Купалы. Проблемы гражданского права и процесса. 2020. стр.81 <https://hal.archives-ouvertes.fr/hal-03114548/document>

19 Герман улсын нэрт хуульч, улс төрч бөгөөд зорилгын онолыг үндэслэгч.

20 Arthur W.Machen, Jr. *Corporate personality*. Harvard Law Review, Feb., 1911. Vol.24, No.4. p.256 <https://www.jstor.org/stable/1234056>

(organicism)²¹, “хамтын ухамсрын онол” (the collective soul theory)²², “нийгмийн организмын онол” (social organism theory)²³ багтана.

- Формалист онол (Франциско Феррара)²⁴: “этгээд” буюу “person” гэдэг үгийг Феррара гурван утгатай гэж үзсэн. Үүнд: (а) биологийн хувьд оршин буй бие; (б) философийн хувьд зорилго тавьж, түүнийгээ хэрэгжүүлэх чадвартай ухамсарт оршихуй; ба (в) хууль зүйн хувьд, эрх үүрэг бүхий эрх зүйн харилцааны субъект юм.

Үүнээс үзэхэд, дээр дурдсан онол болгон өөрийн гэсэн үндэслэл бүхий санааг дэвшүүлсэн бөгөөд хуулийн этгээдийн ойлголтыг тайлбарлахад ихээхэн ач холбогдолтой байна.

3. Эрх зүйн чадвар, чадамж

Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно гэжээ. Үүнийг доктор Э.Байгал тайлбарлахдаа: “Хувь хүний хувьд иргэний эрх зүйн чадвар ба чадамж хэмээх хоёр тусдаа ойлголт яригддаг бол хуулийн этгээдийн хувьд иргэний эрх зүйн харилцаанд оролцож хүчин төгөлдөр хэлцэл хийх, эрх үүрэг олж авахад иргэний эрх зүйн чадвартай байх шаардлага тавигдана. Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар гэдэг нь түүнийг үүсгэн байгуулах баримт бичигт заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцсэн эрх эдэлж, энэхүү үйл ажиллагаатайгаа холбогдсон үүрэг хүлээх чадвар юм” гэжээ.

2002 оны Иргэний хуульд хуулийн этгээд нь эрх зүйн чадвартай бус “иргэний” эрх зүйн чадвартай гэж тодотгосон байна. Ингэснээр Монгол Улсад хуулийн этгээдийг гагцхүү иргэний эрх зүйн ойлголт болгон хэрэглэх үндсийг тавьсан байж болох юм.

Оросын эрдэмтэн Е.А.Суханов хуулийн этгээдийг иргэний эрх зүйд хамааралтай буюу эдийн баялгийн үүднээс тодорхой хэрэгцээгээ хангах зорилгоор үүсдэг гэж үзжээ. Гэвч хуулийн этгээд нь иргэний, хөдөлмөрийн, захиргааны, иргэний процессын болон бусад салбар эрх зүйн харилцаанд нэгэн адил оролцох боломжтой юм. Үүнээс үүдэн эрх зүйн онолд хуулийн этгээдийн эрх зүйн чадавхын²⁵

21 Органицизм нь “байгууллагын нэгдэл нь хувь хүнтэй харьцуулахад бодитой байгууллага мөн” гэж үздэг.

22 Энэхүү сэтгэлгээний дагуу нийгэмд тусдаа ухамсартай бие хүмүүсийн бүлгээс гадна тусдаа ухамсартай нэгдэл байдаг учраас хувь хүнээс гадна хуулийн этгээд орших нь асуудалгүй юм.

23 Нийгмийн организмын онолыг баримтлагчдын томоохон төлөөлөгч бол Отто Гьерк (Otto Gierke) бөгөөд тэрээр “нэгдсэн этгээд бол гишүүдийнхээ хувьд гуравдагч этгээд бус, харин тэдгээрийг эрхийн хувьд нэг цул болгон нэгтгэж буй органик холбоос юм. Тиймээс нэгдсэн этгээд нь түүнийг бүрдүүлж буй бүлэг хүмүүсээс салшгүй холбоотойгоор дээр нь оршино. Энэ бол нэгдэл бүхий өвөрмөц байгууллага юм” гэжээ.

24 Италийн нэрт эдийн засагч, улс төрийн ухааны эрдэмтэн. Тэрээр Адам Смит, Дэвид Рикардо нарын эдийн засгийн сонгодог онолыг Италийн шинжлэх ухаанд нэвтрүүлсэн хүн бөгөөд формалист онолыг үндэслэгч юм.

25 Англи хэлэнд “legal personality”, орос хэлэнд “правосубъектность” гэж хэлдэг байна. Уг ойлголт эрх зүйн чадвар болон чадамжийг өөртөө багтаасан тул энэхүү судалгааны хүрээнд монгол хэлэнд эрх зүйн чадавх гэж орчуулав.

асуудал бий болдог. Хийсвэрлэх онолын төлөөлөгчид хуулийн этгээдийг эрх зүйн чадамжгүй гэж үзэхдээ уг асуудлыг тухайн этгээд удирдлагаараа дамжуулан шийдвэрлэх боломжтой хэмээжээ. Харин Е.А.Сухановын үзсэнээр хуулийн этгээд нь эрх зүйн чадамжтай юм.

Жишээ нь, Швейцар улсын Иргэний хуулийн 54 дүгээр зүйлд хуулийн этгээдийн эрх зүйн чадамж хууль болон үүсгэн байгуулах баримт бичигт заасан хуулийн этгээдийн байгууллага байгуулагдсанаар үүснэ. Хуулийн этгээдийг эрх зүйн чадамжтай гэж үздэг бусад улсын жишээнд Украин болон Молдав улсыг дурдаж болно. ОХУ-ын Иргэний хуулийн 53 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хуулийн этгээд нь иргэний эрхийг хууль, бусад эрх зүйн акт болон дүрмийн дагуу үүссэн өөрийн байгууллагаар дамжуулан эдэлнэ гэжээ. Ингэснээр ОХУ-ын хууль тогтоогчид хуулийн этгээдийн эрх зүйн чадамжийг түүний байгууллагын эрх зүйн чадамжаар дамжуулан тодорхойлсон байна.²⁶

Ийнхүү хуулийн этгээдийн эрх зүйн чадавх (legal personality, legal personhood)-г үгүйсгэх боломжгүй юм. Учир нь эрх зүйн чадавх нь эрх зүйн чадвар болон чадамжийг өөртөө багтаах бөгөөд улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуулийн этгээдийг эрх зүйн харилцаанд оролцогч болохыг тодорхойлно. Энэ учраас эрх зүйн чадварыг заримдаа эрх зүйн чадавх гэж нэрлэдэг ч түүний нэг төрөл гэж оросын эрдэмтэн В.Ф.Яковлев үзжээ.²⁷

1963 оны БНМАУ-ын Иргэний хуулийн 22 дугаар зүйл, 1994 оны Монгол Улсын Иргэний хуулийн 25 дугаар зүйлд хуулийн этгээдийн байгууллагын талаар зохицуулж байсан бөгөөд хуулийн этгээд нь байгууллагаараа дамжуулан иргэний эрх зүйн харилцаанд оролцох боломжтой байжээ. Мөн 2002 оны Монгол Улсын Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэгт хуулийн этгээд удирдах байгууллагаараа дамжуулан иргэний эрх зүйн харилцаанд оролцохоор заасан тул хуулийн этгээдийн эрх зүйн чадамжийг ОХУ-ын Иргэний хуулийн холбогдох заалттай ижил байдлаар тайлбарлах боломжтой юм.

Харин эрх зүйн чадавхын талаар Монгол Улсад нарийн судлагдаагүй байна. Академич С.Нарангэрэл иргэний эрх зүйн чадварын агуулгыг дараах байдлаар тайлбарласан. Үүнд:

1. Эд хөрөнгө өмчлөх эрхтэй байх;
2. Эд хөрөнгөө өвлүүлэх ба гэрээслэх;
3. Хуулиар хориглоогүй аливаа аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх;
4. Бие дааж буюу бусад иргэн ба хуулийн этгээдтэй хамтран хуулийн этгээд байгуулах;
5. Хуульд харшлаагүй аливаа хэлцэл хийх ба үүрэгт оролцох;
6. Оршин суух газраа сонгох;
7. Шинжлэх ухаан, утга зохиол ба урлагийн бүтээл, шинэ бүтээл ба хуулиар хамгаалагдсан оюуны бүтээлч үйл ажиллагааны бусад үр дүнгийн зохиогчийн эрх эдлэх;

26 Сабирова Л.Л. Теоритические и правовые основы юридических лиц в российском и зарубежном праве. Вестник экономики, права и социологии, 2014, №2. стр.143.

27 Гордеева Ж.А. Правоспособность и правосубъектность: к вопросу о содержании и соотношении понятий. <https://cyberleninka.ru/article/n/pravosposobnost-i-pravosubektnost-k-voprosu-o-soderzhanii-i-sootnoshenii-ponyatiy/viewer>

8. Эдийн ба эдийн бус баялгийн бусад эрх эдлэх зэргээр тодорхойлогдоно гэжээ.²⁸

Эрх зүйн чадвар нь өөрийн үйлдлээр эдгээр эрх ба үүргийг хэрэгжүүлэхгүй, харин гагцхүү эдлэх боломжтой болохыг илэрхийлнэ.²⁹ Хуулийн этгээдийн эрх зүйн чадварыг дээр тодорхойлсон иргэний эрх зүйн чадварын агуулгаар тайлбарлаж болох ч хуулийн этгээдийн эрхгүй байгууллага болон хуулийн этгээдийн мөн чанарыг ялгахад түүний эрх зүйн чадавх буюу эрх зүйн чадвар, чадамжийн асуудлыг цаашид дэлгэрүүлэн судлах хэрэгцээтэй байгаа нь харагдаж байна.

4. Үндсэн шинж

Академич С.Нарангэрэл “Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь бичиг” бүтээлдээ хуулийн этгээдийн үндсэн шинжийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Зохион байгуулалтын нэгдэл;

Тусгайлсан эд хөрөнгөтэй;

Бие даасан баланс ба эд хөрөнгийн төсөв бүхий;

Эд хөрөнгийн бие даасан хариуцлага хүлээсэн;

Иргэний гүйлгээ ба иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрийн нэрийн өмнөөс оролцох боломж зэрэг юм.

Доктор Э.Байгал “Иргэний эрх зүйн ерөнхий анги” бүтээлд дээр дурдсан бие даасан баланс ба эд хөрөнгийн төсөв бүхий шинжийн оронд хуулийн этгээд нь өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээх шинжийг тодорхойлсныг дэлгэрүүлбэл,

- Тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдэл- энэ шинж нь тухайн хуулийн этгээд өөрийн зорилго чиг үүргээ хэрэгжүүлэхэд чиглэсэн удирдах байгууллага, дотоод бүтэцтэй байхыг хэлнэ. Хуулийн этгээдийг үүсгэн байгуулах үндсэн баримт бичиг болох дүрэм, үүсгэн байгуулах хурлын шийдвэрт түүний зохион байгуулалт удирдлага, чиг үүрэг зэргийг тодорхой зааж өгдөг ба иймээс ч аливаа хуулийн этгээдийн дүрэм нь хамгийн чухал баримтын тоонд зүй ёсоор багтдаг. Хуулийн этгээдийн дүрмээс тухайн хуулийн этгээд чухам ямар төрөл, хэлбэрийн хуулийн этгээд болохыг тодорхойлох боломжтой юм.
- Тусгайлсан хөрөнгөтэй байх- хуулийн этгээдийн өмчлөх эрхэд байх хөрөнгө нь хуулийн этгээдийн хувь нийлүүлэгчид буюу үүсгэн байгуулагчдын оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх ба харин энэхүү хөрөнгө нь тэдний хувийн хөрөнгөөс тусгаарлагдсан байдаг. Ийм эд хөрөнгөгүй байх нь иргэний гүйлгээнд оролцох боломжгүйг илтгэх бөгөөд иргэний эрх зүйн субъект болох боломжгүй юм. Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагчдын хувь нийлүүлсэн хөрөнгө нь түүнийг үүсгэн байгуулсан үед балансад нь бүрэн тусгагдсан байна.

28 С.Нарангэрэл, Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг, 2021, 629 дэх тал.

29 Мөн тэнд.

- Хуулийн этгээд нь өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээх- аливаа хуулийн этгээд нь улсын бүртгэлд бүртгүүлсэн, оноосон нэрээрээ тодорхой эрхийг олж авах, үүрэг хүлээх боломжтой юм. Тухайлбал, газар эзэмших, эсхүл уул уурхайн хайгуулын тусгай зөвшөөрөл олж авах гэх мэт. Эдгээр эрхүүд нь тухайн хуулийн этгээдийн нэр дээр л олгогдож байгаа эрх болно.
- Хуулийн этгээдийн үйл ажиллагаанаас үүсэн бий болох эрх зүйн үр дагаврыг дээрх тусгайлсан хөрөнгөөрөө хариуцах- энэхүү шинж нь түүний тусгайлсан эд хөрөнгөтэй байх шинжтэй салшгүй холбоотой ба хуулийн этгээд нь явуулж буй аливаа үйл ажиллагаа /бусадтай байгуулсан гэрээ, үйл ажиллагаатай холбоотой бусдад учруулсан хохирол гэх мэт/-ны улмаас үүсэх бүхий л үр дагаврыг тусгайлсан хөрөнгөөрөө хариуцах юм.
- Шүүх арбитрт өөрийн нэрийн өмнөөс оролцох- нэгэнт тодорхой үйл ажиллагаа явуулж, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээсэн хуулийн этгээд нь үүнээсээ гарах үр дагавартай холбоотойгоор шүүх, арбитрт нэхэмжлэл гаргах, эсхүл хариуцагчаар татагдах чадвартай байна. Тухайн хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд /ерөнхий захирал, дарга, хуулийн хэлтсийн ажилтан гэх мэт/, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч нь шүүх арбитрт төлөөлөх боломжтой.³⁰

Дээр дурдсан шинж нь хуулийн этгээдийг иргэний эрх зүйн харилцаанд оролцогч субъект байхаар хязгаарлаагүй байна. Нэгэнт хуулийн этгээд гэх ойлголтыг эрх зүйн субъект болохынх нь хувьд авч үзэхийн тулд түүний шинжийг зарим онолын дагуу авч үзье.

Кельзений онолын дагуу хуулийн этгээдийн шинжүүд нь:

- Зохиомол байгууллага байх;
- Удирдлага, зохион байгуулалттай байх;
- Эрх зүйн чадвартай байх;
- Субъектив эрх, үүрэг эдлэх боломжтой байх;
- Хүсэл зоригтой байх;
- Эрх зүйн чадавх (legal personhood)-тай байх зэрэг юм.

Де Бенитогийн хувьд хуулийн этгээдийн шинжүүд нь:

- Хэд хэдэн хувь хүний нэгдэл байх;
- Хамтын ажиллагаатай байх;
- Байгууллага байх;
- Эд хөрөнгийн онцгой эрхтэй байх;
- Нийгмийн тодорхой зорилгод үйлчилдэг байх юм.

Карнелуттигийн хувьд хуулийн этгээдийн шинжүүд нь:

- Эрх зүйн чадвартай байх;
- Эрх зүйн чадавх (legal personhood)-тай байх;
- Эдийн засгийн шинжтэй байх;
- Хууль зүйн шинжтэй байх зэрэг юм.

30 Э.Байгал, Иргэний эрх зүйн ерөнхий анги, 2009, 45-46 дахь тал.

Кельзен хуулийн этгээдэд байх шинжид хүсэл зоригийг хамааруулсан нь хуулийн этгээд ухамсаргүйн хувьд өөрийн гэсэн хүсэл зориггүй байдаг. Харин бусад шинжээр хуулийн этгээдийн агуулгыг бүрэн гаргах боломжтой. Эдгээрт гагцхүү иргэний эрх зүйн харилцааны субъект байх шинжийг огт дурдаагүй байгаа нь хуулийн этгээд гэх ойлголтын цар хүрээг харуулж байна. Хуулийн этгээдийн шинж төрийн байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон төрийн өмчит хуулийн этгээдүүдэд байгааг дурдах нь зүйтэй.

5. Чиг үүрэг

Хуулийн этгээдийн нийтлэг чиг үүргийг дараах байдлаар томьёолжээ. Үүнд³¹:

Хамтын ашиг сонирхлыг томьёолон тогтоох хуулийн этгээд болсноор оролцогчдын үйл ажиллагааг зохион байгуулалтад оруулж дотоод харилцааг журамлан тэдний хүсэл зоригийг байгууллагын (хуулийн этгээдийн) болгон төвлөрүүлж иргэний эрх зүйн харилцаанд өөрийнхөө нэрээр оролцох боломжийг бий болгодог.

Хөрөнгө нэгтгэх хуулийн этгээд нь томоохон үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагаа явуулах гол нөхцөлийг бүрдүүлж хөрөнгийг удаан хугацаагаар төвлөрүүлэх зохистой хэлбэр тул зохих үр ашигтай ажиллах боломж олгоно.

Эд хөрөнгийг зохистой удирдах- хуулийн этгээд нь үйлдвэрлэл, үйлчилгээний янз бүрийн хүрээнд хөрөнгийг зах зээлийн зүй тогтлын дагуу гүйлгээнд оруулах хүчтэй арга хэрэгсэл болдог.

Үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны эрсдлийг хязгаарлах нөхөрлөл, хоршооноос бусад хуулийн этгээд алдагдал, эрсдэл гарвал хувь нийлүүлэгчийн хувь хэмжээгээр эрсдлийг хязгаарлахаар зохион байгуулагдсан байна.

Ийнхүү хуулийн этгээд гэдэг ойлголт иргэний эрх зүйн харилцаагаар л хязгаарлагдахгүй өргөн хүрээнд хэрэглэгдэх агуулгатай ойлголт байна. Үүнийг гавьяат хуульч Б.Чимид: “Уул нь “хуулийн этгээд” гэдэг бол хувь хүн, төр нутаг дэвсгэрийн «автономи» гурваас бусад эрх зүйн харилцаанд оролцогчдыг тэдгээрийн төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, онцлогоос хамаарахгүйгээр хураан багтаасан аугаа их хүчит нэр томьёо буюу уламжлалт ойлголт мөн. Харин социалист эрх зүйн хуучин тогтолцоонд хуулийн этгээд гэдгийг гол төлөв иргэний эрх зүйн харилцааны субьектийн утгаар хэрэглэж ирсэн билээ. Уг ойлголт энэ төвшнөөс одоо ч хэтрээгүй шахам байна. Манай олон хуульд хувь хүн, хуулийн этгээд гэхийн оронд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гэж бичих, хэрэглэх нь ард түмэнд илүү ойлгомжтой, тэдний хяналт тогтооход ч хэрэгтэй юм.”³² гэжээ.

Иймд хуулийн этгээдийг уламжлалт буюу өргөн утгаар нь ойлгож, хэрэглээнд нэвтрүүлэх шаардлага бий болжээ. Ингэснээр эрх зүйн харилцаанд оролцогчдийн эрх зүйн байдал, төрөл, харилцаа хамаарал, эрх, үүрэг, хариуцлага эмх цэгцэндээ орох суурь тавигдах юм.

31 О.Жамбалдорж, Монгол Улсын Иргэний эрх зүй ерөнхий үндэслэл. I дэвтэр, 2004. 118 дахь тал.

32 Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг үндэслэл. Нэгдүгээр дэвтэр, 2004. 315-316 дахь тал.

II.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ ИРГЭНИЙ ХУУЛИАР ЗОХИЦУУЛЖ ИРСЭН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

Хуулийн этгээдийг манай улс өмнөх иргэний хуулиудаар зохицуулж ирсэн уламжлалыг доорх хүснэгтээс харах боломжтой.

Хүснэгт 1. Хуулийн этгээдийг иргэний хуулиар зохицуулж ирсэн түүхэн уламжлал

№	ОЙЛГОЛТ	БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬ (1952)	БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬ (1963)	МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬ (1994)	МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬ (2002)
1	Хуулийн этгээд	Биеэ дааж эд хөрөнгөний эрхийг олж чадах, үүрэг авах, түүнээ хариуцах ба өөрийн эрхийн тухай шүүхэд маргаж чадах хүмүүсийн нэгдэл, албан газар ба байгууллага бол хуулийн этгээдүүд болно.	Өөртөө тусгайлсан эзэмшсэн эд хөрөнгөтэй, өөрийн нэрийн өмнөөс эд хөрөнгийн ба түүнтэй холбоотой эд хөрөнгийн бус эрх олох, үүрэг бий болгож чадах, мөн шүүх, арбитрын газар нэхэмжлэгч, хариуцагч байж чадах байгууллагыг хуулийн этгээд гэнэ.	Өмчлөх буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан эд хөрөнгөтэй; өөрийн үйл ажиллагаагаараа эрх олж, үүрэг бий болгох чадвартай; үйл ажиллагаанаасаа үүсэн гарах үүргийг эд хөрөнгөөрөө хариуцдаг; шүүх арбитрт өөрийн нэрийн өмнөөс оролцдог байгууллагыг хуулийн этгээд гэнэ.	Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ.
2	Хуулийн этгээдийн төрөл		Аж ахуйн тооцооны үндсэн дээр ажилладаг, өөртөө үндсэн ба эргэлт хөрөнгөтэй, биеэ даасан баланстай улсын үйлдвэр, бусад байгууллага; Улсаас санхүүждэг, биеэ даасан төсөвтэй, дарга эрх баригчид нь /хуулиар хязгаарласнаас бусдаар/ уул төсвийг захиран зарцуулах эрхтэй улсын албан байгууллага;	Үүсгэн байгуулагч буюу оролцогч нь тусгайлсан эд хөрөнгийн тухайд эрх, үүргээ хадгалдаг хуулийн этгээд: Компани; Нөхөрлөл; Хоршоо; Өмчлөгчөөс санхүүждэг байгууллага.	Ашгийн төлөө хуулийн этгээд: Нөхөрлөл Компани Ашгийн төлөө бус хуулийн этгээд: Холбоо Сан Хоршоо

			Хөдөө аж ахуйн нэгдэл, үйлдвэр хоршооллын ба олон нийтийн бусад байгууллага, түүнчлэн хууль буюу эдгээр байгууллагын дүрэмд заасан бол тэдгээрийн харьяа биеэ даасан төсөв, баланс бүхий үйлдвэр, албан байгууллага, улс, хоршооллын дундын байгууллага.	Үүсгэн байгуулагч буюу оролцогч нь тухайн хуулийн этгээдийн тусгайлсан эд хөрөнгийн хувьд эд хөрөнгийн эрхээ хадгалдаггүй хуулийн этгээд: Олон нийтийн байгууллага Шашны байгууллага Буяны болон бусад зорилгоор байгуулагдсан сан	
3	Компани	–	–	Гишүүд /хувьцаа эзэмшигчид/-ийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх дүрмийн сантай, хүлээсэн үүргээ өөрийн хөрөнгөөр хариуцдаг, гишүүн нь гагцхүү дүрмийн санд оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцлага хүлээдэг хуулийн этгээдийг компани гэнэ.	Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан хөрөнгөтэй, ашгийн төлөө үндсэн зорилготой хуулийн этгээдийг компани гэнэ.
4	Нөхөрлөл			Гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ энэхүү эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хуульд заасны дагуу хариуцдаг хуулийн этгээдийг нөхөрлөл гэнэ.	Гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ уг эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хуульд заасны дагуу хариуцдаг хуулийн этгээдийг нөхөрлөл гэнэ.
5	Хоршоо			Материаллаг болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хувь хүмүүс сайн дураараа нэгдсэн, ардчилсан удирдлага, хяналт бүхий, хамтран өмчлөх дундын эд хөрөнгө дээр үндэслэн аж ахуй эрхлэх хуулийн этгээдийн хоршоо гэнэ.	Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн затгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.

6	Сан			Нийгэм, соёл, боловсрол, буяны болон нийтэд тустай бусад зорилгоор сайн дурын хандив, тусламж төвлөрүүлж, гагцхүү дүрэмдээ заасан зориулалтын дагуу захиран зарцуулах эрх бүхий сайн дурын, гишүүнчлэлгүй байгууллагыг сан гэнэ.	Нэг буюу хэд хэдэн үүсгэн байгуулагч нийгэмд ашиг тустай, нэгдмэл зорилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх замаар байгуулсан гишүүнчлэлгүй хуулийн этгээдийг сан гэнэ.
7	Холбоо				Нэгдмэл, тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, гишүүнчлэл бүхий хуулийн этгээдийг холбоо гэнэ.
8	Олон нийтийн байгууллага			Оюуны, материаллаг болон материаллаг бус бусад ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор сайн дурын үндсэн дээр нэгдсэн иргэд, хуулийн этгээдийн нэгдлийг олон нийтийн байгууллага гэнэ.	
9	Шашны байгууллага			Сүсэгтэн олны шашны зан үйл, хурал ном, боловсролын хэрэгцээг хангах зорилго бүхий байгууллагыг шашны байгууллага гэнэ.	Сүм хийд иргэний эрх зүйн харилцаанд оролцохдоо сангийн эрх зүйн байдлын талаарх хуулийн заалтыг мөрдөнө.

Хуулийн этгээд гэх ойлголт манай улсад анх 1952 оны Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний хуулиар бий болжээ. Ингэхдээ тодорхой шинж бүхий хүмүүсийн нэгдэл, албан газар болон байгууллага хуулийн этгээдэд хамаарч байв.

1963 оны Иргэний хуульд хуулийн этгээдийг байгууллага гэж үзсэн бөгөөд үүнд төрийн байгууллага болон бусад төрийн өмчит үйлдвэр, бусад байгууллага хамаарч байжээ. Харин 1994 оны Иргэний хуулиар хуулийн этгээдийг үүсгэн байгуулагч буюу оролцогчийг тусгайлсан эд хөрөнгийн тухайд эрх, үүргээ хадгалдаг болон хадгалдаггүй гэж хувааснаас гадна шашны байгууллага, олон нийтийн байгууллага, бусад буяны сан нь хуулийн этгээдэд хамаарч байжээ.

2002 оны Иргэний хуулиар хуулийн этгээд гэдэгт тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа явуулах зохион байгуулалтын нэгдэл байх шинж нэмэгдсэнээс гадна хуулийн этгээдийн төрөлд холбоо шинээр нэмэгдэж, шашны байгууллага, олон нийтийн байгууллага болон төрийн байгууллага хасагдсан байна. Иргэний хуулиас хасагдсан эдгээр байгууллага одоо хүртэл хууль тогтоомжид хэрэглэгдсээр байгаагаас гадна зарим байгууллагын эрх зүйн байдал тодорхойгүй байгаа асуудлыг дараагийн бүлэгт авч үзэх болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХУУЛЬ ТОГТООМЖ ДАХЬ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТӨРӨЛ, НЭР ТОМЬЁО, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

УЛСЫН БҮРТГЭЛ ДЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТӨРӨЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт дараах хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэхээр заасан. Үүнд:

1. Нөхөрлөл;
2. Компани;
3. Холбоо /төрийн бус байгууллага/;
4. Сан;
5. Хоршоо;
6. Шашны байгууллага;
7. Нийтийн эрх зүйн хуулийн этгээд;
8. Төрийн байгууллага, албан газар;
9. Улсын төсөвт үйлдвэрийн газар;
10. Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар.


Иргэний хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу нөхөрлөл, компани нь ашгийн төлөө хуулийн этгээд бол холбоо, сан, хоршоо нь ашгийн бус хуулийн этгээд юм. Гэтэл Иргэний хууль дахь хуулийн этгээдийн таван төрлөөс гадна төрийн бус байгууллага, нийтийн эрх зүйн хуулийн этгээд, төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг хуулийн этгээдээр бүртгэж байна. Өөрөөр хэлбэл, эдгээр байгууллага нь хуулийн этгээдийн ямар төрөлд хамаарах нь тодорхойгүй байна. Улсын бүртгэлээр хуулийн этгээдийн эрх зүйн чадварыг үүсгэх ач холбогдолтой хэдий ч хуулийн этгээдийн ангиллыг бий болгосон гэж үзэх нь өрөөсгөл юм.

2000 онд Монгол Улсад хуулийн этгээдийг таван байгууллагад бүртгэдэг байжээ. Үүнийг тодруулбал:

1. Ашиг олох зорилго бүхий аж ахуйн нэгж болох нөхөрлөл, компани, хоршоо, хувиараа эрхлэх аж ахуйг Улсын татварын ерөнхий газар болон орон нутаг дахь албанд;
2. Төрийн байгууллага, төсөвт албан газрыг Санхүү, эдийн засгийн яаманд;
3. Төрийн бус үүрэг гүйцэтгэдэг үйлдвэрчин, шашин, холбоо, нийгэмлэг, сонин радио, телевиз, сууц өмчлөгчдийн холбоо, хууль зүйн товчоо зэргийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд;
4. Их, дээд сургууль коллежийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд;
5. Улс төрийн намуудыг Улсын Дээд шүүхэд тус тус бүртгэдэг байсан.

Үүнээс үзэхэд, улс төрийн намаас бусад байгууллагын бүртгэлийг хуулийн этгээдийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэхээр зохицуулахаар өөрчлөгдсөн ч бүртгүүлэхээр заасан хуулийн этгээдийн төрлүүд өмнөх туршлагатай ижил байгааг харж болно.


Хүснэгт 2. Бизнес регистрийн санд бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын нийт тоо (2020 он)³³



Дээрх хүснэгтээс төсвийн байгууллага гэсэн нэр томьёог ашигласныг харах боломжтой бөгөөд хуулийн этгээдийг замбараагүй төрөлжүүлэн бүртгэсээр ирснийг илтгэж байна. Монгол Улсын Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасан хуулийн этгээдийн таван төрөл нь хуулийн этгээдэд зүй ёсоор хамаарч явдаг бол хуулийн этгээдийг өмчийн хэлбэрээр нь хуваахдаа дээрх таван төрлийн хуулийн этгээдийг ойлгох уу, өөр хуулийн этгээдийн төрөл бий болох уу гэдэг нь тодорхойгүй байна. Иргэний хуульд заасны дагуу ангилбал, хуулийн этгээдийн төрлийг дараах байдлаар нэгтгэх боломжтой юм.

33 <https://www.1212.mn/>

Хүснэгт 3. Иргэний хуульд заасан хуулийн этгээдийн төрөл



Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсэгт хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно гэж заасан тул хуулийн этгээдийн төрлүүдийн эрх зүйн байдлыг тусдаа хуулиар зохицуулахаар ойлгогдож байна. Нөхөрлөл, компанийн эрх зүйн байдлыг бие даасан хуулиар зохицуулдаг тул тэдгээрийн эрх зүйн байдал ашгийн төлөө бус хуулийн этгээдтэй харьцуулахад тодорхой байна.

1. Ашгийн төлөө хуулийн этгээд

“Ашгийн төлөө” гэдэг бол хувийн аливаа бусад үйл ажиллагаанаас бизнесийг ялгаж буй гол шалгуур юм. Албан хаагч, төсөвт байгууллагын бүх үйлчилгээний ажилтан гэх мэт нь ажил хэргийн хүн мөн боловч ашгийн төлөө биш, цалинтай боловч ашиг олох зорилгогүй хөдөлмөр эрхлэгч гэж болно.³⁴

а. Нөхөрлөл

Гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ уг эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хуульд заасны дагуу хариуцдаг хуулийн этгээдийг нөхөрлөл гэдэг.³⁵ Нөхөрлөл дараах хэлбэртэй байна. Үүнд:

- Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай- нөхөрлөлийн хүлээсэн үүргийг гишүүд нь хувь нийлүүлсэн эд хөрөнгө болон хувийн өмчийн эд хөрөнгөөрөө хамтран хариуцдаг нөхөрлөлийг бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэнэ.

34 Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: Хүний эрх, шүүх эрх мэдэл, Хоёрдугаар дэвтэр, 2004, 93 дахь тал.

35 Иргэний хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг.

- Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлийн хүлээсэн үүргийг наад зах нь нэг гишүүн нөхөрлөлд оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцдаг, бусад нь бүрэн хариуцлага хүлээдэг нөхөрлөлийг зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэнэ.
- Хязгаарлагдмал хариуцлагатай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий хоёр ба түүнээс дээш иргэн хамтран байгуулах бөгөөд нөхөрлөлийн үүргийг гишүүд нь нөхөрлөлд оруулсан хөрөнгийн хэмжээгээр, нөхөх хариуцлагыг буруутай үйл ажиллагаа явуулсан гишүүн нөхөрлөлд оруулсан хөрөнгө болон хувийн өмчийн хөрөнгийн хэмжээгээр бүрэн хариуцах юм.

6. Компани

Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан хөрөнгөтэй, ашгийн төлөө үндсэн зорилготой хуулийн этгээдийг компани гэнэ. Компани нь дараах хэлбэртэй байна. Үүнд:

- Хязгаарлагдмал хариуцлагатай хувь нийлүүлэгчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь дүрмээр хязгаарлагддаг компанийг нэрлэнэ.
- Хувьцаат компани (нээлттэй, хаалттай) хувь нийлүүлэгчдийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, энэ хувьцаагаа нээлттэй арилжаалдаг компани.

Ашгийн төлөө байх шалгуурыг үндэслэл болговол нөхөрлөл, компаниас гадна төрийн өмчит компани нь ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдэд хамаарахаар байгааг цаашид анхаарах нь зүйтэй.

2. Ашгийн төлөө бус хуулийн этгээд

Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн үндсэн хэлбэр нь хамтран ажиллах гэрээний талууд байх ёстой боловч манай улсын хуульд энэ тухай тодорхой зохицуулалт одоогоор байхгүй байна. Иргэний хуульд ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төрлийг заасан ч бусад хууль тогтоомжоор өөр олон янзын нэр томьёог хэрэглэж байна. Түүнчлэн эдгээр тодорхой төрлүүдийг төрийн бус байгууллагаар бүртгэж байгаа нь тэдгээрийн эрх зүйн байдлыг тодорхойлсон бие даасан хууль байхгүйгээс үүдэлтэй юм.

2021 оны 11 дүгээр сард Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Улсын Их Хуралд “Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”, “Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл”-ийг өргөн барьсан. Иймд хууль тогтоомж дахь нэр томьёонуудад дүн шинжилгээ хийх замаар тулгамдсан асуудлыг тодруулж, өргөн баригдсан хуулийн төслүүд уг асуудлыг шийдвэрлэхэд дөхөм болох эсэхийг авч үзье.

а. Холбоо

Нэгдмэл, тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, гишүүнчлэл бүхий хуулийн этгээдийг холбоо гэнэ.³⁶ Иргэний хуульд заасан холбоог зарим хуулийн этгээдийн эрхгүй буюу бүртгэгдээгүй холбооноос ялгах хэрэгтэй. Тухайлбал, Сууц өмчлөгчдийн холбоо нь хэдийгээр холбоо нэрээр явдаг ч хуулийн этгээдийн эрхгүй байна.³⁷

36 Иргэний хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг.

37 Иргэний хуулийн 143 дугаар зүйлийн 143.3 дахь хэсэг.

Холбоог хуулийн этгээдийн улсын бүртгэлд холбоо /төрийн бус байгууллага/ гэж бүртгэж байгаа нь тэдгээрийг нэг ойлголт мэт төөрөгдөл үүсгэж байна. Түүнчлэн ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төрөл болох хоршоо нэгдэж, хоршоодын холбоо байгуулж болохоор хуульчилсан. Үүнийг 2021 оны Хоршооны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт заасан бөгөөд мөн зүйлийн 44.2 дахь хэсэгт “Хоршоодын холбоо нь гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага байна” гэжээ. Ингэснээр төрийн бус байгууллагыг холбоог дотроо багтааж буй өргөн хүрээтэй ойлголт болгон бичсэн нь ойлгомжгүй байдал бий болгож байна.

Мөн зарим хууль тогтоомжид мэргэжлийн холбоо гэсэн ухагдахууныг хэрэглэснийг Хавсралт 14-өөс харах боломжтой. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт, Өмгөөллийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэгт Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, Монголын телевизүүдийн холбоог нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна гэсэн бол зарим холбоог хуульд “мэргэжлийн холбоо” гэж нэрлэжээ. Эдгээрээс Хуульчдын холбоо нийтийн эрх зүйн хуулийн этгээд үү, мэргэжлийн холбоо юу гэсэн асуулт урган гарч байна.

Холбооны эрх зүйн байдлыг тодорхойлсон бие даасан хууль байхгүй ч 2021 оны 11 дүгээр сард Улсын Их Хуралд Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийг төслийг өргөн барьсан.³⁸ Иймд уг төслийн зарим заалтад дүн шинжилгээ хийж, холбооны эрх зүйн байдлыг тодорхой болгоход ач холбогдолтой зохицуулалт байгаа эсэхийг авч үзье.

Хүснэгт 4. Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн зарим зүйл, заалтад хийсэн дүн шинжилгээ

№	Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн зүйл, заалт	Дүн шинжилгээ
1	4.1.5. “мэргэжлийн холбоо” гэж нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээдийн эрх, үүргийг хүлээж, хууль болон өөрийн дүрмээр зохион байгуулалт, үйл ажиллагаагаа зохицуулдаг, энэ хуулийн 33.1-д заасан эрх бүхий байгууллагаас эрх олгогдсон хуулийн этгээдийг хэлнэ.	Уг заалтад анх удаа мэргэжлийн холбоо гэснийг тодорхойлсон бөгөөд хуулийн этгээдийг нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээд гэж хуваах алхам хийжээ. Харин нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээдийн ойлголт, ялгагдах шинжийг тодорхойлсон нарийвчилсан зохицуулалт одоогоор байхгүй тул эдгээрийн эрх, үүрэгт юуг ойлгох нь тодорхойгүй болно. Түүнчлэн холбоо нь Иргэний хуульд заасан ашгийн төлөө бус, хувийн эрх зүйн хуулийн этгээд байхад мэргэжлийн холбоо нь нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээдэд хамаарах нь хэр оновчтойг дахин нягтлах шаардлагатай гэж үзлээ.

2	5.1.Холбоо нь үйл ажиллагаагаа төрөөс хараат бусаар, өөрийгөө удирдан хууль тогтоомжийн хүрээнд явуулна. 5.4.Холбоо нь Улсын Их Хурал, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээллийг хуульд заасны дагуу олж авах, түгээх, өөрийн байр сууриа илэрхийлэх эрхтэй.	Үүнээс харвал, холбоог төрийн бус байгууллагатай дүйцүүлж, төрөөс хараат бус байх, эрх бүхий байгууллагуудад байр сууриа илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг эдлэх хүрээнд байгуулагдах хуулийн этгээдийн агуулгаар тодорхойлжээ. Ингэснээр төрийн бус байгууллага болон холбоог давхардуулан бүртгэж буй практикийг нэгтгэх ач холбогдолтой. Гэвч холбоог "association", төрийн бус байгууллагыг "non-governmental organization" гэж нэрлэдэг бөгөөд уг хоёр ойлголт нэг агуулгатай биш юм. Тодруулбал, холбоо нь нэгдмэл зорилготой хүмүүсийн нэгдэл байдаг бол төрийн бус байгууллага нь төрөөс хараат бус байгуулагдаж, аль нэг улсын харьяалалд хамаарахгүй байгууллага байдаг. Харин тус хуулийн төслөөр холбоо болон төрийн бус байгууллагыг нэг байгууллага болгосноор "олон нийтийн байгууллага" гэдэг нэр томьёогоор эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэхээр байгуулагдсан бүртгэгдсэн болон бүртгэгдээгүй нэгдэл, холбоо, эвсэл, нийгэмлэгийг авч үзэх боломж бүрдэхээр байна.
3	8.1.Төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хуульд заасан зарим чиг үүргийг холбоогоор хуульд заасны дагуу, эсхүл гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно. 8.2.Энэ хуулийн 8.1-д заасан чиг үүрэгт нэг удаагийн шинжтэй ажил, үйлчилгээг гүйцэтгүүлэх төрийн чиг үүрэг хамаарахгүй. 8.3.Холбоогоор гүйцэтгүүлэх төрийн чиг үүргийн жагсаалтыг Засгийн газар батална. 8.4.Төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын чиг үүргийг холбоогоор гүйцэтгүүлэх тухай шийдвэрийг сонгон шалгаруулалтын дүн болон тухайн салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар гаргана. 8.5.Холбоог сонгон шалгаруулах, гэрээ байгуулахад дараах зарчмыг баримтална: 8.5.1.холбооны хараат бус байдлыг хүндэтгэх; 8.5.2.үл ялгаварлах, тэгш боломж олгох; 8.5.3.нээлттэй, ил тод байх; 8.5.4.ашиг сонирхлын зөрчилгүй байх.	Холбоонд төрийн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хуульд заасан зарим чиг үүргийг хуулиар, эсхүл гэрээний үндсэн дээр шилжүүлэх нь төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан холбооны үйл ажиллагаа төрөөс хараат бус байх зарчимтай зөрчилдөж байна. Мөн Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад заасан захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэх авсан этгээдээс ялгагдахгүй болох үр дагавартай байна. Холбоог төрийн бус байгууллагын агуулгаар тодорхойлсон хирнээ төрийн зарим эрх мэдлийг шилжүүлэх нь зохимжгүй байх бөгөөд ийнхүү шилжүүлснээр хүн холбоо байгуулах замаар эвлэлдэн нэгдэх эрхээ чөлөөтэй хэрэгжүүлэх боломжийг хязгаарлахаар байна.

Ийнхүү Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд холбоог нэгдмэл, тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, гишүүнчлэл бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээдийг ойлгохоор заажээ. Түүнчлэн мэргэжлийн холбоо гэдгийг тодорхойлсон ч нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээдийн эрх, үүргийг эдэлнэ гэж зааснаар мэргэжлийн холбоог нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээдийн алинд нь ч хамаарч болох мэтээр тодорхойлсон нь өрөөсгөл байна. Учир нь нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээдийн ойлголт, эрх, үүргийг хуулиар тодорхойлоогүй бөгөөд тэдгээр нь хоорондоо ялгагдах өөр шинжийг агуулж байдаг. Иймд төслийн зарим заалтыг дахин нягтлах шаардлагатай гэж үзлээ.

6.Сан

Нэг буюу хэд хэдэн үүсгэн байгуулагч нийгэмд ашиг тустай, нэгдмэл зорилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх замаар байгуулсан гишүүнчлэлгүй хуулийн

этгээдийг сан гэнэ.³⁹ Сан нь хөрөнгийн нэгдэл бүхий хуулийн этгээд болохын хувьд онцлог зохицуулалтыг шаардана. Одоогийн байдлаар Төрийн бус байгууллагын тухай хуулийн 25 дугаар зүйлд сангийн тухай тусгай зохицуулалтаар санг зохицуулж байна. Сангийн зохицуулалтын хувьд аливаа нэг Сан нь ТББ гэж нэрлэгдэх, бүртгэгдэж байгааг зайлшгүй засаж, Иргэний хуульд нийцүүлэх шаардлагатай.⁴⁰

Зарим хуульд сан нь төрийн өмчит хуулийн этгээд болон өөр бусад хуулийн этгээд байхаар заажээ. Тухайлбал, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт хөрөнгө оруулалтын сан нь хуулийн этгээдийн эрхтэй тусгай зориулалтын компани байна. Харилцааны холбооны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт Засгийн газар харилцаа холбооны талаар хэрэгжүүлэх бүрэн эрхийнхээ хүрээнд бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан бүрдүүлэх, түүнийг зарцуулах журам батлахаар заажээ. Энэ сан нь Засгийн газраас үүсгэн байгуулагдаж байгаагаараа онцлог байна.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад Засгийн газрын тусгай сан гэж Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг санхүүжүүлэх зориулалттай төсвийн тусгай дансыг ойлгохоор заажээ. Ийнхүү үүнд хамаарах байгаль орчин, уур амьсгалын сан, боловсролын зээлийн сан, бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан, гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Засгийн газрын нөөц сан, зэвсэгт хүчний хөгжлийн сан, ирээдүйн өв сан, кино урлагийг дэмжих сан, мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан, нийгмийн даатгалын сан, нийгмийн халамжийн сан, соёл, урлагийг дэмжих сан, спортыг дэмжих сан, төсвийн тогтворжуулалтын сан, улсын авто замын сан, хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, хөдөө аж ахуйг дэмжих сан, шинжлэх ухаан, технологийн сан, эрүүл мэндийг дэмжих сан, эрүүл мэндийн даатгалын сан, өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан зэрэг нь нийтийн эрх зүйн хуулийн этгээд, эсхүл төрийн өмчит хуулийн этгээдийн аль нь болох тодорхойгүй байна.

Тухайлбал, Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтад Ирээдүйд өв сан корпорацийг төрийн өмчит хуулийн этгээд байхаар заасан бол бусад Засгийн газрын тусгай сангууд хуулийн этгээд болох эсэхийг тодруулах шаардлагатай байна. Доктор П.Одгэрэл “Захиргааны ерөнхий анги” бүтээлдээ нийтийн эрх зүйн хуулийн этгээд дотор нийтийн эрх зүйн санг хамааруулжээ. Ингэхдээ: “Сан нь тодорхой хөрөнгийн тусламжтайгаар өмнөө тавьсан зорилгыг хэрэгжүүлэх хэрэгслүүр юм. Нийтийн зорилтыг хэрэгжүүлэхийн тулд захиргааны байгууллага болон бусад нийтийн эрх зүйн этгээдээс байгуулдаг. Эдгээрт Сургалтын төрийн сан, Хүний хөгжлийн сан, орон нутгийг хөгжүүлэх сан, байгаль орчныг хамгаалах сан гэх мэт хамаарах бөгөөд энд мөнгийг нь биш байгууллагыг нь хэлнэ”⁴¹ гэжээ.

Үүнээс харахад, зарим сан нь нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн нэг төрөлд хамаарахаар байгааг анхаарч хувийн эрх зүйн сангийн эрх зүйн байдлыг оновчтой тодорхойлох шаардлагатай байна. 2021 оны 11 дүгээр сард Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн барьсан бөгөөд уг төслийн зарим заалтад дүн шинжилгээ хийж үзье.

39 Иргэний хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэг.

40 Баасанжав Консалтинг ХХК, Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, 2017, 23 дахь тал.

41 П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги, 2016, 109 дэх тал.

Хүснэгт 5. Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн зарим зүйл, заалтад хийсэн дүн шинжилгээ

№	Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн зүйл, заалт	Дүн шинжилгээ
1	3.1.Засгийн газрын тусгай сан, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулахгүй.	Засгийн газрын тусгай сан, хөрөнгө оруулалтын санг уг хуулийн төслөөр зохицуулахгүй тул тэдгээрийг нийтийн эрх зүйн хуулийн этгээд, төрийн өмчит хуулийн этгээдэд хамаарах эсэхийг тодруулж, нэгдсэн байр сууринд хүрэх шаардлага хэвээр үлдэнэ.
2	4.1.2.“хувийн сан” гэж зөвхөн дүрэмдээ заасан нэг, эсхүл хэд хэдэн тодорхой этгээдээс хандивласан хөрөнгөөр санхүүжилт авч үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээдийг; 4.1.3.“нийтийн сан” гэж олон нийтээс болон бусад этгээдээс хөрөнгө төвлөрүүлэх замаар санхүүжилт авч үйл ажиллагаа явуулдаг ашгийн төлөө бус хуулийн этгээдийг;	Иргэний хуульд заасан санг нийтийн болон хувийн гэж хуваасан байх бөгөөд ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төрөлд хамаарахаар төсөлд тусгажээ.
3	5.1.Сан нь дүрэмд заасан зорилго, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхийн тулд аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж болно. 5.2.Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх шийдвэрийг тухайн сангийн дүрэмд заасан эрх барих байгууллага гаргана.	Хуулийн төсөлд нийтийн болон хувийн санг ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахыг хориглож, ашгийн төлөө бус хуулийн этгээд гэж тодорхойлсон хирнээ дүрэмд заасан зорилго, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх нэрээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн нь оновчгүй зохицуулалт байна. Учир нь Монгол Улсад төрийн бус байгууллагууд нь өөрийн зорилго, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхээр аж ахуйн үйл ажиллагаа явуулж, татвараас чөлөөлөгддөг тул мөнгө угаах арга хэрэгсэл болох эрсдэл үүсдэгээс гадна ашгийн төлөө хуулийн этгээд татвараас зугтахын тулд төрийн бус байгууллагын хэлбэрээр байгуулагдах тохиолдол газар авсан. Иймд санг ТББ-ын нэгэн адил аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөх зохицуулалт нь тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх бус даамжруулах сөрөг үр дагавартай байна.

Ийнхүү сан нь гишүүнчлэл бүхий хүмүүсийн нэгдэл бус хөрөнгийн нэгдэл бүхий хуулийн этгээд тул аж ахуйн үйл ажиллагаа явуулах тухай ойлголт байх боломжгүй юм. Иймд Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн зарим зохицуулалт сангийн онцлог шинжийг алдагдуулахаар байна. Түүнчлэн Засгийн газрын тусгай сангуудыг нийтийн эрх зүйн хуулийн этгээд, эсхүл төрийн өмчит хуулийн этгээдэд хамааруулах асуудал тодорхойгүй үлдэж байна.

с.Хоршоо

Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ.⁴² Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2021 оны 05 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан. Уг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасны дагуу хоршоо нь анхан шатны болон дундын гэсэн хэлбэртэй байгуулагдах юм. Ийнхүү 1998 оны Хоршооны тухай хуулийг шинэчлэн найруулснаар хоршоотой холбоотой эрх зүйн зохицуулалт Иргэний хуульд нийцэх боломж бүрдэхээр байна.

42 Иргэний хуулийн 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэг.

3.Төрийн бус байгууллага

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд холбоо болон төрийн бус байгууллагыг нэг байгууллага болгон бүртгэж байгаа тухай өмнөх хэсэгт авч үзсэн билээ. Төрийн бус байгууллага гэсэн ойлголтоос гадна олон нийтийн байгууллага гэсэн нэр томъёог хэрэглэдэг бөгөөд тэдгээр нь утга агуулгын хувьд ойролцоо боловч үүслээрээ ялгаатай байна. Олон нийтийн байгууллага гэх ойлголтыг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 16 хуульд, төрийн бус байгууллага гэх ойлголтыг харин 56 хуулиар хэрэглэжээ.

Төрийн бус байгууллага (non-governmental organization) гэх ойлголтыг анх Засгийн газар хоорондын төрөлжсөн байгууллага болон олон улсын хувийн байгууллагуудын оролцооны эрхийг ялгах хэрэгцээ шаардлага үүссэнээр 1945 онд НҮБ оруулж ирсэн. НҮБ-ын гишүүн улс орнуудын 1945 оны 6 сарын 26-ны өдөр баталсан НҮБ-ийн дүрмийн 71-р зүйлд:

“71 дүгээр зүйл. Эдийн засаг, нийгмийн зөвлөл түүний эрх хэмжээний хүрээний тодорхой асуудлыг сонирхож байгаа засгийн газрын бус байгууллагуудтай уг асуудлаар зөвлөлдөх талаар зохих арга хэмжээ авах эрхтэй. Тийм арга хэмжээг олон улсын байгууллагуудтай тохиролцож болох бөгөөд мөн шаардлагатай бол Нэгдсэн Үндэстний Байгууллагын холбогдох гишүүн улстай зөвлөлдсөний дараа тухайн улсын үндэсний байгууллагуудтай тохиролцож болно.

Article 71. The Economic and Social Council may make suitable arrangements for consultation with non-governmental organizations which are concerned with matters within its competence. Such arrangements may be made with international organizations and, where appropriate, with national organizations after consultation with the Member of the United Nations concerned.” гэж тусгасан.

Үүгээр “non-governmental organization” гэдгээр төр болон Засгийн газраас хараат бус байгууллагыг энэ ойлголтын хүрээнд хамруулсан.⁴³ Ийнхүү НҮБ бараг бүх төрлийн хувийн байгууллагыг төрийн бус байгууллага гэж хүлээн зөвшөөрч байна. Эдгээр байгууллагын үндсэн шинж нь төрийн хяналтаас хараат бус, үйл ажиллагаа нь ашгийн төлөө чиглээгүй, гэмт хэргийн бус шинжтэй байх явдал юм.

Монгол Улс НҮБ-ын гишүүн орны хувьд 1997 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр Төрийн бус байгууллагын тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулиар нам, үйлдвэрчний эвлэл, сүм хийдээс бусад төрийн бус байгууллагын харилцааг зохицуулахаар заажээ. Төрийн бус байгууллага гэдэгт иргэд, төрийн байгууллага /хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага/-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг ойлгоно.⁴⁴ Уг хууль Иргэний хуулиас өмнө батлагдсан тул төрийн бус байгууллага нь ашгийн төлөө бус хуулийн этгээд мөн эсэх тодорхойгүй байна.

Олон нийтийн байгууллага гэх нэр томъёог 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 10 дахь хэсэгт “...нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бус байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй” гэж заасан. Үүний дагуу 1994 оны Иргэний

43 <https://www.gdrc.org/ngo/peter-willets.html#one>

44 Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар олон нийтийн байгууллагыг үүсгэн байгуулагч буюу оролцогч нь тухайн хуулийн этгээдийн тусгайлсан эд хөрөнгийн хувьд эд хөрөнгийн эрхээ хадгалдаггүй хуулийн этгээдийн төрөлд хамаарч байжээ. Харин 2002 оны Иргэний хуулиар олон нийтийн байгууллага гэсэн хуулийн этгээдийн төрөлд хамаарахгүй бөгөөд хуулийн этгээдээс өргөн агуулгатай ойлголт байна.

Үүнийг Монгол Улсын гавьяат хуульч Г.Совд “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар” бүтээлдээ:

“Иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх бол тэдгээрийн сайн дурын үндсэн дээр өөрсдийнх нь үнэнхүү итгэл үнэмшил, ашиг сонирхолд нийцсэн бөгөөд тэр нь нэр томьёоны хувьд эвлэл, эвсэл, холбоо, нам, үйлдвэрчин, зөвлөл гэх мэт байж болох бөгөөд аль ч нэрийг авсан байхаас шалтгаалахгүй гол зорилго нь нийгмийн болон эсхүл эвлэлдэн нэгдсэн хэсгийн ашиг сонирхлыг хамгаалахад оршино. Ардчилсан нийгэмд иргэд улс төрийн нийтлэг үзэл бодлын хувьд эвлэлдэн нэгдэх явдал чөлөөтэй байдаг учраас ямар ч нэртэй байгууллагад эвлэлдэн нэгдэж болдог. Гэхдээ эдгээр байгууллагууд нь ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж болохгүй гэдэг түгээмэл хэвшил байдаг.

Ардчилсан нийгэмд иргэд улс төрийн нийтлэг үзэл бодлын хувьд эвлэлдэн нэгдэх явдал чөлөөтэй байдаг учраас ямар ч нэртэй байгууллагад эвлэлдэн нэгдэж болдог. Гэхдээ эдгээр байгууллагууд нь ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж болохгүй гэдэг түгээмэл хэвшил байдаг.

Иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг илэрхийлдэг нийгэм-эдийн засгийн, нийгэм-соёлын нэгдлүүдэд төрийн биш байгууллагууд гэдэг нэрийн дор хамаарсан үйлдвэрчний байгууллага, ажил хэрэгч хүмүүсийн нэгдэл, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах байгууллага болон төрөл бүрийн мэргэжлийн хүмүүсийн ашиг сонирхлыг илэрхийлэх, хамгаалах зорилго бүхий эвлэл, холбоо зэрэг олон төрөл байгууллага байж болно”⁴⁵ хэмээн тайлбарлажээ.

Үүнээс харахад, олон нийтийн байгууллагад бүртгэгдээгүй холбоо, хүмүүсийн нэгдэл хамаарч болохоор байх тул хуулийн этгээдээс өргөн хүрээтэй ойлголт байх боломжтой юм. 1994 оны Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар олон нийтийн байгууллагыг үүсгэн байгуулагч буюу оролцогч нь тухайн хуулийн этгээдийн тусгайлсан эд хөрөнгийн хувьд эд хөрөнгийн эрхээ хадгалдаггүй хуулийн этгээдийн төрөлд хамаарч байжээ. Хэрэв төрийн бус байгууллагыг Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд заасанчлан холбоо нэрээр томьёолсон тохиолдолд эвлэлдэн нэгдэх эрхийн хүрээнд байгуулагдсан хүмүүсийн бүх төрлийн нэгдлийг Үндсэн хуульд заасан олон нийтийн байгууллага гэсэн нэр томьёогоор илэрхийлэх боломжтой гэж харж байна. Төрийн бус байгууллага хуулийн этгээд мөн эсэхийг тодруулахын тулд АНУ болон Европын Холбооны зохицуулалтыг харьцуулан авч үзье.

45 Г.Совд, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2000, 103 дахь тал.

АНУ дахь төрийн бус байгууллагын тухай

АНУ-д төрийн бус байгууллага нь ихэвчлэн ашгийн төлөө бус үйл ажиллагаа явуулдаг ч ашгийн төлөө бус байгууллага болгон төрийн бус байгууллага болдоггүй байна. Дэлхий дахинд улс бүрийн хууль, эрх зүйн тогтолцооноос хамааран төрийн бус байгууллагыг янз бүрээр байгуулдаг.⁴⁶

АНУ-д ардчилал хөгжих үндэс нь төрийн хяналт, засгийн газрын оролцооноос хараат бус иргэний нийгэм гэж үздэг. Иргэний нийгэм гэдэг нь нийтлэг зорилго, ашиг сонирхлын төлөө нэгдсэн иргэдийн сайн дурын үндсэн дээр байгуулагдсан нийгмийн байгууллагуудын нэгдэл юм. Үүнд төрийн бодлого бүхий бие даасан судалгааны байгууллага, өмгөөллийн байгууллага, хүний эрхийг хамгаалагч, ардчиллыг дэмжигч байгууллага, хүмүүнлэгийн байгууллага, хувийн сан, буяны байгууллага, нийгэмлэг, холбоо зэрэг ашгийн төлөө бус хуулийн этгээд ордог ба улс төрийн нам хамаарахгүй.

АНУ-д ойролцоогоор 1.5 сая орчим төрийн бус байгууллага үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр төрийн бус байгууллагууд нь гадаад бодлого, сонгууль, байгаль орчин, эрүүл мэнд, эмэгтэйчүүдийн эрх, эдийн засгийн хөгжил болон бусад олон асуудлаар олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг. Ихэвчлэн засгийн газар дангаараа шийдэж чадахгүй нийгэм, эдийн засгийн асуудалд шинэ хандлагыг боловсруулж, шийдвэрлэдэг. АНУ-д улс төртэй холбоогүйгээр олон ТББ үйл ажиллагаа явуулдаг. Эдгээрт нийтлэг итгэл үнэмшилд суурилсан шашны байгууллага, үйлдвэрчний эвлэл, ядуу, хөгжлийн бэрхшээлтэй гэх мэт эмзэг бүлгийн хүмүүст тусалдаг бүлгүүд багтах бөгөөд төсөөлж болох бүхий л асуудлыг төлөөлөх ТББ-ууд байдаг.

Аливаа бүлэг хүмүүс санаа бодол, нийтлэг ашиг сонирхлоороо нэгдэж төрийн ямар ч оролцоо, зөвшөөрөлгүйгээр албан бус байгууллага байгуулах, нэгдэх боломжтой. Гэхдээ тухайн бүлэгт холбооны болон муж улсын татвараас чөлөөлөгдөх зэрэг хуулийн ашигтай байдал үүсэх нь тодорхой байвал АНУ-ын 50 муж улсын аль нэг мужийн хуулийн дагуу албан ёсоор нэгдэж, төрийн бус байгууллагаар бүртгүүлэх боломжтой. ТББ байгуулахын тулд заавал АНУ-ын иргэн байхыг шаарддаггүй.

Бүртгэлд тавигдах шаардлага, төрийн бус байгууллагын хэлбэр нь муж бүрд харилцан адилгүй байдаг ч ерөнхийдөө энгийн тул хэн ч хэдхэн хоногийн дотор мужийн түвшинд ТББ байгуулах боломжтой. Бүртгэлийн явцад байгууллагын товч тодорхойлолт, түүний зорилго, нэр, муж дахь төлөөлөгчийн хаяг зэргийг бүрдүүлэх ба зохих хэмжээний төлбөрийг төлөх ёстой байдаг.

Ихэнх мужид ТББ-ыг бүртгэх үйл явцыг хууль тогтоох байгууллага эсвэл бусад төрийн албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр явуулах өөрийн хуультай байна. Энэ нь төрийн албан тушаалтан ямар байгууллагыг бүртгэх эсэхийг зөвшөөрөхдөө эрх мэдлээ урвуулан ашиглах эрсдэлийг бууруулдаг. Харин хэд хэдэн мужид шашин шүтлэг, боловсролын болон бусад буяны зорилгоор байгуулагдсан зарим ТББ-ууд буяны хөрөнгийг хамгаалах, олон нийтээс хандив цуглуулах үйл ажиллагааг зохицуулах үүрэгтэй төрийн албан тушаалтанд бүртгүүлэх ёстой байдаг.

46 <https://www.humanrightscareers.com/issues/types-of-ngos/>

АНУ-д олон ТББ-ууд муж болон холбооны татвараас чөлөөлөгддөг. Энэ нь ТББ-ууд ашгийн бус байгууллагын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулахад хялбар болдог төдийгүй өөрсдийн орлогодоо (санхүүжилт) татвар төлөх шаардлагагүй. Хэрэв АНУ-ын Холбооны Засгийн газрын орлогын албан татвараас чөлөөлөгдөхийг хүсвэл тус төрийн бус байгууллага АНУ-н Дотоод орлогын албанд хандан хүсэлтээ өгдөг. Татвараас чөлөөлөгдөх эрх бүхий ТББ-уудыг Дотоодын орлогын тухай хуульд заасан байх бөгөөд ТББ-ын төрөл, явуулж буй үйл ажиллагаанаас хамаарна.⁴⁷ Үүнээс харвал, АНУ нь төрийн бус байгууллагыг төрөөс хараат бус, татвараас чөлөөлөгдөх, өргөн эрх мэдэлтэй байгууллага болгон өргөмжилсөн байна.

Европын Холбооны төрийн бус байгууллагын тухай

2001 оны 11 дүгээр сарын 19-20, 2002 оны 03 дугаар сарын 20-22, 2002 оны 07 дугаар сарын 05-ны хооронд Страсбург хотод зохион байгуулагдсан олон талт уулзалтад оролцогчид Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай конвенцын 11 дүгээр зүйлд заасан “Хүн бүр тайван жагсаал хийх, бусадтай эвлэлдэн нэгдэх эрх чөлөөтэй” гэсэн заалт болон төрийн бус байгууллагууд ардчилсан нийгмийг хөгжүүлэх, цаашид оршин тогтнохдоо иргэдийн оролцоог хангах үйл ажиллагаанд чухал хувь нэмэр оруулдаг гэдгийг харгалзан үзээд санамж бичиг гаргажээ. Үүндээ төрийн бус байгууллагын тухай ойлголт, түүний үндсэн зарчим зэргийг тодорхойлсон бөгөөд доор дэлгэрүүлэн авч үзлээ.

2002 оны Европ дахь төрийн бус байгууллагын статусын үндсэн зарчим тайлбар, санамж бичгийн хамрах хүрээ⁴⁸:

- ТББ нь үндсэндээ сайн дурын өөрөө удирдах ёсны байгууллага учир төрийн эрх бүхий байгууллага түүнийг удирдан чиглүүлдэггүй. Үндэсний хууль тогтоомжид тодорхойлохдоо хэрэглэгддэг нэр томьёо нь өөр өөр байж болох ч холбоо, буяны байгууллага, сан, ашгийн бус хуулийн этгээд, нийгэмлэг, итгэлцэл зэрэг хамаарна. Харин улс төрийн намын үүрэг бүхий байгууллага хамаарахгүй;
- ТББ-д хүн, хуулийн этгээд болон хүмүүсийн нэгдэл бүхий бусад байгууллагыг хамааруулна. Тэдгээр нь бүтэц, үйл ажиллагааны хүрээнд үндэсний болон олон улсын байж болно;
- ТББ ихэвчлэн гишүүнчлэлтэй байдаг ч заавал байх шинж биш юм;
- ТББ нь ашиг олох үндсэн зорилгогүй байх ёстой. Өөрсдийн үйл ажиллагаанаас олсон ашгийг гишүүд, үүсгэн байгуулагчдад хуваарилдаггүй, харин зорилгодоо хүрэхийн тулд ашигладаг байна;
- ТББ нь албан бус байгууллага эсхүл эрх зүйн чадавхтай хуулийн этгээдийн аль нэг нь байж болно. Хуулийн этгээдээс гадна үндэсний хууль тогтоомжийн дагуу өөр өөр статустай байж болно.

47 United States Department of State. 2021. Non-Governmental Organizations (NGOs) in the United States - United States Department of State. <https://www.state.gov/non-governmental-organizations-ngos-in-the-united-states/>

48 <https://www.legislationline.org/documents/action/popup/id/8082>

Иргэний нийгмийн байгууллага гэдэг утгаараа төрийн бус байгууллага хуулийн этгээдээс өргөн хүрээтэй ойлголт болж байх тул Монгол Улс ижил утга агуулгатай олон нийтийн байгууллага гэсэн ухагдахуунаар эвлэлдэн нэгдэх эрхээ хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдах хуулийн этгээд болон хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг ойлгож, хэрэглэх боломжтой. Иймд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар төрийн бус байгууллагыг хуулийн этгээдээр бүртгэх нь оновчгүй байна.

4.Шашны байгууллага

Иргэний хуулийн 36 дугаар зүйлийн 36.6 дахь хэсэгт сүм хийд иргэний эрх зүйн харилцаанд оролцохдоо сангийн эрх зүйн байдлын талаарх хуулийн заалтыг мөрдөнө гэж заасан боловч сангийн эрх зүйн байдлыг зохицуулсан хууль одоогоор байхгүйг дурдсан билээ. Монгол Улсын Үндсэн хуулийн Есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт төр, сүм хийдийн хоорондын харилцааг хуулиар зохицуулна гэсний үндсэн дээр 1993 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Төр, сүм хийдийн харилцааны тухай хууль батлагдан гарсан.

Уг хуульд “шашны байгууллага” гэж сүсэгтэн олны шашин-номын эрэлт хэрэгцээг хангах зорилгоор байгуулагдаж, шашны зан үйл, хурал ном, боловсролын ажлыг эрхлэн гүйцэтгэж буй албан ёсны зөвшөөрөл бүхий хийд, сүм, дацан, төв болон тэдгээрийн удирдах байгууллагыг ойлгохоор хуульчилжээ. Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3.6 дахь заалтад сүм хийд дүрэмдээ хуулийн этгээд болох үндэслэлээ заахаар зохицуулсан.

1994 оны Иргэний хуульд шашны байгууллагыг хуулийн этгээдийн нэг төрөл болгон хуульчилж байсан түүх бий. Ингэхдээ шашны байгууллага, санг ашгийн төлөө бус байхаар заасан байсан тул Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3.6 дахь заалт 1994 оны Иргэний хууль дахь хуулийн этгээдийн ойлголттой нийцдэг байсан бол одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж тус заалттай зөрчилдөж байгааг анхаарах шаардлагатай.

Ийнхүү ашгийн бус байгууллагын бүртгэл болон зарим төрлийн үйл ажиллагаа нь тусгай зөвшөөрөл, шалгуурын үндсэн дээр олгогдсон байхаас гадна үйл ажиллагаа нь хууль болон дүрэмд заасан зорилгод нийцэж байгаа эсэх, орлогын эх үүсвэр болон зарцуулалт, тэр дундаа аж ахуйн үйл ажиллагааны орлогыг үндсэн үйл ажиллагаандаа зарцуулж байгаа эсэх нь хуулийн дагуу төрийн болон олон нийтийн хяналтад байх ёстой юм.⁴⁹

Гандантэгчэглин хийд нь улсын бүртгэлд төрийн бус байгууллага гэсэн бүртгэлтэй байна.⁵⁰ Үүнээс өөр бусад шашны байгууллагууд мөн ялгаагүй төрийн бус байгууллагаар бүртгүүлжээ. Үүнийг 2017 оны тоон мэдээллээс харах боломжтой.

49 Иргэдэд туслах хүний эрхийн төв ТББ, Ашгийн бус байгууллагын талаарх Монгол Улсын эрх зүйн зохицуулалт. Эрх зүйн дүн шинжилгээ, 2018, 12 дахь тал.

50 <https://ikon.mn/n/2dtf?fbclid=IwAR2adhmYsbi8kRCZ3i2KVdcOvG16Hv9AIMHQVYNIf9yGey93eeRhEIOpxLg>

Хүснэгт 6. Шашны ТББ-ын тоо баримт⁵¹

№	Шашны урсгал	Тоо	Хувь
1	Христийн	277	52.8
2	Буддын	206	39.2
3	Ислам	21	4
4	Бөө мөргөл	17	3.2
5	Шинто	2	0.4
6	Хиндү	1	0.2
7	Бахай	1	0.2
Нийт тоо		525	100

Шашны байгууллагууд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасны дагуу шашны байгууллагаар бус төрийн бус байгууллагаар бүртгүүлдэг буруу практик тогтсон байна. Иймд шашны байгууллагыг Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар зохицуулж, хуулийн этгээдээр бүртгэсэн тохиолдолд ТББ бус шашны байгууллагаар бүртгэх хэрэгцээ шаардлага бий болжээ.

5.Нийтийн эрх зүйн хуулийн этгээд

Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар хуульд заасан журмаар байгуулагдсанаар үүсч татан буугдсанаар дуусгавар болох бөгөөд иргэний эрх зүйн харилцаанд оролцохдоо бусад оролцогчидтой адил тэгш эрхтэй гэжээ. Өөрөөр хэлбэл, нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь хуулийн этгээдийн адил иргэний эрх зүйн чадвартай байх бөгөөд хуульд зааснаар үүсэхээр байна.

Монгол Улсын Иргэний хуулийн шинжлэх ухааны тайлбарт “Нийтийн эрх зүйн олонхи хуулийн этгээд нь төр, засаглалын бүрэн эрхтэй байдаг. Тэдгээрт улсын сан хөмрөгийн хувьд эд хөрөнгийн харилцаанд оролцож байгаа төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хамаарна. Нийтийн эрх зүйн хэм хэмжээн дээр үндэслэн байгуулагдсан, төр засаглалын бүрэн эрх хэрэгжүүлдэггүй шинжлэх ухаан, соёл гэгээрлийн, шашны болон төр засаг, нийгэмд тустай чиг үүрэг бүхий бусад байгууллага, албан газар нь нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна. Эдгээрийн тоонд академи, их сургууль, дунд сургууль, музей, эмнэлэг, халамжийн газар, худалдааны танхим, номын сан, шашны байгууллага зэрэг багтана. Ихэнх тохиолдолд нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь эрх зүйн тусгай чадамжтай байна. Өөрөөр хэлбэл, эрх зүйн тусгай актаар тодорхойлогдсон бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаа явуулна”⁵² гэжээ.

Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн заалтын агуулгаас үзэхэд нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь өөрийн дүрэм, үүсгэн байгуулсан бусад баримт бичигт заасан зорилгод нийцсэн үйл ажиллагаа явуулах ёстой тул эрх зүйн чадвар нь зорилгодоо нийцсэн тусгай буюу хязгаарлагдмал шинжтэй байдаг гэж зарим судлаач үзжээ.⁵³

51 Баасанжав Консалтинг ХХК, Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа, 2017, 15-16 дахь тал.

52 Монгол Улсын Иргэний хуулийн шинжлэх ухааны тайлбар, 2015, 49 дэх тал.

53 О.Жамбалдорж, Монгол Улсын Иргэний эрх зүй ерөнхий үндэслэл, I дэвтэр. 2004, 126 дахь тал.

Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн онол анх Франц улсаас гаралтай бөгөөд “нийтийн өмч” гэх ойлголт бий болсноор эрх зүйн чадавхтай байгууллагыг нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээд гэж хуваах шалгуур үүсжээ. Тухайн үед Герман улсад мөн нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн үзэл санаа бий болсон ч эдгээр хоёр улсын хууль тогтоомжид өөрөөр тусгагдсан. Францын хувьсгалын үр дүнд хаант засаглалаас бүгд найрамдах засаглал руу шилжсэнээр төрийн эрх мэдлийг ард түмэн хэрэгжүүлэх үндэс тавигджээ. Тухайн үед төрийг хувийн эрх зүйн хуулийн этгээдтэй ижил эрхтэй эрх зүйн харилцаанд оролцохоос бусад тохиолдолд хуулийн этгээд гэж үздэггүй байсан. Харин 20-р зууны эхэнд захиргааны эрх зүйн салбарт төрийн байгууллагын бүрэн эрхээ хэрэгжүүлэхийг нийтийн өмчийг удирдах хувийн шинжтэй үйл ажиллагаанаас ялгаж эхэлжээ.⁵⁴

Герман улсад төрийг бүхэлд нь хуулийн этгээдийн хувиар авч үзэхээс гадна эрх мэдлийн хэрэгжүүлэх бүрэн эрх бүхий этгээдийн хувьд ганц өмчийн харилцаагаар хязгаарлагдахгүйгээр иргэдийн нэгэн адил субъектив эрх эдэлнэ гэж үзэж байжээ.⁵⁵ Нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэх ойлголт төр өөрийн байгууллагаар дамжуулан өмчийн харилцаанд оролцох шаардлагаас анх үүссэн гэж үзэж болохоор байна. Ийнхүү Франц, Герман улсад нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд төр өөрөө хамаарах эсхүл зөвхөн төрийн байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг хамааруулах байдлаараа ялгаатай хөгжсөн болох нь харагдаж байна.

АНУ-ын судлаач Kenneth C.Cole эрдэм шинжилгээний бүтээлдээ төрийг хуулийн этгээдийн төрөл бус бие даасан, бүрэн эрхт хуулийн этгээд гэж үзэх онолын талаар бичжээ.⁵⁶ Оросын эрдэмтэн В.И.Чиркин “Нийтийн эрх зүйн хуулийн этгээд” өгүүлэлдээ “хуулийн этгээд” гэх ойлголт нь анх Германы ном зохиолуудад 19-р зууны 2-р хагаст гарч ирсэн, харин дараагаар нь Германы 1896 оны иргэний хуульд тусгагдсан гэж үзэж болохоор байна хэмээн бичжээ. Эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагддаг харилцаа нь амьдралын явцад илүү олон төрөлд хуваагдах болсноор “хуулийн этгээд” гэх ойлголт нь ч мөн адил олон төрөлд хуваагдах болсон. М.И.Кулагин 1987 онд бичсэн “Төрийн монополи капитализм ба хуулийн этгээд” гэсэн бүтээлдээ гадаад орнуудад хуулийн этгээдийн 3 үндсэн хэлбэр байна гэжээ. Үүнд: 1. Хувийн эрх зүйн хуулийн этгээд, 2. Нийтийн эрх зүйн хуулийн этгээд 3. Холимог гэсэн 3 төрлийн хуулийн этгээд байна гэж үзсэн.⁵⁷

Эрдэм шинжилгээний бүтээл, судалгаанд “public legal entity”, “legal entity of public law”, “public corporation”, “legal entity with public participation”, “publicly traded company”, “public company”, “legal entity of public interest”, “public interest company” гэсэн олон нэр томьёо байдаг ч бүгд нэг утгыг илэрхийлдэггүй байна. Жишээ нь, “public company” болон “publicly traded company” гэх нэр томьёо бол хувийн эрх зүйн томоохон компанийг илэрхийлэх англо-саксоны эрх зүйн бүлийн орнуудад байдаг ухагдахуун юм. Харин “legal entity of public interest”, “public interest company” гэж төрийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийг илэрхийлсэн нэр

54 Сулейменов М.К., Карагусов Ф.С., Кот А.А., Дуйсенова А.Е., Скрыбин С.В. О понятии и правовом статусе юридических лиц публичного права в законодательстве некоторых развитых иностранных государствах и бывших советских республиках.

55 Мөн тэнд.

56 Yз: Kenneth C. Cole. The Theory of the State as a Sovereign Juristic Person. The American Political Science Review. Vol.42, No.1, 1948. p.16-31 <https://doi.org/10.2307/1949458>

57 В.Е.Чиркин. Юридическое лицо публичного права. <https://cyberleninka.ru/article/n/yuridicheskoe-litso-publichnogo-prava/viewer>

томьёо байна. Дани, Эстони улсад эдгээр байгууллага нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд хамаардаг бол бусад улс оронд хамаардаггүй юм. Ийнхүү нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг “public legal entity”, “legal entity of public law”, “public corporation”, “legal entity with public participation” гэж нэрлэдэг⁵⁸ тул цаашид дэлгэрүүлэн судлах нөхцөлд өөр утга агуулгатай төсөөтэй нэр томьёог хооронд нь ялгаж ойлгох, хэрэглэхэд анхаарах нь зүйтэй.

Иргэний хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон аймаг, нийслэл, сум, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцоно гэж заасан. Харин төрийн байгууллага, захиргааны байгууллага, төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж буй болон хуулийг хэрэгжүүлж буй байгууллага иргэний эрх зүйн харилцаанд ямар байдлаар оролцохыг тодорхой заасан зохицуулалт байхгүй. Үүнийг нэг хуулиар, эсхүл тодорхой хуулийн зүйл, заалтаар шууд хуульчлахаас илүү онолын болон тогтолцооны үүднээс тайлбарлаж, нэгтгэх шаардлагатай асуудал юм. Өөрөөр хэлбэл, нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэх ойлголтыг тодорхойлж, түүнд ямар байгууллага хамаарахыг шинж, үүсгэн байгуулах нөхцөл, эрх, үүрэг, хариуцлагаар ялгах шаардлагатай байна.

Хуулийн этгээдийг дотор нь нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээд гэж үздэг орнуудын жишгээр авч үзэх тохиолдолд “нийтийн эрх зүйн хуулийн этгээд”-ийн нөгөө талд “хувийн эрх зүйн хуулийн этгээд” оршино. Ингэснээр хуулийн этгээдүүдийг дотор нь нийтийн болон хувийн эрх зүйн гэж ялгаснаар үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах харилцаа, ажилтнуудын хөдөлмөр, нийгмийн баталгаа, энэ талаар төрөөс хүлээх үүрэг, хуулийн этгээдийн удирдлага, нийтийн ба хувийн өмчийн талаар эдлэх эрх, хуулийн этгээдийн татвар, дампуурал, захиргааны, иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрхэн оролцох зэрэг нь тодорхой болно.

Монгол Улсын Иргэний хуулийн тайлбарт төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, албан газар, соён гэгээрлийн, шинжлэх ухаан, шашны байгууллага цөм нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд хамаарахаар тайлбарласан нь Герман улсын нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн ойлголтыг нутагшуулах оролдлого хийсэн болохыг илтгэж байна.

Нийтийн эрх зүйн хуулийн этгээд болон хувийн эрх зүйн хуулийн этгээд гэсэн ойлголтууд нь агуулга болон багтаамжийн хувьд давхцах тохиолдол байх тул тэдгээрийг хооронд ялгаж зааглах хүндрэлтэй байдлыг бий болгодог. Тодруулбал:

- Хувийн эрх зүйн хуулийн этгээдийг үүсгэн байгуулагчийн өргөдлөөр бүртгэдэг бол нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг хууль болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр үүсгэн байгуулдаг. Гэвч хувийн эрх зүйн хуулийн этгээдийг төрийн захиргааны эрх бүхий байгууллага байгуулах тохиолдол (тухайлбал захиргааны байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд хувийн эрх зүйн хуулийн этгээд байгуулах шаардлага тулгарах) байх тул энэ шинжээр нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээдийг ялгах хангалттай шалгуур болж чадахгүйд хүрч байна.

58 Сулейменов М.К., Карагусов Ф.С., Кот А.А., Дуйсенова А.Е., Скрыбин С.В. О понятии и правовом статусе юридических лиц публичного права в законодательстве некоторых развитых иностранных государствах и бывших советских республиках.

- Нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь нийтийн эрх ашгийн төлөө байдаг бол хувийн эрх зүйн хуулийн этгээд хувийн эрх ашгийн төлөө байна гэсэн шинжийг шалгуур болгох нь хангалтгүй бөгөөд хувийн эрх зүйн хуулийн этгээд нь нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаа явуулах тохиолдол (үүнд ашгийн төлөө бус хуулийн этгээдүүдийг хамруулан ойлгож болно) байдаг бөгөөд хувийн эрх зүйн хуулийн этгээдийн үйл ажиллагаа нь үндсэндээ нийтийн эрх ашгийн төлөө л байдаг (ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд нь хэдийгээр ашиг олох зорилготой үйл ажиллагаа явууллаа ч нийтийн ашиг сонирхлыг тодорхой хэмжээнд хангаж байж үйл ажиллагаа явуулах боломжтой⁵⁹, мөн олсон ашгаасаа татвар төлдөг) гэж тайлбарлаж болно.
- Хувийн эрх зүйн хуулийн этгээд нь улсын бүртгэлд заавал бүртгүүлснээр түүний эрх зүйн чадвар бий болдог бол нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь бүртгүүлэх шаардлагагүйгээр үүсэн байгууллын баримт бичгээр чадвар чадамжийн асуудал нь шийдэгдэнэ⁶⁰ гэж үзвэл мөн л хангалтгүй юм. Учир нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 7.1.7-с үзвэл нийтийн эрх зүйн хуулийн этгээд улсын бүртгэлд бүртгүүлэх ёстой байна.
- Үйл ажиллагаа нь нийтийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж байна уу, хувийн эрх зүйн хууль тогтоомжоор зохицуулагдаж байна уу гэдгээр шалгуур болгож нийтийн эрх зүйн хуулийн этгээд болон хувийн эрх зүйн хуулийн этгээдийг ялгахад мөн л хүндрэлтэй байна. Тодруулбал, орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдэд компанийн засаглал хэрэгжихгүй байна.⁶¹ Өөрөөр хэлбэл, Компанийн тухай хуульд заасан зохицуулалт буюу хувийн эрх зүйн хэм хэмжээ үйлчлэхгүй байна (Хувьцаа эзэмшигчдийн хурал, аймаг, нийслэлийн ИТХ-ын болон ЗД-ын шийдвэрээр орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ТУЗ-ийг томилж байна. Орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ихэнх буюу 231 байгууллагын гүйцэтгэх захирлыг ЗД томилж, хөлсөөр ажиллах, эсхүл контрактын гэрээ байгуулан дүгнэж байна).⁶²
- Нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь нийтийн засаглалын эрх мэдэлтэй байдаг гэж үзвэл хувийн эрх зүйн хуулийн этгээд нь хууль болон, гэрээний үндсэн дээр төрийн захиргааны эрх мэдлийг шилжүүлэн авсан байх тохиолдол байдаг. Төрийн захиргааны эрхтэй хувийн эрх зүйн хуулийн этгээд нь Захиргааны ерөнхий хуулийн 5.1 дүгээр зүйлийн 5.1.3-д зааснаар

59 МУ-ын ҮХ-ийн 16 дугаар зүйлийн 16.10-д "...олон нийтийн бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж хуулийг дээдлэн биелүүлнэ..." гэж зааснаас үзвэл ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж буй хувийн эрх зүйн хуулийн этгээдийн үйл ажиллагаа нь нийтийн ашиг сонирхлыг хангаж байх шаардлагатай байна.

60 Оросын эрдэмтэн В. И.Чиркин "Нийтийн эрх зүйн этгээд" өгүүлэлдээ нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн шинжүүдийг тодорхойлсон байх бөгөөд нийтийн эрх зүйн этгээд нь дандаа бүртгүүлээд байх шаардлага байдаггүй харин ямар нэгэн хууль зүйн баримт бичиг дээр тулгуурлан байгуулагдаж, үйл ажиллагаа явуулдаг гэж бичжээ. <https://cyberleninka.ru/article/n/yuridicheskoe-litso-publichnogo-prava/viewer>

61 Хуулийн нөхөрлөл Өмгөөллийн ивээл баг. Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд орон нутгийн өмчийн төрөл, ангилал, зохион байгуулалтын талаарх судалгааны тайлан. УБ., 2021. 63 дахь тал.

62 Мөн тэнд.

захиргааны байгууллага болж байх тул төрийн засаглалын тодорхой эрхийг олж авдаг байна. Иймд төрийн засаглалын тодорхой эрхтэй эсэх нь нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг хувийн эрх зүйн хуулийн этгээдээс ялгах гол шалгуур болж байна. Гэвч төрийн захиргааны эрх мэдлийг хувийн эрх зүйн хуулийн этгээд гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх хүрээнд гарсан актын талаар гаргасан гомдлыг хэн шийдвэрлэх нь нэлээд асуудалтай байдаг, учир нь тэд төрийн захиргааны шаталсан бүтцийн гадна оршдог тул шууд харьяалан захирах дээд байгууллага гэж байхгүй, харьцангуй автономи, өөрөө удирдах ёсны үндсэн дээр ажилладаг.⁶³

Дээрхээс үзвэл, хувийн болон нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн шинжийг давхар агуулдаг хуулийн этгээд буюу холимог хуулийн этгээд байна гэдэг нь харагдаж байна. Хувийн болон нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн зааг ялгааг бүрэн гаргах боломжгүй, эсхүл ийнхүү ялгааг нь гаргаж чадахгүй байгаагаас холимог хуулийн этгээд гэх ойлголт урган гарч байгаа төдийгүй түүний (холимог хуулийн этгээд) эрх зүйн байдлыг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид хараахан тодорхойлоогүй байна. Үүнээс үүдэн зарим судалгаанд нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг хуулиар олгосон тусгай чиг үүрэг бүхий төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд хэмээн тодорхойлжээ.⁶⁴

Хуулийн этгээдийн улсын бүртгэлд Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, Монголын телевизүүдийн холбоо нийтийн эрх зүйн хуулийн этгээдээр бүртгэлтэй байна. Харин нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн бусад тодорхой төрлийг тодорхойлоогүй тул тэдгээр нь улсын бүртгэлд өөр хуулийн этгээдээр бүртгүүлэх үр дагавар бий болжээ. Нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс гадна нийтийн эрх зүйн этгээд гэсэн нэр томьёог зарим хууль тогтоомжоор хэрэглэж байгаа нь ойлгомжгүй байна.

Нийтийн эрх зүйн этгээдэд захиргааны байгууллага, Монголын Нотариатчдын танхим, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, дагуул хотыг хамааруулж байна. Ийнхүү нийтийн эрх зүйн этгээд болон нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэж нэг утга агуулгатай ойлголтыг хоёр өөрөөр, эсхүл хоёр өөр агуулгатай ойлголтыг ойлгомжгүй томьёолсон эсэх тодорхойгүй байна. Хэрэв нийтийн эрх зүйн этгээдэд хуулийн этгээдийн эрхгүй аливаа байгууллага хамааруулах нөхцөлд нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс өргөн агуулгатай болно. Энэ тохиолдолд ч нийтийн эрх зүйн этгээд гэсэн нэр томьёог хэрэглэх нь зохимжгүй юм.

Учир нь эрх зүйн этгээд гэж эрх эдэлж, үүрэг хүлээх чадвартай хүний эрх зүйн байдлыг тэмдэглэсэн ойлголт.⁶⁵ Ийм ойлголтын нэрийн урд “нийтийн” гэсэн тодотгол нэмснээр нэр томьёоны утга агуулга ойлгомжгүй бөгөөд нийтийн эрх зүйн хуулийн этгээдтэй давхардах асуудал үүсэхээр байна. Иймд нийтийн эрх зүйн этгээдийг нарийвчлан судалж, нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс ерөнхий ойлголт гэж үзэх тохиолдолд өөрөөр томьёолох нь зүйтэй бөгөөд цаашид хуулийн этгээдийг хувийн болон нийтийн гэж ангилах хэрэгцээ бий болсныг үгүйсгэхгүй юм.

63 Хууль зүйн үндэсний хүрээлэн, Төрийн бус байгууллагад төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр шилжүүлэх нь-харьцуулсан судалгаа. 2013, 23 дахь тал.

64 Иргэдэд туслах хүний эрхийн төв ТББ, Ашгийн бус байгууллагын талаарх Монгол Улсын эрх зүйн зохицуулалт. Эрх зүйн дүн шинжилгээ. 2018, 22 дахь тал.

65 Д.Баярсайхан, Эрх зүйн онол. 1996, 227 дахь тал.

6.Төрийн байгууллага, албан газар

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8, 7.1.9 дэх заалтад заасан төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газарт Засгийн газрын тусгай сан, комисс, хороо, үндэсний зөвлөл хамаарахгүй байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар гэнэ.” гэжээ. Төрийн байгууллага болон албан газар чухам яаж ялгагдах нь тодорхойгүй байна.

Тус ерөнхий тодорхойлолтоос төрийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг хэдий ч төсвөөс санхүүждэггүй байгууллагуудын эрх зүйн байдал, нийтийн эрх зүйн хуулийн этгээд болон төрийн өмчит хуулийн этгээдийн харилцаа хамаарал, уялдаа холбоог тодорхойлох боломжгүй юм. Жишээ нь, Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт заасанчлан Монголбанк нь төрөөс үүсгэн байгуулсан хуулийн этгээд байна. Санхүүжилтийн хувьд Монголбанк үйл ажиллагаагаа явуулахад хүлээх үүргийн баталгаа болгох зорилгоор өөрийн хөрөнгөтэй бөгөөд энэ нь дүрмийн сан, ерөнхий нөөцийн сан, дахин үнэлгээний сан, бусад сан, цэвэр орлогоос бүрдэж⁶⁶ байх тул улсын төсвөөс санхүүждэггүй байгууллага гэж үзнэ. Гэтэл дээрх хуулийн тодорхойлолт ёсоор Монголбанк нь төрийн байгууллага, албан газарт хамаарахгүй тул нийтийн эрх зүйн хуулийн этгээд мөн гэж дүгнэхэд хүндрэлтэй байна.

Тэгвэл төрийн байгууллага, албан газрыг эрдэмтэн судлаачдын бүтээлд хэрхэн тодорхойлсныг авч үзвэл, Үндсэн хуулийн эхийг баригч Б.Чимид үзэхдээ төрийн байгууллага гэдэг бол төрөөс хуулийн дагуу байгуулагдан, албан хаагчдаас бүрдэн төсвөөр санхүүжиж, төрийн тодорхой чиг үүрэг, түүний аль нэг хэсгийг шууд эрхлэн хэрэгжүүлдэг, түүндээ тохирсон засаглах бүрэн эрх, эдлэг (материаллаг) нөөц бүхий нийтийн эрх зүйн субъект мөн.⁶⁷ Өөрөөр хэлбэл төрийн байгууллага гэдэгт шинэ Үндсэн хуулийн ёсоор хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагын тогтолцоонд ордог засаглах эрх бүхий байгууллага⁶⁸ хамаарах юм гэлээ.

Чингэлтэй дүүргийн анхан шатны шүүхийн шүүгч, доктор Н.Баярмаа “төрийн байгууллага”-ыг дээрх шинжүүдийг агуулсан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд хамааруулсан бол доктор П.Одгэрэл нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг:

1. Төрийн гүйцэтгэх байгууллагууд;
2. Нийтийн эрх зүйн бусад хуулийн этгээд;
 - а. гишүүнчлэл бүхий нэгдэл
 - б. албан газар
 - в. нийтийн эрх зүйн сан гэж ангилсан.⁶⁹

Үүний дагуу Монголбанкыг албан газар гэсэн ангилалд хамааруулжээ. Улсын төсвөөс санхүүждэггүй, өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг Монголбанк шиг байгууллага

66 Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг.

67 Б.Чимид, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс. Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил, 2006, 86 дахь тал.

68 Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал. 2 дахь хэвлэл, 183 дахь тал.

69 П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги, 2016, 106-110 дахь талаас дэлгэрэнгүй үзнэ үү.

төсвийн байгууллагад тооцогдох эсэх асуудал мөн гарч болох талаар судлаачид авч үзсэн байна.⁷⁰ Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34 дэх заалтын дагуу төсвийн байгууллага гэдэгт баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг хэлж байна.

Ийнхүү ТБОНӨТХ-д төрийн өмчийн хуулийн этгээдийн төрлийг ойлгомжгүй, чухамдаа бол бизнесийн харилцааг зохицуулах суурь хууль болж байгаа Иргэний хуульд заасан хуулийн этгээдийн хэлбэрийг зөрчиж тогтоосон байна.⁷¹ Эдгээрээс дүгнэвэл төрийн байгууллага, албан газар болон төрийн өмчит үйлдвэрийн газар зэрэг төрийн өмчит хуулийн этгээдэд хамаарч байгаа ойлголтуудын ангиллыг оновчтой хийж эрх зүйн зохицуулалтын хувьд тодорхой болгох шаардлагатай байна.

Үүнийг гавьяат хуульч Б.Чимид: “Нөгөө талаар улсын өмч, төрийн төсөвт улсын их, дээд сургууль мэргэжлийн их урлагийн газар, улсын нэгдсэн эмнэлэг зэрэг албан газрууд төлбөртэй үйлчилгээ үзүүлж, өөрөө санхүүжүүлэх арга механизмд шилжиж байгаа нь тэдгээрийн нийтийн болон тусгай эрх зүйн субъект байх боломж өөрчлөгдөж байна. Үүнээс шалтгаалан соёл, боловсрол, эрүүл мэндийн зэрэг төрийн албан газруудын статусыг тогтоосон хууль, эрх зүйн актуудыг нийтийн ба тусгай (хувийн) эрх зүйн онолын үүднээс задлан шинжилж шинэчлэхэд тус дөхөм үзүүлэхүйц шинжлэх ухааны санал зөвлөмж гаргах нь чухал болжээ.”⁷² гэснийг мөн онцлох нь зүйтэй.

Төрийн байгууллага нийтийн эрх зүйн хуулийн этгээд, ашгийн төлөө бус төрийн өмчит хуулийн этгээдийн аль болохыг нарийн тодорхойлох боломжгүй хэдий ч хуулийн этгээд мөн байна. Үүнтэй зөрчилдөх хэм хэмжээ бол 2015 оны Эрүүгийн хуулиар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалт юм. Төр өөрөө өөртөө эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал байх боломжгүй. Тэр ч утгаараа Эрүүгийн хуульд заасан хуулийн этгээдэд нийтийн эрх зүйн хуулийн этгээд, тэр дундаа төрийн байгууллага хамаарах боломжгүйг анхаарах шаардлагатай.

Хуулийн этгээд нь ухамсаргүй, хүсэл зориггүй хийсвэр этгээд болохыг судалгааны эхний хэсэгт авч үзсэн. Энэ утгаараа хуулийн этгээд үйлдэх гэмт хэргийн бүрэлдэхүүнийг задлан шинжлэхэд түүний субъектив талыг (мэдэх, хүсэх элемент) тодорхойлох боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, хуулийн этгээдэд зөрчлийн хариуцлага хүлээлгэх боломжтой байдаг тул нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг тодорхойлохдоо Эрүүгийн хуулийн холбогдох зохицуулалттай уялдуулах хэрэгцээ, шаардлага үүсэхийг үгүйсгэх аргагүй билээ.

7. Үйлдвэрийн газар

“Үйлдвэрийн газар” гэх ойлголт 1991 онд “Аж ахуйн нэгжийн тухай” хууль баталж, “хувиараа эрхлэх аж ахуй”, “хоршоо”, “нөхөрлөл”, “компани” гэх мэт нэр өргөн хэрэглэх болсноор нэлээд бүдгэрсэн юм. Эдгээр нэр нь аль нэг аж ахуйн

70 Н.Баярмаа, Нийтийн эд юмсын эрх зүй: Монгол Улс дахь төрийн болон Орон нутгийн өмчийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам, 2018, 29 дэх тал.

71 Мөн тэнд, 37 дахь тал.

72 Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: нийтлэг үндэслэл. Нэгдүгээр дэвтэр, 2004, 318 дахь тал.

буюу эдийн засаг дахь бизнесийн байгууллагуудыг төрөлжүүлсэн нэр болохоос бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх ажил эрхэлдэг нийт газрын ерөнхий нэр болох “үйлдвэрийн газар” гэдгийг төлөөлөхгүй мэт. Ийм учраас үйлдвэрийн газрын зохион байгуулалтын хэлбэр болсон ХК, ХХК мэтийг оролцуулан, төрийн 100 хувийн өмчит бүх газрыг бүхэлд нь “үйлдвэрийн газар” гэсэн томъёогоор “төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-д бүлэглэж статусыг тогтсон болно.⁷³

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орох бөгөөд тэдгээрийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж ангилахаар заасан.

Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэж өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг хэлнэ. Харин улсын төсөвт үйлдвэрийн газар гэж өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг хэлнэ.

Шүүгч Н.Баярмаа үйлдвэрийн газруудын талаар: “Салбар хуулийн зохицуулалтын хүрээнд тодорхойгүй нөхцөл байдлыг дагуулж буй төрийн өмчит аж ахуйн нэгжийн нэгэн хэлбэр болох үйлдвэрийн газар, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын зохицуулалтыг тодорхой болгох, төрийн өмчит компаниудад компанийн сайн засаглалын стандартыг хуульчлан тогтоох явдал эдгээр зохицуулалтад илт үгүйлэгдсэн хэвээр байна. Төрийн өмчит үйлдвэрийн газар хэмээх ойлголт нь зохион байгуулалт эрх зүйн хэлбэрийн хувьд тодорхой бус хуулийн этгээд тул компанийн засаглалыг шууд үйлчилнэ гэж ойлгоход бэрхшээлтэй байна. Суурь зохион байгуулалтын хэлбэр тодорхойгүйгээс болоод энэ төрлийн хуулийн этгээдийн дотоодод үйл ажиллагаа хэрхэн өрнөж байгааг төсөөлөхөд бэрх байна”⁷⁴ гэжээ. Үүнээс төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж гэсэн ойлголт мөн гарч ирж байгаа тул үйлдвэрийн газрууд төрийн өмчийн оролцоотой ашгийн төлөө хувийн эрх зүйн хуулийн этгээд болох эсэхийг гүнзгийрүүлэн судлах шаардлагатай юм.

II. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ ДАХЬ НЭР ТОМЬЁО, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Эрх зүйн харилцаанд оролцогч нь төр, иргэн, албан тушаалтан, ажилтан, хуулийн этгээд, мөн хуулийн этгээдийн эрхгүй байгууллага байдаг бөгөөд манай улс иргэний хуулиараа хуулийн этгээдийн төрлийг тоочих аргаар зохицуулсан. Харин бусад хууль тогтоомжид эрх зүйн харилцааны субъектүүдийг олон янзаар томъёолон хэрэглэж байна. Тухайлбал, “иргэн, хуулийн этгээд”, “төрийн болон төрийн бус байгууллага”, “иргэн, аж ахуйн нэгж, байгууллага”, “албан тушаалтан, хувь хүн, хуулийн этгээд”, “банк, бусад хуулийн этгээд, иргэн”, “төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд” гэж

73 Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: Нийтлэг үндэслэл. Нэгдүгээр дэвтэр, 2004, 319 дэх тал.

74 Н.Баярмаа, Нийтийн эд юмсын эрх зүй: Монгол Улс дахь Төрийн болон орон нутгийн өмчийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам, 2018.

эрх зүйн харилцааны субъектүүдтийг замбараагүй ангилан хэрэглэжээ. Эдгээрт хамаарах зарим ойлголтыг судалгааны өмнөх хэсэгт авч үзсэн тул төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, аж ахуйн нэгж, корпораци гэсэн нэр томьёоны агуулга, тулгамдаж буй асуудлыг тодорхойлъя.

1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд


Иргэний хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт “Чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаар буюу хамтран хуулийн этгээд байгуулж болно” гэж төрийн өмчит хуулийн этгээд байгуулж болохыг баталгаажуулсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь 1/төрийн байгууллага, албан газар; 2/төрийн өмчит үйлдвэрийн газар; 3/төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг гэж ангилна. Үүнээс харвал, төрийн өмчит хуулийн этгээдийг тодорхойлсон бөгөөд төрийн болон нутгийн өмчит хуулийн этгээдийг тодорхойлсон хууль байхгүй ч бусад хуулиар уг нэр томьёог түгээмэл хэрэглэж байна. Түүнчлэн хууль тогтоомжид ялгамжтай дараах нэр томьёог хэрэглэж байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж;
- Төрийн болон орон нутгийн өмчит компани;
- Төрийн болон орон нутгийн өмчит хувьцаат компани;
- Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар;
- Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой газар.

Эдгээрийг нийтэд нь төрийн болон орон нутгийн өмчит этгээд гэж нэрлэсэн тохиолдол байгааг доорх тоон хүснэгтээс харах боломжтой.

Хүснэгт 8. Төрийн болон орон нутгийн өмчит этгээдийн тоо (2020 он) ⁷⁵



75 Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2020 оны 08 дугаар сарын байдлаар мэдээлсэн тоо.

Мөн төрийн өмчит этгээдүүдийг нийтийн болон хувийн эрх зүйн статусыг нь ялгахгүйгээр төрийн өмчит хуулийн этгээд гэж “нэг малгайн дор” өөрөөр хэлбэл ерөнхийлсөн байдлаар зохицуулахыг хичээсний үр дүнд өөр хоорондоо үйл ажиллагаа нь уялдаагүй, хуулийн хийдлийг ашиглахыг эрмэлзсэн, үр ашиг муутай олон компани, сан, төслийн нэгж, үйлдвэрийн газрууд төрөн гарахад хүрсэн⁷⁶ гэсэн судлаачдын шүүмжлэл бий. Иймд төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь хуулийн этгээдийн ямар төрөл болохыг оновчтой зохицуулах шаардлагатай байна.

2.Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж

2011 оны Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэгт “төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж” гэсэн нэр томъёог ашигласан. Аж ахуйн нэгж гэдэг нь хуулийн этгээдээс өргөн агуулгатай ойлголт. Үүнийг Аж ахуйн нэгжийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад “Улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээд болон үндсэн үйл ажиллагаа нь ашгийн бус боловч бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлж орлого олсон дотоод, гадаадын хуулийн этгээдийг хэлнэ” гэж тодорхойлсноос харж болно.

Ийнхүү аж ахуйн нэгж нь дотроо хуулийн этгээд болон хуулийн этгээдийн эрхгүй байгууллагыг багтаасан ойлголт байна. Харин төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж гэдэгт төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг ойлгох уу, аж ахуйн нэгжийг дотор нь ийнхүү хуваасан уу гэсэн асуулт урган гарч байна. Нэгэнт хуульд аж ахуйн нэгжийг дотор нь ангилаагүй тул төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж гэсэн ойлголтыг тодорхойлоход бэрхшээлтэй байна.

Хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх олон улсын төвийн Улс болон гадаад улсын иргэний хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенц (ICSID)-ийг 1965 онд “эдийн засгийн хөгжлийн төлөөх олон улсын хамтын ажиллагаа”-ны ашиг сонирхолд нийцүүлэн, эдгээр ашиг сонирхлыг хангахад “олон улсын хувийн хөрөнгө оруулалт” гүйцэтгэх үүргийг хүлээн зөвшөөрч боловсруулсан.⁷⁷

Хөрөнгө оруулагч-улсын маргааныг шийдвэрлэх дэглэм нь гадаадын хөрөнгө оруулагчдын маргааныг улс төрөөс ангид байлгах зорилготой байсан тул ICSID-ийн конвенц нь уг дэглэмийг зөвхөн “Хэлэлцэн тохирогч улсын болон хэлэлцэн тохирогч бусад улсын харьяат (national)-ын хооронд хөрөнгө оруулалтаас шууд үүссэн эрх зүйн маргааныг шүүх эрхтэй байхаар зохицуулсан.”⁷⁸

Тиймээс ICSID-ийн конвенц нь улс хоорондын маргаан эсвэл хувь этгээдүүдийн хоорондын маргааныг арбитраар хэлэлцэхээс сэргийлдэг. Хэрэв Төрийн өмчит аж ахуйн нэгж нь үндсэндээ төрийн чиг үүргийг гүйцэтгэж байсан эсвэл төрийн төлөөлөгчийн үүргийг гүйцэтгэж байсан бол түүнийг хөрөнгө оруулалтын гэрээний хамгаалалтаас хасна гэж хэлэх нь маргаангүй мэт санагдана. Хэрэв тухайн аж

76 Н.Баярмаа, Төрийн нийтийн өмч: Газар ба үл хөдлөх эд хөрөнгө, газрын хэвлийн баялаг ба хувьцаа, 2021, 73 дахь тал.

77 Convention on the Settlement of Investment Disputes between States and Nationals of Other States (ICSID Convention), preamble.

78 Мөн тэнд, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

ахуйн нэгж гадаадад арилжааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бол шүүхүүд тэднийг хүлээн авагч улсын эсрэг нэхэмжлэл гаргах чадвартай хэлэлцэн тохирогч бусад улсын «харьяат» болохыг тогтоодог байна.

ICSID-ийн конвенцын төслийг боловсруулах үед төрийн өмчит үйлдвэрийн газрууд нэхэмжлэл гаргахдаа ямар статустай байх эсэхийг тодруулах шаардлага бий болсон. ICSID-ийн анхны Ерөнхий нарийн бичгийн дарга, Конвенцыг бичсэн гол хүмүүсийн нэг Аарон Брочес энэ асуултад нийцүүлэхийн тулд одоо “Брочесын тест” гэж нэрлэгддэг шалгуурыг зохиожээ. Брочес “холимог эдийн засгийн компани эсвэл төрийн өмчит хуулийн этгээд нь засгийн газрын төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэдэг эсвэл үндсэндээ төрийн чиг үүргийг гүйцэтгэдэг бол Хэлэлцэн тохирогч бусад улсын харьяат байх эрхийг хасч болохгүй” гэж хоёр үндсэн шалгуураар дүгнэх санааг гаргажээ.⁷⁹

“Хэлэлцэн тохирогч бусад улсын харьяат (National of another Contracting State)” гэдэгт маргаанд хамаарахгүй энэхүү конвенцын бусад гишүүн орнууд болон гадаадын хяналтын дагуу талуудын хүлээн зөвшөөрсөн маргааны талуудын харьяат хувь хүн, хуулийн этгээд байж болно.⁸⁰ Иймд Монгол Улсын төрийн өмчит хуулийн этгээдийг дотор нь ангилж, ялгахдаа энэхүү Брочесын тестийг харгалзан үзэх боломжтой байна.

3.Корпораци

Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтад “Ирээдүйн өв сан корпораци” /цаашид корпораци/ гэж Сангийн хөрөнгийн удирдлагын мандатаар олгогдсон эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх үүрэг бүхий 100 хувь төрийн өмчит хуулийн этгээдийг хэлнэ” гэжээ. Корпорацийг хуулийн этгээдийн нэг төрөл хэмээн андуурах тохиолдол элбэг байдаг. Гэтэл уг ойлголт нь хуулийн этгээдтэй ижил утгатай нэр томьёо юм.

Тодруулбал, англо-саксоны эрх зүйн бүлийн орнуудад хуулийн этгээдийг корпораци буюу “corporation” гэж нэрлэдэг байна. Америкийн Нэгдсэн Улсад хуулийн этгээд буюу корпорацийг дотор нь:

- 1/ нийтийн (public);
- 2/ холимог (quasi-public);
- 3/ ашгийн төлөө (business);
- 4/ ашгийн төлөө бус (non-profit) гэж дөрөв хуваадаг.⁸¹

Иймд корпораци гэх англо-саксоны эрх зүйн орнуудын хуулийн этгээдийг илэрхийлсэн нэр томьёог Монгол Улсын хууль тогтоомжид хэрэглэх нь зохимжгүй байна. Түүнчлэн өмнөх хэсэгт дурдсанчлан Засгийн газрын тусгай сангуудыг Иргэний хуульд заасан сан, нийтийн эрх зүйн хуулийн этгээд, эсхүл төрийн өмчит хуулийн этгээдэд хамааруулах асуудал тодорхойгүй байгааг анхаарах шаардлагатай юм.

79 Aaron Broches, Selected Essays, World Bank, ICSID, and other Subjects of Public and Private International Law (Martinus Nijhoff Publishers 1995).

80 Convention on the Settlement of Investment Disputes between States and Nationals of Other States (ICSID Convention), preamble, Article 25(2).

81 Сабирова Л.Л. Теоретические и правовые основы юридических лиц в российском и зарубежном праве. Вестник экономики, права и социологии, 2014. №2. стр.143.


ГУРАВДУГААР БҮЛЭГ. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

1.ОХУ-ын хуулийн этгээдийн төрөл

ОХУ-ын Иргэний хуулийн Дөрөвдүгээр бүлэгт хуулийн этгээдийн талаар тусгайлан зохицуулсан. 2014 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс “Оросын Холбооны Улсын Иргэний хуулийн 4 дүгээр бүлэгт өөрчлөлт оруулах тухай” хууль хүчин төгөлдөр болсон. Уг хуулиар хуулийн этгээдийн институтийг өөрчилж, хуулийн этгээдийн ойлголт, үүсгэн байгуулах баримт бичгийн бүрэлдэхүүн, удирдах байгууллагын хариуцлага, хуулийн этгээдийн төрлийг өөрчилсөн.

ОХУ-ын Иргэний хуулийн 4 дүгээр бүлэгт өмнө нь хуулийн этгээдийг ашгийн төлөө болон ашгийн төлөө бус гэж ангилдаг байсан бөгөөд дараах төрлийн хуулийн этгээдийг зохицуулсан байжээ. Үүнд⁸²:

Хүснэгт 9. ОХУ-ын хуулийн этгээдийн хуучин ангилал



82 <https://zhazhda.biz/base/vidy-jurlic>

Хүснэгт 10. ОХУ-ын Иргэний хуулийн Дөрөвдүгээр бүлэг⁸³

Хуулийн дэд бүлэг	Хуулийн зүйл, заалт	Агуулга
Нийтлэг үндэслэл	48 дүгээр зүйл. Хуулийн этгээдийн ойлголт	1. Хуулийн этгээд гэж өөрийн гэсэн эд хөрөнгөтэй, түүгээрээ хариуцлага хүлээх, иргэний эрх, үүргийг өөрийн нэрээр олж авч, хэрэгжүүлэх, шүүхэд нэхэмжлэгч болон хариуцагч байх чадвартай байгууллагыг хэлнэ. 2. Хуулийн этгээд нь энэ хуульд заасан зохион байгуулалтын аль нэг хэлбэрээр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн байх ёстой. 3. Үүсгэн байгуулагч нар нь эд хөрөнгийн өмчлөх эрхтэй хуулийн этгээдэд төрийн болон орон нутгийн нэгдмэл байгууллага, албан байгууллага хамаарна. Гишүүд нь нэгдлийн эрх эдэлдэг хуулийн этгээдэд нэгдлийн байгууллага (корпоративные организации) хамаарна.
	50 дугаар зүйл. Ашгийн болон ашгийн бус байгууллага	1. Ашиг олох үндсэн зорилгоор үйл ажиллагаа явуулах хуулийн этгээд нь ашгийн төлөө байгууллага байна. Ашиг олох үндсэн зорилгогүй, олсон ашгаа гишүүддээ хуваадаггүй хуулийн этгээд нь ашгийн төлөө бус байгууллага байна. 2. Ашгийн төлөө хуулийн этгээдийг аж ахуйн нөхөрлөл болон холбоо, тариалангийн (фермерийн) аж ахуй, аж ахуйн нөхөрлөл (хозяйственное партнерство), үйлдвэрлэлийн хоршоо (производственные кооперативы), төрийн болон орон нутгийн нэгдмэл үйлдвэрийн газар хэлбэрээр байгуулна. 3. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг зохион байгуулалтын дараах хэлбэрээр байгуулна: 1. Хэрэглэгчийн хоршоо; 2. Олон нийтийн байгууллага; 3. Нийгмийн хөдөлгөөн; 4. Холбоо; 5. Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгчдийн нөхөрлөл; 6. Хасаг нийгэмлэг; 7. ОХУ-ын угсаатны цөөнхийн нэгдэл; 8. Нийтийн болон сайн үйлсийн сан; 9. Төрийн байгууллага; 10. Шашны байгууллага; 11. Нийтийн эрх зүйн компани (публично-правовая компания); 12. Өмгөөлөгчдийн холбоо; 13. Улсын нэгдэл; 14. Нотариатчдын танхим.

Үүнээс харахад, ОХУ-ын Иргэний хуулиар хуулийн этгээдийг ангилахдаа ашгийн болон ашгийн төлөө бус гэдгээс гадна бүх хуулийн этгээдийг нэгдмэл (унитарные) болон нэгдэл (корпоративные) гэж хуваах болжээ. Нэгдэл бүхий хуулийн этгээдийн үүсгэн байгуулагчид нь тус хуулийн этгээдийн гишүүн байдаг бол нэгдмэл хуулийн этгээдийн үүсгэн байгуулагчид гишүүн байдаггүй байна. Д.И.Степанова зэрэг зарим судлаачид уг ангиллыг дэмжихгүй байгаа ч хуулийн хийдлийг арилгахад ач холбогдолтой гэсэн байр суурьтай судлаачид ч байгаа юм.⁸⁴ Түүнчлэн судлаачид тэдгээр хуулийн этгээдийг нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээд гэж хуваадаг бөгөөд төр болон төрийн байгууллагыг хуулийн этгээд гэж үздэгээрээ онцлог байна.

83 <http://www.consultant.ru/>

84 Соломонов.Е.В. Виды юридических лиц: новое в гражданском законодательстве. Вестник Омского университета. Серия "Право". 2015. №1 (42). стр.132.

1.БНКУ-ын хуулийн этгээдийн төрөл

Бүгд Найрамдах Казахстан Улсын 1994 оны Иргэний хуулийн 2 дугаар бүлгийн 33-57 дугаар зүйлд хуулийн этгээдийн ойлголт, төрөл, хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, улсын бүртгэлд бүртгүүлэх, эрх зүйн чадваргүйд тооцох, салбар, төлөөлөгчийн газар зэрэг олон зохицуулалтыг хуулийн этгээдийн ойлголтын хүрээнд тусгаж зохицуулсан байна. Үүний дараагийн бүлгүүдэд нөхөрлөл, компани, холбоо, сан зэрэг хуулийн этгээдийн хэлбэрүүдийг тус тус авч үзжээ.

Уг хуулийн дагуу үйл ажиллагааны үндсэн зорилго нь ашиг олох /ашгийн төлөө байгууллага/ болон ашиг олох зорилгогүй, цэвэр ашгаа гишүүддээ хуваарилдаггүй байгууллага /ашгийн төлөө бус байгууллага/-ыг хуулийн этгээд гэнэ.⁸⁵

Хүснэгт 11. БНКУ-ын хуулийн этгээдийн төрөл⁸⁶

Ашгийн төлөө хуулийн этгээд	1. Аж ахуйн нөхөрлөл	• Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл; • Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл; • Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл; • Нэмэлт хариуцлагатай нөхөрлөл.
	2. Хувьцаат компани	
	3. Үйлдвэрлэлийн хоршоо	
	4.Төрийн өмчит үйлдвэрийн газар ⁸⁷	• Санхүүгийн удирдлагад суурилсан; • Үйл ажиллагааг удирдах эрхэд суурилсан.
Ашгийн төлөө бус хуулийн этгээд	1. Албан газар	Улсын төсвийн санхүүждэг хуулийн этгээдийг зөвхөн албан газрын хэлбэрээр байгуулж болно. ⁸⁸
	2. Холбоо	
	3. Хэрэглэгчийн хоршоо	
	4. Сан	
	5. Шашны байгууллага	

Казахстан улсын Төрийн өмчийн тухай хуульд төрийн өмчит хуулийн этгээдэд төрийн өмчит үйлдвэрийн газар болон албан газар⁸⁹-ыг хамруулсан байх бөгөөд албан газар гэдэгт удирдлагын, нийгэм-соёлын болон ашгийн төлөө бус бусад чиг үүргийг хэрэгжүүлдэг, БНКУ-ын хууль тогтоомжоор нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийг тогтоогоогүй бол гагцхүү улсын төсвөөс санхүүждэг, төрөөс үүсгэн байгуулсан ашгийн төлөө бус байгууллагыг⁹⁰ ойлгохоор заасан байна. Энэ нь доктор П.Одгэрэлийн “Захиргааны эрх зүйн ерөнхий анги” бүтээлдээ тодорхойлсон албан газрын ойлголттой төстэй байна.

85 Казахстан улсын Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

86 <https://adilet.zan.kz/eng/docs/K940001000?fbclid=IwAR120eb3iU2d5jrkCBP6dSI2eW45PeVYvap6hABK5CZLrhQubfmoCyVP6S8>

87 Казахстан улсын Иргэний хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэгт зааснаар аж ахуйн нэгж нь хуулийн этгээдэд хамаардаг.

88 Төрийн өмчийн тухай хууль, 2011, 34.3-1-р зүйл.

89 Төрийн өмчийн тухай хууль, Law of the Republic of Kazakhstan dated 1 March 2011 No. 413-IV, 14-р зүйл, <https://adilet.zan.kz/eng/docs/Z1100000413>

90 Мөн тэнд, 15-р зүйл.

Хуулийн этгээдийн бүртгэлийн журмыг зохицуулсан гол хууль тогтоомж нь 1995 оны 04-р сарын 17-ны өдрийн Хуулийн этгээдийн улсын бүртгэл, салбар, төлөөлөгчийн газрын бүртгэлийн тухай хууль, Бүгд Найрамдах Казахстан Улсын Хууль зүйн сайдын 2007 оны 04-р сарын 12-ны өдрийн тушаалаар батлагдсан Хуулийн этгээдийн улсын бүртгэл, салбар, төлөөлөгчийн газрын бүртгэлийн тухай заавар юм. 1995 оны Хуулийн этгээдийн улсын бүртгэл, салбар, төлөөлөгчийн газрын бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд хуулийн этгээдийн бүртгэлийг дараах байдлаар зохицуулсан. Үүнд:

Хүснэгт 12. БНКУ-ын хуулийн этгээдийн бүртгэл


3 дугаар зүйл. Улсын бүртгэлд бүртгүүлэх хуулийн этгээд, салбар, төлөөлөгчийн газар
Бүгд Найрамдах Казахстан Улсын нутаг дэвсгэрт байгуулагдсан бүх хуулийн этгээдийг үүсгэн байгуулах зорилго, үйл ажиллагааны төрөл, шинж чанар, оролцогчдын (гишүүдийн) бүрэлдэхүүнээс үл хамааран улсын бүртгэлд бүртгэнэ.
Бүгд Найрамдах Казахстан улсын нутаг дэвсгэрт байрлах хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхийг олж авахгүйгээр бүртгэлд хамрагдана.

Мөн БНКУ-ын Иргэний хуулийн 42 дугаар зүйлд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ерөнхий заалтуудыг тусгасан байна. Үүнд зааснаар ашгийн төлөө бус хуулийн этгээд нь шүүхийн байгууллагад бүртгүүлэх ёстой бол ашгийн төлөө хуулийн этгээд нь Бүгд Найрамдах Казахстан улсын хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд «Иргэдийн төлөөх засгийн газар» төрийн байгууллагад бүртгүүлэх ёстой байна.

Эдгээрээс үзэхэд БНКУ нь Монгол Улсын адилаар хуулийн этгээдийг ашгийн төлөө болон ашгийн төлөө бус гэж ангилсан бөгөөд ашгийн төлөө бус хуулийн этгээдэд албан газрыг оруулан хуульчилснаараа онцлог байна. Мөн БНКУ-ын хууль тогтоомжоор нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрийг тогтоогоогүй бол гагцхүү улсын төсвөөс санхүүждэг, төрөөс үүсгэн байгуулсан ашгийн төлөө бус байгууллагыг албан газарт хамааруулж байна. Ингэснээр улсын төсвөөс санхүүждэггүй, төрөөс үүсгэн байгуулсан байгууллагын статус орхигдоогүй зохицуулагдсан байна.

2.БНФУ-ын хуулийн этгээдийн төрөл, бүртгэл

Хүснэгт 13. БНФУ-ын хуулийн этгээдийн төрөл⁹¹



91 https://miit.ru/content/rpaжд+и+topr+npавo.pdf?id_vf=14346

БНФУ-д аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг байгууллага харьцангуй олон байдаг. Тухайлбал, хязгаарлагдмал хариуцлагатай компани (SARL), хувьцаат компани (SA), хувьцаа эзэмших хязгаарлагдмал эрхтэй компани (SAS), ганцхан үүсгэн байгуулагчтай хязгаарлагдмал хариуцлагатай компани (EURL), бүрэн хариуцлагатай нөхөрлөл (SNC), хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл (SCS), хязгаарлагдмал хариуцлагатай хувьцаат нөхөрлөл (SCPA) зэрэг юм.⁹² Дээрх ангиллаас харахад төр болон муж зэрэг онцлог субъектүүдийг нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд хамааруулж байгаа бол Монгол Улсын хувьд төрийг хуулийн этгээдийн нэг төрөл гэж хуульчлаагүй байна. Мөн Монгол Улсад аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар хэмээх ойлголт байх ба энэ нь төрийн өмчит хуулийн этгээдийн нэгэн төрөл байхад БНФУ-д улсын аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар хэмээх төстэй ойлголтыг нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд хамааруулжээ.

3. ХБНГУ-ын хуулийн этгээдийн төрөл, бүртгэл

ХБНГУ-ын хууль тогтоомжид хуулийн этгээд гэх ойлголтыг эрх зүйн чадвар, чадамжтай, хуулийн этгээдийн шинжийг агуулж буй хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн холбоо, хөрөнгийн нэгдэл гэж үздэг байна. Иргэний хуульд заасны дагуу хуулийн этгээд нь холбоо, сан, бусад хувийн компаниас бүрддэг.⁹³

Хүснэгт 14. ХБНГУ-ын хуулийн этгээдийн төрөл

Хувийн эрх зүйн хуулийн этгээд	1. Холбоо (Vereine)- нийтлэг нэгдсэн зорилго бүхий, өөрийн гэсэн дүрэмтэй хэд хэдэн этгээдүүдийн үүсгэн байгуулсан байнгын шинжтэй байгууллагын нэгдэл.	- Ашгийн төлөө бус- үйл ажиллагааны үндсэн зорилго нь ашиг олох, арилжаа хийх бус, шүүхийн харьяалал бүхий нутаг дэвсгэрийнхээ хүрээнд хууль ёсны дагуу бүртгүүлснээр эрх зүйн чадавхыг олж авдаг аливаа холбоог хэлнэ (Amtsgericht). Жишээ нь: Ажил олгогчдын Холбоо, Амбулатори эрүүл мэндийн холбоо, Үл хөдлөх хөрөнгө, газар өмчлөгчдийн холбоо гэх мэт. - Ашгийн төлөө- үйл ажиллагааны үндсэн зорилго нь ашгийн төлөө, холбооны хуулиар тусгайлсан зохицуулалт дутмаг байдгийн улмаас улсын шийдвэрээр эрх зүйн чадавх олж авдаг аливаа холбоог хэлнэ. Энэхүү шийдвэр нь тухайн холбоо байрлаж буй нутаг дэвсгэрийн газрын эрх мэдэлд хамаарна. Жишээ нь: Өр цуглуулагчдын холбоо, Үл хөдлөх хөрөнгийн зах зээл, Албан тушаалтнууд /эвлэлийн гишүүдэд зориулсан худалдааны төв, Хувийн эрүүл мэндийн тооцооны газрууд гэх мэт.
	Сан (Stiftungen)- хуулийн этгээдийн шинжтэй хууль ёсны дагуу эрх зүйн чадавх олж авсан, харьяалах газар нутгийн төрийн захиргааны эрх бүхий байгууллагаар хүлээн зөвшөөрөгдсөн эд хөрөнгийн нэгдлийг хэлнэ.	- Сан нь зөвхөн хөрөнгөөс бүрдэх ба гишүүнгүй байна; сангаас ашиг хүртдэг этгээдүүд ч мөн адил сангийн гишүүн бус мөн түүний нэг хэсэгт тооцогдохгүй. - Сангийн зорилго нь үүсгэн байгуулагчийн хүсэл зоригоос шалтгаалдаг. - Хандивын гүйлгээ хийгдэж, сан байрлах газрын төрийн эрх бүхий байгууллага хүлээн зөвшөөрснөөр сангийн эрх зүйн чадвар үүснэ. - Сан нь тусгайлсан эрх зүйн чадвартай байна.

92 Феликсовна Б.З. Юридические лица: понятие, признаки, виды во Франции. М., 2017. стр.10-11.

93 Steffen Wrttig, Eberhard Zehendner. The Electronic Agent: A Legal Personality under German Law. 2003. https://www.researchgate.net/publication/228978997_The_electronic_agent_a_legal_personality_under_German_Law

	3. Бусад хувийн компани	- Хувьцаат компани: Өр төлбөрийг нэхэмжлэгчдийн өмнө зөвхөн байгууллагын хөрөнгөөр хариуцна. Хувьцаанд хуваагдах зарласан хөрөнгөтэй байна. - Хувьцаагаар хязгаарлагдмал нөхөрлөл: Удирдах зөвлөлдөө хувийн хариуцлага хүлээх гишүүдтэй хувьцаат корпораци. - Хязгаарлагдмал хариуцлагатай компани: Германы хязгаарлагдмал хариуцлагатай компани нь тусдаа бие даасан эрх зүйн чадвартай ашгийн төлөө компани бөгөөд хуулиар зөвшөөрөгдсөн ямар ч зорилгоор байгуулж болно. Хувьцаа эзэмшигчид нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөнд нэг буюу хэд хэдэн хувьцаа эзэмших замаар компанид оролцоно. Тусдаа бие даасан эрх зүйн чадвартай учир компани гуравдагч этгээдтэй хэлцэл хийхэд хувьцаа эзэмшигчид нь гуравдагч этгээдийн өмнө хувиараа хариуцлага хүлээхгүй. - Бүртгэлтэй хоршоо: Эдийн засаг, нийгэм, соёлын хэрэгцээ, хүсэл эрмэлзлээ хамтран эзэмшдэг, ардчилсан удирдлагатай бизнес хийх замаар хангахаар сайн дурын үндсэн дээр нэгдсэн хүмүүсийн өөрөө удирдах холбоо. - Хамтын даатгалын холбоо: харилцан хамаарлын зарчмын үндсэн дээр гишүүдээ даатгалд хамруулах зорилготой, даатгагчдад зориулсан тусгайлсан хуулийн этгээдийн хэлбэр буюу холбоо.
Нийтийн эрх зүйн хуулийн этгээд	1. Гишүүнчлэл бүхий нэгдэл (Körperschaften): гишүүд дээр суурилсан, жишээ нь сүмийн цуглаан, Германы Анагаах ухааны Танхим, мэргэжлийн холбоод гэх мэт	
	2. Албан газар (Anstalten): хэрэглэгч дээр суурилсан, жишээ нь өргөн нэвтрүүлгийн байгууллага, эмнэлэг, нийтийн номын сан, Deutsche Bundesbank	
	3. Нийтийн эрх зүйн сан (Stiftungen): хүмүүсийн нэгдэл байхгүй, зөвхөн хөрөнгө	

ХБНГУ-ын хууль тогтоомжид хуулийн этгээдийг хувийн ба нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэсэн үндсэн хоёр төрөлд хуваан авч үзээд нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн ангилал дотор гишүүнчлэл бүхий нэгдэл, албан газар, нийтийн эрх зүйн санг багтаан хуульчилжээ. Монгол Улсын хууль тогтоомжтой харьцуулахад “сан” гэх ойлголтыг нарийвчлан зохицуулж, нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээд гэх ялгаатай ойлголтыг төрөлжүүлэн ангилж, нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг илүү системчлэн тусгасан байна.

4. Япон Улсын хуулийн этгээдийн төрөл, бүртгэл

Япон Улсад хуулийн этгээдийг 1896 оны Иргэний хуульд тодорхойлсон. Тус хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсэгт “Эрдэм шинжилгээний, урлагийн, буяны, тахилгын, шашны болон бусад олон нийтийн эрх ашгийн төлөөх хуулийн этгээд, үйлдвэр аж ахуй эрхлэх зорилго бүхий хуулийн этгээд болон бусад хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, бүтэц зохион байгуулалтыг нь тодорхойлох, үйл

ажиллагаа эрхлэх, эрхлэн хамгаалахыг тус ба бусад хуульд заасны дагуу явуулна”⁹⁴ гэжээ.

Хүснэгт 15. Япон улсын хуулийн этгээдийн төрөл

1. Ашгийн төлөө бус хуулийн этгээд	1. Нийтийн ашиг сонирхлын хуулийн этгээд ИХ-ийн 34 дүгээр зүйлд Эрдэм шинжилгээний аливаа үйл ажиллагаа, урлаг, буяны үйлс, тахилга, шашин шүтлэг, нийтийн ашиг сонирхолд хамаарах ашгийн төлөө бус аливаа холбоо, санг төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр хуулийн этгээдээр байгуулж болно.	• Холбоо. • Сан
Ашгийн төлөө хуулийн этгээд	3.Компани Япон Улсын Компанийн тухай хуульд ⁹⁵ Компанийн 4 төрөл байхаар хуульчилсан бөгөөд Компани нь хуулийн этгээд байна ⁹⁶ гэж тодорхойлжээ. Мөн уг хуулиар нийтийн өмчит компани хэмээх ойлголтыг тодорхойлж өгсөн байна.	• Хувьцаат компани-“Кабушики-Кайша” • Ерөнхий түншлэлийн компани-“Гомэй-Кайша”, • Хязгаарлагдмал түншлэлийн компани-“Гоуши-Кайша” • Хязгаарлагдмал хариуцлагатай компани-“Гоуду-Кайша”
	4.Нөхөрлөл Япон улсын хууль тогтоомжоор Иргэний хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан нөхөрлөл, Худалдааны хуулийн дагуу үүссэн нөхөрлөл, Хөрөнгө оруулалтын хязгаарлагдмал нөхөрлөлийн тухай хуулийн дагуу үүссэн хязгаарлагдмал нөхөрлөл болон хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл зэрэг хэлбэрийг хүлээн зөвшөөрч байна	• Кумиай (partnership) • Кумиай гэж нэрлэгддэг бизнесийн холбоо нь тусдаа хуулийн этгээдийн чадваргүй тул аж ахуйн нэгжийн хувьд бизнес эрхлэх боломжгүй.⁹⁷ Хэдийгээр Кумиай нь Худалдааны тухай хуулиар бус Иргэний хуулийн дагуу байгуулагддаг боловч хэд хэдэн чиглэлээр Арилжааны хуульд захирагддаг ба Кумиайг олон талаараа АНУ-ын нөхөрлөлийн нийтлэг эрх зүйн үзэл баримтлалтай харьцуулах боломжтой.⁹⁸ • Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл • Хувь хүн эсвэл хуулийн этгээд хөрөнгө оруулахаар тохиролцсон үед Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн гэрээ («Түншлэлийн гэрээ») нь хүчин төгөлдөр болох талаар хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл ийн тухай хуульд⁹⁹ тусгажээ. Өөрөөр хэлбэл хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл нь нөхөрлөлийн хэлбэр болж байна.

94 Б.Урангоо, Япон улсын иргэний хуулийн орчуулга. Ерөнхий үндэслэл, 2016, 15-16 дахь тал.

95 Companies Act of Japan (Part I, Part II, Part III and Part IV) Law number: Act No. 86 of 2005, Article 6.2, <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=2035&vm=04&re=02>

96 Companies Act of Japan (Part I, Part II, Part III and Part IV) Law number: Act No. 86 of 2005, Article 3, <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=2035&vm=04&re=02>,

97 The Civil Code (Law No. 89, 27 April 1896) English: EHS No. 2100 II(FA-FAA), Art. 667-688.

98 Scott K. Goldsmith, Japanese business entities, Case Western Journal of International Law, Volume 6, Issue 2, Article 7, p.275.

99 Limited Liability Partnership Act - Act No. 40 of 2005, Article 3.1 <http://www.asianlii.org/jp/legis/laws/lpaan40o2005376/>

		• Anonymous partnership (silent partnership) • Хэлэлцээрийн эхний тал нь хоёр дахь талын бизнест хувь нэмрээ оруулах, хоёр дахь тал нь өөрийн бизнесээс олсон ашгийг эхний этгээдэд хуваарилах амлалт өгснөөр дуугүй нөхөрлөлийн гэрээ хүчин төгөлдөр болно.¹⁰⁰ Дуугүй тал нь идэвхтэй үүрэг гүйцэтгэдэггүй бөгөөд зөвхөн хувь нэмэр оруулах үүрэгтэй.
		• Хөрөнгө оруулалтын хязгаарлагдмал нөхөрлөл Энэ хуульд ашигласан «хөрөнгө оруулалтын хязгаарлагдмал нөхөрлөл» гэсэн нэр томьёо нь... хөрөнгө оруулалтын хязгаарлагдмал нөхөрлөлийн гэрээний дагуу хязгаарлагдмал биш хариуцлагатай тал болон хязгаарлагдмал хариуцлагатай талуудаас байгуулагдсан нөхөрлөлийг хэлнэ.¹⁰¹
Бусад	2.Гадаадын хуулийн этгээд ИХ. 36 дугаар зүйл: Үндэсний засгийн газар, үндэсний засаг захиргааны нэгж, аливаа арилжааны хуулийн этгээд (корпораци)-аас бусад нь гадаадын хуулийн этгээд (корпораци) байгуулахыг зөвшөөрдөггүй. Гэхдээ энэ нь хууль тогтоомж, гэрээгээр зөвшөөрөгдсөн гадаадын хуулийн этгээд (корпораци)-д хамаарахгүй.	

Үүнээс харахад шашны байгууллага, эрдэм шинжилгээний болон урлагийн зэрэг байгууллага нь ашгийн төлөө бус холбоо буюу сангийн хэлбэрээр үүсгэн байгуулагдаж болохоор байна. Харин эдгээр холбоо, сангийн хэлбэрээр үүсгэн байгуулагдаагүй аливаа этгээд өөрийн нэрэндээ «үүсгэн байгуулагдсан “холбоо» эсвэл «үүсгэн байгуулагдсан сан» гэсэн үг эсвэл эдгээртэй андуурч болзошгүй бусад нэрийг ашиглаж болохгүй¹⁰² гэж нэр ашиглах хязгаарлалт хийж өгчээ. Япон улсад мөн Төрийн бус байгууллага нь хуулийн этгээдийн статусыг авч болохоор¹⁰³ байгаа нь сонирхол татаж байна.

Хөрөнгө оруулалтын хязгаарлагдмал нөхөрлөлийн тухай хуулиар мөн аж ахуй нэгж (enterprise) гэсэн ойлголтыг тодорхойлсон. Үүний дагуу аж ахуй нэгж гэсэн нэр томьёо нь хуулийн этгээд (гадаадын хуулийн этгээдээс бусад) эсвэл бизнес эрхэлж буй хувь хүнийг хэлнэ¹⁰⁴ гэж заажээ. Япон улсын хууль тогтоомжуудаас харвал “Энэ хуулийн дагуу шашны бүлгүүд хуулийн этгээд болж болно¹⁰⁵, Японы банк бол

100 Commercial Code, Book 2 Ch.4 Article 535

http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=02&id=2735 ,

101 Limited Partnership Act for Investment, Law number: Act No. 90 of 1998, Article 2.2.

<http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=3822&vm=2&re=>

102 The Civil Code, Act No. 89 of April 27, 1896, Article 35,

<http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?printID=&id=2057&re=02&vm=02>

103 Specified Nonprofit Activity Promotion Law (Act No. 7 of 1998) Chapter 4, Article 70 A,

<https://elaws.e-gov.go.jp/document?lawid=410AC1000000007>

<https://www.jnpoc.ne.jp/en/nonprofits-in-japan/legal-framework/>

104 Мөн тэнд, Article 2.1.

105 Religious Corporations Act, Law number: Act No. 126 of 1951, Article 4.1,

<http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?ft=1&re=2&dn=1&x=43&y=15&co=01&ia=03&ja=04&ky=%E5%AE%97%E6%95%99%E6%B3%95%E4%BA%BA%E6%B3%95&page=1>

хуулийн этгээд юм.”¹⁰⁶ зэргээр байгууллагууд нь хууль тус бүрээр хуулийн этгээдийн статусыг олж авч байгаа бөгөөд улсын бүртгэлд бүртгүүлэхдээ мөн л хуульд заасан хуулийн этгээдүүдийг бүртгэж байна. Жишээлбэл Худалдааны бүртгэлийн тухай хуульд Иргэний хуульд заасан компаниудыг бүртгэхээр заажээ. Үүнд:

6 дугаар зүйл.Бүртгэлийн алба нь дараах төрлийн арилжааны бүртгэлийг хөтөлнө. Үүнд:

- (i) худалдааны нэрийн бүртгэл;
- (ii) насанд хүрээгүйн бүртгэл;
- (iii) асран хамгаалагчийн бүртгэл;
- (iv) менежерийн бүртгэл;
- (v) хувьцаат компанийн бүртгэл;
- (vi) ерөнхий түншлэлийн компанийн бүртгэл;
- (vii) хязгаарлагдмал түншлэлийн компанийн бүртгэл;
- (viii) хязгаарлагдмал хариуцлагатай компанийн бүртгэл;
- (ix) гадаадын компанийн бүртгэл.

Үүнээс үзвэл Япон улс хуулийн этгээд гэсэн нэр томъёоны тодорхойлолт хийгээгүй тул хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульгүй байна.

Япон улс нь төрийн өмчийн талаар авч үзэхдээ Монгол Улсаас ялгаатай нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль гэж нэгтгэж зохицуулаагүй бөгөөд Төрийн өмчийн тухай хууль¹⁰⁷, Орон нутгийн нийтийн өмчит аж ахуй нэгжийн тухай хууль¹⁰⁸ зэрэг бие даасан тусдаа хуулиудаар төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг ялгаж зохицуулахын зэрэгцээ өмчийн тухай хуульдаа зөвхөн өмчийн ангилал, харилцааг, аж ахуй нэгж, хуулийн этгээдийн тухай хуульдаа тэдгээрийн үйл ажиллагааны талаар л зохицуулж байгааг харж болно.

Орон нутгийн нийтийн өмчит аж ахуй нэгжийн тухай хуульд “орон нутгийн төрийн байгууллагын удирдаж буй аж ахуйн нэгжүүдийн дундах дараах аж ахуйн нэгжид (үүнд хамаарах аж ахуйн нэгж, цаашид «орон нутгийн нийтийн аж ахуйн нэгж» гэх) хамаарна.” гэж заасан. Үүнд:

- 1. ус хангамжийн төсөл (усан хангамжийн системийн жижиг бизнесээс бусад);
- 2. Үйлдвэрлэлийн усан хангамжийн бизнес;
- 3. замын бизнес;
- 4. автомат машин тээврийн бизнес;
- 5. төмөр замын аж ахуйн нэгж;
- 6. цахилгаан эрчим хүчний бизнес;

106 Bank of Japan Act, Law number: Act No. 89 of 1997, Article 6 <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=3788&vm=02&re=01>

107 National Property Law (Act No. 73 of 1952), <https://elaws.e-gov.go.jp/document?lawid=323AC0000000073>

108 Local Public Enterprise Law (Act No. 292 of 1952), https://elaws.e-gov.go.jp/document?lawid=327AC0000000292_20191214_501AC0000000037&keyword=%E5%9C%B0%E6%96%B9%E5%85%AC%E5%96%B6%E4%BC%81%E6%A5%AD%E6%B3%95document?lawid=327AC0000000292_20191214_501AC0000000037&keyword=%E5%9C%B0%E6%96%B9%E5%85%AC%E5%96%B6%E4%BC%81%E6%A5%AD%E6%B3%95

7. хийн бизнес зэргийг тусгажээ.

Өөрөөр хэлбэл үйл ажиллагаанаас нь хамаарсан ангиллын хүрээнд орон нутгийн нийтийн өмчит аж ахуйн нэгж хариуцсан үйл ажиллагааг тодруулж хуулийн хамрах хүрээг мөн үйл ажиллагаагаар нь тодорхойлжээ. Гэсэн ч энэхүү хуульд хуулийн этгээдтэй холбогдох заалтыг тусгаагүй байна.

Дүгнэвэл,

Монгол Улсын хууль тогтоомж дахь хуулийн этгээдийн ойлголтын талаар судлахдаа хэд хэдэн улсын жишээн дээр харьцуулан судалж үзлээ. Хуулийн этгээдийг үйл ажиллагааны зорилго, үндсэн чиглэлээс хамаарч ашгийн болон ашгийн бус хэмээн ангилах нь улс бүрд нийтлэг байгаа бол харин хуулийн этгээдийг хувийн болон нийтийн эрх зүйн хуулийн этгээд хэмээн төрөлжүүлэн ангилах практик ХБНГУ болон БНФУ-ын жишээн дээр харагдаж байна. Эдгээр улсууд нь хуулийн этгээдийн ойлголтыг нарийвчлан зохицуулж, нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээд гэх ялгаатай ойлголтыг төрөлжүүлэн ангилж, нийтийн эрх зүйн хуулийн этгээд болон түүний доторх бусад ойлголтуудыг илүү тусгайлан зохицуулсан нь авууштай тал юм.

ДҮГНЭЛТ

1. Хуулийн этгээдийн тухай хийсвэрлэх онолын дагуу хуулийн этгээд нь эрх, үүрэг эдлэх боломжтой хийсвэр этгээд байх бөгөөд эрх зүйн чадамжгүй, харин эрх зүйн чадвартай байна. Харин бусад онолын дагуу хуулийн этгээд нь тодорхой зорилгод үйлчилдэг, амьдрал дээр бодитойгоор орших байгууллага юм.
2. “Хуулийн этгээдийн эрх зүйн чадавх” гэж манайд судлагдаагүй ухагдахуун байх бөгөөд хүнээс бусад этгээд (байгууллага, амьтан, хиймэл оюун ухаан)-ийг хуулийн этгээд мөн эсэхийг тодорхойлдог томоохон шалгуур тул дэлгэрүүлэн судлах шаардлагатай байна. ОХУ-ын зарим судлаачид хуулийн этгээдийн эрх зүйн чадавх нь эрх зүйн чадвар болон чадамжаас бүрддэг гэж үзжээ. Тус ухагдахууныг дэлгэрүүлэн судалснаар хуулийн этгээдийн мөн чанарыг ойлгох, оновчтой төрөлжүүлэн ангилахад ач холбогдолтой болно.
3. Манай улсад хуулийн этгээд гэх ойлголт анх 1952 оны Иргэний хуулиар бий болсон бөгөөд нэр томъёоны хувьд орос хэлний “юридическое лицо” гэснийг орчуулсан хууль зүйн нэр томъёо байх боломжтой байна.
4. 1963 оны Иргэний хуульд хуулийн этгээдийг байгууллага гэж үзсэн бөгөөд үүнд төрийн байгууллага болон бусад төрийн өмчит үйлдвэр, бусад байгууллага хамаарч байжээ. Харин 1994 оны Иргэний хуулиар хуулийн этгээдийг үүсгэн байгуулагч буюу оролцогчийг тусгайлсан эд хөрөнгийн тухайд эрх, үүргээ хадгалдаг болон хадгалдаггүй гэж хувааснаас гадна шашны байгууллага, олон нийтийн байгууллага, бусад буяны сан нь хуулийн этгээдэд хамаарч байжээ. Харин 2002 оны Иргэний хуулиар олон нийтийн байгууллага, шашны байгууллагыг хуулийн этгээдийн төрөлд хамааруулаагүй байна.
5. 2002 оны Иргэний хуульд хуулийн этгээдийг “иргэний эрх зүйн чадвар”-тай гэж үзсэнээр түүнийг гагцхүү иргэний эрх зүйн харилцааны субъект болох үүднээс ойлгох, хэрэглэх нөхцөл бий болжээ. Хуулийн этгээдийн эрх зүйн чадварыг тодорхойлсон эх сурвалж, судалгааны бүтээл тун цөөхөн байгаа бол бусад улсад хуулийн этгээдийг эрх зүйн чадвартай, эрх зүйн чадамжтай гэж үздэг байна. Хуулийн этгээдийн эрх зүйн чадамж нь хууль болон үүсгэн байгуулах баримт бичигт заасны дагуу хуулийн этгээд бодитойгоор байгууллагаа байгуулсан үеэс үүснэ хэмээн тайлбарладаг байна.
6. Кельзен хуулийн этгээдийг чөлөөт хүсэл зоригтой гэж үзсэн бол бусад судлаачид хуулийн этгээд өөрийн гэсэн ухамсар, хүсэл зориггүй гэж тайлбарладаг байна. Хуулийн этгээдийн бусад шинжийг Монгол Улсын Иргэний хуульд тодорхой заасан бөгөөд хуулийн этгээд нь эрх зүйн харилцааны субъект болохын хувьд өргөн агуулгатай ойлголт байна.
7. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиар Иргэний хуулийн 33 дугаар зүйлд заасан хуулийн этгээдийн таван төрлөөс гадна төрийн бус байгууллага, шашны байгууллага, нийтийн эрх зүйн хуулийн этгээд, төрийн байгууллага, албан газар, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар зэргийг хуулийн этгээд гэж бүртгэж байна.

Ингэхдээ ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төрөл болох сан, холбоог, түүнчлэн хуучин хуулийн этгээдийн нэг төрөлд хамаарч байсан шашны байгууллагыг төрийн бус байгууллагаар бүртгэж байгаа буруу практик тогтжээ.

8. Төрийн бус байгууллага болон олон нийтийн байгууллага гэсэн нэр томьёогоор ойролцоо утгатай (эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөө хэрэгжүүлэхээр нэгдсэн бүлэг хүмүүс) боловч үүслээрээ ялгаатай ойлголт байна. Олон нийтийн байгууллага нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан нэр томьёо бөгөөд хуулийн этгээдээс өргөн агуулгатай ойлголт байх тул цаашид төрийн бус байгууллага бус олон нийтийн байгууллага гэсэн нэр томьёог хэрэглэх нь оновчтой гэж үзэж байна.
9. Төрийн бус байгууллага нь ашгийн төлөө бус байгууллага байдаг ч ашгийн төлөө бус хуулийн этгээд болгон төрийн бус байгууллага биш юм. Ийнхүү хуулийн этгээдийн нэг төрөлд хамааруулах эсэх нь тухайн улсын сонголт байдаг ч манай улсын хувьд төрийн бус байгууллагыг хуулийн этгээд гэж үзэх шаардлагагүй байна. Иймд бүртгэлийн давхардал, зөрчилдөөнийг цэгцлэхээс гадна төрийн бус байгууллагын хяналтгүйгээр аж ахуйн үйл ажиллагаа явуулан мөнгө угаах арга хэрэгсэл болж буй асуудлыг шийдвэрлэх шаардлагатай юм.
10. Иргэний хуульд заасан холбооноос гадна зарим хуулиар мэргэжлийн холбоо гэсэн нэр томьёог өргөн хэрэглэж байна. Монголын Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, Монголын телевизүүдийн холбоог нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэж хуулиар тодорхойлсон хэдий ч эдгээр холбоо нь мэргэжлийн холбоонд хамаарахаар байгаа тул зөрчилдөөн үүсч байна.
11. 2021 оны 11 дүгээр сард Улсын Их Хуралд өргөн баригдсан Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зарим заалтад дүн шинжилгээ хийж үзэхэд мэргэжлийн холбоог нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээдийн эрх, үүргийг эдлэх холбоо гэж тодорхойлж, холбоог төрийн бус байгууллагатай адилтгаж, төрийн бус байгууллага гэх нэр томьёог хэрэглээгүй байна. Уг хуулийн төслөөр хуулийн этгээдийг нийтийн болон хувийн гэж хуваах алхам хийсэн боловч мэргэжлийн холбоо нь тэдгээрийн аль алинд хамаарахаар зохицуулсан нь өрөөсгөл юм. Учир нь нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээдийн шинж, ялгааг тодорхойлж, уг асуудал дээр нэгдсэн байр сууринд хүрээгүй атлаа мэргэжлийн холбооний эдлэх эрх, үүргийг ийнхүү бүрхэг томьёолсон нь асуудлыг шийдвэрлэх ач холбогдолгүй байна. Түүнчлэн холбоог төрөөс хараат бус байх зарчмыг заасан хэрнээ гэрээний үндсэн дээр төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх боломж олгосныг дахин нягтлах шаардлагатай гэж үзлээ.
12. Сангийн эрх зүйн байдлыг зохицуулсан бие даасан хууль байхгүйгээс болж хөрөнгийн нэгдэл бүхий хуулийн этгээдийн төрлийг зохицуулж буй хэм хэмжээ хийдэлтэй байна. Мөн Засгийн газрын тусгай сан, төрийн сангууд нь Иргэний хуулийн сан, нийтийн эрх зүйн хуулийн этгээд, төрийн өмчит хуулийн этгээдийн алинд хамаарах нь тодорхойгүй байна.
13. Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийн зарим зүйл, заалтад дүн шинжилгээ хийхэд санг аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж болохоор заажээ.

Ингэснээр сангаар дамжуулан мөнгө угаах нөхцөлийг бүрдүүлэх эрсдэлтэй юм. Түүнчлэн Засгийн газрын тусгай сан, төрийн санг тус хуулийн төслөөр зохицуулахгүй тул тэдгээр нь төрийн өмчит хуулийн этгээд үү, нийтийн эрх зүйн хуулийн этгээд үү гэсэн асуулт хэвээр үлдэж байна.

14. Нийтийн эрх зүйн хуулийн этгээд нь Герман, Францаас үүсэлтэй ойлголт бөгөөд төр өөрийн байгууллагаар дамжуулан өмчийн харилцаанд оролцох шаардлагаас анх үүссэн гэж үзэж болохоор байна. Төрийг нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэж үзэхгүй ч төрийн байгууллага, албан газар, зарим сан, төрийн засаглах чиг үүргийг хэрэгжүүлэх ашгийн төлөө бус байгууллагыг нийтийн эрх зүйн хуулийн этгээд гэж үзэх боломжтой байна.
15. Монгол Улсын хувьд Иргэний хуульд нийтийн эрх зүйн этгээдийн эрх зүйн чадварын талаар заасан боловч бусад хууль тогтоомжоор нийтийн эрх зүйн этгээд гэсэн нэр томъёо зэрэгцэн оршиж байх тул тэдгээрийн ижил болон ялгаатай шинжийг задлан шинжлэх шаардлагатай байна. Хэрэв нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг хүлээн зөвшөөрөх тохиолдолд нөгөө талд нь хувийн эрх зүйн хуулийн этгээд байх шаардлага үүснэ. Ийнхүү хуулийн этгээдийн улсын бүртгэлд төрийн байгууллага, албан газар зэрэг нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд хамаарах байгууллагыг тусдаа бүртгэх тохиолдолд “нийтийн эрх зүйн хуулийн этгээд” гэж бүртгэхгүйгээр түүнд хамааруулан ойлгоход л хангалттай байна.
16. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулиас бусад хууль тогтоомжоор хуулийн этгээдийн төрөлд хамааруулаагүй боловч хуулийн этгээд эсэх нь тодорхойгүй олон байгууллагыг зохицуулжээ. Тухайлбал, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит компани, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж гэсэн ялгамжтай, олон нэр томъёо байна. Эдгээрийг нийтэд нь төрийн болон орон нутгийн өмчит этгээд гэсэн нэршил дор судлаачид бичиж байгаа хэдий ч хоорондоо ялгамжтай эрх зүйн зохицуулалт шаарддаг олон байгууллагыг хамруулан замбараагүй хэрэглэж буй асуудлыг цэгцлэх шаардлагатай юм.
17. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь нийтийн эрх зүйн хуулийн этгээдтэй ямар харилцаа холбоотой болох нь тодорхойгүй байна. Хувийн болон нийтийн эрх зүйн салбарын судлаач, эрдэмтэд хүртэл өөр өөр байр суурьтай байгаагаас болж уг асуудлыг нэг мөр болгоход бэрхшээлтэй байна.
18. Ийнхүү Иргэний хуульд заагаагүй хуулийн этгээдийн төрлүүд бусад хууль тогтоомжоор бий болсон боловч хоорондоо уялдаа холбоогүй байгаа нь тэдгээр хууль тогтоомж хийдэл, зөрчилтэй байгааг илэрхийлж байна.

Иймд эдгээр асуудлыг цэгцлэхэд нэмэр болох дараах зөвлөмжийг боловсрууллаа.

ЗӨВЛӨМЖ

1. Хуулийн этгээдийг эрх зүйн харилцааны субъектынх нь хувьд ойлгож, нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээд гэж ангилах шаардлага бий болжээ. Үүний тулд хуулийн этгээдийн эрх зүйн чадвар, чадамж, тэдгээрийг багтаасан “legal personality” гэх ойлголтыг нарийвчлан судлах шаардлагатай байна.
2. Ийнхүү хуваахын тулд нийтийн эрх зүйн этгээдийг дэлгэрүүлэн судалж, нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс өргөн ойлголт мөн эсэхийг тодорхойлж, өөр агуулгатай тохиолдолд өөр нэр томьёогоор илэрхийлэх хэрэгтэй юм. Учир нь эрх зүйн этгээд гэж хүний эрх зүйн байдлыг илтгэх ойлголт бөгөөд урд нь “нийтийн” гэж тодотгосноор уг нэр томьёоны агуулга бүрэн дүүрэн илэрхийлэгдэхгүй байна. Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн шинжийг тодорхой болгосны үндсэн дээр бусад улс орны жишгээр Захиргааны ерөнхий хуулиар тусгайлан зохицуулах боломжтой юм. Мөн нийтийн эрх зүйн хуулийн этгээд захиргааны эрх зүйн чадавхтай эсэхийг тодруулах шаардлагатай.
3. Төрийн болон орон нутгийн өмчит этгээдүүдийн олон янз байгууллагыг хооронд нь уялдуулж, онцлогт нь тааруулсан зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төслийг боловсруулах явцад төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг нийтийн эрх зүйн хуулийн этгээдтэй уялдуулах, үйлдвэрийн газар, албан газар, төрийн өмчит компанийг нэг малгай дор хийхээс илүүтэйгээр тус бүрд нь тохирсон зохицуулалтыг бий болгож, хуулийн этгээдийн ойлголт, ангиллыг шинээр эргэцүүлэн шийдэл гаргахад анхаарах нь зүйтэй.
4. Хуулийн этгээдийг хэдийгээр англи хэлэнд “legal person”, “legal entity”, “juridical person”, “juridical entity”, “fictitious person” гэж нэрлэдэг ч “corporation” гэж англо-саксоны эрх зүйн бүлийн орнуудын хуулийн этгээд болохыг санаж, харьцуулсан судалгаа хийхдээ корпораци гэж монгол хэлэнд хуулийн этгээдийг буулгахгүй байхад анхаарах шаардлагатай.
5. Нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг англи хэлэнд “public legal entity”, “legal entity of public law”, “public corporation”, “legal entity with public participation” гэж олон янзаар хэлдэг ч “publicly traded company”, “public company”, “legal entity of public interest”, “public interest company” гэсэн өөр утгатай нэр томьёотой андуурахгүй байх нь зүйтэй. Жишээ нь, “public company” болон “publicly traded company” гэх нэр томьёо бол хувийн эрх зүйн томоохон компанийг илэрхийлэх англо-саксоны эрх зүйн бүлийн орнуудад байдаг ухагдахуун юм. Харин “legal entity of public interest”, “public interest company” гэж төрийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийг илэрхийлсэн нэр томьёо байна.
6. Ийнхүү цаашид дэлгэрүүлэн судалгаа хийхэд эрх зүйн бүлээс хамааран хуулийн этгээдийн ойлголт, ангилал, тэдгээрийг илэрхийлсэн нэр томьёо өөр болохыг анхааралдаа авч, өөрийн орны онцлогт тохируулан хуулийн этгээдийг оновчтой тодорхойлох, төрөлжүүлэн ангилах, зөрүүтэй ойлголтуудыг жигдлэх шаардлагатай юм.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль (1992)
2. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний хууль (1952)
3. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Иргэний хууль (1963)
4. Монгол Улсын Иргэний хууль (1994)
5. Газрын хэвлийн тухай хууль (1988)
6. Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль (1991)
7. Өмч хувьчлах тухай хууль (1991)
8. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль (1993)
9. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль (1994)
10. Эрдэсийн сангийн тухай хууль (1994)
11. Нөхөрлөлийн тухай хууль (1995)
12. Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995)
13. Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль (1995)
14. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль (1995)
15. Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль (1995)
16. Төв банк /Монголбанк/-ны тухай хууль (1996)
17. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль (1996)
18. Орон сууц хувьчлах тухай хууль (1996)
19. Соёлын тухай хууль (1996)
20. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль (1997)
21. Дампуурлын тухай хууль (1997)
22. Төрийн бус байгууллагын тухай хууль (1997)
23. Дайчилгааны тухай хууль (1998)
24. Аялал жуулчлалын тухай хууль (2000)
25. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль (2000)
26. Ажиллах хүч, гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль (2001)
27. Харилцаа холбооны тухай хууль (2001)
28. Иргэний хууль (2002)
29. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2002)
30. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль (2002)
31. Зар сурталчилгааны тухай хууль (2002)
32. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002)
33. Боловсролын тухай хууль (2002)

34. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль (2003)
35. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль (2003)
36. Даатгалын тухай хууль (2004)
37. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль (2004)
38. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьчилан сэргийлэх тухай хууль (2004)
39. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль (2005)
40. Тамхины хяналтын тухай хууль (2005)
41. Авлигын эсрэг хууль (2006)
42. Ашигт малтмалын тухай хууль (2006)
43. Гаалийн тухай хууль (2008)
44. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль (2009)
45. Банкны тухай хууль (2010)
46. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль (2010)
47. Компанийн тухай хууль (2011)
48. Нотариатын тухай хууль (2011)
49. Эрүүл мэндийн тухай хууль (2011)
50. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль (2011)
51. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011)
52. Төсвийн тухай хууль (2011)
53. Жолоочийн даатгалын тухай хууль (2011)
54. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль (2011)
55. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (2011)
56. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2011)
57. Нийгмийн халамжийн тухай хууль (2012)
58. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль (2012)
59. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль (2012)
60. Инновацийн тухай хууль (2012)
61. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)
62. Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль (2012)
63. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль (2013)
64. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль (2013)
65. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (2013)
66. Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль (2013)
67. Номын сангийн тухай хууль (2014)
68. Соёлын өвийг хамгаалах тухай хууль (2014)
69. Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль (2014)

70. Эрүүгийн хууль (2015)
71. Захиргааны ерөнхий хууль (2015)
72. Галын аюулгүй байдлын тухай хууль (2015)
73. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль (2015)
74. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (2015)
75. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016)
76. Ард нийтийн санал асуулгын тухай хууль (2016)
77. Барилгын тухай хууль (2016)
78. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2016)
79. Ирээдүйн өв сангийн тухай хууль (2016)
80. Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль (2016)
81. Ахмад настны тухай хууль (2017)
82. Арбитрын тухай хууль (2017)
83. Авто замын тухай хууль (2017)
84. Биеийн тамир, спортын тухай хууль (2017)
85. Гамшгаас хамгаалах тухай хууль (2017)
86. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль (2017)
87. Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль (2017)
88. Зөрчлийн тухай хууль (2017)
89. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (2017)
90. Монгол Улсын хөгжлийн банкны тухай хууль (2017)
91. Малын генетик нөөцийн тухай хууль (2017)
92. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль (2017)
93. Төрийн албаны тухай хууль (2017)
94. Хог хаягдлын тухай хууль (2017)
95. Үндэсний төлбөрийн системийн тухай хууль (2017)
96. Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хууль (2018)
97. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль (2018)
98. Донорын тухай хууль (2018)
99. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль (2019)
100. Өмгөөллийн тухай хууль (2019)
101. Өргөн нэвтрүүлгийн тухай хууль (2019)
102. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (2019)
103. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль (2019)
104. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль (2019)
105. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль (2020)
106. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль (2020)
107. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (2020)

108. Оюуны өмчийн тухай хууль (2020)
109. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль (2021)
110. Патентийн тухай хууль (2021)
111. Хоршооны тухай хууль (2021)
112. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (2021)
113. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль (2021)
114. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль (2021)
115. Кино урлагийг дэмжих тухай хууль (2021)
116. Хөдөлмөрийн тухай хууль (2021)
117. НҮБ-ын дүрэм (1945)
118. Улс болон гадаад иргэний хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенц (1965)
119. Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
120. Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл

Сурах бичиг, гарын авлага

1. Г.Совд, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2000
2. Д.Баярсайхан, Эрх зүйн онол, 1996
3. Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн удиртгал, 2012
4. О.Жамбалдорж, Монгол Улсын Иргэний эрх зүй ерөнхий үндэслэл, I дэвтэр 2004
5. Э.Байгаль, Иргэний эрх зүйн ерөнхий анги, 2009
6. Б.Тэмүүлэн, Д.Энхзүл, Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн ерөнхий анги. Анхны хэвлэл, 2010
7. Б.Урангоо, Япон улсын иргэний хуулийн орчуулга. Ерөнхий үндэслэл, 2016
8. Анатолий Коструба. Теория юридического лица: Интегративный подход. Учреждение образования Гродненский Государственный Университет имени Янки Купалы. Проблемы гражданского права и процесса. 2020.

Эрдэм шинжилгээний өгүүлэл

1. Elvia Arcelia Quintana Adriano. Natural persons, juridical persons and legal personhood. Mexican Law Review, Vol.VIII, No.1. p.104
2. A Theory of Legal Personhood. Visa Kurki.A.J. 2019. Oxford University
3. Scott K. Goldsmith, Japanese business entities, Case Western Journal of International Law, Volume 6, Issue 2, Article 7
4. Aaron Broches, Selected Essays, World Bank, ICSID, and other Subjects of Public and Private International Law (Martinus Nijhoff Publishers 1995)
5. Kenneth C. Cole. The Theory of the State as a Sovereign Juristic Person. The American Political Science Review. Vol.42, No.1, 1948
6. Steffen Wrttig, Eberhard Zehendner. The Electronic Agent: A Legal Personality

under German Law. 2003

7. Соломонов.Е.В. Виды юридических лиц: новое в гражданском законодательстве. Вестник Омского университета. Серия "Право". 2015. №1 (42)
8. Гордеева Ж.А. Правоспособность и правосубъектность: к вопросу о содержании и соотношении понятий.
9. Сулейменов М.К., Карагузов Ф.С., Кот А.А., Дуйсенова А.Е., Скрыбин С.В. О понятии и правовом статусе юридических лиц публичного права в законодательстве некоторых развитых иностранных государствах и бывших советских республиках.
10. В.Е.Чиркин. Юридическое лицо публичного права.

Судалгааны ажил, нэг сэдэвт бүтээл

1. С.Нарангэрэл, Монгол Улсын хууль зүйн нэвтэрхий толь бичиг. 2021
2. Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: нийтлэг үндэслэл. Нэгдүгээр дэвтэр. 2004
3. Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал: хүний эрх, шүүх эрх мэдэл. Хоёрдугаар дэвтэр. 2004
4. Б.Чимид, Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс (Ихэс дээдэс, хүн бүрт хандсан дөрвөн өчил). 2006
5. Хууль зүйн үндэсний хүрээлэн. Төрийн бус байгууллагад төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр шилжүүлэх нь: харьцуулсан судалгаа. 2013
6. Хуулийн нөхөрлөл "Өмгөөллийн ивээл баг", "Орон нутгийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд орон нутгийн өмчийн төрөл, ангилал, зохион байгуулалтын талаарх судалгааны тайлан", УБ., 2021
7. Т.Мөнхжаргал, Монгол, БНХАУ-ын Иргэний хуулийн харьцуулсан судалгаа. 2011
8. Иргэдэд туслах хүний эрхийн төв ТББ. Ашгийн бус байгууллагын талаарх Монгол Улсын эрх зүйн зохицуулалт. Эрх зүйн дүн шинжилгээ. 2018
9. Н.Баярмаа, Нийтийн эд юмсын эрх зүй: Монгол Улс дахь Төрийн болон орон нутгийн өмчийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам. 2018
10. Н.Баярмаа, Төрийн нийтийн өмч: Газар ба үл хөдлөх эд хөрөнгө, газрын хэвлийн баялаг ба хувьцаа. 2021
11. Баасанжав Консалтинг ХХК, Төрийн бус байгууллагын тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагын тандан судалгаа. 2017
12. Феликсовна Б.З. Юридические лица: понятие, признаки, виды во Франции. М., 2017. стр.10-11

Цахим эх сурвалж

1. <https://adilet.zan.kz/eng/docs/Z1100000413>
2. <http://www.consultant.ru/>
3. www.oxford.universitypressscholarship.com
4. <https://www.1212.mn/>

5. <https://languages.oup.com/google-dictionary-en/>
6. https://elaws.e-gov.go.jp/document?lawid=327AC0000000292_20191214_501AC0000000037&keyword=%E5%9C%B0%E6%96%B9%E5%85%AC%E5%96%B6%E4%BC%81%E6%A5%AD%E6%B3%95
7. <https://elaws.e-gov.go.jp/document?lawid=323AC0000000073>
8. <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=3788&vm=02&re=01>
9. <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?ft=1&re=2&dn=1&x=43&y=15&co=01&ia=03&ja=04&ky=%E5%AE%97%E6%95%99%E6%B3%95%E4%BA%BA%E6%B3%95&page=1>
10. <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=3822&vm=2&re>
11. http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=02&id=2735
12. <http://www.asianlii.org/jp/legis/laws/lpaan40o2005376/>
13. <https://www.jnpoc.ne.jp/en/nonprofits-in-japan/legal-framework/>
14. <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=2035&vm=04&re=02>
15. https://miit.ru/content/гражд+и+торг+право.pdf?id_vf=14346
16. <http://forum.parliament.mn/>
17. <https://www.gdrc.org/ngo/peter-willets.html#one>
18. <https://www.humanrightscareers.com/issues/types-of-ngos/>
19. <https://www.state.gov/non-governmental-organizations-ngos-in-the-united-states/>
20. <https://www.legislationline.org/documents/action/popup/id/8082>
21. <https://ikon.mn/n/2dtf?fbclid=IwAR2adhMYsbi8kRCZ3i2KVdcOvG16Hv9AIMHQVYNIf9yGey93eeRhEIOPxLg>
22. <https://doi.org/10.2307/1949458>
23. <https://cyberleninka.ru/article/n/yuridicheskoe-litso-publichnogo-prava/viewer>
24. https://www.researchgate.net/publication/228978997_The_electronic_agent_a_legal_personality_under_German_Law

ХАВСРАЛТ**Хавсралт 1.**

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬ (1952)
ГУРАВДУГААР БҮЛЭГ ХУУЛИЙН ЭТГЭЭД
13. Биеэ дааж эд хөрөнгөний эрхийг олж чадах, үүрэг авах, түүнээ хариуцах ба өөрийн эрхийн тухай шүүхэд маргаж чадах хүмүүсийн нэгдэл, албан газар ба байгууллага бол хуулийн этгээдүүд болно. 14. Хуулийн этгээд бол хуулиар тогтоосон журмаар батлагдсан буюу бүртгэгдсэн тусгай дүрэм буюу хуультай байх ёстой. Хуулийн этгээдийн эрх эдлэх явдал нь уул хуулийг баталсан буюу дүрмийг бүртгэсэн үеэс эхэлнэ. Хуулийн этгээд нь иргэний гүйлгээнд өөрийн төлөөлөгч нараар дамжуулан оролцоно. 15. Хэрэв хуулийн этгээд нь өөрийн хууль буюу дүрмээрээ биелүүлэхээс зайлсхийх буюу улсын ашиг тустай харшилбал зохих газруудаас түүний ажиллагааг хориглон зогсоож болно. 16. Төсвийн журмаар санхүүжихгүй бөгөөд аж ахуйн тооцоон дээр ажиллах улсын үйлдвэрүүд ба тэдгээрийн нэгдлүүд нь иргэний гүйлгээнд биеэ даасан хэжлийн этгээдийн адилаар ба үндсэн хөрөнгөнд холбогдолгүй оролцоно. Тэдгээр байгууллагууд бол өөрийн өрийг ганцхан өөрийн мэдэлд байгаа бөгөөд иргэний гүйлгээнээс хасагдаагүй эд хөрөнгөөр хариуцна.

Хавсралт 2.

БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬ (1963)
ХОЁРДУГААР БҮЛЭГ ИРГЭН БА ХУУЛИЙН ЭТГЭЭД 2. Хуулийн этгээд
18 дугаар зүйл. Хуулийн этгээдийн тухай Өөртөө тусгайлсан эзэмшсэн эд хөрөнгөтэй, өөрийн нэрийн өмнөөс эд хөрөнгийн ба түүнтэй холбоотой эд хөрөнгийн бус эрх олох, үүрэг бий болгож чадах, мөн шүүх, арбитрын газар нэхэмжлэгч, хариуцагч байж чадах байгууллагыг хуулийн этгээд гэнэ.
19 дүгээр зүйл. Хуулийн этгээд болох улс, хоршоолол, олон нийтийн байгууллага Хуулийн этгээд нь: Аж ахуйн тооцооны үндсэн дээр ажилладаг, өөртөө үндсэн ба эргэлт хөрөнгөтэй, биеэ даасан баланстай улсын үйлдвэр, бусад байгууллага; Улсаас санхүүждэг, биеэ даасан төсөвтэй, дарга эрх баригчид нь /хуулиар хязгаарласнаас бусдаар/ уул төсвийг захиран зарцуулах эрхтэй улсын албан байгууллага; Хөдөө аж ахуйн нэгдэл, үйлдвэр хоршооллын ба олон нийтийн бусад байгууллага, түүнчлэн хууль буюу эдгээр байгууллагын дүрэмд заасан бол тэдгээрийн харьяа биеэ даасан төсөв, баланс бүхий үйлдвэр, албан байгууллага, улс, хоршооллын дундын байгууллага. Хэрэв тус улсын хуульд заасан бол энэ зүйлд дурдсан улсын төсөвтэй байгууллага хуулийн этгээдийн хувиар бус харин БНМАУ-ын нэрийн өмнөөс ажиллаж болно.
22 дугаар зүйл. Хуулийн этгээдийн байгууллага Хуулийн этгээд иргэний эрх олгох, үүрэг гүйцэтгэхдээ хууль, дүрэмд заасан эрх хэмжээний дотор ажиллаж байгаа өөрийн байгууллагаар дамжуулан гүйцэтгэнэ. Хуулийн этгээдийн байгууллагыг томилох буюу сонгох явдлыг дүрэмд зааснаар гүйцэтгэнэ.

24 дугаар зүйл. Хуулийн этгээдийн хүлээх хариуцлага
Хуулийн этгээд хүлээсэн үүргийнхээ талаар зохих хариуцлагыг өөртөө байгаа бөгөөд /улсын байгууллага бол өөрт нь олгосон/ хууль ёсоор төлбөр гаргуулж болох эд хөрөнгөөр хариуцна.
Хуулийн этгээд болох улсын байгууллагын гүйцэтгэвэл зохих үүргийг улс хариуцахгүй, түүнчлэн улсын гүйцэтгэвэл зохих үүргийг эдгээр байгууллага хариуцахгүй. Хэрэв улсын төсөвтэй байгууллагын төсөвт хөрөнгө үүргээ гүйцэтгэхэд нь хүрэлцэхгүй бол шаардагдах хөрөнгийг нөхөн олгох нөхцөл, журмыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл тогтооно.
Улс, хоршоолол, олон нийтийн байгууллага нь хууль буюу гэрээ, түүнчлэн тэдгээр байгууллагын дүрэмд зааснаас өөрөөр хуулийн этгээд болох доод байгууллагынхаа гүйцэтгэвэл зохих үүргийг хариуцахгүй. Хэрэв хуульд тусгайлан заагаагүй бол хуулийн этгээд болох доод байгууллага нь дээд байгууллагынхаа гүйцэтгэвэл зохих үүргийг хариуцахгүй.
Хоршоолол, олон нийтийн байгууллага гишүүдийнхээ хүлээсэн үүргийг, гишүүд нь эдгээр байгууллагын хүлээсэн үүргийг хариуцахгүй.
Эдгээр байгууллагын хүлээсэн үүргийн талаар төлбөр гаргуулахдаа түүний хувь нийлүүлсэн хөрөнгөөс гаргуулж болохгүй.

Хавсралт 3.

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬ (1994)	
ХОЁРДУГААР БҮЛЭГ	
Иргэн ба хуулийн этгээд	
21 дүгээр зүйл. Хуулийн этгээд	Өмчлөх буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан эд хөрөнгөтэй; өөрийн үйл ажиллагаагаараа эрх олж, үүрэг бий болгох чадвартай; үйл ажиллагаанаасаа үүсэн гарах үүргийг эд хөрөнгөөрөө хариуцдаг; шүүх арбитрад өөрийн нэрийн өмнөөс оролцдог байгууллагыг хуулийн этгээд гэнэ. Хуулийн этгээд нь ашиг олох үндсэн зорилготой ба ашгийн төлөө, хууль буюу дүрэмд заасан өөр зорилготой ба ашгийн төлөө бус байж болно. Хуулийн этгээдийн тусгайлсан эд хөрөнгийн хувьд түүний үүсгэн байгуулагч буюу оролцогч нь эд хөрөнгийн эрх, үүргээ хадгалдаг буюу хадгалдаггүй байхаар хуулиар тогтоож болно. Үүсгэн байгуулагч буюу оролцогч нь тусгайлсан эд хөрөнгийн тухайд эрх, үүргээ хадгалдаг хуулийн этгээдэд компани, нөхөрлөл, хоршоо, түүнчлэн өмчлөгчөөс санхүүждэг байгууллага хамаарна. Үүсгэн байгуулагч буюу оролцогч нь тухайн хуулийн этгээдийн тусгайлсан эд хөрөнгийн хувьд эд хөрөнгийн эрхээ хадгалдаггүй хуулийн этгээдэд олон нийтийн, шашны байгууллага, буяны болон бусад зорилгоор байгуулагдсан сан хамаарна.
22 дугаар зүйл. Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн эрхийн чадвар	Хуулийн этгээд нь үүсгэн байгуулах баримт бичигт заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцсэн эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Хуулийн этгээд нь үйл ажиллагааныхаа зорилгод харшлаагүй бөгөөд хууль тогтоомжоор хориглоогүй аливаа үйл ажиллагааг явуулж болно. Хуулийн этгээд нь хуульд заасан зарим үйл ажиллагааг гагцхүү эрх бүхий байгууллагын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр явуулна. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу хуулийн этгээдийн эрхийг хязгаарлаж болно.
23 дугаар зүйл. Хуулийн этгээд байгуулах, үүсгэн байгуулах баримт бичиг	Хуулийн этгээдийг иргэн, төр, түүнээс эрх олгосон байгууллага, түүнчлэн хуульд заасан бол бусад хуулийн этгээд, гадаад улсын иргэн, байгууллага, харьяалалгүй хүн хуульд заасан журмын дагуу үүсгэн байгуулж болно. Хуулийн этгээдийг байгуулахад үүсгэн байгуулах баримт бичгийг бүрдүүлэх ба түүний төрөл, хэлбэр, бүрдүүлэх журмыг хуулиар тогтооно. Хуулийн этгээдийг үүсгэн байгуулах баримт бичиг нь эрх бүхий байгууллагын шийдвэр, дүрэм, үүсгэн байгуулах тухай гэрээ байж болно. Хуулийн этгээдийн дүрмийг түүний үүсгэн байгуулагч /оролцогч/, эсхүл түүнээс эрх олгогдсон байгууллага батална. 6. Хуульд заасан бол хуулийн этгээдийг үүсгэн байгуулах тухай гэрээ байгуулна. 8. Хуульд заасан бол хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэнэ.
25 дугаар зүйл. Хуулийн этгээдийн байгууллага	Хуулийн этгээд нь байгууллагаараа дамжуулан иргэний эрх зүйн харилцаанд оролцоно. Хуулийн этгээдийн байгууллагын эрх зүйн байдлыг хууль буюу үүсгэн байгуулах баримт бичгээр тодорхойлно.

32 дугаар зүйл. Компани

Гишүүд /хувьцаа эзэмшигчид/-ийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх дүрмийн сантай, хүлээсэн үүргээ өөрийн хөрөнгөөр хариуцдаг, гишүүн нь гагцхүү дүрмийн санд оруулсан хөрөнгийнхөө хэмжээгээр хариуцлага хүлээдэг хуулийн этгээдийг компани гэнэ.

Компани нь ганц гишүүнтэй байж болно.

Дүрмийн сан нь үүсгэн байгуулах баримт бичигт дурдсан хэмжээний ногдол хувьд хуваагддаг, гишүүн нь бусад гишүүний ногдол хувь эзэмших эрхийг тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхтэй компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани гэнэ. Гишүүнд ногдол хувь эзэмших эрхийн гэрчилгээ олгоно. Дүрмийн сан нь нэг бүрийн нэрлэсэн үнэ бүхий тодорхой тооны хувьцаанд хуваагддаг хувьцаа эзэмшигчид нь хувьцаагаа нийтэд чөлөөтэй худалддаг, эсхүл хувьцаа эзэмшигч нь бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхтэй компанийг хувьцаат компани гэнэ.

Компанийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

33 дугаар зүйл. Нөхөрлөл

Гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бүрдэх эд хөрөнгөтэй, хүлээсэн үүргээ энэхүү эд хөрөнгө болон гишүүдийн хувийн өмчийн эд хөрөнгөөр хуульд заасны дагуу хариуцлаг хуулийн этгээдийг нөхөрлөл гэнэ.

Нөхөрлөлийн эд хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд бүх гишүүд нь хувийн өмчийн эд хөрөнгөөр нөхөрлөлийн хүлээсэн үүргийг хамтран хариуцдаг нөхөрлөлийг бүрэн хариуцлагатай нөхөрлөл гэнэ. Нөхөрлөлийн эд хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд наад зах нь нэг гишүүн хувийн өмчийн эд хөрөнгөөр нөхөрлөлийн хүлээсэн үүргийг бүрэн /бүрэн хариуцлагатай гишүүн/ хариуцдаг нөхөрлөлийг бүрэн бус хариуцлагатай нөхөрлөл гэнэ. Нөхөрлөлийн бусад гишүүд нь бүрэн бус хариуцлагатай байна.

Нөхөрлөлийн өөр хэлбэрийг хуулиар тодорхойлж болно.

Нөхөрлөлийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

34 дүгээр зүйл. Хоршоо

Материаллаг болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хувь хүмүүс сайн дураараа нэгдсэн, ардчилсан удирдлага, хяналт бүхий, хамтран өмчлөх дундын эд хөрөнгө дээр үндэслэн аж ахуй эрхлэх хуулийн этгээдийг хоршоо гэнэ.

Хоршоод аж ахуйн үйл ажиллагаа хамтран эрхлэх зорилгоор дундын хоршоо байгуулж болно.

Хариуцлагын хэмжээ болон олсон орлогыг гишүүдэд хуваарилах журмыг үүсгэн байгуулах баримт бичигт заана.

Хоршооны эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.

35 дугаар зүйл. Хуулийн этгээдийн нэгдэл

Хуульд өөрөөр заагаагүй бол компани, нөхөрлөл, хоршоо нь үйл ажиллагаагаа зохицуулах зорилгоор нэгдэж болно.

Нэгдлийг ашгийн төлөө, эсхүл ашгийн төлөө бус байгууллагын хэлбэрээр байгуулна.

Олон нийтийн болон шашны байгууллага, сан нь гагцхүү ашгийн төлөө бус байгууллагын хэлбэрээр нэгдэл байгуулж болно.

Нэгдлийн оролцогчид хуулийн этгээдийн эрхээ хадгална.

36 дугаар зүйл. Олон нийтийн болон шашны байгууллага, сан

Оюуны, материаллаг болон материаллаг бус бусад ашиг сонирхлоо хамгаалах зорилгоор сайн дурын үндсэн дээр нэгдсэн иргэд, хуулийн этгээдийн нэгдлийг олон нийтийн байгууллага гэнэ.

Сүсэгтэн олны шашны зан үйл, хурал ном, боловсролын хэрэгцээг хангах зорилго бүхий байгууллагыг шашны байгууллага гэнэ.

Нийгэм, соёл, боловсрол, буяны болон нийтэд тустай бусад зорилгоор сайн дурын хандив, тусламж төвлөрүүлж, гагцхүү дүрэмдээ заасан зориулалтын дагуу захиран зарцуулах эрх бүхий сайн дурын, гишүүнчлэлгүй байгууллагыг сан гэнэ.

Олон нийтийн болон шашны байгууллага, сан нь ашгийн төлөө бус байна.

Олон нийтийн болон шашны байгууллага, сангийн эрх зүйн байдлыг хуулиар тодорхойлно.

37 дугаар зүйл. Төр болон аймаг, нийслэл, сум, дүүрэг, иргэний эрх зүйн харилцаанд оролцох

Төрийн хувьд төрийн эрх барих дээд байгууллага; аймаг, нийслэл, сум, дүүргийн хувьд тэдгээрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ хуульд заасан иргэний эрх, үүргийг хэрэгжүүлнэ. Хууль буюу гэрээнд зааснаар тэдгээр нь иргэний эрх, үүргээ хэрэгжүүлэх эрхийг бусдад шилжүүлж болно.

Хавсралт 4.

Албан газар			
№	Хууль	Бүлэг	Залт
1	Банкны тухай хууль	Тавдугаар дэд бүлэг Банкийг татан буулгах	68.6.Банкны эрх хүлээн авагч нь банкны эрх хүлээн авагч томилогдсон хугацаа, банк хадгаламжийн үйл ажиллагаа явуулахгүй тухай болон банкны эрх хүлээн авагчаас шаардлагатай гэж үзсэн бусад асуудлыг тусгасан банкныг татан буулгах тухай шийдвэрийг тухайн банкны бүх салбар, албан газарт нэн даруй байршуулж, олон нийтэд мэдээлнэ.
2	Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай	Гуравдугаар бүлэг. Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох	13.2.1.мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах зорилгоор сурталчилгаа, ухуулга хийх, эсхүл ийм зорилгоор албан газар нээх, ажиллуулах;
3	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай	Дөрөвдүгээр бүлэг. Засаг дарга, түүний бүрэн эрх	28.1.Баг, хорооны Засаг дарга харьяалах нутаг дэвсгэртээ дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 28.1.19.нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, албан газар...
4	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай	Зургаадугаар бүлэг. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын үйл ажиллагааны баталгаа	40.3.Засаг захиргааны тухайн нэгжид үйл ажиллагаа явуулдаг бөгөөд дээд шатны байгууллагад харьяалагддаг аж ахуйн нэгж, албан газар...
5	Статистикийн тухай	Хоёрдугаар бүлэг. Статистикийн мэдээллийн тогтолцоо	3.Албан ёсны статистикийн мэдээллийг Үндэсний статистикийн хороо, яам, төрийн бусад албан газар, бүх шатны Засаг дарга эрхлэн гаргана.
6	Статистикийн тухай	Хоёрдугаар бүлэг. Статистикийн мэдээллийн тогтолцоо	6.2.Мөнгө, зээл, санхүү, гааль, татвар, байгаль орчин, соёл, урлаг, боловсрол, шинжлэх ухаан техник, технологи, хүн амын эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хүнсний аюулгүй байдал, шүүхийн статистикийн мэдээллийг холбогдох яам, төрийн бусад албан газар тус тус эрхлэн гаргаж, Үндэсний статистикийн хороонд өгнө.
7	Статистикийн тухай	Тавдугаар бүлэг. Төрийн гүйцэтгэх байгууллагын статистикийн үйл ажиллагааны талаархи бүрэн эрх	18 дугаар зүйл. Яам, төрийн бусад албан газар, бүх шатны Засаг дарга статистикийн мэдээллийн талаар дараахь нийтлэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
8	Статистикийн тухай	Тавдугаар бүлэг. Төрийн гүйцэтгэх байгууллагын статистикийн үйл ажиллагааны талаархи бүрэн эрх	19 дүгээр зүйл. Яам, төрийн бусад албан газар энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
9	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай	Хоёрдугаар бүлэг. Төрийн өмчийн зүйлс	5.1.Төрийн өөрийн өмчид энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад төр эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулж болох дараахь эд хөрөнгө хамаарна: 1/ төрийн байгууллага, албан газарт эзэмшүүлсэн эд хөрөнгө;

10	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай	Дөрөвдүгээр бүлэг. Төрийн өмчит хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх	13 дугаар зүйл. Төр чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаараа байгуулсан хуулийн этгээдийг төрийн өмчит хуулийн этгээд гэнэ. Төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь дор дурдсанаар ангилна: 1/ төрийн байгууллага, албан газар; 14 дүгээр зүйл 1.Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар гэнэ. 2.Төрийн байгууллага, албан газар төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараахь эрх, үүрэгтэй: 17 дугаар зүйл. 1. Улсын төсөвт үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан төрийн байгууллага, албан газартай нэгэн адил эрхтэй.
11	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай	Хоёрдугаар бүлэг. Улсын бүртгэлийн байгууллага, түүний чиг үүрэг	7 дугаар зүйл. 7.1.Улсын бүртгэлийн байгууллага дараах хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэнэ: ... 7.1.8.төрийн байгууллага, албан газар;...
12	Хөрөнгө оруулалтын тухай	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	4 дүгээр зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ 4.5.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу төрийн байгууллага, албан газарт улсын болон орон нутгийн төсвөөс хийх хөрөнгө оруулалтад энэ хууль хамаарахгүй.

Хавсралт 5.

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд			
№	Хууль	Бүлэг	Заалт
1	Төсвийн тухай хууль	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	3.1.Энэ хууль нь төсвийн байгууллага, түүний албан тушаалтан, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сан, төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлдэг болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хамаарна. 4.1.34."төсвийн байгууллага" гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг; 8.9.8.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

2	Төсвийн тухай хууль	Дөрөвдүгээр бүлэг. Төсвийн бүтэц	23.3.Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээслэсний орлого, торгуулийн орлого, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ. 25.1.2.төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авах тусламж, хандив. 25.4.Төсвийн байгууллага төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан дараах тохиолдолд төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгө, хөдлөх эд хөрөнгийн хэлбэрээр тусламж, хандив авч болно: 25.9.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон орон нутгийн өмчит бус хуулийн этгээд татвар ногдуулсны дараах ашгаас хандив, тусламж өгнө. 25.10.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно.
3	Төсвийн тухай хууль	Тавдугаар бүлэг. Төсвийн төсөл боловсруулах өргөн мэдүүлэх батлах	32.2.10.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төсөвт төлөх ногдол ашгийн хэмжээ;
4	Төсвийн тухай хууль	Зургаадугаар бүлэг. Төсвийн хэрэгжилт, гүйцэтгэл	43.1.5.төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан тусламж, хандив. 47.1.Төсвийн захирагч нь дараах нэмэлт төсвийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болно: 47.1.1.төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж;
5	Төсвийн тухай хууль	Долдугаар бүлэг. Өмч хөрөнгө, болзошгүй өмч хөрөнгө болзошгүй өр төлбөр	52.6.2.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн өр;

Хавсралт 6.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж			
№	Хууль	Бүлэг	Заалт
1	Төсвийн тухай хууль	Дөрөвдүгээр бүлэг. Төсвийн бүтэц	24.2.Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн өөрөө санхүүжүүлснээс бусад хэлбэрээр төрийн болон орон нутгийн өмч бий болгох, худалдан авах, хуулийн этгээд үүсгэн байгуулах зардал, хувь оролцоо, дүрмийн санд оруулсан хөрөнгө, түүнтэй холбогдсон бүх төрлийн санхүүгийн хэрэгсэл нь тухайн шатны төсвийн зарлага байна.

Хавсралт 7.

Төрийн өмчит компани			
№	Хууль	Бүлэг	Заалт
1	Зөрчлийн тухай	Арван тавдугаар бүлэг. Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааны эсрэг зөрчил	15.30 дугаар зүйл. ...төрийн өмчит компани, олон улсын байгууллагын дарга, захирлын албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд нь нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд нээлттэй тендер шалгаруулалтаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд ... болсон бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2	Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай		5 дугаар зүйл. 5.5.Тэтгэврийн зээлийг төлөхтэй холбоотойгоор энэ хуулийн 5.1-д заасан төрийн өмчит компани зээл авах болон үнэт цаас гаргахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 16 дахь хэсэгт заасан зөвшөөрлийг авахгүй.
3	Компанийн тухай	Нэгдүгээр бүлэг.	2 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ 2.6.Энэ хуулийн 2.5-д заасны дагуу үүссэн төрийн өмчит компанийн хувьд өмчлөгч нь төрийг төлөөлж Улсын Их Хурал, орон нутгийн өмчит компанийн хувьд тухайн орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байх бөгөөд тэдгээрийг төлөөлж хувьцаа эзэмшигч нь Засгийн газар болон орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас эрх олгосон этгээд байж болно.
4	Компанийн тухай	Компани байгуулах	12.5.2.төрийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн байгуулах замаар үүссэн төрийн өмчит компанийн;
5	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай	Гуравдугаар бүлэг. Албан тушаалтанд тавигдах хориглолт хязгаарлалт	...төрийн өмчит компани, олон улсын байгууллагын дарга, захирлын албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд нээлттэй тендер шалгаруулалтаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд ...хувиараа аж ахуй эрхлэгч байж болохгүй.

Хавсралт 8.

Төрийн болон орон нутгийн өмчит компани			
№	Хууль	Бүлэг	Заалт
1	Компанийн тухай хууль	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	2.5.Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн зохион байгуулах замаар үүссэн төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулна.
2	Компанийн тухай хууль	Есдүгээр бүлэг. Компанийн удирдлдага	79.4.Төрийн болон орон нутгийн өмчит компани, 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн энэ хуулийн 76.1, 79.3-т зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй:

Хавсралт 9.

Төрийн өмчит хувьцаат компани			
№	Хууль	Бүлэг	Заалт
1	Монгол Улсын 2014 оны төсвийн тухай	Хоёрдугаар бүлэг. Монгол Улсын 2014 оны төсвийн орлого, зарлага болон хөрөнгө өрийн удирдлага	3 дугаар зүйл. Монгол Улсын төсөвт 2014 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг доор дурдсанаар баталсугай: Монголын төмөр зам төрийн өмчит хувьцаат компани
2	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай	Гуравдугаар бүлэг. Хөгжлийн бодлого, төлөвлөлийн тогтолцоо, оролцогчдын эрх, үүрэг	8.2.Энэ хуулийн 8.1-д зааснаас бусад төрийн захиргааны байгууллага, шинжлэх ухааны төв байгууллага, төрийн өмчит хувьцаат компани, сан, Хөгжлийн банк, төрийн гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг эрхлэн гүйцэтгэгчид, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн байгууллагууд болон хувийн хэвшлийн хуулийн этгээд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд оролцоно.

Хавсралт 10.

Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар			
№	Хууль	Бүлэг	Заалт
1	Дампуурлын тухай хууль	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	3.1.2."хариуцагч" гэж тусгай зориулалтын компани, орон сууцны санхүүжилтийн компаниас бусад төлбөрийн чадваргүй болсон нөхөрлөл, хоршоо, компани, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, хуулийн этгээдийн эрх бүхий төрийн бус байгууллагыг;
2	Дампуурлын тухай хууль	Хоёрдугаар бүлэг. Дампуурлын хэрэг үүсгэх	16.1.Засгийн газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төлбөрийн чадваргүй болсон төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын өр, төлбөрийг төлөх тухай баталгааг нэхэмжлэгчдийн анхны хурлаас өмнө шүүхэд гаргаж болно.
3	Компанийн тухай хууль	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	2.3.Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг хувьчлах замаар байгуулагдсан компанийн үйл ажиллагааг энэ хуулиар, түүнийг үүсгэн байгуулахтай холбогдсон харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулна.
4	Компанийн тухай хууль	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	2.5.Төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрт оруулан өөрчлөн зохион байгуулах замаар үүссэн төрийн болон орон нутгийн өмчит компанийн үйл ажиллагааг энэ хуулиар зохицуулна.
5	Компанийн тухай хууль	Гуравдугаар бүлэг. Компани байгуулах	12.5.Төр, түүний байгууллага нь дараах тохиолдолд компанийн үүсгэн байгуулагч болон түүний хувьцаа эзэмшигч байж болно: 12.5.1.төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг хувьчилснаар шинээр бий болсон компанийн;
6	Концессын тухай хууль	Хоёрдугаар бүлэг. Концессын талаар төрийн нутгийн захиргааны болон нутгын өөрөө удирдах байгууллын бүрэн эрх	8.2.Төрийн, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь концесс эзэмшигчид шилжүүлсэн концессын зүйлийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх, шинэчлэн сайжруулах эрх буюу үүрэг хүлээхгүй бөгөөд концесс эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр концессын зүйлтэй холбогдсон зээлийн гэрээ, эсхүл барьцааны гэрээ байгуулахыг хориглоно.

Хавсралт 11.

Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар			
№	Хууль	Бүлэг	Заалт
1	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай	Зургаадугаар бүлэг. Худалдан авах ажиллагааны удирдлага	45.7.Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, хил хамгаалах, онцгой байдлын байгууллага, цагдаа, дотоодын цэрэг, хорих байгууллагын тусгай хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээг тухайн салбарын төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар гүйцэтгүүлэх... нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхгүй байж болно.
2	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	4.1.1.“аж ахуйн нэгж” гэж улсын бүртгэлд бүртгэгдэж, аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа компани, нөхөрлөл, хоршоо, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, тэдгээртэй адилтгах орлогын албан татвар төлөх үүрэг бүхий хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй этгээд болон үндсэн үйл ажиллагаа нь ашгийн бус боловч бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлж орлого олсон дотоод, гадаадын хуулийн этгээдийг;
3	Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	3.2.Төрийн бус байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой компани, улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой газар, гадаад улсын хуулийн этгээд энэ хуулийн зохицуулалтад хамаарахгүй.
4	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай	Дөрөвдүгээр бүлэг. Төрийн өмчит хуулийн этгээд, түүний эд хөрөнгийн эрх Тавдугаар бүлэг. Төрийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах журам	15 дугаар зүйл. Төрийн өмчит үйлдвэрийн газрын ангилал 1.Төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орох бөгөөд тэдгээрийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж ангилна: 2.Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ. 16 дугаар зүйл. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх 1. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар дараахь эрх, үүрэгтэй:..... 2. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар үндсэн хөрөнгийг зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр данснаас хасах буюу борлуулах, устгах эрхтэй. 18 дугаар зүйл. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиргаа 1.Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана. Захирлыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, зохих салбар, хүрээний яам, агентлагтай зөвшилцөн томилох буюу өөрчилнө. 5. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиргааны албан тушаалын жагсаалт, орон тооны нормативыг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтооно.

4			19 дүгээр зүйл. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиралтай байгуулах гэрээ Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг / цаашид «захирал» гэх/ томилохдоо гэрээ байгуулна. Гэрээнд дараахь нөхцөлийг тусгана. 24 дүгээр зүйл. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар өөрийн чиг, үүрэг зорилтыг ...Сангийн ямааар зардлын дээд хязгаарыг батлуулна. 25 дугаар зүйл. 3. Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газраас бүтээгдэхүүн, ажил үйлчилгээндээ ... гэж үзвэл Засгийн газраас хянаж, өөрчлүүлэх тухай шийдвэр гаргаж болно.
5	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай	Хоёрдугаар бүлэг. Улсын бүртгэлийн байгууллага, түүний чиг үүрэг	7.1.Улсын бүртгэлийн байгууллага дараах хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэнэ: 7.1.10.аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар.

Хавсралт 12.

Олон нийтийн байгууллага			
№	Хууль	Бүлэг	Заалт
1	Байгаль орчныг хамгаалах тухай	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	4 дүгээр зүйл.Байгаль орчныг хамгаалах талаархи иргэний эрх, үүрэг 1.Иргэн байгаль орчныг хамгаалах талаар дараахь эрхийг эдэлнэ: ...3/байгаль орчныг хамгаалах олон нийтийн байгууллага байгуулах, хөрөнгийн сан үүсгэх нутгийн иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгалийн баялгийг арчлан хамгаалах, нөхөн сэргээх, түүний ашиг шимийг хүртэх;
2	Байгаль орчныг хамгаалах тухай	Зургаадугаар бүлэг. Байгаль орчин, байгалийн баялгийг хамгаалах талаархи аж ахуйн нэгж байгууллагын үүрэг	32 дугаар зүйл.Байгаль орчныг хамгаалахад төрийн бус байгууллага оролцох 1.Байгаль орчин, түүний баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий олон нийтийн байгууллага болон байгалийн нөөцийн хамтын менежмент эрхлэн явуулах нөхөрлөл байгаль орчныг хамгаалах талаар дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлж болно:
3	Газрын хэвлийн тухай /энэ хуулийн гарчигт 1994 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан	Долдугаар бүлэг. Газрын хэвлийг хамгаалах	44 дүгээр зүйл.Газрын хэвлийг хамгаалах, ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэхэд олон нийтийн байгууллага, хөдөлмөрийн хамт олон, иргэдийн оролцоо 1.Олон нийтийн байгууллага, хөдөлмөрийн хамт олон нь хууль тогтоомж, дүрмийнхээ дагуу газрын хэвлийг хамгаалах, зохистой ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцож, төрийн байгууллагад тус дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.
4	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай	Гуравдугаар бүлэг. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт Дөрөвдүгээр бүлэг. Жендэрийн эрх тэгш байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн талаархи гомдлыг хянан шийдвэрлэх	22.1.Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад олон нийтийн байгууллага дараахь оролцоотой байна:.... 23.2.Энэ хуулиар баталгаажуулсан жендэрийн эрх тэгш байдлыг хангах, мөн эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагыг аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан зөрчсөн гэж үзвэл үйлдвэрчний эвлэлийн болон бусад олон нийтийн байгууллага гомдол гаргах эрхтэй.

5	Монгол Улсын засгийн газрын тухай	Хоёрдугаар бүлэг. Засгийн газрын бүрэн эрх	7 дугаар зүйл.Хуулийн биелэлтийг зохион байгуулж хангах талаархи Засгийн газрын бүрэн эрх 5.Нам, олон нийтийн байгууллага, хувийн өмчийн аж ахуйн нэгж хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хуулиар олгосон эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина. 6.Шаардлагатай бол нам, олон нийтийн байгууллага, хувийн өмчийн аж ахуйн нэгжийн удирдлагын хүсэлтийг үндэслэн тэдгээрийн мэдээллийг хэлэлцэж болно. 9 дүгээр зүйл.Нийгмийн хөгжлийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хүн амын нийгмийн хамгаалалтын талаархи Засгийн газрын бүрэн эрх 4.Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлнэ. Хууль тогтоомжид заасны дагуу хүн амын эрүүл мэндийг хамгаалах ажилд улс, олон нийтийн байгууллага, иргэдийн хүчийг нэгтгэн зохион байгуулна. 11 дүгээр зүйл.Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах талаархи Засгийн газрын бүрэн эрх
6	Нийслэлийн рэх зүйн байдлын тухай	Хоёрдугаар бүлэг. Нийслэлийн удирдлага Гуравдугаар бүлэг. Нийслэлийн удирдлага, иргэд байгууллагын хоорондын харилцаа	7 дугаар зүйл. Удирдлагын үйл ажиллагааны үндсэн зарчим ...3. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, засаг дарга, үйл ажиллагаандаа иргэдийн санал бодол, нутаг дэвсгэртээ ажиллаж буй төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, сүм хийд, буяны болон сайн санааны байгууллага, олон түмний идэвх оролцсонд тулгуурлах зарчмыг баримтална. 12 дугаар зүйл. Төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгжээс нийслэлийн өмнө хүлээх үүрэг Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж нь өмчийн хэлбэрээр үл хамааран нийслэлийн өмнө дараахь үүрэг хүлээнэ:
7	Инновацийн тухай	Гуравдугаар бүлэг. Инновацийн үйл ажиллагаа, төрийн дэмжлэг	17 дугаар зүйл. Инновацийн үйл ажиллагааг төрөөс дэмжих ..1.9.үзэсгэлэн худалдаа, хурал семинар зохион байгуулах, инновацийн мэдлэг, соёлыг сурталчлах арга хэмжээг олон нийтийн байгууллагатай хамтран зохион байгуулах, санхүүжүүлэх;
8	Номын сангийн тухай	Хоёрдугаар бүлэг. Номын сангийн үйл ажиллагаа эрхлэх этгээд, түүний эрх үүрэг	5.5.Номын сангийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь уншлага үйлчилгээний чанарыг сайжруулах, хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэхэд олон нийтийн дэмжлэгийг авах, тэдний зүгээс номын сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах зорилгоор соёл, боловсрол, хүүхэд, залуучуудын болон олон нийтийн байгууллага, иргэдийн төлөөлөл бүхий орон тооны бус номын сангийн зөвлөл ажиллуулж болно.
9	Орон сууц хувьчлах тухай	Гуравдугаар бүлэг. Орон сууц хувьчлах	13 дугаар зүйл. Магадлан шинжлэх хэсэг 2. Магадлан шинжлэх хэсэг нь орон сууцны ашиглалт, дулаан, цахилгаан, эрчим хүч, гал, ариун цэвэр, барилгын техникийн хяналтын эрх бүхий байгууллага болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах олон нийтийн байгууллага, сууц эзэмшигчдийн төлөөлөгчөөс бүрдэнэ.

10	Соёлын тухай	Дөрөвдүгээр бүлэг. Соёлын удирдлага, зохицуулалт	13дүгээр зүйл.Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх 9/соёл, урлагийн мэргэжлийн холбоод, олон нийтийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах, тэдгээрт дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
11	Соёлын өвийг хамгаалах тухай	Зургаадугаар бүлэг. Соёлын өвийг эзэмших, ашиглах, өмчлөх	31 дүгээр зүйл.Соёлын биет өвийг эзэмших 31.1.Нийтийн өмчийн соёлын биет өвийг төрийн болон орон нутгийн, шашны, олон нийтийн байгууллага өмчлөгчийн тогтоосон нөхцөлөөр тус тус эзэмшинэ.
12	Төрийн тусгай хамгаалалтын тухай	Төрийн тусгай хамгаалалтын тухай	11 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалтын газрын эрх, үүрэг 3/хамгаалуулагч, төрийн тусгай хамгаалалтад авсан барилга, бусад зүйлийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор төр, захиргаа, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас хамгаалалтын ажлын нөхцөл байдалтай холбогдох мэдээ, судалгаа гаргуулж авах; 20 дугаар зүйл.Бусад байгууллага, албан тушаалтан, иргэний үүрэг 1.Төрийн захиргааны төв, орон нутгийн болон олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтан төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хүсэлтээр холбогдох мэдээ, судалгаа гарган өгч, шаардлагатай бусад туслалцаа үзүүлнэ.
13	Хөдөлмөрийн тухай	Тавдугаар бүлэг. Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа	44.3.Хуульд өөрөөр заагаагүй бол ажилтны хувийн нууцад хамаарах, эсхүл улс төрийн нам, олон нийтийн байгууллага, үйлдвэрчний эвлэлийн гишүүнчлэлийн талаар мэдээлэл авах, боловсруулах, хадгалахыг хориглоно.
14	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай	Нэгдүгээр бүлэг. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн журам	14 дүгээр зүйл.Хэргийн харьяалал тогтоох Аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны хэргийн харьяаллыг тогтоолгохоор иргэн, албан тушаалтан, төр, олон нийтийн байгууллага Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргавал хэргийн харьяаллыг тогтоож холбогдох шүүхэд шилжүүлнэ.
15	Монгол Улсын үндсэн хууль	Хоёрдугаар бүлэг. Хүний эрх, эрх чөлөө	Арван зургаадугаар зүйл. 10/нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно;
16	Монгол Улсын үндсэн хууль	Дөрөв. Шүүх эрх мэдэл	Дөчин есдүгээр зүйл. 2.Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй.

Хавсралт 13.

Төрийн бус байгууллага			
№	Хууль	Бүлэг	Заалт
1	Төрийн бус байгууллагын тухай хууль	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёо Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 1/"төрийн бус байгууллага" гэж иргэд, төрийн байгууллага /хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага/-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг;
2	Авто замын тухай хууль	Хоёрдугаар бүлэг. Авто замын талаархи төрийн байгууллагын бүрэн эрх	13.1.Авто замын салбарын төрийн бус байгууллага нь авто замын тухай хууль тогтоомж, норм, норматив, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох, төрөөс үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, салбарын мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэжлийн зэрэг олгох, авто замчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж болно.
3	Авлигын эсрэг хууль	Дөрөвдүгээр бүлэг. Авлигатай тэмцэх байгууллага, түүний бүрэн эрх	18.1.4.төрийн бус байгууллага, иргэдээс авлигатай тэмцэх талаар явуулж байгаа үйл ажиллагаа, гаргасан санал, санаачилгыг дэмжин туслах, тэдний оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах; 18.3.Авлигатай тэмцэх газар чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтан өөрийн эрх хэмжээний хүрээнд хамтран ажиллана.
4	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	Гуравдугаар бүлэг. Албан татвар ногдох орлогоос хасагдах зардал	15.1.7.хөгжлийн бэрхшээлтэй Монгол Улсын иргэний үүсгэн байгуулсан төрийн бус байгууллагыг дэмжих зорилгоор өгсөн 10 сая хүртэлх төгрөгийн хандив;
5	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч мэргэжилтэн авах тухай	Хоёрдугаар бүлэг. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах үйл ажиллагааны зохицуулалт	4.1.5.ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах асуудлаар төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, төрийн бус байгууллагын үйл ажиллагааг уялдуулах, гадаадын холбогдох төрийн захиргааны болон төрийн бус байгууллагатай гэрээ байгуулах.
6	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай	Есдүгээр бүлэг. Санал авах, сонгуулийн дүн гаргах	66.1.Орон нутгийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, эсхүл нэр дэвшигч нь нэг санал авах байранд гурав хүртэл, Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн төрийн бус байгууллага нэг санал авах байранд хоёр хүртэл сонгуулийн ажиглагч /цаашид "ажиглагч" гэх/-ийг томилж ажиллуулах эрхтэй.
7	Арбитрын тухай хууль	Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл	7.3.Монгол Улсад байнгын арбитрыг худалдаа, аж үйлдвэрийн танхим, худалдаа үйлдвэрлэгчийн болон хэрэглэгчийн зэрэг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын дэргэд байгуулж болно.

8	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай	Тавдугаар бүлэг. Архивын сан хөмрөгийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт, ашиглалт	28.10.Төрийн байгууллагын үйл ажиллагааны явцад үүссэн архивын баримтыг шашны байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн хуулийн этгээд, хувь хүнд шилжүүлэхийг хориглоно. 28.12.Музей, номын сан болон төрийн бус байгууллага нь төрийн архивын сан хөмрөгт хамаарах эх баримтаар бүрдүүлэлт хийхийг хориглоно.
9	Ард нийтийн санал асуулгын тухай	Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэл	7.6.Улс төрийн нам, төрийн бус байгууллага сонгуулийн төв байгууллагаас баталсан журмын дагуу ухуулга сурталчилгааг өөрийн зардлаар явуулж болно.
10	Ашигт малтмалын тухай	Хоёрдугаар бүлэг. Ашигт малтмалын салбар дахь төрийн зохицуулалт	4.1.26."мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч" гэж үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, геологи, уул уурхайн салбарын төрийн бус байгууллагаас эрх олгогдсон иргэнийг. 10.1.16.геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журмыг батлах; 10.1.18.үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, геологи, уул уурхайн салбарын төрийн бус байгууллагатай хамтран ашигт малтмалын баялаг, ордын нөөц, хайгуулын ажлын үр дүнг нийтэд нээлттэй тайлагнах журмыг батлах.
11	Аялал жуулчлалын тухай	Дөрөвдүгээр бүлэг. Аялал жуулчлалын талаархи төрийн байгууллагын бүрэн эрх	15.3. Зөвлөл нь дарга, улсын төсөв, санхүү, аялал жуулчлал, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон тус бүр нэг, аялал жуулчлал эрхэлсэн төрийн бус байгууллагаас санал болгосон аялал жуулчлалын байгууллагын гурван гишүүнээс тус тус бүрдэнэ.
12	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай	Хоёрдугаар бүлэг. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний бүтэц тогтолцоо, зохицуулалт	9.12.Байгаль орчны менежментийн болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавина.
13	Банкны тухай	Гуравдугаар бүлэг. Банк байгуулах, банкныг өөрчлөн байгуулах	18.1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд /төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд/, төрийн бус байгууллага, тэдгээртэй холбогдох этгээдээс бусад хуулийн этгээд, иргэн банк үүсгэн байгуулж болох бөгөөд энэ нь Засгийн газар банк үүсгэн байгуулахад хамаарахгүй.
14	Байгаль орчныг хамгаалах тухай	Зургаадугаар бүлэг. Байгаль орчин байгалийн баялгийг хамгаалах талаархи аж ахуйн нэгж байгууллагын үүрэг	32 дугаар зүйл.Байгаль орчныг хамгаалахад төрийн бус байгууллага оролцох 2.Засгийн газар байгаль орчныг хамгаалах талаархи төрийн гүйцэтгэх байгууллагын тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр байгаль орчныг хамгаалах дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллагад эсхүл тухайн нутгийн иргэдийн сайн дурын үндсэн дээр нэгдэн байгуулагдсан этгээдэд шилжүүлж, түүний хэрэгжилтийг санхүүжүүлж болно.
15	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай	Хоёрдугаар бүлэг Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх	6.2. Улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээд, шашны болон улс төрийн байгууллага, төрийн бус байгууллага, Иргэний хуулийн 36.2.-т заасан банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

16	Барилгын тухай	Зургаадугаар бүлэг. Барилгын үйл ажиллагаанд оролцогч	36.3.Иргэн, төрийн бус байгууллага барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт санал өгч болно.
17	Биеийн тамир, спортын тухай	Хоёрдугаар бүлэг. Биеийн тамир, спортын талаархи төрийн байгууллагын бүрэн эрх	10 дугаар зүйл.Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх 10.1.12.энэ хуульд заасан өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж, холбогдох зардлыг санхүүжүүлэх;
18	Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай	Хоёрдугаар бүлэг. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалт	7.3.Зөвлөлийн бүрэлдэхүүнд дараахь байгууллагын төлөөллийг оруулж болно: 7.3.2.иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны хамтын ашиг сонирхлыг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллага 8.1.7.тухайн бүсийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэх талаар иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагаас тавьж буй санал, санаачлагыг дэмжин зохион байгуулалтын удирдлагаар хангах;
19	Гаалийн тухай	Нэгдүгээр дэд бүлэг. Гаалийн хяналтыг хэрэгжүүлэх үед хийх магадлан шинжилгээ, шинжилгээ	252.4.Магадлан шинжилгээг мэргэжлийн хувийн өмчийн болон төрийн бус байгууллага, эсхүл бие даасан шинжээчээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болох бөгөөд энэ тохиолдолд магадлан шинжилгээний төлбөрийг мэдүүлэгч хариуцна.
20	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай	Гуравдугаар бүлэг. Төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрх, аж ахуйн нэгж, иргэний үүрэг	9.3.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гадаадын иргэний асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 9.3.5.энэ хуулийн 40.1.5-д заасан олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журам батлах; 40.1.5.олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих;
21	Галын аюулгүй байдлын тухай	Хоёрдугаар бүлэг. Галын аюулгүй байдлыг хангах талаар онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийн тогтолцоо	7 дугаар зүйл.Гал түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа 7.1.Гал түймрээс урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгаа явуулах чиг үүргийг аймаг, нийслэлийн онцгой байдлын байгууллага төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлнэ. 17.1.1.галын аюулгүй байдлыг хангах зорилгоор холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдээс арга зүйн туслалцаа, зааварчилгаа, зөвлөгөө авах;
22	Гамшгаас хамгаалах тухай	Тавдугаар бүлэг Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, удирдлага	27.1.3.гамшгаас хамгаалах алба, орон нутгийн онцгой комисс, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах асуудлаар хүлээсэн эрх, үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох; 35.1.Төрийн бус байгууллага нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дараахь эрх, үүрэгтэй оролцоно:

23	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	1.1.Энэ хуулийн зорилт нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын зарчим, үндсэн чиглэл, зохион байгуулалт, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог тодорхойлох замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын эрх зүйн үндсийг тогтооход оршееино. 17.1.3.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, хуулийн этгээдтэй хамтран ажиллах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд түүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; 17.1.8.холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, олон нийт, эрдэмтдийн төлөөллийг оролцуулан ажлын хэсэг байгуулан ажиллуулах; 28.1.4.шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагатай хамтран ажиллах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагаа, санал, санаачилгыг дэмжин туслах; 29.1.4.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэдийн оролцоог хангах, хамтран ажиллах; 36.1.Энэ хуулийн 14.1-д заасан хууль сахиулах болон төрийн захиргааны байгууллага нь иргэд, хуулийн этгээд, төрийн бус байгууллагаас гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх шинэ арга барил, ажиллагаа, төсөл, хөтөлбөрийн талаар санал, санаачилгыг дэмжиж хамтран ажиллана. 36.2.1.хүний эрхийг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, судлаачийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хэрэгжүүлж байгаа ажилд оролцуулах; 40.1.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн бус байгууллага болон баг, хорооны Засаг даргын саналыг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ эргүүлийн үүрэг гүйцэтгэх олон нийтийн байцаагчийг томилон ажиллуулна. 40.5.2.нийтийн хэв журам сахиулах талаар нутгийн захиргааны болон цагдаа, төрийн бус байгууллагаас зохион байгуулж байгаа ажилд оролцох, тусалцаа үзүүлэх; 44.1.6.хяналтад байгаа хүнийг нийгэмд дасан зохицох, ажил хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх, гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд хүргэж болзошгүй шалтгаан, нөхцөлийг арилгах, бусад асуудлыг шийдвэрлэх талаар нутгийн захиргааны болон бусад төрийн, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах. 46.5.1.гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хууль сахиулах болон төрийн бус байгууллага, иргэдээс иргэд, байгууллагын дунд зохион байгуулж байгаа сургалт, сурталчилгааны ажлын зардлыг санхүүжүүлэх;
----	--	--------------------------------------	---

24	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	5.1.3. “нэг цэгийн үйлчилгээ” гэж хохирогчийг эмнэлэг, төрийн, төрийн бус байгууллагад түр байрлуулан эмнэлгийн тусламж болон энэ хуульд заасан бусад үйлчилгээг нэг доор үзүүлэх ажиллагааг; 5.1.7. “холбон зуучлах үйлчилгээ” гэж гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд учирсан сөрөг үр дагаврыг арилгах, хэвийн байдалд нь оруулах, нөхөн сэргээхэд туслах зорилгоор холбогдох төрийн, төрийн бус байгууллагад зуучилж, хамтран үйлчилгээ үзүүлэхийг; 8.1.7. хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх бүхий этгээд, өмгөөлөгч, төрийн, төрийн бус байгууллага хохирогчийн эрх ашгийг хуульд заасны дагуу төлөөлөх; 20.2.1. гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах; 22.1. Төрийн бус байгууллага нь дүрмийнхээ зорилгод нийцүүлэн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэж болно: 22.2. Энэ хуулийн 22.1.1, 22.1.3-т заасан чиг үүргийг энэ чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ. 22.3. Энэ хуулийн 22.2-т заасан гэрээний үндсэн дээр үйлчилгээ үзүүлж байгаа төрийн бус байгууллагад олгох санхүүжилт, ажилтны цалин, урамшуулал нь адил төрлийн үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллагынхаас багагүй байна. 22.4. Төрийн бус байгууллага нь хохирогчийн хүсэлтээр түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлнэ. 22.5.1. хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр төрийн, төрийн бус байгууллага, бусад этгээдтэй харилцах 30.1.3. хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн, төрийн бус байгууллагад хүргэх. 33.6. Хуулийн этгээд, бусад этгээд нь хохирогчийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан цагдаагийн байгууллага, алба хаагч, сум, багийн Засаг дарга, хохирогчид үйлчилгээ үзүүлж байгаа төрийн, төрийн бус байгууллага, ажилтнаас өгсөн заавар, зөвлөмж, мэдэгдэл, тавьсан шаардлагыг биелүүлэх, туслалцаа, дэмжлэг үзүүлэх, мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй. 36.1. Энэ хуулийн 33.1-д заасан үйлчилгээг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй 24 цагийн турш нэг цэгээс үзүүлэх чиг үүрэг бүхий нэгж нь эмнэлэг, төрийн, төрийн бус байгууллагад ажиллана. 44.2. Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтыг энэ чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага хэрэгжүүлж болно.
25	Гэрч хохирогчийг хамгаалах тухай	Дөрөвдүгээр бүлэг Бусад зүйл	25.5.3. холбогдох яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн бус байгууллагад зөвлөмж өгөх;

26	Дайчилгааны тухай Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	Дөрөвдүгээр бүлэг. Дайчилгаа явуулах	25.3.Төрийн бус байгууллага, хувийн өмчийн эд хөрөнгийг нөхөх олговортойгоор дайчилна.
27	Донорын тухай. /Шинэчилсэн найруулга/	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	1.1.Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амь насыг нь аврах зорилгоор сайн дураараа цус, эс, эд, эрхтнээ үнэ төлбөргүй өгөх, шилжүүлэн суулгах, цусны аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагаа болон уг үйл ажиллагааны талаархи төрийн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэний эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино. 21.1.Цусны донорын эгнээг өргөжүүлэх зорилгоор донорын хөдөлгөөнийг сурталчлах, элсүүлэх ажлыг Монголын улаан загалмай нийгэмлэг, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран зохион байгуулна. 21.2.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн донорын эгнээг өргөжүүлэх үйл ажиллагаа, үйлсийг сурталчлах, тэдгээрт зориулсан сургалт явуулахад цусны асуудал хариуцсан байгууллагад дэмжлэг үзүүлнэ. 22.2.Цусны донорыг алдаршуулах, урамшуулах зорилгоор эд материал, санхүү, сэтгэл зүйн тусламж үзүүлж болох бөгөөд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагаас шагнаж урамшуулж болно.
28	Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай	Хоёдугаар бүлэг. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчид үзүүлэх санхүүгийн дэмжлэг	8.6.Аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэн болон сургалтын байгууллага тодорхой нөхцөл, болзол хангасан суралцагчид өөрийн нэрэмжит тэтгэлэг олгож болох бөгөөд уг тэтгэлгийн болзол, нөхцөлийг тэтгэлэг олгогч этгээд тогтооно.
29	Жагсаал цуглаан хийх журмын тухай		4 дүгээр зүйл. Жагсаал, цуглаан зохион байгуулах эрх 1. Жагсаал, цуглааныг Монгол Улсын иргэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн улс төрийн нам, төрийн бус байгууллага зохион байгуулах эрхтэй.
30	Жендэрийн эрх тэгш байлыг хангах тухай	Гуравдугаар бүлэг. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт	19.1.5.төрийн байгууллагын жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой зарим чиг үүргийг олон нийтийн болон төрийн бус байгууллагаар гэрээний дагуу гүйцэтгүүлэх, үүнд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж батлуулах; 19.2.Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага хууль тогтоомж, бодлого, ерөнхий төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, жендэрийн тэгш байдлын судалгаа, дүн шинжилгээний ажлыг жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно. 22.2.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гэрээгээр хариуцан гүйцэтгэж болно.

31	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл Гуравдугаар бүлэг. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төрийн бодлого төрийн бус байгууллага,	3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ 3.2.Төрийн бус байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой компани, улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой газар, гадаад улсын хуулийн этгээд энэ хуулийн зохицуулалтад хамаарахгүй. 10.3.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, дүгнэхэд эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог хангана.
32	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай	Хоёрдугаар бүлэг. Төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих	4.1.5."залуучуудын иргэний нийгмийн байгууллага" гэж залуучуудын оролцоотой, тэдний эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагыг; 12.1.4.гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдэлсэн залуучуудад боловсрол, мэргэжил олгох, хорих ангиас суллагдах үед ажлын байраар хангах талаар төрийн болон төрийн бус байгууллага хувийн хэвшлийн гаргасан санаачилгыг дэмжих;
33	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай	Хоёрдугаар бүлэг. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад төрийн байгууллагын хэрэгжүүлэх эрх, үүрэг	7.6.2.замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг уялдуулан зохион байгуулах;
34	Зар сурталчилгааны тухай	Тавдугаар бүлэг. Зар сурталчилгааг хянах зохицуулах	25.2.Хэрэглэгчийн эрх ашиг, түүнчлэн зар сурталчилгаа бүтээх, түгээх үйл ажиллагаанд оролцогчийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий төрийн бус байгууллага зар сурталчилгаанд хяналт тавих чиглэлээр дараахь эрх эдэлнэ: 25.3.Зар сурталчилгааны хяналттай холбоотой тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн улсын төсвөөс санхүүжүүлж болно.
35	Засгийн газрын тусгай сангийн тухай	Дөрөвдүгээр бүлэг. Тусгай сангийн удирдлага, санхүүжилт Тавдугаар бүлэг. Тусгай сангийн тайлагнал, ил тод байдал, хяналт	23.3.Засгийн газрын нөөц сангаас олгох санхүүжилтийг тухайн төсөл, арга хэмжээ, ажил, үйлчилгээг хэрэгжүүлж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүний харилцах дансанд шууд шилжүүлэхийг хориглоно. 25.5.Энэ хуулийн 5.3.2, 5.3.5, 5.3.18, 5.3.19-д заасан тусгай сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах хороо, төслийн удирдах хороо болон хяналтын хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулах ба тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаанд хяналт тавихад олон нийтийн оролцоог хангана.
36	Зээлийн батлан даалтын сангийн тухай	Хоёрдугаар бүлэг. Санг үүсгэн байгуулах, түүний удирдлага, бүтэц зохион байгуулалт	6 дугаар зүйл.Санг үүсгэн байгуулах Хэвлэх 6.1.Төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, иргэн, хуулийн этгээд Сангийн үүсгэн байгуулагч байж болно.

37	Зөвлөлдөх санал асуулгын тухай	Хоёрдугаар бүлэг. зөвлөлдөх санал асуулга, түүнийг зохион байгуулах	8.6.Энэ хуулийн 8.3-т заасан шаардлагыг хангасан эрдэмтэн, судлаачийг их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагаас, хувийн хэвшлийн төлөөллийг мэргэжлийн холбооноос, иргэнийг нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагаас, эсхүл өөрөө нэр дэвшүүлэн санал болгоно.
38	Инновацийн тухай	Гуравдугаар бүлэг. Инновацийн үйл ажиллагаа, төрийн дэмжлэг.	13.14.Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг төрийн болон төрийн бус байгууллага, шинжлэх ухаан, аж үйлдвэрийн төлөөллийг оролцуулан Засгийн газрын баталсан журмын дагуу боловсруулна.
39	Зөрчлийн тухай	Есдүгээр бүлэг. Боловсрол, соёл шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны журмын эсрэг зөрчил	3.Монгол Улсад аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж байгаа гадаад улсын хуулийн этгээд, төрийн бус байгууллага нь Монгол Улсын төрийн байгууллагатай төрийн албан ёсны хэлээр харилцах, санхүү, татвар, хөдөлмөр, ажлын байрны аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдолтой баримт бичгийг төрийн албан ёсны хэлээр хөтлөх журам зөрчсөн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
40	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг зүйл	3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ 3.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэхэд энэ хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь заалт, 16 дугаар зүйлд заасан хугацааг баримтална.
41	Ирээдүйн өв сангийн тухай	Дөрөвдүгээр бүлэг. Сангийн засаглал	15.5.2.Монгол Улсын Их Хурлын даргын сонгосон санхүү, эдийн засгийн судалгаа, шинжилгээний туршлагатай, нийгэмд үйлчлэх гурав хүртэлх төрийн бус байгууллагаас;
42	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай	Дөрөвдүгээр бүлэг. Нотлох баримт	44.4.Төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд нь бичмэл нотлох баримтыг өөрийн байгууллагын архивын “хуулбар үнэн” гэсэн тэмдэг дарж баталгаажуулна.
43	Кино урлагийг дэмжих тухай	Хоёрдугаар бүлэг. Кино урлагийг дэмжих талаарх төрийн байгууллагын эрх	9.4.Мэргэжлийн төрийн бус байгууллага кино урлагийн чиглэлээр мэргэшсэн, таваас доошгүй жил ажилласан туршлагатай иргэнийг энэ хуулийн 6.1.4-т заасан журмын дагуу нэр дэвшүүлнэ. 9.5.Кино урлагийн чиглэлээр мэргэшсэн, таваас доошгүй жил ажилласан туршлагатай уран бүтээлч нь энэ хуулийн 6.1.4-т заасан журмын дагуу бие даан болон мэргэжлийн төрийн бус байгууллагаас нэр дэвшинэ.
44	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай	Хоёрдугаар бүлэг. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын зохион байгуулалт, оролцогчдын эрх, үүрэг.	4.2.Энэ хуулийн 4.1-д заасан чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ ажлыг зохион байгуулж болно.

45	Компанийн тухай	Есдүгээр бүлэг. Компанийн удирдлага	79.2.Төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан компанийн хувьд хараат бус гишүүнд тухайн компанийг удирдах мэргэжлийн өндөр ур чадвартай хүний нэрийг компанийн сайн засаглалыг дэмжих зорилготой төрийн бус байгууллагаас дэвшүүлэх саналаа тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хороонд ирүүлж болно.
46	Мал амьтны эрүүл мэндийн тухай	Хоёрдугаар бүлэг. Мал амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх.	9.9.Дархлаажуулалтын гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага бусад төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулна.
47	Малын генетик нөөцийн тухай	Тавдугаар бүлэг. Малын генетик нөөцийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх.	17.2.Энэ хуулийн 7.4-т заасан Үндэсний зохицуулагч нь хорооны дарга байх бөгөөд хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын төрийн болон төрийн бус байгууллага, сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, үүлдэр, ашиг шимийн зөвлөл, мэргэжлийн холбоо, үүлдрийн нийгэмлэг, үйлдвэрлэгч, боловсруулах салбарын төлөөллийг оролцуулна.
48	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай	Гуравдугаар бүлэг. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх	11.1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах талаар төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, түүнчилэн эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, соёл урлаг, шинжлэх ухаан, боловсролын байгууллага болон мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллага сурталчилгаа явуулах үүрэгтэй.
49	Монгол Улсын Батлан хамгаалах тухай	Гуравдугаар бүлэг. Батлан хамгаалахын удирдлагын бүрэн эрх	14.1.4.батлан хамгаалах болон зэвсэгт хүчний хангалт, үйлчилгээний зарим чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журмыг батлах; 15.3.12.батлан хамгаалах арга хэмжээний төлөвлөлтөд шаардагдах мэдээ, судалгааны нэр төрлийг тогтоож, шаардлагатай мэдээ, мэдээлэл, судалгааг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс гаргуулан авах;
50	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай	Наймдугаар бүлэг. Санал авах, сонгуулийн дүн гаргах	63 дугаар зүйл.Сонгууль ажиглах 63.1.Нэр дэвшигч нэг санал авах байранд гурав хүртэл, Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн төрийн бус байгууллага нэг санал авах байранд хоёр хүртэл сонгуулийн ажиглагч /цаашид “ажиглагч” гэх/-ийг томилж ажиллуулах эрхтэй бөгөөд энэ эрхийг хууль бусаар хязгаарлахыг хориглоно. 63.13.Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах зорилт бүхий дүрэмтэй, улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй, хараат бус төрийн бус байгууллага нь сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх эрхтэй.
51	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай	Гуравдугаар бүлэг. Хурал, Тэргүүлэгчид, Хурлын дарга, тэдгээрийн бүрэн эрх	20.1.10.олон нийтийн үүсгэл санаачилгыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тухайн нутаг дэвсгэр дэх төрийн бус байгууллага, сүм хийдтэй харилцах; 24.2.Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн тухайн шатны Хуралд, сум, дүүрэг, баг, хорооны Хурал зохих дээд шатны Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно.

52	Хөдөлмөрийн тухай	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	6.6.Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхагдсан гэж үзсэн хүн, ажилтан, ажилтны төлөөлөгч гомдлоо тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, дээд шатных нь албан тушаалтан, холбогдох төрийн бус байгууллага, үйлдвэрчний эвлэл, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх байгууллага, хууль хяналтын байгууллага, хөдөлмөрийн хяналтын байгууллага, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүхэд тус тус гаргаж болно. Гомдлыг хүлээн авах байгууллага, албан тушаалтны нэр, хаяг, харилцах утас, цахим шуудангийн хаягийг ажил олгогч нийт ажилтанд харагдахуйц газар байршуулах үүрэгтэй.
53	Хоршооны тухай /Шинэчилсэн найруулга/	Зургаадугаар бүлэг. Хоршооны талаарх төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, хоршооллын нэгдсэн ба хоршоодын холбооны бүрэн эрх	42.1.3.хоршооны хөгжлийг дэмжих бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;
54	Төрийн албаны тухай. /Шинэчилсэн найруулга/	Есдүгээр бүлэг. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүрэг, эрх, хориглох зүйл.	39.1.5.улс төрийн намын гишүүн байх, улс төрийн нам, хөдөлгөөн, улс төрийн намын дэргэдэх төрийн бус байгууллага болон шашны байгууллагын үйл ажиллагаанд хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд аливаа хэлбэрээр оролцох;
55	Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай		7.2.6.холбоог төрийн бус байгууллагад элсүүлэх, гишүүнээс гаргах; 8.10.Хуралд төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас гадна төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөлөгчийг оролцуулж болно.

Холбоо			
№	Хууль	Бүлэг	Заалт
1	Биеийн тамир, спортын тухай /Шинэчилсэн найруулга/	Гуравдугаар бүлэг. Байгууллага, аж ахуйн нэгж дэх биеийн тамир спортын үйл ажиллагаа	11.1.Спортын холбоо нь тухайн спортын төрлийг дэлгэрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах, төлөөлөгчийн газар, салбар, спортын клубээр дамжуулан иргэнд идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлнэ. 11.2.Спортын холбоо нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тухайн спортын төрлийн олон улсын холбооны дүрэмд нийцүүлэн үйл ажиллагаа явуулна.
2	Газрын тухай /Шинэчилсэн найруулга/	Зургаадугаар бүлэг. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах	56.8.Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн орчны газрыг тохижуулах, арчлах, цэвэрлэх, хамгаалах үүргийг тухайн сууц өмчлөгчдийн холбоо хариуцна.

3	Даатгалын тухай (Шинэчилсэн найруулга)	Гуравдугаар бүлэг. Даатгалын үйл ажиллагааг төрөөс зохицуулах	12.1.1.Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгагч нь Албан журмын даатгагчдын холбоо /цаашид “Холбоо” гэх/-нд гишүүн болох үүрэгтэй.
4	Жолоочийн даатгалын тухай	Тавдугаар бүлэг. Жолоочийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалт	21.2.Даатгалын тухай хуулийн 121 дүгээр зүйлд заасан Албан журмын даатгагчдын холбоо нь Жолоочийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх тайланг жил бүр гаргах бөгөөд уг сангийн үйл ажиллагаа, тайланд Санхүүгийн зохицуулах хороо хяналт тавина.
5	Иргэний хууль	Хоёрдугаар дэд бүлэг. Хуулийн этгээдийн төрөл	36.1.Нэгдмэл, тодорхой зорилго тавьсан хэд хэдэн этгээд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгуулсан, гишүүнчлэл бүхий хуулийн этгээдийг холбоо гэнэ.
		Тавдугаар дэд бүлэг. Нийтийн зориулалттай орон сууц өмчлөх эрх	143.1.Нийтийн зориулалттай орон сууцны нэг байшинд хоёр буюу түүнээс дээш эрх сууц өмчлөгч болсон тохиолдолд дундын өмчлөлийн эд хөрөнгийг дундаа өмчлөх эрхийг хэрэгжүүлэх, орон сууцны ашиглалтын хэвийн байдлыг хангах, сууц өмчлөгчдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор сууц өмчлөгчдийн холбоо /цаашид “холбоо” гэх/-г байгуулна.
6	Малын генетик нөөцийн тухай	Орон сууцны тухай	13.5.Мэргэжлийн холбоо нь мал хамгаалах үйл ажиллагааны талаархи санал, дүгнэлтийг малын генетик нөөцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.
7	Орон сууц хувьчлах тухай	Хоёрдугаар бүлэг. Орон сууц хувьчлах ажлын удирдлага, зохион байгуулалт	11. 9/ орон сууц өмчлөгчдийн холбоо байгуулахад арга зүйн туслалцаа үзүүлэх;
8	Орон сууцны тухай	Тавдугаар бүлэг. Нийтийн зориулалттай орон сууцны байшингийн ашиглалт	14.1.Сууц өмчлөгчдийн холбоо нь дундын өмчлөлийн эд хөрөнгийн засвар, үйлчилгээ, дэвсгэр болон орчны газар, орчны зам, талбайн тохижилтын ажлыг тогтмол хийж, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу холбогдох зардлыг хариуцна.
9	Өмгөөллийн тухай	Хоёрдугаар бүлэг. Өмгөөллийн ажиллагаа эрхлэх	7.2.Өмгөөлөгчийн шалгалтад тэнцсэн хуульч шалгалтын нэгдсэн дүнг мэдээлсэн өдрөөс хойш нэг жилийн дотор өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрх авах тухай хүсэлтийг Монголын Өмгөөлөгчдийн Холбоо /цаашид “Өмгөөлөгчдийн Холбоо” гэх/-нд гаргана. Энэ хэсэгт заасан хүсэлт гаргах хугацаа өнгөрсөн бол шалгалтад тэнцсэн дүн хүчингүй болно.
10	Өргөн нэвтрүүлгийн тухай	Дөрөвдүгээр бүлэг. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэхтэй холбоотой онцлог зохицуулалт	20.6.Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн заавал гишүүнчлэлтэй, нийтийн эрх зүйн хуулийн этгээд болох Монголын телевизүүдийн холбоо /цаашид “Холбоо” гэх/ нь энэ хуулийн 20.5.3-т заасан хөлсийг төвлөрүүлж, өргөн нэвтрүүлгийн телевизийн үзэлтийн судалгааг үндэслэн гишүүдэд хуваарилна.

11	Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай		5.1.Сууц өмчлөгчдийн холбоо /цаашид “холбоо” гэх/-ны эрх зүйн байдал нь Иргэний хуулийн 143 дугаар зүйл болон энэ хуулиар тодорхойлогдоно. 5.7.Хуульд өөрөөр заагаагүй бол холбоо нь гишүүдийн хүлээх үүргийг, гишүүд нь холбооны хүлээх үүргийг хариуцахгүй.
12	Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай		3.Үйлдвэрчний эвлэлүүд нь сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж холбоо байгуулах, олон улсын үйлдвэрчний эвлэлүүдийн нэгдэлд гишүүнээр элсэх эрхтэй.
13	Үнэт цаасны зах зээлийн тухай /Шинэчилсэн найруулга/	Гуравдугаар дэд бүлэг. Мэргэжилтэнд эрх олгох	35.3.Энэ хуулийн 35.2-т заасан төрөл, зэрэглэлийг үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн холбоо болон өөрийгөө зохицуулах байгууллагын саналыг харгалзан Хороо тогтооно.
14	Хадгаламж зээлийн хоршооны тухай	Наймдугаар бүлэг. Хадгаламж, зээлийн хоршоодын холбоо	49.1.Хадгаламж, зээлийн хоршоод хамтран ажиллах, харилцан туслалцах зорилгоор сайн дурын үндсэн дээр нэгдэж Хадгаламж, зээлийн хоршоодын холбоо /цаашид Холбоо гэх/-г энэ хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үүсгэн байгуулж болно. 49.2.Хорооноос тогтоосон шаардлагыг хангасан холбоо Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооны эрх, үүргийг хэрэгжүүлж хоршоодын эрх ашгийг хамгаалах, тэдгээрийг төрийн байгууллага болон гадаад харилцаанд төлөөлөх эрхийг эдэлнэ. Бусад холбоо нь “үндэсний” гэх тодотголыг оноосон нэрд хэрэглэхийг хориглоно. 51.4.7.тэргүүлэгчдийн зөвлөл, гүйцэтгэх захирлын үйл ажиллагаа хууль бус, Холбоо болон гишүүн хадгаламж, зээлийн хоршооны эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр бол уг үйл ажиллагааг таслан зогсоох, гаргасан шийдвэрийг хүчингүй болгохыг шаардах.
15	Хоршооны тухай /Шинэчилсэн найруулга/	Зургаадугаар бүлэг. Хоршооны талаарх төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, хоршооллын нэгдсэн ба хоршоодын холбооны бүрэн эрх	44.1.Хоршоод үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу эвлэлдэн нэгдэж, хоршоодын холбоо байгуулж болно. Хоршоо нь хоршоодын холбооны гишүүн байна. 44.2.Хоршоодын холбоо нь гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага байна. 46.2.Хоршооллын нэгдсэн холбоо дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулна: 46.2.1.хоршооллын салбарын хөгжлийн нэгдсэн бодлого, хоршооллын хөдөлгөөнийг өргөжүүлэх талаар төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах, хоршоологчдын эрх ашгийг хамгаалах;
16	Хөдөлмөрийн тухай. /Шинэчилсэн найруулга/	Гуравдугаар бүлэг. Хамтын хэлэлцээ	26.2.Салбарын болон үндэсний хэмжээнд ажил хаялт зохион байгуулах эсэх асуудлыг тухайн шатны үйлдвэрчний эвлэлийн холбооны гишүүн байгууллагуудын дийлэнх олонх ажил хаялт зарлах тухай санал хураалтад оролцож, олонх нь дэмжсэн тохиолдолд тухайн шатны үйлдвэрчний эвлэлийн холбоо шийдвэрлэнэ.
17	Хуульчийн эрх зүйн байдлын тухай	Хоёрдугаар бүлэг. Хуульчийн мэргэжлийн шалгалт	9.2.Гадаад улсын хууль зүйн сургуулийг төгссөн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн хуульчийн шалгалтад орох журмыг Хуульчдын холбоо батална.

18	Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай	Хоёрдугаар бүлэг. Хүний эрх хамгаалагчийн эрх, санхүүжилт, хориглох зүйл. Дөрөвдүгээр бүлэг. Хүний эрх хамгаалагчийг хамгаалах тогтолцоо	6.1.3.хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих зорилгоор аливаа хэлбэрээр эвлэлдэн нэгдэх, төрийн бус байгууллага, эвсэл, холбоо, бүлэг, нэгдэл байгуулах, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцох; 11.4.Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо нь тус тусын хуралдаанаараа нэр дэвшигчээ шалгаруулж Комиссын хуралдаанд санал болгоно.
19	Эвлэрүүлэн зуучлалын тухай	Хоёрдугаар бүлэг. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа	8.1.Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо үйл ажиллагааныхаа чиглэлийн дагуу тухайн салбарын эрх зүйн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэх эвлэрүүлэн зуучлагчийг ажиллуулж болно.
20	Эрүүл мэндийн тухай	Дөрөвдүгээр бүлэг. Эрүүл мэндийн байгууллагын тогтолцоо	19.7.Хэрэгцээний үнэлгээг тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагаас сонгон шалгаруулсан мэргэжлийн нийгэмлэг, холбоо гүйцэтгэнэ.

Сан, корпораци			
№	Хууль	Бүлэг	Заалт
1	Авлигын эсрэг хууль	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	4.1.Доор дурдсан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарна: 4.1.9.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн.
2	Авто замын тухай /Шинэчилсэн найруулга/	Хоёрдугаар бүлэг. Авто замын талаархи төрийн байгууллагын бүрэн эрх	8.4.Авто замын норм, норматив, техникийн баримт бичгийг боловсруулах, батлах, боловсронгуй болгож хөгжүүлэх “Авто замын норм, нормативын сан”-тай байх бөгөөд уг сан дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:
3	Авто тээврийн тухай хууль	Хоёрдугаар бүлэг. Автотээврийн талаархи төрийн байгууллагын бүрэн эрх	6.1.11.тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, холбогдох байгууллагыг байнгын мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;
4	Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай /Шинэчилсэн найруулга/	Гуравдугаар бүлэг. Албан татвар ногдох орлогоос хасагдах зардал Дөрөвдүгээр бүлэг. Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох	15.1.Энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан дараах зардлыг албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцож болно: 15.1.13.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Цөмийн энергийн тухай хуульд заасны дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, төсөл хэрэгжүүлэгч, гэрээлэгчийн байгаль орчны менежментийн жилийн төлөвлөгөөнд тусгаж, холбогдох төрийн байгууллагаас нээсэн тусгай сан, төрийн сан болон Газрын тосны тухай хуулийн 11.2.9-д заасан дансанд шилжүүлсэн мөнгөн хөрөнгө; 18.11.Даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжийн даатгалын үйл ажиллагааны нийт орлогоос эрх бүхий төрийн байгууллагаас баталсан дүрэмд заасны дагуу тухайн жилд байгуулсан нөөцийн сан болон үйл ажиллагааны зардлыг хасаж, албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

5	Архив албан хэрэг хөтлөлтийн тухай. /Шинэчилсэн найруулга/	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл. Хоёрдугаар бүлэг. Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, чиг үүрэг, зохион байгуулалт	4.1.10.“үндэсний архивын сан хөмрөг” гэж хадгалагдаж байгаа байршил, өмчийн хэлбэр, үүссэн эх сурвалж, хугацаанаас үл хамаарч монголын ард түмний амьдрал, хөгжлийн түүхийг тусгасан, эрдэм шинжилгээ, нийгэм, улс төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухааны ач холбогдолтой архивт байнга хадгалагдах бүх төрлийн баримтыг; 5.1.2.төрийн архивын сан хөмрөгт хамаарах баримтын өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх асуудлыг шийдвэрлэх; 28.8.Төрийн өмчийн бус архивын сан хөмрөгийг өмчлөгч байгууллагын үйл ажиллагаа дуусгавар болсон, эсхүл иргэн нас барсан тохиолдолд эрх залгамжлагч байхгүй бол тэдгээр архивын баримтыг төрийн өмчид хамааруулж, холбогдох төрийн архивт шилжүүлэн хадгалуулна.
6	Архидан согтуурахтай тэмцэх тухай	Дөрөвдүгээр бүлэг. Архидан согтуурахтай хийх тэмцэл	.1. Архидан согтуурахтай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор Архидан согтуурахтай тэмцэх сан /цаашид “сан” гэх/-г байгуулна.
7	Ахмад настны тухай /Шинэчилсэн найруулга/	Дөрөвдүгээр бүлэг. Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг	14.7.Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална.
8	Ашигт малтмалын тухай /шинэчилсэн найруулга/	Есдүгээр бүлэг. Мэдээлэл, төлбөрийн хуваарилалт, нөхөн төлбөр, санхүү бүртгэлийн онцлог	61.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч уул уурхайн үйлдвэрлэлд ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгөд түүний элэгдэл, хорогдлын шимтгэлийн сан байгуулна.
9	Байгаль орчныг хамгаалах тухай	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	1.Иргэн байгаль орчныг хамгаалах талаар дараахь эрхийг эдэлнэ: 3/байгаль орчныг хамгаалах олон нийтийн байгууллага байгуулах, хөрөнгийн сан үүсгэх нутгийн иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгалийн баялгийг арчлан хамгаалах, нөхөн сэргээх, түүний ашиг шимийг хүртэх;
10	Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай	Хоёрдугаар бүлэг. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх	14.2.Дүрмийн сан нь банк бус санхүүгийн байгууллагын хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний хэмжээг улсын эдийн засгийн байдал, мөнгөний ханшийн өөрчлөлт, банк бус санхүүгийн байгууллагын төлбөрийн чадвар, эрхлэх үйл ажиллагааны онцлогийг харгалзан Санхүүгийн зохицуулах хороо тогтооно.
11	Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай. / Шинэчилсэн найруулга/	Дөрөвдүгээр бүлэг. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн зээлийн үйл ажиллагаа	27.1.Зээлдүүлэгч олгосон зээлдээ судалгаа хийж, зээлийнхээ үлдэгдлийг хууль, журамд заасны дагуу ангилж, харгалзах эрсдэлийн сан байгуулна.

12	Банкан дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай	Хоёрдугаар бүлэг. Хадгаламжийн даатгалын сангийн үйл ажиллагаа	10.1.Хадгаламжийн даатгалын сан /цаашид “Сан” гэх/-гийн удирдлагыг Хадгаламжийн даатгалын корпораци хэрэгжүүлнэ.
13	Банкны тухай /Шинэчилсэн найруулга/	Тавдугаар бүлэг. Банкны хөрөнгө, хяналт шалгалт Дөрөвдүгээр дэд бүлэг Банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээ	35.5.Банкны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журмыг Монголбанк санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах бөгөөд банк активыг энэхүү журмын дагуу ангилж, эрсдэлийн сан байгуулна. 62.1.Монголбанк нь банкны санхүүгийн байдлыг сайжруулах, тогтворжуулах, банкны бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай мөнгөн хөрөнгийн сан /цаашид “Сан” гэх/-г бүрдүүлж, зохих журмын дагуу дараахь байдлаар зарцуулж болно.
14	Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай /Шинэчилсэн найруулга/	Гуравдугаар бүлэг. Барааны тэмдэг эзэмшигчийн онцгой эрх	13.3.Барааны тэмдгийн оюуны бүтээлийн өртгийг тооцсон үнэлгээг хөрөнгийн баталгаа, барьцаа, хөрөнгө оруулалт болгох, хувьцаа гаргах, хувьчлал болон дуудлага худалдаанд оруулах, дүрмийн сан бүрдүүлэх, даатгалд хамруулах зэрэгт хэрэглэж болно.
15	Барилгын тухай /Шинэчилсэн найруулга/	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	5.7.Барилга байгууламжийн норм, нормативын сан дараахь эх үүсвэрээс бүрдэнэ: 5.7.1.барилга байгууламжийн төсөвт өртгөөс 0.18 хувиар авсан орлого;
16	Боловсролын тухай	Тавдугаар бүлэг. Боловсролын эдийн засаг	39.8.Олон нийтийн үүсгэл санаачилгаар аймаг, нийслэл, сум, дүүрэгт боловсрол хөгжүүлэх сан байгуулж болно.
17	Гаалийн тухай /Шинэчилсэн найруулга/	Зургаадугаар бүлэг. Гаалийн бүрдүүлэлт хийх Долдугаар дэд бүлэг Гаалийн зуучлагч	67.1.4.мэдүүлэгчийн өмнөөс гаалийн болон холбогдох бусад татварыг төлөх, эсхүл төлөхөөр гаргасан баталгааг хангахад учирч болзошгүй алдагдлаас хамгаалах зорилгоор эрсдлийн сан байгуулсан байх.
18	Гамшгаас хамгаалах тухай /Шинэчилсэн найруулга/	Долдугаар бүлэг. Хуулийн этгээд, иргэний эрх, үүрэг.	37.1.Иргэн гамшгаас хамгаалах талаар дараахь эрхийг эдэлнэ: 37.1.2.гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг байгуулах, гишүүнээр элсэх, гамшгаас хамгаалах дундын хөрөнгийн сан үүсгэх;
19	Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай	Дөрөвдүгээр бүлэг. Хөрөнгө, хувьцаа	14.1.Даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн дүрмийн сан нь мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд дараахь хэмжээтэй байна: 14.1.1.даатгалын багц дүрэмд заасан хэмжээнээс багагүй;

20	Даатгалын тухай (Шинэчилсэн найруулга)	Гуравдугаар бүлэг. Даатгалын үйл ажиллагааг төрөөс зохицуулах Зургаадугаар бүлэг. Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр, төлбөрийн чадвар Аравдугаар бүлэг. Даатгагчийн үүрэг, даатгагчид тавих хязгаарлалт	14.2.3.даатгалын нөөц сан албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, хуваарилах, түүнд хяналт тавих журам; 22.1.Даатгалын компанийн дүрмийн сан нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний доод хэмжээг даатгалын ангилал, давхар даатгалын онцлогийг харгалзан Зохицуулах хороо тогтооно. Дүрмийн санг зээлийн хөрөнгөөр бүрдүүлэхийг хориглоно. 22.4.Даатгагчийн дүрмийн сан энэ хуулийн 22.1-д заасан хэмжээнд хүрэхгүй болсон тохиолдолд даатгагч Зохицуулах хороонд нэн даруй бичгээр мэдэгдэнэ. 25.1.Даатгагч нь гэрээний явцад үүссэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор даатгалын нөөц сан бүрдүүлнэ. 51.1.Урт хугацааны даатгагч нь эрхэлж буй даатгалын төрөл тус бүрт тусгайлсан данс нээж, тусгайлсан сан байгуулна.
21	Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай	Хоёрдугаар бүлэг. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчид үзүүлэх санхүүгийн дэмжлэг үзүүлэх байгууллагын эрх, үүрэг.	9.3.Суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг олгох үйлчилгээг эрхлэн гүйцэтгэх байгууллага нь Боловсролын зээлийн сан байх бөгөөд суралцагчид төрөөс олгосон санхүүгийн дэмжлэгийг чанартай боловсролд сонгон хэрэглэх боломж нь нээлттэй байна. 12.4.4.сургалт, судалгааны санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор тодорхой төрлийн дэд сан байгуулах, сангийн хөрөнгөө арвижуулах талаар хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа эрхлэх.
22	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай. /Шинэчилсэн найруулга/	Гуравдугаар бүлэг. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төрийн бодлого.	11.1.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх зорилго бүхий Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан /цаашид "Сан" гэх/ байна.
23	Жолоочийн даатгалийн тухай	Дөрөвдүгээр бүлэг. Даатгалын тохиолдолд нөхөн төлбөр	13.5.Даатгуулагч энэ хуулийн 13.1, 13.4-т заасан үүргээ хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүйн улмаас үүсэх үр дагаврыг даатгагч, жолоочийн даатгалын сан хариуцахгүй бөгөөд хохирлыг даатгуулагч өөрөө хариуцна.
24	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай	Тавдугаар бүлэг. Залуучуудын хөгжлийг дэмжих сан.	23.1.Залуучуудын хөгжлийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дэргэдээ Залуучуудын хөгжлийг дэмжих сан /цаашид "сан" гэх/ -тай байна.
25	Засгийн газрын тусгай сангийн тухай /Шинэчилсэн. найруулга/	Хоёрдугаар бүлэг. Тусгай сан, түүний төрөл Гуравдугаар бүлэг. Тусгай сангийн эх үүсвэр, зарцуулалт.	5.4.Энэ хуулийн 5.3.4, 5.3.6, 5.3.8, 5.3.15-д зааснаас бусад тусгай сан нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд туссан үйл ажиллагааг санхүүжүүлдэг байх зарчим баримтална. 7.1.Байгаль орчин, уур амьсгалын сан нь байгаль орчныг хамгаалах, байгалийн гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад дэмжлэг үзүүлэх зориулалттай байна. 8.1.Боловсролын зээлийн сан нь санхүүгийн дэмжлэг, тэтгэлэг, сургалтын төлбөрийн зээл олгох замаар дээд боловсрол эзэмших хүсэлтэй тодорхой шалгуур, шаардлагыг хангасан иргэнийг төрөөс дэмжих бодлогыг хэрэгжүүлэх зориулалттай байна.

			9.1.Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан нь төрийн бодлогын хүрээнд харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг алслагдсан орон нутагт болон үйлчилгээ хүрээгүй хүн амд бодит үнээр хүргэх, шинээр сүлжээ байгуулах, харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, өргөтгөх, шинэчлэх зориулалттай байна. 10.1.Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдсэн, энэ хуулийн 10.3-т заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, хүнд гэмтэл учирсан хохирогчид нөхөн төлбөр олгох зориулалттай байна. 11.1.Засгийн газрын нөөц сан нь тухайн жилийн төсөвт урьдчилан тооцож, төлөвлөн тусгах боломжгүй, хойшлуулшгүй цаг үеийн шинжтэй арга хэмжээ болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.8-д заасан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, 4.1.15-д заасан гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагааг шат дараатай зохион байгуулах зорилгоор улс, орон нутгийн төсвийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлын хүрэлцэхгүй хэсгийг санхүүжүүлэх зориулалттай байна. 13.1.Соёл, урлагийг дэмжих сан нь соёл, урлагийг хөгжүүлэх, сурталчлан таниулах, соёлын өвийг бүртгэх, судлах, хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зориулалттай байна. 14.1.Спортыг дэмжих сан нь нийтийн биеийн тамир, хүн амын идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх, өндөр зэрэглэлийн тамирчин, дасгалжуулагчийг шинжлэх ухааны үндэслэлтэй бэлтгэх, үндэсний спортын төрлийг хөгжүүлэх, үндэсний хэмжээний тэмцээн, наадмын сэргээшийн эсрэг хяналтыг хэрэгжүүлэх, сэргээшийн эсрэг үйл ажиллагааны сургалт, сурталчилгааг зохион байгуулах, биеийн тамир, спортын чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх зориулалттай байна. 15.1.Төсвийн тогтворжуулалтын сан нь нэгдсэн төсвийн дунд болон урт хугацааны тэнцвэртэй, тогтвортой байдлыг хангах, төсвийн тэнцвэржүүлсэн горимыг хэрэгжүүлэхэд санхүүгийн хэрэгслийн үүрэг гүйцэтгэнэ. 16.1.Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зориулалттай байна. 17.1.Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан нь хилийн чанадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, эрх нь зөрчигдсөн тохиолдолд хууль, эрх зүйн туслалцааг шуурхай үзүүлэх, иргэний улсын бүртгэл, нотариатын болон консулын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах зориулалттай байна. 18.1.Шинжлэх ухаан, технологийн сан нь шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн онолын суурь судалгаа гүйцэтгэх, шинжлэх ухаан, технологийн болон инновацийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зориулалттай байна.
--	--	--	---

			19.1.Эрүүл мэндийг дэмжих сан нь эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зориулалттай байна. 20.1.Кино урлагийг дэмжих сан нь кино урлагийг хөгжүүлэх, үйлдвэрлэх, түгээн таниулахад дэмжлэг үзүүлэх зориулалттай байна. 21.1.Хөдөө аж ахуйг дэмжих сан нь газар тариалан, мал аж ахуй эрхлэх үйл ажиллагааг дэмжих зориулалттай байна. 22.1.Хүүхдийн төлөө сан нь хүүхдэд зориулсан бүтээн байгуулалт, хүүхдийн хөгжил, хамгаалал, оролцоог дэмжих зориулалттай байна.
26	Зөрчил шалган шийдвэрлэх тухай	Тавдугаар бүлэг. Эрх хязгаарлах арга хэмжээ	10.Барьцааны мөнгийг төрийн сан дахь тусгай дансанд байршуулна.
27	Зөрчлийн тухай /Шинэчилсэн найруулга/	Арван нэгдүгээр бүлэг. Үнэт цаас, банк, санхүү, гааль, татвар, маргэжлийн хяналт, даатгалын журмын эсрэг зөрчил	2.Хүн, хуулийн этгээд: 2.5.хөрөнгө оруулалтын сан хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан; 15.Даатгагч: 15.12.урт хугацааны даатгагчийн сан байгуулах, түүнийг зарцуулах журам зөрчсөн; 3.Хуульд заасныг зөрчиж: 3.3.хамтын хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах ажиллагаа явуулсан, эсхүл бусдад мэдээлэл өгсөн, эсхүл бусдаас хөрөнгө төвлөрүүлсэн; 3.8.гадаад улсад бүртгэлтэй хөрөнгө оруулалтын сан нь Монгол Улсын нутаг дэвсгэрт сангийн хувьцаа, нэгж эрхээ нийтэд санал болгон худалдсан;
28	Зээлийн батлан даалтын сангийн тухай	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	4.1.Зээлийн батлан даалтын сан /цаашид “Сан” гэх/ нь барьцаа хөрөнгийн дутагдалтай жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээлийн батлан даалт гаргах ашгийн төлөө бус хуулийн этгээд байна.
29	Иргэний хууль	Дөрөвдүгээр бүлэг. Хуулийн этгээд Хоёрдугаар дэд бүлэг Хуулийн этгээдийн төрөл	36.2.Нэг буюу хэд хэдэн үүсгэн байгуулагч нийгэмд ашиг тустай, нэгдмэл зорилгод хүрэхийн тулд эд хөрөнгө төвлөрүүлэх замаар байгуулсан гишүүнчлэлгүй хуулийн этгээдийг сан гэнэ.
30	Ирээдүйн ав сангийн тухай	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно: 4.1.6.“Ирээдүйн өв сан корпораци” /цаашид “Корпораци” гэх/ гэж Сангийн хөрөнгийн удирдлагыг мандатаар олгогдсон эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх үүрэг бүхий 100 хувь төрийн өмчит хуулийн этгээдийг;
31	Кино урлагийг дэмжих тухай	Дөрөвдүгээр бүлэг. Кино урлагийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	12.2.Кино урлагийг дэмжих сан Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан эх үүсвэрээс бүрдэх бөгөөд уг сангаас дараах хэлбэрээр дэмжлэг үзүүлнэ: 12.2.1.эргэн төлөх нөхцөлгүй олгох санхүүжилт;
32	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	16.1.Энэ хуулийн 4.1-д заасан салбар зөвлөлийн дэргэд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тусгай сан байгуулж болно.

33	Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль	Тавдугаар бүлэг. Малын индексжүүлсэн даатгалын сан	25.1.Малын индексжүүлсэн даатгалын сан дараах төрөлтэй байна: 25.1.1.даатгагчдын Хамтын эрсдэлийн сан; 25.1.2.давхар даатгалын компанийн сан. 26.1.Хамтын эрсдэлийн сан нь давхар даатгалын компанийн дэргэд тусдаа бүртгэлтэй, бие даасан данстай байна.
34	Монгол Улсын хөгжлийн банкны тухай /Шинэчилсэн найруулга/	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	6.2.Хөгжлийн банк нь тухайн жилийн цэвэр ашгаас хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлж, үлдэх хэсгээр алдагдлыг нөхөх зорилго бүхий нөөц сан байгуулна.
35	Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай. /Шинэчилсэн найруулга/	Тавдугаар бүлэг. Бусад зүйл	22.1.Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ: 22.1.1.улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;
36	Нийгмийн даатгалын тухай	Хоёрдугаар бүлэг. Нийгмийн даатгалын сан	2.Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулах, зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно.
37	Нийгмийн халамжийн тухай /Шинэчилсэн найруулга/	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	6.1.Нийгмийн халамжийн сан /цаашид “халамжийн сан” гэх/ нь мөнгөн хөрөнгийн сан байна. 6.2.Халамжийн сан дараах төрөлтэй байна: 6.2.1.тэтгэвэр, тэтгэмжийн сан; 6.2.2.нийгмийн үйлчилгээний сан.
38	Оюуны өмчийн тухай	Дөрөвдүгээр бүлэг. Оюуны өмчийн эрхийг эдийн засгийн эргэлтэд оруулах, төрөөс үзүүлэх дэмжлэг.	22.1.3.оюуны өмчийн эрхийг эдийн засгийн эргэлтэд оруулах сан байгуулах;
39	Өмч хувьчлах тухай	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	2.Хувьчлалын сан нь хувьчлах эд хөрөнгийг борлуулсны орлого, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө, хувьчлалыг дэмжиж БНМАУ-ын байгууллага, иргэд, түүнчлэн олон улсын болон гадаадын байгууллага, иргэд, харьяалалгүй хүмүүсээс үзүүлсэн зээл, тусламжийн хөрөнгө, бусад орлогоос бүрдэнэ.
40	Өргөн нэвтрүүлгийн тухай	Долдугаар бүлэг. Өргөн нэвтрүүлгийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан байгууллагын эрх, үүрэг.	28.3.Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан бүрдүүлэх, түүнийг зарцуулах журмыг батална.
41	Патентийн тухай /Шинэчилсэн найруулга/	Дөрөвдүгээр бүлэг. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загвар зохиогч болон патент, гэрчилгээ эзэмшигчийн эрх	21.2.Оюуны бүтээлийн өртгийг тооцсон үнэлгээг хөрөнгийн баталгаа, барьцаа, хөрөнгө оруулалт, хувьцаа гаргах, хувьчлал болон дуудлагын худалдаанд оруулах, дүрмийн сан бүрдүүлэх, даатгалд хамруулах зэрэгт хэрэглэж болно.
42	Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай	Хоёрдугаар бүлэг. Санхүүгийн зохицуулах хороо, түүний бүрэн эрх, бусад байгууллагатай харилцах	6.1.Хороо дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 6.1.8.даатгалын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн дүрмийн сан буюу хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, түүнд тавих шаардлагыг тогтоох. /Энэ заалтыг 2009 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн хуулиар нэмсэн. /

43	Согтуурах мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай /Шинэчилсэн найруулга/	Хоёрдугаар бүлэг. Албадан эмчлэх эмнэлэг.	14.3.Албадан эмчлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ, үйл ажиллагаанд Архидан согтуурахтай тэмцэх сан болон аж ахуйн нэгж, байгууллага, хамт олон, хувь хүний хандив, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр байж болно.
44	Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай		6.1.Холбооны дүрэмд дараахь зүйлийг заавал тусгана: 6.1.7.холбооны үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө бүрдүүлэх, сан байгуулж, ажиллах журам; 7.2.Дараахь асуудлыг зөвхөн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ: 7.2.2.холбооны төсөв, тайлан, тэнцлийг хэлэлцэж батлах, орон сууцны хэвийн ажиллагааг хангах зорилгоор сан байгуулах, зээл авах; 7.2.3.холбооны сан болон зээлийн хөрөнгийн бүрдүүлэлт, ашиглалт, захиран зарцуулалтыг шийдвэрлэх;
45	Тамхины хяналтын тухай /Шинэчилсэн найруулга/	Гуравдугаар бүлэг. Тамхины хяналтын үйл ажиллагааны санхүүжилт	10.1.Иргэдэд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, тамхины хэрэглээг бууруулах зорилгоор эрүүл мэндийг дэмжих сан /цаашид “сан” гэх/ байгуулна.
46	Төв банк /Монгол банк/-ны тухай	Гуравдугаар бүлэг. Монголбанкны үйл ажиллагаа Долдугаар бүлэг. Монголбанкны өөрийн хөрөнгө, орлогын хуваарилалт	23 дугаар зүйл. Монголбанкны үйл ажиллагаанд хориглох зүйл 1. Монголбанкнаас дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 3/Засгийн газар болон банк, Хадгаламжийн даатгалын болон Ирээдүйн өв сан корпораци, Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасан шууд оролцогч, оператороос бусад хуулийн этгээд, иргэний мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалах, төлбөр тооцоо хийх, зээлийн үйл ажиллагаа эрхлэх; 36 дугаар зүйл. Дүрмийн сан. 1. Монголбанкны дүрмийн сан таван тэрбум төгрөгөөс доошгүй байх бөгөөд энэ хэмжээг гагцхүү хуулиар өөрчилнө. 37 дугаар зүйл. Монголбанкны цэвэр орлогыг тодорхойлох 1. Монголбанкны санхүүгийн жилийн цэвэр орлогыг тодорхойлохдоо дараахь зарчмыг баримтална: 5/тухайн санхүүгийн жилд гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн ханшийн зөрүүнээс үүссэн цэвэр алдагдлыг дахин үнэлгээний сан болон ерөнхий нөөцийн сангаас хааж, хүрэлцэхгүй тохиолдолд зөрүүг хуримтлагдсан алдагдлын дансанд үлдээх. 2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан орлого,зарлагыг хуримтлуулан тооцох, нөөцийн сан байгуулах,актив, пассивыг дахин үнэлэх журам, аргачлалыг Монголбанк тогтооно.

47	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай.	Нэгдүгээр бүлэг. Зургаадугаар бүлэг. Төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах	2. Энэ хууль нь улсын болон орон нутгийн төсөв, Монгол Улсын эрдэнэсийн сан, Ирээдүйн өв сангийн бүрдүүлэлт, хуваарилалт, захиран зарцуулалттай болон Монгол Улсын Хөгжлийн банк, Хадгаламжийн даатгалын корпораци, Ирээдүйн өв сан корпорацийн болон Малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад үйлчлэхгүй. 63 дугаар зүйл. Хувьчилсан өмч хөрөнгийн үнийг төлөх хөрөнгийн эх үүсвэр 2. Үнийг төлөхөд зориулж хувьчлалд зориулсан сан болон бусад эх үүсвэрээс хуульд заасан нөхцөл, журмын дагуу Засгийн газар өмчлөгчид зээл олгож болно. 65 дугаар зүйл. Хувьчлалын тайлан 3. Баталсан тайланг зохих журмын дагуу архивт тусгай сан хөмрөг болгон шилжүүлнэ.
48	Төрийн бус байгууллагын тухай	Долдугаар бүлэг. Бусад зүйл	25.1.Энэ хуульд Иргэний хуулийн 36.2-т заасаны дагуу чиг үүрэг бүхий сан хамаарах бөгөөд сан нь зөвхөн дор дурдсан зориулалтаар бусдад мөнгө хандивлаж болно: 1/төрийн бус байгууллагаас нийгмийн тусын тулд явуулж байгаа ажлыг дэмжих;
49	Төсвийн тухай /Шинэчилсэн найруулга/	Хоёрдугаар бүлэг. Төсвийн зарчим, түүнийг хэрэгжүүлэх Гуравдугаар бүлэг. Төсвийн талаарх төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрх Зургаадугаар бүлэг. Төсвийн хэрэгжилт, гүйцэтгэл	8.9.3.сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны төсвийн хагас жилийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны дотор дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх 18.2.Тусгай сан нь Засгийн газрын тусгай сан, орон нутгийн тусгай сан гэсэн төрөлтэй байна. 18.5.Засгийн газрын тусгай сан нь улсын төсвийн, орон нутгийн тусгай сан нь орон нутгийн төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна. 18.7.Эргэлтийн сан байгуулах, эргэлтийн сангийн орлого, зориулалт, зарцуулалт, тайлагналттай холбогдсон харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулна. 36.2.Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна.
50	Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай	Хоёрдугаар бүлэг. Паркийн талаар төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх	8.1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал паркийн талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.1.2.паркийн үйл ажиллагааг дэмжих орон нутгийн сан байгуулах, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих;
51	Үндэсний төлбөрийн системийн тухай	Гуравдугаар бүлэг. Зөвшөөрөл	18.4.Зөвшөөрөл эзэмшигч нь төлбөр гүйцэтгэх баталгааг хангах зорилго бүхий сан байгуулж, ажиллуулна.

52	Үнэт цаасны зах зээлийн тухай /Шинэчилсэн найруулга/	Дөрөвдүгээр дэд бүлэг. Зохицуулалттай үйл ажиллагааны төрөл	38.1.Хөрөнгө оруулалтын сан хөрөнгө оруулагчийн эрх ашгийг бүрэн төлөөлж ажиллах, сангийн хөрөнгийг үр ашигтайгаар өсгөн нэмэгдүүлэх зорилготой байна. 43.2.Тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд /цаашид “тооцооны байгууллага” гэх/ гишүүнчлэлтэй байх бөгөөд үнэт цаасны арилжааны явцад хийгдсэн гэрээ, хэлцэл цуцлагдах аливаа эрсдэлийг бууруулах зорилгоор тусгай сан байгуулж ажиллана.
53	Хадгаламж зээлийн хоршооны тухай.	Наймдугаар бүлэг. хадгаламж зээлийн хоршоодын холбоо.	54.1.Холбоо нь тогтворжилтын сан байгуулж, санхүүгийн тогтворжилтын үйлчилгээ үзүүлэхэд дараах чиг үүргийг гүйцэтгэнэ:
54	Харилцаа холбооны тухай /Шинэчилсэн найруулга/	Гуравдугаар бүлэг. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан.	11.2.Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан дараахь эх үүсвэрээс бүрдэнэ: 11.2.1.хандив, зээл, тусламжийн хөрөнгө; 11.2.2.бусад хөрөнгө.
55	Хог хаягдлын тухай. /Шинэчилсэн найруулга/	Тавдугаар бүлэг. Аюултай хог хаягдлыг савлах, түр хадгалах, тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах	32.7.Энэ хуулийн 32.6-д заасан зардлыг урьдчилан төлөх зарчмын дагуу дараахь хувилбарын аль нэгийг сонгож төвлөрүүлнэ: 32.7.1.итгэлцлийн сан байгуулах; 32.7.2.барьцаа хөрөнгө байршуулах.
	Хот тосгоны эрх зүйн байдлын тухай		8.2.Улсын зэрэглэлтэй хотын хөрөнгийн сан нь улсын ба орон нутгийн төсвөөс, аймгийн зэрэглэлтэй хот, тосгоны хөрөнгийн сан нь тухайн орон нутгийн төсвөөс тэдгээрийн мэдэлд хуваарилсан төсвийн хөрөнгө, түүнчлэн хот, тосгоны өөрийн мэдлийн аж ахуйгаас бий болсон орлого, гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүсээс өргөсөн хандив, буцалтгүй тусламж, бусад орлогоос бүрдэнэ.
	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай.	Дөрөвдүгээр бүлэг. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрх	15.6.Элсэлтийн шалгалтад тэнцэж, дотоод, гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын байгууллагад суралцах эрхтэй болсон хөгжлийн бэрхшээлтэй хүний бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын зардлыг, хөдөлмөрийн чадвараа алдсан гишүүнтэй өрхийн нэг суралцагчийн сургалтын төлбөрийг боловсролын зээлийн сан хариуцна.
	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай /Шинэчилсэн найруулга/	Тавдугаар бүлэг. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан.	22.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ: 22.1.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү; 22.1.6.гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оруулсан хандив, тусламж;
	Хөдөлмөрийн тухай /Шинэчилсэн найруулга/	Гуравдугаар дэд бүлэг Ажилтны хүлээх эд хөрөнгийн хариуцлага	134.1.Ажил олгогч өөрийн эзэмшлийн болон өмчлөлийн зүйлийн бүрэн бүтэн байдлыг хангах, хамгаалах зорилгоор эд хөрөнгөө даатгуулах, эрсдэлийн сан байгуулахдаа ажилтны цалин хөлс, эд хөрөнгөөс дайчлан авах, суутгахыг хориглоно.

Хөрөнгө оруулалтын сангийн тухай	Хоёрдугаар бүлэг. Хөрөнгө оруулалтын сангийн төрөл, хэлбэр, удирдлага, зарчим	5.1.Хөрөнгө оруулалтын сан нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.18-д заасан мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх этгээд байна. 6.1.Хөрөнгө оруулалтын сан доор дурдсан хэлбэртэй байна: 6.1.1.хамтын хөрөнгө оруулалтын сан; 6.1.2.хувийн хөрөнгө оруулалтын сан. 7.1.Хөрөнгө оруулалтын сан нь хуулийн этгээдийн эрхтэй тусгай зориулалтын компани байна.
Эрдэнэсийн сангийн тухай	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын эрдэнэсийн эх нөөцийг хамгаалах, төрийн эрдэнэсийн сан /цаашид “эрдэнэсийн сан” гэх/-г бүрдүүлэх, хамгаалах, арвижуулах, уул сангаас хөрөнгө гүйлгээнд оруулах, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
Эрүүл мэндийн даатгалын тухай /Шинэчилсэн найруулга/	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл	1.1.Энэ хуулийн зорилт нь эрүүл мэндийн албан журмын даатгалын зарчим, хамрах хүрээг тогтоож, Монгол Улсын иргэн бүр эрүүл мэндийн даатгалд хуулийн дагуу даатгуулж шимтгэл төлөх, даатгуулагчид эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийг хуваалцах зорилгоор сан бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг хуваарилах, зарцуулах, эрүүл мэндийн даатгалын байгууллага болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, төр, иргэний хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

**ЗУРГАА. ГЭР БҮЛИЙН ХОЛБОГДОЛТОЙ МАРГААНЫГ
ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГАА
(ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ)**

Судалгааг удирдсан :	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, Хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах
Судалгааг хянасан:	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль зүйн ухааны доктор С.Сүхбаатар
Судалгааг гүйцэтгэсэн:	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан Э.Анударь Дадлагажигч, МУИС-ийн ХЗС-ийн 4 дүгээр түвшний оюутан Т.Лхагважаргал

УДИРТГАЛ

Эвлэрүүлэн зуучлал нь хууль зүйн шинжлэх ухааны ойлголтоор оролцогч талуудын хооронд үүссэн маргааныг тухайн маргаанд ямар нэгэн ашиг сонирхолгүй, хөндлөнгийн гуравдагч этгээдийн оролцоо, удирдлагын дор шийдвэрлэх сонголт, хувилбарын нэг үндсэн технологи (alternative dispute resolution, ADR) юм.¹

Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудад иргэний болон гэр бүлийн эрх зүйн хэрэг, маргааныг шүүх, арбитрын журмаар шийдвэрлэхээс гадна шүүхийн бус журмаар гуравдагч этгээдийн дэмжлэгтэйгээр талуудыг эвлэрүүлэн, маргааныг шийдвэрлэх аргыг хэрэглэх болсон нь манай улсын эрх зүйн тогтолцоонд тухайн аргыг хэрэглэх нэг нөхцөл болсон юм.² Үүний дагуу 2012 онд Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль батлагдан хэрэгжээд 10 жилийн хугацаа өнгөрчээ.

Дээрх хугацаанд хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, эрдэм шинжилгээний өгүүлэл, нэг сэдэвт бүтээлүүд гарсан. Тухайлбал, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын захиалгаар гүйцэтгэсэн “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа”³, ЕАБХАБ-ын Ардчилсан Институт Хүний Эрхийн Газраас боловсруулсан “Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өгөх АИХЭГ-ын санал”⁴, ЖАЙКА-ын “Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах” төслийн хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс боловсруулсан “Эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэх ажиллагаа” гарын авлага болон бусад⁵ судалгааны ажлын бүтээлийг дурдаж болно.

Ийнхүү эвлэрүүлэн зуучлалын асуудал идэвхтэй судлагдаж байгаа хэдий ч хууль тогтоомжийг шинэчлэх ажлын хүрээнд тодорхой асуудлыг нарийвчлан судлах шаардлага байсаар байна. 2014-2020 оны шүүн таслах ажиллагааны тайлангаас үзэхэд, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа иргэний хэрэг маргаан дээр үр дүнгээ өгч байгаа боловч гэр бүлийн холбогдолтой маргааны хувьд жил бүр дунджаар 85%-с дээш хэмжээний хэрэг дээр амжилтгүй үзүүлэлттэй байгаа нь анхаарал татаж байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 12 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 1.8-т зааснаар Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн ерөнхий зөвлөл боловсруулан 2021 онд өргөн барих хуваарьтай байна. Энэ ажлын хүрээнд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ гэр бүл цуцлахтай холбогдсон маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болж буй шалтгаан, нөхцөлийг тодруулахыг зорилоо.

Иймд тус судалгаа⁶-гаар гэр бүлийн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэхэд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх арга замыг эрэлхийлэв.

1 Эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэх ажиллагаа. Гарын авлага, 2015 он, 45 дахь тал.

2 <http://www.supremecourt.mn/news/163>

3 Холбоос: https://drive.google.com/file/d/1T13rKCfRIHF84sgUFlaRHfl_5XF2xzz0/view

4 Холбоос: <https://www.osce.org/files/f/documents/a/7/452919.pdf>

5 Хууль дээдлэх ёс, 2013 он, Цуврал 6 (46)-аас дэлгэрүүлэн үзэх боломжтой.

6 Судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу боловсруулав.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэх шаардлагатай. Төлөвлөх үе шатанд дараах асуудлыг тодруулна. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох ;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.
7. Төлөвлөх үе шатанд, холбогдох асуудлын онцлогийг харгалзан зарим асуудлыг нэгтгэж, нэг дэд хэсэгт багтаан тодруулав.

1.1. Үнэлгээ хийх шалтгаан, хүрээг тодорхойлох

Монгол Улсад гэрлэлтийг захиргааны болон шүүхийн журмаар цуцалж байгаа бөгөөд Гэр бүлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасан урьдчилсан нөхцөлийг хангасан тохиолдолд буюу гэрлэлт цуцлахыг талууд харилцан зөвшөөрсөн, 18 хүртэлх насны хүүхэдгүй, эд хөрөнгийн маргаангүй гэрлэгчид гэрлэлт цуцлах хүсэлтээ бичгээр гаргана. Харин дээрх нөхцөлийг хангахгүй гэрлэгчдийн хувьд гэрлэлт цуцлах өргөдлийг шүүхэд гаргадаг.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.4-т зааснаас бусад гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааны нэг гэж үзнэ.” гэж, мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 6.3-т заасан шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журмын дагуу явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон нь шүүхэд иргэний хэрэг үүсгэснээс хойш гэр бүлийн холбогдолтой маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дахин явуулахаас татгалзах үндэслэл болохгүй.” гэж тус тус зааснаар гэрлэлт цуцлах нэхэмжлэл гаргасан гэрлэгчид заавал эвлэрүүлэн зуучлалд хандсаны дараа шүүх иргэний хэрэг үүсгэдэг болжээ.

2012 онд Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль батлагдсантай холбогдуулан энэ асуудлаар Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд өөрчлөлт оруулсан бөгөөд мөн зүйлийн 14.1 дэх хэсэгт “Гэрлэлт цуцлах асуудлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах боломжгүйгээс бусад тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдсаны дараа шүүх иргэний хэрэг үүсгэнэ.”, мөн зүйлийн 14.2 дахь хэсэгт “Шүүх шаардлагатай гэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж, энэ хугацаанд гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авна. Шүүх гэрлэгчдийг эвлэрүүлэхэд авах бүх талын арга хэмжээг эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан.

Өөрөөр хэлбэл, гэрлэгчдийн аль нэг нь гэрлэлт цуцлуулах нэхэмжлэл шүүхэд гаргасан тохиолдолд эвлэрүүлэх боломжгүйгээс бусад тохиолдолд заавал эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулж амжилтгүй болсон бол иргэний хэрэг үүсгэнэ.

Гэр бүл нь аливаа нийгмийг бүрдүүлэгч суурь нэгж, үнэт зүйл болохын хувьд төрөөс гэр бүлийн тогтвортой байдал, хүүхдийн тасралтгүй хөгжил, хүмүүжлийг хадгалах бодлогыг баримтлан гэрлэлтийг шүүхээс аль болох шууд цуцлахгүйгээр эвлэрүүлэх арга замыг эрэлхийлжээ.

Гэтэл 2018 онд шүүх дэх эвлэрүүлэн зуучлалд гэр бүлийн эрх зүйн маргааны 2,995 өргөдөл ирсэн бөгөөд үүнээс 412 өргөдөл буюу 13.6 хувьд нь амжилттай эвлэрсэн, 2019 онд гэр бүлийн эрх зүйн маргааны 3020 өргөдөл ирсэн бөгөөд үүнээс 377 өргөдөл буюу 12.4 хувьд нь амжилттай эвлэрсэн бол нийт 2,643 өргөдөл буюу 87.6 хувьд нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй явагдсан байна.⁷

ИХШХШТХ-ийн 132 дугаар зүйлийн 132.1 дэх хэсэгт “Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтоох ба гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг авна” гэж заасан. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт “Шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.1-д заасан гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, эсхүл талуудын сонгосон эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлнэ” гэжээ.

Ийнхүү шүүх гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлэх, урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар эвлэрүүлэн зуучлалыг явуулах нь тус ажиллагаа гэр бүлийн маргаанд амжилтгүй хэрэгжих үндэс болсон эсэхийг тодруулах шаардлагатай байна.

Гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлахын тулд урьдчилан шийдвэрлэх журмаар гэрлэгчдэд эвлэрэх арга хэмжээ авахыг шаарддаг улс орнуудын нэг бол Япон улс. Монгол Улсад Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн төслийг боловсруулах ажилд Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын хамтын ажиллагаа, оролцоо байсан тул тухайн орны гэр бүл дэх сэтгэлгээний соёл, онцлог, Япон улсын хувьд гэр бүлийн талаар баримталдаг бодлого манай улсын хуульд тодорхой хэмжээнд шингэсэн байхыг үгүйсгэхгүй.

Иймд тус судалгаагаар гэр бүлийн холбогдолтой маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах хуулийн зохицуулалт эвлэрүүлэн зуучлалын үндсэн зарчимд нийцэж буй эсэхийг тодруулах бөгөөд шүүхийн практикт хэрэгжиж буй байдалд дүн шинжилгээ хийх замаар хууль хэрэглээний асуудлыг тодруулна.

1.2.Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхэд сонгож авсан асуудлын онцлогоос хамааран дараах хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно. Үүнд:

- Зорилгод хүрсэн төвшин;
- Практикт нийцэж байгаа байдал.

7 “Монголын хууль тогтоомжийн нийгэмлэг” ТББ, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа, 2020 он, 59 дэх тал.

1.2.1. “Зорилгод хүрсэн төвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

2012 оны Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь эрх зүйн маргааныг шүүхийн бус аргаар эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр шийдвэрлэх эрх зүйн үндсийг тогтоох, эвлэрүүлэн зуучлалыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж заасан.

Түүнчлэн мөн хуулийн 2 дугаар зүйлд зааснаар эвлэрүүлэн зуучлалын тухай хууль тогтоомжид Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Монгол Улсын шүүхийн тухай хууль хамаарч байх бөгөөд гэр бүлийн холбогдолтой маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахад дээрх хэм хэмжээг баримтална. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд заасан үндсэн зарчим зөрчигдөж буй эсэхийг тодорхойлохын тулд эдгээр хуулийг мөн шинжлэн судлах юм.

Иймд урьдчилан шийдвэрлэх журмаар болон шүүхийн шатанд явагдах эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд дүн шинжилгээ хийх үүднээс Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн дараах зүйл, заалтад үнэлгээ хийхээр сонголоо. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1. Зорилгод хүрсэн төвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг	6.3.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.4-т зааснаас бусад гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааны нэг гэж үзнэ.
2	32 дүгээр зүйлийн 32.1, 32.2 дахь хэсэг	32.1.Энэ хуулийн 6.3-т заасан шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журмын дагуу явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон нь шүүхэд иргэний хэрэг үүсгэснээс хойш гэр бүлийн холбогдолтой маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дахин явуулахаас татгалзах үндэслэл болохгүй. 32.2.Шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.1-д заасан гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, эсхүл талуудын сонгосон эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлнэ.

1.2.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Энэхүү шалгуур үзүүлэлт нь тухайн хууль тогтоомжийн зохицуулалтын практикт хэрэгжиж буй байдал, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлоход чиглэгддэг.

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагы (ЖАЙКА)-ын захиалгаар гүйцэтгэсэн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгааны хүрээнд Шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчтай хийсэн ярилцлагад:

“...Гэр бүлийн маргаан маш их орж ирдэг. Нутаг дэвсгэр, хүн амын тоо, амьжиргааны төвшнээс хамаараад захын дүүргүүдэд хөдөө орон нутгаас шилжиж ирсэн хүмүүсийн тухайд зах зээл, эдийн засгийн хямралаас болоод гэр бүл салалт нэлээн болж байна гэж боддог. Эвлэрүүлэн зуучлагч, сэтгэл зүйч, шүүгч нь ороход болно. Орон нутагт эвлэрүүлэн зуучлагчийн нэг л орон тоо байгаа, гэр бүлийн

маргаан харьцангуй бага, орж ирсэн ч эвлэрэх магадлал өндөр, бие биенээ сайн таньдаг. Дүүргээсээ бас шалтгаалж байна. Олон жил тусдаа амьдарчихсан, өөр хүнтэй гэр бүл болчихсон, хуучин баталгаагаа салгаагүй хүмүүс их орж ирдэг. Бид нар эвлэрүүлэх гэхээр боломж байдаггүй. Орж ирж байгаа хэргүүдийн тал нь ийм нөхцөл байдалтай.”;

“...Гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэхэд бэрхшээлтэй байна. Тухайлбал нэгэнт эвлэрэхгүй нь тодорхой буюу хамтран амьдрагчтай болсон, цаашлаад хүүхэдтэй болсон маргаан бүхий хэрэг дээр эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах нь үр ашиггүй байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой маргааныг шүүх шууд хүлээн авах боломжтой ч шүүхийн зүгээс хүчирхийлэл нотлогдсон тохиолдолд хүлээн авна гээд эвлэрүүлэн зуучлалд буцаагаад байдаг. Гэвч хүчирхийлэл нь олон төрөл ба сэтгэл санаа, эдийн засгийн гээд тэр бүр шууд нотлох баримт байдаггүй тохиолдол гарч байна. Энэ нь бодит байдалд нийцэхгүй, иргэдийг дахин дахин улсын тэмдэгтийн хураамж төлүүлж чирэгдүүлэх асуудал гардаг.” гэжээ.

Гэр бүлийн тогтвортой байдал болон хүүхдийн эрхийг хамгаалахын тулд гэр бүлийн холбогдолтой маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг зайлшгүй явуулах зохицуулалт практикт бүрэн хэрэгжих боломжгүй байдаг нь дээрх ярилцлагаас харагдаж байна. Иймд практикт гарч буй зарим асуудлыг тодруулах зорилгоор хуулийн дараах зүйл, заалтыг сонгож авав. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 2. Практикт хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг	6.3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.4-т зааснаас бусад гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааны нэг гэж үзнэ.
2	32 дугаар зүйлийн 32.1, 32.2 дахь хэсэг	32.1. Энэ хуулийн 6.3-т заасан шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журмын дагуу явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон нь шүүхэд иргэний хэрэг үүсгэснээс хойш гэр бүлийн холбогдолтой маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дахин явуулахаас татгалзах үндэслэл болохгүй. 32.2. Шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.1-д заасан гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, эсхүл талуудын сонгосон эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлнэ.

1.3.Шалгуур үзүүлэлтийг томъёолох, харьцуулах хэлбэрийг сонгох

Шалгуур үзүүлэлтийг томъёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1, 32.2 дахь хэсэгт тохируулан асуулт дэвшүүлж байна.

Зорилгод хүрсэн төвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар явуулах эвлэрүүлэн зуучлах ажиллагаа болон шүүхийн шатанд эвлэрүүлэн зуучлагч, эсхүл талуудын сонгосон эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжих эвлэрүүлэн зуучлах ажиллагаа зорилгодоо хүрсэн эсэх?

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Шүүх гэр бүлийн холбогдолтой маргаанд эвлэрүүлэн зуучлалыг ашиглахад хууль хэрэглээний болон практикийн ямар асуудал үүсэж байна вэ?

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан нөхцөл, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонголоо. Үүнд:

1. Байх ёстой болон одоо байгаа эвлэрүүлэн зуучлалыг гэр бүл цуцлах маргаанд зайлшгүй байх ёстой шат болгон хэрэгжүүлэхээр хуульчилсан нь практикт ямар асуудал үүсгэж буйг судлан тогтооно.
2. Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш хууль тогтоомж хүчин төгөлдөр болсноос хойш гэр бүлийн холбогдолтой маргаанд эвлэрүүлэн зуучлал хэр амжилттай хэрэгжсэнд дүн шинжилгээ хийнэ.
3. Тохиолдол судлах- гэр бүлийн холбогдолтой маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах гадаад орны туршлага, онцлог, манай орноос ялгаатай сэтгэлгээ зэргийг харьцуулах замаар Монгол Улсын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхийг зорьж байна.

1.4. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн, практикт нийцэж буй байдлыг тодруулах зорилгоор шүүхийн практик, тухайн сэдвээр гаргасан мэргэжлийн ном, товхимол, гарын авлага, өгүүлэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, статистикийн тоо баримт, хэвлэл мэдээллийн хэрэгслийг эх сурвалж болгон ашиглав.

ХОЁР. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

2.1. “Зорилгод хүрсэн төвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар явуулах эвлэрүүлэн зуучлах ажиллагаа болон шүүхийн шатанд эвлэрүүлэн зуучлагч, эсхүл талуудын сонгосон эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжих эвлэрүүлэн зуучлах ажиллагаа зорилгодоо хүрсэн эсэх?

Эвлэрүүлэн зуучлагч бол тухайн маргаанд зуучлуулахаар талуудын сонгосон буюу зөвшөөрсөн, маргааны талаар шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий мэргэшсэн этгээд.⁸ Урьдчилан шийдвэрлэх журмаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахыг шаардах, гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг шүүх гагцхүү эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлэх нь оновчтой эсэхийг тодорхойлохын тулд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зарчим болон гэр бүлийн маргаан дахь эвлэрүүлэн зуучлалын зарчмыг авч үзэх шаардлагатай.

8 С.Нарангэрэл, Монголын эрх зүйн эх толь бичиг, Дөрөв дэх хэвлэл, 2015, 632 дахь тал.

Эрх зүйн тогтолцооноос хамааран улс орнуудын эвлэрүүлэн зуучлалын загвар ялгаатай байх нь бий. Англи-америкийн эрх зүйн загвар нь ихэвчлэн сайн дурын үндсэн дээр болон төрийн ба төрийн бус байгууллагын эвлэрүүлэн зуучлах институтц давамгайлах байдлаар илэрч байна. Харин эх газрын эрх зүйн загвар нь шүүх, эсхүл Засгийн газар, түүний дотор Хууль зүйн яамны хяналтад байж, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа шүүхийн болон төрийн тогтолцооны нэг салаа мөчир гэж үзэх хандлагатай байна.⁹

Монгол Улсын хувьд англи-америкийн болон эх газрын загварын холимог тогтолцооны хэв шинжтэй. Шүүхийн ерөнхий зөвлөл нь Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийг байгуулахын хамт анхан шатны шүүх дэх орон тооны болон орон тооны бус эвлэрүүлэн зуучлагч, мөн төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо дахь эвлэрүүлэн зуучлагчдыг сонгон ажиллуулахаар хуульд зохицуулсан байна.¹⁰

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт зааснаар эвлэрүүлэн зуучлалыг дараах 4 зарчимд үндэслэн явуулна. Үүнд:

1. Талуудын сайн дурын үндсэн дээр хэрэгжих;
2. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцогчдын нууцыг хадгалах;
3. Эвлэрүүлэн зуучлагч төвийг сахисан байр суурьтай байх;
4. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд талууд тэгш эрхтэй оролцох зэрэг болно.

Зарим судлаачид эвлэрүүлэн зуучлах ажиллагааны 10 зарчим нэрлэдэг¹¹ ч дээр дурдсан үндсэн зарчмууд гэр бүлийн эвлэрүүлэн зуучлалын үндсэн зарчим болж хэрэгжих учиртай. Гэр бүлийн маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дараах 4 тусгай зарчимтай.¹² Үүнд:

1. Сайн дурын үндсэн дээр хэрэгжих- хоёр тал хоёулаа эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн байх бөгөөд уг ажиллагаанаас аль ч үед татгалзах эрхтэй байна.
2. Төвийг сахих эвлэрүүлэн зуучлагч гэрлэгчдийн аль нэг талд орохгүй бөгөөд төвийг сахисан байр сууриас оролцоно. Талуудын санал, хүсэл зориг, бодлыг сонсож, эрх тэгш хандана.
3. Хувийн нууц хадгалах эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад олж мэдсэн бүхий л мэдээллийг нууцална. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад хэлсэн үг, гаргасан баримтууд шүүхэд ил болох ёсгүй.
4. Талууд шийдвэрээ бие даан гаргах эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үед хэлэлцэх асуудал, шийдвэрийг талууд гаргана. Эвлэрүүлэн зуучлагч хүүхдийн тэтгэмж, санхүүгийн болон эрх зүйн бусад асуудал дээр анхаарал хандуулахыг зөвлөж, мэргэжлийн туслалцаа үзүүлэх замаар тодорхой асуудал дээр шийдвэр гаргахад туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

9 Хууль зүйн үндэсний хүрээлэн. Эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэх ажиллагаа, гарын авлага, 2015, 49 дэх тал.

10 Мөн тэнд.

11 Дэлгэрүүлэн үзэх: David A. Hoffman. Ten principles of Mediation Ethics. Холбоо: <https://blc.law/wp-content/uploads/2016/12/2005-07-mediation-ethics-branchmainlanguagedefault.pdf>

12 <https://www.themediatorsusankaye.com/principles-of-mediation.html>

Дээр дурдсан зарчим 2012 оны Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд тусгалаа олсон байна. Гэсэн хэдий ч гэр бүлийн холбогдолтой маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд өөр тав дахь “албадан эвлэрүүлэх” зарчим үйлчлэх талаар Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заажээ.

Тодруулбал, ИХШХШТХ-ийн 132 дугаар зүйлийн 132.4 дэх хэсэгт зааснаас бусад гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааны эвлэрүүлэн зуучлах ажиллагааг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагааны нэг гэж зааснаар гэр бүл цуцлах маргаанд уг ажиллагаа хийгдэхгүйгээр шүүхэд иргэний хэрэг үүсгэх боломжгүй болжээ. Үүнийг Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “...гэрлэлт цуцлах асуудлаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах боломжгүйгээс бусад тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явагдсаны дараа шүүх иргэний хэрэг үүсгэнэ.” гэж хуульчилсан.

Талууд эвлэрэх боломжгүй гэж үзвэл шүүх иргэний хэрэг үүсгэсний дараа тус хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт зааснаар гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч, эсхүл талуудын сонгосон эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан дахин хэрэгжүүлнэ. Үүнийг Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт бататгасан.

ИХШХШТХ-ийн 132 дугаар зүйлийн 132.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 132.1-т заасан эвлэрүүлэх арга хэмжээг зөвхөн нэг удаа хэрэглэнэ. Шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх журмын дагуу явуулсан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй болсон байх нь шүүхэд иргэний хэрэг үүсгэснээс хойш гэр бүлийн маргааны талаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаанаас татгалзах үндэслэл болохгүй.” гэж заасан. Ийнхүү ИХШХШТХ-ийн 132.4-т заасан нөхцөл тогтоогдоогүй бол гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хоёр удаа явуулах шаардлагатай.

2012 оны Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль батлагдахаас өмнө Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Шүүх шаардлагатай гэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж, энэ хугацаанд гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авна” гэж заасан байсан бөгөөд эвлэрүүлэхэд авах бүх талын арга хэмжээг эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлэх тухай зохицуулалт байгаагүй.

Улсын дээд шүүхийн 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн “Гэр бүлийн болон иргэний бүртгэлийн тухай хуулиудын зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай” 46 дугаар тогтоолын 9.2-т гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг дараах байдлаар тайлбарладаг байв. Үүнд:

- Шүүх шаардлагатай гэж үзвэл- гэрлэлт цуцлах тухай хэрэг бүрийн онцлогоос шалтгаалан гэрлэлтийг зайлшгүй цуцлах ноцтой шаардлага байхгүй, гэрлэгчдийг эвлэрүүлэх бололцоотой, тэдний болон хүүхдийн эрх ашгийг хамгаалах үүднээс гэрлэлтийг цуцлахгүй байх нь илүү ач холбогдолтой байх нөхцөлүүдийг хамааруулна.
- Гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ- гэрлэгч тус бүртэй ганцаарчлан уулзах, зөвлөгөө өгөх, гэрлэлт цуцлуулах болсон шалтгаануудыг нарийвчлан судалж, үндэслэлтэй эсэхийг нь тайлбарлах, шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгчдийг татан оролцуулах зэрэг гэрлэгчдийг эвлэрүүлэхэд ач холбогдолтой бүхий л үйл ажиллагааг хэлнэ.

- Гэрлэгчид эвлэрэх боломжгүй- эхнэр, нөхрийн хэн нэг нь согтууруулах ундаа болон мансууруулах бодис байнга хэрэглэдэг, гэр бүл, үр хүүхдийн амьдрал, хүмүүжилд муугаар нөлөөлдөг, гэр бүлийн гишүүдийг хүндэтгэн үзэхгүй, хэрцгий догшин авирладаг, бэлгийн харьцаа тохирдоггүй, үр хүүхэдтэй болоогүй, гэрлэгчид гэр бүлээ үргэлжлүүлэх санаачилга гаргалгүй удаан хугацаагаар тусдаа амьдарсан зэргийг хамааруулж үзнэ.

Түүнчлэн Улсын дээд шүүхийн 2010 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь зохигчдыг эвлэрүүлэх шүүгчийн ажиллагааны тухай” 02 дугаар зөвлөмжид дараах зүйлийг тайлбарлаж, анхааруулсан байдаг. Үүнд:

- Талууд бусдын албадлагагүйгээр өөрийн ухамсарт ажиллагааны үр дүнд маргааныг зохицуулах нь тэдний сэтгэл санаа, эд хөрөнгө, цаг завьг барахгүйгээс гадна эрх зүйн ухамсрыг нь дээшлүүлэх үндэс суурь болохын зэрэгцээ дахин энэ төрлийн харилцаанд алдаа зөрчилгүй оролцох боломжийг бүрдүүлдэг учир шүүгч талуудад маргааны шалтгаан, нөхцөлийг тайлбарлах, алдаа, зөрчлийг нь ойлгуулах ажиллагаа явуулсны эцэст тэдгээрт өөрсдөө тохиролцох боломжийг нь олгох учиртай. Эвлэрэх болон муудалцах үйлдлийг хүн зөвхөн өөрийн хүсэл зоригоор хийдэг учир шүүх эвлэрэх хүсэл зоригийг нь өдөөх л ажиллагаа явуулахаас бус ямар нэгэн хэлбэрийн дарамт үзүүлэхгүй гэдгийг онцгой анхаарах учиртай.
- Шүүгч иргэний хэрэг маргааны талуудыг эвлэрүүлэх талаар хуульд зааснаас өөрөөр идэвхтэй ажиллагаа явуулах нь зарчмын олон хэм хэмжээгээр хязгаарлагддаг ч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.1, Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасан “Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг тогтоох ба гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авна” гэсэн зохицуулалтаар гэрлэгчдийг эвлэрүүлэх талаар идэвхтэй ажиллах боломжийг шүүхэд олгожээ. Гагцхүү ийнхүү хийх ажиллагаа бүрийг шүүгч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасныг баримтлан тэмдэглэл хөтлөх, үзлэг хийх, туршилт явуулах, шинжээч томилох зэрэг хуульд заасан ажиллагаануудын аль тохирох хэлбэрээр явуулбал тухайн ажиллагааны хууль ёсны байдал хангагдах боломжтой болно.
- Шүүгч гэрлэгчдийг эвлэрүүлэхийн тулд гэрлэгч тус бүртэй ганцаарчлан уулзах, санал бодлыг нь сонсох, гэрлэлт, гэрлэгчдийн эрх, үүргийн талаарх тухайн хүний ойлголтыг тодруулах, үр хүүхдийн хүмүүжил, ирээдүйд гэрлэлт цуцлалт хэрхэн нөлөөлдөг талаар ном, нийтлэл, кино үзүүлэх, гэрлэлт цуцлуулах болсон шалтгааныг нарийвчлан судлах, гэрлэгчдийн найз, садан төрлийн хүмүүстэй уулзах зэргээр гэрлэлт цуцлуулах бодит үндэслэл, шалтгаан байгаа эсэхийг сайтар тогтоосны эцэст гэрлэлтийг цуцлах, эсхүл гэрлэгчдэд эвлэрэх хугацаа өгч, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхийг тус тус шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд сэтгэл судлаач, сурган хүмүүжүүлэгч, хүүхдийн болон холбогдох бусад байгууллагын ажилтнуудыг дээрх ажиллагаанд татан оролцуулж болно гэж заасан.

Үүнээс харахад, 2012 оноос өмнө Улсын дээд шүүхээс гаргасан тайлбар, зөвлөмжид талуудын эвлэрэх хүсэл зоригийг өдөөх л ажиллагаа явуулахаас бус ямар нэгэн хэлбэрээр дарамт үзүүлэх үндэслэлгүйг онцгой анхаарах ёстойг тэмдэглэж байжээ. Түүнчлэн шүүхээс гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг өргөн хүрээнд ойлгохыг зөвлөсөн нь оновчтой байна. Гэтэл Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль батлагдсаны дараа тус хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт “Шүүх гэрлэгчдийг эвлэрүүлэхэд авах бүх талын арга хэмжээг эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлнэ хэмээн цар хүрээг нь хумьжээ.

Үнэхээр л гэрлэлтээ цуцлуулах гэж буй гэр бүлд эвлэрүүлэх бүхий л төрлийн арга хэмжээ авах юм бол зөвхөн эвлэрүүлэн зуучлагч ч биш нийгмийн ажилтан, гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн, сэтгэл зүйч нарын хамтарсан баг тухайн гэр бүлтэй ажиллаж болно.¹³

Шүүх гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг дангаараа авч хэрэгжүүлэх боломжгүй учраас эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлэх нь тохиромжтой гэж зарим судлаач үздэг. Эл үндэслэлээ тайлбарлахдаа: “Гэр бүлийн тухай хуульд “шүүх гэрлэгчдэд эвлэрэх бүх шатны арга хэмжээ авна” гэж зааж өгсөн боловч энэ нь төдийлөн сайн хэрэгжихгүй, ийм боломж шүүхэд эвлэрүүлэн зуучлагчтай харьцуулахад бага байна. Хэргийн оролцогчтой шүүх тэр бүр уулзаж санаа бодлыг нь чөлөөтэй сонсох, ярилцах боломжгүй бөгөөд энэ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиар тогтоосон дэгийн дагуу явагддагтай холбоотой байж болно. Магадгүй шүүхэд эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэй гэр бүл цуцлах асуудлыг шийдвэрлэх талуудын зөв шийдвэр, харилцан ойлголцол нь гэр бүл цуцлах асуудлыг ч зогсоож болох юм”¹⁴.

Гэвч шүүх хэргийн оролцогчидтой тэр бүр уулзах боломжгүй байх нь эвлэрүүлэн зуучлагчид албадан шилжүүлэх үндэслэл болохгүй бөгөөд ингэснээрээ гэр бүл цуцлах асуудлыг зогсоогоогүй нь доорх тоон мэдээллээс харагдаж байна.

Хүснэгт 3. Гэрлэлт, цуцлалтын тоон статистик¹⁵



13 Б.Дугармаа, Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд тулгамдаж буй асуудал, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2019 он, №4, 113 дахь тал.

14 Олон Улсын эрх зүйн хөгжлийн байгууллага, Эвлэрлийн гэрээ, арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудсыг гүйцэтгэх ажиллагаа, 2015 он, 10 дахь тал.

15 <https://www.1212.mn>

Шүүх иргэний хэрэг үүсгэхээс өмнө болон дараа эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулахгүйгээр гэрлэлтийг цуцалж болох ганцхан нөхцөлийг ИХШХШТХ-ийн 132 дугаар зүйлийн 132.4 дэх хэсэгт хуульчилсан. Тодруулбал, гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон байх нөхцөл юм.

Дээрх нөхцөл байдал тогтоогдсон тохиолдолд гэрлэгчдэд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг урьдчилан шийдвэрлэх журмаар явуулахгүйгээр гэрлэлт цуцлах нэхэмжлэлийг шүүх хянан үзээд, шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлэхгүйгээр гэрлэлтийг цуцлах боломжтой.

Үүнийг мөн Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүх энэ хуулийн 14.2-т заасан эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцална.” гэж зохицуулсан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт зааснаар гэр бүлийн хүчирхийлэл нь бие махбодын, сэтгэл санааны, бэлгийн болон эдийн засгийн хэлбэрээр илэрнэ. Улсын дээд шүүхийн 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 47 дугаар тогтоолд эдгээр хэлбэрийн хүчирхийллийг дараах байдлаар тайлбарласан. Үүнд:

1. Бие махбодын хүчирхийлэл- энэ хуулийн 3 дугаар зүйлд¹⁶ заасан этгээд нөгөө этгээдээ өөрийн эрхшээлд байлгах, гэр бүлийн харилцаанд давамгайл байдал тогтоох зорилгоор хүч хэрэглэн биед нь халдсаныг;
2. Сэтгэл санааны хүчирхийлэл- энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд дээрх зорилгоор нөгөө этгээдээ айлган сүрдүүлэх, заналхийлэх, мөрдөн мөшгөх, доромжлох, нэр төр алдар хүндийг гутаах, ах дүү, хамт олноос нь тусгаарлах, хүсэл зоригийнх нь эсрэг үйлдэл хийлгэхийг албадах, тулган шаардах зэргээр үг яриа, үйл хөдлөлөөрөө сэтгэл санааны дарамтад оруулсныг;
3. Бэлгийн хүчирхийлэл- энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд дээрх зорилгоор нөгөө этгээдийнхээ бэлгийн халдашгүй байдал, бэлгийн эрх чөлөөг зөрчсөн, хүүхдээ бэлгийн харилцаанд оруулахаар завдсан, оруулсан, бэлгийн шинжтэй бусад үйлдэлд уруу татсан, шаардсан зэрэг үйлдлийг;
4. Эдийн засгийн хүчирхийлэл- энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд дээрх зорилгоор нөгөө этгээдийнхээ хөдлөх ба үл хөдлөх, түүнчлэн мөнгөн хөрөнгө, цалин хөлсийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг хууль бусаар хязгаарласныг тус тус ойлгоно.

16 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээдэд эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд; тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү; энэ хуулийн зохицуулалтад гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд нэгэн адил хамаарахаар заасан.

Бие махбодын хүчирхийлэл гэж хүний амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан, эсхүл учруулж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхгүйг хэлдэг.¹⁷ Үүнээс үзэхэд, бие махбодын хүчирхийлэл үйлдэхээс бусад тохиолдолд гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирсныг тогтооход бэрхшээлтэй байна.

Харин бэлгийн хүчирхийлэл үзүүлснийг нотлохын тулд Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, 12.1 дүгээр зүйлийн 2.3 дахь заалтад заасан гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэх, мөн зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндэх гэмт хэргийг үйлдсэн нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, эсхүл Зөрчлийн тухай хуулийн 5.4 дэх хэсэгт заасан зөрчлийг үйлдсэн болохыг тогтоосон байх шаардлагатай.

Ийнхүү ИХШХШТХ-ийн 132 дугаар зүйлийн 132.4 дэх хэсэгт заасан нөхцөл байдал үүссэн гэдэгт бие махбодын болон бэлгийн хүчирхийлэл үйлдсэнийг нотолсон байхыг ойлгож байна. Учир нь сэтгэл санааны болон эдийн засгийн хүчирхийллийг нотлоход төвөгтэй байдаг. Сэтгэл санааны хүчирхийлэл зайлшгүй хүний амь нас, эрүүл мэндэд материаллаг хохирол учруулснаар тогтоогдох ёсгүй.

Мөн гэр бүлийн хүчирхийллийн эдийн засгийн хэлбэр нь эдийн засгийн хараат байдалд оруулах, эсхүл эд хөрөнгийн хохирол учруулдаг тул хүний амь нас, эрүүл мэнд, хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учруулснаар тогтоогдох буюу хэмжигдэх боломжгүй юм.

Гэр бүлийн хүчирхийлэл байнгын буюу давтамжтай үйлддэгээрээ онцлог. Гэр бүл цуцлах нь өөрөө хүчирхийллийн нэг сөрөг үр дагавар болдог хэдий ч хүчирхийлэлтэй гэр бүлд өсөн торниж байгаа хүүхэд залуучуудын бие махбод, эрүүл мэндийн хэвийн хөгжил, нийгэмших үйл явцад сөргөөр нөлөөлдөг.¹⁸ Ихэнх тохиолдолд хүүхдүүд өөрсдөө шууд хүчирхийлэлд өртөхгүй ч эх, гэр бүлийн гишүүдийнх нь эсрэг үйлдэгдэж буй хүчирхийллийг харж, сонсдог. Аль ч тохиолдолд хүүхэд хүчирхийллээс болж зовж шаналдаг ба хамгаалагдах хэрэгцээтэй байдаг.¹⁹

Тиймээс гэрлэгчдийн эвлэрэх боломжгүй нөхцөлийг гагцхүү бие махбодын хүчирхийлэл үйлдэж, гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой аюул, хор уршиг учруулсан, эсхүл учруулж болзошгүй нь тогтоогдсон байхаар хуулиар хатуу хязгаарлах нь учир дутагдалтай бөгөөд хүчирхийлэлтэй гэр бүлд хүүхдийг байлгасаар байх нь хүний эрхийн зөрчил мөн.

Шүүхийн шатанд гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гэр бүлийн гэрлэлт цуцлах нэхэмжлэлийг хүлээн авахдаа аливаа шаардлага, цензур, холбогдох нотлох баримтыг шаардаж шалтаг заан буцаахгүй байхад анхаарах хэрэгтэй²⁰ байгааг судлаачид онцолж байна.

Дүгнэвэл, хүчирхийлэл үйлдэгдсээр байтал нотлохыг шаардаж, гэрлэлт цуцлах нэхэмжлэлийг хүлээж авахгүй байх Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 6

17 Олон Улсын хөгжлийн эрх зүйн байгууллага, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын ажилтны гарын авлага, 2017 он. 63 дахь тал.

18 Гэр бүлийн хүчирхийллийг судалж, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх нь, ХЭҮТ, 2011 он.

19 Олон Улсын хөгжлийн эрх зүйн байгууллага, Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээ, 2020 он, 19 дэх тал.

20 Б.Дугармаа, Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд тулгамдаж буй асуудал, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2019 он, №4, 112 дахь тал.

дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, хүчирхийлэл тогтоогдохоос нааш эвлэрүүлэн зуучлах ажиллагааг зайлшгүй явуулахаар заасан Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.2 дахь хэсэг, Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг нь тус тус хүүхдийн болон гэр бүлийн гишүүдийн эрх, эрх чөлөөг хязгаарласан зохицуулалт болжээ. Ийнхүү хязгаарлах нөхцөл нь эдгээр хуулийн заалт зорилгодоо нийцэхгүй, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа талуудын сайн дурын үндсэн дээр хэрэгжих зарчимтай зөрчилдөж байгааг илтгэж байна.

2.1.1. Харьцуулсан судалгаа

Монгол Улс эвлэрүүлэн зуучлалын холимог загвартай улс бөгөөд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд гэр бүлийн эрх зүйн маргаанд эвлэрүүлэн зуучлалыг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагаа болгон заасан нь Япон улсын жишигтэй төстэй байх тул тухайн улсын зохицуулалтыг судлахаар сонгов. Түүнчлэн эх газрын эрх зүйн хэв шинжийг хадгалсан эрх зүйн тогтолцоотой болохын хувьд Бүгд Найрамдах Франц улсын гэр бүлийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зарчим, онцлогийг судлах болно.

I. Япон улс

Япон улсын шүүх дэх эвлэрүүлэн зуучлалын тогтолцоо нь 90 гаруй жилийн түүхтэй бөгөөд гэр бүлийн хэрэг маргаан нь гэр бүлийн шүүхэд харьяалагдана. Шүүх дэх эвлэрүүлэн зуучлал нь Иргэний хэрэг эвлэрүүлэн зуучлах тухай хууль, Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулагддаг.

Монгол Улстай харьцуулахад, иргэний болон гэр бүлийн эрх зүйн маргаан дахь эвлэрүүлэн зуучлах ажиллагааг тусдаа хуулиар зохицуулсан нь тэдгээр ажиллагааны онцлог процессыг салгаж бэхжүүлсэн давуу талтай байна. Энэ нь Япон улсад Гэр бүлийн дагнасан шүүх үйл ажиллагаагаа явуулдагтай холбоотой байх боломжтой.

Япон улсын гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 257 дугаар зүйлд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь шүүхээс гадуурх урьдчилан шийдвэрлэх ажиллагаа байх агуулга бүхий зохицуулалт байдаг нь Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгтэй төстэй байна.

Хүснэгт 4. Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль²¹

257 дугаар зүйл.Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг түрүүлж явуулах зарчим (Principle of Conciliation First)	
1. Энэ хуулийн 244 дүгээр зүйлд заасны дагуу эвлэрэх боломжтой тохиолдолд нэхэмжлэл гаргах хүсэлтэй этгээд нь эхлээд гэр бүлийн шүүхийн дэргэдэх эвлэрүүлэн зуучлагчид өргөдөл гаргах ёстой.	
2. Хэрэв өмнөх хэсэгт заасан нөхцөл үүссэн байхад аливаа этгээд эвлэрүүлэн зуучлагчид өргөдөл гаргалгүйгээр гэр бүлийн шүүхэд нэхэмжлэл гаргасан бол шүүх өөрийн эрх хэмжээний хүрээнд тухайн хэргийг дотоодын асуудал хариуцсан эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлэх ёстой. Тухайн хэргийг эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлэх нь зохимжгүй гэж шүүх үзсэн тохиолдолд энэ заалт хамаарахгүй.	
3. Хэрэв шүүх өмнөх хэсэгт заасны дагуу хэргийг шилжүүлэхээр бол уг хэрэг нь гэр бүлийн шүүхээр эцэслэн шийдвэрлэж болох буюу гэр бүлийн шүүхийн харьяалалд хамаарах ёстой. Харин шүүхээс аливаа хэргийг дотоодын асуудал хариуцсан эвлэрүүлэн зуучлагч руу явуулахын тулд тухайн хэргийг хянан үзэх зайлшгүй шаардлагатай гэж үзвэл гэр бүлийн шүүх, эсхүл тухайн хэргийн харьяалал бүхий шүүх уг хэргийг эвлэрүүлэн зуучлагч уруу шилжүүлэхээс өмнө хянан үзэж болно.	

21 http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=&id=2323

244 дүгээр зүйл
Гэр бүлийн шүүх нь гэр бүлийн байдал болон бусад гэр бүлийн харилцаанаас үүдэлтэй маргаанд (1 дүгээр хавсралтад зааснаас бусад маргаанд) эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах ёстой бөгөөд хуулийн энэ бүлэгт заасны дагуу хянан шийдвэрлэнэ.
1 дүгээр хавсралт
• Насан хүрсэн хүний асран хамгаалалт • Асран хамгаалах (Curatorship) • Харгалзан дэмжих (Assistance) • Ирээдүйд бий болох эд хөрөнгийн удирдлага (Administration of property absentee) • Сураггүй алга болсонд тооцох • Гэрлэлт • Үрчлэлт • Тэжээн тэтгэх үүрэг (Parental authority) • Насанд хүрээгүй хүүхдийг асран хамгаалах (Guardianship of Minor) • Дэмжлэг (Support) • Хууль ёсны хоёрдугаар зэргийн өв залгамжлал (Disinheritance of Presumptive Heir) • Өв залгамжлалыг хүлээн авах, татгалзах (Acceptance and Renunciation of Inheritance) • Эд хөрөнгө хуваах (Separation of Property) • Өв залгамжлагч байхгүй тохиолдол (Nonexistence of Heir) • Гэрээслэл (Will) • Өв залгамжлах эд хөрөнгийн хэмжээ (Heir's Legally Reserved Portion) • Сайн дураараа асран хамгаалах хэлцэл (Voluntary Guardianship Contract Act) • Гэр бүлийн бүртгэл (Family Register Act) • Хүйс солиулах (Act on Special Cases in Handling Gender for People with Gender Identity Disorder) • Хүүхэд хамгааллын харилцаа (Child Welfare Act) • Сэтгэцийн эрүүл мэнд болон хөгжлийн бэрхшээлтэй этгээдийг хамгаалах харилцаа (Act on Mental Health and Welfare for the Mentally Disabled)

Үүнээс үзэхэд, тус хуулийн 257 дугаар зүйлд гэр бүлийн холбогдолтой маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг иргэний хэрэг үүсгэхээс өмнө явуулах зарчмыг тусгажээ. Ингэхдээ мөн зүйлийн 2 дахь хэсэгт шүүх талуудыг эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлэх нь зохимжгүй гэж үзсэн тохиолдолд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг явуулахгүйгээр хэргийг хянан шийдвэрлэх юм. Зохимжгүй гэдэгт ямар нөхцөлийг ойлгохыг дараах байдлаар хуульчилжээ.

Хүснэгт 5. Япон улсын Иргэний хууль²²

Иргэний хуулийн 763 дугаар зүйл
a. Гэрлэгчдийн аль нэг нь ёс суртахуунгүй үйлдэл гаргасан; b. Эхнэр/нөхөр өөрийн нөхөр/эхнэрийнхээ итгэлийг эвдэх байдлаар хаяж явсан; c. Эхнэр/нөхөр нь амьд эсхүл нас барсан эсэх нь гурваас доошгүй жил тодорхойгүй байсан; d. Эхнэр/нөхөр нь хүнд өвчин туссан бөгөөд эдгэрэх найдвар байхгүй; e. Гэрлэлтийг цуцлахаас аргагүйд хүргэсэн бусад ноцтой шалтгаан байгаа тохиолдолд гэрлэгчид хоёулаа зөвшөөрсний үндсэн дээр гэрлэлтийг цуцална.

Шүүх хэргийн нөхцөл байдлаас шалтгаалан өөрийн эрх хэмжээний хүрээнд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг заавал явуулахгүй байх уян хатан зохицуулалт нь практикт үүсэх асуудлыг шийдвэрлэх чухал ач холбогдолтой. Харин Япон улсын хувьд зохимжгүй гэдэгт ямар нөхцлийг ойлгохыг тодорхой хуульчилсан байна.

Монгол Улсын Эвлэрүүлэн зуучлах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн зохицуулалт Япон улсын Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 257 дугаар зүйлд заасантай төстэй байх боловч эвлэрүүлэн зуучлал явуулахгүй шийдвэрлэх шүүхийн эрх хэмжээг олгоогүй

22 <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?printID=&id=2057&re=02&vm=02>

байдлаараа дутагдалтай болжээ. Өөрөөр хэлбэл, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд Япон улсын “эвлэрүүлэн зуучлах ажиллагааг эхний ээлжид явуулах” зарчмыг оруулахдаа Япон улсаас илүү хатуу, албадлагын шинжтэй зохицуулалтыг хуульчилсан байна.

Япон улсын Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 244 дүгээр зүйлд мөн хуулийн 1 дүгээр хавсралтад зааснаас бусад хэрэг маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг урьдчилж явуулах тухай заасан. 1 дүгээр хавсралтад гэр бүл цуцлахаас бусад гэр бүлийн маргаан хамаарч байна. Өөрөөр хэлбэл, гэр бүл цуцлах маргааны тухайд нь урьдчилан шийдвэрлэх журмаар эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд хамаарч байна.

Талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах өргөдлөө гаргаагүй нөхцөлд шүүх дотоодын асуудал хариуцсан эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлдэг байна. Энэ хэм хэмжээ нь эвлэрүүлэн зуучлагчид гаргах өргөдлийг гэрлэгчид сайн дураараа гаргах үүрэг олгож байгаа хэдий ч тус өргөдлийг гаргахгүйгээр гэрлэлт цуцлах нэхэмжлэлээ шүүхэд гаргах боломжтой байх тул “талуудын сайн дурын үндсэн дээр хэрэгжих” зарчимтай зөрчилдөж байна.

Иймд Монгол Улс гэр бүлийн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг урьдчилан явуулах зарчмыг Япон улсын хуулиас нутагшуулсан ч шүүх талуудыг эвлэрүүлэх нь зохимжгүй гэж үзвэл эвлэрүүлэх ажиллагаа явуулахгүй байх уян хатан зохицуулалтыг бий болгоогүй нь олон янз зарим төрлийн маргааныг зохистой шийдвэрлэх боломжийг хязгаарлажээ.

II. Бүгд Найрамдах Франц Улс

Эх газрын эрх зүйн бүлийн улс орнууд эвлэрүүлэн зуучлалыг төрийн хяналттай хэрэгжүүлэхийн сацуу талуудын сайн дурын үндсэн дээр байх зарчмыг бүрэн хангах тал дээр анхаарч байна. Уг зарчим Европын орнуудад нийтлэг байдлаар хэрэгждэг тул Бүгд Найрамдах Франц Улсын эрх зүйн зохицуулалтыг судлахаар сонгосон.

Франц улсад гэр бүлийн эвлэрүүлэн зуучлах ажиллагааг Иргэний хуулиар зохицуулсан. Тус хуулийн 255 дугаар зүйлийн 255.1 дэх хэсэгт “шүүгч гэрлэгчдэд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг санал болгож болох ба талуудын зөвшөөрлийг авсны үндсэн дээр эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хөтлөн явуулах гэр бүлийн эвлэрүүлэн зуучлагчийг томилно”²³ гэжээ.

Шүүгч гэр бүлийн холбогдолтой маргааныг талуудын зөвшөөрлийг авсны үндсэн дээр эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлж болохоор хуулиар зохицуулсан бөгөөд гэр бүлийн маргааныг эвлэрүүлэн зуучлалд шилжүүлэх эрхийг шүүгчид олгожээ.²⁴

Эвлэрүүлэн зуучлал талуудын сайн дурын үндсэн дээр хэрэгжих зарчмын хүрээнд оролцогч тал эвлэрүүлэн зуучлах журмаар маргаанаа зохицуулах талаар өөрийн хүсэл зоригийг аливаа дарамт, шахалтгүйгээр чөлөөтэй илэрхийлэх, эвлэрүүлэн зуучлагчаар маргаанаа шийдвэрлүүлэхийг зөвшөөрөх, татгалзах эрхтэй. Уг зарчим Франц улсын Иргэний хуулийн 255 дугаар зүйлийн 255.1 дэх хэсэгт бүрэн тусгалаа олсон байна.

23 https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070721/LEGISCTA000006165746/#LEGISCTA000038310884

24 Д.Гангабаатар, Гадаад орнуудын туршлага ба эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дагаврыг үнэлэх нь, “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2013 он, №6, 65 дахь тал.

Монгол Улсын хувьд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт шүүх талуудыг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлэхээр заасан тул гэрлэгчдэд болон шүүхэд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах болон түүнээсээ татгалзах эрх олгоогүй байна.

Дүгнэвэл, Франц улсад гэр бүлийн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахыг шүүх талуудад санал болгож, тэдний зөвшөөрлийг авсны үндсэн дээр хэрэгжүүлж байгааг Монгол Улс нутагшуулан бий болгох боломжтой гэж үзлээ.

2.2. “Практикт нийцэж буй байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1, 32.2 дахь хэсгийн зохицуулалт нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа сайн дурын үндсэн дээр хэрэгжих зарчимд нийцэхгүй байгааг өмнөх хэсэгт тогтоосон билээ. Энэ нь практикт ямар асуудал үүсгэж буйг судлан тогтооё.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг 2002 онд баталж, 2013 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсөн бөгөөд иргэний хэргийн анхан шатны бүх шүүхэд орон тооны эвлэрүүлэн зуучлагч ажиллаж, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шинэ аргыг нэвтрүүлсэн юм. Үүнээс хойш эвлэрүүлэн зуучлалд гаргасан өргөдлийг шийдвэрлэсэн үзүүлэлтийг Хүснэгт 5, 6-аас үзнэ үү.

Хүснэгт 6. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хэрэгжилт²⁵



25 Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан 2014-2020 оны “Шүүн таслах ажиллагааны тайлан”-аас нэгтгэн боловсруулав.

Хүснэгт 7. Гэр бүлийн маргаан дахь эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хэрэгжилт

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс жил бүр гаргадаг “Шүүн таслах ажиллагааны тайлан”-аас үзэхэд, эвлэрүүлэн зуучлалд шилжүүлдэг нийт маргааны тоо жил ирэх тусам өсөж байна. 2014 онд иргэн, хөдөлмөр, гэр бүлийн эрх зүйн 2,243 маргааныг эвлэрүүлэн зуучлалд шилжүүлснээс 44% нь амжилттай эвлэрсэн бол 2016 онд 12,589 маргааны 71%, 2017 онд 13,737 маргааны 73%, 2018 онд 12,092 маргааны 72%, 2019 онд 12,860 маргааны 72%, 2020 онд 14,720 маргааны 71% нь тус тус амжилттай эвлэрсэн үзүүлэлттэй байна. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа иргэний маргаанд нийт үзүүлэлтээр амжилттай хэрэгжиж, шүүхийн ачааллыг хөнгөлж байна гэж үзэж болох юм.

Харин гэр бүл цуцлах маргааны тухайд үүнээс эсрэг үр дүн гарч байгаа нь харамсалтай. Тухайлбал, 2014 онд гэр бүлийн 2,243 маргааныг эвлэрүүлэн зуучлалд шилжүүлснээс 82% нь амжилтгүй болсон бол 2016 онд 2,707 маргааны 88%, 2017 онд 2,859 маргааны 86%, 2018 онд 2,995 маргааны 86%, 2019 онд 3,020 маргааны 88%, 2020 онд 88%-д тус тус амжилтгүй буюу эвлэрээгүй үзүүлэлттэй байна.

Зуучлалаар хэлэлцэж тохиролцсон зүйлс болон эвлэрлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэх нь эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилттай болсон эсэхийг тогтоож, үр дүнг илтгэдэг үндсэн шалгуур юм.²⁶ Иргэний маргаантай харьцуулахад гэр бүлийн эрх зүйн маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа заавал хэрэгжүүлэхээр хатуу зохицуулсан. Иймээс эвлэрэх боломжгүй, эсхүл хүсэл зориггүй, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулаад үр ашиггүй гэрлэгчдийн эвлэрээгүй тохиолдлын эзлэх хувь өндөр байх магадлалтай.

Гэр бүл цуцлалтын тоог үзүүлэлт жил ирэх тусам өсөж байгаа бөгөөд гэрлэлтээ цуцлуулах шалтгаан, нөхцөл ч өөрчлөгдсөөр байна. Ямар шалтгаанаар гэрлэлтээ цуцлуулж байгааг судалснаар шүүхээс шийдвэрлэж буй хэргийн нөхцөл байдлыг ерөнхий байдлаар тодорхойлж болох бөгөөд эвлэрүүлэн зуучлах ажиллагааг зайлшгүй хэрэгжүүлэх бодлого баримтлах эсэхэд дүн шинжилгээ хийх боломжтой. Үүнийг Хүснэгт 7-д харьцуулсан болно.

26 Joan B. Kelly. A Decade of Divorce Mediation Research. Family Court Review 34, no.3. 1996, p.373-385

Хүснэгт 8. Гэр бүл цуцлах өргөдөл өгсөн шалтгаан²⁷

2010 онд хийгдсэн судалгааны үр дүн	2017 онд хийгдсэн судалгааны үр дүн
Үзэл бодол таараагүй (26.3%)	Тусдаа амьдарч байгаа (43%)
Архидалт (22.5%)	Таарамжгүй харилцаа, хэрүүл маргаантай, үзэл бодол таараагүй (41.6%)
Гэр бүлээс гадуурх бэлгийн харилцаа (20%)	Гэр бүлээс гадуурх бэлгийн харилцаа (25.9%)
Боловсрол, соёлын түвшин (8.8%)	Бие махбодын хүчирхийлэл (23.4%)
Үр хүүхэдгүй учраас (7.5%)	Архидалт (23.3%)
Эцэг эхийн шахалт (5%)	Тус тусдаа гэр бүлтэй болсон (20.4%)
Амьдралын түвшин харилцан адилгүй	Сэтгэл санааны дарамт, хүчирхийлэл (13.5%)
Хадмуудын нөлөө (3.8%)	Гэрээсээ хол ажилладаг, гадаадад байдаг (8.0%)
Тээвэрт их явдаг (1.3%)	Харааж зовоодог (6.2%)
	Эцэг эхийн үл ойлголцол, хамаатны таарамжгүй харилцаа (5.2%)

Үүнээс харахад, 2010 онд гэр бүл цуцлалтын нийтлэг шалтгаанд үзэл бодол таараагүй, архидалт болон бусад хувийн шинжтэй шалтгаан орж байсан бол 2017 онд тусдаа амьдарч байгаа, бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэл, тус тусдаа гэр бүлтэй болсон зэрэг шалтгаанаас болж гэр бүл цуцлалтын тоо нэмэгдсэн болох нь судалгааны дүнгээс харагдаж байна.

2017 онд, гэрлэгчид тусдаа амьдарч байгаа гэх шалтгаанаар гэр бүлээ цуцлуулсан тохиолдол нийт цуцлалтын 43% буюу тал хувийг эзэлж байна. Ийм нөхцөл байдалтай гэрлэгчид шүүхийн журмаар гэрлэлтээ цуцлуулах тохиолдолд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 32 дугаар зүйлийн 32.1, Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу заавал эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулна.

Түүнчлэн Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2, Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, ИХШХШтХ-ийн 132 дугаар зүйлийн 132.2 дахь хэсэгт заасны дагуу шүүх талуудыг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлэх ёстой. Гэтэл практикт дээрх тохиолдолд талууд тус тусдаа гэр бүлтэй болсон учир эвлэрэх ямар ч боломжгүй учраас шүүх дээр хуулийн хэм хэмжээг зөрчиж, гэрлэлтийг шууд цуцалж байна. Үүнийг иргэний хэргийн анхан шатны шүүхийн 8 шийдвэрийг түүвэрлэн авч, дүн шинжилгээ хийх замаар тодруулсныг Хүснэгт 8-д харуулав.

27 “Good Neighbors” олон улсын байгууллагаас хийсэн “Гэр бүлийн маргаан болон эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцож буй мэргэжилтнүүдийг чадавхижуулах төсөл”-ийн хүрээнд эвлэрүүлэн зуучлагч нараас авсан судалгааны үр дүн. Дам ишлэв: Э.Намуун, Гэр бүлийн харилцаанаас үссэн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зохицуулалт, онцлог, ач холбогдол, Бакалаврын судалгааны ажил, УБ., 2020 он, 20 дахь тал.

Хүснэгт 9. Шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ²⁸

№	Шүүх	Шийдвэрийн огноо, дугаар	Шүүхийн шийдвэрийн агуулга, үндэслэл
1	Хөвсгөл аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	2021.06.02 Дугаар 155/ ШШ2021/00588	Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т зааснаар гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүх энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасан эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцална гэж заасан боловч гэрлэлтийг цуцлах дээрх ноцтой шалтгаан байхгүй боловч нэхэмжлэгч, хариуцагч нар нь 2014 оноос хойш тус тусдаа амьдарч байгаа, зохигч нь Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид хандсан, эвлэрүүлэн зуучлах ажиллагаа дуусгавар болсон зэрэг нөхцөлийг харгалзан гэрлэгчдэд эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцлах нь зүйтэй гэж үзлээ.
2	Хөвсгөл аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	2021.07.28 Дугаар 155/ ШШ2021/00826	Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т зааснаар гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүх энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т заасан эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцална гэж заасан боловч гэрлэлтийг цуцлах дээрх ноцтой шалтгаан байхгүй нэхэмжлэгч, хариуцагч нар нь 2013 оноос хойш өнөөдрийг хүртэл тус тусдаа амьдарч байгаа, мөн гэрлэгчид нь тус шүүх дэх эвлэрүүлэн зуучлагчид хандсан боловч эвлэрэл амжилтгүй болсон зэрэг бодит нөхцөл байдлыг харгалзан зохигчдод эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцлах нь зүйтэй гэж үзлээ.
3	Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	2021.04.08 Дугаар 184/ ШШ2021/00963	Гэрлэгч нар эвлэрүүлэн зуучлах ажиллагаанаас татгалзсан, одоо нэхэмжлэгч, хариуцагч тусдаа амьдарч байгаа, хариуцагч нь өөр гэр бүлтэй болсон, гэрлэлт цуцлуулах шаардлагад хариуцагч Л.С маргаагүй, хэн аль нь шүүхээс эвлэрүүлэх хугацаа авах хүсэлт гаргаагүй, цаашид эвлэрч амьдрах боломжгүй тул хуульд зааснаар дахин эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах шаардлагагүй гэж шүүх үзэж, Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132 дугаар зүйлийн 132.6 дахь хэсэгт зааснаар гэрлэлтийг цуцлах нь зүйтэй гэж шүүх үзлээ.
4	Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	2021.04.08 Дугаар 184/ ШШ2021/00970	Нэхэмжлэгч: Бид хэн аль нь тус тусын амьдралтай, цаашид хамтран амьдрах боломжгүй тул бидний гэрлэлтийг цуцалж өгнө үү. Хүүхдийн асрамжийн талаар болон эд хөрөнгийн талаар маргаангүй гэв. Хариуцагч гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн тул гэрлэлтийг цуцлах нь зүйтэй гэж шүүх шийдвэрлэсэн.

28 Шүүхийн шийдвэрийн нэгдсэн сангаас түүвэрлэн авав. Холбоос: www.shuukh.mn

5	Налайх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	2021.03.19 Дугаар 104/ ШШ2021/00095	Шүүхийн хэлэлцүүлэгт зохигч нь гэрлэлтээ цуцлуулна, цаашид хамтран амьдрах боломжгүй болсон гэдгээ илэрхийлсэн, гэр бүлийн харилцаагаа хэвээр үргэлжлүүлэх санаачилга гаргаагүй тул Гэр бүлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт зааснаар гэрлэлт нь сайн дурын харилцаан дээр үндэслэх зарчим, хэргийн нөхцөл байдал, эхнэр, нөхрийн 2020 оны 08 дугаар сараас хойш тусдаа амьдарч байгаа зэргийг харгалзан гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцлахаар шийдвэрлэв.
6	Налайх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх	2021.03.25 Дугаар 104/ ШШ2021/00102	Зохигчийн тайлбараар гэрлэлт цуцлуулах болсон шалтгаан нь гэрлэгчдийн хоорондын таарамжгүй харилцаанаас үүдэлтэй байна. Шүүхийн хэлэлцүүлэгт зохигч нь гэрлэлтээ цуцлуулна, цаашид хамтран амьдрах боломжгүй ба эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хийлгэхгүй болохоо илэрхийлсэн, гэр бүлийн харилцаагаа хэвээр үргэлжлүүлэх санаачилга гаргаагүй тул Гэр бүлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт зааснаар гэрлэлт нь сайн дурын харилцаан дээр үндэслэх зарчим, хэргийн нөхцөл байдал, тус шүүхийн эвлэрүүлэн зуучлагчийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа 2020 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөр дуусгавар болсон зэргийг харгалзан гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцлахаар шийдвэрлэв.
7	Баянхонгор аймгийн Иргэний хэргийн анхан шатны шүүх	2017.08.08 Дугаар 564	Нэхэмжлэгч М-ийн гэрлэлтээ цуцлуулахыг хүссэн нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч Б хүлээн зөвшөөрсөн, маргаангүй байна. Нэхэмжлэгч М, хариуцагч Б нар нь 2007 оны 03 дугаар сарын 15-ны өдөр гэр бүл болсноо 2007 оны 03 дугаар сарын 15-ны өдөр гэрлэлтийн бүртгэлд бүртгүүлэн гэрлэгсдийн эрх, үүргийг үүсгэн амьдарсан, 2009 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр хүү Б төрж эрүүл энх өсөн торниж байгаа болох нь гэрлэлтийн болон хүүхдийн төрсний гэрчилгээний хуулбар, өрхийн эмчийн тодорхойлолт зэргээр тус тус тогтоогдсон байна. Хариуцагч Б, нэхэмжлэгч М нар нь 2012 оноос тусдаа амьдарсан, нэхэмжлэгч М нь 2014 онд хамтран амьдрагчтай болж 1 хүүхэдтэй болсон, одоо амьдралаа хэвийн үргэлжлүүлж байгаа зэрэг амьдралын бодит байдал бий болсон, зохигчид нь цаашид хамтран амьдрах боломжгүйгээс гэрлэлтээ цуцлуулж, хүү Б-г эх М-ийн асрамжид хэвээр үлдээж, тэтгэлэг төлөхгүйгээр харилцан тохиролцсон талаар шүүхэд тайлбар гаргасан зэргийг үндэслэн эвлэрэх хугацаа зааж, эвлэрүүлэн зуучлагчид хандуулалгүйгээр гэрлэлтийг цуцлахаар шийдвэрлэв.
8	Баянхонгор аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх	2017.05.04 Дугаар 356	"...хол тусдаа амьдарч байгаад би өөр хүнтэй гэр бүл болсон нь үнэн, одоо бол ганцаараа амьдардаг, бид 2 гэрлэлтээ цуцлуулахаар тохиролцсон..." гэх хариуцагчийн шүүх болон шүүх хуралдаанд гаргасан тайлбаруудыг үндэслэн тэдгээрийн 2012 оноос тусдаа амьдарсан, амьдралын бодит байдал үүссэн болон гэрлэлтээ цуцлуулахаар харилцан тохиролцсон зэргийг харгалзан тэдний хүсэлтээр гэрлэлтийг цуцалж шийдвэрлэв.

Шүүхийн шийдвэрүүдээс үзэхэд, шүүх ИХШХШТХ-ийн 132 дугаар зүйлийн 132.4 дэх хэсэгт заасан гэрлэгчид эвлэрэх боломжгүй нөхцөл байдал үүсээгүй байсан ч амьдралын бодит байдал бий болсон, эсхүл талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагаанаас татгалзсан гэх үндэслэлээр эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хэрэглэхгүйгээр гэрлэлтийг шууд цуцалсан байна. Гэрлэгчид тусдаа амьдарч буй,

тусдаа гэр бүлтэй болсон, эвлэрэх боломжгүй бусад нөхцөл байдлыг харгалзан шүүх талуудад эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлэхгүйгээр шийдвэр гаргажээ. Түүнчлэн талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах санал гаргаагүй тул талуудын сайн дурын үндсэн дээр хэрэгжих зарчмыг баримтлан гэрлэлтийг шууд цуцалсан байна.

Гэвч эдгээр шийдвэр нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.2 дахь хэсэг, ИХШХШТХ-ийн 132 дугаар зүйлийн 132.2, 132.4 дэх хэсгийг шууд зөрчжээ. Шүүх дээрх хуулийн заалтыг баримтлан шийдвэрлэхэд эвлэрүүлэх боломжгүй нөхцөл үүссэн, талууд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах хүсэлгүй байсан ч эвлэрүүлэн зуучлагчид шилжүүлэх ёстой байсан. Харин шүүх гэр бүлийн хувь заяаг шийдэх чухал шийдвэрийг гаргахдаа гэрлэлт сайн дурын үндсэн дээр хэрэгжих зарчимд нийцүүлэхээс өөр аргагүй байгаа нь шүүхийн практикаас харагдаж байна.

Шүүгч Шүүхийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.23 дахь заалтад “хуулийн илт тодорхой заалтыг ноцтой, эсхүл удаа дараа зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргах” гэж заасныг зөрчсөн тохиолдолд, мөн хуулийн 57 дугаар зүйлийн 57.1.7 дахь заалтад заасны дагуу хаалттай сануулах, эсхүл нээлттэй сануулах, эсхүл цалингийн хэмжээг зургаа хүртэл сараар 20 хүртэл хувиар бууруулах, эсхүл шүүгчийн бүрэн эрхийг гурван сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлж, сургалтад суухыг даалгах, эсхүл огцруулах сахилгын шийтгэл оногдуулна.

Ийнхүү талуудыг эвлэрүүлэн зуучлал руу явуулах боломжгүй амьдралын бодит нөхцөл байдал бий болсон ч уян хатан зохицуулалт хуульд байхгүйгээс болж хууль зөрчин шийдвэр гаргаж байна. Энэ мэтчилэн маргааныг шийдвэрлэхдээ ингэж хуулийн илт тодорхой заалтыг зөрчсөн шүүгчид Шүүхийн тухай хуульд заасан сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл бий.

Иймд шүүгч эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зарчим болон амьдралын шаардлагад нийцүүлэн талуудын эрх ашигт нийцсэн шийдвэр гаргахаас цааргалах нь мэдээж юм. Энэ нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.2 дахь хэсэг, ИХШХШТХ-ийн 132.2, 132.3 дахь хэсгийн зохицуулалт талуудын эрх ашгийг хамгаалж чадахгүй, шүүхээс зөв шийдвэр гарах боломжийг хязгаарлаж байгааг илэрхийлж байна.

2019 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн барьжээ. Уг төслийн 24 дүгээр зүйлд гэр бүлийн холбогдолтой маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулах процессыг өөрчилж, дээр үүссэн асуудлыг шийдвэрлэх ач холбогдолтой байх магадлалтай тул дүн шинжилгээ хийе.

Хүснэгт 10. Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагасан хуулийн төслийн харьцуулалт²⁹

№	1999 оны Гэр бүлийн тухай хууль	Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зүйл, заалт	Дүн шинжилгээ
1	14.2.Шүүх шаардлагатай гэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж, энэ хугацаанд гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авна. Шүүх гэрлэгчдийг эвлэрүүлэхэд авах бүх талын арга хэмжээг эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлнэ.	24.3.Шүүх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гэрлэгчдийг эвлэрүүлэх зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.	Шүүх талуудыг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг гагцхүү эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан хэрэгжүүлэх хэм хэмжээг илүү уян хатан болгож, шүүх хэргийн нөхцөл байдалд тулгуурлан бие даан шийдвэр гаргах боломж бүрдэх ач холбогдолтой зохицуулалт байна.
2		24.4.Энэ хуулийн 24.3-д заасан хугацаанд шүүх дэх эвлэрүүлэн зуучлагч гэрлэгчдийг эвлэрүүлэхэд дэмжлэг үзүүлж дараах арга хэмжээг авна: 24.4.1.гэрлэгчидтэй хамтарсан болон ганцаарчилсан уулзалт хийж, гэрлэлт цуцлуулах болсон шалтгаан үндэслэлтэй эсэхийг тогтоох, гэр бүл цуцлалтын үр дагаврыг тайлбарлах; 24.4.2.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32.4-т заасан хүмүүсээс гадна өмгөөлөгч, нийгмийн ажилтан, гэр бүл судлаач, сурган хүмүүжүүлэгчийг оролцуулж, гэрлэгчдэд зөвлөгөө өгөх; 24.4.3.гэрлэгчдийг шаардлагатай сургалт, мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээнд хамруулах; 24.4.4.бусад арга хэмжээг хэрэгжүүлэх.	Эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ гэдэгт юуг хамруулахыг хуульд тодорхой бичсэнээр шүүхээс явуулах арга хэмжээ хууль ёсны байх нөхцөл бүрдэнэ. Түүнчлэн бусад арга хэмжээ хэмээн нээлттэй зохицуулалт тусгаснаар нь тэдгээр арга хэмжээний нэг нь эвлэрүүлэн зуучлал болохыг хүлээн зөвшөөрсөн байна. Хуулийн төслийн уг зохицуулалт Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийн зорилго, практикт нийцэхгүй байдлыг залруулахад чухал хэрэгтэй юм.
3		24.5.Эвлэрүүлэн зуучлагч энэ хуулийн 24.4-т заасан эвлэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэргэжил, арга зүйн дэмжлэгийг авч, хамтран ажиллах, эсхүл магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.	Тус зохицуулалтад эвлэрүүлэн зуучлагч гэж заагаагүй нь аль хэдийн бий болгосон эвлэрүүлэн зуучлагчдын орон тоог тодорхойгүй болгож байх тул эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан эвлэрүүлэх арга хэмжээ явуулахыг заах нь зүйтэй гэж үзэж байна.

29 “Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл” Улсын Их Хуралд өргөн барьсан хувилбараар байгаа тул тухайн төсөл өөрчлөгдсөн тохиолдолд судалгааны дүгнэлтэд өөрчлөлт орно. Төслийн холбоос: <http://forum.parliament.mn/projects/561>

4	14.4.Гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл, дарамтаас болж гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд болон хүүхдийн хүмүүжилд ноцтой хохирол учирч болзошгүй, эсхүл учирсан нь тогтоогдсон бол шүүх энэ хуулийн 14.2-т заасан эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцална.	24.6.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 132.4-д заасан нөхцөл бий болсон бол шүүх энэ хуулийн 24.4-т заасан эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцалж болно.	Энэ заалт хэвээр хадгалагдсан байна. Хууль зүйн техникийн хувьд Гэр бүлийн тухай хууль болон ИХШХШТХ-д энэ талаар давхардуулан 2 тусдаа заасан байсныг засах нь ач холбогдолтой байна.
5	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2002)	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл	Дүн шинжилгээ
6		129.1.8. гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас гэр бүлийг эвлэрүүлэх, хүүхдийн асрамжийг тогтоохтой холбоотой мэргэжил, арга зүйн дэмжлэг авахыг даалгах.	Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагаж ИХШХШТХ-д нэмэлт оруулахаар заажээ. Гэвч уг хуулийн 132 дугаар зүйлийн 132.2 дахь хэсэгт өөрчлөлт оруулахгүйгээр дээр заасан төслийн заалтууд хэрэгжих боломжгүй бөгөөд зөрчилдөхөөр байна. Иймд ИХШХШТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэв.

Үүнээс үзэхэд, Улсын Их Хуралд өргөн барьсан Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 24 дүгээр зүйл нь гэр бүлийн маргаанд эвлэрүүлэх зуучлал явуулах ажиллагаанд эерэг үр нөлөө авчрах ач холбогдолтой боловч үүсээд буй асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй байна.

Учир нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 32 дугаар зүйлийн 32.1, 32.2 дахь хэсэгт заасан шүүхийн өмнөх болон дараагийн шатанд явуулах эвлэрүүлэн зуучлах ажиллагааг сайн дурын үндсэн дээр явуулдаг болгож, шүүхийн хэрэгжүүлэх бүх талын эвлэрүүлэх арга хэмжээнд гагцхүү эвлэрүүлэн зуучлалыг ойлгохоор заасныг өөрчлөхгүйгээр төслийн 24 дүгээр зүйл хэрэгжих боломжгүй юм.

Иймд төслийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг боловсронгуй болгох шаардлагатайгаас гадна төслийг дагасан хуулиар Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийг хөндөөгүй учир Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

2012 онд Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль батлагдсанаар иргэний болон хөдөлмөрийн маргаанд эвлэрүүлэн зуучлал амжилттай хэрэгжиж байна. Харин гэрлэлт цуцлах маргааны тухайд Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль хүчин төгөлдөр болсноос хойшхи 7 жилийн хугацаанд, жилд тогтмол нийт маргааны 85 хувиас дээш тооны маргаанд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа амжилтгүй хэрэгжсэнд дараах хүчин зүйл нөлөөлж байгааг тогтоолоо. Үүнд:

1. Гэрлэлт цуцлах нэхэмжлэл гаргаж буй гэрлэгчид эхлээд урьдчилан шийдвэрлүүлэх журмаар эвлэрүүлэн зуучлалд хандах шаардлагатай байгаа нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааг сайн дурын үндсэн дээр бус албадан хэрэгжүүлэх үндэс болжээ. Энэ нь Япон улсын Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 257 дугаар зүйлд заасан зарчмыг Монгол Улс хууль тогтоомжид шүүхийн эрх хэмжээг хязгаарлан нутагшуулсантай холбоотой байна.
2. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас гэр бүлийн гишүүдийн амь нас, эрүүл мэнд, хүүхдийн хүмүүжилд ноцтой аюул, хор уршиг учирсан нь тогтоогдсон нөхцөлд л талуудад эвлэрүүлэх арга хэмжээ авахгүйгээр гэрлэлтийг цуцлах боломжтой байгаа нь учир дутагдалтай юм. Сэтгэл санааны болон эдийн засгийн хүчирхийллийн улмаас материаллаг хор уршиг учрах боломжгүй бөгөөд бие махбодын болон бэлгийн хүчирхийллийг Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил, Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэнийг тогтоосон шүүхийн шийдвэрээр л нотлох боломжтой нь практикт хүндрэл үүсгэж байна.
3. Шүүх гэрлэгчид олон жил тусдаа амьдарсан, өөр гэр бүл зохиосон зэрэг амьдралын нөхцөл байдал болон талууд эвлэрэх санаачилга гаргаагүй байдлыг харгалзаж, талуудын сайн дурын үндсэн дээр хэрэгжих зарчмыг баримтлан эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахгүйгээр гэрлэлтийг цуцалж буй тохиолдлууд байна. Шүүхийн энэхүү практик нь Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, ИХШХШТХ-ийн зохицуулалтууд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зарчимд нийцээгүй, хэргийн олон янзын нөхцөл байдлыг харгалзахаар зохицуулаагүйтэй холбоотой.
4. Дээр дурдсан байдлаар шүүх хуулийн илт тодорхой заалтыг зөрчиж шийдвэр гаргахаас өөр аргагүй нөхцөл байдал үүсэж, улмаар энэ нь хуульд заасан бусад зарчмыг ханган талуудын эрх ашгийг хамгаалж шийдвэр гаргасан шүүгчид Шүүхийн тухай хуулиар сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болж байна. Үүнээс үүдэн шүүгчид гэрлэгчдийн нөхцөл байдлыг харгалзахгүйгээр эвлэрүүлэн зуучлагчидууд шилжүүлдэг практик үүсдэг.
5. Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа талуудын сайн дурын үндсэн дээр явагдах зарчим эх газрын эрх зүйн бүлийн улс орнуудад нийтлэг байгаа нь Бүгд Найрамдах Франц Улсын жишээн дээр мөн харагдаж байна. Харин Монгол Улсад гэрлэгчид эвлэрүүлэн зуучлах ажиллагаа явуулахыг зөвшөөрөх, эсхүл татгалзах эрхийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч үе шатанд эдлэх боломжгүй байна.

6. Гэр бүлийн эвлэрүүлэн зуучлалын 4 зарчимд эвлэрүүлэн зуучлалыг талуудын сайн дурын үндсэн дээр явуулах зарчим томоохон байр суурь эзэлдэг. Харин урьдчилан шийдвэрлүүлэх журмаар эвлэрүүлэн зуучлах ажиллагааг заавал явуулахаар заасан Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг, Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг; шүүх талуудыг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээг гагцхүү эвлэрүүлэн зуучлагчаар дамжуулан заавал явуулахаар заасан Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэг, Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, ИХШХШтХ-ийн 132 дугаар зүйлийн 132.2 дахь хэсэг нь эвлэрүүлэн зуучлах ажиллагааг талуудын сайн дурын үндсэн дээр явуулах зарчимд тус тус нийцэхгүй байна.
7. Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсан тохиолдолд дээр дурдсан асуудлыг шийдвэрлэхэд эерэг үр дагавар авчрах ач холбогдолтой боловч бас бүрэн шийдвэрлэж чадахгүй юм. Иймд эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үндсэн зарчмыг хангах, шүүхийн практикт үүссэн асуудлыг шийдвэрлэн гэр бүлийн маргааны эвлэрүүлэн зуучлалын амжилттай хэрэгжих үзүүлэлтийг дээшлүүлэхийн тулд Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль болон ИХШХШтХ-ийн холбогдох зохицуулалтад өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзлээ.

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж

1. Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль (2012)
2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2002)
3. Гэр бүлийн тухай хууль (1999)
4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
5. Эрүүгийн хууль (2015)
6. Зөрчлийн тухай хууль (2015)
7. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол
8. Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл
9. Япон улсын Иргэний хууль (1896)
10. Япон улсын Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2011)
11. Франц Улсын Иргэний хууль (1804)

Ном, гарын авлага

1. С.Нарангэрэл, Монголын эрх зүйн эх толь бичиг. Дөрөв дэх хэвлэл, 2015 он
2. “Эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэх ажиллагаа” гарын авлага, 2015 он
3. Гэр бүлийн хүчирхийллийг судалж, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх нь, ХЭҮТ, 2011 он
4. Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээ, 2020 он
5. Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага. Эвлэрлийн гэрээ, арбитрын шийдвэр, нотариатын мэдэгдэх хуудсыг гүйцэтгэх ажиллагаа, 2015 он.

Эрдэм шинжилгээний өгүүлэл

1. Д.Гангабаатар, Гадаад орнуудын туршлага ба эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үр дагаврыг үнэлэх нь
2. Б.Дугармаа, Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд тулгамдаж буй асуудал

Судалгааны ажил, эрдэм шинжилгээний сэтгүүл

1. “Монголын хууль тогтоомжийн нийгэмлэг” ТББ, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаа, 2020 он
2. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2013 он, Цуврал 6 (46)
3. “Хууль дээдлэх ёс” сэтгүүл, 2019 он, дугаар №04
4. Э.Намуун, Гэр бүлийн харилцаанаас үссэн маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны зохицуулалт, онцлог, ач холбогдол. Бакалаврын судалгааны ажил, 2020 он
5. Joan B. Kelly, A Decade of Divorce Mediation Research, Family Court Review 34, no.3. 1996

Цахим эх сурвалж

1. <http://www.supremecourt.mn/news/163>
2. https://drive.google.com/file/d/1T13rKCfRIHF84sgUF1aRHfl_5XF2xzz0/view
3. <https://www.osce.org/files/f/documents/a/7/452919.pdf>
4. <https://blc.law/wp-content/uploads/2016/12/2005-07-mediation-ethics-branchmainlanguagedefault.pdf>
5. <https://www.themediatorsusankaye.com/principles-of-mediation.html>
6. http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail_main?re=&vm=&id=2323
7. <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?printID=&id=2057&re=02&vm=02>
8. https://www.legifrance.gouv.fr/codes/section_lc/LEGITEXT000006070721/LEGISCTA000006165746/#LEGISCTA000038310884
9. www.shuukh.mn
10. www.1212.mn

**ДОЛОО. ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР
ДАГАВАРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Судалгааны зөвлөх:	Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Э.Золзаяа
Судалгаа гүйцэтгэсэн:	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан Л.Амгаланбаатар Эрдэм шинжилгээний ажилтан С.Цэрэндолгор

Удиртгал

Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /цаашид “ИХШХШТХ” гэх/¹ 2002 онд батлагдан хэрэгжсэнээс хойш даруй 19 жилийн хугацаа өнгөрчээ. Тус хууль нь иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн иргэний эрх зүйн маргааныг шүүх иргэний хэрэг үүсгэн хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг 20 бүлэг, 195 зүйлтэй Монгол Улсын суурь хуулийн нэг юм.

ИХШХШТХ-ийг 2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталснаас хойш судалгаа хийж буй хугацаа болох 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд нийт 23 удаагийн нэмэлт, өөрчлөлтийг оруулжээ.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2021 оны 1 дүгээр улирлаас эхлэн тогтмол ИХШХШТХ-ийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхээр болсон бөгөөд ийнхүү эхний улирлын тайланг боловсруулав.

ИХШХШТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт дүн шинжилгээ хийх ажлыг иргэний эрх зүйн харилцааны явцад бодитоор үүсэж байгаа, ач холбогдолтой, зайлшгүй шийдвэрлэвэл зохих асуудлын хүрээнд хийж гүйцэтгэхийг эрмэлзсэн бөгөөд дүн шинжилгээ хийх ажлын зорилго нь ИХШХШТХ-ийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийх, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашлаад ИХШХШТХ-ийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг санал болгоход оршино.

Ингэхдээ тус хүрээлэнгээс тогтмол дүн шинжилгээ хийхээр болсны хувьд практикт хууль хэрэглээний хамгийн их маргаан дагуулдаг, хэрэгжүүлэхэд хүндрэлтэй гэж үздэг зохицуулалтуудыг сонгон авч, улирал тус бүр тодорхой асуудлын хүрээнд хийх, тухайн асуудлаа дэлгэрүүлэн судлах замаар дүгнэлт гаргах, санал дэвшүүлэх чиглэлийг судалгааны багийн зүгээс баримтлав.

Судалгааг гүйцэтгэхэд баримталсан зарчим

Судалгааг шинжлэх ухааны арга зүйд тулгуурлан хараат бус, бие даасан байдлаар хийж гүйцэтгэж, судалгааны дүгнэлтийг гагцхүү тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитоор гаргахыг зорьсон.

Түүнчлэн, судалгааны багийн хувьд цаг хугацаа, хүний нөөц зэрэг олон хүчин зүйлийг харгалзан нуршуу, үр дүн багатай бичиглэлээс зайлсхийхийг хичээж, товч, тодорхой байдлаар дүн шинжилгээ хийхийг зорьсон гэдгийг дурдах нь зүйтэй.

Судалгааны хүрээ

Судалгааны багийн зүгээс судалгааны хүрээг тодорхойлох зорилгоор иргэний эрх зүйгээр өндөр мэргэшсэн эрдэмтэн, судлаачдаас бичгээр санал авах, уулзалт-ярилцлага зохион байгуулах, бичмэл академик болон бодлогын эх сурвалж цуглуулах зэрэг ажиллагааг богино хугацаанд далайцтай хийж гүйцэтгэсэн ба энэхүү ажиллагаанд үндэслэн ИХШХШТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт дүн шинжилгээнд хамаарах зохицуулалтыг сонголоо.

1 Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002 (№8).

Зохицуулалтыг сонгохдоо тухайлан энэ улирлын дүн шинжилгээнд иргэний хэрэг үүсгэхээс өмнөх ажиллагаатай холбогдох асуудал, иргэний хэрэг үүсгэснээс хойш хийгдэх ажиллагаатай холбогдох асуудал гэж хоёр хувааж, тус бүрд хамаарах хэд хэдэн зүйл сонгон авч судалгааг гүйцэтгэсэн болно.

Судалгааны арга зүй

Судалгааг эрх зүйн харьцуулалтын арга, шүүхийн практик судлах, тайлан, статистикийн тоо баримтад дүн шинжилгээ хийх, онолын эх сурвалжийг ашиглан гүйцэтгэсэн.

Нэг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог

ИХШХШТХ-ийн 12 дугаар зүйлийн агуулгаас үзвэл иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх 3 ажиллагааг энэ хуулиар зохицуулсан байна. Үүнд, ердийн буюу нэхэмжлэлээр үүсэх, гомдлоор үүсэх, онцгой ажиллагааны журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа багтана. Тус байдлаар ангилан зохицуулах нь ажиллагаа бүрд баримтлах зарчимтай холбоотой. Ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчим нь диспозитив болон мэтгэлцэх зарчим байдаг бол гомдлоор үүсэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дээрх хоёр зарчмаас гадна нотлох баримт цуглуулахтай холбоотой нэмэлт зарчмыг хуулиар тодорхойлох шаардлагатай. Харин онцгой ажиллагаа нь “Мөрдөн шалгах” буюу шүүх нотлох баримт цуглуулах зарчим үйлчилж байгаа боловч уг зарчмыг хуульд томъёолон тодорхойлох шаардлага бий эсэхэд мөн судалгаа шаардах юм.

Энэ дүн шинжилгээний хүрээнд ердийн журмаар иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах диспозитив болон мэтгэлцэх зарчим хэрхэн хэрэгжиж байгаатай холбоотой хуулийн зарим зохицуулалтыг хамруулсан болно.

Диспозитив зарчим. 1990-ээд онд хэрэгжсэн эрх зүйн шинэтгэлийн үр дүнд диспозитив зарчим нь Монгол Улсын өнөөгийн ИХШХШТХ-д тусгалаа олсон бөгөөд индивидуализмын үнэт зүйлс болон хувь этгээдийн бие даасан байдал, өөрийн ашиг сонирхлыг бие даан тодорхойлох, хэрэгжүүлэх чадварыг хүлээн зөвшөөрсөн чухал үйл явдал болсон.² Хэдийгээр ИХШХШТХ-д диспозитив зарчмыг шууд заагаагүй ч тус зарчим ИХШХША-ны оролцогчдын процессын шинжтэй үйлдэл, түүний агуулгаар илэрдэг. Өөрөөр хэлбэл, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа талуудын санаачилга буюу хүслийн үндсэн дээр явагддаг.³ Тухайлбал, ИХШХШТХ-ийн 12 дугаар зүйлд иргэний хэрэг үүсгэхийн тулд шүүхэд хүсэлт, нэхэмжлэл гаргах, мөн хуулийн 26 дугаар зүйлд нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах, зохигч эвлэрэх, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх зэрэг харилцан зөвшилцөн сайн дурын үндсэн дээр асуудлаа өөрсдийн хүсэл зоригор шийдвэрлэнэ гэж зааснаар илэрч байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн “ИХШХШТХ-ийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалт, 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай” 02 дугаар дүгнэлтийн үндэслэх хэсэгт “... Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны онцлог нь уг ажиллагаанд удирдлага болгодог тусгай зарчим болох диспозитив буюу иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг зохигчдын санаачилга, хүсэлтийн үндсэн дээр явуулах болон мэтгэлцэх зарчимд үндэслэдэг явдал юм”⁴ гэж тайлбарласан. Мөн зарим судлаачид диспозитив зарчмын агуулгыг зохигчид хэрэг хянан шийдвэрлэх

2 Б.Буянхишиг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, 2021 он, 38 дахь тал.

3 Монгол Улсын Дээд шүүхийн 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн зөвлөмж, дугаар 01, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарчим, иргэний хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа, цаашид анхаарах асуудал.

4 Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн дүгнэлт, дугаар 02, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалт, 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай.

ажиллагааг эхлүүлэх, үргэлжлүүлэх, төгсгөх асуудлаа бие даан чөлөөтэй хэрэгжүүлэх буюу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдах зарчим⁵ гэж тайлбарладаг.

Ийнхүү диспозитив зарчмыг шууд үгчлэн хуульчлаагүй боловч ердийн хуулийн зохицуулалтаар амилуулж чадсан байгаа нь кодификацийн онолыг баримталсан гэж үзэхээр байгааг⁶ судлаач Б.Буянхишиг дурдсан нь тэмдэглүүштэй болжээ.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны диспозитив зарчмын талаар судлаачид өөр өөр байр суурь илэрхийлдэг боловч энэ дүн шинжилгээний хүрээнд уг зарчмын онолын асуудлыг хөндөөгүй болно. Диспозитив зарчмыг иргэний процессын хуульд томьёолон оруулах эсэх асуудал нь Ром-Германы эрх зүйн бүлд⁷ хамаарах улс орнуудын судлаачдын дунд одоог хүртэл маргаантай байна.

Цаашид бид диспозитив зарчмыг үндсэн утгыг нь алдагдуулахгүйгээр дэлгэрүүлэн хөгжүүлэх шаардлагатай. Зарчим нь тодорхойлогдсон эрх зүйн салбартаа чухал үүргийг гүйцэтгэдэг ба “гол тулгуур” нь болдог. Иймд диспозитив зарчмыг хуульд тодорхойлоогүй байдал нь ойлголтын янз бүрийн асуудал үүсгэж болно.

Мэтгэлцэх зарчим. Уг зарчмыг ИХШХШТХ-ийн 6 дугаар зүйлд зохицуулсан. Мэтгэлцэнэ гэдэг нь нэхэмжлэгч тал нэхэмжлэлийн шаардлага, маргааны үйл баримт, хариуцагчийн гэм бурууг нотолж, татгалзлыг үгүйсгэх, хариуцагч нэхэмжлэгчийн шаардлагыг татгалзах, түүнийхээ үндэслэлийг нотлох үүрэгтэйгээр⁸ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд идэвхтэй оролцох байдлаар илэрдэг байна. Диспозитив зарчимтай харьцуулахад хууль тогтоогч нь мэтгэлцэх зарчмыг хуульчлан тогтоож өгснөөр олон янз байдлаар зарчмыг тайлбарлахаас урьдчилан сэргийлж чадсан.⁹ Иймд энэ хэсэгт мэтгэлцэх зарчмын талаар тайлбарлах шаардлагагүй гэж үзлээ.

Энэ удаагийн судалгааны тайланд судалгааны багийн зүгээс гагцхүү эхлэл болгож, иргэний хэрэг үүсгэхээс өмнө болон үүсгэснээс хойш хийх ажиллагаатай холбоотой асуудал хэмээн хоёр ангилж, тодорхой зохицуулалтад товч дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Хоёр. Иргэний хэрэг үүсгэхээс өмнө хийгдэх ажиллагаатай холбоотой асуудал

ИХШХШТХ-ийн 66 дугаар зүйлд заасны дагуу шүүгч нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор хэрэг үүсгэх тухай захирамж гаргана. Энэхүү захирамж гарах үндэслэл нь хуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт заасан нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байхгүй тохиолдол юм. Иймд нэхэмжлэл хүлээн авсан шүүгчийн ажиллагаа нь хуулийн 65.1 дэх хэсэгт заасан үндэслэл байгаа эсэхийг шалгадаг.

5 Ю.Кают, Монгол Улсын Иргэний хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй, 2015 он, 17 дахь тал.

6 Б.Буянхишиг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, 2021 он, 42 дахь тал.

7 Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал, 2017 он, 141 дэх талд ашигласан нэр томьёог хэрэглэв.

8 Монгол Улсын дээд шүүхийн 2017 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн зөвлөмж, дугаар 01, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд баримтлах зарчим, иргэний хэрэг үүсгэсэн шүүгчийн ажиллагаа, цаашид анхаарах асуудал.

9 Дэлгэрэнгүйг дээрх зөвлөмжөөс харна уу.

Гэвч ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт заасан үндэслэлүүдээс практикт төдийлөн хэрэгждэггүй буюу хэрэгжих боломжгүй зохицуулалтууд байна. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэлийн хүрээнд шалгалт хийж буй шүүгч олж тогтоох боломжгүй үндэслэлийг энэ зохицуулалтад оруулсантай холбоотой. Тухайлбал, ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.6, 65.1.7, 65.1.8, 65.1.10 зэргийг дурдаж болно.

№	Хуулийн зүйл, заалт	Тайлбар
1.	65.1.6.Нэхэмжлэлд дурдсан үйл баримт, зохигчийн гэм буруугийн талаар хуулийн хүчин төгөлдөр шүүхийн болон арбитрын шийдвэр, эсхүл нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, түүнчлэн хэргийг хэрэгсэхгүй болгосон хуулийн хүчин төгөлдөр шүүхийн болон арбитрын шийдвэр буюу шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж байгаа;	Шүүгч нийтэд илэрхий үйл баримтаас бусад тохиолдолд хүлээн авсан нэхэмжлэлд дурдагдсан үйл баримт, зохигчийн гэм буруугийн талаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан, хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүхийн болон арбитрын шийдвэр, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж байгаа эсэхийг нэхэмжлэгч холбогдох баримтыг өгөөгүй тохиолдолд тогтоох боломжгүй. Нэхэмжлэгч уг баримтыг өгөөгүй бол шүүх хариуцагчийн тайлбар, түүний гаргаж өгсөн дээр дурдсан үндэслэлтэй холбоотой нотлох баримтыг үндэслэж шийдвэрлэхээр болж байна. Иймд шүүх иргэний хэрэг үүсгэсний дараа уг нөхцөл байдал тодорвол ИХШХШТХ-ийн 117 дугаар зүйлд заасан шүүх хуралдаанаар шийдвэрлэх боломжтой байна. ¹⁰
2.	65.1.7.Зохигчийн маргаж байгаа зүйл ба түүний үндэслэлийн талаарх өөр хэргийг шүүх шийдвэрлэж байгаа;	Зохигчийн зүгээс шүүхэд гаргасан нэхэмжлэлдээ маргаж байгаа зүйл ба түүний үндэслэлийн талаарх өөр хэргийг шүүх шийдвэрлэж байгаа үйл баримтын талаар дурдаагүй нөхцөлд шүүгч өөр хэргийг шүүх шийдвэрлэж байгаа эсэхийг мэдэх боломжгүй. ¹¹ Түүнчлэн эрүүгийн журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь иргэний процесст нөлөөлөхгүй тохиолдлыг ялгаж өгөх шаардлагатай байна. ¹²
3.	65.1.8.Уг нэхэмжлэлтэй холбоотой хэргийг эрүүгийн журмаар шалгаж байгаа;	
4.	65.1.10.Зохигч болох хүн нас барсан, хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд маргаж байгаа шаардлага буюу маргаантай үүрэг нь эрх залгамжлагчид шилжээгүй;	Шүүхэд иргэний болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нэгдсэн мэдээлэл байдаггүй тул хүлээн авсан шүүгч нэхэмжлэгчээс өөрт нь холбогдох мэдээллийг авах боломж байгаагаас бусад тохиолдолд зохигч болох хүн нас барсан байдал, хуулийн этгээд татан буугдсан байдал, маргаантай үүрэг эрх залгамжлагчид шилжсэн байдлыг нэхэмжлэлийг үндэслэн шийдвэрлэх боломжгүй юм. ¹³

Дээрхээс дүгнэвэл уг зохицуулалтуудыг хуулийн 65.1 дэх хэсгээс хасах нь зүйтэй юм.

Түүнчлэн, ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.9-д заасан хариуцагчийн хаяг тодорхойгүй байх тохиолдолтой холбоотойгоор нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах зохицуулалт хуулийн системчлэлийн хувьд буруу зохицуулагдсан. Практикт нэхэмжлэлийг хүлээн авсан шүүгч иргэний хэрэг үүсгэхээс өмнө зарлан дуудах хуудсаар хариуцагчийг дууддаг. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь иргэний хэрэг үүсгэснээр эхлэх учиртай. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа эхлээгүй байхад хариуцагчийг дуудан ирүүлэхтэй холбоотой ажиллагааг хуульд зохицуулаагүй байх тул хууль тогтоогч энэ асуудлыг практикт үлдээсэн гэж тайлбарлахаар байна. Дээрх үндэслэлээр хуулийн 65.1.9 дэх зохицуулалт нь 65.1 дэх хэсэгт заасан ажиллагаанд хамаарахгүй гэж дүгнэх учир хасагдах нь

10 Й.Кают, Монгол улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, 2015 он, 42 дахь тал.

11 Мөн тэнд, 44 дэх тал.

12 Мөн тэнд, 46 дахь тал.

13 Мөн тэнд, 46 дахь тал.

зүйтэй бөгөөд үүнийг хуулийн 117 дугаар зүйлийн 117.1-т томъёолж оруулах нь систематикийн хувьд зөв болно. Үүнтэй холбоотойгоор хуулийн 117.1-т заасан үндэслэлүүдийг эш татах хууль зүйн техник хэрэглэхээс илүүтэйгээр тоочих замаар өөрчлөх боломжтой.

Хэрэв шүүгч ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1.1- 65.1.8 дахь заалтад дурдсан үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах захирамж гаргасан бол нэхэмжлэгч хуулийн 170.1 дэх хэсэгт зааснаар захирамж гарсан өдрөөс хойш 10 хоногийн дотор тухайн шүүхэд гомдол гаргах эрхтэй. Практикт тулгарч буй асуудал нь уг захирамжид заасан *хугацааны дотор гомдол гаргахын тулд нэхэмжлэгч уг захирамжийг гарсан өдрөөс хойш* гомдол гаргах хүртэл тоологдох 10 хоногийн дотор мэдсэн байх боломжоор хангагдсан эсэх юм. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгчид уг захирамж гомдол гаргах хугацааны дотор шүүх захирамжийг хүргүүлсэн эсхүл мэдэгдсэн байх явдал бөгөөд энэ талаар зохицуулалт байхгүй байна. Харин хууль тогтоогч нь захирамжийг хүргүүлэх үүргийг шүүхэд хуваарилах эсэх, эсхүл нэхэмжлэгчид лавлах үүргийг хуваарилах эсэхийг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх боломжтой. Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийг оролцуулахгүйгээр 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр гомдлыг 14 хоногийн дотор хянан шийдвэрлэж хуулийн 171 дүгээр зүйлд заасан тогтоолыг гаргана.

Зохицуулалтын хүрээнд хуулийн 170, 171 дүгээр зүйл нь давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээнд хамаарч байх бөгөөд практикт тухайн анхан шатны шүүх харьяалан шийдвэрлэж байна. Практикт хэрэгжүүлж байгаа зохицуулалт нь хэргийн оролцогчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг богиносгож байгаа юм. Иймд практик хэрэглээг дэмжиж хууль тогтоогч нь холбогдох зохицуулалтуудыг анхан шатны шүүхийн эрх хэмжээнд хуваарилж хуульчлах нь диспозитив зарчим, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бага зардлаар явуулах зарчимд нийцэх юм.

Гурав. Иргэний хэрэг үүсгэснээс хойш хийгдэх ажиллагаатай холбоотой зарим асуудал

Шүүгч нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах үндэслэл байхгүй гэж үзвэл ИХШХШТХ-ийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэгт заасны дагуу иргэний хэрэг үүсгэж, хуулийн 67 дугаар зүйлд нэрлэн заасан ажиллагааг явуулах бөгөөд үүнд нэхэмжлэлийг хариуцагчид гардуулах ажиллагаа хамаарч байна. Нэхэмжлэлийг хэрэг үүсгэсэн өдрөөс хойш нийслэлд 7 хоногийн дотор, орон нутагт 14 хоногийн дотор тус тус гардуулах тухай зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа талаар судалгаа байхгүй, хэргийн оролцогчоос нэхэмжлэлийг гардуулах ажиллагаа хуульд заасан хугацааг баримтлахгүй байна гэсэн гомдол гардаггүй тул нэхэмжлэлийг хариуцагчид гардуулахтай холбоотой хугацааг зааж шүүхэд үүрэгжүүлэх нь зохимжтой эсэх асуудал нээлттэй үлдлээ.

Харин нэхэмжлэлийг гардаж авсан хариуцагчийн идэвхгүй байдлаас гарах үр дагаврын зохицуулалт хуулийн үндсэн зарчим болох диспозитив болон мэтгэлцэх зарчимд нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийв.

3.1. ИХШХШТХ-ийн 72 дугаар зүйлийн 72.3 дахь хэсгийн үр дагавартай холбоотой асуудал

ИХШХШТХ-ийн 72 дугаар зүйлийн 72.2 дахь хэсэгт “Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор, эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан үндэслэл, түүнийг нотлох

баримтаа шүүхэд ирүүлэх үүрэгтэй” гэж заасан. Хэрэв хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авсан боловч 14 хоногийн дотор эсхүл шүүгчээс тогтоосон хугацаанд хариу тайлбар, нотлох баримтаа шүүхэд ирүүлээгүй, шүүхэд ирж тайлбар өгөөгүй бол ИХШХШТХ-ийн 72 дугаар зүйлийн 72.3 дахь хэсэгт заасан үр дагавар үүсэж байна.

ИХШХШТХ-ийн 72 дугаар зүйлийн 72.3-т “Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авсан боловч энэ хуулийн 72.2-т заасан үүргээ биелүүлээгүй, түүнчлэн энэ хуулийн 77 дугаар зүйлд заасан журмын дагуу шүүхэд ирж тайлбар өгөөгүй бол нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцож энэ хуулийн 100.3-т зааснаар түүний эзгүйд хэргийг шийдвэрлэнэ” гэж заасан. Хуулийн хэм хэмжээг үгийн шууд утгаар тайлбарлавал хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг шүүхэд тайлбар гаргаагүй өөрийн эс үйлдэхүйгээр хүлээн зөвшөөрсөн гэж дүгнэхээр байх боловч уг хэм хэмжээнд үгийн шууд утгын тайлбарыг биш системчилсэн тайлбар хийж хэм хэмжээг шүүх практикт зөв хэрэглэж байна. Өөрөөр хэлбэл, хариуцагчийн идэвхгүй байдлыг нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөн гэж дүгнэхгүй нь дараах байдлаар тайлбарлагдана.

ИХШХШТХ-ийн 72 дугаар зүйлийн 72.3 дахь хэсэгт “нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцож” гэж тодорхойлохдоо хууль тогтоогч “тооцох” гэсэн нэр томъёог ашигласан нь ИХШХШТХ-ийн 74 дүгээр зүйлд заасан нэхэмжлэлийг хариуцагч хүлээн зөвшөөрөх гэх зохицуулалтаас ялгаж ойлгох ёстой гэж тайлбарлаж болох боловч нэр томъёоны хэрэглээнд оновчгүй болсныг цаашид залруулах нь зүйтэй. Ийнхүү оновчгүй нэр томъёог хуульд хэрэглэсэн нь практикт хэргийн оролцогч болон тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нар өөрт ашигтайгаар тайлбарлах байдлаар илэрч байгааг давж заалдах болон хяналтын журмаар гаргасан гомдлоос тодорхойлж болох юм.

Хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсгийн зохицуулалтаас үзвэл хариуцагч шүүхэд гаргасан тайлбараараа нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрснөө илэрхийлсэн бол хуулийн 72.3 дахь хэсгийн зохицуулалт нь үзвэл хариуцагч огт тайлбар гаргаагүй тохиолдол юм. Тогтоосон хугацаанд хариуцагч тайлбар гаргаагүй бол хуулийн 100.3 дахь хэсэгт зааснаар түүний эзгүйд /шүүх хуралдаанд хариуцагч ирээгүй/ хэргийг шийдвэрлэнэ гэжээ. Үүний үр дагавар нь шүүх нэхэмжлэгчээс гаргасан тайлбар болон бусад баримт нотолгоог үндэслэн хэргийг хянан шийдвэрлэх бөгөөд хуулийн системчлэлээс харвал шүүхээс хуулийн 115.2 дахь хэсэгт заасан шийдвэр гарна. Энэ хэсгийн зохицуулалтаас дүгнэвэл 3 шийдвэрийн аль нэг буюу нэхэмжлэлийн шаардлагыг хангах, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг хэрэгсэхгүй болгох эсхүл нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох шийдвэрийг шүүх гаргана.

Нэгтгэн дүгнэвэл хуулийн 72.3 дахь хэсэгт зааснаар хариуцагч тайлбар гаргаагүй бол шүүх хэргийг шүүх хуралдаанаар шийдвэрлэж, хуулийн 115.2 дахь хэсэгт заасан шийдвэр гаргана. Иймд хуулийн 72.3 дахь хэсэгт заасан хариуцагч тайлбар өгөөгүйг нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцох үр дагавар үүсэхгүй юм. Ийм учир хууль тогтоогч нь хуулийн 72.3 дахь хэсгийн зохицуулалтын үр дагаврыг зөв томъёолон зохицуулах шаардлагатай байна. Санал болгоход ИХШХШТХ-ийн 72.3 дахь хэсгийг хариуцагч тогтоосон хугацаанд тайлбар гаргаагүй бол хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлнэ гэж томъёолох байна. Хариуцагчид шүүх хуралдааны товыг шүүхээс мэдэгдэх ажиллагааг хуулийн 77 дугаар зүйлд нарийвчлан тогтоосон ба тэрээр товлосон шүүх хуралдаанд ирээгүй тохиолдлыг хуулийн 100.3 дахь хэсгээр нэгэнт зохицуулсан тул хуулийн 72.3 дахь

хэсгийн холбогдох зохицуулалтууд давхардсан шинжийг агуулж байгааг тэмдэглэх нь зүйтэй гэж үзлээ.

Нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцох ойлголт нь англиар Judgement by Default хэмээн нэршсэн байдаг. ХБНГУ-д энэ ойлголтыг иргэний процессын журмыг зөрчсөнд хариуцагчид оногдуулах санкци гэж томъёолжээ. Тодруулбал, энэхүү хариуцагчид оногдуулж буй санкци хэмээх томъёоллын үндэслэл нь хариуцагчийн хариуцлагыг өндөржүүлэх, гарах үр дагаврыг зохицуулан хуульчлахад оршино. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгч шүүх хуралдаанд ирээгүйг тэрээр уг хэргийн талаар сонирхолгүй болсон гэж тайлбарладаг¹⁴ бол хариуцагч шүүх хуралдаанд ирээгүйг нэхэмжлэгчийн шаардлагыг эсэргүүцэхгүй байна гэж үздэг.

ХБНГУ, БНСУ тэргүүтэй орнуудын иргэний процессын хуульд хариуцагч хуульд заасан болон шүүгчийн тогтоосон хугацаанд хариу тайлбарын үндэслэл, нотлох баримтаа шүүхэд ирүүлээгүй тохиолдолд шүүхийн зүгээс хариуцагчид үр дагаврыг мэдэгдсэний үндсэн дээр шүүх хуралдаанд аман болон бичгэн тайлбар гаргах эрхийг олгохгүйгээр шийдвэр гаргахаар зохицуулсан байна.

Дээрх товч туршлагаудаас зохистой хэмжээнд судалж авч хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд энд дурдах зүйл нь ИХШХШтХ-д зохицуулагдаагүй зарим харилцаа байгааг илрүүлэв. Үүнд нэгдүгээрт, хариуцагч хуулиар болон шүүгчийн тогтоосон хугацаанд тайлбар гаргаагүй боловч тэрээр шүүх хуралдаан эхлэхээс өмнө буюу¹⁵ нэгээс доошгүй өдрийн дотор тайлбар, нотлох баримтыг гаргасан бол шүүх хүлээн авах эсэх, шүүх хүлээн авсан бол нэхэмжлэгч уг тайлбар, нотлох баримттай танилцах, түүнд тайлбар өгөх боломж олгох эсэх, олгосон бол энэ шүүх хуралдааны товд өөрчлөлт оруулах эсэх асуудлыг харьцуулсан судалгааг үндэслэн шийдвэрлэх, хоёрдугаарт, хариуцагч шүүх хуралдаан хүртэл тайлбар, нотлох баримт ирүүлээгүй, тэрээр шүүх хуралдаан дээр тайлбар, нотлох баримтаа ирүүлсэн тохиолдол мөн хамаарна. ИХШХШтХ-ийн 105 дугаар зүйлийн 105.2 дахь хэсгийн зохицуулалт нь хэргийн оролцогчоос нэмэлт тайлбар, нотлох баримтыг гаргаж өгч байгаа асуудалд хамаарах бөгөөд хариуцагч өмнө нь гаргаж байгаагүй тайлбарыг шүүх хуралдаан дээр шинээр гаргаж өгч буй тохиолдлыг зохицуулаагүй юм.

3.2. ИХШХШтХ-ийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалтын “Энэ хуулийн 71.1-т заасан хугацаа дууссан” гэсэн үндэслэлээр шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх захирамж гаргах, шүүх хуралдаан товлохтой холбоотой асуудал

Хуулийн 76 дугаар зүйлийн гарчиг нь “Шүүх хуралдааны бэлтгэл хангах шүүгчийн ажиллагаа” гэж заасан. Уг зохицуулалтаас үзвэл шүүгч хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх захирамж гарган шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг

14 Хэргийн оролцогч шүүх хуралдаанд ирээгүй тохиолдлын үр дагаврыг шийдвэрлэсэн ИХШХШтХ-ийн 100 дугаар зүйлийн зохицуулалтад тусад нь дүн шинжилгээ хийхээр төлөвлөж байгаа тул дэлгэрэнгүй тайлбар дараа хийгдэнэ.

15 ИХШХШтХ-ийн зохицуулалтаас дүгнэвэл шүүх хуралдаан хэзээ эхлэдэг вэ? гэсэн асуулт тодорхой бус байдаг. Зарим нь хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх захирамж гарснаар /хуулийн 76 дугаар зүйл/, нөгөө хэсэг нь шүүх хуралдааны ажиллагааг нээснээс /хуулийн 98 дугаар зүйл/, гэтэл нэг хэсэг нь хэргийн оролцогчоос гаргасан хүсэлт хэлэлцэх үед /хуулийн 105 дугаар зүйл/ гэж тайлбарладаг. Уг цаг хугацааг тодорхой болгох нь нотлох баримт цуглуулах, гаргаж өгөх ажиллагаа хэдийд дуусгавар болох, ийнхүү энэ ажиллагааг дуусгавар болсноор хэргийн оролцогчид маргааны хүрээ, хязгаарыг тогтоох боломж бүрдэх юм.

зааж хэргийн болон шүүх хуралдааны оролцогчид мэдэгдэх юм. Харин 76.2-т заасан зохигч шүүх хуралдааны товыг шүүхээс лавлах үүргийн зохицуулалт нь гарчиг буюу шүүх хуралдааны бэлтгэл хангах шүүгчийн ажиллагаанд хамаарахгүй тул тусад нь буюу 76 дугаар зүйлээс өөр хэсэгт зохицуулах нь системчлэлийн хувьд зөв болно.

Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх үндэслэлийг ИХШХШТХ-ийн 76 дугаар зүйлийн 76.1.1-т “Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт хангалттай бүрдсэн гэж шүүгч үзсэн, эсхүл энэ хуулийн 71.1-т заасан хугацаа дууссан, түүнчлэн шаардлагатай гэж үзсэн бусад тохиолдолд” гэж тодорхойлсон нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны диспозитив зарчимд нийцэхгүй байна. Өмнө дурдсанчлан, диспозитив зарчим нь талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удирдах буюу эхлүүлэх, үргэлжлүүлэх, дуусгавар болгохыг шийдвэрлэх учиртай. Шүүгч уг ажиллагааг чиглүүлэх үүрэгтэй.¹⁶

Хуулийн энэ заалтын гипотезийг задалж үзвэл, нэгдүгээрт хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт хангалттай бүрдсэн, хоёрдугаарт энэ хуулийн 71.1-т заасан хугацаа дууссан, гуравдугаарт шаардлагатай гэж үзсэн бусад тохиолдолд гэж хувааж болохоор байна. Эдгээр нөхцөлийн аль нэг хангагдсан тохиолдолд шүүгч шүүх хуралдааныг товлох тухай захирамж гаргах үр дагавар үүснэ.

“Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт хангалттай бүрдсэн гэж шүүгч үзсэн” гэх нөхцөл нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохигчдын санаачилга, хүсэлтийн үндсэн дээр явуулах диспозитив зарчмын агуулгад нийцэхгүй байна гэж өмнө дурдсан билээ. Учир нь ИХШХША-нд хэргийн оролцогч мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэхдээ шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлага, түүнийг үгүйсгэх, татгалзах үндэслэл, тайлбар түүнтэй холбоотой баримтыг өөрөө нотлох, нотлох баримтыг цуглуулах, гаргаж өгөх эрхтэй бөгөөд уг эрхээ хэрэгжүүлсэн гэж үзэж шүүхэд мэдэгдсэн тохиолдолд шүүх процессын дараагийн алхам болох хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр болсныг баталгаажуулж захирамж гаргах учиртай. Иймд диспозитив зарчмыг үндэслэвэл хэргийн оролцогч хангалттай нотлох баримт бүрдсэн гэж үзсэн тохиолдолд шүүх уг ажиллагааг дараагийн шатанд шилжсэн байдлыг баталгаажуулж захирамж гаргах юм.

Өөрөөр хэлбэл, хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт хангалттай бүрдсэн эсэхийг тухайн хэргийн зохигчид бус “шүүгч” өөрийн үзэмжээр шийдвэрлэх байдлаар хуульчилсан нь диспозитив зарчимд харшилж байна. Харин 1994 оны ИХШХШТХ-ийн 75 дугаар зүйл “Шүүх хуралдааны бэлтгэл хангах шүүгчийн ажиллагаа” гэсэн зохицуулалтаас үзвэл “Хэргийг хянан шийдвэрлэхэд нотлох баримт хангалттай гэж зохигч үзсэн” тохиолдолд шүүгч хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх захирамж гаргаж байсан ололттой зохицуулалтаас 2002 онд ухарсан гэж дүгнэхээр байна.

ИХШХШТХ-ийн 76 дугаар зүйлд хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх хоёр дахь үндэслэлийг хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсэгт заасан хугацаа дууссан гэж тодорхойлсон. Тодруулбал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг “Хуулиар өөр хугацаа тогтоогоогүй бол хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоног, давж

16 “Шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг чиглүүлэх үүрэгтэй” гэх талаар манай хуульд шууд тусгагдаагүй, уг үүргийн талаар хуульд хэрхэн зохицуулсан талаарх харьцуулсан судалгааны үндсэн дээр илрүүлэх боломжтой, энэ нь судалгааны өөр сэдэв болох тул энд дэлгэрүүлэн тайлбарлахгүй орхив.

заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ”¹⁷ гэж заасан. Үүнээс үзвэл, хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоног өнгөрсөн бол хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт хангалттай бүрдсэн эсэхээс үл хамааран шүүх хуралдааныг товлож болохыг хуулиар зөвшөөрсөн байна. Гэвч ИХШХШТХ-ийн 71 дүгээр зүйлийн 71.1 болон 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалт нь агуулгын хувьд өөр хоорондоо зөрчилдөж байна. Учир нь хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсгийн зохицуулалт нь хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоногийн дотор шүүх хуралдааныг товлож, хэргийг шийдвэрлэх агуулгатай. Харин хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалтад 60 хоногийн хугацаа дууссаны дараа хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамж гаргаж болохоор зохицуулсан байна. Эндээс дүгнэвэл, шүүх хуралдааны товыг хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоногийн дотор зарлах эсхүл 60 хоногийн хугацаа дууссаны дараа зарлах гэсэн зөрчлөөс үүдэн хугацааг зөв ойлгож хэрэглэхэд эргэлзээ үүсгэхээр байна.¹⁸

Нөгөө талаас иргэний хэргийн анхан шатны шүүх дэх хэргийн үлдэгдлийн сүүлийн 3 жилийн дунджаас үзвэл, нийт хэргийн үлдэгдлийн 88.5 орчим хувь нь хэрэг хянан шийдвэрлэх хуулийн хугацаанд, харин 11.5 хувь нь хугацаа хэтэрсэн үзүүлэлттэй байна.¹⁹ Энэ үзүүлэлт нь хэрэг хянан шийдвэрлэх хугацаа дууссан гэх үндэслэлээр шүүх хуралдааныг товлох нь ач холбогдол багатай болохыг шууд бус байдлаар илэрхийлж байна. Иймд ИХШХШТХ-ийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалтаас “эсхүл энэ хуулийн 71.1-т заасан хугацаа дууссан” гэснийг хасах нь зүйтэй. Энэ зохицуулалт нь 1994 оны Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтаас уламжлагдан ирсэн, цаг хугацааны хувьд одоогийн нөхцөлд шаардлагагүй болжээ.

3 дахь үндэслэл буюу “...түүнчлэн шаардлагатай гэж үзсэн бусад тохиолдолд” шүүгч хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр заажээ. ИХШХШТХуулийн ердийн ажиллагаагаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтын хүрээнд хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзэх тохиолдлуудын талаар заалт байхгүй. Хууль тогтоогч ийнхүү шаардлагатай гэж үзсэн тохиолдлуудыг шүүгчийн үзэмжид үлдээгээгүй, үлдээх ч учиргүй юм. Түүнчлэн 1994 оны ИХШХШТХ-ийн 75 дугаар зүйлийн зохицуулалттай яг адил томъёологдсон нь иргэний хэрэг хянан шийдвэрлэх социалист маягийн хуультай /1967 оны БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх хуулийн 110 дугаар зүйлийг “Хэргийг шүүхээр хэлэлцүүлэхэд бэлтгэх шүүгчийн ажиллагаа”-ны 13 дахь хэсэгт “Энэ хуулийн дагуу шүүгч ганцаараа гүйцэтгэж болох бусад ажиллагаа явуулах эрхтэй”/ байснаас улбаатай гэж дүгнэхээр байна. 2002 оны хуулийн холбогдох зохицуулалтыг зарим судлаачид хэрэг хянан шийдвэрлэх онцгой ажиллагаанд хамаарна гэж тайлбарладаг боловч системчлэлийн хувьд оновчгүй байршуулсан гэж няцааж болно. Хэрэв хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзэх тохиолдол нь онцгой ажиллагаанд хамаарна гэвэл тухайн журмын зохицуулалт болох хуулийн 133-155 дугаар зүйлд зохицуулах эсхүл уг хуульд заасан гэж урьдчилсан нөхцөл оруулах байжээ.

17 Тус зохицуулалт нь диспозитив зарчимтай нийцэхгүй.

18 Й.Кают, Монгол Улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, 2015 он, 59 дахь тал

19 Уг тоон үзүүлэлтийг шүүхийн тайланд тусгагдсан хэргийн үлдэгдлээс тооцсон болохыг анхаарна уу.

3.3. Шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт гаргуулж, шүүх хуралдааныг хойшлуулахтай холбоотой асуудал

Хэргийн оролцогч шүүх хуралдааныг хуульд заасан үндэслэлээр хойшлуулах тухай хүсэлт гаргах эрхтэй. Нотлох баримт гаргах, цуглуулах, бүрдүүлэхтэй холбоотойгоор шүүх хуралдааныг хойшлуулах талаар ИХШХШТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.9 дэх хэсэгт “Шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт шаардагдвал шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулах, хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг хэргийн нотлох баримтаас хасах буюу шаардан авахаас татгалзах эрхийг шүүх эдлэх бөгөөд эдгээр тохиолдолд шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана” гэж заасан.

Гэвч хуулийн дээрх хэсэгт “Шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт шаардагдвал” гэж заасан нь хэргийн оролцогчдын хүсэл зоригоос үл хамаарах шинжтэй байна. Өөрөөр хэлбэл, тус зохицуулалтыг шүүх хуралдаанд хэргийн оролцогч хүсэлт гаргаагүй, шүүхэд шинэ нотлох баримт шаардлагатай болсон тохиолдолд үр дагавар нь шүүх хуралдааныг хойшлуулж, хэргийн оролцогчийн хүсэл зоригоос үл хамааран шүүх нотлох баримт цуглуулах ажиллагаа хийх эрхтэй, үүрэгтэй мэт ойлгогдохоор байна. Үүнийг хэргийн оролцогч, түүний өмгөөлөгч, төлөөлөгч нараас шүүхэд гаргаж буй давж заалдах болон хяналтын гомдолд тусгагдаж байгаагаар тайлбарлаж болно. Энэ зохицуулалт нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг мэтгэлцэх зарчмын үндсэн дээр хэрэгжүүлэх гэснийг зөрчсөн алдаатай зохицуулалт болсон байна. Диспозитив зарчимд нийцээгүй тул хуулийн 38.9 дэх хэсгээс уг зохицуулалтыг хасах нь зүйтэй.

Харин ИХШХШТХ-ийн 105 дугаар зүйлийн 105.2 дахь хэсэгт “Хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдолтой нэмэлт тайлбар, нотлох баримтыг урьд нь гаргах буюу санал болгох бололцоотой байсан боловч шүүх хуралдааны үед гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаантай гэж шүүх үзвэл түүнийг хүлээн авч, шинжлэн судлах шаардлагатай бол шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулж болно” гэж заасан. Энэ зохицуулалтын дутагдалтай тал нь “Хүндэтгэх үзэх шалтгаантай” гэдгийг хэрхэн тайлбарлаж хэрэглэх явдал болно. ИХШХШТХ-ийн зохицуулалтуудаас үзвэл хүндэтгэн үзэх шалтгааныг тайлбарлахтай холбоотой тусламж үзүүлэх заалт байхгүй гэж дүгнэхээр байна.

Практикт “Хүндэтгэн үзэх шалтгаан” гэдгийг хэрхэн хэрэглэж байгаа талаар судалгаа хийж дараах дүгнэлтэд хүрэв. Шүүх хуралдааныг хойшлуулж буй шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжаас харвал ихэнх тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулах хүсэлтийг хариуцагч талаас гаргадаг ба уг хүсэлтдээ дурдсан шалтгаан нь шинэ баримт, материалыг нотлох баримтаар гаргуулахтай холбоотой байх бөгөөд шүүхээс хүндэтгэн үзэх шалтгааныг тодруулалгүйгээр хүсэлтийг хүлээн авсан байдаг. Шүүх хуралдааны тэмдэглэлээс үзвэл шүүгч хүсэлт гаргагч талаас хүндэтгэн үзэх шалтгаантай байсан эсэх талаар асуудаг боловч шүүгчийн захирамж, тогтоолын үндэслэх хэсэгт төдийлөн ойлгомжтой байдлаар илэрхийлж бичдэггүй байна. Өөрөөр хэлбэл, актын үндэслэх хэсэгт “...хүсэлтийг хүлээж авах нь зүйтэй байна” гэх агуулгаар илэрхийлсэн нь шүүгч өөрийн үзэмжээр шийдвэрлэж байгаа гэсэн дүгнэлтэд хүрдэг. Иймд ИХШХШТХ-ийн 105.2-т заасан “Хүндэтгэн үзэх шалтгаан”-д ямар нөхцөл байдлыг тооцохыг практикт үлдээж шийдвэрлэсэн нь оновчтой шийдэл болсон гэж дүгнэх боломжгүй байна.

Иргэний хэргийн анхан шатны шүүх дэх хэргийн үлдэгдэл нь сүүлийн 3 жилийн дунджаар 6961 байна. Үүнээс хуулийн хугацаанд хянан шийдвэрлэгдэж

буй 4656 буюу 66.8 хувь, шүүх хуралдаан хойшлуулсан 502 хэрэг буюу 7.2 хувь, түдгэлзүүлсэн 1010 буюу 14.5 хувь, хуулийн хугацаа хэтэрсэн хэрэг 792 буюу 11.3 хувийг тус тус эзэлж байна.

Иргэний хэргийн анхан шатны шүүх дэх хэргийн үлдэгдэл /Сүүлийн 3 жил/

№		2018 он	2019 он	2020 он	Дундаж тоо	Хувь
	Тайлангийн эцсийн үлдэгдэл	5966	7107	7812	6961	
1.	Хуулийн хугацаанд	3790	5016	5162	4656	66.8
2.	Хойшлуулсан	667	484	356	502	7.2
3.	Түдгэлзүүлсэн	922	960	1150	1010	14.5
4.	Хугацаа хэтэрсэн	587	647	1144	792	11.3

Эх сурвалж: Шүүхийн ерөнхий зөвлөл, Монгол Улсын шүүхийн тайлан 2018, 2019, 2020.²⁰

Судалгаанаас үзвэл шүүх хуралдаан хойшлуулсан хэргийн тоо бууралттай харагдаж байгаа боловч үндэслэл нь хуульд нийцсэн эсэх байдал анхаарал татна.

ИХШХШТХ-д хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулах дараах 5 үндэслэлийг заасан. Үүнд:

- “Шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт шаардагдсан” (ИХШХШТХ-ийн 38.9.)²¹;
- “Зөрчлийн улмаас хэргийн оролцогч, гэрч, шинжээчийг шүүх хуралдааны танхимаас гаргасан бөгөөд тэдгээрийн тайлбар, мэдүүлгийг сонсох шаардлагатай гэж шүүх хуралдаан даргалагч буюу шүүгч үзсэн” (ИХШХШТХ-ийн 90.5.);
- “Томилогдсон иргэдийн төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй бөгөөд зохигчийн аль нэг нь түүний эзгүйд шүүх хуралдаан явуулахыг зөвшөөрөөгүй” (ИХШХШТХ-ийн 100.8.);
- “Хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдолтой нэмэлт тайлбар, нотлох баримтыг урьд нь гаргах буюу санал болгох бололцоотой байсан боловч шүүх хуралдааны үед гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаантай гэж шүүх үзсэн бол түүнийг хүлээн авч, шинжлэн судлах шаардлагатай” (ИХШХШТХ-ийн 105.2.)
- “Гэрлэгчдийн хэн нэг нь хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдаанд ирээгүй бол” шүүх хуралдааныг хойшлуулж болно. (ИХШХШТХ-ийн 131.2.)

Шүүхийн практикт хийсэн судалгаанд шүүх хуралдаан хойшилсон тохиолдлыг дараах байдлаар ангилан авч үзсэн байна.

20 Уг судалгаанаас дүгнэлтийг харьцангуй байдлаар хийсэн болно. Учир нь судалгаанаас иргэний хэргийн үлдэгдлийг хуулийн хугацаанд байгаа хэрэг, хуулийн хугацаа хэтэрсэн хэргүүд гэж ангилж харж болох боловч шүүх хуралдаан хойшлуулсан хэрэг, түдгэлзүүлсэн хэрэг нь хуулийн хугацаанд байгаа эсхүл хугацаа хэтэрсэн хэргүүдийн алинд хамаарч байгаа нь тодорхой бус байгааг тэмдэглэх нь зүйтэй байна.

21 Судалгааны тайлангийн 3.3 дахь хэсэгт ИХШХШТХ-ийн 38.9 дэх хэсэгт “Шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт шаардагдвал” гэж заасан нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны диспозитив зарчимд нийцээгүй гэж үзсэнийг энд тэмдэглэх нь зүйтэй.

№	Төрөл	Үндэслэл	ИХШХШТХ-ийн зүйл, заалт
1.	Нотлох баримт гаргахтай холбоотой	Хэргийн оролцогчид өөрөө олж авах боломжгүй нотлох баримтыг байгууллага, аж ахуй нэгж болон бусад этгээдээс гаргуулах хүсэлт;	38.9
		Хэргийн оролцогчид гэрч оролцуулах, дуудах хүсэлт	37.2 25.1.3
		Хэргийн оролцогчид шинээр ирүүлсэн нотлох баримттай танилцах хүсэлт;	25.1.3,
		Шинжээч томилуулах, үзлэг хийлгүүлэх хүсэлт;	37.1, 47.1
2.	Өмгөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс хамааралтай	Шүүх хуралдаанд оролцох боломжгүй болсон. (шүүх хуралдаан давхацсан, эрүүл мэндийн шалтгаан, хэргийн материалтай танилцах зэрэг)	6, 32.4, 34
3.	Өмгөөлөгч, хууль зүйн туслалцаа авахтай холбоотой	Зохигчдын итгэмжлэгдсэн төлөөлөгч нар өмгөөлөгч авах хүсэлт гаргасан;	32.4, 34
4.	Шүүхээс хамааралтай	Шүүгчийн захирамжийн биелэлтийг хангуулах; Хэргийн оролцогчдод хурлын тов мэдэгдээгүй; Эрх, үүрэг танилцуулаагүй зэрэг.	-
5.	Сөрөг нэхэмжлэл гаргасан	Хариуцагчаас сөрөг нэхэмжлэл гаргасан;	3, 26.3, 73
6.	Бусад тохиолдол	Эвлэрэн хэлэлцэх хугацаа олгох хүсэлт гаргасан, хэргийн оролцогчид хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй, шүүгчийг татгалзан гарах, шүүх хуралдааны өдөр шүүгчийн захирамжид гомдол гаргасан зэрэг.	-

Судалгаанаас дүгнэвэл шүүх хуралдаан хойшлуулж байгаа “Хүндэтгэн үзэх шалтгаан”-д хэргийн оролцогчийн эрүүл мэндийн байдлыг оруулжээ. Бусад үндэслэлүүд нь хүндэтгэн үзэх шалтгаантай байсан эсэх талаар судалгаанд дурдагдаагүй байна. Түүнээс гадна шүүх хуралдаан давхцах асуудал нь хэргийн оролцогчид биш өмгөөлөгчийн үйл ажиллагаанаас²² хамаарч байна.²³

Монгол Улсын Дээд шүүхийн 2002 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа хугацаа хэтэрсэн болон түдгэлзүүлсэн хэргийн судалгааны тойм”-д 2019 оны байдлаар анхан шатны 38 шүүхэд ажиллагаанд байгаа хугацаа хэтэрсэн 647 хэрэг нь нийт ажиллагаанд байгаа хэргийн 9,5 хувийг эзэлж байгаа талаар дурджээ.

Дээрх судалгааны тоймд дурдсан дүгнэлтэд хэргийн оролцогчоос шалтгаалж шүүх хуралдаан хойшилсон үндэслэл нь нотлох баримт гаргаж өгөх, нотлох баримт гаргуулах, бүрдүүлэх /шинжээч томилуулах г.м/, нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлсэн, өөрчилсөн, тодруулсан, өмгөөлөгч авах эрхээр хамгаалуулах, хэргийн материалтай танилцах, /эсрэг талын шүүх хуралдаан дээр гаргаж өгсөн

22 Хэргийн оролцогчийн төлөөлөгч нь мэргэжлийн байх эсэх талаар судалгаа хийж, шийдэл гаргах, ялангуяа давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд оролцох оролцоонд хязгаарлалт тогтоох эсэх асуудлыг шийдвэрлэх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хурдан шуурхай явуулахад ач холбогдолтойг тэмдэглэх нь зүйтэй байна.

23 ИХШХШТХ-ийн 34 дүгээр зүйл “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох, түүний эрх, үүрэг” -ийг зохицуулсан заалтуудаас үзвэл хэргийн оролцогчийн эрхтэй /хуулийн 25 дугаар зүйл/ давхацсан, хэргийн оролцогчийн эдлэх эрхээс илүү байгаагаас дүгнэлт хийх, хууль зүйн техникийн хувь иш татах байдлаар томъёолох алдаатай болсныг тэмдэглэх нь зүйтэй.

баримттай танилцах г.м/ сөрөг нэхэмжлэл гаргах, шүүх хуралдаан давхардах, өвчтэй, чөлөөтэй байх, хэргийн оролцогч, шүүх бүрэлдэхүүнээс татгалзах, бие даасан шаардлага гаргасан, гаргаагүй гуравдагч этгээд оролцох, бусад гэж тодорхойлсон бол шүүхээс шалтгаалсан үндэслэлийг хэргийн оролцогчид хуралдааны тов мэдэгдээгүй, хэргийн материалтай танилцах боломж олгоогүй, өмнөх захирамжийн заалт биелэгдээгүй, /биелүүлэх талаар шаардлагатай анхаарал тавиагүйгээс/ гэрч, хариуцагчийг албадан ирүүлэх, шүүх хуралдаанд биечлэн оролцуулах зэргийг дурдсан байна.

Тус судалгааны тоймд шүүх хуралдааныг хойшлуулахад нөлөөлсөн хэд хэдэн үндэслэлийг дурдсан бөгөөд бидний хийж буй дүн шинжилгээнд хамааралтай хэсэг нь “Шүүх хуралдаан хойшлуулж байгаа үндэслэлийг үзэхэд шүүгч, шүүх бүрэлдэхүүн ихэнх тохиолдолд хэргийн оролцогчийн хүсэлтийг хүлээн авч, хангаж байх боловч шүүх хуралдааны үед гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаантай байсан эсэх, энэ нь баримтаар тогтоогдсон эсэх талаар шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид үндэслэл бүхий дүгнэлт хийлгүйгээр шүүх хуралдааныг хойшлуулж байгаа нь хуулийн дээрх заалтыг /ИХШХШтХ 105.2/ шүүгч биелүүлэхгүй байна” гэж дүгнэсэн байдал юм.

Дээрхээс үзэхэд, практикт шүүх хуралдаан хойшилж байгаа үндэслэлүүдийн ихэнх нь хэргийн оролцогчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эдлэх эрхийг хангах, мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байгааг буруутгах боломжгүй боловч хүндэтгэн үзэх шалтгаантай байдлыг шүүх хуралдааныг хойшлуулах урьдчилсан нөхцөл болгосон байдалд анхаарахгүй байна гэж дүгнэхэд хүргэж байна..

ОХУ-ын Иргэний процессын кодексийн 169 дүгээр зүйлд шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэлийг “Тухайн хуульд заасан үндэслэл болон хэргийн оролцогч ирээгүй, сөрөг нэхэмжлэл гаргасан, нэмэлт нотлох баримт шаардлагатай болсон, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинээр оролцогч оруулахаар болсон тохиолдол нь шүүх хуралдааныг явуулах боломжгүй болсон гэж шүүх үзсэн бол” гэж нөхцөлийг тоочих аргыг хэрэглэсэн сайн туршлага байна. Тус зохицуулалт нь шүүгч шүүх хуралдааныг хойшлуулах баримжааг бий болгож байна.

Шүүх хуралдааныг практикт нэг бус удаа хойшлуулдаг. Энэ нь ч үндэслэлтэй байдаг тул ИХШХШтХ-ийн 105.2-т заасан шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулах гэсэн зохицуулалтыг эргэж харах хэрэгтэй байна.

Иймд шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулах шаардлага тавигдаж байгаа бол хуралдааны бэлтгэл сайн хангагдсан байх учиртай. Шүүх хуралдааны бэлтгэл ажиллагааг хангах нь зөвхөн шүүхийн үүрэг биш юм. Хэргийн оролцогч шүүх хуралдаанд бэлтгэл ажиллагааг хангасан байх ёстой. Энэ бэлтгэл ажиллагаа хэрхэн хангагддаг талаарх зохицуулалт дутмаг тул хэргийн оролцогч хэрхэн шүүх хуралдаанд бэлдэж ирэхээ мэддэггүй. Дүгнэвэл, шүүх хуралдаан болохоос өмнө нотлох баримт бүрэн бүрдсэн байх ёстой цаг хугацааг тодорхойлох, тухайн цаг хугацаанд нотлох баримт гаргаж өгөөгүй гэдгийг ойлгомжтой томъёолох шаардлагатай байна.

Мөн урьдчилсан шүүх хуралдаан хийх, урьдчилсан шүүх хуралдаан дээр шийдвэрлэвэл зохих асуудлыг хуулиар тодорхойлж өгөх шаардлага бий болсон гэж дүгнэж байна.

Дөрөв. Харьцуулалт

Судалгааны холбогдох зүйл, заалтууд нь ХБНГУ-ын Иргэний процессын кодекс /цаашид “ИПК” гэх/ болон Япон Улсын Иргэний процессын дүрэмд тус тус хэрхэн тусгагдсаныг харьцуулан хүснэгтээр харуулав.

№	Харьцуулалт		
	Монгол Улсын ИХШХШТХ	ХБНГУ-ын ИПК	Япон Улсын Иргэний процессын дүрэм
	Иргэний хэрэг үүсгэхээс өмнө хийгдэх ажиллагаатай холбоотой асуудал		
1.	66.1.Шүүгч энэ хуулийн 13.2, 65.1-д заасан үндэслэл байхгүй гэж үзвэл нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор хэрэг үүсгэх тухай захирамж гаргана.	Иргэний хэрэг үүсгэх тухай шууд үгчлэн хуульчлаагүй боловч нэхэмжлэлийг хүлээн авч, хүргүүлснээр ИХШХША эхэлнэ.	137 дугаар зүйл. Нэхэмжлэл 133 дугаар зүйлд нийцээгүй бол шүүгч хугацаа тогтоож, тус хугацаанд нийцээгүй зөрчлийг хэрхэн засахыг заасан захирамж гаргана. 137.2. 133.1 дэх хэсэгт зааснаар зөрчлийг нэхэмжлэгч засаагүй бол шүүгч нэхэмжлэлийг буцаах тухай захирамж гаргана. 137.3. 137.2 дахь хэсгийн дагуу гаргасан захирамжид даруй гомдол гаргаж болно.
2.	170 дугаар зүйл. Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гомдол гаргах. 170.1.Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 20.1, 38.9, 65.1.1-65.1.8, 65.1.10, 69.1, 92.4, 97.1, 100.2 дахь хэсэг, 80, 117, 124 дүгээр зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гарсан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргаж болно. 171 дүгээр зүйл. Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх. 171.1.Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт энэ хуулийн 170.1-д заасны дагуу гаргасан гомдлыг 14 хоногийн дотор тухайн хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгчийг оролцуулахгүйгээр 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр дараах байдлаар хянан шийдвэрлэж тогтоол гаргана:		250 дугаар зүйл. Талууд урьдчилсан хэлэлцүүлгийг чиглүүлэхтэй холбоотойгоор даргалагч шүүгчийн гаргасан захирамжид гомдол гаргасан бол шүүх тухайн гомдлыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоол гаргана. 90 дүгээр зүйл. Талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой зохицуулалтын зөрчлийг мэдсэн буюу мэдэх боломжтой байсан ч даруй гомдол гаргаагүй бол гомдол гаргах эрхээ алдана. Харин эрхээ алдах боломжгүй тохиолдлын хувьд энэ хамаарахгүй.
Иргэний хэрэг үүсгэснээс хойш хийгдэх ажиллагаатай холбоотой асуудал			

1.	72 дугаар зүйл. Нэхэмжлэлийг хариуцагчид гардуулах. 72.1.Хэрэг үүсгэсэн өдрөөс хойш хариуцагчид нэхэмжлэлийг нийслэлд 7 хоногийн, орон нутагт 14 хоногийн дотор тус тус гардуулна.	271 дүгээр зүйл. Нэхэмжлэлийг хүргүүлэх 1. Нэхэмжлэлийг нэн даруй хүргүүлнэ. 2. Хариуцагч нэхэмжлэлийг гардан аваад нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрсөн тохиолдолд өмгөөлөгч томилуулах хүсэлт гаргана. 277 дугаар зүйл. Хариу тайлбар гаргах 1. Хариуцагчийн бичгээр хариу тайлбараа гаргах хугацаа дор хаяж 2 долоо хоног байна.	Хугацааг багасгах, нэмэлт хугацаа тогтоох. 96 дугаар зүйл. Шүүх хуулиар тогтоосон болон шүүхээс тогтоосон хугацааг сунгах эсхүл багасгаж болно. Харин өөрчилж болохгүй хугацаанд энэ хамаарахгүй. 96.2 Өөрчилж болохгүй хугацааны хувьд шүүхээс хол газрын хаяг дээр оршин суудаг этгээдэд зориулж нэмэлт хугацаа тогтоож болно.
2.	72.3. Хариуцагч нэхэмжлэлийг хүлээн авсан боловч энэ хуулийн 72.2-т заасан үүргээ биелүүлээгүй, түүнчлэн энэ хуулийн 77 дугаар зүйлд заасан журмын дагуу шүүхэд ирж тайлбар өгөөгүй бол нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцож энэ хуулийн 100.3-т зааснаар түүний эзгүйд хэргийг шийдвэрлэнэ.	269 дүгээр зүйл. Нэхэмжлэлийн хувийг гардуулан өгсөн өдрөөс хойш хуульд заасан хугацаа болох 2 долоо хоногийн дотор хариуцагч бичмэл тайлбараа шүүхэд ирүүлээгүй тохиолдолд нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрсөнд тооцож, эсэргүүцлийг хүчингүйд тооцох бөгөөд хариуцагчид энэ тухай үр дагаврыг урьдчилж мэдэгдсэн байна.	105 дугаар зүйл. Нэхэмжлэлийг хүлээн авбал зохих этгээдийн хаяг тодорхойгүй тохиолдолд тухайн этгээдийн байгаа газар биечлэн гардуулж болно.
3.	76 дугаар зүйл. Шүүх хуралдааны бэлтгэл хангах шүүгчийн ажиллагаа 76.1.Хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан шүүгч дараах бэлтгэл ажиллагаа явуулна: 76.1.1.хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт хангалттай бүрдсэн гэж шүүгч үзсэн, эсхүл энэ хуулийн 71.1-д заасан хугацаа дууссан, түүнчлэн шаардлагатай гэж үзсэн бусад тохиолдолд шүүгч уг хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай захирамж гаргаж, шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг товлон; 38 дугаар зүйл. Нотлох баримт гаргах ба цуглуулах, бүрдүүлэх	§227-д шүүх хуралдааны товыг өөрчлөх тухай заасан. Ингэхдээ “чухал үндэслэл” (хүндэтгэн үзэх шалтгаан) байгаа тохиолдолд шүүх хуралдааны товыг цуцлах, хойшлуулах, эсхүл шүүх хуралдааныг хойшлуулж болно гэжээ. Энэхүү “чухал үндэслэл гэдэгт дараах нөхцөл байдал хамаарахгүй: Талууд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй эсхүл ирэхгүй тухайгаа мэдэгдээгүй; • Талуудын бэлтгэл хангалтгүй бөгөөд үүнийгээ зөвтгөх үндэслэл байхгүй бол; • Талуудын нэг тал нь дангаараа зөвшөөрсөн бол гэжээ.	Хугацаа мэдэгдэх 154 дугаар зүйл. Шүүх хуралдааны товыг тов мэдэгдэх хуудас, тухайн хэрэгт оролцсон этгээдэд шууд мэдэгдэх, бусад зохих аргаар хэрэгжүүлнэ. Хугацаа тогтоох, өөрчлөх 93 дугаар зүйл. Хугацааг хүсэлт эсхүл шүүхэд олгогдсон эрх хэмжээний дагуу шүүх хуралдаан даргалагч тогтооно. 93.3. Урьдчилсан шатны хэлэлцүүлэг, хэлэлцүүлгийн бэлтгэл ажиллагааны хугацааг гагцхүү хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд өөрчилж болно. Харин эхний хугацааг талуудын зөвшөөрлийн үндсэн дээр өөрчилж болно.

	- 38.9. Шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт шаардагдвал шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулах, хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг хэргийн нотлох баримтаас хасах буюу шаардан авахаас татгалзах эрхийг шүүх эдлэх бөгөөд эдгээр тохиолдолд шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.	Шүүх хуралдааны тов болон шүүх хуралдаан хойшлуулах үндэслэлд зохицуулсан бас нэгэн онцгой зохицуулалт нь “Долдугаар сарын 1-ээс Наймдугаар сарын 31-ний хооронд товлосон шүүх хуралдааныг талуудын 7-оос доошгүй хоногийн өмнө бичгээр гаргасан хүсэлтийн дагуу хойшлуулж болно” гэсэн бөгөөд гэвч дараах тохиолдолд хойшлуулахгүй: Хөрөнгө хураахтай холбоотой маргаан, шүүхийн даалгавар, шүүхийн хамгаалалт тогтоосон шийдвэртэй холбоотой хэрэг маргаан • Зай талбай ашиглах, нүүхтэй холбоотой маргаан, орон сууцны түрээсийн гэрээг үргэлжлүүлэх эсэхтэй холбоотой маргаан; • Векселээс үүссэн нэхэмжлэл эсвэл чекийн төлбөрийн талаар гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг хянан шийдвэрлэх ажиллагаа; • Нэгэнт эхэлсэн барилгын төслийг үргэлжлүүлэх эсэхтэй холбоотой барилгын эрх зүйн маргаан; • Шүүхийн эрх бүхий байгууллагаас харьяалах эрхгүй этгээдэд эд юмс ашиглах зөвшөөрөл олгох, эсвэл хүлээлгэн өгсөнтэй холбоотой маргаан; • Албадан гүйцэтгэх ажиллагаа; Хүчин төгөлдөр болох тухай мэдэгдэх эсхүл арбитрын ажиллагааны явцад шүүгчээс арга хэмжээ авах ажиллагаа.	- 93.4 Дээр дурдсанаас үл хамааран хэлэлцүүлгийн бэлтгэл ажиллагаа дуусаж, урьдчилсан шатны хэлэлцүүлэгт шилжсэн бол хэлэлцүүлгийн хугацааг зайлшгүй шалтгаантайгаас бусад тохиолдолд өөрчилж болохгүй.
--	---	--	--

4.	105 дугаар зүйл. Хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг шийдвэрлэх 105.2.Хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдолтой нэмэлт тайлбар, нотлох баримтыг урьд нь гаргах буюу санал болгох бололцоотой байсан боловч шүүх хуралдааны үед гаргасан нь хүндэтгэн үзэх шалтгаантай гэж шүүх үзвэл түүнийг хүлээн авч, шинжлэн судлах шаардлагатай бол шүүх хуралдааныг нэг удаа хойшлуулж болно.	296 дугаар зүйл. Хожимдсон хүсэлтийг хангахаас татгалзах (1) Аливаа хариу тайлбар, хамгаалах арга хэрэгслийг тогтоосон хугацаанд гаргаагүй хожимдуулсан нь үүнийг хүлээн авахад хэрэг хянан шийдвэрлэх хугацааг сунжруулахгүй гэж үзэхээр байгаа, мөн талууд хүндэтгэн үзэх шалтгаантай байсан бол шүүх өөрийн үзэмжээр харгалзан үзэж хүлээн авах эсэхийг шийдвэрлэнэ.	-
----	---	---	---

Тав. Дүгнэлт, санал

ИХШХШТХ-ийн үндсэн зарчим болох диспозитив зарчмыг тодорхойлохдоо уг зарчмыг өөрийг нь тодорхойлохоос илүүтэйгээр талуудын эрх, үүрэг хэрэгжүүлэх хэсэгт тусгаж өгөх шаардлагатай. Жишээлбэл, хэргийн оролцогч нь тайлбар, тайлбараа нотлож буй нотолж баримтын жагсаалтыг эсрэг талдаа илгээх, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх хүсэлт гаргах /ач холбогдол нь өөрийн зүгээс өгөх тайлбар, нотлох баримт хангалттай бүрдсэн гэдгийг илэрхийлэх юм/ замаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг талууд удирдаж байгаа байдлаар хуулийн зохицуулалтуудыг томъёолох хэрэгтэй.

Иргэний хэрэг үүсгэхээс өмнөх шатанд хэргийн оролцогчид нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах тухай шүүгчийн захирамжид гомдол гаргасан тохиолдолд тухайн гомдлыг хянан шийдвэрлэх, цаашлаад иргэний хэрэг үүсгэх хүртэл зарцуулагдах хугацаа ойролцоогоор 31 хоног байна. ИХШХШТХ-ийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт практикт төдийлөн хэрэгждэггүй буюу хэрэгжих боломжгүй олон үндэслэлийг тусгасан нь нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах тухай захирамж гаргах явдлыг нэмэгдүүлэх хүчин зүйлийн нэг тул шаардлагагүй заалтуудыг хасах саналтай байна.

ИХШХШТХ-ийн 72 дугаар зүйлийн 72.3 дахь хэсгийн бичвэрт “..нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцож” гэж шууд тусгасан нь хэрэг үүсгэснээс хойш шүүх хуралдаан хүртэлх хугацаанд хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн бол хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх тухай ИХШХШТХ-ийн 74 дүгээр зүйлийн зохицуулалттай ижил төстэй байдлаар ойлгогдоход хүргэж байна. Ингэснээр практикт хариуцагч хариу тайлбар, нотлох баримтаа шүүхэд ирүүлээгүй, шүүхэд ирж тайлбар өгөөгүй эс үйлдлийг нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцох агуулгаар биш харин түүний идэвхгүй байр суурь нь хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх үндэслэл болгох үр дагаврыг бий болгоно.

Түүнчлэн шүүх хуралдааныг товлон зарлахтай холбоотойгоор ИХШХШТХ-ийн 76 дугаар зүйлийн 76.1.1 дэх заалтын дагуу “Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт хангалттай бүрдсэн” гэдгийг шүүгч биш зохигч шийдвэрлэхээр өөрчлөх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны диспозитив зарчимд нийцэх юм. Мөн тус заалтад “эсхүл энэ хуулийн 71.1-т заасан хугацаа дууссан” гэж заасан нь хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт хангалттай бүрдсэн гэж зохигч үзээгүй нөхцөлд хэрэг хянан шийдвэрлэх хугацаа

дууссан гэх үндэслэлээр шүүгч шүүх хуралдааныг товлон мөн диспозитив зарчимд харш болжээ.

“Хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримт хангалттай бүрдсэн” нь хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх үндэслэл болох тул хэргийн оролцогчид гагцхүү шүүх хуралдааны бэлтгэл хангах шатанд шүүхэд тайлбар өгөх, нотлох баримт гаргах, цуглуулах зэрэг ажиллагааг хэрэгжүүлбэл зохилтой. Харин шүүх хуралдааны явцад хэрэг хянан шийдвэрлэхтэй холбогдсон нэмэлт тайлбар, шинэ нотлох баримт, бусад асуудлын талаар хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд хангахгүй орхих, хүндэтгэн үзэх шалтгаан бий гэж үзсэн бол энэ талаарх зохих дүгнэлтийг захирамж, тогтоолын үндэслэлд дүгнэж байх шаардлагатай.

Иймд ИХШХШТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.9 дэх хэсэгт зааснаар шүүгч шүүх хуралдааны явцад шинээр нотлох баримт шаардагдсан гэж өөрөө үзэх нь мэтгэлцэх зарчмыг зөрчиж байх тул уг заалтаас энэ хэсгийг хасах учиртай.

Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны диспозитив зарчмыг хангах үүднээс шүүх хуралдаанд бэлтгэх зохигчийн үүргийг тодорхой болгох, урьдчилсан шүүх хуралдаан явуулах зохицуулалт шинээр шаардлагатай гэж дүгнэхээр байна.

Дүн шинжилгээ хийх зорилгод хамааралгүй ч хуулийн системчлэлийн хувьд ИХШХШТХ-ийн 170, 171 дүгээр зүйлийн зохицуулалтуудыг давж заалдах шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтаас хасаж, анхан шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтуудад оруулах нь оновчтой гэх саналыг гаргаж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Хууль тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 1992 (№1).
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2002 (№8).
- ХБНГУ-ын Иргэний процессын кодекс.
- Япон Улсын Иргэний процесс хууль, Иргэний процессын дүрэм (Дээд шүүх).
- ОХУ-ын Иргэний процессын кодекс, Проспект, Москва. 2015 он

Монгол хэлээр:

- Б.Буянхишиг, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй. УБ. 2021 он
- Йоахим Кают, Монгол Улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй. Анхны хэвлэл. УБ. 2015 он
- А.Түвшинтөгс, “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 72.3 дахь зохицуулалтын онолын тайлбар, практик хэрэглээ”. Хууль дээдлэх ёс сэтгүүл 2019 №79 (1)
- Ю.Ёохамски, Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар. УБ. 2004 он
- Монгол Улсын дээд шүүх, ИХШХШТХ-ийн дэлгэрэнгүй тайлбар. УБ. 2008 он
- Монгол Улсын дээд шүүх, ИХШХШТХ-ийн дэлгэрэнгүй тайлбар. УБ. 2014 он
- Монгол Улсын дээд шүүхийн 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллаганд байгаа хугацаа хэтэрсэн болон түдгэлзүүлсэн хэргийн судалгааны тойм.
- Хууль зүй дотоод хэргийн яам, Хууль тогтоомжийн тухай хууль /аргачлал, гарын авлага/. УБ. 2016 он
- Нээлттэй нийгэм форум. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа: Хэргийн оролцогчийн эрх ба иргэний хэрэг хойшлуулалт, шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ. УБ. 2021
- Шүүхийн ерөнхий зөвлөл. Монгол Улсын шүүхийн тайлан 2019. УБ.2020 он

Цахим эх сурвалж:

- Legalinfo.mn – Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем
- Gesetze-im-internet.de – ХБНГУ-ын хууль тогтоомжийн нэгдсэн сан
- <https://elaws.egov.go.jp/> – Япон улсын хууль тогтоомжийн нэгдсэн сан